МОНГОЛ УЛС
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

ХУУЛЬ САХИУЛАХУЙ

ОНОЛ, АРГА ЗҮЙН
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2026
№02 (48)

Улаанбаатар хот

UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS,
MONGOLIA

LAW ENFORCEMENT

THEORETICAL AND METHODOLOGICAL
QUARTERLY JOURNAL

2026
№02 (48)

Ulaanbaatar

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Эрхлэгч:
Ц.Азбаяр Доктор (Ph.D)

Ерөнхий редактор:
Л.Одхүү

Нарийн бичгийн дарга:
Ч.Анна

Гишүүд:
Ж.Амарсанаа Академич

О.Үржин Шинжлэх ухааны доктор, профессор

Д.Зүмбэрэллхам Шинжлэх ухааны доктор, профессор

И Габ Хван Доктор, профессор

Д.Эрдэнэбаатар Доктор, профессор

Н.Мөнхзул Доктор, дэд профессор

Хармаев Юрий Владимирович Доктор, дэд профессор

Б.Энхболд Доктор, дэд профессор

Б.Мөнхдорж Доктор, дэд профессор

Б.Баянмөнх Доктор, дэд профессор

Ж.Нямдулам Доктор, дэд профессор

М.Алтан-Очир Доктор, дэд профессор

Ц.Одбаяр Доктор, дэд профессор

Н.Угтахбаяр Доктор, дэд профессор

Г.Буянтогтох Доктор, дэд профессор

Г.Базарваань Доктор

Б.Нямжав Доктор

Б.Одгэрэл Доктор

В.Амарсанаа Доктор

Ц.Очгэрэл Доктор

П.Чимэдцэрэн Доктор

JOURNAL EDITORIAL BOARD

Editor-in-Chief:
Azbayar Ts, Ph.D.

First Secretary:
Odkhuu L,

Secretary:
Anna Ch,

Members:
Amarsanaa J, Academician

Urjin O, Sc.D., Professor

Zumberellkham D, Sc.D., Professor

Eui Gab Hwang, Ph.D., Professor

Erdenebaatar D, Ph.D., Professor

Munkhzul N, Ph.D., Associate professor

Kharmaev Y. V, Ph.D, Associate professor

Enkhbold B, Ph.D., Associate professor

Munkhdorj B, Ph.D., Associate professor

Bayanmunkh B, Ph.D., Associate professor

Nyamdulam J, Ph.D., Associate Professor

Altan-Ochir M, Ph.D., Associate Professor

Odbayar Ts, Ph.D., Associate professor

Ugtakhbayar N, Ph.D., Associate professor

Buyantogtokh G, Ph.D., Associate professor

Bazarvaani G, Ph.D.

Nyamjav B, Ph.D.

Odgerel B, Ph.D.

Amarsanaa B, Ph.D.

Ochgerel Ts, Ph.D.

Chimedtseren P, Ph.D.

ГАРЧИГ–TITLE

ХУУЛЬ САХИУЛАХЫН УДИРДЛАГА
LAW ENFORCEMENT MANAGEMENT

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН МЕНЕЖМЕНТИЙН ОНЦЛОГ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

FEATURES AND FUTURE TRENDS IN THE MANAGEMENT OF LAW ENFORCEMENT AGENCIES — 11

Д.Оюу
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн докторант, хошууч
Oyu D.
Doctoral student of the Academy of Management, of the University of Internal Affairs, Major

ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ
CRIMINOLOGY

ЭРҮҮГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЯЛТАН, ЭТГЭЭДИЙН ГАДААДАД ЗОРЧИХ, ХИЛЭЭР НЭВТРЭХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES IN IMPROVING THE LEGAL REGULATION ON THE SUSPENSION OF THE RIGHT OF CONVICTED PERSONS AND OTHER SUBJECTS TO TRAVEL ABROAD AND CROSS NATIONAL BORDERS DURING CRIMINAL JUDGMENT ENFORCEMENT PROCEEDINGS — 19

П.Оростогоо
Дотоод хэргийн их сургуулийн докторант, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, клиникийн профессор, хурандаа
Orostogoo P.
Doctoral Candidate, University of Internal Affairs; Director of the Policy Implementation Coordination Department, Ministry of Justice and Internal Affairs; Clinical Professor; Colonel

ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

STATUTE OF LIMITATIONS AND INTERNATIONAL EXPERIENCE — 29

Г.Батжаргал
Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
Batjargal G.
Professor of the Private Law Department, School of Law and Social Sciences, Ph.D., Police Lieutenant Colonel

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА (ШИНЖЭЭЧ ТОМИЛЖ, ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ) АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES OF INVESTIGATIVE ACTIVITIES RELATED TO NARCOTIC DRUGS AND PSYCHOTROPIC SUBSTANCES (APPOINTMENT OF EXPERTS AND CONDUCTING FORENSIC EXAMINATIONS) — 39

Б.Хишигтогтох
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн албаны тэнхимийн профессор, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа
Khishigtogtokh B.
Professor of the Department of Internal Troops Service, Ph.D., Police Colonel
Э.Түвшин-Эрдэнэ
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн ахмад
Tuvshin-Erdene E.
Senior Lecturer at the Department of Criminal Investigation Methodology Police School, Ph.D., Police Captain

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТҮҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ILLEGAL HUNTING CRIME, VIOLATION CONDITIONS AND ANALYSIS

Ц.Ялалт
Судлаач, доктор (Ph.D) 48
Yalalt Ts.
Researcher, Ph.D.
Д.Мягмарцэрэн
Шүүхийн сахилгын хорооны гишүүн, доктор (Ph.D), дэд профессор
Myagmartseren D.
Member of the Judicial Disciplinary Committee, Ph.D., Professor

МӨРДӨН БАЙЦААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

LEGAL STATUS OF THE INVESTIGATOR

М.Билгүүн 55
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлагч
Bilguun M.
Police school, University of Internal Affairs, Lecturer, Police sergeant

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ПРАКТИК

LEGAL REGULATION OF COMPENSATION FOR PSYCHOLOGICAL HARM CAUSED BY CRIMINAL OFFENSES: JUDICIAL PRACTICE IN MONGOLIA 62

Д.Доржсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн докторант
Dorjsuren D.
Doctoral Candidate, University of Internal Affairs

"ХИМИЙН ХОРТ, АЮУЛТАЙ БОДИСЫГ ХУУЛЬ БУС ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ"

"ISSUES TO CONSIDER IN INVESTIGATING THE ILLEGAL CIRCULATION OF TOXIC AND HAZARDOUS CHEMICAL SUBSTANCES" 74

Б.Баярсайхан
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч
Bayarsaikhan B.
University of Internal Affairs, School of Police Criminal Procedure law department of the teacher Police Major

ЦАГДАА СУДЛАЛ
POLICE STUDIES

НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА БА ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

LEGAL ISSUES OF COOPERATION BETWEEN POLICE ORGANIZATIONS AND PRIVATE SECURITY ORGANIZATIONS IN IMPLEMENTING PUBLIC ORDER PROTECTION FUNCTIONS 83

Б.Баянмөнх
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тэргүүлэх судлаач, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа
Bayanmunkh B.
Police Colonel, Ph.D., Associate Professor, Leading Researcher at the Research Institute of the University of Internal Affairs, Mongolia

МОНГОЛ УЛСАД АЙЛЧИЛСАН ГАДААДЫН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ ЗОЧИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЙЛЧЛАЛЫН ХАМГААЛАЛТЫН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ

SECURITY CONCEPTS AND TYPES OF PROTECTION FOR HIGH-LEVEL FOREIGN DELEGATIONS VISITING MONGOLIA 94

Н.Лхагвасайхан
Дотоодын цэргийн штабын дарга, доктор (Ph.D), хурандаа
Lkhagvasaihan N.
Chief of Staff of the Internal Troops, Ph.D., Colonel

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙ АЛБА ХААГЧИД ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТАД ӨРТӨХ ЭРСДЭЛ

FEMALE POLICE OFFICERS AT RISK OF DISCRIMINATION

В.Амарсанаа
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, доктор (Ph.D), цагдаагийн хошууч 105
Amarsanaa V.
Senior Researcher at the University of Internal Affairs, Mongolia, Ph.D., Police Major
В.Номинчулуун
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, цагдаагийн хошууч
Nomichuluun V.
Senior Researcher at the University of Internal Affairs, Mongolia, Police Major

ХИЛ СУДЛАЛ
LIMNOLOGY

ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ЗАН ТӨЛӨВИЙН ЗАРИМ ШИНЖИЙН СУДАЛГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

AN ANALYTICAL REVIEW OF SELECTED CHARACTERISTICS OF THE PERSONALITY TRAITS OF BORDER TROOPS PERSONNEL 116

Б.Нямжав
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тэргүүлэх судлаач, доктор (Ph.D), хурандаа
Nyamjav B.
University of Internal Affairs, Research and Innovation Department, Research Institute Leading Researcher, Ph.D., Colonel

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ХАРИЛЦАА: ТҮҮХЭН ХӨГЖИЛ БА ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

FOREIGN RELATIONS OF THE BORDER GUARD: HISTORICAL DEVELOPMENT AND FUTURE DIRECTIONS 131

Б.Хонгорзул
Хил судлалын Магистрант, дэслэгч
Khongorzul B.
Master's degree in Border Studies, Lieutenant

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ
COURT DECISION EXECUTION STUDIES

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАЛААР ГАРСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

IMPLEMENTING INTERNATIONAL TREATIES IN THE ENFORCEMENT OF CIVIL COURT JUDGMENTS: CHALLENGES AND PROSPECTS IN MONGOLIA

Э.Цэрэнханд 138
Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн ахлах багш, хошууч
Tserenkhand E.
Major, Senior Lecturer, Department of Civil Enforcement, School of Court Decision Enforcement, University of Internal Affairs, Ulaanbaatar, Mongolia

ХОРИГДЛЫН ЗАН ҮЙЛИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

SOME RESULTS OF THE RESEARCH ON PRISONER BEHAVIOR

О.Баяржаргал 148
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, дэд хурандаа
Bayarjargal O.
Senior Researcher, Research Institute, Lieutenant Colonel

НИЙГМИЙН ҮЛ ҮЗЭГДЭХ БҮЛЭГ: ЭЦЭГ, ЭХ НЬ ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ХҮҮХДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

THE INVISIBLE SOCIAL GROUP: THE SITUATION OF CHILDREN WHOSE PARENTS ARE INCARCERATED 157

Н.Удвалцэцэг
Дотоод хэргийн их сургуулийн докторант, хошууч
Udvaltsetseg N.
Ph.D., student, University of Internal Affairs of Mongolia, major

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХОРИГДЛЫГ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА, ОНЦЛОГ

EXECUTION OF SENTENCES FOR PRISONERS WITH DISABILITIES: KEY CHARACTERISTICS 163

Д.Жамъяндагва
Дотоод хэргийн их сургуулийн докторант
Jamyandagva D.
Ph.D., student, University of Internal Affairs of Mongolia,

ГАМШИГ СУДЛАЛ
DISASTER STUDIES

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

EARTHQUAKE RISK ASSESSMENT IN THE SOUTHERN PROVINCE ANALYSIS

М.Батсүх
Дотоод хэргийн их сургуулийн Гамшиг судлалын магистрант, ахмад
Batsukh M. 173
Graduate student of master degree of disaster research of the University of Internal, capitian
Б.Одгэрэл
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тэргүүлэх судлаач, доктор (Ph.D), дэслэгч
Odgerel B.
Ph.D., Leading Researcher at the Research Institute of the University of Internal Affairs, Mongolia, Lieutenant

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НУРАНГИД ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНД ГАЛ СӨНӨӨГЧДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

THE ROLE OF FIREFIGHTERS IN URBAN SEARCH AND RESCUE OPERATIONS IN COLLAPSED BUILDINGS AND STRUCTURES 185

Б.Ганзагас
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, ахмад
Ganzagas B.
Captain, Scientific Senior Researcher-Lecturer, Research Institute, University of Internal Affairs

ГАМШГИЙН ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО БА ЭРХЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

THE ROLE OF NON-GOVERNMENTAL ORGANIZATIONS AND AN EVALUATION OF THE LEGAL FRAMEWORK IN STRENGTHENING DISASTER RESILIENCE 192

С.Амартүвшин
Анкарагийн Нийгмийн Ухааны Их Сургуулийн магистрант
Amartuvshin S.
Master's Student at Social Sciences University of Ankara

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ СУДЛАЛ
FORENSIC STUDIES

МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ХАМТАРСАН ШИНЖИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

THE CURRENT SITUATION OF COOPERATIVE INVESTIGATION OF FORENSIC MEDICINE

А.Болор-Эрдэнэ
Анагаах ухааны магистр, шинжлэн магадлахуйн докторант
Bolor-Erdene A.
Master of Medicine, Ph.D., candidate of forensic science
З.Сүлд
Шинжлэн магадлах ухааны доктор (Ph.D)
Suld Z.
Forensic Science Ph.D. 203

КРИМИНАЛИСТИКИЙН ДУУ АВИА СУДЛАЛ

FORENSIC PHONETICS STUDY

Х.Түвшин-Эрдэнэ
Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн Байгалийн ухаан, техник зүйн шинжилгээний тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа
Tuvshin-erdene Kh.
Forensic science school of UIA, Senior taecher Police lieutenant colonel 209

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

SOME HISTORICAL ISSUES OF FORENSIC SCIENCE

Э.Батбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, цагдаагийн дэд хурандаа
Batbayar E.
Police lieutenant colonel, Senior Researcher, Research Institute, University of Internal Affairs 220

ЭРХ ЗҮЙ СУДЛАЛ
LEGAL STUDIES

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛЖ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES TO BE CONSIDERED WHEN ISSUING APPLICATIONS FROM NON-GOVERNMENTAL ORGANIZATIONS REPRESENTING THE PUBLIC INTEREST TO ADMINISTRATIVE COURTS

М.Эрдэнэбаяр
Олон улсын Улаанбаатарын их сургууль, доктор (Ph.D), дэд профессор
Erdenebayar M.
Ph.D., Associate Professor, International Ulaanbaatar University
М.Болормаа
Хууль зүйн магистр
Bolormaa M.
Master of Laws, Senior Lecturer 225

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖИЛ ЗҮЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

POLICY AND REGULATORY IMPLEMENTATION FOR METROLOGICAL INSTITUTIONS OF MONGOLIA

Ж.Ариунтунгалаг
Стандарт, хэмжил зүйн газрын ахлах мэргэжилтэн
Ariuntungalag J.
Senior Specialist of Mongolian Agency for Standard and Metrology 231

ГЭРЛЭЛТТЭЙ АДИЛТГАХ ХАРИЛЦАА БУЮУ ХАМТРАН АМЬДРАГЧДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

"THE LEGAL REGULATION OF COHABITING PARTNERS IN MARRIAGE-EQUIVALENT RELATIONSHIPS"

Б.Золбоо 243
Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403-р анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч
Zolboo B.
Teacher, Major, Department of Civil Enforcement of Court Decisions, School of Court Decision Enforcement Service, Training and Research Unit 403, University of Internal Affairs

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ БАТЛАН ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: ХУУЛЬД ҮНДЭСЛЭХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

THE PROCESS OF ADOPTING ADMINISTRATIVE NORMATIVE ACTS IN MONGOLIA: THE IMPLEMENTATION OF THE PRINCIPLE OF LEGALITY

Д.Энх-Амар 248
Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад
Enkh-Amar D.
Senior lecturer at the Department of Public Law, School of Law University of Internal Affairs, Police Captain

ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХ

PROTECTION OF HUMAN RIGHTS IN CIVIL JUDGMENT ENFORCEMENT PROCEEDINGS

Х.Энхтулга 257
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын Академийн магистрант
Enkhtulga Kh.
A master's degree student, University of Internal Affairs

ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ
LAW ENFORCEMENT EDUCATION STUDIES

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХУУЛИЙН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧДЫН ШҮҮХ СЭТГЭЦ ЭМГЭГ СУДЛАЛЫН МЭДЛЭГ, ХАНДЛАГЫН СУДАЛГАА

A STUDY ON THE KNOWLEDGE AND ATTITUDES OF LAW SCHOOL STUDENTS TOWARDS FORENSIC PSYCHIATRY

Ц.Нандинцэцэг 263
Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн Байгалийн ухаан, техник зүйн шинжилгээний тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч
Nandintsetseg Ts.
University of Internal Affairs, Department of Natural Science and Technical Expertise, School of forensic Science, Senior Lecturer, Police Major

ОСНОВНЫЕ ПРОБЛЕМЫ ИНОСТРАННЫХ ОБУЧАЮЩИХСЯ В ОБРАЗОВАТЕЛЬНЫХ ОРГАНИЗАЦИЯХ МВД РОССИИ

ОХУ-ЫН ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ИХ ДЭЭД СУРГУУЛИУДАД СУРАЛЦАЖ БАЙГАА ГАДААД СУРАЛЦАГЧДАД ТУЛГАРЧ БУЙ ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД

Букина Татьяна Григорьевна 270
Заведующий кафедрой иностранных языков Уральского юридического института МВД России, кандидат филологических наук, доцент
Bukina Tatyana Grigoryevna
Head of the Department of Foreign Languages of the Ural Law Institute of the Ministry of the Interior of the Russian Federation, Candidate of Philology, Associate Professor

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ГАРДАН ТУЛААНЫ СУРГАЛТЫН АГУУЛГЫГ БОДИТ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЦЭЭНД НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

"ISSUES IN IMPROVING THE CONTENT OF HAND-TO-HAND COMBAT TRAINING IN LAW ENFORCEMENT AGENCIES TO ALIGN WITH OPERATIONAL REQUIREMENTS"

278

Э.Сандагжав
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа
Sandagjav E.
Senior Lecturer, Department of Military Studies, Border Troops School, University of Internal Affairs, Lieutenant Colonel

ТЭМЦЭЭНИЙ ӨМНӨ ТАМИРЧДЫН СЭТГЭЛЗҮЙГ БЭЛТГЭХ НЬ

PREPARING ATHLETES PSYCHOLOGICALLY BEFORE COMPETITION

286

Б.Баатарсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн Албаны бэлтгэлийн "Соёмбо" төвийн ахлах багш, цагдаагийн хошууч
Baatarsuren B.
Lecturer, Department of Professional Training, University of Internal Affairs, Police Major

АЖЛААС ХАЛШРАХ ХАМ ШИНЖ БА ТҮҮНИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМ
(Төрийн цэргийн байгууллагын алба хаагчдаас авсан судалгааны жишээн дээр)

BURNOUT SYNDROME AND COPING STRATEGIES
Based on a Study of Public Military Organization Employees

291

Л.Отгондулам
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахмад
Otgondulam L.
Master's student of Border Studies, Captain at Border Protection School, University of Internal Affairs, Captain

ЭРДЭМТЭН, СУДЛААЧИЙН ҮЗЭЛ БОДОЛ
SCIENTIST AND RESEARCHER›S VIEW

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ ДАХЬ НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХЭД ДИЖИТАЛ ТЕХНОЛОГИ БА ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ҮҮРЭГ

THE ROLE OF DIGITAL TECHNOLOGIES AND ARTIFICIAL INTELLIGENCE IN ENHANCING SOCIAL PARTNERSHIPS AND COLLABORATIVE GOVERNANCE IN CHILD PROTECTION

297

Н.Жинжиймаа
Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэслэгч
Jinjiimaa N.
Ph.D., Associate Professor Department of Private Law School of Law and Social Sciences University of Internal Affairs, Police lieutenant

ХҮНИЙ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХАД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД, ТЭДГЭЭРИЙН ТААМАГЛАЛ, ЗАГВАР

FACTORS INFLUENCING THE REALIZATION OF THE HUMAN RIGHT TO LIVE IN A HEALTHY AND SAFE ENVIRONMENT: HYPOTHESES AND MODELS

307

Д.Бадамцэцэг
Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
Badamtsetseg D.
Ph.D., at University of Internal Affairs, Mongolia. Police lieutenant colonel

НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЛИЙГ ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД АШИГЛАХ БОЛОМЖ, СОРИЛТ БА ШИЙДЭЛ

UAVS IN PUBLIC SECURITY: OPPORTUNITIES, CHALLENGES, AND STRATEGIC SOLUTIONS

317

Ш.Ундарга
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн ахлах багш, хошууч
Undarga Sh.
Senior Lecturer at the School of Border Service, University of Internal Affairs, Major

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН МЕНЕЖМЕНТИЙН ОНЦЛОГ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

FEATURES AND FUTURE TRENDS IN THE MANAGEMENT OF LAW ENFORCEMENT AGENCIES

Д.Оюу*
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн докторант, хошууч
Oyu D.
Doctoral student of the Academy of Management, of the University of Internal Affairs, Major

*Хариуцлагатай зохиогч: Doyu96.uia@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлд хууль сахиулах байгууллагын менежментийн онцлог, гадаад ба дотоод орчны нөлөөлөл, цаашдын чиг хандлагыг судлан шинжиллээ. Бидний судалж буй сэдэв нь төрийн онол, эрх зүйн онол, төрийн удирдлага, менежментийн онол, системийн онол зэрэг олон салбарын огтлолцолд оршдог бөгөөд олон үндсэн онолууд дээр тулгуурлан судлагдана.

Өгүүлэлд чанарын судалгааны арга зүй буюу стратегийн шинжилгээний арга зүйг ашиглаж, SWOT болон PESTLE шинжилгээгээр нэгтгэн дүгнэв.

Судалгааны үр дүнгээс үзэхэд хууль сахиулах байгууллагын менежмент нь шатлан захирах бүтэц, хатуу эрх зүйн зохицуулалтад тулгуурласан хэвээр боловч нийгэм, технологийн өөрчлөлттэй уялдан шинэчлэгдэх шаардлагатай байна. Гадаад орчинд улс төр, эрх зүйн хүчин зүйлс давамгайлж, эдийн засаг, технологийн нөлөө өсөн нэмэгдэж байгаа бол дотоод орчинд процессын давхардал, байгууллага хоорондын сул уялдаа, гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцооны сул тал ажиглагдав. Цаашид хүний эрх, ёс зүй, ил тод байдал, инновац, хамтын ажиллагаанд суурилсан иргэн төвтэй менежментийн загварт шилжих хандлага тодорхойлогдож байна.

Abstract: This article examines the characteristics of law enforcement agency management, the impact of external and internal environments, and future trends. The topic we are studying is at the intersection of many fields, including state theory, legal theory, public administration, management theory, and system theory, and is based on many basic theories.

The article uses qualitative research methodology or strategic analysis methodology, and summarizes it using SWOT and PESTLE analysis.

According to the results of the study, law enforcement agency management is still based on a hierarchical structure and strict legal regulations, but it needs to be updated in line with social and technological changes. While political and legal factors dominate in the external environment and the influence of economics and technology is increasing, duplication of processes, weak coordination between organizations, and weaknesses in the performance evaluation system are observed in the internal environment. In the future, a trend is being identified to move to a citizen-centered management model based on human rights, ethics, transparency, innovation, and cooperation.

Түлхүүр үг: Хууль сахиулах байгууллага, менежмент, албадлага, инновац,
Keywords: Law enforcement, management, enforcement, innovation,

Удиртгал: Хууль сахиулах байгууллага нь нийгмийн хэв журам, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах суурь чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн институцийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Гэвч энэхүү үйл ажиллагааны үр нөлөө нь зөвхөн эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдахгүй бөгөөд байгууллагын удирдлагын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавх, технологийн дэвшилтэт шийдлийн нэвтрүүлэлт, мөн олон нийтийн оролцоо, итгэлцлийн түвшин зэрэг олон хүчин зүйлээс шууд хамааралтай байна.

XXI зуунд дэлхийн улс орнуудад хууль сахиулах салбар нь даяаршил, технологийн хурдацтай хөгжил, кибер гэмт хэргийн

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

өсөлт, хүний эрхийн мэдрэмжийн нэмэгдэл зэрэг шинэ сорилтуудтай тулгарч, улам бүр нарийн төвөгтэй болж байна. Үүний улмаас уламжлалт удирдлагын арга барилыг шинэчлэх, ил тод, хариуцлагатай, үр ашигтай менежментийн тогтолцоог бүрдүүлэх шаардлага нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын хувьд ч мөн адил бодитой тулгамдсан асуудал болж байна.

Орчин үеийн хурдтай өөрчлөгдөж буй нийгэмд хууль сахиулах байгууллагуудын менежмент нь төрийн захиргааны уламжлалт загварт тулгуурласан, шаталсан бүтэц, хатуу дүрэм журамд хэт төвлөрсөн хэв шинжийг хадгалсаар байгаа нь шинэ техник технологи, олон улсын менежментийн шинэ хандлагуудад дасан зохицох чадамжийг хязгаарлаж байна. Мөн шударга бус байдал, төрийн тусгай байгууллага гэх нэрийн доор нээлттэй бус байдал зэрэг нь иргэдийн итгэл буурах хандлага ажиглагдаж байгаа нь менежментийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Түүнчлэн дижитал шилжилт, өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх үйл явц удаашралтай, хүний нөөцийн чадавх, байгууллагын соёлын бэлэн байдал хангалтгүй байгаа нь стратегийн шинэчлэлийг сааруулж байна.

Иймд хууль сахиулах байгууллагын менежментэд процессын шинэчлэл, гүйцэтгэлд суурилсан удирдлага, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурласан менежментийн загварыг нэвтрүүлэх хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаа нь **судалгааны гол тулгамдсан асуудал** болж байна.

Судлагдсан байдлын тойм

Судлагдсан байдлыг судалж үзэхэд олон улсын судлаачид процедурын шударга ёс, байгууллагын дотоод соёл, манлайлал нь байгууллагын үр ашиг, олон нийтийн итгэлд чухал нөлөөтэйг онцолсон (Donner, C. Maskaly, J., Fridell, L. A., Jennings, W. G., 2015) (Mastrofski, 2019). Үүний зэрэгцээ өгөгдөлд суурилсан удирдлага, дижитал технологийн хэрэглээ нь хууль сахиулах байгууллагын менежментийн үр нөлөөг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна (Ratcliffe, 2016) (Ferguson, 2017) гэх мэтээр үзжээ.

Харин Монгол Улсын хувьд төрийн тусгай албаны тогтолцоо, үйл ажиллагаа, мөн чанарын талаар судалсан эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээлүүд байх ба хууль сахиулах байгууллагын талаар нарийвчилсан судалгаа хомс боловч хууль зүйн доктор Ц.Азбаяр докторын зэрэг горилсон бүтээлдээ дэлгэрэнгүй судалсан байна (Ц.Азбаяр, 2025).

Мөн хууль сахиулах байгууллагын шинэчлэл, гүйцэтгэл, хүний нөөцийн чадавх, байгууллагын дотоод зохион байгуулалтын асуудлыг түлхүү авч үзсэн байна. Судалгаануудын үр дүнд байгууллага хоорондын уялдаа сул, процессын давхардал, хүний нөөцийн ур чадвар сул, технологийн бэлэн байдал хангалтгүй зэрэг асуудлууд нийтлэг байгааг тусгажээ (Баттөр, 2018) (Энхтүвшин, 2020). Менежментийн үр ашигт байгууллагын соёл, манлайлал, харилцааны ур чадвар чухал нөлөөтэйг онцолж, “зөөлөн хүчин зүйлс”-ийг судлах хандлага нэмэгдсэн (Э. Эрдэнэбат Д.Болд, О.Эрдэнэбаяр, 2025).

Иймхүү 2015 оноос хойших судалгааны чиг хандлага нь хууль сахиулах байгууллагын менежментийг үр дүнд суурилсан, иргэд төвтэй, технологид суурилсан хэлбэрт шилжүүлэхэд чиглэж байгаа боловч Монгол Улсын хувьд энэхүү шилжилт хангалттай түвшинд хэрэгжээгүй, ялангуяа процессын нэгдмэл менежмент, дижитал удирдлага, байгууллага хоорондын уялдаа холбоог цогцоор нь судалсан ажил дутмаг хэвээр байна.

Онолын асуудал

Өгүүллийг онолын талаас нь судалж үзвэл төрийн удирдлагын ерөнхий онолын хүрээнд хөгжиж ирсэн боловч онцлог чиг үүрэг, эрх зүйн зохицуулалт, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоос шалтгаалан тусгайлсан онолын хандлагыг шаарддаг. Товчоор дурдахад:

- ✓ Төрийн удирдлагын уламжлалт ба орчин үеийн онолын зөрчил
- ✓ Процессын менежмент ба институцийн онолын уялдаа

✓ Хариуцлага болон гүйцэтгэлийн удирдлага
✓ Эрсдэлийн удирдлага ба аюулгүй байдлын онол
✓ Технологи ба дижитал шилжилтийн онол
✓ Байгууллагын соёл ба манлайллын онол

Ийнхүү хууль сахиулах байгууллагын менежментийн онолын асуудал нь уламжлалт төвлөрсөн удирдлага ба орчин үеийн уян хатан, үр дүнд суурилсан хандлагын зөрчил, процесс ба институцийн нийцэл, гүйцэтгэлийн үнэлгээний хязгаар, эрсдэлийн удирдлага, дижитал шилжилт, манлайллын шинэ хэлбэр зэрэг олон хэмжээсээр илэрч байна. Цаашид эдгээр онолын хандлагуудыг уялдуулсан интеграцчилсан загвар боловсруулах нь судалгааны гол чиг хандлага болж байна.

Хууль сахиулах байгууллагуудын менежментийн онцлогийг онол, практикийн түвшинд тодорхойлох, Монгол Улсын нөхцөлд тулгамдаж буй асуудлыг шинжлэх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох нь судалгааны чухал ач холбогдолтой асуудал болж байна. Иймд энэхүү өгүүллийн зорилго нь хууль сахиулах байгууллагуудын менежментийн онцлогийг системийн болон институцийн онолын үүднээс шинжлэх, орчин үеийн чиг хандлагыг тодорхойлон, цаашдын хөгжлийн боломж, загварыг тодорхойлоход оршино.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагаас нийгмийн харилцааг зохицуулахаар батлан гаргасан заавал биелэгдэх шинжтэй хууль, дүрэм, журамд заасан хэм хэмжээнд иргэний биеэ авч явах үйлдлийг нийцүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, таслан зогсоох, илрүүлэх, нийтийн дэг журмыг хангах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн эмх цэгц, амар тайван байлгахын тулд хуульд заасан үндэслэл журмын дагуу чиглүүлэх, албадах, хүч хэрэглэх, шийтгэх замаар нөлөөлөх үйлдэл, үйл явцыг хэрэгжүүлэгч субъект зэрэг нийтлэг шинжээр нь “хууль сахиулах” ойлголтыг “ойлголт тодорхойлох тусч” аргыг ашиглан өргөн болон явцуу утгаар нь тодорхойлжээ (Ц.Азбаяр, 2025).

“Хууль сахиулах байгууллага” гэж хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн дэг журмыг хангах зорилгоор гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хуулиар тогтоосон эрхийн хүрээнд төрийн албадлага, хүч хэрэглэх замаар бусдын зан үйлийг төрөөс тогтоосон хэм хэмжээнд нийцүүлэх, мөрдүүлэх цогц үйл ажиллагааг гүйцэтгэдэг хөдөлмөрийн хуваарийн дагуу бүтэцлэгдсэн хүмүүсийн нэгдлийг хэлнэ.

Манай улсын хувьд хууль сахиулах тогтолцоо нь түүхэн хөгжлийн явцад бүрэлдэн төлөвшсөн бөгөөд 1992 оны Үндсэн хуулийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан үзэл баримтлалд шилжсэн ч эрх зүйн зохицуулалтын хувьд нэр томъёоны нэгдмэл байдал хангалтгүй, олон хуульд тархсан, зөрүүтэй хэрэглээ ажиглагдаж байна. Тухайлбал “хууль сахиулах байгууллага”, “хууль сахиулагч”, “төрийн тусгай байгууллага” зэрэг ойлголтуудын ялгаа, хамрах хүрээ тодорхойгүй байгаа нь байгууллагын чиг үүргийн давхардал, менежментийн үр ашиггүй байдлыг бий болгож байна.

Орчин үеийн төрийн удирдлагын тогтолцоонд хууль сахиулах байгууллагууд нь нийгмийн дэг журам, олон нийтийн аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг хангах үндсэн институцийн нэг бөгөөд төрийн эрх мэдлийн бодит хэрэгжилтийг илэрхийлдэг онцгой салбар юм. Төрийн үндсэн чиг үүргийн нэг болох хууль сахиулах үйл ажиллагаа нь нийгмийн тогтвортой байдал, шударга ёсны баталгаа болохын хувьд төрийн институцийн үр нөлөө, легитим чанарыг тодорхойлогч гол хүчин зүйлд тооцогддог (Kelsen, 1945). Иймээс хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны үр ашиг нь зөвхөн эрх зүйн зохицуулалтаас гадна менежментийн оновчтой тогтолцоо, зохион байгуулалтаас шууд хамааралтай юм.

Даяаршил, технологийн хурдацтай хөгжил, нийгмийн харилцааны нарийсал, гэмт хэргийн бүтэц, хэлбэрийн хувьсал нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд шинэ сорилтуудыг бий болгож, менежментийн уламжлалт загварыг шинэчлэх шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна. Ялангуяа мэдээллийн технологид суурилсан гэмт хэрэг, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн өсөлт нь хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, стратегийн удирдлагын шинэ хэлбэрийг шаардаж байна (UNODC, 2020).

Олон улсын түвшинд хууль сахиулах байгууллагын менежмент нь ил тод байдал, хариуцлагатай байдал, олон нийтийн оролцоонд суурилсан загварт шилжиж, дижитал технологи, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, байгууллага хоорондын интеграцчилсан системийг нэвтрүүлэх чиг хандлага давамгайлж байна (Goldstein, 1990). Энэ нь хууль сахиулах байгууллагын үр ашиг, иргэдийн итгэлцлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Энэхүү судалгаанд байгууллагын дотоод болон гадаад орчныг үнэлэх зорилгоор стратегийн шинжилгээний аргууд болох SWOT болон PESTLE шинжилгээг ашигласан. Эдгээр нь чанарын судалгааны хүрээнд хамаарах бөгөөд баримт бичгийн шинжилгээ, асуулга, ярилцлагын үр дүнд тулгуурлан байгууллагын давуу болон сул тал, боломж ба эрсдэл, түүнчлэн макро орчныг хүчин зүйлсийг тодорхойлох боломжийг бүрдүүлдэг.

Хүчин зүйл		Гол агуулга	Менежментэд үзүүлэх нөлөө
P	Улс төр	Төрийн бодлого, аюулгүй байдлын стратеги, улс төрийн тогтвортой байдал	Удирдлагын шийдвэр гаргалт улс төрийн нөлөөнд автах эрсдэлтэй, бодлогын өөрчлөлтөөс хамааралтай.
E	Эдийн засаг	Төсвийн санхүүжилт, эдийн засгийн өсөлт/бууралт	Санхүүгийн нөөц хязгаарлагдмал бол үйл ажиллагааны үр ашиг буурна.
S	Нийгэм	Иргэдийн итгэл, гэмт хэргийн түвшин, хүн ам зүйн өөрчлөлт	Олон нийтийн оролцоо, итгэлцэл нь гүйцэтгэлд шууд нөлөөлнө.
T	Технологи	Дижитал систем, хиймэл оюун, хяналтын технологи	Мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт нэмэгдэнэ, кибер аюул нэмэгдэнэ.
L	Эрх зүй	Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэл, хяналтын механизм	Үйл ажиллагаа хатуу зохицуулалттай, албадлагыг хуульд заасны дагуу хийдэг бөгөөд өөрчлөлтөд дасан зохицох шаардлагатай.
E	Байгаль орчин	Онцгой байдал, гамшиг, уур амьсгалын эрсдэл	Шуурхай хариу арга хэмжээ, шийдвэр гаргалт, нөөцийн удирдлага чухал болно.

Хүснэгт 1. PESTLE шинжилгээ

PESTLE шинжилгээний үр дүнгээс харахад хууль сахиулах байгууллагын менежмент нь гадаад орчны олон талт хүчин зүйлсийн нөлөөлөлд өндөр хамааралтай байна. Ялангуяа улс төр, эрх зүйн орчин нь байгууллагын үйл ажиллагааны чиглэл, шийдвэр гаргалтад шууд нөлөөлөх үндсэн хүчин зүйл болж байна. Эдийн засгийн нөхцөл, төсвийн хязгаарлалт нь нөөцийн оновчтой хуваарилалтыг шаарддаг, мөн зардал хэмнэсэн байхыг шаарддаг бол нийгмийн хүчин зүйлс, тухайлбал иргэдийн итгэл, оролцоо нь байгууллагын үр нөлөө, нэр хүндийг тодорхойлох чухал үзүүлэлт болж байна.

Түүнчлэн технологийн хурдацтай хөгжил нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах боломж бүрдүүлж байгаа хэдий ч кибер аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Байгаль орчны болон гамшгийн шинжтэй эрсдэлүүд нь байгууллагын шуурхай хариу арга хэмжээний чадавхыг тасралтгүй сайжруулах шаардлагыг бий болгож байна. Иймээс хууль сахиулах байгууллагын менежмент нь гадаад орчны өөрчлөлтөд дасан зохицох, уян хатан, эрсдэлд суурилсан удирдлагын тогтолцоонд шилжих шаардлагатай байна гэж дүгнэлээ.

Ангилал		Агуулга
S	Давуу тал	• Төрийн эрх бүхий статус, хууль хэрэгжүүлэх бүрэн эрх • Сахилга бат, шатлан захирах тогтолцоо сайн • Туршлагатай хүний нөөц, мэргэшсэн алба хаагчид
W	Сул тал	суртал, олон шат дамжлага • Процессын давхардал, удаашрал • Дижитал шилжилт хангалтгүй • Гүйцэтгэлийн үнэлгээ сул
O	Боломж	• Дижитал технологи нэвтрүүлэх боломж • Олон улсын хамтын ажиллагаа • Шинэчлэлийн бодлого, институцийн реформ
T	Аюул занал	• Кибер гэмт хэрэг, шинэ төрлийн аюул • Олон нийтийн итгэл буурах эрсдэл • Улс төрийн нөлөөлөл • Санхүүгийн хязгаарлалт

Хүснэгт 2. SWOT шинжилгээ

SWOT шинжилгээний үр дүнгээс үзэхэд хууль сахиулах байгууллага нь төрийн эрх бүхий статус, зохион байгуулалтын сахилга бат, туршлагатай хүний нөөц зэрэг давуу талтай боловч менежментийн хувьд хүнд суртал, процессын давхардал, гүйцэтгэлийн үнэлгээний сул тогтолцоо зэрэг дотоод сул талууд оршиж байна.

Гадаад орчны хувьд дижитал технологийн хөгжил, олон улсын хамтын ажиллагаа нь байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх боломжийг бүрдүүлж байгаа бол кибер гэмт хэрэг, олон нийтийн итгэл буурах эрсдэл, улс төрийн нөлөөлөл зэрэг нь томоохон сорилт болж байна.

Иймд цаашид байгууллагын менежментийг боловсронгуй болгохын тулд давуу талдаа тулгуурлан боломжийг ашиглах (SO), сул талаа засах замаар боломжийг ашиглах (WO), эрсдэлийг бууруулах (ST, WT) стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа процессын шинэчлэл, дижитал шилжилт, ил тод байдал, гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог сайжруулах нь тэргүүлэх чиглэл болж байна.

	Боломж (O)	Аюул (T)
Давуу тал (S)	**SO стратеги** • Дижитал технологийг ашиглан үйл ажиллагааг сайжруулах • Туршлагатай хүний нөөцөд тулгуурлан инноваци нэвтрүүлэх	**ST стратеги** • Сахилга бат, бүтцэдээ тулгуурлан эрсдэлийг бууруулах • Кибер аюулд хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх
Сул тал (W)	**WO стратеги** • Процессын шинэчлэл, автоматжуулалт хийх • Гадаад туршлага нэвтрүүлж менежментийг сайжруулах	**WT стратеги** • Хүнд суртлыг бууруулах реформ хийх • Ил тод байдлыг нэмэгдүүлж олон нийтийн итгэлийг сэргээх

Хүснэгт 3. Стратегийн шинжилгээ

Судалгаанд байгууллагын гадаад орчны нөлөөллийг тодорхойлох зорилгоор PESTLE шинжилгээ, дотоод болон гадаад орчны уялдааг үнэлэх зорилгоор SWOT шинжилгээг тус тус ашигласан. PESTLE шинжилгээгээр улс төр, эдийн засаг, нийгэм, технологи, эрх зүй, байгаль орчны хүчин зүйлсийг тодорхойлсон бол SWOT шинжилгээгээр байгууллагын давуу болон сул тал, боломж, аюул заналыг нэгтгэн дүгнэсэн. Улмаар эдгээрийг уялдуулан стратегийн хувилбаруудыг (SO, ST, WO, WT) боловсруулсан болно.

PESTLE болон SWOT шинжилгээний үр дүнг нэгтгэн үзвэл хууль сахиулах байгууллагын менежмент нь дотоод зохион байгуулалтын сул тал болон гадаад орчны динамик өөрчлөлтийн огтлолцолд оршиж

байна. Ийм нөхцөлд уламжлалт захиргааны хандлагаас татгалзаж, уян хатан, технологид суурилсан, иргэн төвтэй менежментийн загварт шилжих шаардлага улам бүр нэмэгдэж байна. Цаашид стратегийн төлөвлөлт нь гадаад орчныг нөлөөллийг харгалзан үзсэн, дотоод нөөц боломжид тулгуурласан, интеграцчилсан хандлагад суурилах нь зүйтэй гэж дүгнэлээ.

Хууль сахиулах байгууллагын менежмент нь төрийн удирдлагын тусгай хэлбэр бөгөөд нийгмийн аюулгүй байдал, хууль дээдлэх зарчмыг хангах зорилготойгоор эрх зүйн хатуу зохицуулалт, шатлан захирах бүтэц, өндөр хариуцлага, эрсдэлд суурилсан шийдвэр гаргалт зэрэг онцлог шинжээр тодорхойлогддог (Cordner, 2016). Энэхүү менежмент нь уламжлалт бюрократ зохион байгуулалтад тулгуурлахын зэрэгцээ орчин үед үр дүнд суурилсан удирдлага, ил тод байдал, иргэн төвтэй хандлагыг хослуулах шаардлагатай болж байна. Мөн гэмт хэрэг, зөрчлийн шинж чанар байнга өөрчлөгдөж буй нөхцөлд хууль сахиулах байгууллагын менежмент нь уян хатан, шуурхай, мэдээлэлд суурилсан байх шаардлага улам бүр нэмэгдэж байна (UNODC, Hand book on police accountability, oversight and integrity., 2011).

Хууль сахиулах байгууллагын менежментийн цаашдын чиг хандлага

Орчин үеийн хууль сахиулах байгууллагын менежмент нь уламжлалт реактив хандлагаас татгалзаж, урьдчилан сэргийлэх, өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоо руу шилжих хандлагатай байна. Ялангуяа гэмт хэргийн шинж чанар улам бүр төвөгтэй, хил дамнасан хэлбэрт шилжиж буй нөхцөлд байгууллагууд криминал тагнуул, мэдээлэл солилцоо, дүн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргалтыг чухалчлах болжээ. Энэ нь хууль сахиулах байгууллагын менежментийг илүү шинжлэх ухааны, өгөгдөлд тулгуурласан болгох үндсэн чиглэл болж байна (UNODC, Law enforcement and criminal intelligence., 2024).

Нөгөө талаас дижитал технологи, хиймэл оюун ухааны хөгжил нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт авчирч байна. Тухайлбал, хиймэл оюунд суурилсан нотлох баримтын удирдлага, бодит цагийн мэдээллийн төвүүд, урьдчилан таамаглах аналитик зэрэг нь нөөцийн хуваарилалт, шийдвэр гаргалтыг оновчтой болгох боломжийг бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ дижитал нотлох баримтын хэмжээ огцом өссөн нь мэдээллийн аюулгүй байдал, ёс зүйн зохицуулалтын шинэ сорилтыг бий болгож байна (Rev., 2026).

Цаашид хууль сахиулах байгууллагын менежмент нь зөвхөн хууль хэрэгжүүлэх чиг үүргээр хязгаарлагдахгүй, харин олон талт хамтын ажиллагаа, институц хоорондын уялдаа, нийгмийн оролцоонд суурилсан загвар руу шилжих хандлага ажиглагдаж байна. Олон улсын байгууллагуудын судалгаагаар гэмт хэрэгтэй тэмцэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлэх нь чухал болж байгаа бөгөөд энэ нь менежментийн шинэ парадигмыг тодорхойлж байна (Development, 2026).

Мөн кибер гэмт хэрэг, хиймэл оюунд суурилсан шинэ төрлийн аюул нэмэгдэж буйтай холбоотойгоор хууль сахиулах байгууллагуудын менежмент нь уян хатан, инновацад суурилсан, эрсдэлийн удирдлагыг тэргүүнд тавьсан хэлбэрт шилжих шаардлагатай болж байна. Энэ нь зөвхөн технологийн шинэчлэл төдийгүй байгууллагын соёл, манлайлал, хүний нөөцийн чадавхыг бүхэлд нь шинэчлэх шаардлагыг бий болгож байна (Schiliro, 2024).

Монгол Улсын нөхцөлд хууль сахиулах байгууллагын менежментийг боловсронгуй болгохын тулд уламжлалт удирдлагын хандлагыг орчин үеийн дижитал, уян хатан, иргэн төвтэй менежменттэй уялдуулах шаардлага тулгамдаж байна. Ийм өөрчлөлтийг системтэйгээр хэрэгжүүлснээр байгууллагын үр ашиг, олон нийтийн итгэл, аюулгүй байдлын түвшинг цогцоор нь сайжруулах боломж бүрдэнэ.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар хууль сахиулах байгууллагын менежментийн онцлог, гадаад болон дотоод орчны нөлөөлөл, цаашдын чиг хандлагыг онол, шинжилгээний түвшинд авч үзлээ. Судалгааны үр дүнгээс харахад хууль сахиулах байгууллагын менежмент нь уламжлалт бюрократ бүтэц, хатуу эрх зүйн зохицуулалт, шатлан захирах тогтолцоонд тулгуурласан хэвээр байгаа боловч орчин үеийн нийгэм, технологийн өөрчлөлттэй уялдан шинэчлэгдэх зайлшгүй шаардлагатай байна.

PESTLE болон SWOT шинжилгээний үр дүнгээс үзэхэд байгууллагын менежментэд улс төр, эрх зүйн орчны нөлөөлөл өндөр, эдийн засгийн болон технологийн хүчин зүйлсийн нөлөө нэмэгдэж, харин дотоодын хувьд процессын давхардал, уялдаа холбооны сул байдал, гүйцэтгэлийн үнэлгээний дутагдал зэрэг асуудлууд тулгамдсан хэвээр байна. Үүний зэрэгцээ дижитал шилжилт, олон улсын хамтын ажиллагаа, инновац нэвтрүүлэх боломжууд нь менежментийг шинэ түвшинд гаргах нөхцөлийг бүрдүүлж байна.

Цаашдын чиг хандлагын хувьд хууль сахиулах байгууллагын менежмент нь өгөгдөлд суурилсан, эрсдэлд чиглэсэн, иргэн төвтэй, ил тод, хамтын ажиллагаанд тулгуурласан хэлбэрт шилжих хандлага давамгайлж байна. Гэвч Монгол Улсын нөхцөлд эдгээр өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд институцийн уялдаа, хүний нөөцийн чадавх, технологийн бэлэн байдал, байгууллагын соёл зэрэг хүчин зүйлс бодит сорилт болж байна.

Иймд хууль сахиулах байгууллагын менежментийг боловсронгуй болгохын тулд процессын шинэчлэл, дижитал шилжилт, гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоонд суурилсан менежментийг төлөвшүүлэх шаардлагатай байна. Эдгээр өөрчлөлтийг системтэй хэрэгжүүлснээр хууль сахиулах байгууллагын үр ашиг, чанар, олон нийтийн итгэлцэл, нийгмийн аюулгүй байдлын түвшинг цогцоор нь дээшлүүлэх боломж бүрдэнэ.

Санал

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах саналыг дэвшүүлж байна. Тухайлбал:

- Хууль сахиулах байгууллагын менежментэд процессын удирдлага, гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах
- Дижитал шилжилт, мэдээллийн нэгдсэн сан, хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргалтыг хөгжүүлэх замаар удирдлагын үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх
- Хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгож, алба хаагчдын ёс зүй, манлайлал, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалтын тогтолцоог шинэчлэх
- Иргэн төвтэй, хүний эрхэд суурилсан менежментийн загварыг төлөвшүүлж, олон нийтийн оролцоо, итгэлийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байгууллагуудад нэвтрүүлэх
- Олон улсын улсын туршлага, хамтын ажиллагааг өргөжүүлэн, инновац болон ухаалаг технологийг хууль сахиулах үйл ажиллагаанд үе шаттайгаар нэвтрүүлэх зэрэг болно.

Ашигласан эх сурвалж

Cordner, G. (2016). Police administration. *Routledge, 35*, 78-80.

Development, O. f.-o. (2026). *Anti-corruption and integrity outlook.*

Donner, C. Maskaly, J., Fridell, L. A., Jennings, W. G. (2015). Policing and procedural justice. *Journal of Criminal Justice,, 1*(43), 1-12.

Ferguson, A. (2017). *The rise of big data policing.* NYU Press.

Goldstein, H. (1990). *Problem-oriented policing.* McGraw-Hill.

Kelsen, H. (1945). *General theory of law and state.* Harvard University press.

Mastrofski, S. (2019). Procedural justice and police legitimacy. *Annual Review of Criminology*(2), 373-394.

Ratcliffe, J. (2016). *Intelligence-led policing.*

Rev. (2026). *Trends in law enforcement shaping the future of policing.*

Schiliro, F. (2024). *From crime to hypercrime: Evolving threats and law enfoecement's new mandate in the AI age.*

Scott, R. W. (2003). Organizations: Rational, natural, and open systems. *Prentice Hall.* https://doi.org/5th ed.

UNODC. (2011). *Hand book on police accountability, oversight and integrity.* United nations.

UNODC. (2020). *Global study on crime trends and criminal justice6.*

UNODC. (2024). *Law enforcement and criminal intelligence.*

Баттөр, Б. (2018). Төрийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний асуудал. *Төрийн удирдлага сэтгүүл, 3*(12), 45-52.

Ц.Азбаяр. (2025). *Хууль сахиулах байгууллагын онцгой тогтолцоо.* М: Дотоод хэргийн Их сургууль.

Э. Эрдэнэбат Д.Болд, О.Эрдэнэбаяр. (2025). Цагдаагийн удирдах ажилтны харилцааны соёлын шинжилгээ. *Хууль сахиулахуй, 1*(41), 14-27.

Энхтүвшин, А. (2020). Төрийн байгууллагын процессын менежмент, шинэчлэлийн асуудал. *Удирдлагын академийн эмхэтгэл, 1*(8), 60-68.

ЭРҮҮГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЯЛТАН, ЭТГЭЭДИЙН ГАДААДАД ЗОРЧИХ, ХИЛЭЭР НЭВТРЭХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES IN IMPROVING THE LEGAL REGULATION ON THE SUSPENSION OF THE RIGHT OF CONVICTED PERSONS AND OTHER SUBJECTS TO TRAVEL ABROAD AND CROSS NATIONAL BORDERS DURING CRIMINAL JUDGMENT ENFORCEMENT PROCEEDINGS

П.Оростогоо*
Дотоод хэргийн их сургуулийн докторант, Хууль зүй, дотоод хэрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, клиникийн профессор, хурандаа
Orostogoo P.
Doctoral Candidate, University of Internal Affairs; Director of the Policy Implementation Coordination Department, Ministry of Justice and Internal Affairs; Clinical Professor; Colonel

*Хариуцлагатай зохиогч: Orostogoo0220@gmail.com

Хураангуй. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөө, ял шийтгэлийн гарцаагүй байдлыг хангахад хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих, хилээр гарах эрхийг хуульд үндэслэн зөв зохистой хязгаарлах эрх зүйн зохицуулалт чухал ач холбогдолтой боловч өнөөгийн хууль тогтоомжид уг харилцааг бүрэн, тодорхой зохицуулаагүй байна.

Энэхүү өгүүллээр эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд ялтан, этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээхтэй холбоотой хүчин төгөлдөр эрх зүйн зохицуулалт, практикт тулгамдаж буй асуудал, хүний эрхийн эрсдэл болон хууль хэрэглээний зөрчлийг судлан авч үзэв.

Судалгааны үр дүнд шийдвэр гаргах эрх бүхий субъект, хэрэглэх үндэслэл, журам, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд болон нэмэгдэл ялын хүрээний зохицуулалтыг боловсронгуй болгож, эрх түдгэлзүүлэх, сэргээх харилцааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид тодорхой хуульчлах саналыг дэвшүүлсэн болно.

Abstract. Ensuring the effectiveness of criminal sentence enforcement and the inevitability of punishment requires a clear and appropriate legal framework governing the restriction of the right to travel abroad and cross national borders of persons sentenced to non-custodial penalties and persons subjected to coercive measures. However, the current legislation does not fully and clearly regulate these legal relations.

This article examines the existing legal framework concerning the suspension and restoration of the right of convicted persons and other relevant subjects to travel abroad within the scope of criminal sentence enforcement proceedings, as well as practical challenges, human rights risks, and inconsistencies in the application of law.

The study proposes improving the legal regulation concerning the competent decision-making authority, applicable grounds and procedures, the legal status of persons subjected to coercive measures, and the scope of additional punishments, and recommends explicitly codifying the legal framework governing the suspension and restoration of such rights in the Law on Court Decision Enforcement and other relevant legislation.

Түлхүүр үг: эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ, гадаадад зорчих эрх, эрх түдгэлзүүлэх, эрх сэргээх, эрх зүйн зохицуулалт, хүний эрх, ялтан, шийдвэр гүйцэтгэл.

Keywords: criminal sentence enforcement proceedings, non-custodial penalties, coercive measures, right to travel abroad, suspension of rights, restoration of rights, legal regulation, human rights, convicted person, enforcement of court decisions.

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Оршил хэсэг. Монгол Улсад эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааны ач холбогдол нэмэгдэж байгаа боловч ялтан, этгээдийн гадаадад зорчих, хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, сэргээхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт салангид, бүрэн бус хэвээр байна. (УИХ, 2017)

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд ял шийтгүүлсэн этгээдийн гадаадад зорчих, хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх зохицуулалт тусгагдсан боловч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад уг эрхийг ямар үндэслэл, журам, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хэрэгжүүлэх асуудлыг тусгайлан тодорхойлоогүй байна.

Практикт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих эрхийг хязгаарлах ажиллагаанд шийдвэр гаргах эрх бүхий субъект, хэрэглэх үндэслэл, нэмэгдэл ял болон албадлагын арга хэмжээний хүрээнд хэрэглэх эсэх асуудал тодорхой бус байгаагаас хууль хэрэглээний зөрүүтэй ойлголт, байгууллага хоорондын маргаан үүсэх нөхцөл ажиглагдаж байна.

Түүнчлэн өнөөгийн зохицуулалтаар зарим төрлийн албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих, хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн үндэслэл хангалтгүй байгаа нь нэг талаас эрүүгийн хариуцлагаас зайлсхийх эрсдэлийг нэмэгдүүлж, нөгөө талаас хүний эрх, чөлөөтэй зорчих эрхтэй холбоотой гомдол, маргаан үүсэхэд нөлөөлөх нөхцөл болж байна. (ХЭҮК, 2026)

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь Эрүүгийн хуульд заасан хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний төрлөөс хамаарч ялтан этгээдийг хүлээн авч, хяналтад авахаас эхлээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхэлснийг мэдэгдэх, эрх үүрэг танилцуулах, оршин суух хаягийг тодруулах, хаягаар очиж биечилсэн хяналт тавих, хууль тогтоомжид заасан хугацаанд бүртгэл хяналтад авах, гуравдагч этгээдэд үүрэг хүлээлгэх, мэдэгдэл хүргүүлэх, шүүхийн шийдвэрт заасан эд хөрөнгийг хурааж улсын орлого болгох, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийсэн ялтан, этгээдийг эрэн сурвалжилж олж тогтоох, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, гаргасан зөрчлийн дагуу холбогдох шалгалтыг явуулж, баримтжуулж, сануулах, улмаар хуульд заасан үндэслэлээр ял солих хүртэл хуульд заасан олон төрлийн процесс ажиллагааг явуулдаг.

Ач холбогдол. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн биелэлтийг бодитой хангах, ялтан этгээдийн хуульд захирагдах хандлагыг төлөвшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулах, нийгмийн хэв журам, шударга ёс, иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн эрүүгийн бодлогын чухал хэрэгжилтийн механизм болох ач холбогдолтой.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг ялтан этгээдийн нөхцөл байдал, зан үйл, хуульд заасан шаардлагад нийцүүлэн уян хатан, шат дараалсан, хяналттай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, ял эдлүүлэх явцын хууль ёсны байдал, хэрэгжилтийн үр нөлөө, төрийн хяналтын нэгдмэл байдлыг хангадаг давуу талтай юм.

Дээрх процесс ажиллагааг хэрхэн явуулах үндэслэл журмыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актуудаар зохицуулсан байдаг боловч зарим процесс ажиллагааны арга хэлбэрийг хууль, журмаар бүрэн зохицуулаагүйгээс эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүрэн явуулахад хүндрэл үүсэх, ял завших, нөгөөтэйгүүр ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөх зэрэг сөрөг үр дагавар байсаар байна.

Тухайлбал эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ялтан, этгээд эрүүгийн хариуцлагаас зайлсхийж, Монгол Улсын хилээр нэвтэрч гадаад улс руу оргон зайлах тохиолдол байдаг бөгөөд өнөөгийн хүчин

төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид ял, албадлагын арга хэмжээнээс зайлсхийсэн ялтан, этгээдийн хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх нөхцөл, журмаар бүрэн зохицуулагдаагүй байдаг.

Эрх зүйн хийдлийн хор уршиг.

Ял, албадлагын арга хэмжээнээс зайлсхийсэн ялтан, этгээдийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх үндэслэл, журам хууль тогтоомжид тодорхой, бүрэн зохицуулагдаагүйгээс эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ялтан этгээд гадаад улс руу оргон зайлж, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр биелэгдэхгүй болох, улмаар ял завших нөхцөл бодитоор бүрдэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Энэхүү зохицуулалтын орхигдол нь шийдвэр гүйцэтгэх байгууллага, хилийн болон бусад эрх бүхий байгууллагын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, эрх хэмжээний хэрэгжилтэд хүндрэл үүсгэж, ялтан, этгээдийн зорчих эрхийг ямар нөхцөлд хязгаарлах, хэзээ сэргээх талаар нэгдсэн процессгүй байдлаас шалтгаалан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагааны үр нөлөө, шуурхай байдал буурахад хүргэж байна.

Нөгөө талаас, хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх ажиллагааны шалгуур, хугацаа, хяналтын механизм тодорхой бус байгаа нь эрх бүхий байгууллагын практикт ялгаатай хэрэглээ бий болгох эрсдэлтэй бөгөөд энэ нь хүний чөлөөтэй зорчих эрх, хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр хязгаарлах, эсхүл эсрэгээрээ хяналтаас мултран ял завших боломжийг давхар үүсгэх замаар хүний эрхийн болон хууль хэрэгжилтийн сөрөг үр дагаврыг дагуулж байна.

Ялтан, этгээдийн хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх нөхцөл, журам тодорхой бус байгаа нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийх бодит эрсдэлийг бий болгож байгаа бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зохион байгуулсан “Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилт, тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлаар хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд практик хүндрэл, хэрэгжилтийн саад бэрхшээл байгааг хөндөн хэлэлцсэн нь эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байгааг харуулж байна.

Манай улсад сүүлийн 10 жилд хорихоос өөр төрлийн ял эдэлж буй иргэдийн тоо өсжээ. Өнөөдрийн байдлаар нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 273, эрх хасах ялаар шийтгүүлсэн 1530, торгох ялаар шийтгүүлсэн 1685, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн 1315 иргэн байна. Тус алба өнгөрсөн хугацаанд торгох ялаар шийтгүүлсэн 8531 иргэн, 10 хуулийн этгээдэд холбогдох 13.1 тэрбум төгрөгөөс 7.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэнийг Ялын бүртгэл, хяналтын хэлтсийн дарга, хурандаа С.Зул-Очир онцлов. Эрх хасах ялаар шийтгүүлсэн нийт иргэний 84.2 хувь тээврийн хэрэгсэл жолоод эрхээ хасуулсан байгаа бол 12 хувь нь нийтийн албанд ажиллах эрхээ хасуулжээ (Болд.Б, 2022).

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх нөхцөл, журмыг хангалттай хэмжээнд зохицуулсан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны А/80 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэл хөтлөх журам” (ШШГЕГ, 2020)-аар илүү нарийвчлан зохицуулсан байдаг бол тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн “гадаадад зорчих, цагаачлахыг хориглохоор хуульчилсан байна (УИХ, 2017). Үүнээс өөрөөр эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ялтан, этгээдийн хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх нөхцөл, журмыг бүрэн зохицуулаагүй нь ялтан, этгээдийн зүгээс эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийх, нөгөө талдаа ажиллагааны явцад хүний эрхийн зөрчил үүсэхэд нөлөөлдөг тулгамдсан асуудал болж байна.

Монгол Улсад 2021 оноос хэрэгжиж эхэлсэн зорчих эрхийг хязгаарлах ялын практикт цахим бугуйвч, электрон мониторингийн хяналт ашиглаж байгаа боловч эрх зүйн зохицуулалт, техникийн болон процедурын зарим асуудал бүрэн шийдэгдээгүй хэвээр байгаа нь ялтан этгээдийн хөдөлгөөнд бодит, тасралтгүй хяналт тавих боломжийг хязгаарлаж, улмаар ял завших болон хүний эрхийн маргаан үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байгааг судлаачид тэмдэглэсэн байна. (Д.Батцогт, 2025)

Нэг. Эрх зүйн зохицуулалт болон гадаадад зорчих эрх түдгэлзүүлэх, сэргээх ажиллагааны өнөөгийн байдал,

1. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх асуудлыг зохицуулсан зохицуулалт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хуульчлагдаагүй бөгөөд дараах хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлэх, сэргээх саналыг Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газарт хүргүүлэн, шийдвэрлүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг “эрүүгийн ял шийтгүүлсэн бол уг ялыг эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх хүртэл;” хугацаагаар түдгэлзүүлэхээр хуульчилсан. (legalinfo, 1993)

Мөн хуулийн 5.1.4-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол түдгэлзүүлэхээр хуульчилсан байна.

- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2-т “шүүхээр ял шийтгүүлсэн бол ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх хүртэл;” гэж заасан байдаг (УИХ, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 2010). Үүний дагуу гадаад улсын иргэний Монгол улсын хилээр гарах эрхийг тус тус түдгэлзүүлэх саналыг Гадаадын иргэн, харьяатын газарт хүргүүлэн шийдвэрлүүлж байгаа болно.

Мөн хуулийн 34.2.3-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэхээр хуульчилсан байна.

Дээрх зохицуулалтуудын хүрээнд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж байгаа боловч одоогийн хууль тогтоомжид хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны явцад ямар үндэслэлээр, ямар тохиолдолд, хэний шийдвэрээр ялтан, этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхийг хуульчлаагүй орхигдуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.15 дахь хэсэг, мөн 59 дүгээр зүйлд заасан бүлэг зохицуулалт нь зөвхөн иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээний хүрээнд хийгдэх ажиллагааг зохицуулсан тул хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэх боломжгүй байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3-т “Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид, ахлах шийдвэр гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл ажлын 3 өдрийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлэх”-ээр, мөн хуулийн 271.3.5-д “Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн удирдах албан тушаалтны гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх” эрхтэй байхаар тус

тус хуульчилсан бөгөөд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан “ерөнхий шийдвэр гүйцэтгэгч” гэсэн ойлголт хуульчлагдаагүйгээс хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гаргах эрх бүхий субъект тодорхой бус байна.

Мөн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээхтэй холбоотой харилцааг журмаар зохицуулах боломжийг хуульчлаагүйгээс нарийвчилсан зохицуулалтыг журамлах боломжгүй байна. Практикт энэхүү зохицуулалттай холбоотой дараах жишээнүүдийг түүвэрлэн авч үзлээ. Тухайлбал:

1. ШШГБ-аас хил нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн этгээдэд хуурамч паспорт олгосон бодит хэрэг

2026 онд прокурорын байгууллагаас мэдээлснээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Монгол Улсын хилээр нэвтрэх эрхийг нь түдгэлзүүлсэн иргэнд албан тушаалтан хуурамч гадаад паспорт олгож, хахууль авсан хэрэг илэрч, шүүхэд шилжсэн байна. Энэ нь хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх ажиллагааны хэрэгжилт, байгууллага хоорондын хяналт, мэдээллийн уялдаа хангалтгүй тохиолдолд ялтан, этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийж, улмаар гадаад улс руу гарах бодит боломж үүсэж болохыг харуулсан бодит жишээ юм. (Б.Батчимэг, 2026)

2. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийж оргон зайлсан бодит хэрэг

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022/ШЦТ/249 дугаар шийтгэх тогтоолын хэрэгжилтийн явцад ялтан Б.А-д оногдуулсан 500,000 төгрөгийн торгох ялыг сайн дураар биелүүлэх болон сунгасан хугацаа олгосон боловч ялтан шийдвэрийг биелүүлээгүй, улмаар оргон зайлсан байна. Иймд шүүх биелэгдээгүй торгох ялыг 33 хоногийн хорих ялаар сольж шийдвэрлэсэн нь хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх ажиллагаанд зайлсхийх бодит эрсдэл оршиж байгааг харуулж байна. (сан, 2022)

3. Судалгаагаар тогтоогдсон бодит практик хүндрэл

Дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээний “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” сэтгүүлд Б.Уянга судлаачийн 2024 онд нийтлүүлсэн өгүүлэлд шийдвэр гүйцэтгэгчид хорихоос өөр төрлийн ялаас оргон зайлсан ялтныг олж тогтоосон ч түүнийг хууль ёсоор саатуулах, баривчлах нарийвчилсан зохицуулалт дутмаг байдгаас практикт албан өрөөндөө байлгах, хувийн хяналт дор авч явах зэрэг хүний эрхийн эрсдэлтэй нөхцөл үүсдэг талаар дурдсан байна. Судалгаанд мөн ял эдлэхээс зайлсхийсэн, оргон зайлсан этгээдэд холбогдох ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээх, хариуцлага тооцох зохицуулалтын цоорхой байгааг тэмдэглэсэн нь таны хөндөж буй асуудлын бодит практик үндэслэл болж байна. (Б.Уянга, 2024)

Дээрх бодит хэрэг, шүүхийн шийдвэр болон эрдэм шинжилгээний судалгаанаас үзэхэд хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаанд ялтан, этгээд шийдвэр гүйцэтгэхээс зайлсхийх, оргон зайлах, хилээр гарах боломж ашиглах бодит эрсдэл практикт оршиж байна. Мөн хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, оргон зайлсан этгээдийг саатуулах, ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээх зэрэг процесс ажиллагааны эрх зүйн зохицуулалт бүрэн бус байгаа нь шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажиллагааны үр нөлөөг сулруулж, байгууллага хоорондын уялдаа, хяналтыг хүндрүүлэх нөхцөл болж байна.

Иймд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдох процессын нарийвчилсан зохицуулалтыг боловсронгуй болгож, ял завших боломжийг бууруулахын зэрэгцээ хүний эрхийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Одоогийн эрх зүйн зохицуулалтуудын хүрээнд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанаас ялтан,

этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааны явцад дараах асуудлууд үүсч байна. Тухайлбал:

- Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад Монгол Улсын иргэн болон гадаад улсын харьяат ялтан, этгээдийн гадаадад зорчих, хилээр нэвтрүүлэх эрхийг түдгэлзүүлж байгаа ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар ял шийтгүүлсэн этгээдийн гадаадад зорчих, цагаачлах, хилээр гарах эрхийг түдгэлзүүлэхээр хуульчлахдаа нэмэгдэл ялаар шийтгүүлсэн этгээдэд уг зохицуулалтыг хэрэглэх эсэх нь тодорхой тусгагдаагүйгээс үндсэн болон нэмэгдэл ялаар шийтгүүлснээс үл хамаарч, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийн гадаадад зорчих болон хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлж байгаагаас хүний эрх зөрчигдөх нөхцөл байдал үүсч байна.

Тухайлбал нийтийн албанд томилогдох эрх хасах ял, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах нэмэгдэл ялаар шийтгүүлсэн ялтны гадаадад зорчих, хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх нь эрх зүйн хувьд ач холбогдолгүй бөгөөд тухайн ялтны шүүхийн шийдвэрээр хязгаарлаагүй чөлөөтэй зорчих эрх, оршин суух газраа чөлөөтэй сонгох наад захын эрх зөрчигдөхөд хүрч, Хүний эрхийн байгууллагаас буруутгах үндэслэл болдог боловч Прокурорын байгууллагаас хууль тогтоомжид үндсэн болон нэмэгдэл “ял” гэсэн ганцхан ойлголт хуульд байгаа тул нэмэгдэл ялаар шийтгүүлсэн ялтны гадаадад зорчих, хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх ёстой гэсэн байр суурийг илэрхийлж, маргаан үүсэх нөхцөл болж байна.

- Мөн өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар дээр дурдсанчлан тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн “гадаадад зорчих, цагаачлахыг хориглохоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 187 дугаар зүйлийн 187.1.1 дэх хэсэгт хуульчилснаас өөрөөр албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих, хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх зохицуулалт хуульчлагдаагүйгээс Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын нэг төрөл болох албадлагын арга хэмжээ авагдсан этгээд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх боломжийг хязгаарлах боломжгүй нөхцөл байдалтай байна.

- Өнөөгийн хууль тогтоомжийн хүрээнд Эрүүгийн хуульд заасан 7 төрлийн албадлагын арга хэмжээнээс зөвхөн тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн гадаадад зорчих, хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх боломжтой байгаа бөгөөд хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дахь гадаадад зорчих түдгэлзүүлэх зохицуулалтыг (УИХ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуул, 2017) хэрэглэн, шийдвэрлэх практик тогтоод байна.

Энэ хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан этгээд Эрүүгийн хариуцлагаас зайлсхийх боломжийг тодорхой хэмжээнд хязгаарлахад эерэг нөлөө үзүүлж байгаа боловч хуулийг нэг мөр хэрэглэх зарчимд харшилж, гомдол, маргаан гарсан тохиолдолд эргээд уг ажиллагааг хүний эрхийн байгууллага болон шүүхээс буруутгах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулж байгаа байгууллага, албан тушаалтан гэм хохирол төлөх, өр төлбөрт орох эрсдэл дагуулж байдгийг анхаарч эрх зүйн зохицуулалтыг туйлын тодорхой, ойлгомжтой болгох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Хоёр. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим арга зам

Өнөөгийн эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийхэд Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар ялтан, этгээдүүдийн гадаадад зорчих, хилээр гарах эрхийг түдгэлзүүлэхээр хуульчилсан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтан, этгээдүүдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тусгайлсан зохицуулалт байхгүй, шийдвэр гаргах субъектийг тодорхойлоогүй орхигдуулсан байна.

Бидний хийсэн судалгааны материалаас үзэхэд Монгол Улсад ялтан, этгээдийн

гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалтыг илүү нарийвчлан боловсронгуй болгох шаардлага тулгамдаж байгаа бөгөөд үүнийг гадаад орнуудын туршлагад тулгуурлан шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна. Тухайлбал:

Нэгдүгээрт, АНУ-ын туршлагаар шүүхийн хяналтад байгаа этгээдийн гадаад зорчих асуудлыг “урьдчилан зөвшөөрөл авах” зарчмаар зохицуулж, гадаад зорчих зөвшөөрлийг зөвхөн шүүх эсхүл хяналтын ажилтны бичгээр олгодог тогтолцоог нэвтрүүлэх боломжтой байна. (institute, 2026)

Хоёрдугаарт, АНУ-д зарим тохиолдолд шүүх, хууль сахиулах байгууллагаас хураасан паспортыг буцаан олгох, сэргээх ажиллагааг тодорхой нөхцөл, баримт бичиг, албан зөвшөөрөлтэй холбон журамласан байдаг тул Монгол Улсад ч хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх-сэргээх тусгай процедур-ыг хуульчлах шаардлагатай байна. (travel.state, 2026)

Гуравдугаарт, Их Британи (Англи-Уэльс)-ийн практикт электрон мониторинг, GPS хяналт, байршлын технологийг пробац, ял эдлүүлэх ажиллагаанд өргөн ашиглаж байгаа нь оргон зайлах, зөвшөөрөлгүй шилжилт хөдөлгөөнийг эрт илрүүлэх давуу талтай тул зорчих эрхийг хязгаарлах ял болон шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд цахим хяналтын хэрэглээг өргөжүүлэх нь үр дүнтэй арга зам болно.

Дөрөвдүгээрт, Их Британийн туршлагаас харахад электрон мониторингийг зөвхөн хяналтын хэрэгсэл бус, шүүх, цагдаа, пробац, дотоод хэргийн байгууллагын мэдээллийн нэгдсэн тогтолцоотой уялдуулан ашигладаг тул Монгол Улсад ШШГБ, Хил хамгаалах байгууллага, ЦЕГ, ГИХГ-ын мэдээллийн нэгдсэн сан, автомат мэдэгдлийн систем бий болгох шаардлагатай байна. (Justice, 2024)

Тавдугаарт, хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл, эрсдэлийн шалгуур, хугацаа, сунгалт, цуцлалт, гомдол гаргах журмыг хуульд тодорхой тусгаж өгөх нь хүний эрхийн зөрчил, байгууллагын дур зоргын хэрэглээг бууруулах ач холбогдолтой.

Зургаадугаарт, гадаад зорчих зөвшөөрөл хүсэх тохиолдолд зорчих зорилго, хугацаа, буцах баталгаа, оршин суух хаяг, хяналтын нөхцөлийг заавал үнэлдэг эрсдэлд суурилсан механизмыг нэвтрүүлэх нь ял завших эрсдэлийг бууруулна. (Ruiz, 2026)

Долоодугаарт, оргон зайлсан этгээдийг олж тогтоосны дараах саатуулах, шилжүүлэх, хяналтад авах процесс ажиллагааг тусгайлан зохицуулж, шийдвэр гүйцэтгэгчийн эрх хэмжээ, хүний эрхийн баталгааг нарийвчлан хуульчлах шаардлагатай байна.

Наймдугаарт, хилээр гарах эрх түдгэлзүүлсэн этгээдийн мэдээллийг хил, паспорт, консулын болон иргэний бүртгэлийн системтэй бодит хугацаанд холбох замаар хуурамч баримт бичиг ашиглан оргон зайлах эрсдэлийг бууруулах боломжтой.

Есдүгээрт, гадаадад оргон зайлсан ялтан, этгээдтэй холбоотой эрх зүйн туслалцаа, шилжүүлэн өгөх болон олон улсын хамтын ажиллагааны механизмыг шийдвэр гүйцэтгэх эрх зүйтэй уялдуулах нь практик үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Аравдугаарт, дээрх шинэчлэлийг хэрэгжүүлснээр эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөө дээшилж, ял завших боломж хумигдахын зэрэгцээ зорчих эрхийг хязгаарлах ажиллагаа хууль ёсны, ил тод, хүний эрхэд нийцсэн стандарттай болох боломж бүрдэх юм.

Гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, технологийн шийдэл, байгууллага хоорондын хамтын ажиллагааны туршлагаас үзэхэд ялтан, этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд зөвхөн эрх хязгаарлах арга хэмжээг хуульчлах бус, түүнийг хэрэгжүүлэх үндэслэл, шалгуур, хугацаа, сэргээх журам, шүүхийн хяналт, гомдол шийдвэрлэх механизмыг цогцоор нь нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Мөн электрон мониторинг, GPS хяналт, мэдээллийн нэгдсэн сан, байгууллага хоорондын автомат мэдээлэл солилцоо, олон улсын эрх зүйн хамтын ажиллагааг шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай

уялдуулан нэвтрүүлэх нь ялтан, этгээд оргон зайлах, хилээр хууль бусаар нэвтрэх, ял завших эрсдэлийг бууруулахын зэрэгцээ хяналтын бодит үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой байна.

Дүгнэлт

Дээрх эрх зүйн зохицуулалт, бодит хэрэг, шүүхийн практик, статистик мэдээлэл болон эрдэм шинжилгээний судалгаанд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд Монгол Улсад эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ялтан, этгээдийн гадаадад зорчих, хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, сэргээхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт салангид, хийдэлтэй, хууль хэрэглээний хувьд нэгдмэл бус хэвээр байгаа нь практикт ял завших, оргон зайлах, хүний эрхийн зөрчил, байгууллага хоорондын маргаан үүсэх бодит нөхцөл болж байна.

Ялангуяа хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх ажиллагаанд шийдвэр гаргах эрх бүхий субъект, хэрэглэх үндэслэл, журам, хугацаа, сэргээх нөхцөл, нэмэгдэл ял болон албадлагын арга хэмжээнд хэрэглэх хүрээ тодорхой бус байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөө, хууль ёсны байдал, хүний эрхийн баталгаанд сөргөөр нөлөөлж байгааг бодит кейсүүд болон судалгааны үр дүн нотолж байна.

Нөгөө талаас, гадаад орнуудын туршлагаас харахад ялтан, этгээдийн зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зөвхөн хориглох шинжтэй зохицуулалт хангалтгүй бөгөөд урьдчилан зөвшөөрөл олгох тогтолцоо, эрсдэлд суурилсан үнэлгээ, электрон мониторинг, GPS хяналт, мэдээллийн нэгдсэн сан, байгууллага хоорондын автомат мэдээлэл солилцоо, олон улсын эрх зүйн хамтын ажиллагааг цогцоор нь нэвтрүүлсэн байх шаардлагатай болдог нь харагдаж байна.

Иймд Монгол Улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтан, этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх ажиллагааны тусгайлсан зохицуулалтыг бий болгож, шийдвэр гаргах субъект, процесс ажиллагаа, шүүхийн болон хүний эрхийн хяналтын механизмыг тодорхой хуульчлахын зэрэгцээ технологид суурилсан хяналтын тогтолцоог хөгжүүлэх нь эрх зүйн хийдлийг арилгах үндсэн арга зам болно. Энэхүү зохицуулалтыг боловсронгуй болгосноор эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит хэрэгжилт, шүүхийн шийдвэрийн биелэлт, төрийн хяналтын үр нөлөө дээшлэхийн зэрэгцээ ялтан, этгээдийн чөлөөтэй зорчих эрхийг хууль ёсны, үндэслэлтэй, хүний эрхэд нийцсэн стандартаар хязгаарлах эрх зүйн орчин бүрдэх боломжтой гэж дүгнэж байна.

Санал

Иймд судлаачийн зүгээс ялтан, этгээдүүдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Шийдвэр гүйцэтгэгч нь Иргэний болон Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчээс бүрдэнэ” гэсэн агуулгатай зохицуулалтыг нэмэх;

2. Эсхүл хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны даргын ялтан, этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх асуудлыг шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга шийдвэрлэдэг байхаар зохицуулалтыг оруулж өгөх;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн бүлэг зохицуулалтаар иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх харилцааг зохицуулж байгаатай ижил ялтан, этгээдүүдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл журмыг тодорхойлсон бүлэг зохицуулалтыг бий болгох;

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар “Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгч, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, шийтгүүлсэн болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, тоо бүртгэл хөтлөх

журам”-ыг 2020 оны 02 дугаар сард батална болов Улсын ерөнхий прокурортой зөвшилцөөгүй гэсэн үндэслэлээр 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр хүчингүй болгосон тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтан, этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, прокурорын байгууллагатай хамтран батлах зохицуулалтыг хуульчилж өгөх;

5. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хууль болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд шүүхээс ял шийтгүүлсэн этгээдээс гадна Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих, цагаачлах, хилээр гарах эрхийг түдгэлзүүлдэг байхаар зохицуулалт оруулж өгөх;

6. Мөн өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар ял шийтгүүлсэн этгээдийн гадаадад зорчих, цагаачлах, хилээр гарах эрхийг түдгэлзүүлэхээр хуульчлахдаа нэмэгдэл ялаар шийтгүүлсэн этгээдэд уг зохицуулалтыг хэрэглэх эсэх нь тодорхой тусгагдаагүйгээс хүний эрхийн зөрчил маргаан гардаг тул зөвхөн үндсэн ялаар шийтгүүлсэн ялтны гадаадад зорчих, цагаачлах, хилээр гарах эрхийг түдгэлзүүлэхээр тодорхой тусгах /нэмэгдэл ялаар шийтгүүлсэн ялтанд уг арга хэмжээг хэрэглэхгүй байх;

7. Мөн хууль эрх зүйн зохицуулалтад ялтан, этгээдийн гадаадад зорчих, цагаачлах, хилээр гарах эрхийг түдгэлзүүлэхээс гадна түдгэлзүүлсэн эрхийг “сэргээх” үндэслэл журмыг хуульчлах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материал

1. institute, L. l. (2026). *28 CFR § 2.41 - Travel approval.* Retrieved from Cornell Law School: https://www.law.cornell.edu/cfr/text/28/2.41

2. Justice, M. o. (2024, 4 25). *Overview of Electronic Monitoring Statistics.* Retrieved from Cookies on GOV.UK: https://www.gov.uk/government/statistics/electronic-monitoring-statistics-publication-march-2024/technical-note

3. legalinfo. (1993, 12 24). - *Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хууль.* Retrieved from legalinfo: https://legalinfo.mn/mn/detail?lawId=345

4. Ruiz, R. R. (2026). *Post Conviction Supervision.* Retrieved from United States Probation and Pretrial Services: https://www.flsp.uscourts.gov/traveling

5. travel.state. (2026, 5 13). *Get a Passport On or After Probation or Parole.* Retrieved from travel.state: ttps://travel.state.gov/en/passports/contact-support/legal-matters/probation-parole.html

6. Б.Батчимэг. (2026, 4 6). *Монгол Улсын хилээр нэвтрэх эрхгүй хүнд хуурамч гадаад паспорт олгож, хахууль авчээ.* Retrieved from isee: https://isee.mn/n/89524

7. Б.Уянга. (2024). Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдсан зарим асуудал. *Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал*, 73-88.

8. Болд.Б. (2022, 11 18). *Торгох ялаар шийтгүүлсэн иргэдээс 7.5 тэрбум төгрөг төвлөрүүлжээ.* Retrieved from МОНГОЛЫН МЭДЭЭ: https://www.montsame.mn/en/read/308337

9. Д.Батцогт. (2025, 3 10). *Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт, цаашдын чиг хандлага.* Retrieved from ДХИС сэтгүүлийн систем: https://journal.uia.gov.mn/

10. сан, Ш. ш. (2022, 4 4). *ХУД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны тогтоол.* Retrieved from shuukh.mn: https://shuukh.mn/single_case/65582?daterange=2022-04-04%20-%202022-04-04&id=1&court_cat=2&bb=1

11. УИХ. (2010, 7 8). *Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль.* Retrieved from legalinfo: https://legalinfo.mn/mn/detail/211

12. УИХ. (2017, 6 9). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуул.* Retrieved from legalinfo.mn: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12701

13. ХЭҮК, М. У. (2026). *Иргэний болон улс төрийн эрх.* Retrieved from nhrcm:

https://nhrcm.gov.mn/#/page/42/post/view/6870

14. ШШГЕГ. (2020). *Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэл хөтлөх журам.* Retrieved from Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар: https://cd.gov.mn/index/index.php

ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА
STATUTE OF LIMITATIONS AND INTERNATIONAL EXPERIENCE

Г.Батжаргал*
Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
Batjargal G.
Professor of the Private Law Department, School of Law and Social Sciences, Ph.D., Police Lieutenant Colonel

*Хариуцлагатай зохиогч: Gerelbatjargal0@gmail.com

Хураангуй: Хөөн хэлэлцэх хугацааны агуулга, мөн чанар, зорилгыг тодорхойлох онол, үзэл баримтлал, зарчим болон түүнийг тоолох (эхлэх, түр зогсоох, тасалдах, дуусах) арга зүй нь иргэнлэг болон нийтлэг эрх зүйн уламжлал бүхий улсуудад ялгаатай байдлаар тодорхойлогдож ирсэн байна. Өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацааны хязгаарыг тодорхойлох улс орнуудад харилцан адилгүй байна.

Уг сэдэвтэй холбогдуулан Англи-Саксоны эрх зүйн бүл болон Ром-Германи эрх зүйн бүлтэй улс орнууд болох ХБНГУ, БНФУ, Япон улс, АНУ, ИБУИНХУ гэх мэт улсуудын хөөн хэлэлцэх хугацааны талаар дэлгэрэнгүй судлан үзлээ.

Энэхүү судалгааны зорилго нь хөөн хэлэлцэх хугацааны ойлголтыг Англи-Саксоны эрх зүйн бүл болон Эх газрын эрх зүйн бүлтэй улс орнуудыг харьцуулан судалж, хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоо, түүний хэрэглээний талаар тухайн улс орны эрх зүйн орчинд хэрхэн тодорхойлогдож, хөгжиж ирснийг харуулах юм. Судалгааны үр дүнд, улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлох, тоолох арга зүйн ялгаа, түүний эрх зүйн практик нь тухайн улс орны эрх зүйн системийн онцлог, түүх, соёлд хэрхэн нийцэж байгаа талаар гүнзгий ойлголт авч болох юм.

Abstract: The theory, concept, principles for determining the content, nature, and purpose of the limitation period, as well as the methodology for calculating it (commencement, suspension, interruption, and expiration), are defined differently in countries with civil law and common law traditions. In other words, the definition of the limitation period varies from country to country.

In this regard, the limitation period in countries with Anglo-Saxon and Romano-Germanic legal systems, such as the Federal Republic of Germany, the Federal Republic of Germany, Japan, the United States, and the United Kingdom, is examined in detail.

The purpose of this study is to compare the concept of the limitation period in Anglo-Saxon and civil law countries and to demonstrate how the limitation period system and its application have been defined and developed in the legal environment of each country. This study will provide a deeper understanding of the differences in the methodologies for determining and calculating the limitation period in different countries, as well as how their legal practices relate to the specific features of the legal system, history, and culture of each country.

Түлхүүр үгс: Хөөн хэлэлцэх хугацаа, Англи-Саксоны, Эх газрын эрх зүйн бүл, материаллаг, процессын эрх зүй

Keywords: Statute of limitations, Anglo-Saxon, Continental legal tradition, substantive law, procedural law

Хөөн хэлэлцэх хугацаа түүний эрх зүйн агуулга нь улс орнуудын эрх зүйн уламжлал, эрх зүйн системийн онцлогтой уялдаатайгаар өөр өөрөөр тодорхойлогддог. Хөөн хэлэлцэх хугацааг иргэнлэг эрх зүйн уламжлал бүхий цөөнгүй улс голчлон ***материаллаг эрх зүйн хэм хэмжээ*** гэж авч үздэг бөгөөд түүний эрх зүйн тодорхой байдал буюу хууль ёсны байдлыг хангах үүргийг чухалчлан үздэг. Тухайлбал Итали, Австри, Грек, Унгар, Польш (Poland, 1997) зэрэг улс хөөн хэлэлцэх хугацааг материаллаг эрх зүйн асуудал гэж үздэг бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг хүчингүй

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

болгох нь үндэслэлтэй төдийгүй шийтгэл оногдуулахад буцаан хэрэглэдэг гэж үздэг байна.

Үүний эсрэгээр, зарим эрх мэдлийн хүрээнд хөөн хэлэлцэх хугацааг ***процессын эрх зүйн асуудал*** гэж үздэг бөгөөд эн хандлагыг баримталж буй улсуудын хувьд цаг хугацаа өнгөрөхөд нотлох баримт алдагдахад хүргэдэг. Учир нь гэрчүүд үйл явдлыг хамгийн сайндаа хязгаарлагдмал хэмжээгээр санаж, бусад нотлох баримтыг олж авах боломжгүй байдаг учир нь хууль бусаар шийтгэгдэх, яллах аюул нэмэгдэнэ гэж үздэг. Мөн эд хөрөнгийн эрхийг хөндөхөөс илүүтэйгээр шүүхийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгт нь анхаардаг. ХБНГУ, БНФУ, БНЭнэтхэг зэрэг улсад хөөн хэлэлцэх хугацааг шүүх ажиллагаанд саад учруулдаг хэмээн процессын хуулийн хүрээнд тодорхойлж, процессын шинж чанарыг онцолсон байдаг.

Зарим улс ***материаллаг болон процессын аль алиных нь ангиллын элементийг хүлээн зөвшөөрч, холимог арга барилыг баримталдаг*** байна. Тухайлбал, Эстони, Испани, Швед зэрэг улс энэ хоёр үзэл хандлагын аль алийг дэмжсэн холимог шинжтэй байна. Эстони улсад зохиогчийн эрхийн хөөн хэлэлцэх хугацааг процессын эрх зүйн хүрээнд авч үздэг бол, Испани улсад зохиогчийн эрхийг цэвэр материаллаг эрх зүйн хүрээнд хөөн хэлэлцэх хугацааг авч үздэг. (Laches, 1980)

Энэхүү илтгэлээр хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлох, тоолох арга зүйн ялгаа, түүний улс орнуудад хэрхэн хэрэглэгдэж, хөгжиж буй талаар судлан авч үзлээ.

Хөөн хэлэлцэх хугацаа нь талуудын хооронд хууль ёсны тодорхой байдлыг бий болгож, маргаан, хариуцлагыг хязгаарлахад чиглэгддэг. Мөн эрх нь зөрчигдсөн талыг хариуцлагатай байх, эрхээ цаг хугацаанд нь эдлэхийг шаардахын зэрэгцээ хариуцагчийг хязгааргүй хүлээлтийн дарамтаас хамгаалах замаар нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Энэ эрх зүйн уламжлал бүхий улсууд төрийн бодлогын улмаас ихэнх иргэний үйлдлүүд нь тодорхой хугацаа өнгөрсний дараа хариуцагчийг тухайн үйлдлийнхээ дагуу шүүхэд өгөх боломжгүй болдог онцлогтой байдаг. Цаг хугацаа өнгөрөхөд нөхөн олговор олгох үйл ажиллагааг хориглохтой холбоотой хоёр өөр эрх зүйн дэглэм байдаг. Эхний дэглэм нь 1980 оны Хязгаарлалтын тухай хуульд тусгагдсан бөгөөд энэ нь янз бүрийн төрлийн үйл ажиллагааны хязгаарлалтын тодорхой хугацааг шууд заасан байдаг. Хоёр дахь дэглэм нь эргэн тойрны бүх нөхцөл байдлыг харгалзан тухайн хэргийн улмаас шударга ёсны дагуу арга хэмжээ авах хугацааг хязгаарласан эсэхийг тодорхойлдог laches-ийг шударгаар хамгаалах явдал юм. (Graham Virgo, 2006)

laches нь тодорхой нөхцөлд хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоож болох үндэслэл мөн бөгөөд шүүгч шударга байдлыг хангах, *хууль ёсны хамгаалалтыг хэрэгжүүлэхийн* тулд тэгш эрхийн үүднээс хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох явдал мөн.

Хөөн хэлэлцэх хугацаа нь талуудын хооронд хууль ёсны тодорхой байдлыг бий болгож, маргаан, хариуцлагыг хязгаарлахад чиглэгддэг. Энэ нь нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Эрх зүйн бүлийн хувьд харьцуулан үзвэл Англи-Саксоны эрх зүйн бүл бүхий орнуудад хөөн хэлэлцэх хугацааны ойлголт бараг байдаггүй бөгөөд зөвхөн зарим төрлийн хөнгөн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэдэг онцлогтой. Харин хөөн хэлэлцэх хугацааны ойлголтыг Эх газрын буюу Ром-Германы эрх зүйн бүл бүхий орнуудад гол төлөв хэрэглэдэг байна. Тэр дундаа эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацаа тооцох арга зүйн асуудал нь нэлээд маргаантай байдаг.

Энэ нь гэмт хэргийг үйлдсэн тэр л цаг хугацаанд нь түүнд тохирсон хариуцлага ногдуулах ёстой, эсхүл гэмт хэргийн нийгмийн хор аюул хэзээ ч алба болдоггүй гэсэн эсрэг тэсрэг байр суурь, хандлагын зөрүүгээс үүсдэг. Нөгөө талаар аливаа үйлдлийг эрүүлжүүлэх нийгмийн үзэл хандлага, гэмт хэргийн объектив талын шинжийн хувьсал, тэр дундаа үйлдлийн арга хувьсан өөрчлөгдөж буй байдал зэрэг

нь гэмт хэргийн талаарх нийгмийн үзэл хандлагад өөрчлөлт бий болгож, аливаа үйлдлийг гэмт хэрэгт тооцох материаллаг болон процессын эрх зүй хувьсан өөрчлөгдөж ирсэн байна.

Эрх зүйн бүлийн хувьд ялгаатай улсууд хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй онолын үндэслэлийг харьцуулсан байдлыг нэгтгэн харуулбал:

Хүснэгт №1. Эрх зүйн бүлийн хувьд ялгаатай улсууд хөөн хэлэлцэх хугацаа тогтооож буй онолын үндэслэлийг харьцуулсан байдал

Асуудал	**Эх газрын эрх зүйн бүл**	**Англо-Саксоны эрх зүйн бүл**
Хууль тогтоомжийн шинж	Нарийвчилсан зохицуулалттай, кодчилсон	Уян хатан, шүүхийн тайлбар, шийдвэрт тулгуурлана.
Уян хатан байдал	Хуульд заасан хугацааг чанд мөрддөг	Шүүх эрх мэдлийн хүрээнд хугацааг сунгаж болно.
Хугацааг түдгэлзүүлэх ба тасрах	Тодорхой зааг ялгаатай	"Tolling" механизмаар нэгдмэл байдлаар авч үздэг.
Хугацааны урт	Ерөнхийдөө урт (5-30 жил)	Төрлөөс хамааран хувьсамтгай байна.

Хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй арга зүйн асуудлыг харьцуулан үзвэл:

1. хөөн хэлэлцэх хугацааг объектив болон субьектив шалгууруар тогтоож байгаа;
2. хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг материаллаг /нийт хугацааг тогтоосон/ болон процессын /хугацааг хэрэглэх журам тогтоосон/ шинжтэй гэж ялгамжтай авч үздэг;
3. хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангилал, оногдуулж болох ялын төрөл, түүний интервал, эсхүл эдгээрийн аль алийг нь хослуулж шалгуур болгох замаар тогтоож байгаа;
4. хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн хор аюулыг шалгуур болгон хэрэг тус бүрээр тогтоох болсон зэрэг ялгамжтай байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тогтоож байна.

Энэ нь нэг талаас тухайн улсын эрх зүйн уламжлал болон эрх зүйн бүлээс хамаарч болох ч нөгөө талаас эрх зүйн үнэт зүйлийн хувьсал, хөгжлийн чиг хандлага, хөөн хэлэлцэх хугацааны мөн чанар, үзэл баримтлал, зорилгоос хамааралтай.

Улс орнуудын ялгаатай эрх зүйн зохицуулалтын онолын үндэслэл, практикийг харьцуулан судалж, тэдний нийтлэг болон өвөрмөц байдал, өөр хоорондын уялдаа, харилцан хамаарлыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх зорилтын хүрээнд эрх зүйн бүлийн онцлог, ижил төстэй байдал, эрх зүйг хөгжлийн түвшин зэргийг харгалзан ***ХБНГУ, БНФУ, Япон улс, АНУ, ИБУИНХУ***-ыг сонгон авч онолын үндэслэл болон эрх зүйн зохицуулалтынх нь хувьд харьцуулан үзлээ.

Эдгээрээс иргэнлэг эрх зүйн уламжлал бүхий Франц, Герман, Япон зэрэг улс хөөн хэлэлцэх хугацааг ижил төрлийн нэхэмжлэлийн дагуу кодолсон хуульд үндэслэн хууль тогтоомжийг чанд баримтлан тодорхой хугацаа өнгөрсний дараа нэхэмжлэл гаргах эрхэд хязгаарлалт тогтоодог бөгөөд онол, арга зүйн хувьд харьцангуй жигд байна.

Дээрх хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй арга зүйн ялгамжтай байдал нь түүнийг тоолох, түр зогсоох буюу түдгэлзүүлэх, тасалдах үндэслэлийг өөр өөрөөр тодорхойлоход хүргэдэг байна. Тухайлбал,

ХБНГУ. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын эрх зүйн бүл нь "Civil Law" буюу иргэнлэг эрх зүйн уламжлалд суурилсан бөгөөд Ромын эрх зүйн уламжлал дээр үндэслэгдсэн.

Германы эрх зүйн тогтолцоо нь формализм буюу тодорхой дүрэм, журмыг чанд мөрдөх шинжтэй бөгөөд шийдвэрүүдийг өргөн хэрэглээнд хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Түүнчлэн

Германы хуулиуд нь зөвхөн бичгийн хууль биш, урт хугацаанд боловсронгуй болж ирсэн онолын үндсийг мөн агуулдаг. Германы эрүүгийн хууль нь гүнзгий онолын үндэслэл, хүнд сурталгүй, шуурхай шийдвэрлэх механизмтай.

ХБНГУ-ын Эрүүгийн хууль *(Strafgesetzbuch, StGB)*-ийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "хөөн хэлэлцэх хугацаа *(Verjährungsfrist)* нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгож, албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх үндэслэл болно" гэж нийтлэг байдлаар тодорхойлсон ч 2 дахь хэсэгт" "хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг алах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй" гэжээ. (Ж., 2023)

Хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт гэмт хэргийн хүндрэлийн зэрэг, оноох ялын хэмжээнээс хамааруулан хөөн хэлэлцэх ерөнхий хугацааг дараах байдлаар ялгаатай тогтоосон байна: (Өмирбек, 2023)

- Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн бол 30 жил;
- 10-аас дээш жил хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 20 жил;
- 5-10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 10 жил;
- 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 5 жил;
- Бусад гэмт хэрэгт 3 жил. (Өмирбек, 2023; Өмирбек, 2023)

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг гэмт үйлдэл төгссөн хугацаанаас (үргэлжилсэн үйлдэлтэй буюу давтан гэмт хэрэг үйлдсэн бол сүүлийн гэмт үйлдлээс) эхэлж тоолохоор заасан боловч тодорхой нөхцөлд (жишээлбэл, хохирогч нь насанд хүрээгүй байх үед) хугацааг тоолох эхлэл нь өөрчлөгдөж болно. Мөн гэмт хэргийн хор уршгийг гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамааруулсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг хор уршиг илэрсэн өдрөөс эхлэн тоолохоор, 78 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлэн тодорхой хугацаа өнгөрөх хүртэл хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсоож, хуульд заасан хугацаанаас эхлэн шинээр тоолохоор зохицуулсан байна. (Өмирбек, 2023)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байх буюу хязгаартайгаар тоолох (Өмирбек, 2023) ойлголт улс орон бүрийн Эрүүгийн хууль тогтоомжид өөр өөр онцлогтойгоор зохицуулагдсан. Үүнд:

ХБНГУ-д гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй холбоотой аливаа процессын шинжтэй үйл ажиллагаа (*гэмт хэрэгт холбогдох этгээдийг сэжигтнээр бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх, гэмт хэргийн талаарх шийдвэр гаргах үйл явц эхлэх, шүүхээс шийдвэр гаргах эсвэл шүүх хурал товлох г.м)* эхлүүлснээр хөөн хэлэлцэх хугацааг тасалж, цаашид тоолохгүй байхаар хуульчилсан бөгөөд тасралтын дараа хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолдог байна. (Republic of Poland, 1997)

Мөн гэмт хэрэг үйлдсэн этгээд гадаадад байх, Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байх, дайн эсвэл онц байдал зарласан зэрэг тусгай нөхцөлд хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох буюу түдгэлзүүлэхээр заасан байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд тодорхой төрлийн тухайлбал, хүн амины хэрэг геноцид болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайнтай холбоотой гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаагүй байхаар заасан байна.

ХБНГУ-ын Иргэний хууль нь иргэний эрх зүйн харилцаанд хөөн хэлэлцэх хугацааг нарийвчлан зохицуулж, гэрээ, үүрэг, нэхэмжлэлийн эрх зүйн үр дагаврыг тодорхойлсон зохицуулалтыг агуулдаг (ХБНГУ, 1896). Тус хуульд зааснаар ерөнхий хөөн хэлэлцэх хугацаа нь 3 жил байх бөгөөд энэ хугацааг нэхэмжлэл гаргах эрх үүссэнээс хойш тоолдог. Зарим онцгой тохиолдолд (жишээлбэл, үл хөдлөх хөрөнгийн өмчтэй холбоотой маргаан) 10-30 жил, тэр дундаа үндсэн эрх, өмчийн эрхтэй холбоотой тодорхой нэхэмжлэлд 30 жилийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон нь онцлогтой байна.

Хөөн хэлэлцэх хугацааг тухайн эрх зөрчигдсөн эсвэл нэхэмжлэл гаргах боломж

үүссэн өдрөөс эхлэн тоолдог. Гэсэн хэдий ч хохирогч тухайн эрх зөрчигдсөн талаар мэдээгүй тохиолдолд хугацаа зөрчлийг мэдсэн өдрөөс эхэлдэг. Хуульд заасан тодорхой нөхцөлд (Гэрээний маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэх хэлэлцээ хийх үед, өрийг хүлээн зөвшөөрсөн эсвэл шийдвэрлэх боломжгүй нөхцөлд, дайн, байгалийн гамшиг зэрэг шалтгаанаар талууд эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд г.м) хөөн хэлэлцэх хугацаа түдгэлздэг.

ХБНГУ-ын Иргэний хуульд нэхэмжлэл гаргах, шүүхийн процесс эхлэх, өрийг хүлээн зөвшөөрөх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг таслахаар заасан бөгөөд ийнхүү тасалсан тохиолдолд тухайн үеэс эхлэн хугацааг шинээр тоолно. Зарим төрлийн иргэний нэхэмжлэл, тухайлбал, хүүхдийн эцэг, эхийн харилцаатай холбоотой үндсэн эрх зөрчигдөх асуудалд хөөн хэлэлцэх хугацаагүй гэж заасан байдаг.

ХБНГУ-ын Иргэний хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь 3 жилийн ерөнхий хугацаатай боловч, бүхэлдээ хугацааг түдгэлзүүлэх болон таслах нөхцөлийг нарийвчлан тодорхойлсон, хохирогч эрхээ мэдсэн эсвэл мэдэх боломжтой үеэс хугацаа эхлэх уян хатан зохицуулалттай, эрх зүйн тогтвортой байдал, эдийн засгийн эргэлт, шударга шүүхийн зарчмыг хангах чиглэлээр оновчтой шийдлийг агуулсан байна.

Бүгд Найрамдах Франц Улс (БНФУ). Францын эрх зүйн тогтолцоо нь Ромын эрх зүйн тогтолцооны үндэс дээр бүтээгдсэн. Францын эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, гэмт хэрэгт холбогдсон этгээдийг хууль ёсны хариуцлагад татах хугацааны хязгаарлалт байдлаар тусгагдсан байдаг. Энэхүү зохицуулалт нь хүний эрхийг хамгаалах, шүүхийн үйл ажиллагааны үр дүнг баталгаажуулах, нотлох баримтыг цаг хугацааны явцад алдагдахаас сэргийлэх зорилготой.

Франц улсын эрүүгийн хуулиар гэмт хэргийн шинж чанар, хүндрэлийн түвшингээс хамааран дараах байдлаар тогтоосон байна:

- Онц хүнд гэмт хэрэг (*Crimes*)-т 10-20 жил (хүн амины хэрэг, онц ноцтой хүчирхийлэл
- Хүндэвтэр гэмт хэрэг (*Délits*)-т 3-6 жил (залилах, хулгайлах, санхүүгийн гэмт хэрэг)
- Хөнгөн гэмт хэрэг (*Contraventions*)-т 1 жил (замын хөдөлгөөний дүрэм зөрчих)

Хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэх ерөнхий зохицуулалттай боловч тодорхой нөхцөлд хугацааг өөрөөр эхлүүлэх зохицуулалттай. Тухайлбал, нуугдмал гэмт хэрэгт хөөн хугацааг хохирогч гэмт хэргийг мэдсэн өдрөөс, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэргүүдэд хохирогч насанд хүрсэн өдрөөс хугацааг тоолох зохицуулалттай байна.

Гэмт хэрэгтэн оргон зайлсан, шүүхийн болон мөрдөн байцаалтын үйл явц саатсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг дараах нөхцөлд түдгэлзүүлдэг бөгөөд гэмт хэрэгтэнтэй холбоотой ямар нэгэн процесс эхэлсэн үед хөөн хэлэлцэх хугацааг тасалж, шинээр тоолох зохицуулалттай.

Геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй. Энэ нь хүний эрхийг хамгаалах олон улсын жишигтэй нийцдэг.

Франц Улсын Иргэний хуулийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь эрх зүйн харилцааны тогтвортой байдлыг хангах, нотлох баримтын чанарыг алдагдахаас сэргийлэх, шударга ёсыг баталгаажуулахад чиглэсэн. (Франц улс, 2013) Энэ нь талуудын эрхийг хамгаалахад онцгой үүрэгтэй эрх зүйн зохицуулалт юм.

Францын Иргэний хуулийн 2008 оны шинэчлэлийн дагуу иргэний хэргийн ерөнхий хөөн хэлэлцэх хугацааг 30 жилээс 5 жил болгон тогтоосон байна. Энэ хугацаа нь нэхэмжлэгч өөрийн эрх зөрчигдсөнийг мэдсэн өдрөөс эхэлнэ. Зарим төрлийн нэхэмжлэл (*гэрээний маргаан 5 жил, гэм хорын нөхөн төлбөр хохирлыг мэдсэн өдрөөс эхэлнэ10 жил, өмчлөх эрхийн маргаан 30 жил, өв залгамжлал өвлөгч эрхээ мэдсэнээс хойш 5 жил*)-д хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан заасан байдаг.

Нэхэмжлэгч насанд хүрээгүй эсвэл сэтгэцийн чадамжгүй байх, онцгой нөхцөл (байгалийн гамшиг, дайн)-ийн үед хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлдэг бөгөөд хариуцагч өр төлбөрөө хүлээн зөвшөөрөх, нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасарч, шинээр эхэлдэг байна.

Франц улсын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь хууль ёсны тогтвортой байдлыг хангах, иргэдийн эрхийг хамгаалахад чиглэсэн оновчтой тогтолцоо юм. 2008 оны шинэчлэл нь хөөн хэлэлцэх хугацааг богиносгосноор эрх зүйн тодорхой байдлыг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцүүлсэн. Францын энэ зохицуулалт нь зөвхөн шүүхийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэхээс гадна эдийн засгийн харилцааны итгэлцлийг баталгаажуулахад чухал ач холбогдолтой болсныг судлаачид онцолсон байна (French Republic, 2013).

Япон улс. Япон улсын эрх зүйн бүл нь Европын болон Америкийн эрх зүйн тогтолцооны нөлөөгөөр бүрэлдэн тогтсон бөгөөд "Civil Law" буюу иргэнлэг эрх зүйн уламжлалд суурилсан байдаг. Энэ нь Ромын эрх зүйн уламжлалаас гаралтай бөгөөд Япон улс нь 19 дүгээр зууны үеэс Европын эрх зүйн тогтолцоог өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлжээ.

Японы иргэний болон эрүүгийн хуулиуд нь хөөн хэлэлцэх хугацаа (時効, Jikō)-г чухал ач холбогдолтой гэж үздэг. Японы эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн гэмт хэргийн төрлөөс хамаардаг бөгөөд энэ нь гэмт этгээдийн хариуцлага хүлээх хугацааг дуусгахгүй байх, шүүхээр шийдвэрлэхээс өмнө хөөн хэлэлцэх хугацааг таслах болон эхлүүлэх боломжтой байдаг.

Япон улсын Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хүндрэлийн түвшинг харгалзан амиа хорлох гэмт хэрэгт 25 жил (2010 оноос өмнө хугацаагүй байсан), хүнд гэмт хэрэгт 15-20 жил (хүн амины хэрэг, хүнд гэм хор учруулах гэх мэт), хөнгөн гэмт хэрэгт 3-10 жил (хулгай, залилах гэх мэт) байхаар тогтоосон.

Хөөн хэлэлцэх хугацаа нь ерөнхийдөө гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхэлдэг. Гэхдээ зарим гэмт хэргийн хувьд (жишээ нь, хохирогч гэмт хэргийг шууд мэдэх боломжгүй нөхцөлд), тухайн гэмт хэргийг мэдсэн үеэс хугацааг эхэлж тоолно.

Гэмт хэрэгт холбогдсон этгээдэд холбоотой аливаа процесс эхлэх үед хөөн хэлэлцэх хугацааг тасалж, шинээр тоолж эхэлдэг.

2020 оны 04 дүгээр сарын 1-нд хэрэгжиж эхэлсэн Япон улсын Иргэний хуулийн шинэчлэлд хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар тогтоожээ:

- Ерөнхий хугацаа: Иргэний хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа 5 жил
- Гэрээний маргаан: Хоёр талын гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн үүргийн хувьд 5 жил.
- Энгийн нэхэмжлэл: Иргэний эрх зөрчигдсөнөөс хойш 10 жилийн дотор нэхэмжлэл гаргах эрхтэй.

Нэхэмжлэгч өөрийн эрх зөрчигдсөнийг мэдсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тооцно. Хэрэв нэхэмжлэгч эрхийн зөрчлийг мэдээгүй байсан бол зөрчил гарсан өдрөөс эхлэн 10 жилийн хязгаарлалт тавигдана.

Байгалийн гамшиг, дайн зэрэг тодорхой хүчин зүйлийн улмаас нэхэмжлэгч нэхэмжлэл гаргах боломжгүй байх, хариуцагчийн нас барсан тохиолдолд өв залгамжлагчид хугацааг сунгах боломж олгох, нэхэмжлэгч нь насанд хүрээгүй эсвэл сэтгэцийн чадамжгүй байх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлдэг:

Хариуцагч өрийг хүлээн зөвшөөрөх, эсвэл шүүхэд хандах үйлдэл хийх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасалж, шинээр эхэлнэ.

Иргэний хэргийн нэхэмжлэлийн төрлөөс хамааран хөөн хэлэлцэх хугацаа харилцан адилгүй байна. Үүнд:

- Гэрээний үүрэг: 5 жил.
- Хувийн гэм хор: 3 жил (хохирлыг мэдсэн өдрөөс).
- Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой: 10 жил.
- Өв залгамжлал: Өв залгамжлах эрхээ мэдсэнээс хойш 3 жил.

Америкийн нэгдсэн улс. АНУ-ын эрх зүйн бүл нь эрх зүйн тогтолцооны хувьд

"Common Law" буюу нийтлэг эрх зүйд суурилсан байдаг. Шүүхийн шийдвэрүүд нь прецедент болдог бөгөөд дараагийн шүүх хэргүүдэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Прецедент нь хууль зүйн шийдвэр гаргахад нь шүүхүүдэд чухал зөвлөмж болдог. АНУ нь Холбооны улс бөгөөд төрийн эрх мэдэл нь холбооны засаг болон тухайн мужийн засгийн газар хооронд хуваарилагдсан байдаг. Энэ бүтэц нь АНУ-ын эрх зүйн системд онцгой нөлөө үзүүлдэг.

АНУ-ын эрх зүйн систем нь нийтлэг эрх зүйн уламжлалд суурилсан бөгөөд шүүхийн шийдвэрүүд нь хуулийн зөвлөмж, үүрэг даалгавар болгон ажилладаг. Тиймээс, шүүхийн шийдвэрүүд нь хуулийн чухал хэсэг болж, хуульчид эдгээр шийдвэрийг зөвшөөрч, хэрэглэх замаар хуулийн амьд практикийг бий болгодог.

АНУ-ын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь бүхэлдээ шударга ёс, эрх зүйн тодорхой байдал, нийгмийн ашиг сонирхлыг хангах онолд үндэслэдэг бөгөөд гэмт хэргийн төрөл, онцлог, хүндрэлийн зэргээр ялгаатай тогтоогддог. Хөөн хэлэлцэх хугацааг холбооны болон мужийн хуулиудаар зохицуулагддаг.

Холбооны хуульд зааснаар хүнд гэмт хэрэг ихэвчлэн 5-10 жил, хөнгөн гэмт хэрэг ихэвчлэн 1-2 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай.

Гэхдээ онц хүнд гэмт хэрэг, тухайлбал, хүн амины хэрэг, геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл (зарим мужуудад), террорист үйл ажиллагаа зэрэгт хөөн хэлэлцэх хугацаа байхгүй.

Хөөн хэлэлцэх хугацааг ерөнхийдөө гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэн тоолно. Гэвч зарим тохиолдолд хохирогч гэмт хэргийг мэдсэн эсвэл мэдэх боломжтой болсон өдрөөс тоолдог. Энэ нь ялангуяа санхүүгийн залилан эсвэл бэлгийн хүчирхийллийн гэмт хэргүүдэд хамаардаг байна.

Гэмт хэрэгтэн гадаад улсад оргон зайлсан, хохирогч нь насанд хүрээгүй, сэтгэцийн хувьд чадамжгүй байсан, хууль зүйн саад тотгор үүссэн зэрэг нөхцөлд хөөн хэлэлцэх хугацааг түр түдгэлзүүлж болно.

Холбогдох этгээдийг баривчлах, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулснаар хөөн хэлэлцэх хугацааг тасалж, шинэ хугацааг эхлүүлэх боломжтой.

АНУ-д олон мужид хүн амины хэргийн хөөн хэлэлцэх хугацаа байдаггүй. Зарим муж харьяаллаас хамааран бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хасдаг.

АНУ-ын хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь Европын орнуудаас илүү уян хатан, нөхцөл байдалд суурилсан байдаг. Ялангуяа хохирогчийн эрхийг хамгаалахад ихээхэн ач холбогдол өгдөг бөгөөд хохирогч гэмт хэргийг мэдэх боломжтой болсон үеэс хугацаа тоологддог зохицуулалт нь онцлог юм.

АНУ-ын Иргэний хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тогтоох байдал нь мужууд болон нэхэмжлэлийн төрлөөр ихээхэн ялгаатай байдаг.

Иргэний хуулийн маргаанд хамаарах хугацаа нь нэхэмжлэлийн төрлөөс хамааран өөрчлөгддөг. Тухайлбал,

- Гэрээний маргаан: Ерөнхийдөө 3-6 жил.
- Хувийн гэм хор: Ихэнх мужид 2-3 жил.
- Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудал: 5-10 жил.
- Өв залгамжлал, гэрээслэлтэй холбоотой асуудал: 1-3 жил
- Холбооны ажил олгогчдод холбогдох маргаанд хөөн хэлэлцэх хугацаа 2 жил.
- Санхүүгийн залилангийн маргаанд 5 жилийн хугацаа тогтоогдсон.

Хөөн хэлэлцэх хугацаа нь нэхэмжлэгч тухайн эрх зөрчигдсөнийг мэдсэн эсвэл мэдэх боломжтой болсон өдрөөс эхлэн тоологдох бөгөөд хууль заасан зарим нөхцөлд хөөн хэлэлцэх хугацааг түр түдгэлзүүлнэ.

Холбогдох этгээд өрийг хүлээн зөвшөөрөх, маргаантай асуудалд эвлэрэл хийх оролдлого эхлэх, эсвэл шүүхийн процесс эхлэх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасалж, шинээр эхэлдэг.

АНУ-ын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь Европын эрх зүйн системтэй харьцуулахад илүү уян хатан бөгөөд нөхцөл

байдлыг харгалзан хугацааг түдгэлзүүлэх, таслах зохицуулалтаараа онцлогтой. Ялангуяа хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлд ихээхэн ач холбогдол өгч, хугацааг тоолох эхлэлийн үеийг нэхэмжлэгчийн эрх мэдэх боломжтой болсон үеэс эхлүүлэх зохицуулалт нь онцгой давуу талтай.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ). Их Британийн эрх зүйн тогтолцоо нь нийтлэг эрх зүйн бүлд хамаарах тул хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь онцлогтой. Ихэнх эрүүгийн хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа тогтоохгүй байх зарчим баримталдаг нь бусад улс орнуудын зохицуулалтаас ялгаатай. Энэ нь ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлагаас зайлсхийх боломж олгохгүй байхыг эрхэмлэсэн зарчимтай уялдана.

Их Британид гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэх бөгөөд гэмт хэргийн төрлөөс хамааран хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт харилцан адилгүй байна. Үүнд: Хөнгөн гэмт хэргийн хувьд 6 сар, хүнд болон онц хүнд гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тогтоохгүй.

Зарим гэмт хэргийг хөнгөн эсвэл хүнд байдлаар ангилж ял оноох боломжтой. Шүүх хэргийн хүндрэлийг тодорхойлсны дараа хөөн хэлэлцэх хугацаа хэрэгжих эсэхийг шийддэг. Нууцлагдмал гэмт хэргийг илэрсэн өдрөөс эхлэн тоолдог. Геноцид болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эсрэг бэлгийн дарамттай холбоотой хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй бөгөөд насанд хүрээгүй хохирогчид насанд хүрсний дараа ч нэхэмжлэл гаргах эрхтэй.

Хөөн хэлэлцэх хугацаа нь ихэвчлэн гэмт хэргийг илрүүлж, нотлох баримтыг олсон өдрөөс эхэлнэ.

Их Британид хүнд гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа тогтоохгүй байх нь Европын бусад орны эрх зүйн зохицуулалтаас ялгаатай. Их Британийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь нийтлэг эрх зүйн системд тулгуурласан бөгөөд хүнд болон онц хүнд гэмт хэргүүдэд хугацаа тогтоохгүй байх зарчим баримталдаг. Энэ нь нийгмийн аюулгүй байдлыг хангах, хохирогчдын эрхийг хамгаалах, шударга ёсыг хэрэгжүүлэхэд чиглэсэн чухал зохицуулалт юм. Тус улсын энэхүү хандлага нь гэмт хэргийн хариуцлагаас зайлсхийх боломжийг хааж, гэм бурууг цаг хугацаанаас үл хамааран шийдвэрлэх үндэс суурийг бий болгодог.

Их Британи улсын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь олон улсын эрх зүйн системийн хүрээнд онцлог бөгөөд энэ нь түүхэн болон практик үндсээрээ төлөвшсөн. Иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зохицуулахдаа "Шударга ёс", "Нийгмийн итгэлцэл" болон "Баримт нотолгооны чанар" гэсэн онолын үндэслэлүүдийг баримталдаг. Их Британи улсын хөөн хэлэлцэх хугацаа нь тодорхой эрх зүйн хүрээнд хүчтэй хяналттай байдаг бөгөөд иргэний хэргүүдэд хязгаарлагдмал хугацааг тогтоох замаар эдгээр зорилтыг хангаж байна.

Их Британи улсад иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь 1980 оны Хязгаарлалтын тухай хууль (Limitation Act, 1980)-иар тодорхойлогддог бөгөөд энэ хуулиар иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, хэрэглэх зарчим тодорхой хязгаартай байдаг. Иргэний хэргүүдэд ерөнхий хөөн хэлэлцэх хугацаа нь 6 жил байна. Энэ нь уг хэрэгт нэхэмжлэгч гаргасан шаардлагыг шүүх шийдвэрлэхэд хугацаа тогтоож, нэхэмжлэгчийг хурдан шийдвэр гаргуулахыг шаарддаг. (htt4) Үйлдлийн хувьд энэ хугацаа 12 жил хүртэл үргэлжилнэ.

Зөрчлийн нэхэмжлэл: Зөрчлийн, түүний дотор хайхрамжгүй хандсан үйлдлийг ихэвчлэн 6 жилийн дотор эхлүүлэх ёстой.

Гэхдээ бодит хохиролтой хэрэг буюу гэмтэл, бэртэл гарсан бол хөөн хэлэлцэх хугацаа гэмтэл авсан өдрөөс 3 жилийн дотор эхэлдэг онцлогтой. Хэрвээ гэмт хэрэг нь илрээгүй тохиолдолд, хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн илрэлээс хойш эхэлнэ.

Иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь ямар ч нөхцөлд 15 жилээс илүү байж болохгүй. Хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх шатанд байх буюу хэргийг дахин хянан үзэх үед талаарх асуудлыг

анхааралтай авч үзэх үед хөөн хэлэлцэх хугацаа зогсоно. Зарим нөхцөлд хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргийг тодорхой хязгаарлагдмал хугацааны дараа сэргээж болох бөгөөд энэ нь ***"reasonable period"*** буюу тодорхой хэмжээний хугацаанд хийгдсэн байх ёстой.

Хүүхдэд холбогдох хувийн гэмтлийн нэхэмжлэлийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа нь 18 нас хүрэхээс нааш эхэлдэггүй онцгой зохицуулалттай. Сэтгэцийн хомсдолын улмаас ажлаа удирдаж чадахгүй байгаа хүмүүсийн хөөн хэлэлцэх хугацааг нөхөн сэргээх хүртэл сунгахаар зааж хамгаалагдсан байна.

Их Британи улсын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь хохирогчдын эрхийг хамгаалах, шүүхийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг хангах, шударга ёсны хэрэгжилтийг дэмжих зорилгоор боловсруулсан, бусад улстай харьцуулахад зарим талаар бага хугацаатай байж болох боловч хүчтэй зохицуулалттай байдаг.

Дүгнэлт, санал

Хөөн хэлэлцэх хугацааны ойлголт, түүний хэрэгжилт нь улс орнуудын эрх зүйн уламжлал, соёл, түүхээс хамаарч ялгаатай байдаг. Англи-Саксоны эрх зүйн бүл бүхий орнуудад хөөн хэлэлцэх хугацааны ойлголт бараг байдаггүй бөгөөд зөвхөн зарим төрлийн хөнгөн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэдэг онцлогтой. Харин хөөн хэлэлцэх хугацааны ойлголтыг Эх газрын буюу Ром-Германы эрх зүйн бүл бүхий орнуудад гол төлөв хэрэглэдэг байна.

Англи-Саксоны болон Ром-Германы эрх зүйн бүлтэй улс орнууд болох ХБНГУ, БНФУ, Япон улс, АНУ, ИБУИНХУ улсуудын хөөн хэлэлцэх хугацааг судлан үзэхэд ХБНГУ болон Франц улсын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь тус бүрийн эрх зүйн тогтолцоо, онолын үндсээр ялгаатай боловч мөн зарим ижил төстэй үзүүлэлттэй байна. ХБНГУ болон Франц улс хоёрт нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн төрлөөс хамаарч өөр өөр байдаг. ХБНГУ нь 3 жил болон 10 жил гэсэн хөөн хэлэлцэх хугацаатай байдаг бол Францад энэ хугацаа нь 6 жил, 20 жил зэрэг өөр өөр байна..

ХБНГУ болон Франц улс хоёрын хувьд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг таслах зарчим нь тохиромжтой бөгөөд хэргийг мөрдөн байцааж эхлэх үед хугацаа тасарч эхэлнэ. Харин Франц улс нь зарим үед хөөн хэлэлцэх хугацааг сэргээж чаддаг. ХБНГУ болон Франц улсад ноцтой гэмт хэргүүд (жишээ нь, аллага, терроризм) нь хөөн хэлэлцэх хугацаа байхгүй буюу тэр хугацааг уртасгаж байхаар зохицуулсан байдаг. Энэ нь шүүхийн шийдвэр гаргах, гэмт этгээдийг байцаах, хэрэг хянан шийдвэрлэх хүндрэлийг арилгах зорилготой.

ХБНГУ болон Франц улсын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зохицуулах хууль тогтоомж нь зарим талаараа төстэй бөгөөд зарим нь ялгаатай байна. Эдгээр улс орнууд гэмт хэргийн төрлөөс хамааран хөөн хэлэлцэх хугацааг уртасгаж, хязгаарладаг боловч тус улсын хууль зүйн тогтолцооны онцлог, гэмт хэргийн төрлөөс хамааран зохицуулалт нь ялгаатай байна.

Их Британи болон АНУ-ын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зохицуулах эрх зүйн зохицуулалт нь тодорхой ялгаатай боловч зарим талаар төстэй. Их Британи болон АНУ-ын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь аливаа маргааны хурдтай шийдвэрлэгдэх, шударга ёс хэрэгжүүлэх болон нийгмийн итгэлцлийг хангах зорилгоор нэгтгэн зохион байгуулагдсан байна. Гэхдээ тус хоёр улсын хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтад зарим ялгаа байгаагаас шалтгаалан, маргаан бүрийн онцлог, нөхцөл байдлаас хамааран өөр өөрийнхөө дүрмийг хэрэглэж байна.

Их Британи улсад шүүхийн шийдвэртэй холбоотой хөөн хэлэлцэх хугацаа нь 6 жил байна. АНУ-д шүүхийн шийдвэрийн хөөн хэлэлцэх хугацаа тухайн мужийн хууль тогтоомжтой холбоотойгоор илүү удаан, зарим тохиолдолд 10 жил хүртэл хугацаатай байж болно.

Их Британи улсад зарим хүнд гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа байхгүй (жишээ нь, аллага), харин АНУ-д ихэнх тохиолдолд хамгийн урт хөөн хэлэлцэх

хугацаа нь 10 жил байдаг. АНУ-д ***discovery rule*** буюу гэмт хэрэг илэрсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацаа тоологддог бол Их Британи улсад энэ дүрэм илүү хязгаарлагдмал хэрэглэгддэг. Мөн Их Британи улс хөөн хэлэлцэх хугацааг баримт нотолгооны чанарт тулгуурлан тогтоохыг зорьдог бол АНУ-д хохирогчийн эрхийг хамгаалах нь чухал байж, гэмт хэрэг илэрсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацаа тоологддог.

Ерөнхийдөө, хоёр улсын хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх болон шүүхийн шударга шийдвэр гаргахыг зорьдог боловч хоёр улсын хууль зүйн зохицуулалт зарим талаар ялгаатай байна.

Иймд, хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэж буй арга зүй, түүний зохицуулалтуудын ялгаа нь тухайн улсын эрх зүйн практик, соёл болон эрх зүйн бүлийн онцлогоос шалтгаалан өөр өөр байна.

Эх сурвалж

(n.d.). Retrieved from https://www.copytrust.ru/articles/Avtorskoe-pravo-Ispanii

(n.d.). Retrieved from https://www.gesetze-im-internet.de/bgb/

(n.d.). Retrieved from https://www.legislation.gov.uk/ukpga/1980/58

Anthony Bradley, D. G. (2011). Limitation periods under English law. Retrieved from https://www.pinsentmasons.com/out-law/guides/limitation-periods-under-english-law

Civil Code of French Republic (excerpts related to citizenship). (2013). Retrieved from https://legislationline.org/taxonomy/term/21680

French Republic. (2013). *Civil Code of French Republic (excerpts related to citizenship)*. Paris: Journal Officiel de la République Française.

Graham Virgo, L. P. (2006). *The Principles of the Law of Restitution* (2nd ed.). Retrieved from https://doi.org/10.1093/acprof:oso/9780199298501.003.0028

Laches. (1980). In *Эрүүгийн эрх зүйн судалгаа* (p. 12).

Poland. (1997). *The Criminal Code z dnia 6 czerwca 1997 r. (Dz.U. thum. IO gb Nr 88, poz. 553.* Warsaw: Dziennik Ustaw.

Republic of Poland. (1997). *The Criminal Code z dnia 6 czerwca 1997 r. (Dz.U. thum. IO gb Nr 88, poz. 553.* Warsaw: Dziennik Ustaw.

The Criminal Code z dnia 6 czerwca 1997 r. (Dz.U. tłum. IO gb Nr 88, poz. 553), Chapter XI. (n.d.).

Ж., Ө. (2023). *Харьцуулсан эрүүгийн эрх зүй: Хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт.* Улаанбаатар хот : Мөнхийн үсэг .

Өмирбек, С. (2023, 11 10). *Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам харьцуулсан судалгаа*. Retrieved from https://omir.blogmn.net/116964/?cv=1

Франц улс. (2013). *Civil Code of French Republic.* Paris: Journal Officiel de la République Française.

ХБНГУ. (1896). *Bürgerliches Gesetzbuch (BGB).* Bonn: Bundesgesetzblatt.

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА (ШИНЖЭЭЧ ТОМИЛЖ, ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ) АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES OF INVESTIGATIVE ACTIVITIES RELATED TO NARCOTIC DRUGS AND PSYCHOTROPIC SUBSTANCES (APPOINTMENT OF EXPERTS AND CONDUCTING FORENSIC EXAMINATIONS)

Б.Хишигтогтох*
Дотоод хэргийн их сургуулийн Дотоодын цэргийн албаны тэнхимийн профессор, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа
Khishigtogtokh B.
Professor of the Department of Internal Troops Service, Ph.D., Police Colonel
Э.Түвшин-Эрдэнэ
Дотоод хэргийн их сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн ахмад
Tuvshin-Erdene E.
Senior Lecturer at the Department of Criminal Investigation Methodology Police School, Ph.D., Police Captain

*Хариуцлагатай зохиогч: Khishigee.baatarjav@gmail.com

Хураангуй: Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад хураагдсан бодисыг Монгол Улсын Шүүх Шинжилгээний Ерөнхий Газрын Байгалийн Ухааны Шинжилгээний Газрын “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лаборатори”-т шинжлүүлэн дүгнэлт гаргуулахаар эрх бүхий байгууллагаас шинжээч томилох тогтоол үйлдэн бодисыг хүргүүлэхэд шинжээч нар НҮБ-ын 1961 оны “Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц”, 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-ын жагсаалтыг үндэслэж дүгнэлт гаргахад Монгол Улсын холбогдох хууль дүрэм, шаардлагатай техник төхөөрөмж хангалтгүй байдлаас тухайн ажлын үр дүн хангалтгүй байна гэж судлаач бид үзсэн. Тухайлбал, Хууль, эрх зүйн зохицуулалт дутмаг, Шүүх Шинжилгээний Ерөнхий газарт дэвшилтэт техник технологи хомс, шинэ төрлийн буюу синтетик гаралтай бодисын найрлага болон гарал үүсэл, лабораторит эсхүл гар аргаар боловсруулсан эсэхийг тогтоож чадахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд тулгамдсан асуудал болж байна.

Abstract: The task of conducting analyses and providing expert conclusions on substances seized or discovered during investigative operations, assigned by the competent investigative authority to the “Laboratory for the Examination of Narcotic Drugs and Psychotropic Substances” under the Department of Natural Science Examination of the General Agency of Forensic Science of Mongolia, has been found by us, as researchers, to yield insufficient results when based on the schedules of the 1961 United Nations “Single Convention on Narcotic Drugs” and the 1971 “Convention on Psychotropic Substances.” The inadequacy of the forensic agency’s expert conclusions stems from several factors. In particular, there is a lack of adequate legal regulation, a shortage of advanced technology within the General Agency of Forensic Science, and an inability to determine the composition and origin of new or synthetic substances, including whether they were produced in a laboratory or manually. These challenges have become significant obstacles in combating this type of crime.

Түлхүүр үгс: Синтетик гаралтай бодист шинжилгээ хийх, шинжээчийн дүгнэлт, эрх зүйн зохицуулалт.

Keywords: Forensic analysis of Synthetic Substances, analyst opinion, and Legal Regulation

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Удиртгал: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус наймаа нь НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцод заасанчлан үндэстэн дамнасан, нарийн зохион байгуулалттай, нууц, далд аргаар үйлдэгддэг гэмт хэрэг юм. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх арга, зохион байгуулалт боловсронгуй болж, манай улсын үндэсний аюулгүй байдалд аюул, занал учруулах шинжтэй болж байна.

Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн тоо өсөж, нийгэмд аюул заналхийлэл үүсгэж байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалтад орж улмаар Монгол Улсын дотоодын аюулгүй байдал, тэр дундаа хүн амын удмын санд ноцтой нөлөөлөх эрсдэлтэй төдийгүй нийгмийн хэвийн орчинд сөрөг үр дагавар үзүүлж байна. Дээрх төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд шинжээчийн тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай төдийгүй тухайн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын гарал үүсэл, нийлүүлэг зэргийг нарийвчлан тогтоосноор энэ төрлийн гэмт хэрэгтэй өргөн хүрээгээр тэмцэж чадна гэж судлаач бид үзлээ.

Монгол Улсад 2016-2024 онуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой 1772 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 86 хувь буюу 1527 гэмт хэрэг нь нийслэл хотод бүртгэгдсэн байна. Жил бүр 278 иргэн энэ төрлийн гэмт хэрэгт яллагдагчаар татагдаж, гэмт хэргийн илрүүлэлт 70.2 хувьтай байна. Дээрх хугацаанд 419.2 мянган иргэний нэг удаагийн хэрэглэх бодис хураан авч, 46.3 тэрбум төгрөгийн хууль бус эргэлтийг таслан зогсоосноос өнгөрсөн 2025 онд 71.386 иргэний нэг удаагийн хэрэглэх бодис хураан авснаас 116.7 кг өвс, 2.3 кг мөс хураан авч, мөрдөн шалгах ажиллагаа явуулан шалгаж байна. (Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн статистик тайлан, 2013-2014)

Үндсэн хэсэг: Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хар тамхитай тэмцэх албаны 2020 оны судалгааны тайланд дэлхийд нийттэй 188 сая хүн каннабис, 89 сая хүн опиум, 29 сая хүн амфетамин, 21 сая хүн экстази, 18 сая хүн кокайн хэрэглэж байна гэж тэмдэглэжээ. Олон улсад шинэ төрлийн сэтгэцэт нөлөөт бодис “Флакка”, “Гамма”, “экстази”, сэргээш ундаан холимог, синтетик марихуан зэргийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис шинээр дэлгэрч байна.

Монгол Улсын Үндсэн хууль-д (монгол улсын үндсэн хууль, n.d.) хүн бүр дараах эрхийг эдэлнэ гэж заасан байна. Үүнд: “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй" гэж заасан байдаг. Мөн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-д,(*Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал Батлах Тухай*, n.d.) Оршин тогтнохуйн аюулгүй байдал хэсгийн хүн ам, удмын сангийн аюулгүй байдал-д “Цус ойртолтыг багасгах, архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна.”, (Үндэсний аюулгүй байдлын тухай, n.d.)мөн хүний аюулгүй байдал хэсгийн 3.4.4-т “Иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах” (Я.Цэвэл, 1958)гэж тус тус заасан байдаг.(*Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал Батлах Тухай*, n.d.)

Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ Богд хааны үеэс эхлэн нэвтэрсэн бөгөөд Хятадын худалдаачид XIX зууны сүүлээр бараа товар тээвэрлэх, худалдаа арилжаа хийхийн хажуугаар анх хар тамхи буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар оруулж ирэн жирийн ард иргэдэд бус дээд давхаргын хүмүүст хэрэглүүлэн улмаар нэг хэрэглэсэн хүн дахин хэрэглэх сэдэл төрөх үед нь худалдан борлуулах ажиллагааг нэлээн далд хэлбэрээр зохион байгуулж эхэлжээ. Үүнээс үүдэн 1912 онд Богд хаан хар тамхийг хатуу хориглосон зарлиг гаргасан нь Монгол Улсын анхны бодлогын илрэл гэж хэлж болно.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үгийн утгыг илэрхийлэгдэх


хэлбэрээр нь судлахад дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

Үг зүйн талаас нь: Монгол хэлний товч тайлбар толь-д: “Хар тамхи гэдэг нь намуу цэцгийн төрлийн урт бөгөөд том навчтай, цагаан ба улаан цэцэгтэй ургамал эсхүл ургамлыг гүйцэд боловсроогүй байхад огтолж хатааж боловсруулсныг” гэсэн утга илэрхийлнэ гэж тайлбарласан байна. (Я.Цэвэл, 1958)

Харин Хууль зүйн талаас нь: “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль (2002)-д “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, НҮБ-ын 1961 оны “Мансууруулах эмийн тухай” конвенц, 1971 оны НҮБ-ын “Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай” конвенцын жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг ойлгоно гэж уг хуулийн 3.1.1-т заасан. Харин НҮБ-ын 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц-д (Конвенцод нэгдэн орох тухай /мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг” нэгдсэн үндэстний байгууллагын конвенц/, n.d.)“Мансууруулах эм” гэж тус конвенцын I болон II жагсаалтад орсон байгалийн болон нийлэг бодисыг, НҮБ-ын 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц-д “Сэтгэцэд нөлөөлөх бодис” гэж тус конвенцын I, II, III, IV жагсаалтад орсон байгалийн буюу нийлэг аливаа бодис, эсхүл байгалийн аливаа материалыг хэлнэ” гэж тус тус хуульчлан бэхжүүлсэн байна. Дээрх төрлийн бодист шинжилгээ хийж шинжээчийн дүгнэлт гаргасан байдлыг авч үзвэл: (сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, n.d.)

Улсын хэмжээнд **2020** онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой **204** гэмт хэрэг бүртгэгдэж Шүүх шинжилгээний Ерөнхий газрын Мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лабораторт **673** шинжилгээ, **2021** онд **187** гэмт хэрэгт **328** шинжилгээ, **2022** онд **230** гэмт хэрэгт **189** (Шүүх Шинжилгээний Хүрээлэнгийн статистик тайлан, 2020-2022) шинжилгээ, **2023** онд **238** гэмт хэрэгт **350 шинжилгээ**, (Шүүх Шинжилгээний Ерөнхий газрын статистик тайлан, 2024) **2024** онд 254 гэмт хэрэгт **535** шинжилгээ, 2025 оны эхний хагас жилд 2600 тус, тус шинжилгээ хийгдсэн байна. Үүнийг графикаар харуулбал: (Шүүх Шинжилгээний Ерөнхий газрын статистик мэдээлэл, 2025)

График №1. Шүүх Шинжилгээний Ерөнхий газарт шинжээч томилж, шинжилгээний дүгнэлт гаргасан үзүүлэлт.



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг шинжлэх, шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд болон бусад төрлийн шинжилгээнд удирдлага болгон

ашиглаж буй дотоодын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээгээр дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:


Агуулга	Шүүхийн Шинжилгээний тухай хууль	Химийн шинжилгээ хийх журам	Биологийн шинжилгээ хийх журам	ДНХ-ийн шинжилгээ хийх журам
Объектын талаар	Шаардагдах тоо хэмжээтэй байх, эх хувь эсхүл шаардлага хангасан байх.	Объектын хэмжээ, хадгалах нөхцөлийг тусгасан.	Хуурай чийгүй, нэмэлт бодис хийгээгүй байх.	Объект нь хуурай чийгүй, нэмэлт бодис хийгээгүй байх.
Дээж бэлтгэлийн талаар	-	-	-	-
Шинжилгээ хийх үе шатын тухай.	Шинжилгээ эхлэхээс өмнө гэрэл зургаар бэхжүүлж, итгэмжлэгдсэн лабораторит хийж гүйцэтгэнэ.	Шинжилгээ хийх 8 үе шаттай.	Шинжилгээ хийх 5 үе шаттай.	Шинжилгээ хийх 8 үе шаттай.
Шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийн талаар.	Баталгаажуулсан багаж, төхөөрөмж ашиглана.	-	-	-
Шинжилгээний арга зүй.	-	-	Стандарт ажлын зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.	Фрагментын анализ, нуклеотидын дараалал тогтоох.
Дүгнэлтийн талаар.	Дүгнэлт бичих ерөнхий шаардлагын тухай тусгасан.	-	-	-

Дээрх хүснэгтээс харахад ДНХ-ийн шинжилгээ хийх журамд шинжилгээний үе шат арга зүйн талаар хамгийн ойлгомжтой дэлгэрэнгүй зааж өгсөн байна. Харин мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодист шинжилгээ хийж дүгнэлт гаргуулах ажилд нарийн процесс ажиллагаа чухал байдаг боловч Шүүх Шинжилгээний тухай хуульд нийцүүлэн гаргасан Химийн шинжилгээ хийх журамд мансууруулах сэтгэцэд нөлөөт бодист шинжилгээ хийх талаар ерөнхий байдлаар тусгаж өгсөн байна. Мөн Химийн шинжилгээ хийх журамд энэ төрлийн бодисын шинж чанар, найрлага, гарал үүсэл, химийн бүтэц зэрэг мэдээллүүдийг тогтоох тухай тусгаж өгөөгүй учраас зөвхөн тухайн бодисыг тодорхойлох процесс ажиллагаа хийгддэг. Иймд Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодист шинжилгээ хийж шинжээчийн дүгнэлт гаргах үйл хэрэгт тусгайлсан журам ашиглах шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсын хувьд НҮБ-ын холбогдох конвенцуудын жагсаалтад орсон бодисыг олж авсан, хэрэглэсэн, тээвэрлэсэн, худалдан борлуулсан зэрэг үйлдлийг хууль бус гэж үзэн Эрүүгийн хууль (эрүүгийн хууль, n.d.) болон Зөрчлийн тухай хуулиар зохицуулдаг. (Зөрчлийн тухай, n.d.) Энэ төрлийн гэмт хэргийн тоо 2010 оноос тасралтгүй өсөж,

жилд дунджаар 200 орчим гэмт хэрэг цагдаагийн байгууллага-т бүртгэгдэж байна. Улсын хэмжээнд 2006 оноос хойш бүртгэгдсэн гэмт хэргийн түвшинг доорх графикт харуулав. (Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээлэл , 2025)

График 1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөтэй бодистой холбоотой гэмт хэргийн түвшин:



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөтэй бодистой холбоотой гэмт хэргийг бүтцээр нь авч үзэхэд 70 хувийг Монгол Улсын нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах үйлчилгээ үзүүлэх ургамалтай холбоотой гэмт хэрэг, 30 хувийг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн синтетик гаралтай мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг эзэлж байна.

Монгол Улсын хувьд 2022 оноос “Синтетик каннабинойд”, “Альфа пвп” зэрэг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисуудыг хэрэглэх иргэд олширч, эдгээр бодисын шинжилгээнд эзлэх хувь тасралтгүй өсөж байна. Мансууруулах бодисын шинэ төрөл нэмэгдэж байгаа нь түүнийг таньж мэдэх, тодорхойлоход хүндрэлтэй байдлыг бий болгож байна. Үүний нэг тод илрэл нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодист шинжилгээ хийхэд гарч буй алдаа дутагдал юм. (Б.Алтансүх, 2020)

Энэ төрлийн гэмт хэрэгт Шүүх Шинжилгээний Ерөнхий газрын шинжилгээгээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний төрөл зүйлийг тодорхойлох, мансууруулах бодисын ул мөр байгаа эсэхийг тодорхойлдог. Шүүх Шинжилгээний Ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний газарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой дараах шинжилгээг хийж дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шинжилгээний лаборатори: эд мөрийн баримтаар хураагдсан бодис болон биологийн дээжээс НҮБ-ын 1961 оны "Мансууруулах эмийн тухай" конвенц, 1971 оны "Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай" конвенцын жагсаалтад багтсан бодисыг илрүүлэх шинжилгээ.

2. Хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээний лаборатори: Эд мөрийн баримтаар хураагдсан ургамал нь ямар төрөл, зүйлийн ургамал болохыг тогтоох шинжилгээг хийж байна.

Судлаач бидний шинжээч томилж, шинжилгээ хийлгэх ажилд тулгамдсан асуудлын талаар Шүүх Шинжилгээний Ерөнхий газрын шинжээч, мөрдөн шалгах эрх бүхий алба хаагч нартай хийсэн фокус ярилцлагын хүрээнд дараах нөхцөл байдал тогтоогдсон. Тодруулбал,

1. Хэргийн материалд эд мөрийн баримтаар хураагдсан бодисыг НҮБ-ын конвенцуудын жагсаалтад багтсан эсэхээс гадна тухайн бодисын агууламж, цэвэршилт, гарал үүсэл, хүний биед учруулах сөрөг үр дагавар зэргийг нарийвчлан тогтоосноор мөрдөн шалгах ажиллагааг төлөвлөх, энэ төрлийн хэрэгт яллагдагч этгээдэд шүүхээс оногдуулах ялыг ялгамжтай байдлаар оногдуулахад чухал ач холбогдолтой байхаар байна. Жишээлбэл: Гадаад улсын шүүх шинжилгээний байгууллага нь Метамфетаминий агууламж бүхий “Мөс” гэх бодисын гарал үүслийг нь тогтоож,

түүнд агуулагдах бусад бодисын агууламж, цэвэршилт зэргийг нарийвчлан тогтоодог байхад Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллага нь энэ талаар дүгнэлт гаргадаггүй. Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж байгаа дээрх бодисын гарал үүслийг тогтоосноор мөрдөн шалгах ажиллагаагаар тухайн бодисыг олж авсан эх сурвалжийг нарийвчлан тогтоох, улмаар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой төлөвлөх ач холбогдолтой. Мөн тухайн синтетик гаралтай бодисыг нь аль бүс нутаг, улсаас Монгол Улсын хилээр, гаалийн хилээр нэвтрүүлж байгааг тогтоосноор тухайн улсын хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, гэмт хэрэгтэй тэмцэх, үндэстэн дамнасан, бүлэг зохион байгуулалттай эсэхийг тогтоох ажиллагааг олон улсын түвшинд хэрэгжүүлэх боломжтой.

Гадаад улсын туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж АНУ, БНСУ, ХБНГУ-ын мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, тухайн ажиллагаанд хэрэглэж буй дэвшилтэт техник технологийн талаар судаллаа. Үүнд:

Метамфетаминий дэлхий дахинд өргөн тархсан хууль бус хэрэглээнээс үүдэн өндөр хөгжилтэй улс орнууд тухайн бодисын найрлага, цэвэршилт, хольцын бүтэц, гарал үүслийг тогтоох шинжилгээ хийх тогтолцоог бүрдүүлсэн байдаг байна.

№	АНУ	БНСУ	ХБНГУ
1	Тус улсын Хар тамхитай тэмцэх алба (Drug Enforcement Administration) болон Холбооны мөрдөх товчоо (Federal Bureau of Investigation) нь хураагдсан мансууруулах бодисын шинжилгээг Scientific Working Group for the Analysis of Seized Drugs (SWGDRUG) стандартын дагуу гүйцэтгэдэг. (https://www.swgdrug.org/) АНУ-ын Хар тамхитай тэмцэх алба нь “Methamphetamine Profiling Program (MPP)”-аар дамжуулан илэрсэн бодисын хольцын бүтэц, катализаторын ул мөр, изомерын харьцааг шинжилж, тухайн бодисыг лабораторийн гаралтай эсэхийг тогтоож мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилладаг байна. (Monitoring methamphetamine in the United States: A two-decade review as seen by the DEA methamphetamine profiling program, 2021)	National Forensic Service (NFS) нь буюу Шүүх шинжилгээний байгууллага нь мансууруулах бодисын шинжилгээг ISO/IEC 17025 стандартад нийцүүлэн явуулдаг. Бодисын цэвэршилт болон найрлагын шинжилгээг урвалж ба катализаторын хольцын шинжилгээ, урвалын үлдэгдлийн харьцаанд тулгуурлан (Synthetic cannabinoids abused in South Korea: Drug identifications by the National Forensic Service from , 2013)тодорхойлж, мөрдөн шалгах ажиллагаанд дүгнэлт гаргадаг байна. (БНСУ-ын Шүүх шинжилгээний албаны цахим)	Тус улсын мансууруулах бодисын шинжилгээ нь Bundeskriminalamt (BKA) болон Landeskriminalämter (LKA) лабораториудаар хийгддэг бөгөөд Европын Холбооны ENFSI (European Network of Forensic Science Institutes) стандартын дагуу явагдана. (https://www.berlin.de/polizei/dienststellen/landeskriminalamt/lka-kriminaltechnik/artikel.958591) Герман газын хроматограф–изотопийн масс спектрометр (GC–IRMS) технологи ашиглан уг бодисын изотопын найрлагын харьцаа ($\delta^{13}C$, $\delta^{15}N$ гэх мэт) тогтоож, үүн дээр үндэслэн геохимийн гарал буюу үйлдвэрлэсэн бүс нутгийг таамаглах судалгаа явуулдаг. Мөн метамфетамины хольцын бүтэц, синтезийн зам, уусгагчийн үлдэгдэл зэрэг шинжүүдийг тодорхойлоход multivariate chemometric (PCA, cluster analysis, discriminant analysis гэх мэт) аргыг ашиглан цэвэршилтийн профайл (impurity profile) гаргадаг. Энэ аргыг Европын хэмжээнд European Drug Profiling System (EDPS)-д холбон мэдээлэл солилцдог нь хил дамнасан мөрдөн шалгах ажиллагаанд чухал ач холбогдолтой. (Novel approaches for impurity and isotopic profiling… — describes GC-IRMS methods and chemometric evaluation used in German forensic research contexts. (PhD dissertation / institutional report)

Дээрх өндөр хөгжилтэй улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын найрлага, цэвэршилт, хольцын агууламжийг тодорхойлохдоо нотолгоонд суурилсан аналитик химийн аргуудыг ашиглан, олон улсын стандартад нийцсэн шинжилгээний тогтолцоог бүрдүүлжээ. Энэ нь зөвхөн эрүүгийн хэрэгт нотлох баримт бүрдүүлэхээс гадна бодлогын түвшний, урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн бодлого боловсруулахад чухал мэдээлэл болох тул Монгол Улс бодлогын түвшинд гадаадын зарим орны туршлагыг нэвтрүүлэн дээрх аргыг ашиглах шаардлагатай байна гэж судлаач бид үзлээ.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ны тайланд Америк болон Баруун Европын улс онуудад каннабисийн, Алс болон Ойрх дорнод, Зүүн өмнөд Азийн улс орнуудад амфетамин, синтетик төрлийн хар тамхины хэрэглээ, үйлдвэрлэл ихээр нэмэгдэж, зах зээл өргөжиж байгаа талаар онцолсон байна. Мөн уг тайланд хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын эдийн засаг, хууль, эрх зүйн болон бусад сул талыг нь ашиглан зохион байгуулалтай бүлэг, гэмт бүлэглэлүүд мансууруулах бодисын үйлдвэрлэлээ бусад улс орнуудад шилжүүлэн байрлуулж байна. Европын холбооны улс орнуудад метамфетамины агууламж бүхий мансууруулах бодис, кокаин, героин, Азид ICE буюу метамфетамины агууламж бүхий “Мөс” гэх мансууруулах бодис, героин, кокаин, Төв азид каннабисийн хэрэглээ өсөж, улмаар хууль бус үйлдвэрлэл болон эмийн хэрэглээ нэмэгдсээр байгааг дурдсан байна.

2. Шинэ төрлийн буюу синтетик гаралтай бодисын хувьд, жишээлбэл: **“Mdmb-4en-PINACA”** гэх нэршилтэй бодисыг эд мөрийн баримтаар эрүүгийн болон хэрэг бүртгэлтийн хэрэгт хураагдсан үед шинжээч томилж шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулж байгаа боловч хэрэглэсэн буюу хүний биологийн дээж болох шээс, цус зэргээс тухайн бодисыг илрүүлж чадахгүй байна. (Судлаачийн мөрдөн шалгах эрх бүхий алба хаагч нартай хийсэн фокус ярилцлага, 2025)

Мөн тэнсэн харгалзах ялтай байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад байдаг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээдүүдээс 14 хоногт 1 удаа биологийн дээж болох шээсийг нь авч шалгахад урд өмнө нь ял шийтгэл эдлэхдээ хэрэглэсэн бодисоос өөр төрлийн буюу шээснээс илрүүлэх боломжгүй мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг олж хэрэглэж байна. Дээрх хяналтад байгаа этгээдүүдийн хэрэглэж байгаа сентитек гаралтай бодисууд нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенцын жагсаалтад байхгүй, шинээр химийн аргаар гаргаж авсан мансууруулах бодисууд байна.

Монгол Улсын хувьд мөрдөн шалгах эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тогтоолын дагуу Шүүх Шинжилгээний Ерөнхий газарт хийгдсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын шинжилгээнд шинэ төрлийн мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын эзлэх хувь 2022 онд 1%, 2023 онд 2%, 2024 онд 13%, 2025 оны эхний 10 сарын байдлаар 20%-г эзэлж байгаа нь синтетик гаралтай бодисын хэрэглээ хурдацтай ихсэж байгаа болохыг харуулж байна. (Д.Золзаяа, 2025)

Олон улсад хүний биед хурдан задардаг **Mdmb-4en-PINACA** гэх бодисын хувьд эх бодисыг биш түүнээс задарч үүссэн метаболитуудыг илрүүлэх (colleagues, 2020) зорилгоор хольц, уургийг салгах, дээжийг ууршуулж уусгагчид уусгах, илрүүлэх шинжилгээнд High-Resolution Mass Spectrometry (HRMS), triple quadrupole (QQQ) MS/MS, UHPLC- Ultra-High-Performance Liquid Chromatography зэрэг багажуудыг ашигладаг байна. (B.V., 2020)

Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагад одоогийн байдлаар мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх шинжилгээнд MSD - Хийн хроматографи ба масс спектрометр (Agilent technology GC 7820G 5977 E), MS Шингэний хроматографи ба масс спектрометр (Agilent technology 1290 HPLC 6530 QTQF), LC/MS - Шингэний хроматографи ба масс спектрометр (Agilent

1290/Sciex QTRAP 4500), GC/MSD- Хийн хромотограф масс спектрометр (Agilent 8890GC system 5977), Хийн хромотограф (Agilent system 7697G Headspace sampler) зэрэг багаж, төхөөрөмжийг ашиглаж байна.

Дүгнэлт, дэвшүүлж буй санал: Монгол Улсад мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чадавх сул байна. Учир нь энэ төрлийн гэмт хэрэг жилээс жилд өсөж, Монгол Улсын иргэд дээрх бодисыг хэрэглэж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж, олон нийт айдас түгшүүрт амьдарч байна. Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шаардлага Монгол Улсын нэн тэргүүний асуудал болсон бөгөөд мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болон Шүүх Шинжилгээний Ерөнхий газрын хамтын ажиллагааг хууль эрх зүйн орчинд улам өргөжүүлэх, тус газарт дэвшилтэт шинэ техник технологийг нэвтрүүлэх, алба хаагч нарын мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай байгааг харуулж байна гэж судлаач бид дүгнэж дараах саналуудыг гаргалаа. Үүнд:

1. Шүүх Шинжилгээний Ерөнхий газар “Шүүх Шинжилгээний тухай хууль”-д нийцүүлэн “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодист шинжилгээ хийх журам” шинээр боловсруулан үйл ажиллагаанд ашиглах (Журмын төсөл хавсралт №1);
2. АНУ, БНСУ, ХБНГУ-ын Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэж буй, шинжилгээний байгууллагын үндэслэл бүхий дүгнэлт гаргаж буй дараах туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх;

- Шүүх Шинжилгээний Ерөнхий газарт “Methamphetamine Profiling Program (MPP)”-г нэвтрүүлж тухайн программаар дамжуулан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хольцын бүтэц, катализаторын ул мөр, изомерын харьцааг шинжилж, тухайн бодисыг лабораторийн гаралтай эсэхийг тогтоох;
- Бодисын цэвэршилт болон найрлагыг тогтоох шинжилгээг урвалж ба катализаторын хольцын шинжилгээ, урвалын үлдэгдлийн харьцаанд тулгуурлан тодорхойлох;
- ХБНГУ-ын Шүүх Шинжилгээний байгууллага нь газын хроматограф–изотопийн масс спектрометр (GC–IRMS) ашиглан синтетик гаралтай бодисын изотопын найрлагын харьцаа ($\delta^{13}C$, $\delta^{15}N$)-г тогтоож, геохимийн гарал буюу үйлдвэрлэсэн бүс нутгийг тогтоох;
- Метамфетамины хольцын бүтэц, синтезийн зам, уусгагчийн үлдэгдэл зэрэг шинжүүдийг тодорхойлоход “Multivariate chemometric (PCA, cluster analysis, discriminant analysis)” аргыг ашиглан цэвэршилтийн профайл (impurity profile) гаргах шинжилгээнүүд нь мөрдөн шалгах ажиллагаанд маш чухал нөлөө үзүүлж байх тул дээрх аргуудыг ашиглах үйл ажиллагаанд нэвтрүүлэх. Мөн Шүүх Шинжилгээний Ерөнхий газарт дээрх шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэхэд UHPLC зэрэг багажийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

3. Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодист шинжилгээ хийж шинжээчийн дүгнэлт гаргуулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх, шинэ төрлийн буюу синтетик гаралтай бодисыг илрүүлэх, тухайн бодисын гарал үүсэл, химийн бүтэц зэргийг нарийвчлан тогтоож, шинжээчийн дүгнэлт гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нэгж (Шинжээч мөрдөгч)-ийг Шүүх Шинжилгээний Ерөнхий газарт байгуулах хэрэгцээ шаардлагын талаарх судалгааг хийх;

Ашигласан эх сурвалж

Хууль тогтоомжийн хүрээнд:

1. НҮБ-ын Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц. 1961 он.
2. НҮБ-ын Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц. 1971 он.
3. Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он.
4. Эрүүгийн хууль. УБ. 2017 он.
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017 он.
6. Шүүх Шинжилгээний тухай хууль. УБ. 2022 он.
7. Зөрчлийн тухай хууль. УБ. 2017 он.
8. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1 дүгээр заалт. //Төрийн мэдээлэл. 2010. №48.

9. Монгол Улсын Их хурлын тогтоол. Оршин тогтнохуйн аюулгүй байдал хэсгийн хүн ам, удмын сангийн аюулгүй байдлын 3.1.3.4 дэх заалт. //Төрийн мэдээлэл. 2022.№1.

10. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/227 дугаар тушаал.

Ном зохиолын хүрээнд:

11. Судлаачийн мөрдөн шалгах эрх бүхий алба хаагч нартай хийсэн фокус ярилцлага. УБ. 2025. №1.

12. Б.Алтансүх. Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн олон улсын нөхцөл байдал, ковид-19 цар тахлын нөлөөлөл. Хууль сахиулахуй. УБ. 2020. №2(24). Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл.

13. Д.Золзаяа, Г.Золжаргал. Монгол Улсад бүртгэгдсэн шинэ төрлийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын нөхцөл байдал, чиг хандлага. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ 2025.

14. Andersson, A., & colleagues. (2020). In vitro phase I metabolism of the recently emerged synthetic MDMB-4en-PINACA and its detection in human urine samples. Journal of Analytical Toxicology.

15. Metabolic profiles and screening tactics for MDMB-4en-PINACA in human matrices“. (2022). Elsevier B.V.

Цахим эх сурвалж

16. https://www.swgdrug.org/

17. Monitoring methamphetamine in the United States: A two-decade review as seen by the DEA methamphetamine profiling program. U.S. Government work. **Published 2021**.

18. https://nfs.go.kr/site/eng/01/10102020000002017092005. БНСУ-ын Шүүх шинжилгээний албаны цахим сайт.

19. Synthetic cannabinoids abused in South Korea: Drug identifications by the National Forensic Service from 2009 to June 2013

20. https://www.berlin.de/polizei/dienststellen/landeskriminalamt/lka-kriminaltechnik/artikel.958591

21. Novel approaches for impurity and isotopic profiling… — describes GC-IRMS methods and chemometric evaluation used in German forensic research contexts. (PhD dissertation / institutional report.

22. https://nfs.go.kr/site/eng/01/10102020000002017092005. БНСУ-ын Шүүх шинжилгээний албаны цахим сайт.

23. Synthetic cannabinoids abused in South Korea: Drug identifications by the National Forensic Service from 2009 to June 2013

24. https://www.berlin.de/polizei/dienststellen/landeskriminalamt/lka-kriminaltechnik/artikel.958591

Байгууллагын тайлан, статистик мэдээлэл ашигласан байдал.

25. Шүүх Шинжилгээний Хүрээлэнгийн тайлан. УБ. 2020 он.

26. Шүүх Шинжилгээний Хүрээлэнгийн тайлан. УБ. 2021 он.

27. Шүүх Шинжилгээний Хүрээлэнгийн тайлан. УБ. 2022 он.

28. Шүүх Шинжилгээний Хүрээлэнгийн тайлан. УБ. 2023 он.

29. Шүүх Шинжилгээний Ерөнхий газрын тайлан. УБ.2024 он.

30. Шүүх Шинжилгээний Ерөнхий газрын статистик мэдээлэл. УБ. 2025 он.

31. Цагдаагийн Ерөнхий газрын статистик мэдээлэл. УБ.2025. №3

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТҮҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ILLEGAL HUNTING CRIME, VIOLATION CONDITIONS AND ANALYSIS

Ц.Ялалт*
Судлаач, доктор (Ph.D)
Yalalt Ts.
Researcher, Ph.D.
Д.Мягмарцэрэн
Шүүхийн сахилгын хорооны гишүүн, доктор (Ph.D), дэд профессор
Myagmartseren D.
Member of the Judicial Disciplinary Committee, Ph.D., Professor

*Хариуцлагатай зохиогч: Yalaltye@gmail.com

Хураангуй: Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс хамгийн түгээмэл үйлдэгддэг гэмт хэрэг бол хууль бусаар ан агнах гэмт хэрэг юм. Энэхүү гэмт хэрэг нь үйлдлийн хувьд нууц далд аргаар үйлдэгддэг бөгөөд амьтны эд эрхтний зарж борлуулах, тээвэрлэх, хадгалах, хил дамжуулан худалдаалах зэрэг үргэлжилсэн үйлдлээр үйлдэгддэг, нийгмийн хор аюул ихтэй байдаг. Тус гэмт хэргийг үйлдэхэд хүргэдэг үндсэн шалтгаан нөхцөл бол ашиг орлого олохоос гадна ард нийтийн дунд тархсан уламжлалт эмчилгээний арга, ярианаас үүдэлтэйгээр амьтны эд эрхтнийг авах зорилгоор агнах, зарж борлуулах, тээвэрлэх, худалдан авах үйлдэл түгээмэл байна. Мөн гоёл чимэглэл, бэлэг дурсгалын зүйл хийх, шашны зан үйлд хэрэглэх зорилгоор нууц далд аргаар үйлдэгдэж байна. Нууц далд аргаар үйлдэгддэг энэхүү гэмт хэргийн гаралт, үйлдлийн хэлбэр, зорилго нь техник технологийн хөгжил, хотжилт, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч хувьсан өөрчлөгдөж, агнахаас илүүтэйгээр амьтны эд эрхтнийг худалдаалах үйлдэл илүү давамгайлж хил дамнасан, зохион байгуулалттай сүлжээ хэлбэрт шилжсэн байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийн гаралт, нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ эрх зүйн орчныг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан тулгамдаж буй асуудлыг нээн гаргаж, түүнийг шийдвэрлэх арга замын талаар саналаа илэрхийлсэн болно.

Abstract: The report analyzes the incidence and circumstances of illegal hunting crimes and violations, identifies their impact on the balance of the ecosystem, and presents proposals for solutions to address the current legal environment and the challenges it faces.


Түлхүүр үгс: Ан амьтан, гэмт хэрэг, зөрчил.
Keywords: Wildlife, crime, and conflict.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, эрх зүйн ухамсар, соёл, иргэдийн амьжиргаанаас хамаарч хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт, түүний улмаас учирч буй хохирол жилээс жилд өсөж байна. Үүн дотроос эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлд заасан Хууль бусаар ан агнах гэмт хэрэг улам бүр өсөн нэмэгдэж учруулах хор хохирол нь тухайн орон нутгаас гадна бүс нутаг, улсын хэмжээнд нөлөөлөх болсон байна. Иймд хууль бусаар ан агнах гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн тодорхойлсон болно.

Манай улсын байгаль цаг уур, газар орны онцлогт зохицон оршдог амьтдын тархац өргөн уудам газар нутагт харилцан адилгүй бөгөөд нийтдээ 128 зүйлийн хөхтөн амьтан бүртгэгдсэн байгааг судлаачид тогтоосон байдаг.

Тэдгээр хөхтөн амьтдын 60 орчим зүйл нь Монгол орны Хөвсгөлийн уулс, Хэнтий, Хангай нурууны хойд хэсгээр нутагладаг. Хөхтөн амьтны зүйлийн баялаг нь тус орны хойд нутгаар хамгийн өндөр үзүүлэлттэй байдаг.

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia



Зураг 1. Монгол орны хөхтөн амьтны зүйлийн байдал
(Өнгө тодрох тусад амьтны нөөц баялаг элбэг байгаа болно.)

Манай оронд агнуурын ач холбогдолтой 60 шахам зүйл хөхтөн байгаа ба эдгээрээс 24 зүйл нь агнуурын үндсэн амьтад ба тэдгээрээс цөөн тоогоор агнадаг 32, агнаж заншаагүй 4 зүйл амьтад байна. (Монгол орны байгаль орчны өнөөгийн байдлын тойм. УБ.,2006. 18 дах тал., 2006).

Монгол орны амьтны 45 хувь нь уламжлалт ан агнуурын өргөн ач холбогдолтой амьтад байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд олон хөхтөн амьтдын тоо толгой хурдацтайгаар цөөрсөн байгааг судлаачид тогтоож, тэдгээрийн тоо толгой ховордож буурахад нөлөөлж буй шалтгааныг гурван хэсэгт хуваан ангилжээ.

Үүний эхний шалтгаан нь амьтны амьдрах орчны доройтол бөгөөд хоёрдогч шалтгаанд ан агнуур, гуравдагч шалтгаан нь амьтдын амьдрах орчны хуваагдал болсныг Монгол Улсын хөхтөн амьтны улаан дансанд тэмдэглэжээ. (Монгол Улсын хөхтөн амьтны улаан данс, 2006)

Хөхтөн амьтны ховордлын хоёрдогч шалтгаан болсон агнуурыг хууль ёсны болон хууль бус агнуур гэж үзэж, хууль бус үйлдлийг хориглох, түүнтэй тэмцэх, хууль ёсны агнуурыг эрх зүйн хувьд зохицуулах шаардлага нийгэмд үүссэн байдаг.

Тухайн жилд агнах амьтны тоо хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосноор амьтныг өсгөн үржүүлэх, сүргийн бүтцийг алдагдуулахгүй, нөөцийг зөв ашиглах нөхцөлийг бүрдүүлж өгдгөөрөө олон талын ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, хууль ёсны агнуур нь хууль бус агнууртай тэмцэх онцгой хэлбэр болно.

Тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтоохоор хуульчилж, эрх зохицуулалтыг бий болгосон.




Chart 1. Quantitative indicators of game animals hunted and captured for special purposes

Дээрх агнуур нь хяналттай бөгөөд түүнийг зохицуулах боломжтой бол хууль бус агнуурыг гаргахгүй байх, түүнтэй тэмцэх явдал нь байгаль орчныг хамгаалах ажлын салшгүй нэг хэсэг мөн.

Ан амьтныг гэмт халдлагаас хамгаалах олон арга байх бөгөөд эдгээрээс хамгийн чухал нөлөө бүхий арга бол эрх зүйн хамгаалалт юм. Монгол Улсад үйлдэгдэж буй хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс нэлээд түгээмэл үйлдэгддэг гэмт хэрэг бол хууль бусаар ан агнах гэмт хэрэг юм.

Монгол Улс байгаль орчны чиглэлээр олон улсын 23 гэрээ конвенцод нэгдэн орсон бөгөөд үүнээс амьтан, ургамлыг хамгаалах, түүний эрх зүйн зохицуулалттай холбоотой 6 олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж соёрхон баталсан байна. Тодруулбал, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (Төрийн мэдээлэл, 2010), Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Төрийн мэдээлэл, эмхэтгэл, 2010), Биологийн олон янз байдлын тухай конвенц (Төрийн мэдээлэл, 2010), Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцид (Төрийн мэдээлэл, 2010) нэгдэн орсон бөгөөд дээрх конвенциудын зарчим, агуулга, үзэл санааг үндэсний хууль тогтоомжууддаа тусгасан байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг эрх зүйн зохицуулалт үндсэндээ бүрдсэн гэж үзэж болох бөгөөд 2023 оны байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 880 хуулиас 110 орчим хуульд хүрээлэн буй орчныг асуудлыг зохицуулсан хуулиуд үйлчилж байна. Эдгээрээс амьтантай холбоотой харилцааг зохицуулсан 11 хууль, түүнтэй нийцүүлэн гарсан 20 орчим хуульчилсан актыг даган мөрдөж байна. Монгол Улсын Үндсэн хуульд (https://legalinfo.mn, 1992) “амьтан” ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад байна. Иргэдэд өмчлүүлснээс бусад ан амьтан төрийн нийтийн өмч байна” гэж төрийн бодлогын үндсийг тодорхойлсон байна.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн (https://legalinfo.mn, 2015) 24.5 дугаар зүйлд “Хууль бусаар ан агнах” гэмт хэргийн шинжийг:

“1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн.

2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан,

худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн гэж тодорхойлон заасан байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг гэдэг нь амьтныг зорих зөвшөөрөлгүйгээр агнах, барих болон амьтны эд эрхтнийг бэлтгэх, худалдаалах, үржүүлэх, тээвэрлэх, түүхий эдийг хадгалах, амьтны амьдрах орчныг алдагдуулах, чихмэл цуглуулаг хийх үйлдлүүдийн нийлбэр юм (Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд, 2022).

Ан амьтны эрүүгийн эрх зүйн хамгаалалт нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хүрээлэн буй орчны онцлогтой нийцүүлэн үе үеийн эрүүгийн хуулиудад тусгагдаж, цаг хугацааны туршид нэмэлт, өөрчлөлт орон баяжигдаж ирсэн байна. Тухайлбал, 2002 оны Эрүүгийн хуульд "Ан агнуурын хууль тогтоомж зөрчих" гэж хуульчилсан бөгөөд тус хуулиар зөвхөн хууль бусар амьтан агнасан, барьсан болон нэн ховор амьтны үр төл, түүхий эдийг улсын хичээл гаргасан үйлдлийг л гэмт хэрэгт тооцож байв. Энэ нь тухайн үед элбэгшээд байсан амьтны эд эрхтнийг худалдаалах үйлдлийг хуульчлаагүй нь нууц далд аргаар үйлдэгддэг эл үйлдэлтэй тэмцэх, таслан зогсоох боломжгүй байсан тул 2008 онд Эрүүгийн хуулийн 203 дугаар зүйлд (Төрийн мэдээлэл эмхэтгэл №5 , 2008) тэдгээрийн түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн гэж нэмэлт өөрчлөлт оруулж объектыг өргөтгөсөн байна. 2015 оны Эрүүгийн хуульд "чихмэл", "цуглуулга хийсэн", "үржүүлсэн", "амьдрах орчныг алдагдуулсан", "бэлтгэсэн" зэрэг нэмэлтүүдийг зохицуулсан байна.

2002 оны Эрүүгийн хууль	*2008 оны Эрүүгийн хууль*	*2015 оны Эрүүгийн хууль*
203 дугаар зүйл. **Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих**	***203 дугаар зүйл.*** **Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих**	***24.5 дугаар зүйл.*** **Хууль бусаар ан агнах**
203.1. Хориотой үед, хориглосон газарт болон хориглосон арга, зэвсэг хэрэгслээр ан амьтан агнасан, барьсны улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан, агнахыг хориглосон ан амьтныг зохих зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан	203.1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт болон хориотой үед, хориглосон арга, зэвсэг, хэрэгслээр ан амьтан агнасан, барьсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, ховор ан амьтныг зохих зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, **тэжээж гаршуулсан, тэдгээрийн түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн бол**	1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн**, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол**
203.2. Нэн ховор ан амьтан агнасан, барьсан, ~~хууль бусаар түүний үр төл, түүхий эдийн зүйлийг улсын хилээр гаргасан бол~~	203.2.Энэ хэргийн улмаас их буюу ~~онц их хэмжээний хохирол учирсан,~~ нэн ховор ан амьтан агнасан, барьсан бол	2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, **зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол**

Хүснэгт 1. Монгол Улсын Эрүүгийн хуулиуд дахь "Хууль бусаар ан агнах гэмт хэргийн харьцуулалт"

2015 оны Эрүүгийн хууль дах хууль бусаар ан агнах гэмт хэргийн талаар эрх зүйн зохицуулалтад гарсан нэгэн ахицтай нэмэлт өөрчлөлт бол 2008 оны Эрүүгийн хуулиар амьтны эд эрхтнийг хилээр хууль бусаар гаргасан үйлдлийг 175 дугаар зүйл буюу "Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх" гэсэн өөр зүйлд хамааруулж байсныг 24.5 дахь зүйлд нэгтгэн хамааруулсан нь өмнөх хуулиас ахиц гарч ойлголтыг нэгтгэсэн байна.

Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2013-2023 оны байдлаар 358 хууль бусаар ан агнах гэмт хэргийн шийдвэрлэж 46 хүнд холбогдох 22 хэргийг прокурорт буцааж, 6 хүнд холбогдох 2 хэргийг цагаатгаж, 381 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон байна.




Chart. 2. Court decisions 2013-2024

2013-2024 оны байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 99639 хэрэг хянан шийдвэрлэсэн байх ба жилд дунджаар 9963.9 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Жилд хянан шийдвэрлэж буй эрүүгийн хэргийн дунджаар 0.4 хувийг Хууль бусаар ан агнах гэмт хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Огноо	**Хянан шийдвэрлэсэн хэрэг** /Хууль бусаар ан агнах/	**Хянан шийдвэрлэсэн нийт хэрэг**	**Эзлэх хувь**
2013 он	27	6169	0.4
2014 он	22	6375	0.3
2015 он	32	6756	0.5
2016 он	18	5762	0.3
2017 он	25	8839	0.3
2018 он	26	12551	0.2
2019 он	30	13427	0.2
2020 он	64	12088	0.5
2021 он	57	13470	0.4
2022 он	57	14202	0.4
2023 он	61	14208	0.4
2024 он	78	13690	0.4
2025 он	89	14800	0.5

Хүснэгт 2. Хууль бусаар ан агнах /2013-2025 он/

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгт 2018-2025 оны байдлаар 17 тэр бум 835 сая 830 мянга 187 төгрөгийн хохирол учирснаас хууль бус ан агнах гэмт хэргийн улмаас 1 тэрбум 725 сая 407 мянга 34 төгрөгийн хохирол учирсан байна. Үүнээс 42,5 хувь буюу 1 тэрбум 574 сая 799 мянга 854 төгрөгийн хохирлыг нөхөн төлжээ.

Дээрх судалгааны дүнгээс үзэхэд жил бүр хууль бусаар ан агнах гэмт хэргийн гаралт, түүний шийдвэрлэлт өсөж байна. 2018-2025 онд үйлдэгдсэн нийт 336 хууль бусаар ан агнах гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдалд дүн шинжилгээ хийн дараах шалтгаан нөхцөлөөр тус гэмт хэрэг үйлдэгдэж байна гэж үзэв. Үүнд:

1. Ямар нэгэн эдийн засгийн үр шим хүртэх, ашиг орлого олох зорилгогүйгээр зөвхөн хувийн хэрэгцээнд зориулан тухайлбал хоол хүнсэндээ хэрэглэх зорилгоор амьтан агнах тохиолдол нийт гэмт хэргийн нэлээдгүй хувийг эзэлж байна.

2. Худалдаа наймаа хийж ашиг олох зорилгоор үйлдэгдсэн байдал нийт хэргийн 35 хувийг эзэлж байна. Тухайлбал, Хурдан морины хөлсийг хусах хусуурыг хийх зорилгоор хотон шувууны хошууг авахын тулд агнах, баавгайн савар, арьсыг зарж борлуулах гэх мэт дурдаж болно.

3. Эм эмчилгээний зориулалтаар агнах, барих, энэ зорилгоор амьтны эд эрхтнийг худалдан авах. Иргэдийн дунд уламжлалт анагаах ухаанд хэрэглэж байсан ан амьтны эд эрхтнийг эмчилгээнд хэрэглэх хандлага түгээмэл байна. Тухайлбал, элэгний өвчтэй тул зэрлэг гахайн элгийг авах зорилгоор агнасан (Баян-Өлгийн аймгийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2021), хагалгаанд ороход хойлгийн мах сайн гэсэн тул хойлог агнасан (ХУД-ийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2023) гэх мэт.

4. Гадаад улс руу өндөр ашиг олох зорилгоор хууль бус худалдаа хийх, зохион байгуулах. Гэмт этгээдүүд амьтны эд эрхтнийг биедээ болон автомашин тээврийн хэрэгсэлд нууж хил гарах нэн ялангуяа БНХАУ руу гаргах тохиолдол их байна.

5. Зэрлэг амьтдын довтолгооноос биеэ хамгаалах зорилгоор эсвэл өөр амьтантай андуурч агнах. Энэ тохиолдолд гэмт хэрэг үйлдэгч нь ан амьтан болон эрх зүйн мэдлэг ойлголт дутуу дулимаг, мэдээлэлгүй байгаа нь харагддаг. Мөн байгалийн жамаар үхсэн амьтны ялангуяа нэн ховор, ховор амьтны эд эрхтнийг сонирхон авч хадгалснаар тухайн гэмт хэргийн субъект болох тохиолдол түгээмэл байна.

6. Гадаад улсын иргэдэд хууль бусаар ан агнах гэмт хэргийг үйлдэж байна. Гадаадын иргэд дангаараа энэ гэмт хэргийн үйлдэх нь маш ховор бөгөөд түүнд тусалсан, тээвэрлэсэн, зааж зөвлөсөн хүмүүс нь Монгол Улсын иргэд байх бөгөөд зарим тохиолдолд зохион байгуулалттай сүлжээ хэлбэрээр үйлдэгдэж байна. Нөгөө талаас гадаадын иргэдийн хувьд Монгол Улсын хууль тогтоомжийг мэдэхгүйгээсээ болж энэ төрлийн гэмт хэрэгт холбогдох тохиолдол нэлээдгүй байгаа тул тэдэнд урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, аяллын зорилгыг тодорхой болгох, мөн тэдэнд үйлчилж буй орчуулагч, жолооч нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах шаардлагатай байна.

7. Тусгай хамгаалалттай газар нутагт элбэг тархацтай амьтан агнах. Тухайн газар нутгийг тусгай хамгаалалттай газар нутаг гэж мэдээгүйн улмаас ан агнасан нь мөн л энэ чиглэлийн буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах шаардлага тулгарч байна.

зэрэг болно.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг үйлдэхдээ дараах зэвсэг хэрэгслийг түгээмэл ашиглаж байна (Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд, 2022). Үүнд:

1. Амьтан өөрөө баригч, агнах хэрэгсэл. Үүнд занга, сааль, хаж, баригч нүх, тэвх зэрэг багаж хэрэгслүүд орно.

2. Галт зэвсэг. Энэ нь ан агнах гол хэрэгсэл юм. Төрөл бүрийн их, бага калибрын хол, ойрын тусгалтай бууг ашиглаж байна.

3. Амьтнаар бариулах. Тусгайлан сургасан амьтнаар агнуулах бөгөөд гол төлөв нохой, шувуугаар агнадаг.

4. Амьдаар нь баригч багаж хэрэгсэл. Үслэг жижиг мэрэгч амьтан шувуу барих болон загасны элдэв тор, хашлага, хаалт байна.

Дээрх зэвсэг, хэрэгслээс гадна тухайн амьтныг машин, мотоциклоор хөөж бахардуулах, эцээх маягаар агнаж байгаа бөгөөд нэн ялангуяа малчдын хувьд мод, чулуугаар цохих зэргээр агнаж байна.

Дүгнэлт

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн бүтэц, гаралт, шинж байдал нь техник технологийн хөгжлийг даган улам бүр хувьсан өөрчлөгдөж байна.

1. Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэг хангалтгүй байгаа нь сөргөөр нөлөөлж байна. Мөн нийгэм, эдийн засгийн байдлаас хамааран иргэдийн амьжиргааны түвшин улам бүр доройтож байгаа нь иргэдийг ямар ч эрсдэлийг хүлээгээд ч болов мөнгөтэй болох гэсэн сэтгэл зүй ихээхэн нөлөөлж байна.

2. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг нууц, далд аргаар үйлдэгддэг тул гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгахад саад учирч байна.

Санал

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж буй ухуулга, сурталчилгаа, тэдгээрийн давтамж, хүртээмжийн ач холбогдлыг тухай бүр тооцож, шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах шаардлагатай.

2. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь нууц, далд аргаар үйлдэгддэг бөгөөд гол төлөв иргэдийн мэдээллийн үндсэн дээр илэрдэг тул иргэдийн оролцоог хангах, тэднийг идэвхжүүлэх, урамшуулах шаардлагатай тохиолдолд хууль сахиулах байгууллагын хамгаалалтад авах зэрэг үйл ажиллагааг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

3. Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлд заасан амьтны түүхий эдийг “хадгалсан” үйлдэлд нөхөн төлбөр тогтоох эсэх, хэрхэх талаар нэгдсэн журмыг баталж хэрэгжүүлэх шаардлагатай.

4. Ан агнахдаа ашигласан зэвсэг хэрэгслээс шалтгаалан оногдуулах хууль зүйн хариуцлагыг ялгамжтай оногдуулах. Тухайлбал, амьтныг машин, мотоциклоор хөөж бахардуулах, эцээх нь амьтны жам ёсны эрхийг зөрчиж хүнлэг бус хандаж байгаа тул үйлдлийн шалтгаан нөхцөлийг харгалзан ялгамжтай байдлаар хууль зүйн хариуцлагыг оногдуулах зэрэг болно.

Эх сурвалж

Нэг. Хууль тогтоомж

1.1. Монгол Улсын Үндсэн хууль . (1992). Төрийн мэдээлэл эмхэтгэл №1.

1.2. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №5 . (2008).

1.3. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №9. 2010.

Хоёр. Шүүхийн шийдвэр

2.1. Баян-Өлгийн аймгийн анхан шатны шүүхийн шийдвэр, 088 (Баян-Өлгий аймаг 2021).

2.2. ХУД-ийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2023/746 (ХУД-ийн шүүх 2023).

Гурав. Судалгааны тайлан, гарын авлага

3.1. Лондонгийн Амьтан судлалын нийгэмлэг. Монгол Улсын хөхтөн амьтны Улаан данс.УБ.,2006

3.2. Монгол орны байгаль орчны өнөөгийн байдлын тойм. УБ.,2006.

3.3. (Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд, 2022)

Дөрөв. Цахим эх сурвалж

4.1. www.http//shuukh.mn

4.2. www.http//legalinfo.mn

МӨРДӨН БАЙЦААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ
LEGAL STATUS OF THE INVESTIGATOR

М.Билгүүн*
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлагч
Bilguun M.
Police school, University of Internal Affairs, Lecturer, Police sergeant

*Хариуцлагатай зохиогч: beck.realmadrid1@gmail.com

Хураангуй: Мөрдөгчийн эрх зүйн байдлыг онолын болон хэрэглээний хоёр тал дээр нарийвчлан судлах зорилготой юм. Мөрдөгч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хамгийн чухал субъектүүдийн нэг бөгөөд нотлох баримт цуглуулах, хэрэг бүртгэлт хийх, мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Судалгааны гол зорилго нь Монгол Улсын эрүүгийн процессын хүрээнд мөрдөгчийн эрх зүйн байдлыг бүрдүүлдэг эрх, үүрэг, хариуцлага, баталгаа болон нийгэмд гүйцэтгэж буй дүрийг иж бүрнээр тодорхойлох явдал юм. Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, харьцуулсан эрх зүйн арга болон системийн шинжилгээний аргыг хосолж ашигласан болно. Харьцуулсан судалгааны хүрээнд Герман, Франц, Япон, АНУ болон ОХУ-ын тогтолцоог тус тус авч үзэж, Монгол Улстай харьцуулан дүн шинжилгээ хийсэн. Судалгааны дүнд мөрдөгчийн хуулиар тогтоосон эрх зүйн байдал практик хэрэгжилтийн хувьд хэд хэдэн бэрхшээлтэй тулгарч байгааг илрүүлсэн бөгөөд тухайлбал прокурорын хэт төвлөрсөн хяналт, институцийн бие даасан байдлын дутагдал, мэргэжлийн баталгааны хангалтгүй тогтолцоо зэрэг нь мөрдөгчийн үйл ажиллагааны үр нөлөөг бууруулах хандлагатай байгааг тогтоов. Эдгээр дүгнэлтэд үндэслэн хуулийн орчныг боловсронгуй болгох, мөрдөгчийн бие даасан байдлыг хуульчлан баталгаажуулах болон мэргэжлийн сургалтын тогтолцоог шинэчлэх зэрэг тодорхой санал дэвшүүлэв.

Abstract: This article provides an in-depth examination of the legal status of investigators from both theoretical and applied perspectives. The investigator is one of the most critical actors in criminal proceedings, bearing primary responsibility for gathering evidence, conducting preliminary inquiries, and implementing investigative measures. The central aim of this study is to comprehensively define the rights, duties, responsibilities, procedural guarantees, and societal role that constitute the legal status of an investigator within Mongolia's criminal justice framework. To this end, the study employs document analysis, comparative legal methodology, and systems analysis in combination. The comparative component examines investigative frameworks in Germany, France, Japan, the United States, and Russia, benchmarking each against Mongolia's existing system. The findings reveal that the legally established status of investigators encounters several practical challenges, including excessive centralization of prosecutorial oversight, insufficient institutional independence, and an underdeveloped system of professional guarantees, all of which tend to diminish the effectiveness of investigative work. Drawing on these conclusions, specific recommendations are advanced to improve the legislative environment, legally entrench investigator independence, and reform professional training systems.

Түлхүүр үг: мөрдөгч, эрх зүйн байдал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, прокурорын хяналт, институцийн бие даасан байдал, харьцуулсан эрх зүй.

Keywords: investigator, legal status, criminal procedure, prosecutorial supervision, institutional independence, comparative law.

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн нь нотлох баримтыг хэрхэн цуглуулж, боловсруулж, үнэлснээс шууд хамаарна. Энэхүү нотлох ажиллагааны голлох субъект нь мөрдөгч юм. Тиймээс мөрдөгчийн эрх зүйн байдлыг зөв тодорхойлж, хуульчлан баталгаажуулах асуудал нь зөвхөн онолын биш, практик ач холбогдолтой юм. Учир нь мөрдөгчийн процессын байдал нь нэг талаас хэрэгт оролцогч талуудын эрхийн баталгаатай шууд холбоотой бол нөгөө талаас шударга ёсны тогтолцоонд бүхэлд нь нөлөөлдөг (Redmayne, 2010)

Монгол Улсад 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид ЭХХШТХ гэх) нь мөрдөгчийн тухай хэд хэдэн зохицуулалтыг тусгасан боловч тэдгээр зохицуулалт нь бодит хэрэгжилтийнхээ хувьд хэд хэдэн бэрхшээлтэй тулгарч байна. Тухайлбал прокурорын хяналтын хүрээний тодорхойгүй байдал, мөрдөгчийн шийдвэр гаргах эрхийн хэмжээ болон байгууллагын дотоод шатлалын нөлөөлөл зэрэг асуудлууд харьцангуй шийдэгдэлгүй үлдсэн байна.

Дэлхийн олон улсад мөрдөгчийн эрх зүйн байдлыг хуульчлах хандлага харилцан адилгүй бөгөөд Ром-Герман болон Англи-саксон хоёр том системийн ялгаа нь мөрдөгчийн институцийн загварт мэдэгдэхүйц нөлөөлдөг (Damaska, 1986). Иймд Монгол Улсын тогтолцоог харьцуулсан судалгааны аргаар бусад улсуудтай жишиж судлах нь шинэчлэлийн чиглэл тодорхойлоход зайлшгүй шаардлагатай.

Энэхүү өгүүллийн судалгааны зорилго нь мөрдөгчийн эрх зүйн байдлын онолын тогтолцоог тодорхойлох, Монгол Улсын хуулийн зохицуулалтыг шинжлэх, гадаад улсын туршлагатай харьцуулан дүн шинжилгээ хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох тодорхой санал дэвшүүлэхэд оршино.

Судалгааны арга зүй нь судлагдаж буй асуудлын онцлог, нарийн төвөгтэй байдлыг харгалзан тодорхойлогдсон. Тус өгүүлэлд дараах дөрвөн аргыг цогц байдлаар ашиглав.

1. Баримт бичгийн шинжилгээний арга: Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Цагдаагийн тухай хууль болон холбогдох дүрэм журмуудыг системтэйгээр дүн шинжилгээ хийж, мөрдөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлдог хуулийн нормуудыг хамруулан авч үзэв. Үүнтэй зэрэгцэн Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол болон Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүдийг хамруулан судалсан нь хуулийн нормын бодит тайлбар болон хэрэглээний талыг тодруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

2. Харьцуулсан эрх зүйн арга: Харьцуулсан эрх зүйн арга нь нэг улсын эрх зүйн институцийг ойлгохын тулд гадаадын тогтолцоотой жишин судлах аргачлал бөгөөд (Zweigert & Kötz, 1998) тус судалгаанд Герман, Франц, Япон, АНУ болон ОХУ-ын мөрдөн шалгах тогтолцоог хамруулан Монгол улстай харьцуулав. Эдгээр улсуудыг сонгохдоо тэдгээр нь янз бүрийн эрх зүйн гэр бүлд харьяалагдах болон Монгол Улсын хуулийн хөгжилд янз бүрийн хэмжээгээр нөлөөлсөн гэдгийг голлон харгалзсан.

3. Системийн шинжилгээний арга: Мөрдөгчийн эрх зүйн байдлыг тусгаарлагдсан хэлбэрээр биш, харин эрүүгийн процессын бүхэл бүтэн тогтолцооны нэг хэсэг болгон авч үзсэн. Ингэснээр тухайн институцийн доторх уялдаа холбоо болон бусад процессын субъектуудтай харилцааны зүй тогтлыг тодорхойлох боломж бүрдсэн.

4. Индукц, дедукцийн арга: Ерөнхий онолын зарчмаас тодорхой хуулийн нормуудыг дүн шинжилгээ хийх дедукцийн болон тодорхой хуулийн нормуудаас ерөнхий дүгнэлт гарган авах индукцийн аргуудыг хосолж ашигласнаар судалгааны үр дүн илүү иж бүрэн, баталгаатай болсон.

1. Мөрдөгчийн эрх зүйн байдлын онолын үндэс

Эрх зүйн байдал гэдэг нь ерөнхийдөө аливаа субъектийн хуулиар тогтоосон эрх, үүрэг, хариуцлагын нэгдлийг хэлнэ. (Алексеев, 1999)Тус ойлголт нь зөвхөн хуульд тусгагдсан эрх, үүргийг хамааруулахаас гадна тэдгээрийн бодит хэрэгжилтийн баталгааг мөн агуулдаг. Мөрдөгчийн эрх зүйн байдал нь дараах таван үндсэн элементээс бүрдэнэ: нэгдүгээрт эрх хэмжээ; хоёрдугаарт процессын үүрэг; гуравдугаарт хариуцлага; дөрөвдүгээрт баталгаа; тавдугаарт институцийн бие даасан байдал. (Packer, 1998)

Эрх хэмжээ нь мөрдөгчийн хэрэгт оролцогч бусад субъектуудтай харьцахдаа хэрэглэж болох хэм хэмжээг тогтооно. Процессын үүрэг нь мөрдөгч нотлох ажиллагааг явуулахдаа дагаж мөрдөх зан үйлийн стандартыг тодорхойлно. Хариуцлага нь мөрдөгч хуулийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд хүлээх сөрөг үр дагаврыг тодорхойлно. Баталгаа нь мөрдөгч үйл ажиллагаагаа саадгүй явуулах нөхцөл, хамгаалалтыг хангадаг. Институцийн бие даасан байдал нь мөрдөгч хэрэг хянан шийдвэрлэхдээ аливаа хууль бус нөлөөлөлгүйгээр ажиллах боломжийг баталгаажуулдаг.

Онолын хувьд мөрдөгчийн эрх зүйн байдал нь эрүүгийн процессын загвараас шууд хамаарна. Ром-Германы эрх зүйн тогтолцоонд мөрдөгч нь шүүгч эсвэл прокурорын удирдлага доор ажиллах бол Англи-саксон загварт хэргийн баримт цуглуулах нь ихэнхдээ цагдаагийн байгууллагын бие даасан эрх мэдэлд хамаарна (Damaska, 1986). Монгол Улс нь уламжлалт хувьд эх газрын тогтолцоотой бөгөөд 2017 оны шинэ хуульд зарим Англи-саксон маягийн элементийг нэвтрүүлснээр өвөрмөц нийлмэл тогтолцоо бий болжээ.

2. Монгол Улсын хуулийн зохицуулалт

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйл нь мөрдөгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчоор тодорхойлж, 16 дугаар зүйлд мөрдөгчийн эрх, үүргийг тогтоосон байна. Уг зүйлийн дагуу мөрдөгч нь хэрэг бүртгэлт эхлүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хэрэгт оролцогч этгээдийн мэдүүлэг авах, нотлох баримт цуглуулах, нэгтгэх, үнэлэх зэрэг цогц эрх мэдлийг хэрэгжүүлнэ. (Хурал, 2017)Гэхдээ практикт мөрдөгчийн эдгээр эрх хэмжээний хэрэгжилт нь хэд хэдэн хүчин зүйлээр хязгаарлагддаг.

Нэгдүгээрт тус хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу прокурор нь мөрдөн шалгах ажиллагааг хянах, чиглүүлэх, шийдвэрийг нь хүчингүй болгох өргөн эрх хэмжээтэй байдаг нь мөрдөгчийн бие даасан шийдвэр гаргах орон зайг хязгаарлах хандлагатай байна. Хоёрдугаарт мөрдөн шалгах ажиллагааны явцад албадлагын арга хэмжээ хэрэглэхийн тулд прокурорын зөвшөөрөл шаардагдах нь мөрдөгчийн гүйцэтгэлийн хурдыг удаашруулдаг. Гуравдугаарт мөрдөгчийн тоо, ажлын ачаалал болон материал-техникийн хангамжийн асуудал нь хуулийн норм бодит амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг шийддэг чухал хүчин зүйл болдог. Мөрдөгч нь шаардлагатай бүх арга хэмжээ авах эрхтэй гэж заасан хэдий ч тэдгээр арга хэмжээний ихэнх нь прокурорын урьдчилсан зөвшөөрөл эсвэл тайлан шаарддаг нь практик зөрчилдөөнд хүргэдэг. (Зандаа, 2020)

3. Мөрдөгчийн институцийн бие даасан байдал: онол ба практик

Мөрдөгчийн бие даасан байдал нь шударга мөрдөн шалгах ажиллагааны суурь баталгаа юм. Бие даасан байдлыг хоёр хэмжигдэхүүнд авч үзэх нь зохимжтой: нэгдүгээрт хуульд тусгагдсан хэм хэмжээний хувьд (de jure), хоёрдугаарт практикт бодитоор ажиллаж байгаа хэлбэрийн хувьд (de facto). Хоёр хэмжигдэхүүн хоорондын зөрүү их байх тусам эрх зүйн зохицуулалтын үр нөлөө буурна. (Thaman, 2013) Монгол Улсын хувьд хуульд мөрдөгчийн нэлээд өргөн эрхийг тусгасан боловч практикт байгууллагын дотоод шатлалын нөлөөлөл, мөрдөгч прокурорын шийдвэрт давж заалдах тодорхой механизмын дутагдал болон мэргэжлийн хамгаалалтын хангалтгүй байдал зэрэг хүчин зүйлс тэдгээрийн хэрэгжилтийг хязгаарладаг.

Зарим судлаачид мөрдөгч нь практикт прокурорын зааврыг гүйцэтгэгч болж

хувирсан гэж шүүмжилдэг бол (Лхагвасүрэн, 2019) прокурорын тал мөрдөн шалгах ажиллагааны чанарыг хангахад хяналт зайлшгүй шаардлагатай гэж үздэг. Хоёр байр суурийн хооронд тэнцвэрт цэгийг олох нь эрх зүйн шинэчлэлийн гол сорилт болж байна. Бие даасан байдлын асуудалтай нягт холбоотой нь хариуцлагын тогтолцоо юм. Мөрдөгч нь нэг талаас хэрэгт оролцогчдын эрхийг хамгаалах, нөгөө талаас хүчин төгөлдөр мөрдөн шалгах ажиллагаа явуулах давхар хариуцлагатай бөгөөд ийнхүү хоёрдмол байдалд ажиллах нь зарим тохиолдолд шийдвэр гаргалтыг хүндрүүлдэг.

4. Харьцуулсан судалгаа: Зарим гадаад улсын тогтолцоо

Дараах дүн шинжилгээнд Монгол Улсын мөрдөгчийн эрх зүйн байдлыг таван улсын тогтолцоотой харьцуулсан болно. Улсуудыг сонгохдоо эрх зүйн олон янз байдал болон Монгол Улсын хуулийн хөгжилд үзүүлсэн нөлөөг харгалзан үзсэн болно.

Үзүүлэлт	Монгол	Герман	Франц	Япон	АНУ
Эрх зүйн гэр бүл	Нийлмэл (тивийн + англо-саксон)	Тивийн (Romano-Germanic)	Тивийн (Romano-Germanic)	Нийлмэл (тивийн + англо-саксон)	Англи-саксон (Common Law)
Мөрдөгчийн загвар	Цагдаагийн мөрдөгч, прокурор давамгай	Прокурор мөрдөнө; цагдаа тусална	Шүүгч-мөрдөгч (juge d'instruction)	Цагдаа мөрдөнө; прокурор хянана	Цагдаагийн бие даасан мөрдөлт
Прокурортой харилцаа	Шууд хяналт, зөвшөөрөл шаардлагатай	Мөрдөгч прокурорын туслах орган	Шүүгч-мөрдөгч прокуророос бие даасан	Прокурор заавар өгөх эрхтэй	Прокурор буруутгалтыг хариуцна; мөрдөлт тусдаа
Институцийн бие даасан байдал	Дунд (хуульд бий, практикт хязгаарлагдмал)	Дунд (прокурорын доор)	Өндөр (шүүхийн хянан үзэх)	Дунд	Өндөр (институцийн хувьд тусдаа)
Шүүхийн хяналт	Хязгаарлагдмал	Шүүгч зарим арга хэмжээ зөвшөөрнө	Шүүгч-мөрдөгч өөрөө шүүхийн эрх мэдэлтэй	Шүүгч баривчлалыг зөвшөөрнө	Шүүгч тушаал гарсны дараа хянана
Хүний эрхийн баталгаа	Хуульд тусгасан, хэрэгжилт тэгш биш	Өндөр, Үндсэн хуулиар баталгаажсан	Өндөр, ECHR-ийн хяналтад	Дунд-өндөр	Өндөр, Билл оф Райтс хамгаалдаг
Мэргэжлийн шаардлага	Хуульд тодорхойлсон, практикт тогтворгүй	Маш өндөр, тусгай сургалт шаардлагатай	Хуулийн зэрэгтэй байх шаардлагатай	Өндөр, тасралтгүй сургалт	Байгууллагаас хамаарч ялгаатай

Үзүүлэлт	Монгол	Герман	Франц	Япон	АНУ
Давж заалдах механизм	Прокурор/шүүх рүү (хязгаарлагдмал)	Шүүхэд давж заалдах боломжтой	Давж заалдах шүүх шийддэг	Шүүхэд хандах боломж бий	Шүүхэд бүрэн давж заалдах боломж

Хүснэгт 1. Мөрдөгчийн эрх зүйн байдлын харьцуулсан шинжилгээний хүснэгт

Дээрх хүснэгтэд үзүүлснээр Германы тогтолцоонд мөрдөгч нь прокурорын удирдлагад ажилладаг боловч мэргэжлийн бие даасан байдал болон хуулийн баталгааны хэмжээ өндөр байдаг. (Schünemann, 2011) Францын хувьд шүүгч-мөрдөгч гэдэг ерөнхийдөө хоёр мэргэжлийн давхардсан үүргийг нэгтгэсэн загвар байдаг бөгөөд уг системийг олон шүүмжлэгч буруутгал ба мөрдлөгийн эрх мэдлийн зөрчилтэй байдлаас болж 2008 оноос хойш хязгаарлаж байна. (Pradel, 2009)Японы тогтолцоо нь цагдаагийн байгууллага болон прокурорын хоорондох нягт хамтын ажиллагаанд суурилсан бол АНУ-д мөрдөн шалгах байгууллага нь прокурорын газраас институцийн хувьд тусдаа, гэхдээ нягт зохицуулалттайгаар ажилладаг. Монгол Улсын тогтолцоо нь Германы болон пост-советийн нөлөөг хүлээн авсан боловч институцийн хувьд прокурорын хяналтын хэмжээ нь шинжилгээнд хамрагдсан бусад улсуудтай харьцуулахад харьцангуй өндөр хэвээр байна.

3.5. Мөрдөгчийн эрх, үүргийн агуулга ба хэрэгжилт

Мөрдөгчийн хуулиар олгогдсон эрх хэмжээ нь гурван үндсэн бүлэгт хуваагдана. Нэгдүгээр бүлэгт нотлох баримт цуглуулах, хамгаалах эрх орно, үүнд хэрэгт оролцогч этгээдээс мэдүүлэг авах, шинжилгээнд хамруулах санал гаргах, дүгнэлт гаргах болон бусад байгууллагад тавьсан хүсэлт шаардлагаа хангуулах зэрэг багтана. Хоёрдугаар бүлэгт мөрдөн шалгах ажиллагааны удирдлагын эрх орно. Гуравдугаарт прокурорт хандах санал болон давж заалдах эрх хамаарна (Монгол Улсын Их Хурал, 2017).

Эрх (Rights)	Үүрэг (Duties)
Хэрэг бүртгэлт эхлүүлэх эсэхийг шийдвэрлэх	Хуулийн шаардлагыг дагаж мөрдөх
Нотлох баримт цуглуулах, нэгтгэх	Хэрэгт оролцогчдын эрхийг хангах
Шинжилгээ хийлгэх санал гаргах	Нотлох баримтыг объектив үнэлэх
Мэдүүлэг авах, харьцуулах	Хэрэгт оролцогчдод мэдэгдэл хийх
Прокурорт саналаа гаргах	Прокурорын хяналтыг хүлээн зөвшөөрөх
Давж заалдах эрхтэй	Нууцлалын шаардлагыг сахих
Хамгаалалт, тусламж хүсэх	Хугацааг чанд мөрдөх

Хүснэгт 2. Монгол Улсын ЭХХШТХ-д тусгагдсан мөрдөгчийн эрх, үүргийн нэгтгэл (ЭХХШТХ, 2017 дээр үндэслэн нэгтгэсэн).

Практикт мөрдөгчийн өдөр тутмын ажлын ачаалал нь хуулиар олгогдсон эрх хэмжээний бодит хэрэгжилтэд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны 2022 оны мэдээлэлд дурдсанаар нийт мөрдөгчийн дунджаар нэг мөрдөгч жилд 40-60 хэрэг шийдвэрлэдэг байна. Харин ОХУ болон Казахстаны жишигт нэг мөрдөгчид 20-30 хэрэг ногдуулахыг хэвийн хэмжээ гэж үздэг нь ачааллын асуудал шийдэгдэх шаардлагатайг тодорхой харуулж байна.

3.6. Мөрдөгчийн хариуцлагын тогтолцоо

Мөрдөгчийн хариуцлага нь дөрвөн хэлбэртэй байдаг: эрүүгийн хариуцлага, захиргааны хариуцлага, сахилгын хариуцлага болон иргэний хариуцлага. Монгол Улсын хуулийн хүрээнд мөрдөгч нь хэрэгт оролцогчдын эрхийг зөрчсөн, нотлох баримт хуурамчаар бүрдүүлсэн, хэрэгт холбогдох мэдээллийг задруулсан зэрэг тохиолдолд дээрх хариуцлагуудын аль нэгийг буюу хэд хэдийг нь давхар хүлээнэ (Монгол Улсын Их Хурал, 2015). Хэт хатуу хариуцлагын орчин нь мөрдөгчийн идэвхтэй, шинэлэг ажиллагааг хязгаарлах, хэт болгоомжтой шийдвэр гаргахад хүргэх эрсдэлтэй (Zuckerman, 2007). Иймд мөрдөгчийн хариуцлага болон баталгааны хоорондын тэнцвэрийг зохистой тогтоох нь эрх зүйн шинэчлэлийн тулгамдсан асуудал болж байна.

3.7. Мөрдөгчийн мэргэжлийн сургалт ба чадавхжуулалд

Мөрдөгчийн эрх зүйн байдлын практик хэрэгжилт нь мэргэжлийн чадавхтай нягт холбоотой. Харьцуулсан судалгаагаас харахад Германд мөрдөгч болохын тулд хуулийн дээд боловсрол эсвэл тусгай мэргэжлийн сургалт дүүргэх шаардлагатай байдаг (Roxin & Schünemann, 2017). Монгол Улсад мөрдөгчид тавигдах боловсролын шаардлагыг хуульд тодорхой заагаагүй байна. Мэргэжлийн тасралтгүй хөгжил буюу continuing professional development (CPD) нь олон улсын жишигт мөрдөгчийн чадавхыг хадгалах, шинэчлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үздэг (Hodgson, 2005). Монгол Улсад Цагдаагийн дээд сургуулийн хүрээнд тодорхой сургалт явагдаж байгаа хэдий ч тогтмол, стандартчилсан тогтолцоо бүрдээгүй байна. Ингэснээр хуулийн зохицуулалт хэчнээн сайн байсан ч сургалтын тогтолцоо нь практик хэрэгжилтийн хамгийн сул цэг болж үлдэж байна.

Дүгнэлт

Нэгдүгээрт, мөрдөгчийн эрх зүйн байдал нь эрүүгийн шударга ёсны тогтолцооны үр нөлөөг шийдвэрлэдэг чухал хүчин зүйл бөгөөд зөвхөн хуулийн норм биш, институцийн бүтэц, мэргэжлийн баталгаа болон практик хэрэгжилт зэрэг олон хэмжигдэхүүнээр тодорхойлогдоно.

Хоёрдугаарт, Монгол Улсын 2017 оны ЭХХШТХ нь мөрдөгчийн эрх зүйн байдлыг харьцангуй иж бүрнээр зохицуулсан хэдий ч прокурорын хяналтын хэмжээ, институцийн бие даасан байдал болон мэргэжлийн баталгааны тогтолцоо гэсэн гурван чиглэлд цаашид боловсронгуй болгох шаардлага тодорхой байна.

Гуравдугаарт, харьцуулсан судалгааны дүнд Герман, Франц, Японы тогтолцоо нь мөрдөгчийн мэргэжлийн бие даасан байдал болон шүүхийн хяналтын тогтолцооны хувьд Монголд суурилж болох зарим жишгийг санал болгож байна. АНУ-ын тогтолцоо нь институцийн тусгаарлалын хувьд сургамжтай боловч нийгэм болон хуулийн уламжлалын ялгааг анхаарах шаардлагатай.

Дөрөвдүгээрт, мөрдөгчийн хариуцлага болон баталгааны хоорондын тэнцвэрийг тогтоох нь дан ганц хуулийн асуудал биш, байгууллагын соёл болон удирдлагын философитой нягт уялдаатай нийгмийн цогц асуудал юм. Иймд хуулийн шинэчлэл нь байгууллагын соёлын өөрчлөлтийг дагалдахгүй бол үр дүн хязгаарлагдах эрсдэлтэй.

Санал

Судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах таван саналыг тус тус дэвшүүлж байна.

Нэгдүгээр санал: Мөрдөгчийн институцийн бие даасан байдлыг хуульд тодорхой заах. ЭХХШТХ-д мөрдөгч нь аливаа хууль бус нөлөөллийг эсэргүүцэх эрхтэй бөгөөд тийм нөлөөллийн талаар давж заалдах тодорхой механизм байна гэдгийг тусгах шаардлагатай. Ингэхдээ прокурорын хяналтын шаардлагатай хэм хэмжээг хадгалж, харин хэт авторитар хяналтыг хязгаарлах нь чухал.

Хоёрдугаар санал: Прокурорын хяналтын хүрээ болон мөрдөгчийн бие даасан шийдвэр гаргах эрхийн хилийг хуульд тодорхой зааглах. Одоогийн ЭХХШТХ-д прокурорын зөвшөөрөл шаардагдах ажиллагааны жагсаалт болон мөрдөгч бие даан шийдвэр гаргаж болох ажиллагааны жагсаалт хоёрыг нарийвчлах

нь практикт гарч буй асуудлыг ихэвчлэн шийднэ.

Гуравдугаар санал: Мөрдөгчийн мэргэжлийн шаардлага болон тасралтгүй сургалтын тогтолцоог хуульчлан тогтоох. Германы жишгийг харгалзан мөрдөгчид тавигдах боловсролын доод шаардлага, ажилд авах стандарт болон тогтмол мэргэжлийн үнэлгээний тогтолцоог хуульд тусгах нь мөрдөн шалгах ажиллагааны чанарыг дэмжинэ.

Дөрөвдүгээр санал: Мөрдөгч дээр ногдох хэргийн ачааллыг хуульд хязгаарлах. Харьцуулсан судалгаанд үндэслэн нэг мөрдөгчид ногдох ажлын дунджийн дээд хязгаарыг тогтоосон дотоод журам болон цаашид хуулийн зохицуулалтыг боловсруулах нь зүйтэй.

Тавдугаар санал: Шүүхийн хяналтын хамрах хүрээг өргөтгөх. Одоогийн зохицуулалтад шүүхийн хяналт нь мөрдөн шалгах ажиллагааны тодорхой арга хэмжээнд хязгаарлагдаж байна. Европын жишгийг харгалзан мөрдөгчийн шийдвэрийн шүүхийн хяналтын боломжийг нэмэгдүүлэх нь хүний эрхийн баталгааг сайжруулна.

Ашигласан материал

Алексеев, С. С. (1999). Теория государства и права [Улсын ба эрхийн онол]. Норма.

Зандаа, Д. (2020). Монгол Улсад мөрдөн шалгах ажиллагааны онцлог. Хууль дээдлэх ёс, 1(45), 34–50.

Лхагвасүрэн, Б. (2019). Прокурорын хяналтын хүрээ ба мөрдөгчийн бие даасан байдал. Эрх зүйн судлал, 22(3), 12–29.

Монгол Улсын Их Хурал. (2015). Эрүүгийн хууль. https://www.legalinfo.mn

Монгол Улсын Их Хурал. (2017). Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. https://www.legalinfo.mn

Ashworth, A., & Redmayne, M. (2010). The criminal process (4th ed.). Oxford University Press.

Damaska, M. R. (1986). The faces of justice and state authority: A comparative approach to the legal process. Yale University Press.

Hodgson, J. (2005). French criminal justice: A comparative account of the investigation and prosecution of crime in France. Hart Publishing.

Packer, H. L. (1968). The limits of the criminal sanction. Stanford University Press.

Pradel, J. (2009). Droit pénal comparé [Харьцуулсан эрүүгийн эрх зүй] (3rd ed.). Dalloz.

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ПРАКТИК

LEGAL REGULATION OF COMPENSATION FOR PSYCHOLOGICAL HARM CAUSED BY CRIMINAL OFFENSES: JUDICIAL PRACTICE IN MONGOLIA

Д.Доржсүрэн*
Дотоод хэргийн их сургуулийн докторант
Dorjsuren D.
Doctoral Candidate, University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: dorjoo 4777@gmail.com

Хураангуй: Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн чухал механизмд тооцогддог. Сэтгэцэд учирсан хохирол нь эд хөрөнгийн шинжтэй хохирлоос ялгаатай тул түүнийг үнэлэх, хэмжээг тогтоох, нотлох ажиллагаа шүүхийн практикт төвөгтэй хэвээр байна.

Монгол Улсад энэхүү харилцааг Иргэний хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүх шинжилгээний тухай хуульд зохицуулж, шинжилгээний байгууллагаар сэтгэцийн хор уршгийг тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч шүүхийн практикт нөхөн төлбөрийн хэмжээ, үнэлгээний шалгуур, нотлох баримтыг үнэлэх хандлага харилцан адилгүй хэрэгжиж байна. Энэхүү өгүүлэлд дээрх эрх зүйн зохицуулалт болон шүүхийн практикт дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлон, практик хэрэглээ болон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал дэвшүүлэв.

Abstract: Compensation for psychological harm caused by criminal offenses constitutes an essential legal mechanism for safeguarding the rights and legitimate interests of crime victims. Unlike pecuniary damage, psychological harm possesses an intangible nature, making its assessment, quantification, and evidentiary determination particularly complex in judicial practice.

In Mongolia, the legal regulation governing such relations is established under the Civil Code, the Criminal Procedure Law, and the Law on Forensic Examination, which collectively provide the legal basis for determining psychological consequences through forensic expert evaluation. Nevertheless, judicial practice demonstrates inconsistencies in the assessment criteria applied to psychological harm, the determination of compensation amounts, and the evaluation of evidentiary materials.

This article analyzes the existing legal framework and judicial practice concerning compensation for psychological harm resulting from criminal acts. Based on the findings, it identifies several practical and legal challenges and proposes recommendations aimed at improving both the legal regulation and its practical implementation.

Түлхүүр үг: Гэм хор, эдийн бус хохирол, сэтгэцэд учирсан хохирол, гэмт хэргийн хохирогч, нөхөн төлбөр.

Keywords: Tort, non-pecuniary damage, psychological harm, crime victim, compensation.

Эрүүгийн эрх зүйн хөгжлийн орчин үеийн чиг хандлагад гэмт хэргийн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал онцгой ач холбогдолтой байр суурь эзлэх болсон. Эрүүгийн шударга ёсны тогтолцоо нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх замаар нийгмийн дэг журмыг хамгаалахаас гадна гэмт хэргийн улмаас хохирол амссан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэгдэх шаардлагатай байдаг. Энэ утгаараа гэмт хэргийн улмаас учирсан

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хохирогчийн эрхийг хамгаалах эрх зүйн чухал механизмын нэг юм.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нь зөвхөн эд хөрөнгийн хохирлоор хязгаарлагдахгүй бөгөөд хүний нэр төр, алдар хүнд, сэтгэл санаанд сөрөг нөлөө үзүүлэх тохиолдол түгээмэл байдаг. Ийм төрлийн хохирлыг эрх зүйн шинжлэх ухаанд ихэвчлэн эдийн бус хохирол буюу хүний сэтгэцэд учирсан хохирол гэж тодорхойлдог. Сэтгэцэд учирсан хохирол нь айдас, стресс, сэтгэл санааны шаналал, дороомжлол, нэр төр, алдар хүндэд халдсан байдлаар илэрч болох бөгөөд эдгээр нь хохирогчийн амьдралын чанар болон нийгмийн харилцаанд оролцох боломжид тодорхой хэмжээгээр сөргөөр нөлөөлөх онцлогтой.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалтад гэм хорын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Иргэний хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүх шинжилгээний тухай хууль зэрэг хууль тогтоомжид тодорхой хэмжээгээр зохицуулсан байдаг. Тухайлбал, гэм хор учруулсан этгээд нь учруулсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлөх үүрэгтэй бөгөөд энэ нь эдийн болон эдийн бус хохирлыг хамарч ойлгогддог. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн хохирогч нь өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Түүнчлэн Шүүх шинжилгээний тухай хуульд гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг шинжилгээний байгууллага тогтоож дүгнэлт гаргах эрх зүйн үндсийг тусгайлан зохицуулсан нь тухайн төрлийн хохирлыг нотлох ажиллагаанд чухал ач холбогдолтой юм.

Гэсэн хэдий ч практикт хүний сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх, нотлох, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох асуудал тодорхой хүндрэл дагуулж байна. Ялангуяа эдийн бус хохирлын шинж чанар нь эдийн хохирлоос ялгаатай бөгөөд бодитоор хэмжих боломж хязгаарлагдмал байдаг тул шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хэрэг бүрийн нөхцөл байдалд тулгуурлан үнэлгээ хийх шаардлага гардаг. Үүнээс шалтгаалан ижил төстэй нөхцөл бүхий хэрэгт нөхөн төлбөрийн хэмжээ харилцан адилгүй тогтоогдох, мөн шинжилгээний байгууллагын дүгнэлтийг нотлох баримтын хэлбэрээр тогтмол ашиглахгүй байх зэрэг асуудал шүүхийн практикт ажиглагдаж байна.

Иймээс гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг шүүхээр нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг судлан шинжилж, Монгол Улсын шүүхийн практикт илэрч буй зарим асуудлыг тодорхойлох нь онол, практикийн аль алинд ач холбогдолтой юм. Энэхүү өгүүллийн зорилго нь гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг судлан шинжилж, Монгол Улсын шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан тулгамдаж буй зарим асуудлыг тодорхойлон, уг харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт дэвшүүлэхэд оршино. Судалгаанд эрх зүйн шинжилгээний арга, харьцуулсан судалгааны арга болон шүүхийн практикт дүн шинжилгээ хийх арга зэрэг судалгааны арга зүйг ашигласан болно.

Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлын онолын ойлголт

Эрх зүйн шинжлэх ухаанд гэм хорын улмаас учирсан хохирлыг ерөнхийд нь эдийн болон эдийн бус хохирол гэж ангилж үздэг. Эдийн хохирол нь эд хөрөнгө, орлого болон өмчийн эрхэд шууд учирсан алдагдлыг илэрхийлдэг бол эдийн бус хохирол нь хүний нэр төр, алдар хүнд, хувийн амьдрал, сэтгэл санаанд учирсан сөрөг нөлөөллийг хамардаг онцлогтой. Хүний сэтгэцэд учирсан хохирол нь эдийн бус хохирлын нэг төрөлд хамаарах бөгөөд тухайн этгээдийн сэтгэл санааны байдал, сэтгэл зүйд үүссэн сөрөг өөрчлөлтөөр илэрдэг гэж үздэг (Van Dam, 2017).

Сэтгэцэд учирсан хохирол нь айдас, стресс, сэтгэл санааны шаналал, сэтгэл зүйн дарамт, дороомжлол, нэр төр, алдар хүндэд халдах зэрэг хэлбэрээр илэрч болно. Зарим тохиолдолд гэмт хэргийн улмаас

үүссэн сэтгэл санааны хямрал нь удаан хугацаанд үргэлжилж, хохирогчийн өдөр тутмын амьдрал болон нийгмийн харилцаанд оролцох боломжид сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдүүлдэг. Иймээс сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь зөвхөн эдийн засгийн нөхөн төлбөр олгохтой хязгаарлагдахгүй бөгөөд хохирогчийн эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг хангах чухал хэрэгсэл гэж үздэг (Deakin, Johnston, & Markesinis, 2019).

Судлаачдын үзэж байгаагаар сэтгэцэд учирсан хохирлын нэг онцлог шинж нь эдийн хохиролтой харьцуулахад бодитоор хэмжих боломж хязгаарлагдмал байдагт оршино. Өөрөөр хэлбэл, эд хөрөнгийн хохирлыг мөнгөн дүнгээр тодорхойлох боломжтой байдаг бол сэтгэл санаанд учирсан хохирлыг ижил аргаар шууд хэмжих боломжгүй байдаг. Иймээс шүүхээс эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн хэрэгт холбогдох нөхцөл байдал, гэмт хэргийн шинж чанар, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай болдог (Krajewski, 2018).

Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэл нь хүний нэр төр, алдар хүнд, хувийн амьдрал, сэтгэл санааны халдашгүй байдлыг хамгаалах шаардлагатай шууд холбоотой байдаг. Эдгээр эрх нь хүний үндсэн эрхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэгт тооцогддог бөгөөд уг эрхэд халдсан тохиолдолд учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлбөр олгох замаар тодорхой хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой гэж үздэг.

Гадаадын зарим судлаачид хүний сэтгэцэд учирсан хохирлыг дараах үндсэн хэлбэрүүдэд ангилан авч үздэг. Үүнд:

- сэтгэл санааны шаналал, зовлон;
- айдас, түгшүүр, стресс;
- дороомжлол, нэр төр, алдар хүндэд халдсан байдал;
- сэтгэл санааны хямрал, сэтгэцийн гэмтэл.

Эдгээр төрлийн хохирол нь ихэвчлэн хүний нэр төр, алдар хүндэд халдах, хүчирхийлэл үйлдэх, бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, мөн хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдсан гэмт хэргийн улмаас үүсэх нь түгээмэл тохиолддог.

Иймээс сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь зөвхөн иргэний эрх зүйн харилцааны хүрээнд бус, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ч мөн чухал байр суурь эзэлдэг. Энэ нь гэмт хэргийн улмаас хохирол амссан этгээдийн эрхийг хамгаалах, гэм хорын үр дагаврыг тодорхой хэмжээгээр арилгах, нийгмийн шударга ёсыг хангах эрх зүйн механизмын нэг хэлбэр гэж үзэж болно.

Сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн үндсийг Монгол Улсын Иргэний хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүх шинжилгээний тухай хууль зэрэг хууль тогтоомжид зохицуулсан байдаг. Эдгээр эрх зүйн зохицуулалт нь гэмт хэргийн улмаас хохирол амссан этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, учирсан хохирлыг нөхөн сэргээхэд чиглэсэн эрх зүйн механизмыг бүрдүүлж байна.

Юуны өмнө, Монгол Улсын Иргэний хуульд гэм хор учруулсан этгээд нь учруулсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлөх үүрэгтэй гэж заасан байдаг (Монгол Улсын Иргэний хууль, 2002). Энэхүү зохицуулалт нь зөвхөн эд хөрөнгийн хохирлоор хязгаарлагдахгүй бөгөөд эдийн бус хохирлыг мөн хамарч ойлгогддог. Өөрөөр хэлбэл, хүний нэр төр, алдар хүнд, хувийн амьдрал, сэтгэл санаанд учирсан хохирлыг тодорхой нөхцөлд мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх боломжтой юм.

Нөгөө талаас, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн хохирогч нь өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017). Хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй хамтатган шүүхэд гаргах

боломжтой бөгөөд энэ нь хохирогчийн эрхийг шуурхай хамгаалах, шүүхийн ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Түүнчлэн гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг тогтоох асуудлыг Шүүх шинжилгээний тухай хуульд тусгайлан зохицуулсан байдаг. Тус хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар шинжилгээний байгууллага нь тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, холбогдох дүгнэлт гаргах үүрэгтэй (Шүүх шинжилгээний тухай хууль, 2020). Уг дүгнэлтийг гаргахдаа тухайн этгээд нь гэмт хэргийн хохирогч байх, гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэцэд түр зуурын эсхүл байнгын шинжтэй өөрчлөлт орсон байх, уг өөрчлөлтийг сэтгэцийн шинжилгээгээр тогтоосон байх зэрэг нөхцөлийг харгалзан үзэхээр хуульд заасан байдаг. Энэхүү зохицуулалт нь хүний сэтгэцэд учирсан хор уршгийг мэргэжлийн түвшинд тогтоох, улмаар шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд ашиглагдах нотлох баримтын үндсийг бүрдүүлж байна.

Гэсэн хэдий ч практикт хүний сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх, нотлох, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох асуудал тодорхой хүндрэл дагуулж байна. Эдийн бус хохирол нь эдийн хохирлоос ялгаатайгаар бодитоор хэмжих боломж хязгаарлагдмал байдаг тул шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хэрэг бүрийн нөхцөл байдалд тулгуурлан үнэлгээ хийх шаардлага гардаг. Үүнээс шалтгаалан ижил төстэй нөхцөл бүхий хэрэгт нөхөн төлбөрийн хэмжээ харилцан адилгүй тогтоогдох тохиолдол ажиглагдаж байна.

Мөн сэтгэцэд учирсан хохирлыг нотлох ажиллагаанд шинжилгээний байгууллагын дүгнэлт чухал ач холбогдолтой боловч практикт ийм төрлийн дүгнэлтийг тогтмол ашиглахгүй байх тохиолдол ажиглагддаг. Энэ нь шүүхийн шийдвэрийн үндэслэл, нотлох баримтын үнэлгээний асуудалд тодорхой хүндрэл үүсгэх нөхцөл бүрдүүлж байна.

Иймээс гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгох, мөн шүүхийн практикт нэгдсэн хандлага төлөвшүүлэх шаардлага байгааг судалгааны үр дүн харуулж байна. Ялангуяа эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох шалгуур, нотлох ажиллагаанд ашиглах аргачлал, шинжилгээний байгууллагын дүгнэлтийн үүргийг тодорхой болгох нь энэ төрлийн маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Иймд Монгол Улсын шүүхийн практикт сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал хэрхэн шийдвэрлэгдэж байгаад дүн шинжилгээ хийх нь эрх зүйн зохицуулалтын бодит хэрэгжилтийг тодорхойлох, цаашид боловсронгуй болгох чиглэлийг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Монгол Улсын шүүхийн практикт сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал

Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь Монгол Улсын шүүхийн практикт тодорхой хэмжээгээр шийдвэрлэгдэж байгаа боловч нөхөн төлбөрийн хэмжээ, нотлох баримтын үнэлгээ, хохирлын шинж чанарыг тодорхойлох асуудалд нэгдсэн хандлага бүрэн төлөвшөөгүй байна. Шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой маргаан нь ихэвчлэн хүний нэр төр, алдар хүндэд халдсан хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдсан гэмт хэргийн хүрээнд үүсэх нь ажиглагдаж байна.

Тухайлбал, хүний нэр төр, алдар хүндэд халдсан хэрэгтэй холбоотой маргаанд шүүхээс хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн нөхөн төлбөрөөр үнэлэн шийдвэрлэх тохиолдол практикт түгээмэл байна. Монгол Улсын Дээд шүүхийн зарим шийдвэрт нэр төр, алдар хүндэд халдсан үйлдлийн улмаас хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг тогтоохдоо тухайн мэдээллийн шинж чанар, тараасан хүрээ, хохирогчид учирсан сэтгэл санааны нөлөөлөл, нийгмийн харилцаанд үзүүлсэн үр дагавар

зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзсэн байдаг.

Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зарим хэрэгт шүүхээс хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг авч үзсэн тохиолдол ажиглагддаг. Удаа дараагийн хүчирхийллийн улмаас хохирогчид учирсан айдас, сэтгэл санааны дарамт, стресс зэрэг нь эдийн бус хохирлын нэг хэлбэрт тооцогдох боломжтой бөгөөд ийм нөхцөлд шүүхээс нөхөн төлбөр тогтоох боломжтой гэж үзсэн байна.

Түүнчлэн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой зарим хэрэгт хохирогчийн сэтгэл санаанд учирсан сөрөг нөлөөллийг харгалзан үзэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Ийм төрлийн хэрэгт хохирогчид учирсан сэтгэл санааны хямрал, сэтгэцэд учирсан хор уршиг нь удаан хугацаанд үргэлжлэх боломжтой тул шүүхээс сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэхдээ эмнэлгийн баримт болон шинжилгээний байгууллагын дүгнэлтийг нотлох баримтын нэг хэлбэр болгон харгалзан үзэх шаардлага гардаг.

Гэсэн хэдий ч шүүхийн практикт сэтгэцэд учирсан хохирлын хэмжээг тогтоох нэгдсэн аргачлал бүрэн төлөвшөөгүй байгаа нь ажиглагдаж байна. Ижил төстэй нөхцөл бүхий хэрэгт шүүхээс тогтоосон нөхөн төлбөрийн хэмжээ харилцан адилгүй байх тохиолдол гардаг. Зарим хэрэгт харьцангуй бага хэмжээний нөхөн төлбөр тогтоосон байхад, зарим хэрэгт илүү өндөр хэмжээ тогтоосон байх зэрэг практикийн ялгаа ажиглагдаж байна.

Мөн сэтгэцэд учирсан хохирлыг нотлох ажиллагаа нь практикт тодорхой хүндрэл дагуулдаг. Эдийн бус хохирлын шинж чанар нь эдийн хохирлоос ялгаатай тул нотлох баримтын хэлбэр, үнэлгээний асуудалд илүү нарийн хандлага шаарддаг. Зарим тохиолдолд шүүхээс хохирогчийн тайлбар болон хэрэгт холбогдох нөхцөл байдлыг үндэслэн сэтгэцэд учирсан хохирлыг тогтоож байгаа бол зарим хэрэгт шинжилгээний байгууллагын дүгнэлтийг нотлох баримтын нэг хэлбэр болгон ашиглах шаардлага гарч байна.

Иймээс Монгол Улсын шүүхийн практикт сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэхэд нэгдсэн шалгуур, аргачлал боловсруулах шаардлага байгааг судалгааны үр дүн харуулж байна. Ялангуяа эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох шалгуур, шинжилгээний байгууллагын дүгнэлтийн ач холбогдол, мөн нотлох баримтыг үнэлэх аргачлалыг илүү тодорхой болгох нь энэ төрлийн маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал

Монгол Улсын шүүхийн практикт гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал тодорхой хэмжээгээр шийдвэрлэгдэж байгаа боловч эрх зүйн зохицуулалт болон практик хэрэгжилтийн түвшинд зарим хүндрэл, асуудал ажиглагдаж байна. Шүүхийн шийдвэрүүд болон холбогдох эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд дараах үндсэн асуудлууд тулгарч байна.

Нэгдүгээрт, сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх нэгдсэн аргачлал хангалттай хөгжөөгүй байна. Эдийн бус хохирол нь эдийн хохирлоос ялгаатай бөгөөд бодитоор хэмжих боломж хязгаарлагдмал байдаг. Иймээс шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн хэрэгт холбогдох нөхцөл байдал, гэмт хэргийн шинж чанар, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үздэг. Гэсэн хэдий ч энэ асуудалд нэгдсэн шалгуур, аргачлал бүрэн тогтоогдоогүй байгаа нь ижил төстэй нөхцөл бүхий хэрэгт нөхөн төлбөрийн хэмжээ харилцан адилгүй тогтоогдох нөхцөл бүрдүүлж байна.

Хоёрдугаарт, сэтгэцэд учирсан хохирлыг нотлох ажиллагаанд тодорхой хүндрэл тулгардаг. Эдийн бус хохирлын шинж чанар нь материаллаг байдлаар шууд хэмжигдэх боломжгүй тул нотлох баримтын хэлбэр, үнэлгээний асуудалд илүү нарийн хандлага шаардагддаг. Зарим тохиолдолд шүүхээс хохирогчийн тайлбар болон хэрэгт холбогдох нөхцөл байдлыг үндэслэн сэтгэцэд учирсан хохирлыг

тогтоож байгаа бол зарим хэрэгт шинжилгээний байгууллагын дүгнэлтийг нотлох баримтын нэг хэлбэр болгон ашиглах шаардлага гарч байна. Гэвч практикт ийм төрлийн дүгнэлтийг тогтмол ашиглахгүй байх тохиолдол ажиглагдаж байгаа нь сэтгэцэд учирсан хохирлыг нотлох ажиллагаанд тодорхой хүндрэл үүсгэж байна.

Гуравдугаарт, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох шалгуур тодорхой бус байдал ажиглагдаж байна. Шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хэрэг бүрийн нөхцөл байдлыг харгалзан үздэг боловч ижил төстэй нөхцөл бүхий хэрэгт нөхөн төлбөрийн хэмжээ харилцан адилгүй тогтоогдох тохиолдол гарч байна. Энэ нь шүүхийн практикт эдийн бус хохирлыг үнэлэх нэгдсэн хандлага бүрэн төлөвшөөгүй байгааг харуулж байна.

Дөрөвдүгээрт, сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудалд хохирогчийн эрхийг хамгаалах механизмын хэрэгжилт хангалттай түвшинд хэрэгжихгүй байх тохиолдол ажиглагддаг. Зарим тохиолдолд хохирогчид өөрт учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх, боломжийн талаар хангалттай мэдээлэлгүй байх, эсхүл иргэний нэхэмжлэл гаргах ажиллагаанд тодорхой хүндрэл тулгарах зэрэг асуудал гарч байна.

Иймээс гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг боловсронгуй болгохын тулд эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгох, мөн шүүхийн практикт нэгдсэн шалгуур, аргачлал төлөвшүүлэх шаардлагатай байна. Ялангуяа эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох шалгуур, нотлох ажиллагаанд ашиглах аргачлал, шинжилгээний байгууллагын дүгнэлтийн ач холбогдлыг тодорхой болгох нь энэ төрлийн маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх олон улсын туршлага

Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь олон улсын эрх зүйн баримт бичиг болон гадаадын улс орнуудын эрх зүйн тогтолцоонд чухал байр суурь эзэлдэг. Орчин үеийн эрүүгийн бодлогын хүрээнд гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах, учирсан хохирлыг нөхөн сэргээх асуудалд онцгой анхаарал хандуулах болсон бөгөөд энэ хүрээнд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн механизмыг хөгжүүлэх хандлага ажиглагдаж байна.

Олон улсын түвшинд гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах үндсэн баримт бичгүүдийн нэг нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1985 онд баталсан “Гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах үндсэн зарчмуудын тунхаглал” юм. Уг баримт бичигт гэмт хэргийн хохирогчид нь учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, нөхөн сэргээх эрхтэй болохыг тодорхойлсон бөгөөд төр нь хохирогчид учирсан эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн болон институцийн механизм бүрдүүлэх үүрэгтэйг онцлон тэмдэглэсэн байдаг (United Nations, 1985).

ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт

Европын зарим улс оронд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт харьцангуй хөгжсөн байдаг. Тухайлбал, ХБНГУ-ын иргэний эрх зүйн тогтолцоонд хүний нэр төр, алдар хүнд, сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжийг хууль тогтоомжид тодорхой тусгасан байдаг. Германы Иргэний хуулийн (Bürgerliches Gesetzbuch – BGB) 253 дугаар зүйлд хүний бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө болон хувийн эрхэд халдсан тохиолдолд эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх боломжийг хуульчилсан байдаг. Энэхүү зохицуулалт нь хүний сэтгэл санаанд учирсан хохирлыг тодорхой хэмжээгээр нөхөн сэргээх, хохирогчийн эрхийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлдэг (Markesinis & Unberath, 2019).

Германы шүүхийн практикт сэтгэл санаанд учирсан хохирлын нөхөн төлбөрийг *Schmerzensgeld* гэж нэрлэдэг бөгөөд энэ нь гэмт хэргийн улмаас учирсан бие махбодын болон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх зорилготой эрх

зүйн механизм юм. Шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо гэмт хэргийн шинж чанар, учирсан хохирлын ноцтой байдал, хохирогчид учирсан сэтгэл санааны болон сэтгэцийн үр дагавар, мөн тухайн хэргийн нөхцөл байдлыг цогцоор нь харгалзан үздэг. Иймхүү нөхөн төлбөр олгох нь зөвхөн учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлөхөөс гадна хохирогчийн зөрчигдсөн эрхийг тодорхой хэмжээгээр сэргээх, гэмт үйлдлийн үр дагаврыг бууруулах ач холбогдолтой гэж үздэг (Van Dam, 2017).

Түүнчлэн Германы шүүхийн практикт сэтгэл санаанд учирсан хохирлыг үнэлэхдээ эмнэлгийн баримт бичиг болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг нотлох баримтын нэг хэлбэр болгон ашиглах нь түгээмэл байдаг. Ялангуяа хүчирхийлэл, бэлгийн халдашгүй байдалд халдсан гэмт хэрэг, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан хэрэг зэрэгт хохирогчийн сэтгэл зүйн байдалд учирсан өөрчлөлтийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоох нь шүүхийн шийдвэр гаргахад чухал ач холбогдолтойд тооцогддог.

Мөн Германы шүүхийн практикт нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо өмнө нь шийдвэрлэгдсэн ижил төстэй хэргийн шийдвэрүүдийг харьцуулан үнэлэх арга хэрэглэдэг. Үүнийг *Schmerzensgeldtabellen* буюу өмнөх шүүхийн шийдвэрүүдэд үндэслэн боловсруулсан нөхөн төлбөрийн жишиг хэмжээг харуулсан хүснэгтийн тусламжтайгаар ашигладаг бөгөөд энэ нь ижил төстэй нөхцөл бүхий хэрэгт нөхөн төлбөрийн хэмжээг харьцангуй жигд тогтоох боломжийг бүрдүүлдэг (Krajewski, 2018). Иймхүү ХБНГУ-ын эрх зүйн тогтолцоонд гэмт хэргийн улмаас хүний сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хууль тогтоомж болон шүүхийн тогтсон практиктай уялдуулан шийдвэрлэдэг бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлын шинж чанар, гэмт хэргийн ноцтой байдал, учирсан үр дагаврыг цогцоор нь үнэлэх хандлага ажиглагдаж байна.

Их Британийн эрх зүйн зохицуулалт

Их Британийн эрх зүйн тогтолцоонд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг *tort law* буюу гэм хорын эрх зүйн хүрээнд авч үздэг. Энэ хүрээнд хүний бие махбод, эрүүл мэнд, нэр төр, хувийн эрхэд халдсаны улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх боломжийг шүүхийн практикт хүлээн зөвшөөрдөг. Иймхүү учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх нь хохирогчид учирсан гэм хорыг тодорхой хэмжээгээр нөхөн сэргээх, зөрчигдсөн эрхийг хамгаалах эрх зүйн механизмын нэг хэлбэр гэж үздэг (McGregor, 2019).

Их Британийн шүүхийн практикт нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлын шинж чанар, гэмт хэргийн ноцтой байдал, тухайн үйлдлийн улмаас үүссэн үр дагавар, мөн хохирогчийн эрүүл мэнд болон амьдралын хэв маягт үзүүлсэн нөлөөллийг харгалзан үздэг. Зарим тохиолдолд шүүхүүд өмнө нь шийдвэрлэгдсэн ижил төстэй хэргийн шийдвэрүүдийг харьцуулан үнэлэх арга хэрэглэдэг бөгөөд энэ нь нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо шүүхийн практикт тодорхой хэмжээгээр жигд байдлыг хангахад чиглэгддэг (Deakin, Johnston, & Markesinis, 2019).

Түүнчлэн Их Британид гэмт хэргийн улмаас бие махбод болон сэтгэл санаанд хохирол учирсан хохирогчдод нөхөн төлбөр олгох зорилгоор *Criminal Injuries Compensation Scheme* хэрэгждэг. Энэхүү тогтолцооны хүрээнд хүчирхийлэл болон бусад ноцтой гэмт хэргийн улмаас хохирол амссан этгээдүүд тодорхой хэмжээний нөхөн төлбөрийг төрөөс авах боломжтой байдаг. Уг механизм нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн сэргээхэд төрийн оролцоог хангах, хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр чухал ач холбогдолтойд тооцогддог (Doerner & Lab, 2019). Иймхүү Их Британийн эрх зүйн тогтолцоонд гэмт хэргийн улмаас хүний сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шүүхийн практик болон төрийн нөхөн төлбөрийн тогтолцоотой уялдуулан шийдвэрлэдэг бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хохирлын

шинж чанар, гэмт хэргийн ноцтой байдал, учирсан үр дагаврыг цогцоор нь үнэлэх хандлага ажиглагддаг.

АНУ-ын эрх зүйн зохицуулалт

АНУ-ын эрх зүйн тогтолцоонд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг иргэний эрх зүйн хүрээнд, ялангуяа *tort law* буюу гэм хорын эрх зүйн зохицуулалтын хүрээнд өргөн авч үздэг. АНУ-ын шүүхийн практикт хүний бие махбод, эрүүл мэнд, нэр төр, хувийн эрхэд халдсаны улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг *pain and suffering* буюу сэтгэл санааны шаналлын хохирол гэж тодорхойлон, мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх боломжийг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү нөхөн төлбөрийн зорилго нь хохирогчид учирсан сэтгэл санааны болон сэтгэцийн хохирлыг тодорхой хэмжээгээр нөхөн сэргээх, улмаар зөрчигдсөн эрхийг хамгаалах явдал гэж үздэг (Goldberg, Sebok, & Zipursky, 2020).

АНУ-ын шүүхийн практикт сэтгэл санаанд учирсан хохирлыг тогтоохдоо хохирогчийн мэдүүлэг, эмнэлгийн баримт бичиг, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, гэрчийн мэдүүлэг зэрэг нотлох баримтыг ашиглах нь түгээмэл байдаг. Ялангуяа хүчирхийлэл, бие махбодод халдсан гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлэл зэрэг хэрэгт хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлын шинж чанар, үр дагаврыг нотлох баримтын цогц үнэлгээний үндсэн дээр тогтоох хандлага ажиглагддаг (Fleming, 2018).

Түүнчлэн АНУ-ын шүүхийн практикт нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо өмнө нь шийдвэрлэгдсэн ижил төстэй хэргийн шийдвэрүүдийг харьцуулан үнэлэх арга хэрэглэдэг. Энэ нь нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо шүүхийн практикт тодорхой хэмжээгээр жигд байдлыг хангах, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг илүү тодорхой болгоход чиглэгддэг. Иймхүү АНУ-ын эрх зүйн тогтолцоонд гэмт хэргийн улмаас хүний сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шүүхийн практикт өргөн авч үздэг бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хохирлын шинж чанар, гэмт хэргийн ноцтой байдал, учирсан үр дагаврыг цогцоор нь үнэлэх хандлага ажиглагдаж байна.

Японы эрх зүйн зохицуулалт

Япон улсын эрх зүйн тогтолцоонд гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг иргэний эрх зүйн хүрээнд зохицуулдаг. Японы Иргэний хуулийн зохицуулалтын дагуу хүний бие махбод, эрүүл мэнд, нэр төр, хувийн эрхэд халдсаны улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх боломжийг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү зохицуулалт нь гэмт үйлдлийн улмаас учирсан сэтгэл санааны болон сэтгэцийн хохирлыг тодорхой хэмжээгээр нөхөн сэргээх, улмаар хохирогчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлдэг (Krajewski, 2018).

Японы шүүхийн практикт сэтгэл санаанд учирсан хохирлын нөхөн төлбөрийг *isharyō* гэж нэрлэдэг бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо гэмт хэргийн шинж чанар, учирсан хохирлын ноцтой байдал, хохирогчийн нас, эрүүл мэндийн байдал, мөн сэтгэл санаанд учирсан үр дагаврыг харгалзан үздэг. Ялангуяа хүчирхийлэл, бэлгийн халдашгүй байдалд халдсан гэмт хэрэг, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан хэрэг зэрэгт хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлын үр дагаврыг эмнэлгийн баримт бичиг болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд тулгуурлан тогтоох нь түгээмэл байдаг (Van Dam, 2017).

Мөн Японы шүүхийн практикт нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо өмнө нь шийдвэрлэгдсэн ижил төстэй хэргийн шийдвэрүүдийг харьцуулан үнэлэх арга хэрэглэдэг. Энэ нь ижил төстэй нөхцөл бүхий хэрэгт нөхөн төлбөрийн хэмжээг харьцангуй жигд тогтоох, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг илүү тодорхой болгоход чиглэгддэг.

Иймхүү Японы эрх зүйн тогтолцоонд гэмт хэргийн улмаас хүний сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хууль тогтоомж болон шүүхийн практиктай уялдуулан зохицуулж байгаа бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хохирлын

шинж чанар, учирсан үр дагаврыг цогцоор нь үнэлэх хандлага ажиглагдаж байна.

Олон улсын туршлагын нийтлэг хандлага

ХБНГУ, Их Британи, АНУ болон Япон зэрэг улсын эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикт хийсэн харьцуулсан дүн шинжилгээнээс үзэхэд гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг зохицуулахад хэд хэдэн нийтлэг хандлага ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, дээрх улс орнуудад хүний нэр төр, алдар хүнд, хувийн амьдрал, сэтгэл санаанд учирсан хохирлыг эдийн бус хохирлын нэг төрөл гэж хүлээн зөвшөөрч, түүнийг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжид тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, Германд *Schmerzensgeld*, Японд *isharyō*, АНУ болон Их Британид *pain and suffering* зэрэг ойлголтын хүрээнд сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх боломжийг хууль зүйн болон шүүхийн практикт хүлээн зөвшөөрсөн байна.

Хоёрдугаарт, шүүхийн практикт нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо тодорхой шалгуур, үнэлгээний аргачлал ашиглах хандлага төлөвшсөн байдаг. Үүнд гэмт хэргийн шинж чанар, учирсан хохирлын ноцтой байдал, хохирогчийн нас, сэтгэл санаанд учирсан үр дагавар, нийгмийн харилцаанд үзүүлсэн нөлөө зэрэг хүчин зүйлсийг цогцоор нь харгалзан үздэг. Зарим улс оронд өмнө нь шийдвэрлэгдсэн ижил төстэй хэргийн шүүхийн шийдвэрүүдэд тулгуурлан нөхөн төлбөрийн жишиг хэмжээг ашиглах практик хөгжсөн байдаг.

Гуравдугаарт, гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг тогтоохдоо эмнэлгийн баримт бичиг болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг нотлох баримтын чухал эх сурвалжийн нэг болгон ашиглах нь нийтлэг байдаг. Энэ нь хохирлын шинж чанарыг илүү бодитой тодорхойлох, шүүхийн шийдвэрийг бодит нөхцөл байдалд тулгуурлан гаргах боломжийг бүрдүүлдэг.

Дөрөвдүгээрт, гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор төрөөс дэмжлэг үзүүлэх институцийн механизмыг бий болгосон байдаг. Тухайлбал, Их Британид *Criminal Injuries Compensation Scheme*, Японд гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгох тогтолцоо хэрэгждэг бөгөөд эдгээр механизм нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн сэргээх, хохирогчийн эрхийг хамгаалахад чухал үүрэгтэй.

Ийнхүү олон улсын туршлагаас үзэхэд гэмт хэргийн улмаас хүний сэтгэлзүйд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг үр нөлөөтэй зохицуулахад эрх зүйн тодорхой зохицуулалт, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нэгдсэн шалгуур, нотлох баримтыг үнэлэх аргачлал, түүнчлэн хохирогчийн эрхийг хамгаалах зохион байгуулалтын болон эрх зүйн механизм онцгой ач холбогдолтой болох нь харагдаж байна. Иймээс эдгээр туршлагыг харгалзан Монгол Улсад эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгох, шүүхийн практикт нэгдсэн шалгуур, аргачлал төлөвшүүлэх, мөн хохирогчийн эрхийг хамгаалах тогтолцоог цогцоор нь боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Хэлэлцүүлэг

Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь орчин үеийн эрүүгийн болон иргэний эрх зүйн огтлолцох хүрээнд хамаарах нарийн төвөгтэй эрх зүйн харилцааны нэг юм. Энэхүү судалгаанд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн үндсийг холбогдох хууль тогтоомжид тодорхой хэмжээгээр тусгасан боловч хүний сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх, нотлох, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох асуудалд практик хэрэгжилтийн тодорхой хүндрэл байсаар байна.

Нэгдүгээрт, хүний сэтгэцэд учирсан хохирлыг эрх зүйн хувьд үнэлэх асуудал нь эдийн хохирлоос ялгаатай онцлогтой. Эдийн хохирлыг мөнгөн дүнгээр харьцангуй тодорхой тогтоох боломжтой байдаг бол сэтгэл санааны болон сэтгэцийн хохирол нь материаллаг хэмжүүрээр шууд илэрхийлэхэд хүндрэлтэй байдаг. Иймээс шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн хэргийн нөхцөл байдал,

гэмт хэргийн шинж чанар, хохирогчид учирсан үр дагаврыг харгалзан үнэлгээ хийх шаардлага үүсдэг. Энэ нь шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд тодорхой уян хатан байдал бий болгодог боловч нөгөө талаас нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нэгдсэн шалгуур дутмаг байх нөхцөл бүрдүүлж байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын шүүхийн практикт сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой маргаан нь ихэвчлэн хүний нэр төр, алдар хүндэд халдсан хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдсан гэмт хэргийн хүрээнд үүсэж байгаа нь ажиглагдаж байна. Эдгээр тохиолдолд шүүхээс хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх шийдвэр гаргах хандлага илэрч байгаа боловч нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал нь харьцангуй ялгаатай хэвээр байна.

Гуравдугаарт, хүний сэтгэцэд учирсан хохирлыг нотлох ажиллагаанд мэргэжлийн байгууллагын дүгнэлт чухал ач холбогдолтой боловч практикт ийм төрлийн дүгнэлтийг тогтмол ашиглахгүй байх тохиолдол ажиглагдаж байна. Шүүх шинжилгээний тухай хуульд гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг тогтоох асуудлыг тодорхой хэмжээгээр зохицуулсан боловч уг зохицуулалтын хэрэгжилт шүүхийн практикт жигд бус байгаа нь нотлох ажиллагаанд тодорхой хүндрэл үүсгэж байна.

Нөгөө талаас, гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикт хийсэн харьцуулсан судалгаанаас үзэхэд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг илүү системтэйгээр зохицуулсан байдаг. Тухайлбал, Германд *Schmerzensgeld*, Японд *isharyō*, АНУ болон Их Британид *pain and suffering* зэрэг ойлголтын хүрээнд сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх боломжийг хууль тогтоомж болон шүүхийн практикт өргөнөөр хэрэглэж байна. Мөн эдгээр улс оронд нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо өмнөх шүүхийн шийдвэрүүдийг харьцуулан үнэлэх, эмнэлгийн баримт бичиг болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг нотлох баримтын эх сурвалж болгон ашиглах зэрэг аргачлал тодорхой хэмжээнд төлөвшсөн байна.

Иймээс Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт тодорхой хэмжээгээр бүрдсэн боловч шүүхийн практикт нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нэгдсэн шалгуур, үнэлгээний аргачлал төлөвшүүлэх шаардлага байгааг энэхүү судалгааны үр дүн харуулж байна. Ялангуяа хүний сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх шалгуур, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал, мөн нотлох баримтыг үнэлэх практикийг илүү тодорхой болгох нь энэ төрлийн маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь гэмт хэргийн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн чухал механизмын нэг юм. Орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах, учирсан хохирлыг нөхөн сэргээх асуудалд илүү анхаарал хандуулах болсон бөгөөд энэ хүрээнд эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт онцгой ач холбогдолтой болж байна.

Энэхүү судалгааны хүрээнд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тодорхой хэмжээгээр тусгасан боловч хүний сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, нотлох ажиллагааг хэрэгжүүлэх асуудалд тодорхой хүндрэл байсаар байна. Ялангуяа эдийн бус хохирлын шинж чанар нь эдийн хохирлоос ялгаатай, бодитоор хэмжих боломж хязгаарлагдмал байдаг тул шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хэрэг бүрийн нөхцөл байдалд тулгуурлан үнэлгээ хийх шаардлага үүсдэг.

Монгол Улсын шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой маргаан нь ихэвчлэн хүний нэр

төр, алдар хүндэд халдсан хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл зэрэг гэмт хэргийн хүрээнд үүсэж байгаа бөгөөд шүүхээс эдгээр тохиолдолд хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх хандлага ажиглагдаж байна.

Гэсэн хэдий ч шүүхийн практикт сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх нэгдсэн аргачлал, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох тодорхой шалгуур бүрэн төлөвшөөгүй байгаа нь ижил төстэй нөхцөл бүхий хэрэгт нөхөн төлбөрийн хэмжээ харилцан адилгүй тогтоогдох нөхцөл бүрдүүлж байна. Харин гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикаас үзэхэд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэхэд нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох тодорхой шалгуур, шүүхийн практикт нэгдсэн хандлага, мөн мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг нотлох баримтад ашиглах зэрэг аргачлал чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна.

Иймээс Монгол Улсад гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгох, мөн шүүхийн практикт нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нэгдсэн шалгуур, аргачлал төлөвшүүлэх шаардлагатай байгаа нь энэхүү судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Санал, зөвлөмж

Судалгааны үр дүнд үндэслэн гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт болон шүүхийн практикийг боловсронгуй болгох чиглэлээр дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт, хүний сэтгэцэд учирсан хохирлыг үнэлэх нэгдсэн аргачлалыг боловсруулах шаардлагатай байна. Ялангуяа эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо харгалзан үзэх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгох нь зүйтэй. Үүнд гэмт хэргийн шинж чанар, учирсан хохирлын ноцтой байдал, хохирогчийн нас, эрүүл мэндийн болон сэтгэцийн байдал, тухайн үйлдлийн улмаас нийгмийн харилцаанд учирсан үр дагавар зэрэг хүчин зүйлсийг системтэйгээр тусгах шаардлагатай.

Хоёрдугаарт, хүний сэтгэцэд учирсан хохирлыг нотлох ажиллагаанд эмнэлгийн баримт бичиг болон шүүх шинжилгээний байгууллагын дүгнэлтийг илүү өргөн ашиглах эрх зүйн болон практик нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. Ингэснээр хохирлын шинж чанарыг мэргэжлийн түвшинд тодорхойлох, шүүхийн шийдвэрийг илүү үндэслэлтэй гаргах боломж бүрдэнэ.

Гуравдугаарт, гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах хүрээнд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Тухайлбал, гэмт хэргийн улмаас учирсан сэтгэцийн болон сэтгэл санааны хохирлыг үнэлэх эрх зүйн үндэслэл, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох шалгуурыг холбогдох хууль тогтоомжид илүү тодорхой тусгах нь шүүхийн практикт нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой.

Дөрөвдүгээрт, шүүхийн практикт гарч буй шийдвэрүүдийг нэгтгэн судалж, эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохтой холбоотой практик жишиг болон арга зүйн зөвлөмж боловсруулах шаардлагатай байна. Энэ нь ижил төстэй нөхцөл бүхий хэрэгт нөхөн төлбөрийн хэмжээг харьцангуй жигд тогтоох, улмаар шүүхийн практикт нэгдсэн хандлага төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Ашигласан эх сурвалж

1. Үндэсний эрх зүйн эх сурвалж-

- Монгол Улсын Их Хурал. (2002). *Монгол Улсын Иргэний хууль*. Улаанбаатар.
- Монгол Улсын Их Хурал. (2015). *Монгол Улсын Эрүүгийн хууль*. Улаанбаатар.
- Монгол Улсын Их Хурал. (2017). *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль*. Улаанбаатар.
- Монгол Улсын Их Хурал. (2022). *Шүүх шинжилгээний тухай хууль*. Улаанбаатар.
- үүх. (2021). *Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл*. Улаанбаатар.
- Монгол Улсын Дээд шүүх. (2022). *Шүүхийн шийдвэрийн тойм*. Улаанбаатар.

2. Олон улсын эрх зүйн эх сурвалж

- Deakin, S., Johnston, A., & Markesinis, B. (2019). *Markesinis and Deakin's tort law* (8th ed.). Oxford University Press.
- Fleming, J. G. (2018). *The law of torts* (10th ed.). Thomson Reuters.
- Goldberg, J. C. P., Sebok, A. J., & Zipursky, B. C. (2020). *Tort law: Responsibilities and redress* (5th ed.). Wolters Kluwer.
- Harlow, C., & Stapleton, J. (2017). *Tort law: Text and materials*. Cambridge University Press.
- Krajewski, M. (2018). *Compensation for moral damage in civil law: A comparative perspective*. Springer.
- McGregor, H. (2019). *McGregor on damages* (20th ed.). Sweet & Maxwell.
- Markesinis, B., & Unberath, H. (2019). *The German law of torts*. Hart Publishing.
- Van Dam, C. (2017). *European tort law* (2nd ed.). Oxford University Press.
- Von Bar, C. (2018). *The common European law of torts*. Oxford University Press.
- Zimmermann, R. (2019). *The law of obligations: Roman foundations of the civil law tradition*. Oxford University Press.
- European Court of Human Rights. (2021). *Guide on Article 8 of the European Convention on Human Rights*. Council of Europe.
- European Court of Human Rights. (2022). *Case-law guide on non-pecuniary damages*. Council of Europe.
- United Nations. (1985). *Declaration of basic principles of justice for victims of crime and abuse of power*. United Nations.
- United Nations Office on Drugs and Crime. (2015). *Justice for victims: Model laws and related commentary*. United Nations.
- Council of Europe. (2018). *Compensation for victims of crime*. Strasbourg.
- Doerner, W., & Lab, S. (2019). *Victimology* (8th ed.). Routledge.
- Walklate, S. (2018). *Handbook of victims and victimology*. Routledge.
- Kirchengast, T. (2017). *Victim advocacy and criminal justice*. Palgrave Macmillan.

ХИМИЙН ХОРТ, АЮУЛТАЙ БОДИСЫГ ХУУЛЬ БУС ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ

ISSUES TO CONSIDER IN INVESTIGATING THE ILLEGAL CIRCULATION OF TOXIC AND HAZARDOUS CHEMICAL SUBSTANCES

Б.Баярсайхан*
Дотоод хэргийн их сургуулийн, Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч
Bayarsaikhan B.
University of Internal Affairs, School of Police Criminal Procedure law department of the teacher Police Major

*Хариуцлагатай зохиогч: bayarsaikhanb48@gmail.com

Хураангуй. Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэл, уул уурхай, хөдөө аж ахуйн салбар өргөжин хөгжихийн хэрээр химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, тэдгээртэй холбоотой эрх зүй, хяналтын асуудал практикт анхаарал татах болсон. Тухайлбал, химийн бодисын нэр төрөл, хэрэглээний хүрээ, эргэлтийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж, үүнтэй уялдан байгаль орчны бохирдол, хүний эрүүл мэндэд хор нөлөөлөл үзүүлэх тохиолдлууд нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэл, жижиг, дунд бизнесийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ бодитойгоор өсөж байгаа нь эрх зүйн болон хяналтын тогтолцоонд шинэ сорилтыг бий болгож байна.

Химийн хорт, аюултай бодисыг экспортлох, импортлох, улсын хилээр нэвтрүүлэх, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт нь зарим талаар нарийвчилсан, нэгдсэн тогтолцоонд бүрэн хүрээгүй байгаа нь хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэндэд хор уршиг учруулах бодит эрсдэлийг нэмэгдүүлж байна. Үүнээс гадна эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдал, байгууллага хоорондын уялдаа сул байх, тусгай мэдлэг шаардсан шинж чанар зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл бэрхшээл учруулдаг онцлогтой.

Иймд энэхүү судалгаанд химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, эрсдэлийн орчин, эрх зүйн зохицуулалт болон мөрдөн шалгах ажиллагааны онцлогт дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, мөрдөн шалгах ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр санал дэвшүүлэхийг зорив.

Summary: The rapid development of modern science and technology has contributed to the growth of industry, agriculture, mining, and other sectors, while simultaneously generating certain risks. In particular, the variety, scope of use, and circulation volume of chemical substances have been increasing annually, which has led to a growing trend of environmental pollution and adverse impacts on human health. Especially with the expansion of agricultural production, mining activities, and small and medium-sized enterprises, the use of toxic and hazardous chemicals has significantly increased, thereby posing new challenges to the legal and regulatory framework.

The legal regulations governing the export, import, cross-border transportation, production, storage, sale, transportation, use, disposal, and supervision of toxic and hazardous chemicals have not yet fully developed into a comprehensive and unified system. As a result, tangible risks to the environment, as well as to human life and health, persist. Furthermore, the lack of clarity in legal regulations, insufficient inter-agency coordination, and the technical complexity requiring specialized expertise create additional challenges in conducting criminal investigations of such offenses.

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Therefore, this study aims to analyze the current situation of crimes involving the unlawful circulation of toxic and hazardous chemicals, assess the associated risk environment, examine the existing legal framework, and evaluate the specific features of investigative procedures. Based on this analysis, the study seeks to identify practical difficulties and propose measures to improve investigative practices in addressing this category of crime.

Түлхүүр үг. Химийн хорт, аюултай бодис, хууль бус эргэлт, мөрдөн шалгах ажиллагаа, нотлох ажиллагаа, эд мөрийн баримт, шинжээчийн дүгнэлт, эрх зүйн зохицуулалт,

Keywords: *Toxic and hazardous chemicals, Illegal circulation, Criminal investigation procedure, Evidentiary process, Physical evidence, Expert opinion, Legal regulation*

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гээд “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Энэ эрхийн хэрэгжилт одоо ч тулгамдсан асуудал хэвээр байгаа бөгөөд нийслэл Улаанбаатарын утааны нөхцөл байдал, ихээр өсөн нэмэгдэж байгаа химийн хорт бодистой гэмт явдлаас харж болно.

Монгол Улсад хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах асуудал нэгдсэн тогтолцоонд шилжих процесс харьцангуй удсан нь түүхийн явцаас тодорхой харагддаг. Тодруулбал, УИХ-ын 1997 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар анх удаа Төрөөс экологийн талаар баримтлах бодлогыг батлан хэрэгжүүлж байв.

“Монгол Улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих явцыг хэрэгжүүлж эхлэхдээ иргэнийхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулж газар нутаг, байгалийн баялгаа нийт ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад авсан билээ. Үндсэн хуулийн дагуу экологийн аюулгүй байдлыг хангах, түүний эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлэх, бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчны хэтийн удирдлагын арга, зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх зорилтыг хэрэгжүүлж байна” гээд, үзэл баримтлалын 3.11.5-д “*Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх цацраг идэвхт болон химийн хорт бодисын хэрэглээг багасгах, зарим онцгой хортой бодис худалдах, ашиглах, тээвэрлэх, хадгалах, импортлоход тавих хяналтыг хүчтэй болгоно*” (хавсралт, 1997) гэж химийн хортой бодисын хяналтыг хэрэгжүүлэх стратегийг томьёолж байжээ.

Дэлхий даяар химийн хорт болон аюултай бодисын үйлдвэрлэл, эргэлт, хэрэглээ нь орчин үеийн нийгмийн салшгүй хэсэг болсон бөгөөд тэдгээрийн хэрэглээ нь үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, уул уурхай, анагаах ухаан болон ахуйн салбарт өргөн хүрээтэй нэвтэрчээ. Гэвч химийн бодисын хяналтгүй хэрэглээ, буруу хадгалалт, зохисгүй устгал нь хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд ноцтой эрсдэл үүсгэж байна. ДЭМБ-аас гаргасан судалгаанд химийн бодист өртөх явдал нь хүүхдийн эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулж байгааг онцолсон бөгөөд ялангуяа бага насны хүүхдийн эндэгдэлд тодорхой хэмжээгээр нөлөөлж буй талаар дурдсан байдаг (World Health Organization, 2016).

Судалгааны зарим бүтээлүүдэд гэр ахуйн химийн бодис, тухайлбал цэвэрлэгээний бодис, пестицид зэрэг нь хүүхдийн хордлогын нийтлэг шалтгаан болохыг тэмдэглэсэн байна (United Nations Children’s Fund, 2020). Түүнчлэн хуванцар савлагаа, будаг, тоглоом зэрэгт агуулагддаг Бисфенол-А (BPA) зэрэг бодисууд нь хүний биед удаан хугацаанд хуримтлагдаж, дотоод шүүрлийн тогтолцоонд нөлөөлөх, нөхөн үржихүйн чадварт сөргөөр нөлөөлөх, цаашлаад хавдрын эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай талаар олон улсын эрдэм шинжилгээний бүтээлүүдэд дурджээ.

Дэлхийн хэмжээнд 11 сая гаруй төрлийн химийн бодис бүртгэгдсэнээс ойролцоогоор 70 мянга орчим нь өдөр тутмын хэрэглээнд ашиглагдаж байгаа бөгөөд тэдгээрийн 10 мянга гаруй нь хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг

нөлөө үзүүлэх эрсдэлтэй хэмээн тогтоогдсон байна (United Nations Environment Programme, 2019). Химийн бодисын үйлдвэрлэл жил бүр өсөн нэмэгдэж байгаа боловч аюулгүй байдлыг хангах хяналт, зохицуулалтын механизм улс орон бүрд жигд хөгжөөгүй байгаа нь олон улсын хэмжээнд тулгамдсан асуудал хэвээр байна.

Химийн хорт болон аюултай бодисын олон улсын худалдаа, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах асуудал нь дэлхийн хэмжээнд анхаарал татсан чиглэл болж, энэ хүрээнд хэд хэдэн олон улсын гэрээ, конвенц хэрэгжиж ирсэн байдаг. Эдгээр зохицуулалт нь аюултай хог хаягдлын хил дамнасан тээвэрлэлтэд хяналт тавих, хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөөтэй химийн бодисын худалдааг зөвшөөрлийн үндсэн дээр зохицуулах, удаан хугацаанд задралгүй хадгалагддаг органик бохирдуулагч бодисын үйлдвэрлэл, хэрэглээг бууруулахад чиглэгддэг. Иймхүү олон улсын хамтын ажиллагааны хүрээнд улс орнууд химийн бодисын хэрэглээ, эргэлт, хяналтын тогтолцоогоо сайжруулж, эрсдэлтэй бодисын талаарх мэдээллийн нэгдсэн механизмыг бүрдүүлэх боломжтой болсон байна.

Ойролцоогоор 1.6 сая тонн химийн хорт бодис жил бүр дэлхийн зах зээлд эргэлдэж байгаа бөгөөд тэдгээрийн дийлэнх нь уул уурхай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт хэрэглэгдэж байна (United Nations Environment Programme, 2019). Буруу хадгалалт, тээвэрлэлт, устгалын улмаас үүссэн хаягдал нь ус, хөрс, агаарын бохирдлыг нэмэгдүүлж, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах ноцтой үр дагаварт хүргэж байгааг олон улсын байгууллагууд анхааруулсаар байна.

Гэмт хэргийн гаралт

Улсын хэмжээнд 2025 онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 2399 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасны 982 гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авч шалгажээ. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг өмнөх онд 489 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17 хэргээр буюу 3.6 хувиар өссөн байна (ЦЕГ-ын Мэдээлэл, 2024).

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг бүртгэгдсэн зүйл ангиар авч үзвэл, 201 буюу 41 хувийг хууль бусаар мод бэлтгэх, 124 буюу 25 хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, 101 буюу 21 хувь нь байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх, 49 буюу 10 хувийг хууль бусаар ан агнах, 11 буюу 2.2 хувь нь химийн хорт аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах, 3 буюу 1 хувь нь ой хээрийн түймэр тавих гэмт хэрэг тус тус эзэлж байна (ЦЕГ-ын Мэдээлэл, 2024).

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээнээс харахад химийн хорт аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэрэг 2022 онд 18, 2023 онд 34, 2024 онд 11 тус тус бүртгэгдэн мөрдөн шалгах ажиллагааг явуулсан.

Цагдаагийн байгууллагын нэгдсэн тоо бүртгэлээс харагдаж байгаа боловч тухайн онд хэдэн гэмт хэрэг бүртгэгдэх нь цагдаагийн байгууллагын хяналт шалгалтын үр дүнтэй холбоотой байна. Учир нь Экологийн цагдаагийн албанаас жил бүр “Бодис” нэртэй хяналт шалгалтын ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулан химийн хорт болон аюултай бодис ашиглаж буй аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг шалгадаг бөгөөд энэхүү шалгалтаар зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг Эрүүгийн хуулийн холбогдох зүйл ангиар гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд авч шалгалтын ажиллагааг явуулдаг байна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас химийн хорт болон аюултай бодисыг хууль бусаар ашигласан, үйл ажиллагаа явуулсан, улсын хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан талаарх дуудлага мэдээлэл бүртгэгдэхгүй зөвхөн цагдаагийн байгууллага хяналт шалгалтын үр дүнгээр илрүүлж байна.



Мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр: Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэрэг гэдэг нь химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан, улсын хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашиглахад гэмт буруугийн санаалтай хэлбэрээр халдсан Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд заасан нийгэмд аюултай үйлдэл юм.

Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргийг нийгмийн аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжид ангилдаг.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд химийн бодисыг шинж чанар, хор нөлөөллөөс нь хамааран ангилан тодорхойлсон байдаг. Тухайлбал, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлж, улмаар амь нас, экологийн тэнцвэрт байдалд аюул учруулах үйлчилгээтэй бодисыг “химийн хорт бодис” гэж үздэг байна. Харин тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч болон цочроох шинж чанартай бодисыг “химийн аюултай бодис” хэмээн ангилжээ. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглахыг бүрэн хориглосон химийн хорт болон аюултай бодисыг “хориглосон химийн бодис” гэж тодорхойлдог бол зөвхөн тусгай зөвшөөрөлтэй орчин, зориулалт, хэмжээ, технологийн нөхцөлийн хүрээнд хяналтын дор ашиглахыг зөвшөөрсөн бодисыг “хязгаарласан химийн бодис” гэж ойлгохоор хуульд тусгасан байна.

Химийн бодисыг шинж чанар болон хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь хортой, аюултай гэж ангилдаг бол химийн хорт болон аюултай бодисын ангиллыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталдаг. Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/356/396 дугаартай “Химийн хорт болон аюултай бодисын ангилал батлах тухай” тушаалаар энэхүү бодисын жагсаалтыг баталж өгсөн байна. Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг 1 дүгээр, химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлалыг 2 дугаар, химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсан байдаг.

Энэхүү жагсаалтаар нийт 3155 төрлийн химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг баталсан. Химийн хорт болон аюултай бодисыг ангилахдаа тухайн бодисын физик, химийн шинж чанар болон хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үндэслэн үнэлдэг байна. Үүнд тэсэрч дэлбэрэх, шатамхай, исэлдүүлэгч, даралтын нөлөөнд урвалд орох, агаарт болон устай харилцан үйлчлэх үед аюул үүсгэх шинж чанартай

бодисуудыг химийн аюултай бодист хамруулан авч үздэг. Мөн өөрөө халалт үүсгэх, органик хэт исэл агуулсан, химийн идэвх өндөртэй зарим төрлийн бодис, хольцыг энэ ангилалд багтаадаг. Харин химийн хорт бодисын ангиллыг тогтоохдоо хүний бие махбод болон экосистемд үзүүлэх хор нөлөөллийг түлхүү харгалзан үздэг бөгөөд арьс, нүд, амьсгалын замыг цочроох, мэдрэгжүүлэх, хавдар үүсгэх, нөхөн үржихүй болон удамшилд сөргөөр нөлөөлөх, тодорхой эрхтэн тогтолцоог хордуулах зэрэг эрсдэлийг үнэлдэг байна. Түүнчлэн усан орчин болон агаар мандлын хамгаалалтын тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлэх шинж чанартай бодисуудыг мөн химийн хорт бодисын ангилалд хамруулжээ.

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс шинэчлэн найруулсан Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйл “Зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа”-ийн 1.14 дэх хэсэгт Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахаар зохицуулсан.

Дээрх хуулийн дагуу өнөөдрийн байдлаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд “*Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах”* тусгай зөвшөөрлийг олгохын зэрэгцээ тус аж ахуйн нэгж байгууллага 3155 төрлийн бодисоос ямар төрлийн бодисыг үйл ажиллагаа явуулахдаа ашиглах, худалдах, үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг зааж өгч хавсралтаар баталж байна.

Мөн Монгол улсын Засгийн газрын 2007 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 95 дугаартай “Жагсаалт батлах тухай” тогтоолоор

1. Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт,
2. Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг тус тус баталсан байна.

Дээрх жагсаалтын 1 дүгээр хавсралтаар олон улсын бүртгэлийн дугаар /GAS/, хэрэглээний түгээмэл хэлбэр, бодисын онцлог, хоруу шинж чанар зэргийг харгалзан Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад 144 нэр төрлийн бодисыг хамааруулан үзсэн бол 2 дугаар хавсралтаар 31 нэр төрлийн бодисыг Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисыг жагсаалтад оруулсан.

Эрүүгийн хуульд химийн хорт болон аюултай бодистой холбоотой тодорхой төрлийн хууль бус үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцохоор тусгасан байдаг. Үүнд химийн бодисыг зөвшөөрөлгүйгээр ашиглах, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, худалдан авах, тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх, бусдад шилжүүлэх, зориулалтын бусаар хэрэглэх зэрэг үйлдлүүд хамаарна. Харин Зөрчлийн тухай хуульд химийн хорт болон аюултай бодистой холбоотой үйл ажиллагааг эрхлэхдээ тогтоосон журам, технологийн горим, аюулгүй ажиллагааны шаардлагыг зөрчсөн тохиолдлыг зөрчилд тооцож хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, зөвшөөрөл, хяналт, ашиглалтын нөхцөлтэй холбоотой зөрчил нь зөрчлийн шинжтэй байх боломжтой бол химийн бодисын хууль бус эргэлттэй холбоотой илүү аюултай үйлдлүүдийг эрүүгийн хариуцлагын хүрээнд авч үзэхээр хуульчилжээ.

Үүнээс үзэхэд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/356/396 дугаартай “Химийн хорт болон аюултай бодисын ангилал батлах тухай” тушаалаар баталсан 3155 нэр төрлийн бодисыг мөн Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад багтсан 144, Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисыг жагсаалтад багтсан 31 нэр төрлийн бодисыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагаас химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг Эрүүгийн хуулийн тодорхой зүйл ангид холбогдуулан мөрдөн шалгах ажиллагааг явуулахаар.

Харин Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдах, ашиглах устгах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллага тухайн химийн бодисын үндсэн шаардлага, журам, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 5.11 зүгээр зүйл "*Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих*" зөрчлөөр шалгалтын ажиллагааг явуулж хариуцлага ноогдуулахаар хуульчилсан байна.

Ашиглаж болох бодис, пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах журам зөрчсөн, эсхүл ашиглалтын хэмжээг хэтрүүлсэн, химийн хорт, аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх журам зөрчсөн, батлагдсан химийн хорт, аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаарх журам зөрчсөн, химийн хорт, аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хүлцэх хэмжээний талаарх стандартыг зөрчсөн, химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалтад дотоод хяналт тавиагүй зэрэг зөрчлүүдэд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага оногдуулахаар хуульчилсан.

Нийгмийн харилцааны явцад тодорхой хэд хэдэн төрлийн асуудал хууль хэрэгжүүлж буй байгууллагуудад тулгараад байна. Үүнд:

1. Байгууллага аж ахуйн нэгж нь Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас "*Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах*" үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахдаа байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд заагдсаны дагуу 3 төрлийн бодис ашиглах зөвшөөрөл авсан боловч үйл ажиллагаа явуулахдаа нэмэлтээр 2 төрлийн бодисыг огт зөвшөөрөл авахгүйгээр ашигладаг.

2. "*Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах*" зөвшөөрлийн хугацаа дууссан боловч төрийн эрх бүхий байгууллагаар сунгуулахгүйгээр ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсаар байдаг.

3. Алт мөнгөний дарханы чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол улсын болон гадаад улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад багтсан давсны хүчил, хүхрийн хүчил, азотын хүчил зэрэг бодисыг өдөр тутамдаа тодорхой зөвшөөрөл авахгүйгээр ашигладаг.

4. Барьцаалан зээлдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж нь барьцааны үнэт эдлэл авахдаа алт, мөнгө мөн эсэхийг шалгахдаа азотын хүчил /HNO_3/-ээр шалгадаг бөгөөд энэхүү бодис хүртэл мөн л хүний эрүүл мэндэд хор аюултай учир Химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад багтаад байна. Дээрх үйлдлүүд зэрэг маш олон төрлийн үйлдвэр, иргэн үйл ажиллагаанд өдөр тутамдаа химийн бодис ашиглаж байгаа үйлдлүүдийг журамлан шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээлүүд тулгарч байна.

Дээрх тодорхой үйлдлүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйл "*Химийн хорт аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах*" гэмт хэргээр шалгаж шийдвэрлэх үү эсхүл Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйл "*Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих"* зөрчлөөр шийдвэрлэх үү гэдэг хяналт тавьж буй прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй мөрдөгчийн үйл ажиллагаанаас шууд хамааралтай болж байна.

Дүгнэлт:

Судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/356/396 дугаартай "Химийн хорт болон аюултай бодисын ангилал батлах тухай" тушаалаар баталсан 3155 нэр төрлийн бодисыг мөн Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад багтсан 144, Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисыг жагсаалтад багтсан 31 нэр төрлийн бодисыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйл "*Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах*" гэмт хэргээр шалгах.

2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдах, ашиглах устгах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллага тухайн химийн бодисын үндсэн шаардлага, журам, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 5.11 зүгээр зүйл "*Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих*" зөрчлөөр шалгах.

3. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийг шинэчлэн найруулж иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүндрэл багатай зөвшөөрлийг олгох зорилгоор нэг удаагийн эсхүл түр зөвшөөрөл олгодог болгох. Мөн зөвшөөрөл олгох үйл явцыг автоматжуулж, нэгдсэн тоо бүртгэлийн системд оруулснаар хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

4. Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад багтсан бодисыг ашигласан тохиолдолд Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд нэмж оруулан ялгамжтай хүнд ял шийтгэлийг оногдуулах.

5. Химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг зохицуулах, устгах тогтолцоог боловсронгуй болгож байгаль орчинд учруулах хор хөнөөлийг багасгах шаардлагатай байна.

Санал:

1. Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйл болон Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлд заасан үйлдлүүдийн ялгамж заагийг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Практикт тухайн үйлдэл гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй эсэх, эсхүл зөрчлийн шинжтэй эсэхийг тодорхойлохдоо мөрдөгч, прокурорын эрх зүйн үнэлэмжээс ихээхэн хамаарч байгаа нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Иймд "хууль бус эргэлт" гэх ойлголтын хүрээнд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа, хориглосон бодисын хэрэглээ, санаатай болон болгоомжгүй хэлбэрийн ялгааг илүү нарийвчлан тодорхойлох, улмаар арга зүйн тайлбар, нэг мөр хэрэглэх зөвлөмжийг эрх бүхий байгууллагаас батлан мөрдүүлэх нь зүйтэй. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн тодорхой байдлыг хангах, ялгамжтай хариуцлагыг оновчтой хэрэгжүүлэх үндэс болно.

2. Химийн хорт болон аюултай бодистой холбоотой тусгай зөвшөөрлийн тогтолцоог илүү ил тод, хяналттай болгох зорилгоор цахим нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг хөгжүүлэх шаардлагатай байна. Одоогийн нөхцөлд зөвшөөрлийн хугацаа дууссан, эсхүл зөвшөөрөлд тусгагдаагүй бодис ашигласан зэрэг зөрчил, гэмт үйлдэл нь ихэвчлэн хяналт шалгалтын явцад илэрч байгаа нь урьдчилан сэргийлэх механизм хангалтгүй байгааг харуулж байна. Иймд тусгай зөвшөөрлийн мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн байгууллага, гаалийн байгууллагын мэдээллийн сантай

уялдуулж, бодисын нэр төрөл, хэмжээ, эргэлтийн мэдээллийг бодит цагийн горимоор хянах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй. Энэ нь хууль бус эргэлтийг эрт илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3. Химийн бодистой холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тусгай мэдлэгийн чадавхыг нэмэгдүүлэх нь чухал байна. Химийн бодисын шинж чанар, ангилал, хоруу чанар, нөлөөллийн хүрээ зэрэг асуудал нь мэргэжлийн өндөр мэдлэг шаарддаг тул мөрдөгч, прокурорын мэргэшлийг дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах, шүүх шинжилгээний байгууллагын лабораторийн хүчин чадлыг сайжруулах, шаардлагатай тохиолдолд байгаль орчин, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг мөрдөн шалгах ажиллагаанд эрт үе шатнаас оролцуулах зохицуулалтыг бий болгох нь зүйтэй. Ингэснээр нотлох баримтын чанар, шинжээчийн дүгнэлтийн үндэслэл, шинжлэх ухааны баталгаажуулалт сайжрах ач холбогдолтой.

4. Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисыг зориуд ашигласан, хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, худалдаалсан тохиолдолд нийгмийн аюулын шинж илүү өндөр тул Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд хүндрүүлэх бүрэлдэхүүнийг тусгайлан тодорхойлох шаардлагатай байна. Хориглосон жагсаалтад багтсан бодис ашигласан, байгаль орчинд ноцтой хохирол учруулсан, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол үүсгэсэн зэрэг нөхцөл байдлыг ялгамжтайгаар үнэлж, хариуцлагыг чангатгах нь урьдчилан сэргийлэх нөлөөллийг нэмэгдүүлнэ.

5. Химийн хорт болон аюултай бодисын хаягдал, устгалын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна. Буруу хадгалалт, устгал, үлдэгдэл хаягдлын зохицуулалт сул байх нь хууль бус эргэлтийн суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд химийн бодисын хаягдлыг төвлөрсөн журмаар устгах, тусгай зөвшөөрөл олгох үе шатанд устгалын зардал, хяналтын механизмыг тусган баталгаажуулах, устгалын бүртгэл, тайлагналын тогтолцоог хуульчлах нь байгаль орчны эрсдэлийг бууруулах, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах ач холбогдолтой.

Ашигласан материал

I. Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Эрүүгийн хууль, 2015 он (шинэчилсэн найруулга).
3. Зөрчлийн тухай хууль, 2017 он.
4. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2006 он.
5. Зөвшөөрлийн тухай хууль, 2022 он (шинэчилсэн найруулга).
6. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 95 дугаар тогтоол “Жагсаалт батлах тухай”.
7. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/356/396 дугаартай тушаал “Химийн хорт болон аюултай бодисын ангилал батлах тухай”.
8. Улсын Их Хурлын 1997 оны 106 дугаар тогтоол “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого батлах тухай”.

II. Олон улсын эрх зүйн баримт бичиг

9. Basel Convention on the Control of Transboundary Movements of Hazardous Wastes and their Disposal, 1989.
10. Rotterdam Convention on the Prior Informed Consent Procedure for Certain Hazardous Chemicals and Pesticides in International Trade, 1998.
11. Stockholm Convention on Persistent Organic Pollutants, 2001.

III. Олон улсын байгууллагын тайлан, судалгааны эх сурвалж

12. World Health Organization. *Preventing disease through healthy environments: A global assessment of the burden of disease from environmental risks*. Geneva: WHO, 2016.
13. World Health Organization & United Nations Environment Programme. *State of the Science of Endocrine Disrupting Chemicals*. Geneva: WHO, 2013.
14. United Nations Environment Programme. *Global Chemicals Outlook II:*

From Legacies to Innovative Solutions. Nairobi: UNEP, 2019.

15. United Nations Children's Fund. *The Toxic Truth: Children's Exposure to Lead Pollution Undermines a Generation of Future Potential*. New York: UNICEF, 2020.

IV. Статистикийн мэдээллийн эх сурвалж

16. Цагдаагийн ерөнхий газар. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээ, 2022–2025 он.

17. Экологийн цагдаагийн алба. "Бодис" нэгдсэн хяналт шалгалтын ажиллагааны тайлан, холбогдох онууд.

НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА БА ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

LEGAL ISSUES OF COOPERATION BETWEEN POLICE ORGANIZATIONS AND PRIVATE SECURITY ORGANIZATIONS IN IMPLEMENTING PUBLIC ORDER PROTECTION FUNCTIONS

Б.Баянмөнх*
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тэргүүлэх судлаач, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа
Bayanmunkh B.
Police Colonel, Ph.D., Associate Professor, Leading Researcher at the Research Institute of the University of Internal Affairs, Mongolia

*Хариуцлагатай зохиогч: B.bayadaa2007@gmail.com

Хураангуй: Өнөөдөр гэмт хэрэг, зөрчил, нийтийн аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэл нэмэгдэж, хамгаалалтын үйлчилгээ эрхлэх хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоо өргөжин тэлж байгаа хэдий ч цагдаагийн байгууллага болон хувийн хамгаалалтын байгууллагын нийтийн хэв журам хамгаалах чиглэл дэх хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт, чиг үүргийн уялдаа, мэдээлэл солилцоо, хариуцлагын тогтолцоо хангалттай бус байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Энэхүү өгүүлэлд нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх цагдаагийн байгууллага болон хувийн хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн өнөөгийн байдал, мөн хамтын ажиллагааны үеийн гүйцэтгэх үүргийн уялдаа, мэдээлэл солилцоо болон хариуцлагын тогтолцоотой холбоотой тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх зарим арга замын талаар судалж үзсэний зэрэгцээ гадаадын зарим оронд цагдаагийн байгууллага болон хувийн хамгаалалтын байгууллага хоорондын хамтын ажиллагааны арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг судалж, өөрийн оронд нэвтрүүлэх боломж шийдэл ямар байдаг талаар товч авч үзсэн болно.

Abstract: Today, risks affecting crime, offences, and public security are increasing, while the participation of private-sector security service providers continues to expand; however, the legal framework governing cooperation between police organizations and private security organizations in maintaining public order, as well as the coordination of functions, information sharing, and accountability mechanisms, remains insufficient and has become a pressing issue.

This article examines the legal regulation and current implementation of cooperation between police organizations and private security organizations in carrying out public order protection functions, analyzes issues related to functional coordination, information exchange, and accountability during cooperation, and explores certain approaches to addressing these challenges; additionally, it briefly reviews the forms, methods, and legal frameworks of cooperation between police and private security organizations in selected foreign countries and considers potential solutions and opportunities for adapting such practices within the national context.

Түлхүүр үг: Нийтийн хэв журам хамгаалах, цагдаагийн байгууллага, хувийн хамгаалалтын байгууллага, хамтын ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, төр-хувийн хэвшлийн түншлэл, аюулгүй байдал.

Keywords: Public order protection, police organization, private security organization, cooperation, legal regulation, public-private partnership, security.

Оршил хэсэг. Даяаршил, хотжилт, хүн амын төвлөрөл, мэдээллийн технологийн хөгжил эрчимжихийн зэрэгцээ гэмт хэрэг, зөрчил, нийтийн хэв журам, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэл дэлхий нийтэд болон Монгол Улсад өсөн нэмэгдэх

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

хандлагатай байна. Монгол Улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд бүртгэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлт нь нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагааг зөвхөн төрийн байгууллагын нөөц боломжид тулгуурлан хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж буйг харуулж байна.

Цагдаагийн байгууллагын статистик мэдээллээс үзэхэд олон нийтийн газар, худалдаа үйлчилгээний төв, орон сууцны хороолол, үйлдвэрлэл, уул уурхайн бүсэд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн тодорхой хувь нь урьдчилан сэргийлэх болон хамгаалалтын хяналт хангалтгүй байдалтай холбоотой байна. Нөгөө талаас Монгол Улсад хамгаалалтын үйлчилгээ эрхлэх хувийн хамгаалалтын байгууллагын тоо, үйлчилгээний төрөл, ажилтан алба хаагчдын оролцоо тогтмол өсөж, төрийн аюулгүй байдлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодит хүчин зүйл болон төлөвшиж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхэд цагдаа болон хувийн хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг эрт илрүүлэх, мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх, нөөцийн үр ашигтай хуваарилалтыг бий болгоход чухал ач холбогдолтой болох нь тогтоогдсон байдаг. Гэвч Монгол Улсад энэхүү хамтын ажиллагааны эрх зүйн үндэс, чиг үүргийн зааг ялгаа, мэдээлэл солилцох журам, хамтарсан ажиллагааны хэлбэр, хяналт болон хариуцлагын зохицуулалт нь салангид, тодорхой бус шинжтэй хэвээр байна. Үүний улмаас цагдаагийн байгууллага болон хувийн хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааны практикт эрх хэмжээ давхцах, мэдээлэл дамжуулах, хамтарсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл үүсэх нөхцөл ажиглагдаж байна.

Иймд нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхэд цагдаагийн байгууллага ба хувийн хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн өнөөгийн байдлыг судлах, гадаад улсын туршлагатай харьцуулан шинжлэх, тулгамдсан асуудал болон боловсронгуй болгох боломжит шийдлийг тодорхойлох нь онолын болон практикийн өндөр ач холбогдолтой судалгааны асуудал болж байна.

Үндсэн хэсэг. Монгол Улсад зохион байгуулагдсан соёл, урлаг, спортын олон нийтийн арга хэмжээ нь сүүлийн 10 жилийн хугацаанд тоо хэмжээ, чанар, хүртээмж, олон улсын ач холбогдлоор эрчимтэй хөгжсөн байна. Эдгээр арга хэмжээ нь нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх, эдийн засгийг дэмжих, соёлын өвийг хадгалах, олон улсын нэр хүндийг өсгөх стратегийн ач холбогдол өгсөөр ирсэн байна. Гэвч үүний хажуугаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, инфляц, ажилгүйдэл, ядуурал зэрэг хүчин зүйлсээс иргэдийн бухимдал үүсэж, төрийн бодлого, үйл ажиллагааг шүүмжлэх, эсэргүүцэх аливаа жагсаал, цуглаан, эсэргүүцлийн арга хэмжээнд оролцох оролцоо нэмэгдэж байна. Мөн иргэдийн бухимдал гүнзгийрч олон нийтийн гудамж, талбайд нийгмийг айдас, цочролд автуулсан үйлдлүүд[1] гаргах, төрийн үйл ажиллагааг сулруулах зорилгоор цагдаагийн байгууллагын алба хаагчдын хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх тохиолдол гарах болжээ.

Монгол Улсад 2014-2025 оны хооронд нийтдээ 10257 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдсан байна (НХЖХОНАБХА, 2025).

[1] Сүүлийн 2 жилийн хугацаанд нийслэлийн Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Д.Сүхбаатарын талбайд өөрийгөө шатаасан 2 тохиолдол цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн




График 1. Нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглаан зохион байгуулагдсан төлөв байдал /2014-2025/

Олон нийтийг хамарсан арга хэмжээ болон жагсаал цуглааны тоо 2014–2017 оны хооронд харьцангуй тогтвортой, бага өсөлттэй байсан нь нийгмийн идэвх оролцоо дунд түвшинд байсныг илтгэн харуулж байна. Харин 2018–2019 оноос эхлэн арга хэмжээний тоо мэдэгдэхүйц өсөж, 2019 онд 350 хүрсэн нь олон нийтийн оролцоо идэвхжиж эхэлснийг харуулж байна.

Дэлхий нийтийг хамарсан COVID-19 халдварт өвчний нөлөөгөөр 2020–2021 онд зарим хязгаарлалт хийж байсан ч жагсаал цуглааны тоо 255 хүртэл өссөн нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх хэрэгцээ нэмэгдсэнийг харуулж байна. Түүнчлэн нийтийг хамарсан арга хэмжээ 2021 онд 468 болж огцом өссөн нь цахим болон холимог хэлбэрийн арга хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой. Харин 2022 онд нийтийг хамарсан арга хэмжээ 420 болж бага зэрэг буурсан ч жагсаал цуглаан 241 болж өссөн нь нийгмийн асуудалд чиглэсэн идэвхжил нэмэгдсэнийг илтгэн харуулж байгаагийн зэрэгцээ 2023 оноос эхлэн нийтийг хамарсан арга хэмжээ огцом нэмэгдэж 1358-д хүрсэн нь бодлогын, соёлын болон олон нийтийн томоохон арга хэмжээнүүд эрс нэмэгдсэнийг харуулж байна.

Нийтийг хамарсан арга хэмжээ 2024–2025 онд энэ өсөлт улам эрчимжиж, 2025 онд 4466 арга хэмжээ бүртгэгдсэн нь өмнөх онуудтай харьцуулахад хэд дахин өссөн өндөр үзүүлэлт юм. Түүнчлэн жагсаал цуглааны тоо мөн тогтмол өсөж 2025 онд 354 болсон нь иргэдийн улс төр, нийгмийн оролцоо тогтвортой нэмэгдэж буйг илтгэнэ.

Сүүлийн 10 жилийн хугацаанд 10257 арга хэмжээ, 2404 жагсаал цуглаан бүртгэгдсэн нь Монгол Улсад соёл, урлаг, спорт болон жагсаал цуглаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээнд олон нийтийн оролцоо улам нэмэгдэж, эрс тэлснийг харуулж байна. Энэ бүх нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас нийтдээ 164037 алба хаагч /давхардсан тоогоор/, 19311 тээврийн хэрэгслийг хамгаалалтын үйл ажиллагаанд татан оролцуулсан байна. Иймд цаашид олон нийтийг хамарсан арга хэмжээний тоо өсөх хандлага үргэлжлэх тул аюулгүй байдал, зохион байгуулалт, хууль эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлага нэмэгдэж байна.

Цагдаагийн байгууллагын оролцоо. Монгол Улсын хэмжээнд 2014-2025 оны хооронд нийтдээ 10257 удаа нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдаж, үүнд давхардсан тоогоор 164037 цагдаагийн алба хаагчид 19311 тээврийн хэрэгсэлтэйгээр уг арга хэмжээний аюулгүй байдлыг хангах

хамгаалалтад ажилласан нь цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн нэг болох олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэгт хамаарч байна.

Сүүлийн 12 жилийн хугацаанд зохион байгуулагдсан нийтийг хамарсан арга хэмжээнд нийт 164037 алба хаагч оролцсон нь цагдаагийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллаагаа болон хүний нөөцөд өндөр ачаалал үүсгэж байсан байна. Энэ нь тухайн хугацаанд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, бусад хууль тогтоомжоор хүлээлгэсэн захиргааны хяналтын үүргийг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл, харуулын ажлаас тодорхой хэмжээгээр нөөц шилжүүлэхэд хүргэж, бусад үйл ажиллагааны үр нөлөөнд нөлөөлөх эрсдэл бий болгож байжээ.

Цагдаагийн алба хаагчид олон цагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэх шаардлагатай болсноор ажлын ядаргаа, стресс нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмж буурах нөхцөл бүрддэг. Мөн давхардсан тоогоор их хэмжээний хүн хүч дайчлагдаж байгаа нь илүү цомхон, оновчтой зохион байгуулалтын арга шаардагдахаас гадна гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын хүч хэрэгслийг татан оролцуулах хэрэгцээ шаардлага үүсч байгааг харуулж байна. Нөгөө талаас нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтад 19311 тээврийн хэрэгслийг хамгаалалтын ажиллагаанд ашигласан нь шатахуун, тосолгооны материалын зардлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байна. Нэг удаагийн арга хэмжээнд олон автомашин урт хугацаанд ажиллах нь бензин, дизель түлшний хэрэглээг огцом өсгөж, улсын төсөвт дарамт учруулж байна. Үүнээс гадна тээврийн хэрэгслийн элэгдэл, засвар үйлчилгээний зардал дагалдан нэмэгдэж, техник хэрэгслийн ашиглалтын хугацааг богиносгоход нөлөөлж байна. Тээврийн хэрэгслийн ашиглалт нэмэгдэхийн хэрээр сэлбэг хэрэгсэл, дугуй, тос, техникийн үйлчилгээний зардал тогтмол өсөх хандлагатай байдаг.

Санхүүгийн хувьд зөвхөн шууд зардлаар хязгаарлагдахгүй, харин нэмэлт илүү цагийн хөлс, хоол хүнс, хамгаалалтын хэрэгсэл, холбооны төхөөрөмжийн зардлууд давхар үүсдэг. Энэ нь жил бүрийн төсвийн төлөвлөлтөд дарамт үүсгэж, бусад салбарт зарцуулах боломжит хөрөнгийг хумьдаг. Цаг хугацааны хувьд алба хаагчид олон нийтийн арга хэмжээнд удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэх нь ажлын үр ашигт нөлөөлөхөөс гадна хувийн амьдралд сөрөг нөлөө үзүүлэх нэг хүчин зүйл болж байна. Мөн давтамж өндөртэй арга хэмжээнүүд нь байгууллагын дотоод зохион байгуулалт, ээлжийн хуваарьт хүндрэл учруулдаг нь тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Энэ бүх нийтийг хамарсан арга хэмжээнүүд зохион байгуулагдаж байгаа нөхцөл байдал нь цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хэт төвлөрөл нэг газарт байнга үүсч байгааг харуулж байна. Иймээс нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтыг илүү оновчтой зохион байгуулах, зарим чиг үүргийг бусад оролцогч тал буюу гэрээт харуул хамгаалалтын байгууллагад шилжүүлэх шаардлага бодитоор тулгарч байна. Ялангуяа төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдлыг хангахтай холбоотой гарч байгаа зардлыг бууруулах боломжтой. Ингэснээр цагдаагийн байгууллага үндсэн чиг үүрэгтээ илүү төвлөрч, нөөцийн үр ашиг нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. Эцсийн дүндээ энэ нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй, зохион байгуулалтын хувьд илүү тогтвортой тогтолцоог бий болгох ач холбогдолтой юм.

Монгол Улсад сүүлийн 12 жилийн хугацаанд зохион байгуулагдсан 12661 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээний 2404 буюу 18.9% нь жагсаал, цуглаан байсан бол 10257 буюу 81.1% нь спорт, урлаг, соёлын арга хэмжээнүүд хамаарч байна.

Дээрх графикаас үзвэл сүүлийн 3 огцом өссөн нь иргэдийн нийгмийн идэвх сайжирч, соёл, олон нийтийн ажил, арга хэмжээнд оролцох оролцоо нь огцом

нэмэгдсэнийг харуулж байна. Графикаас харахад 2014–2025 оны хооронд нийт олон нийтийг хамарсан арга хэмжээ тасралтгүй өсөх хандлагатай байгаа бөгөөд ялангуяа 2023 оноос огцом нэмэгдсэн байна.

Нийтийг хамарсан арга хэмжээ 2022 онд 420 байсан бол 2025 онд 4466 болж эрс өссөн нь хамгийн өндөр өсөлтийн үеийг харуулж байна. Жагсаал, цуглааны тоо мөн тогтмол нэмэгдэж байгаа боловч нийт арга хэмжээний өсөлттэй харьцуулахад харьцангуй бага хэмжээтэй өсөлттэй байна. 2023–2025 онд хоёр үзүүлэлтийн хоорондын зөрүү эрс нэмэгдсэн нь соёл, спорт, олон нийтийн томоохон арга хэмжээний өсөлт давамгай байгааг илтгэнэ. Иймээс нийт арга хэмжээний өсөлт нь аюулгүй байдлын зохион байгуулалт, ялангуяа цагдаагийн болон хамгаалалтын байгууллагын ачааллыг мэдэгдэхүйц нэмэгдүүлж байна.

Жагсаал, цуглаан нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төр, нийгмийн асуудлаар оролцогчид өөрсдийн байр сууриа ил тод илэрхийлэх зорилготой, тайван жагсаал цуглаан хийх эрхийн хүрээнд зохион байгуулагдаж явагддаг бол спорт, урлаг, соёлын арга хэмжээ нь олон нийтийн чөлөөт цаг, соёлын хэрэгцээг хангах, эдийн засаг, аялал жуулчлалыг дэмжих зорилготой байдаг. Жагсаал, цуглаан нь ихэвчлэн аяндаа эсвэл богино хугацаанд зохион байгуулагдаж, оролцогчдын сэтгэл хөдлөл, үзэл бодлын зөрчил ихтэй явагдаж байдаг бол спорт, урлаг, соёлын арга хэмжээ нь урьдчилан нарийн төлөвлөгдсөн, зохион байгуулалт өндөртэй зохион байгуулагдаж байдаг.

Эрсдэлийн хувьд жагсаал, цуглаан нь нийтийн хэв журам алдагдах, оролцогчдын үзэл бодлын зөрчилдөөн үүсэх, зорилгодоо хүрэхийн тулд төр, засаг, эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, хамгаалалтын онцгой бүс рүү хууль бусаар нэвтрэх зэрэг зөрчил үүсэх, түүнчлэн хууль сахиулах байгууллагын алба хаагч нарын хууль ёсны тавьсан шаардлагыг эсэргүүцэх, мөргөлдөөн үүсэх магадлал өндөртэй тул хууль сахиулах байгууллагын шууд оролцоо шаарддаг. Харин спорт, урлаг, соёлын арга хэмжээ нь ихэвчлэн хяналттай орчинд явагддаг ч бөөгнөрөл, осол, техник тоног төхөөрөмжтэй холбоотой эрсдэл үүсэх магадлалтай.

Хууль эрх зүйн зохицуулалтын хувьд жагсаал, цуглаан нь иргэний болон улс төрийн эрхийн хүрээнд тусгайлан хамгаалагддаг бол соёл, спорт, урлагийн арга хэмжээ нь үйлчилгээ, бизнес, олон нийтийн арга хэмжээний зохицуулалтад илүү хамаардаг.

Аюулгүй байдлыг хангах механизмын хувьд жагсаал, цуглаанд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын оролцоо давамгайлдаг бол спорт, урлаг, соёлын арга хэмжээнд хувийн хэвшлийн гэрээт харуул хамгаалалтын байгууллага, зохион байгуулагч талын үүрэг оролцоо илүү давамгайлсан байдалтай байдаг. Гэсэн хэдий ч эдгээр нь бүгд олон нийтийг хамарсан, бөөгнөрөл үүсгэдэг тул эрсдэлийн удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт шаарддаг нийтлэг шинжтэй бөгөөд оролцогчдын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, эмх журмыг сахиулах, яаралтай тусламж үйлчилгээ бэлэн байлгах зэрэг зохион байгуулагч нарт тавигддаг дээрх шаардлагууд аль алинд нь нэгэн адил хэрэгждэг.

Судалгааны үүднээс авч үзвэл, оролцогчдын зан төлөв, бөөгнөрлийн динамик нь аль алинд нь чухал нөлөөтэй бөгөөд олон нийтийн урсгалыг зохицуулах арга зүй ижил хэрэглэгддэг бөгөөд мэдээлэл түгээх, олон нийттэй харилцах, эрсдэлийн харилцаа холбоо нь аль ч төрлийн арга хэмжээнд амжилтын чухал хүчин зүйл болдог. Иймд жагсаал, цуглаан болон спорт, урлаг, соёлын арга хэмжээ нь зорилго, зохион байгуулалт, эрх зүйн орчин, эрсдэлийн шинжээрээ ялгаатай боловч олон нийтийн оролцоо, аюулгүй байдлын хэрэгцээ, менежментийн үндсэн зарчмаараа ижил төстэй гэж дүгнэж болно.

Бидний хийсэн судалгаагаар хувийн гэрээт харуул хамгаалалтын байгууллагууд нь ихэвчлэн объект хамгаалалт, хяналт, урьдчилан сэргийлэх, дэг журам сахиулах чиг үүрэгтэй бөгөөд тэдний эрх мэдэл нь төрийн цагдаагийн байгууллагаас хязгаарлагдмал байдаг. Харин жагсаал,

цуглаан зэрэг улс төр, иргэний эрхтэй холбоотой олон нийтийн үйл ажиллагаанд гэрээт харуул хамгаалалтын байгууллагууд оролцох нь бага байдаг бөгөөд хууль сахиулах, хүч хэрэглэх, баривчлах зэрэг төрийн онцгой бүрэн эрх тэдэнд байхгүй байдаг нь тэдний оролцоог хязгаарлах нэг үндэслэл болж байна.

Жагсаал, цуглаан зэрэг арга хэмжээ нь иргэний эрх, хүний эрхийн асуудалтай шууд холбогддог тул оролцогчдын аюулгүй байдлыг хангах гол үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэх нь олон улсын практикт давамгайлдаг юм байна. Судалгаанд дурдсанаар хувийн гэрээт харуул хамгаалалтын хамгаалалт нь спорт, урлаг, соёлын арга хэмжээний үеэр хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ажиглах, мэдээлэх үүрэгтэй бөгөөд ноцтой нөхцөлд заавал цагдаатай хамтран ажиллах шаардлага үүсдэг юм байна. Тиймээс спорт, урлаг, соёлын арга хэмжээ нь ихэвчлэн эрсдэлийн түвшин харьцангуй бага, зохион байгуулалттай, төлөвлөгдсөн орчин байдаг тул хувийн гэрээт харуул хамгаалалт илүү тохиромжтой юм байна.

Бидний хийсэн судалгаагаар хувийн гэрээт харуул хамгаалалт нь арга хэмжээний оролцогчдын урсгалыг зохицуулах, нэвтрэх хяналт хийх, дэг журам сахиулах зэрэгт өндөр үр ашигтай гэж үзсэн байдаг бөгөөд спорт, урлаг, соёлын арга хэмжээнд хамгаалалтыг гэрээгээр гүйцэтгүүлэх нь уян хатан, зардал багатай, шуурхай зохион байгуулалттай байх давуу талтай юм байна.

Нийтийг хамарсан арга хэмжээнд гэрээт харуул хамгаалалтын байгууллагын үүрэг гүйцэтгэх эрх зүйн төлөв байдал

Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль нь хувийн болон нийтийн өмчийг хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор мэргэжлийн, хариуцлагатай гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагааг зохицуулж, тусгай зөвшөөрөл, алба хаагчийн сургалт, эрх үүргийг тодорхойлсон эрх зүйн үндэс юм. Энэ нь гэрээний үндсэн дээр ажиллах харуул хамгаалалтын байгууллага, алба хаагч, үйлчлүүлэгчдийн харилцааг ил тод, хууль ёсны болгоход оршдог.

Гэрээт харуул хамгаалалтын байгууллагууд дараах хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хувийн хамгаалалтын тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хууль
- Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын ажилтны дүрэмт хувцасны өнгө, ялгах тэмдэг, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам
- Аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээ”MNS-6908*2021 стандарт

Дээрх эрх зүйн зохицуулалтуудыг нэгтгэн авч үзвэл гэрээт харуул хамгаалалтын байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь Үндсэн хууль, салбарын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, мэргэжлийн стандартын түвшинд харьцангуй бүрдсэн бөгөөд тусгай зөвшөөрөл, ажилтны эрх зүйн байдал, сургалт, тусгай хэрэгсэл ашиглалт, үйлчилгээний стандарт, үйлчлүүлэгч байгууллагын харилцааг зохицуулах замаар хамгаалалтын үйл ажиллагааг хууль ёсны, мэргэжлийн, хариуцлагатай байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтын чиг үүрэг, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах эрх хэмжээ, мэдээлэл солилцох механизм, хариуцлагын зааг ялгаа, үйл ажиллагааны нэгдсэн журам зэрэг асуудал зарим хууль, дүрэм, стандартын түвшинд салангид, ерөнхий байдлаар тусгагдсан байгаа нь практикт эрх хэмжээний давхардал, чиг үүргийн тодорхой бус байдал үүсгэх эрсдэлийг дагуулж байна.

Иймд гэрээт харуул хамгаалалтын байгууллагын нийтийг хамарсан арга хэмжээнд үүрэг гүйцэтгэх эрх зүйн төлөв байдлыг боловсронгуй болгохын тулд салбар хоорондын эрх зүйн уялдааг сайжруулах, цагдаагийн байгууллагатай

хамтарсан ажиллагааны тусгайлсан зохицуулалт, нэгдсэн стандарт, хяналт болон хариуцлагын механизмыг илүү нарийвчлан тодорхойлох шаардлага үүсээд байна.

Цагдаагийн байгууллага болон хувийн гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс

Цагдаагийн байгууллага болон хувийн гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс гэдэг нь нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд цагдаагийн байгууллага болон хувийн гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын хооронд үүсэх харилцаа, хамтран ажиллах чиглэл, хэлбэр, эрх хэмжээ, үүрэг, хариуцлага, мэдээлэл солилцоо болон үйл ажиллагааны журмыг зохицуулсан Үндсэн хууль, салбарын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандарт болон бусад эрх зүйн баримт бичгийн нийлбэр цогцыг ойлгоно.

- **Монгол Улсын Үндсэн хууль**

Монгол Улсын Үндсэн хууль нь гэрээт харуул хамгаалалтын байгууллага болон цагдаагийн байгууллагын харилцан, хамтын ажиллагааг шууд зааж зохицуулаагүй боловч төрийн хэв журам хамгаалах, аюулгүй байдлыг хангах суурь үндсийг тогтоодог дээд хүчин чадалтай хууль юм.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйл /Иргэний амьд явах, аюулгүй орчинд амьдрах эрх/, 19 дүгээр зүйл /Төр хүний эрх, эрх чөлөөг хангах үүрэгтэй/, 38 дугаар зүйл /Засгийн газрын нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг/ (УИХ, Монгол Улсын Үндсэн хууль, 1992) -үүд нь цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааны тогтолцооны суурь эрх зүйн үндэс болдог юм.

Монгол Улсын Үндсэн хууль нь гэрээт харуул хамгаалалтын байгууллага болон цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг шууд зохицуулаагүй боловч хүний эрх, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах төрийн үндсэн үүргийг тодорхойлсноор тэдгээрийн хамтын ажиллагааны суурь эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Иймээс гэрээт харуул хамгаалалтын болон цагдаагийн байгууллагын чиг үүргийн уялдаа, хамтын ажиллагааны нарийвчилсан зохицуулалт нь Үндсэн хуулийн дээрх зарчим, үнэт зүйлд нийцсэн байдлаар салбарын хууль тогтоомжоор хэрэгжих шаардлагатай байна.

- **Цагдаагийн албаны тухай хууль**

- 11 дүгээр зүйл /Нийтийн хэв журам хамгаалах/-ийн 11.1.6-д “гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах”,

- 17 дугаар зүйл /Цагдаагийн албаны сургалтын байгууллага/-ийн 17.3-д “Энэ хуулийн 17.1-д заасан төв нь албаны нохой ашиглах болон Галт зэвсгийн тухай хуулийн 10.4-т заасан болон гэрээт харуул хамгаалалтын сургалтыг төлбөртэй зохион байгуулж болно”

- 64 дүгээр зүйл /Иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах/-ийн 64.1.Цагдаагийн байгууллага нь нутгийн захиргааны болон төрийн бус байгууллага, иргэдээс зохион байгуулж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана. 64.2.Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна. 64.3.Цагдаагийн байгууллага, алба хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь иргэн, хуулийн этгээд дэмжлэг, туслалцаа үзүүлж, хамтран ажиллана.

- 65 дугаар зүйл /Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны үүрэг, туслалцаа/-ийн 65.2.Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан дараахь чиглэлээр цагдаагийн байгууллагад туслалцаа үзүүлнэ: 65.2.2.гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга

хэмжээнд оролцох; 65.2.3.гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн болон үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа, үйлдсэн этгээдийн талаар цагдаагийн байгууллагад шуурхай мэдээлэх; 65.2.4.гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаагийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх; 65.2.5.гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах асуудлаар мэдээ, мэдээлэл солилцож, дэмжлэг үзүүлэх талаар цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах (УИХ, 2017) зэрэг зүйл, заалтууд үүнд хамаарна.

Цагдаагийн албаны тухай хууль нь цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг хяналт, сургалт, хамтын оролцоо, мэдээлэл солилцооны механизмаар бүрдүүлж байна. Тухайлбал, хуулийн 11.1.6-д цагдаагийн байгууллага гэрээт харуул, хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах бүрэн эрхтэйгээр зохицуулсан нь тус байгууллагуудын үйл ажиллагааг төрийн хяналтын тогтолцоонд уялдуулсан байна.

Мөн 17.3-т гэрээт харуул хамгаалалтын сургалтыг цагдаагийн сургалтын байгууллагаас зохион байгуулах боломжийг тусгаснаар мэргэжлийн ур чадвар, стандарт, хууль хэрэгжүүлэх нэгдмэл арга зүйн үндэс бий болжээ. Үүнээс гадна 64, 65 дугаар зүйлүүдэд иргэн, хуулийн этгээдийг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх үүрэгтэйгээр тодорхойлсон нь гэрээт харуул хамгаалалтын байгууллагыг урьдчилан сэргийлэх болон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд оролцох эрх зүйн боломж, хамтын ажиллагааны суурь зохицуулалтыг бүрдүүлж байна.

- **Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль**

- 8 дугаар зүйл /Харуул хамгаалалтын тухай гэрээ/-ийн 8.2.1.цагдаагийн байгууллага болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн он, сар, өдөр, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар;

- 10 дугаар зүйл /Харуул хамгаалалтын алба хаагчийн сургалтын агуулга, төлөвлөгөө/-ийн 10.1.Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх асуудлыг цагдаагийн төв байгууллага хариуцна.

- 11 дүгээр зүйл /Харуул хамгаалалтын алба хаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг/-ийн 11.2.Дүрэмт хувцасны загвар болон ялгах тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллага тогтооно.

- 13 дугаар зүйл /Харуул хамгаалалтын байгууллагын үүрэг/-ийн 13.1.4.үйл ажиллагаатай нь холбогдуулан цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

- 17 дугаар зүйл /Үйлчлүүлэгчийн үүрэг/-ийн 17.1.8.эд хөрөнгө, объектын хамгаалалтын талаар цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

- 21 дүгээр зүйл /Харуул хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааг нь зогсоох/-ийн 21.1.Харуул хамгаалалтын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд цагдаагийн байгууллага хяналт тавина. 21.2.Цагдаагийн байгууллага энэ хуулийн 21.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ зохих баримт бичиг шаардан гаргуулах, тодорхойлолт авах эрхтэй (УИХ, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, 2000).

Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль нь цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүртгэл, сургалт, стандарт тогтоох, хяналт хэрэгжүүлэх тогтолцоогоор бүрдүүлж байна. Тухайлбал, хуулийн 8.2.1-д харуул

хамгаалалтын байгууллага нь цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн байх шаардлагыг тогтоосноор тус байгууллагын үйл ажиллагааг төрийн хяналт, мэдээллийн нэгдсэн санд хамруулах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлжээ. Мөн 10.1, 11.2-т харуул хамгаалалтын алба хаагчийн сургалт, давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх асуудал, түүнчлэн дүрэмт хувцас, ялгах тэмдэг, хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллага хариуцахаар зохицуулсан нь мэргэжлийн чадавх, үйл ажиллагааны нэгдсэн стандарт, зохион байгуулалтын уялдаа хангах ач холбогдолтой байна.

Үүнээс гадна 13.1.4, 17.1.8, 21.1–21.2-т харуул хамгаалалтын байгууллага, үйлчлүүлэгч нь цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх, харин цагдаагийн байгууллага хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, баримт бичиг шаардах, тодорхойлолт авах эрхтэй байхаар заасан нь талуудын харилцан үүрэг, хяналт, хамтын ажиллагааны эрх зүйн механизмыг тодорхойлж байна.

- **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль**

- 30 дугаар зүйл /Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн нийтлэг үүрэг/-ийн 30.1.1.байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, арилгах талаар тодорхой арга хэмжээг авах; 30.1.2.үйл ажиллагаа явуулж байгаа байршил, түүний ойр орчимд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг авах; 30.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг ажилтнуудаа мэдээлэх, сурталчлах; 30.1.4.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 30.1.5.барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа стандартад нийцсэн дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавих;[1] зэрэг заалтууд хамаарч байна. (УИХ, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019)

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшил, иргэн, хуулийн этгээдийн хамтын оролцоог хангах зарчмаар бүрдүүлж байна. Тус хуулиар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг зөвхөн төрийн байгууллагын чиг үүрэг бус, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэхээр зохицуулсан нь гэрээт харуул хамгаалалтын байгууллагын оролцооны эрх зүйн үндсийг бий болгодог.

Мөн хуульд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг илрүүлэх, таслан зогсоох, эрсдэлийг бууруулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах үүрэг, зарчмыг тусгасан нь цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлж байна.

Иймд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь гэрээт харуул хамгаалалтын байгууллагыг нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах болон урьдчилан сэргийлэх тогтолцооны хамтрагч субъект болгон тодорхойлж, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах эрх зүй, зохион байгуулалтын суурь орчныг бүрдүүлж байна.

[1] Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан

Өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн зохицуулалтаар гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгчийн эд хөрөнгө, объектыг хамгаалдаг.

Цагдаагийн албаны тухай хуулиар хүлээсэн зарим чиг үүргийг гэрээт харуул хамгаалалтын байгууллагад шилжүүлэх нь нийтийг хамарсан арга хэмжээний үеийн ачааллыг оновчтой хуваарилж, үндсэн чиг үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх ажиллагаанд төвлөрөх боломжийг нэмэгдүүлнэ. Ингэснээр олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд мэргэшсэн, тусгайлсан үүрэг бүхий хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, хамгаалалтын чанар, шуурхай байдлыг сайжруулах нөхцөл бүрдэнэ. Мөн төсөв, хүний нөөцийн зарцуулалт илүү үр ашигтай болж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аюулгүй байдлын тогтолцоог уян хатан, тогтвортой хөгжүүлэх боломж бүрдэх юм. Эцсийн дүндээ энэ нь цагдаагийн байгууллагын ачааллыг бууруулахаас гадна урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлж, олон нийтийн арга хэмжээний аюулгүй байдлыг илүү үр дүнтэй хангах стратегийн ач холбогдолтой юм.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 370 орчим хувийн гэрээт харуул хамгаалалтын байгууллагууд 4000 орчим харуул хамгаалалтын алба хаагчидтайгаар төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгийг хамгаалах, нийтийг хамарсан зарим соёл, урлаг, спортын арга хэмжээний хамгаалалтыг гэрээний үндсэн дээр зохион байгуулан явуулж байна.

Дүгнэлт. Дээрх эрх зүйн зохицуулалтуудад хийсэн шинжилгээнээс үзэхэд Монгол Улсад цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн суурь үндэс Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тодорхой хэмжээнд бүрдсэн байна. Эдгээр хууль тогтоомж нь төрийн хяналт, сургалт, бүртгэл, урьдчилан сэргийлэх ажиллагаа, мэдээлэл солилцоо, хамтын оролцооны ерөнхий зарчим, чиглэлийг тогтоосноор нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд талуудын уялдаа холбоог хангах эрх зүйн боломжийг бий болгожээ.

Гэвч одоогийн зохицуулалт нь ихэвчлэн ерөнхий шинжтэй, салангид байдлаар тусгагдсан бөгөөд нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамтарсан ажиллагааны хэлбэр, чиг үүргийн заг ялгаа, мэдээлэл солилцох механизм, шуурхай удирдлага, хяналт, хариуцлагын нэгдсэн журмыг нарийвчлан тодорхойлоогүй хэвээр байна. Үүний улмаас практикт эрх хэмжээний давхардал, чиг үүргийн тодорхой бус байдал, хамтын ажиллагааны уялдаа сулрах, нөөц ашиглалтын үр ашиг буурах эрсдэл үүсэх нөхцөл ажиглагдаж байна.

Иймд цаашид цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааг тусгайлан зохицуулсан эрх зүйн механизм, нэгдсэн журам, стандарт, мэдээлэл солилцох болон хамтарсан ажиллагааны процедур, хяналт-хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна. Ингэснээр нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдлыг хангах тогтолцоо илүү үр ашигтай, уялдаа холбоотой, хүний эрхэд нийцсэн байдлаар хэрэгжих эрх зүйн орчин бүрдэх боломжтой юм.

Санал. Дээрх судалгааны үр дүн, эрх зүйн шинжилгээ, дүгнэлтэд үндэслэн цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох чиглэлээр дараах 5 шинэ саналыг дэвшүүлж байна. Тухайлбал:

1. Цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагааг тусгайлан зохицуулсан нэгдсэн эрх зүйн зохицуулалт бий болгох.

Одоогийн хууль тогтоомжид хамтын ажиллагааны асуудал салангид, ерөнхий байдлаар тусгагдсан байгаа тул нийтийг хамарсан арга хэмжээ, урьдчилан

сэргийлэх ажиллагаа, объект хамгаалалт, шуурхай нөхцөлд хамтран ажиллах чиглэл, хэлбэр, эрх хэмжээ, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон тусгай бүлэг, нэмэлт зохицуулалтыг Цагдаагийн албаны тухай хууль болон Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль-д тусгах шаардлагатай.

2. Нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтад мөрдөх хамтарсан ажиллагааны нэгдсэн журам, стандарт боловсруулах.

Спорт, урлаг, соёлын арга хэмжээ, жагсаал, цуглаан зэрэг олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд цагдаа болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын оролцооны зааг ялгаа, эрсдэлийн үнэлгээ, хүч хэрэгслийн хуваарилалт, командлал, мэдээлэл дамжуулалт, онцгой нөхцөлд шилжих ажиллагааны дарааллыг нарийвчлан зохицуулсан хамтарсан ажиллагааны нэгдсэн журам, стандарт боловсруулах нь практик дахь эрх хэмжээний давхардал, зохион байгуулалтын тодорхой бус байдлыг бууруулах ач холбогдолтой.

3. Мэдээлэл солилцоо, технологийн уялдаа холбооны эрх зүйн механизмыг боловсронгуй болгох.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг эрт илрүүлэх зорилгоор камерын хяналт, шуурхай мэдээ, эрсдэлийн мэдээлэл, сэжигтэй нөхцөл байдлын талаарх өгөгдлийг цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хооронд хуульд нийцсэн, хүний эрх хамгаалсан, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан журмаар солилцох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

4. Хамтарсан сургалт, мэргэшил, гэрчилгээжүүлэлтийн тогтолцоог бий болгох.

Цагдаагийн байгууллагын сургалтын байгууллагад түшиглэн гэрээт харуул хамгаалалтын ажилтнуудад зориулсан хамтарсан сургалт, давтан сургалт, нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдал, хүний эрх, бөөгнөрлийн менежмент, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх тогтолцоог хөгжүүлж, нэгдсэн стандарт бүхий гэрчилгээжүүлэлтийн тогтолцоо нэвтрүүлэх нь хамтын ажиллагааны чанар, мэргэжлийн нэгдмэл байдлыг нэмэгдүүлнэ.

5. Хяналт, хариуцлага, үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх.

Хамтын ажиллагааны үр нөлөө, хууль тогтоомжийн хэрэгжилт, үйлчилгээний чанар, хүний эрхийн баталгаанд тогтмол үнэлгээ хийх, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох, магадлан хяналт хэрэгжүүлэх, эрсдэлийн ангилалд суурилсан шалгалтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Ингэснээр цагдаагийн байгууллага болон гэрээт харуул хамгаалалтын байгууллагын хамтын ажиллагаа нь зөвхөн хяналт болон захиргааны харилцаанд бус, харилцан хариуцлага, үр ашиг, ил тод байдалд суурилсан тогтвортой эрх зүйн тогтолцоо болж хөгжих боломжтой болно.

Ашигласан материал

1. НХЖХОНАБХА, Ц.-ы. (2025). *Жагсаал, цуглааны статистик тоо мэдээ.* Улаанбаатар хот: ЦЕГ-ын НХЖХОНАБХА.

2. УИХ. (1992 оны 1 13). *Монгол Улсын Үндсэн хууль.* legalinfo: https://legalinfo.mn/mn/detail?lawId=367

3. УИХ. (2000 оны 1 20). *Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль.* legalinfo: https://legalinfo.mn/mn/detail?lawId=228

4. УИХ. (2017 оны 2 9). *Цагдаагийн албаны тухай хууль.* legalinfo: https://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74

5. УИХ. (2019 оны 6 6). *Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.* legalinfo: https://legalinfo.mn/mn/detail?lawId=14700

МОНГОЛ УЛСАД АЙЛЧИЛСАН ГАДААДЫН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ ЗОЧИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЙЛЧЛАЛЫН ХАМГААЛАЛТЫН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ

SECURITY CONCEPTS AND TYPES OF PROTECTION FOR HIGH-LEVEL FOREIGN DELEGATIONS VISITING MONGOLIA

Н.Лхагвасайхан*
Дотоодын цэргийн штабын дарга, доктор (Ph.D), хурандаа
Lkhagvasaihan N.
Chief of Staff of the Internal Troops, Ph.D., of Law, Colonel

*Хариуцлагатай зохиогч: ochirb81@gmail.com

Хураангуй. Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба нь Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах” чиг үүргийн хүрээнд Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин, төлөөлөгчдийн хамгаалалт, зохицуулалтыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд төлөвлөн, зохион байгуулж байна.

Монгол Улсад 2014-2024 онд айлчилсан гадаадын дээд хэмжээний зочин, төлөөлөгчдийн хамгаалалтын судалгаа, танилцуулга, төрийн хамгаалалтын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт, төлөвлөлт, зохион байгуулалт, тусгай чиг үүргийн байгууллагын хамтын ажиллагаа, уламжлал, шинэчлэл, гадаадын зарим орны төрийн хамгаалалтын туршлага, цаашид анхаарах асуудал зэргийг тусгасан болно.

Abstract. Pursuant to Article 12 of the Law on Police Service, which defines the mandate of ensuring public safety, the Public Order Protection and Public Safety Department of the General Police Department plans and implements security and coordination arrangements for state dignitaries and high-level foreign guests and delegations in compliance with applicable laws and regulations.

This study presents an overview and analysis of security arrangements for high-level foreign guests and delegations visiting Mongolia between 2014 and 2024. It covers the organization of state protection, legal regulation, planning and implementation, inter-agency cooperation among specialized bodies, traditions and reforms, selected international practices in state protection, and key issues for future consideration.

Түлхүүр үг. Хамгаалалт, төлөвлөлт, судалгаа, аюулгүй байдал, ойлголт.

Keywords. Protection, Planning, Research, Security, and Understanding.

Удиртгал. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг улам дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хамгаалалт зохицуулалтыг зохион байгуулахад учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалалтад сүүлийн үеийн дэвшилтэд техник, технологи ашиглах, Олон Улсын туршлагаас суралцах талаар судлан бичсэн. Төрт ёсны уламжлал шинэчлэлийг хуулиар хүлээсэн чиг үүрэгтэйгээ хослуулан түүхэн цаг үеийн Төрийн хамгаалалтын тухай ойлголт, төрлийг харуулсан болно.

Үндсэн хэсэг. Монгол Улсын төрийн хамгаалалт нь Хүннү гүрний үеэс үүсч, Их Монгол Улсын үед хүчирхэгжин бэхжиж ирсэн дэлхийн эртний түүхтэй хамгаалалтын албадын нэг бөгөөд түүхт хишигтэн цэргийн зүй ёсны залгамжлагч юм. 1204 оны хавар Чингис Хаан Наймантай байлдахаар мордохын өмнө цэргээ аравтын тогтолцоонд оруулж, уламжлалт турхаг цэрэгт үндэслэсэн хишигтэн цэргийг байгуулж мянгат, зуут, аравтын захирагчид, урт дурын /чөлөөт/ иргэдийн хөвүүд дүү нараас сонгон авч 80 хэвтүүл, 70 торгууд томилов. 1206 онд Чингис Хаан Их Монгол Улсыг байгуулснаар төрийн хамгаалалтын үйл ажиллагаа улам нарийсаж, хишигтний зохион байгуулалт, дэг журам улам чангарч эрх, үүрэг нь үлэмж нэмэгдсэн байна.

Тулгар төр байгуулсны дараа Чингис Хаан ”…Урьд би 80 хэвтүүл манаачтай, 70 шадар хишигтэнтэй байв. Одоо мөнх тэнгэрийн өршөөлөөр, тэнгэр газрын

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

ивээлээр хүч аугаа нэмэгдэж гүр их улсыг хамтатган нэг жолоонд оруулсан тул одоо надад 1000 шадар хишигтэнг ялгаж өг. Хэвтүүл, хорчин, торгуудын хамт түмэн /10,000/ хүн болгож өгтүгэй…" гэж зарлиглаж, хишигтэнг хэрхэн бүрдүүлэх талаар "… Миний хишигтнийг томилоход түмт, мянгат, зуут, арваны ноёдын хөвүүд сул хүний /урт дурын буюу чөлөөт иргэд/ хөвүүдийн дотроос миний дэргэд тэнцэх бэлгэ эрдэмтэй, бие сайтайг нь ялгаж оруултугай" гэж зарлиг болгосон байдаг.

Эртний Монгол нутагт төрт улс үүсч, Төв Азийн хүчирхэг Хүннү гүрэн байгуулагдсан үеэс улбаалан Монгол угсааны улсуудын хаадын хамгаалалт, Их эзэн Чингис хаан нийт Монгол туургатныг нэгтгэн, дэлхийн талыг байлдан дагуулж Их Монгол гүрнийг байгуулсан үеийн төрийн хамгаалалт, тусгаар тогтнолоо дахин сэргээж: Богд хаант Монгол Улс, БНМАУ-ыг тунхагласнаас хойших өнөөдрийг хүртэл орчин цагтайгаа нийцүүлэн боловсронгуй болсоор ирсэн билээ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны салшгүй хэсэг бөгөөд үндсэн хуульт байгууллын аюулгүй байдлыг хангах зорилгоор хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон албан тушаалтан, иргэн, төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, бусад зүйлийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай үйл ажиллагааг Төрийн хамгаалалт гэж хуульчилсан байна.

Мөн хуульд дараах албан тушаалтан, иргэн төрийн хамгаалалтад байна гэж хуульчлан заасан байна. Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын даргын болон Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч; Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигч; Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын албан тушаал хашиж байсан иргэн; Монгол Улсад айлчилж байгаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа гадаад улсын төр, засгийн газрын тэргүүн, парламентын дарга, түүнийг дагалдан яваа эхнэр /нөхөр/.

Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад улсын дэд ерөнхийлөгч, гадаад хэргийн сайд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, гадаад улсын төрийн тэргүүний угсаа залгамжлагч төрийн хамгаалалтад байхаар хуульчилсан заалтын хэрэгжилтийг ханган хамгаалалт, зохицуулалтыг зохион байгуулан ажиллаж байна. Төрийн тусгай хамгаалалтын зэрэглэл, хамрах хүрээг хуульчилж өгснөөр хамгаалалт, зохицуулалтын үйл ажиллагаа, хамрах хүрээг тодорхойлоход чухал ач холбогдолтой билээ.

Зочин төлөөлөгч гэсэн үгсийг эрдэмтэн судлаачид дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал, судлаач Я.Цэвэл "Зочин гэдэг нь гаднаас ирсэн хүндэтгэвэл зохих хүн", харин академич С.Нарангэрэл "Төлөөлөгч гэдэг нь (лат. delegatus; англ, delegate; ор.делегат) сонгогддог буюу томилогдсон төлөөлөгч" хэмээн тодорхойлсон. (Н.Лхагвасайхан, 2025)

Хамгаалуулагчийн аюулгүй байдал: "Хамгаалуулагч" гэдэг нь нийтлэг нэр бөгөөд тэдний аюулгүй байдал нь аливаа хамгаалагдаж буй хүн буюу хамгаалуулагчийн эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа болон эд хөрөнгө нь аюул, заналхийллээс найдвартай хамгаалагдсан байдлыг хэлнэ. Энэ нь ихэвчлэн хууль эрх зүйн болон нийгмийн хамгаалалтаар баталгааждаг.

Хамгаалуулагчийн аюулгүй байдлын үндсэн зарчмуудад Хүний эрхийн хамгаалалт, Сэтгэл зүйн хамгаалалт, Мэдээллийн нууцлал ба хамгаалалт, Нийгмийн хамгаалалт зэрэг юм. Тухайлбал: Бие махбодын аюулгүй байдал гэдэгт Бие махбодод учирч болох аливаа халдлага, гэмтлээс хамгаалах. шаардлагатай тохиолдолд хамгаалалтын байгууллагуудын дэмжлэг авахыг хэлнэ.

Хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах арга зам гэдэгт Хууль эрх зүйн зохицуулалт, Технологийн дэвшил ашиглах, Олон нийтийн оролцоог орно.

Тухайлбал: Хамгаалалтын байгууллагуудын оролцоо нь Цагдаа, хууль сахиулах байгууллагууд хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх., Хувийн хамгаалалтын үйлчилгээ (бие хамгаалагч, аюулгүй байдлын систем) хэлнэ.

Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин, төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Төрийн ёслолын журам, бусад журмаар зохицуулан хуульчилсан байдаг.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд зааснаар "Хамгаалуулагч" гэж төрийн тусгай хамгаалалтад авсан албан тушаалтан, иргэнийг, "Хамгаалуулагчийн аюулгүй байдал" гэж төрийн тусгай хамгаалалтад байгаа албан тушаалтан, иргэний амь бие аливаа аюул, халдлагаас хамгаалагдсан байдлыг, "шадар хамгаалалт" гэж хамгаалуулагчийн аюулгүй байдлыг биечлэн дагаж хамгаалахыг, "далд хамгаалалт" гэж төрийн тусгай хамгаалалтын хүч хэрэгслийг далдалж, нийтэд мэдэгдэхгүйгээр зохиож байгаа төрийн тусгай хамгаалалтын хэлбэрийг; "төрийн тусгай хамгаалалтын бүс" гэж хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтад авсан хурал, барилга, бусад зүйлийн аюулгүй байдлыг хангаж төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх зорилгоор тогтоосон тодорхой орчин, нутаг дэвсгэрийг хэлнэ. (Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, 2024)

Объектын аюулгүй байдал: Объектын хамгаалалт гэдэг нь тодорхой обьектыг (байр, барилга, байгууламж, тоног төхөөрөмж, газар нутаг гэх мэт) гаднын аюул занал, халдлага, эвдрэл сүйтгэл, зэрэг үйлдлээс хамгаалах үйл ажиллагааг хэлнэ.

Объектын хамгаалалтын зорилго: Хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хэвийн ажиллагааг дэмжих, мэдээллийн нууцлалыг хангахад оршино.

Объектын хамгаалалтын төрлүүд: Мэдээллийн хамгаалалт, Хүний хамгаалалт,Техникийн хамгаалалт, Физик, Процедурын хамгаалалт зэрэг юм.

Тухайлбал: Физик хамгаалалт гэдэг нь объектыг физик орчинд хамгаалах, хашаа, хаалт, хяналтын цэгүүд, камерын хяналтын систем (CCTV), дохиоллын систем (Alarm), гэрэлтүүлэг, хөдөлгөөн мэдрэгчийн хамгаалалтууд орно.

Объектын хамгаалалтыг сайжруулахын тулд эрсдэлийн үнэлгээ хийх, дохиолол, камер зэрэг орчин үеийн техник ашиглах, мэргэжлийн хамгаалалтын алба ажиллуулах, байнгын сургалт, дадлага хийх, тодорхой дүрэм, журам мөрдүүлэх шаардлагатай.

Гадаадын дээд хэмжээний зочид, төлөөлөгчид Монгол Улсад төрийн болон албан ёсны айлчлал хийх үед зочид төлөөлөгчид байрлах объектын хамгаалалтыг холбогдох байгууллагатай хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан ажилладаг.

Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочид, төлөөлөгчид Монгол Улсад төрийн болон албан ёсны айлчлал хийх үед зочид төлөөлөгчид, зам маршрут, объектын аюулгүй байдлыг хангах хамгаалалт, зохицуулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан ажилладаг.

Гадаадын дээд хэмжээний зочид төлөөлөгчдийн хамгаалалтын зэрэглэлийг 4 төрлөөр ангилдаг.

№	Зэрэглэл	Зэрэглэлд хамаарах албан тушаалтан, иргэн
1	**НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛ**	Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд хэмжээний зочин
2	**ХОЁРДУГААР ЗЭРЭГЛЭЛ**	Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгэгч, Ерөнхий сайдын үүргийг орлон гүйцэтгэгч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны өндөр хэмжээний зочин
3	**ГУРАВДУГААР ЗЭРЭГЛЭЛ**	Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын алба хашиж байсан иргэн болон Улсын Их

		Хурлын дарга, Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигч, Монгол Улсын хууль, олон улсын гэрээний дагуу төрийн тусгай хамгаалалтад авах бусад албан тушаалтан, иргэн
4	**ДӨРӨВДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛ**	ТТХТхуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан хамгаалуулагчийн эхнэр /нөхөр/ , насанд хүрээгүй хүүхэд болон 6 дугаар зүйлийн 3-т заасан албан тушаалтан, тэдний эхнэр /нөхөр/, насанд хүрээгүй хүүхэд хуульд заасан нөхцөл байдлын үед түр хугацаагаар

/Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж "Хамгаалуулагчийн төрийн тусгай хамгаалалтын зэрэглэлийг ашиглуулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг үндэслэн төрийн тусгай хамгаалалтын байгууллага тогтооно" гэж заасан/

Цагдаагийн байгууллага нь Төрийн тусгай хамгаалалтын тухай Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн дагуу аюулгүй байдлыг хангах зорилгоор, хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага албан тушаалтны харилцан уялдаатай үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Айлчлалын төрөл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 119 дүгээр зарлигаар батлагдсан "Төрийн ёслолын журам"-д Монгол Улсад айлчилж байгаа гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчдийн айлчлалыг Дээд, Өндөр түвшний айлчлал гэж 2 ангилсан байдаг.

Дээд түвшний айлчлал: -Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлал;

-Гадаад улсын төрийн тэргүүний айлчлал;

-Монгол Улсын Их Хурлын даргын айлчлал;

-Гадаад улсын парламентын даргын айлчлал;

-Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлал;

-Гадаад Улсын Засгийн газрын тэргүүний айлчлал

Өндөр түвшний айлчлал:

-Гадаад улсын дэд ерөнхийлөгчийн айлчлал;

-Монгол Улсын Гадаад хэргийн сайдын айлчлал;

-Гадаад улсын Гадаад хэргийн сайдын айлчлал;

-Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын айлчлал;

-НҮБ-ын төрөлжсөн болон Засгийн газар хоорондын олон улсын бусад байгууллагын тэргүүний айлчлал;

-Гадаад улсын төрийн болон Засгийн газрын тэргүүний бие төлөөлөгчийн айлчлал;

-Гадаад улсын төр, парламент, Засгийн газрын тэргүүн асан хүний айлчлал;


-Гадаад улсын төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнжийн айлчлал;

-Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсын төр, парламент, Засгийн газрын тэргүүний айлчлал. Дээд, өндөр түвшний айлчлал нь төрийн айлчлал, албан ёсны айлчлал, ажлын айлчлал, хувийн айлчлал гэсэн ангилалтай байхаар тусгаж өгсөн байна.

Монгол Улсад сүүлийн 10 жилд айлчилсан гадаадын дээд хэмжээний зочин, төлөөлөгчдийн хамгаалалтын судалгаа:

Сүүлийн 10 жилд гадаадын дээд хэмжээний зочин, төлөөлөгчдийн хамгаалалт зохицуулалтын судалгаанд дүн шинжилгээ хийж үзэхэд 1 дүгээр зэргийн хамгаалалт 47, 2 дугаар зэргийн хамгаалалт 34, 3 дугаар зэргийн хамгаалалт 131 удаа тус тус зохион байгуулагдсан байна. (Н.Лхагвасайхан, 2025)

График 1



Судалгаанаас харахад гуравдугаар зэрэглэлийн хамгаалалт 131 буюу нийт хамгаалалтын 61.7 хувийг эзэлж байна.

График-2

Зочид төлөөлөгчдийг тивээр нь авч үзвэл: Ази тивээс 96, Америк тивээс 17, Европ тивээс 90, Африк тивээс 5, Австрали тивээс 4 орны зочин төлөөлөгч айлчилсан байна.





График 3.

Гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчдийн айлчлалыг сараар авч үзвэл:



Судалгаанаас харахад 2014-2024 оны хооронд нийт 215 удаагийн айлчлалаас 7 дугаар сард 31 удаа айлчлал хийгдсэн нь бусад саруудтай харьцуулахад хамгийн өндөр байна.

График-1 Хүснэгтэн мэдээ

д/д	Он	I зэрэг	II зэрэг	III зэрэг	Хамгаалалт аваагүй	Нийт	Ажилласан хүний тоо	Тээврийн хэрэгсэл
1	2014	4	6	11	1	22	7,939	480
2	2015	9	5	15	2	31	14,896	912
3	2016	8	6	4		18	9,252	510
4	2017		4	5		9	541	84
5	2018	1	6	9		16	2,763	230
6	2019	3	4	12		19	5,743	442
7	2020							
8	2021							
9	2022	2	3	23		28	5,680	815
10	2023	8		36		44	12,370	1258
11	2024	12		16		28	11646	1227
Нийт		**47**	**34**	**131**	**3**	**215**	**59180**	**4731**

График-2 Хүснэгтэн мэдээ

Он	Ази тив	Америк тив	Европ тив	Африк тив	Австрали тив	Нийт
2014	9	2	11			22
2015	16	1	14			31
2016	11	2	5			18
2017	8		1			9
2018	9		7			16
2019	7	3	7		2	19
2020						
2021						
2022	10	3	14		1	28
2023	17	3	20	4		44
2024	12	3	11	1	1	28
Нийт	**96**	**17**	**90**	**5**	**4**	**215**

График 3. Хүснэгтэн мэдээ

Он / сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Нийт
2014				2	2	5	6	2	4	0	0	1	22
2015		2	1	2	5	2	9	3	1	3	2	1	31
2016	1		1	3		1	5		4	2	1		18
2017					2		1	2	2	1	1		9
2018	1		1	4		1	1	3	2	2		1	16
2019			1		3	4	3	4	3	1			19
2020													0
2021													0
2022		1		7		4	1	5	4	3	2	1	28
2023	1	2	23	1	5	1	2	2	2	4	1		44
2024		2		9		3	1	4	7	2			28
Нийт	**3**	**7**	**27**	**28**	**17**	**21**	**31**	**25**	**29**	**18**	**7**	**4**	**215**

Улс орны зочин, төлөөлөгчдийг айлчилсан он, зэрэглэлээр нь харуулбал:

№	Улсын нэр	Ерөнхийлөгч	Парламентын дарга	Ерөнхий сайд	Он
1	Оросын Холбооны Улс	Ерөнхийлөгч, В.В.Путин			2014
2	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Төрийн тэргүүн, Си Зиньпин			
3	Бүгд Найрамдах Киргиз Улс			Ерөнхий сайд Джоомарт Кайпович Оторбаев	
4	Бүгд Найрамдах Латви Улс	Ерөнхийлөгч, Андрис Берзинш			
5	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Ерөнхийлөгч, Иоахим Гаук			2015
6	Бүгд Найрамдах Унгар Улс	Ерөнхийлөгч, Янош Адер			
7	Бүгд Найрамдах Энэтхэг Улс			Ерөнхий сайд, Нарендра Моди	
8	Оросын Холбооны Улс		Их хурлын Төрийн Думын дарга, С.Е.Нарышкин		
9	Бүгд Найрамдах Солонгос Улс			Ерөнхий сайд, Хван Гё Ан	
10	Япон Улс			Ерөнхий Сайд, Шинзо Абэ	
11	Бүгд Найрамдах Болгар Улс	Ерөнхийлөгч, Росен Плевнелиев			
12	Кувейт Улс	Эмир Шейх, Сабах Аль-Ахмад Аль Жабер Аль-Сабах			
13	Оросын Холбооны Улс		Их хурлын Төрийн Думын дарга, С.Е.Нарышкин		
14	Бүгд Найрамдах Унгар Улс			Ерөнхий сайд, Виктор Орбан	2016
15	Бүгд Найрамдах Энэтхэг Улс		Парламенты Лок Сабхагийн дарга, Сумитра Махажан		
16	Бүгд Найрамдах Хятад Ард Улс			Төрийн Зөвлөлийн Ерөнхий Сайд, Ли Көцян	
17	Бүгд Найрамдах Итали Улс		Парламентын Сенатын Танхимын дарга, Пьтро Грассо		
18	Бүгд Найрамдах Сингапур Улс			Ерөнхий сайд, Ли Хсиен Лүүн	
19	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс			Ерөнхий Сайд, Нгуен Суан Фук	
20	Япон Улс			Ерөнхий сайд, Шинзо Абэ	

21	Бүгд Найрамдах Солонгос Улс	Ерөнхийлөгч, Пак Гын Хэ			
22	Бүгд Найрамдах Турк Улс			Ерөнхий сайд, Бинали Йылдырым	2018
23	Бүгд Найрамдах Солонгос Улс			Ерөнхий сайд, Ли Наг Ён	2019
24	Бүгд Найрамдах Турк Улс		Их хурлын дарга Мустафа Шентоп		
25	Оросын Холбооны Улс	Ерөнхийлөгч В.В.Путин			
26	Бүгд Найрамдах Хятад Ард Улс		Бүх Хятадын Ардын Их Хурлын Байнгын хорооны дарга, Ли Жаньшу		2022
27	Канад Улс		Парламентын танхимын дарга, Жорж Ж.Фюри		
28	Бүгд Найрамдах Польш Улс	Ерөнхийлөгч, Анджей Дуда			2023
29	Бүгд Найрамдах Унгар Улс		Үндэсний Ассамблейн дарга, Көвер Ласло		
30	Бүгд Найрамдах Франц Улс	Ерөнхийлөгч, Эммануэл Макрон			
31	Бүгд Найрамдах Киргиз Улс	Ерөнхийлөгч, Садыр Нургожоевич Жапаров			
32	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс		Үндэсний Ассамблейн дарга, Саймсупон Фумвихан		
33	Оросын Холбооны Улс		Холбооны Хурлын Төрийн Думын дарга, В.В.Володин		
34	Бүгд Найрамдах Энэтхэг Улс		Парламентын Лок Сабха-гийн дарга, Ом Бирла		
35	Гэгээн Ширээт Улс	Төрийн тэргүүн, Гэгээн хутагт, Пап Франсис			
36	Бүгд Найрамдах Турк Улс		Үндэсний их хурлын дарга, Мустафа Шентоп		
37	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Ерөнхийлөгч Франк Вальтер Штайнмайер			2024
38	Бүгд Найрамдах Киргиз Улс		Жогорку Кенешийн дарга		

			Нурланбек Шакиев	
39	Бүгд Найрамдах Беларусь Улс	Ерөнхийлөгч Александр Лукашенко		
40	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс	Ерөнхийлөгч Тонглун Сисүлит		
41	Америкийн Нэгдсэн Улс			Төрийн нарийн бичгийн дарга Энтони Блинкен
42	Швейцарын Холбооны Улс	Ерөнхийлөгч Виола Амхерд		
43	Бүгд Найрамдах Словени Улс	Ерөнхийлөгч ДР.Наташа Пирц Мусар		
44	Оросын Холбооны Улс	Ерөнхийлөгч Владимр Путин		
45	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	Ерөнхийлөгч То Лам		
46	Бүгд Найрамдах Хятад Ард Улс			Коммунист намын Дэд дарга Хань Жөн
47	Бүгд Найрамдах Казахстан Улс	Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев		

Дүгнэлт

Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр гадаадын өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгчид олон улс, бүс нутгийн харилцааны асуудал хэлэлцэх, стратегийн түншлэлийг бий болгох, зөвлөлдөх, санал солилцох, гэрээ хэлэлцээ байгуулах, олон улсын хурал, соёл, урлаг, спортын арга хэмжээ, түүхт ой, тэмдэглэлт үйл явдалд оролцох зорилгоор төрийн болон албан ёсны айлчлалын давтамж нэмэгдсээр байна.

Монгол Улсад 10 жилийн хугацаанд давхардсан тоогоор гадаад улс орны Төрийн тэргүүн, Парламентын дарга, Ерөнхий сайд зэрэг дээд хэмжээний гаруй зочид төлөөлөгчдийн 210 удаагийн айлчлал хийсэн нь манай улс орны хөгжил, дэвшил, дэлхийн улс орны түншлэл, гадаад харилцаа, стратегийн бодлого өргөжин тэлж байна.

Сүүлийн 5 жилд Монгол улсад гадаадын дээд хэмжээний зочин, төлөөлөгчдийн 102 удаагийн айлчлал хийсэн нь өмнөх 5 жилээс 10 нэгжээр буурсан нь 2020-2021 онуудад дэлхий дахинд үүссэн цар тахал /ковид-19/ үед манай улсад гадаадын дээд хэмжээний зочин, төлөөлөгчдийн айлчлал хийгээгүйтэй холбоотой юм. 2024 онд ОХУ, БНХАУ, ХБНГУ зэрэг дэлхийн томоохон гүрний ерөнхийлөгч, 1.3 тэрбум дагагчтай Гэгээн ширээт /Ватикан/ Католик шашинтны тэргүүн нар манай Улсад айлчилсан нь дэлхийн улс орнуудын анхаарлыг татсан үйл явдал болсон. Гадаадын зарим оронд гэмт бүлэглэлүүдээс төрийн дээд айлчлалын үед Терроризм, улс төрийн аллага үйлдэж улс орнуудыг түгшээх болсон нь өнөө цаг үед бид зайлшгүй анхаарах ёстой асуудал гэж үзлээ.

Ашигласан материалын жагсаалт

Монгол Улсын Хууль.

1. Цагдаагийн албаны тухай хууль. 2017 он
2. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль. 2024 он

Ном, цахим эх сурвалж.

3. Төрийн тусгай хамгаалалтын газар Төрийн хамгаалалтын түүхэн замнал II боть 2014 он

4. С.Ваанчиг Төрийн тусгай хамгаалалтын албаны уламжлал түүхэн сургамж 2010 он
5. Монгол Улсын Гадаад харилцааны яам Монгол Улсын гадаад бодлогын хөх ном. 2016-2022 он
6. Хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа Б.Баянмөнх Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа 2024 он
7. http://www.touristinfocenter.mn/Home.aspx
8. https://mn.wikipedia.org/wiki/
9. s.deeshee@gmail.com /Их засаг хууль/
10. https://sspa.gov.mn/mn/page?id=3
11. https://mn.wikipedia.org/wiki/
12. https://mn.wikipedia.org/wiki/
13. Chat gpt

Зарлиг, тогтоол, журам

14. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 119 дугаар “Төрийн ёслолын журам батлах тухай” зарлиг.
15. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт зохион байгуулах /код-506/ журам.
16. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах (код-507) журам.
17. Цагдаагийн ерөнхий газрын даргын А/122 дугаар тушаал “Шуурхай удирдлагын штаб” ажиллах журам.

Тайлан, мэдээ. судалгаа

18. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн 2014-2024 оны тайлан, танилцуулга.
19. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хамгаалалт, зохицуулалтын газрын Төрийн хамгаалалтын хэлтсийн 2014-2024 оны үйл ажиллагаа, хамгаалалтын тайлан, танилцуулга.
20. Парламентын судалгааны хүрээлэн. “Төрийн хамгаалалтын байгууллагын статус, эрх зүйн орчны талаарх харьцуулсан судалгаа” 2020 он

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙ АЛБА ХААГЧИД ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТАД ӨРТӨХ ЭРСДЭЛ

FEMALE POLICE OFFICERS AT RISK OF DISCRIMINATION

В.Амарсанаа*
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн хошууч
Amarsanaa V.
Senior Researcher at the University of Internal Affairs, Mongolia, Ph.D., Police Major
В.Номинчулуун
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, цагдаагийн хошууч
Nomichuluun V.
Senior Researcher at the University of Internal Affairs, Mongolia, Police Major

*Хариуцлагатай зохиогч: amurskiitigr23@gmail.com

Товч агуулга: Энэхүү өгүүлэл нь Монгол Улсын цагдаагийн байгууллага дахь эмэгтэй алба хаагчдын хүйсийн байдлаас шалтгаалсан ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэл, түүний бодит нөхцөл байдлыг судлахад чиглэгдсэн. Монгол Улсын Үндсэн хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль зэрэг үндэсний хууль тогтоомж болон олон улсын конвенц (CEDAW)-д тулгуурлан эрх зүйн орчныг шинжилж, түүний хэрэгжилт бодит амьдрал дээр ямар байгааг эмэгтэй алба хаагчдын дунд явуулсан тоон судалгааны үр дүнгээр нотлохыг зорьсон. Тодруулбал, цагдаагийн байгууллагад ажиллаж буй 825 эмэгтэй алба хаагчийг хамруулсан асуулга судалгаа явуулж, тэдний ажлын байран дахь бодит нөхцөл байдал, ялгаварлан гадуурхалтын талаарх ойлголт, хувийн туршлагыг тоон үзүүлэлтээр гаргасан.

Судалгаагаар хууль, эрх зүйн хүрээнд ялгаварлан гадуурхалтыг хориглосон ч практикт албан тушаал ахих, хамт олны харилцаа, ажлын байрны уур амьсгал зэрэг олон талбарт ил болон далд хэлбэрийн ялгаварлан гадуурхалт оршсоор байгааг тогтоосон.

Abstract: This article focuses on the risk and actual conditions of gender-based discrimination experienced by female police officers within the Mongolian police force. It analyzes the legal framework, drawing upon national legislation such as the Constitution of Mongolia, the Law on Ensuring Gender Equality, and the Law on Police Service, as well as international conventions (CEDAW). The article aims to demonstrate the actual state of this framework's implementation through the findings of a quantitative survey conducted among female police officers.

Specifically, a survey was conducted with 825 female police officers to gather quantitative data on their actual workplace conditions, perceptions of discrimination, and personal experiences.

The study determined that despite the legal prohibition of discrimination, in practice, both overt and covert forms of it persist in various areas, including career advancement, workplace relationships, and the overall work environment.

Түлхүүр үгс: Жендер, хүйсийн тэгш байдал, цагдаагийн байгууллага, эмэгтэй алба хаагч, ялгаварлан гадуурхалт.

Keywords: Gender, gender equality, police, female officers, discrimination.

Улс орны бодлого тодорхойлох хэмжээний төрийн өндөр албан тушаалтнуудын түвшинд жендерийн эрх тэгш байдал хараахан тэнцвэржээгүй, шууд болон шууд бусаар шалтгаалсан нөхцөл байдлын улмаас төрийн албадад жендерийн эрх тэгш байдлын үзүүлэлт мөн зөрүүтэй байна.

Цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчдын ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлийн тухай ярихад жендерийн эрх тэгш байдлын талаарх асуудал зайлшгүй

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

хөндөгдөнө. “Жендерийн ялгаварлан гадуурхалт гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно” (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011). Уг тодорхойлолтод дурдсанаар, “эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар нь ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эсхүл эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт” гэж ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах гэсэн 3 төрлийн үйлдэл, эс үйлдэхүйгээр ялгаварлан гадуурхалт явагддаг хэмээн хууль тогтоогчид үзжээ.

Я.Цэвэл ялгаварлах гэдгийг “юмыг ангилах, салгах, ялгах, тодорхойлох” гэж нэг утгаар тайлбарласан бол “сайн муугаар ялгаварлах, үйл ажлаар ялгаварлах” хэмээн хоёрдогч утгаар тайлбарлаад, “бусдыг ялгавартай үзэх, ажил хөдөлмөрөөр ялгаварлах, арьс өнгөөр ялгаварлах, залуу хөгшнөөр ялгаварлах, намаар ялгаварлах, үзэл бодлоор ялгаварлах, хөрөнгө чинээгээр ялгаварлах, шашин суртлаар ялгаварлах, эрэгтэй эмэгтэйгээр ялгаварлах” (Цэвэл, 2021, хууд. 1316) гэж гуравдагч утгаар тайлбарлахаас гадна ялгаварлан гадуурхах гэх үгийг “хүнийг ямар нэгэн зүйлээр нь ялгаж үзэх” гэж хоршоо үг нэгдэж утга илэрхийлэхийг харуулсан байхад, Монгол хэлний их тайлбар тольд ялгаварлах гэдэг үгийг 2 салаа утгаар тайлбарлажээ. Үүнд:

1. Үзэгдэл юмсыг ангилах, ялган салгах, ялгагдах шинж тэмдгийг нь тодорхойлох, тодруулах: их багаар нь ялгаварлах (их багаар нь ангилах), сайн муугаар нь ялгаварлах (сайн муугаар нь ялгах) , үйл ажлаар нь ялгаварлах (хүнийг үйл ажлаар нь тодорхойлох);

2. Бусдыг ялгавартай үзэх, гадуурхах, ад үзэх: арьсны өнгөөр ялгаварлах (арьсны өнгөөр гадуурхах) (МУЕТГ, 2016). Эдгээр тайлбаруудаас үзэхэд, ялгаварлах гэх нэршлийг 2 төрөлд ангилан үзэж байх бөгөөд эхнийх нь аливаа үзэгдэл, юмсыг ангилах, зааглах болон ялгагдах шинж тэмдгийг тодорхойлох утгыг агуулдаг бол дараагийнх нь бусдыг гадуурхах гэсэн утгатай байна. Өөрөөр хэлбэл, “ялгаварлах” гэдэг үг “гадуурхах” гэх үгтэй хоршиж байж, нэгэн утга бүрдүүлж байна. Бусдыг ямар нэгэн зүйлээр нь ялгаж, ад үзэх нь ялгаварлан гадуурхалт болж тааруч байна. Ялгаварлан гадуурхах нь бусдыг ялгаж, ад үзэх байдлаар хязгаарлагдах бол үгүйсгэх ба хязгаарлах нь тусдаа үйлдэл юм. Жишээ нь: Дунд сургуулийн нэг ангид чинээлэг айлын 20 хүүхэд, амьдралын боломж тааруу, өрхийн орлого багатай айлын 1 хүүхэд суралцаж байна гэж үзье. Тэдгээр 20 хүүхэд ядуу амьдралтай 1 хүүхдийг амьдралын боломж тааруу байдлаас нь болж хамтдаа хичээл давтах болон тоглохоос татгалзаж байгаа нь ялгаварлан гадуурхалт болох юм. Харин түүнийг ядуу гэх шалтгаар элдэв аргаар хавчин гадуурхах замаар цаашид ангидаа суралцах боломжгүй болгож байгаа нь бусдыг үгүйсгэж, сурч боловсрох эрхийг нь хязгаарлаж байгаа үйлдэл (эс үйлдэхүй) болно.

Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) гэж заасан нь аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтай тэмцэх эрх зүйн үндэс болж, цаашдын чиг хандлагыг тодорхойлсон.

Үндсэн хуулийн уг үзэл баримтлалын дагуу Монгол Улс “Жендерийн эрх тэгш байдлын тухай”, “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” хуулиудыг баталж, жендерийн шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг хуулиар хориглосон. Мөн 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр оруулсан нэмэлтээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйлд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан

бол (Эрүүгийн хууль, 2015) эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт тусгагджээ. Үүнээс гадна "энэ гэмт хэргийг бүлэглэж, хүч хэрэглэж, албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол" (Эрүүгийн хууль, 2015) хүндрүүлэхээр, Зөрчлийн тухай хуульд 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр оруулсан нэмэлтээр хуулийн 6.26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол" (Зөрчлийн тухай хууль, 2017) гэж, 2 дахь хэсэгт "Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй бол" (Зөрчлийн тухай хууль, 2017) гэж тус тус заасан нь хууль, эрх зүйн орчинд ялгаварлан гадуурхалтай тэмцэх хүчтэй механизм үйлчилж эхэлсний илрэл юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам хүний эрхэд нийцсэн байх нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, цагдаагийн ажил, үйлчилгээг хуулийн хүрээнд, олон нийтэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, алба хаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэл хууль ёсны, ил тод байх, мэргэжлийн ур чадвар дээшлэх, мөн тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой (ННФ, 2021).

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөнд "Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй" (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) гэж заасан нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүртэл эрэгтэй, эмэгтэй алба хаагчид тэгш эрхтэйгээр хамтран оршихын баталгаа юм. Уг баталгаа нь салбар хуулиудын хэрэгжилтээр дамжиж хангагддаг. Тухайлбал, ТАТХ-д "Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно" (Төрийн албаны тухай хууль, 2017), "Төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, түүнчлэн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхийг хориглоно" (Төрийн албаны тухай хууль, 2017), "ЖЭТБХТХ-ийн 4.1.5, 4.1.6-д заасан хэлбэрээр иргэнийг ялгаварлан гадуурхахыг хориглоно" (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011) гэж тус тус заасан нь төрийн албанд ажиллаж буй хүмүүсийн хоорондын ялгаварлан гадуурхалтай тэмцэх үндсэн хэрэгсэл болж байна. Уг хуулийн үзэл баримтлалыг үндэс болгож, ажлын байранд үүссэн аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтад хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бүрдэх юм.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд ч мөн адил ялгаварлан гадуурхалтай тэмцэх, даамжруулахгүй байх чиглэлийн үзэл баримтлал шингэсэн. Тодруулбал, уг хуулийн 7 дугаар зүйл (Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ)-д "албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх" (Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, 2023) гэж тухайлан заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа салбар хуулиудад тусгалаа олж, цаашдын харилцааг зохицуулж байгаагийн илрэл юм.

ЦАТХ-д "Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй" (Цагдаагийн албаны тухай хууль, 2017) гэж алба хаагчийн гүйцэтгэх үүргийн хувьд бусдыг ялгаварлан гадуурхалгүйгээр, иргэдэд тэгш үйлчлэх ёстой талаар заасан боловч алба хаагчид хоорондын ялгаварлан

гадуурхалтай тэмцэх чиглэлийн зүйл, заалт хараахан тусгагдаагүй байна. Харин ЦБҮАЖ-ын 914.6 дугаар зүйлийн 914.6.3 дахь хэсэгт “Хүнийг ялгаварлан хандаж гадуурхах, үл тоомсорлосон сэтгэгдэл төрүүлэхүйц үйлдэл хийх, хүнд суртал гарган чирэгдүүлэх, шаардлагагүй баримт бичиг нэхэх, гаргасан гомдол, хүсэлтийн талаар маргах, уурлах, үгүйсгэх, өөрийг нь шалтгаангүйгээр буруутгах, бусдыг эрхшээлдээ оруулах, дарамтлах, танил тал харах, хувийн ашиг сонирхлын үүднээс хандах, бусдын нөлөөнд автах, аливаа хүн, байгууллагын эрх ашгийг илүүд үзэхийг хориглоно” (ЦЕГ, 2024, хууд. 905) гэж заасан нь алба хаагчид үүрэг гүйцэтгэхдээ иргэнд дээрх байдлаар хандах явдал гаргуулахгүй байхыг зорьсон нь ЦАТХ-д заасан үзэл санааг баримталж байгаагаараа дэвшилттэй байна. Мөн журмын 922.3 дугаар зүйл (Ялгаварлан гадуурхалт гарахаас урьдчилан сэргийлэх)-д ялгаварлан гадуурхалтай тэмцэх чиглэлээр нэлээд ач холбогдолтой заалтууд тусгагджээ. Эдгээрээс заримыг дурдвал:

“Цагдаагийн алба хаагч аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалт гаргаж байгаа алба хаагч, ажилтанд энэ тухай албаны үг хэллэгээр зөв шаардлага тавьж ойлгуулна. Шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд холбогдох дээд шатны албан тушаалтанд мэдэгдэнэ” (ЦЕГ, 2024, хууд. 922.3.3). “Ялгаварлан гадуурхалтад өртсөн гэж үзэж байгаа алба хаагч энэ тухай гомдлоо холбогдох албан тушаалтан, байгууллагад гаргана. Түүний гаргасан шийдвэртэй холбоотой гомдлоо дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргаж болно” (ЦЕГ, 2024, хууд. 922.3.4). ЦБҮАЖ-д алба хаагчдын хоорондын ялгаварлан гадуурхалттай тэмцэх бодлого хэрэгжиж байгааг эндээс харж болохоор байна.

Цагдаагийн алба хаагч Төрийн албаны тухай, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай, ЦАТХ, ЦБҮАЖ-д зааснаас гадна хууль дээдлэх (ЦЕГ, 2024), шударга байх (ЦЕГ, 2024), хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх (ЦЕГ, 2024), хариуцлагатай байх (ЦЕГ, 2024), манлайлах, хамтач байх (ЦЕГ, 2024) зэрэг ёс зүйн зарчмыг баримтлах ёстой.

Монгол Улсын Үндсэн хууль, түүний дагавар хууль тогтоомжуудад эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хүндэтгэн дээдлэх, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтын эсрэг заалтууд хүртээмжтэй тусгагдсан болох нь дээрх хуулиуд болон дүрэм, журамд заасан үзэл баримтлалаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэхээс гадна иргэдийг болон алба хаагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх зарчим хамаарах хууль тогтоомжуудад туйлын тодорхой тусгагджээ. Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдсэн боловч бодит амьдралд хэрэгжилтийн байдал ямар хэмжээнд байгаа нь сонирхол татаж байна.

Уг нөхцөл байдлыг тогтоох зорилгоор ЦБЭАХ-дад тавьсан “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны үед таныг үндэс, угсаа, хэл, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эсхүл гадаад төрхөөр тань шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг тань нь хязгаарлах явдал тохиолдож байсан уу?” гэх асуултад оролцогчдын 596 (72.2%) нь “Би ажлын байрны ялгаварлан гадуурхалтад өртөж байгаагүй” гэсэн бол 83 (10.1%) нь “Намайг дээрх байдлаар ялгаварлан гадуурхах тохиолдол гарч байсан”, 166 (20.1%) нь “Практикт эмэгтэй алба хаагчдыг царай зүс, хөрөнгө чинээгээр нь ялгаж харьцах явдал түгээмэл” гэжээ.

Тэгэхээр шат шатны цагдаагийн байгууллагын ажлын байран дахь эмэгтэй алба хаагчдыг ялгаварлан гадуурхах явдал ил болон далд хэлбэрээр оршин байгааг уг судалгааны үр дүн баталж байна.

Нийт судалгаанд оролцогчдын 72.2 хувь нь аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтад өртөж байгаагүй бол 30.2 хувь нь ялгаварлан гадуурхалтад өртөж байсан болон ялгаварлан гадуурхалт түгээмэл болохыг тодотгосон явдал нь эмэгтэй алба хаагчдыг ялгаварлан гадуурхах явдлаас шалтгаалаад уг албанд

ажиллахад хүндрэл учирч болзошгүй нөхцөл байдалтай байна.

Түүнчлэн эмэгтэй алба хаагчдыг хооронд нь зүс царай, биеийн харьцаа болон бусад зүйлсээр нь харьцуулах замаар ялгаварлаж байгаа болохыг оролцогчид дурджээ.

ЦБЭАХ-дад эмэгтэй хүн гэдэг утгаараа учирч буй хүндрэл, бэрхшээлийг тодруулахаар судалгаанд оролцогчдоос “Танд цагдаагийн байгууллагад ажиллахад хүйсийн байдлаас шалтгаалсан хүндрэл, бэрхшээл үүсэж байна уу?” гэх асуултад нийт судалгаанд оролцсон цагдаагийн 825 эмэгтэй алба хаагчдын 206 (25%) нь “Тийм, эмэгтэй хүн учраас албан тушаал ахихад хүндрэлтэй байдаг” гэж хариулсан бол, 422 (51.2%) “Тийм, ажлын онцлогоос шалтгаалаад ар гэртээ анхаарал тавих боломж хомс байдаг”, 35 (4.2%) “Тийм, дарга, хамт олонтой харилцахад хүндрэл учирч байдаг”, 36 (4.4%) “Тийм, хамт олны зүгээс ажилтай холбоотой дарамт, шахалт ирдэг”, 30 (3.6%) Тийм, ажлын байрны бэлгийн дарамтад их, бага хэмжээгээр өртдөг гэсэн бол, 319 (38.7%) алба хаагч “Үгүй, бусдын нэгэн адил ажлаа хэвийн гүйцэтгээд явахад хүндрэл, бэрхшээл үүсдэггүй” гэсэн хариултыг сонгосон байна.



Зураг 1. Алба хаагчдыг ялгаварлан гадуурхаж байсан эсэх талаарх судалгаа



Зураг 2. Алба хаагчийн хүйсийн ялгаатай байдлаас хамаарсан хүндрэлийн талаар

Дээрх хариултуудаас цагдаагийн байгууллагын зарим эмэгтэй алба хаагчид албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, цаашлаад бэлгийн дарамтад өртөх эрсдэлтэй байгааг харж болохоор байна. Тэгвэл энэ нөхцөл байдлыг нарийн тодруулах зорилгоор алба хаагчдад тавьсан “Эрэгтэй алба хаагчдын зүгээс таныг ялгаварлан гадуурхаж байсан уу?” гэх асуултад оролцогчдын 42.9 хувь нь “Ер нь цагдаагийн алба хаагчид дунд хүйсийн байдлаар ялгаварлан гадуурхах явдал байдаггүй”, 43.8 хувь нь “Эрчүүд намайг эмэгтэй гэдэг утгаар нь ялгаварлан гадуурхаж байгаагүй” гэж хариулсан бол 13.3 хувь нь “Эрчүүд намайг эмэгтэй гэдэг утгаар нь ялгаварлан гадуурхаж байсан” гэж хариулсан нь анхаарал татаж байна.

Нийт судалгаанд оролцогчдын 13.3 хувь нь зөвхөн эмэгтэй алба хаагч гэдэг утгаараа бусдын (эрэгтэй алба хаагчдын) зүгээс гаргах их, бага хэмжээний ялгаварлан гадуурхалтад өртөж байсан болох нь харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагад хүйсийн байдлаар ялгаварлан гадуурхах явдал түгээмэл бус боловч, тодорхой хэмжээнд оршин байгаа ажээ. Тэгвэл ялгаварлан гадуурхалт аман хэлбэрээр (хэл амаар доромжлох, бусдад муулах г.м) яригдаад өнгөрөх бус, бусдад давуу байдал олгох зорилго агуулж байсан эсэхийг тодруулахаар судалгаанд оролцогчдоос “Таныг дээрх байдлаар ялгаварлан гадуурхах замаар өөр эмэгтэй, эсхүл эрэгтэй алба хаагчид давуу байдал олгож байсан уу?” гэх асуултад

оролцогчдын 590 (73.2%) нь “Би ийм хэлбэрийн гадуурхалтад өртөж байгаагүй” гэсэн бол 82 (10.2%) нь “Миний албан тушаалд өөр хүн ажиллуулах зорилгоор намайг ялгаварлан гадуурхаж байсан”, 150 (18.6%) нь “Бусдад давуу байдал олгож албан тушаал ахиулдаг тохиолдол практикт түгээмэл” гэж хариулжээ.



Зураг 3. Эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүдэд үзүүлж буй гадуурхалтын талаар



Зураг 4. Алба хаагчдад давуу байдал олгож байсан эсэх талаарх судалгаа

Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагад хүйсийн байдлаар ялгаварлан гадуурхах явдал түгээмэл бус боловч, тодорхой хэмжээнд оршин байгаа ажээ. Тэгвэл ялгаварлан гадуурхалт аман хэлбэрээр (хэл амаар доромжлох, бусдад муулах г.м) яригдаад өнгөрөх бус, бусдад давуу байдал олгох зорилго агуулж байсан эсэхийг тодруулахаар судалгаанд оролцогчдоос “Таныг дээрх байдлаар ялгаварлан гадуурхах замаар өөр эмэгтэй, эсхүл эрэгтэй алба хаагчид давуу байдал олгож байсан уу?” гэх асуултад оролцогчдын 590 (73.2%) нь “Би ийм хэлбэрийн гадуурхалтад өртөж байгаагүй” гэсэн бол 82 (10.2%) нь “Миний албан тушаалд өөр хүн ажиллуулах зорилгоор намайг ялгаварлан гадуурхаж байсан”, 150 (18.6%) нь “Бусдад давуу байдал олгож албан тушаал ахиулдаг тохиолдол практикт түгээмэл” гэж хариулжээ.

Тэгэхээр цагдаагийн байгууллагад чадахуйн (мерит) зарчмын хэрэгжилт хангалтгүй, эмэгтэй алба хаагчдын албан тушаалд өөр алба хаагчийг мэдлэг, ур чадварыг нь харгалзалгүйгээр, өөрийн ойр дотны (хамаатан, найз болон бусад) хүнийг томилох зорилгоор эмэгтэй алба хаагчдыг ялгаварлан гадуурхах явдал бодит амьдралд цөөнгүй байгаа нь дээрх судалгаанаас ажиглагдаж байна. Нийт судалгаанд хамрагдсан 800 гаруй эмэгтэй алба хаагчдын 82-т ийм зүйл тохиолдож байсан нь цагдаагийн байгууллагын албан тушаалд томилох тогтолцоо бусдыг хавчиж, гадуурхах байдлаар хэрэгжих эрсдэлтэй байгааг харуулж байна.

Эмэгтэй алба хаагчдыг ялгаварлан гадуурхах замаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжийг хязгаарлан, цаашилбал, ажлаас халшрах хам шинж илрэн гарах нөхцөлийг бүрдүүлж байгаа нэг зүйл нь хамт олны таарамжгүй уур амьсгал юм. Хоногийн дийлэнх цаг хугацааг өнгөрүүлдэг, хоёр дахь гэр болсон ажлын байрандаа, хамтран зүтгэгчидтэйгээ таарамжгүй уур амьсгалтай байх нь тухайн хүний сэтгэл санаа, биеийн байдал, ажлын үр бүтээмж зэрэгт нөлөөлөхөөс гадна даамжирсан тохиолдолд сэтгэцийн эмгэгтэй болох аюултай.



Зураг 5. Бусад алба хаагчидтай харилцаанд ороход үүсэх хүндрэлийн талаарх судалгаа


Судалгаанд оролцогчдоос "Ажил үүргийнхээ хуваарийн дагуу бусад алба хаагчидтай харилцахад таныг хэрхэн хүлээн авдаг вэ?" гэх асуултад 132 (16.2%) нь "Ажил үүргийн хуваарийн дагуу дээд шатны албан тушаалтантай харилцах үед намайг үл ойшоох явдал түгээмэл гардаг", 76 (9.3%) нь "Ажил үүргийн хуваарийн дагуу доод шатны албан тушаалтантай харилцахад намайг үл ойшоох явдал түгээмэл гардаг", 192 (23.6%) нь "Эмэгтэй алба хаагчаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэхгүй байх, үл ойшоох явдал их гардаг нь хүндрэлтэй байна", 223 (27.4%) нь "Эмэгтэй алба хаагчдаас гаргасан санал, хүсэлт, даалгаврыг эрчүүд хүлээн авч, биелүүлэх болон тусалж, дэмжих тал дээр ямар ч асуудал үүсдэггүй", 367 (45%) нь "Захирах захирагдах ёсонд хүйсийн ялгаа хамааралгүй" гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь дээд, доод шатны албан тушаалтантай харилцахад үл ойлголцол үүсдэг, эрэгтэй алба хаагчдын зүгээс үл ойшоох явдал нэлээд гардаг болохыг цохон тэмдэглэжээ. Мэдээж хэрэг цагдаагийн байгууллагын албан үүргийн онцлог, гүйцэтгэж буй ажлын ачаалал, харилцаж буй иргэдийн зүгээс үзүүлэх (ихэвчлэн) сөрөг нөлөө зэргээс хамааралтай үүрэг гүйцэтгэх үед олон төрлийн стресстэй нүүр тулдаг болохыг үгүйсгэхгүй хэдий ч, хүйсийн байдлаар ялгаварлан гадуурхах явдалтай эвлэрч болохгүй.

ЦБЭАХ-ийн сэтгэгдэл. Ажлын хэт их ачааллаас болж ажлаасаа залхах тохиолдол их. Ажлын хий ачаалал, давхардсан олон бичиг, судалгаанаас болж ар гэр, үр хүүхдээ гаргах цагаас хомсолдог. Цахим болно гээд л цаас нэхээд байдаг...

Ялгаварлан гадуурхалт нь өнгөц байдлаар харахад зөвхөн сэтгэл санаанд сөрөг нөлөөтэй мэт боловч, үнэн хэрэгтээ алба хаагчийн олон зүйлд шууд болон шууд бусаар нөлөөлдөг, хортой зүйл юм. Сэтгэл санаанд нөлөө үзүүлж буй ялгаварлан гадуурхалтаас гадна хүчирхийллийн шинжийг давхар агуулсан ялгаварлан гадуурхалтай ЦБЭАХ-д нүүр тулж байгаа цочирдом мэдээ байна. Тодруулбал, ЦБЭАХ-дад тавьсан "Таны удирдлага, эсхүл хамтран зүтгэгчид доорх зөрчил гаргаж байсан уу?" гэх асуултад судалгаанд оролцогчдын 16 (2%) нь "Зодох, цохих зэргээр эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, үйлдэхээр заналхийлэх" гэсэн хариултыг сонгосон бол 171 (21.5%) нь "Хэл амаар доромжлох, нэр төр, алдар хүндийг гутаах", 29 (3.6%) нь "Хүсээгүй байхад бэлгийн сэдлээ үгээр, биеэр,

цахимаар болон бусад хэлбэрээр илэрхийлэх”, 6 (0.8%) нь “Бэлгийн харилцаанд орох эсэхээс шалтгаалж ажил, албан тушаал, цалин хөлс зэрэг эдийн засгийн болон бусад байдлаар урамшуулах, эсхүл хохироохоор айлган сүрдүүлэх, тулган шаардах, болзол тавих” зэрэг хариултыг сонгосон бол 599 (75.3%) нь “Удирдлага, хамт олноос ямар нэг зөрчил гаргаж байгаагүй” гэжээ.



Зураг 6. Удирдлага ба хамтран зүтгэгчдээс гаргаж буй зөрчлийн талаар

ЦБЭАХ-дыг хамтран зүтгэгчдийнх нь зүгээс зодох, цохих зэргээр эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, эсхүл үйлдэхээр заналхийлэх тохиолдол хүртэл гарч байсан нь эмэгтэй алба хаагчид үүрэг гүйцэтгэх үед нь гаднаас чиглэсэн бус, хамт ажилладаг алба хаагчдынх нь зүгээс гаргасан түрэмгийллийн шинжтэй үйлдэлд өртөж байгаа нь анхаарал тавих шаардлагатай асуудлуудын тэргүүн эгнээнд байна. Үүнээс гадна хэл амаар доромжлох, нэр төр, алдар хүндийг гутаах явдал түгээмэл байгаагаас гадна зарим ЦБЭАХ-дад олон төрлийн бэлгийн дарамт үзүүлэх байдал практикт цөөнгүй тохиолдох болсон нь ноцтой асуудал юм. Энэ нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөнд халдаад зогсохгүй нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод заасан үзэл санаа, хязгаарлалтыг зөрчиж байна.

Монгол Улсын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагаа цоо шинэ түвшинд хүрч, дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох, соёрхон батлах нь нэмэгдсэн. Олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орно гэдэг нь тус гэрээг дотоодын хуулийн нэгэн адил хэлбэрэлтгүй хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Харин нэгдэн орсон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, чухал ач холбогдол бүхий стандарт журам, томьёоллыг дотоодын хуульдаа тусгах, дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээтэй уялдуулж, зохицуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ЦБЭАХ-дын дунд явуулсан асуулгын үр дүнгээс нэгдэн орсон гэрээ, конвенцод заасан үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа гэж дүгнэх үндэстэй байна. Өөрөөр хэлбэл, дээрх байдлаар ЦБЭАХ-дыг ялгаварлан гадуурхах явдал цөөнгүй байгаа нь ЭАБХУТК-ийг ноцтой зөрчсөн байна.

ЭАБХУТК-д “Эмэгтэйчүүдийг алагчлах гэсэн нэр томъёо нь гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа бусад салбарт эмэгтэйчүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, эсхүл үгүйсгэх үр дагавар, эсхүл зорилго бүхий хүйсээр

ялгаварлах, үгүйсгэн гадуурхах буюу хязгаарлахыг хэлнэ” (УИХ, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, 1979) гэж заасан.

ЭАБХУТК-д заасан заавал авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг цагдаагийн байгууллагаас хууль, эрх зүйн орчинд эмэгтэй алба хаагчдад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа байдал хангалтгүй байна. Зөвхөн ЦБҮАЖ-д ЭАБХУТК-оор үүрэг болгосон арга хэмжээг хэрхэн авах талаарх заалтууд журамлагдсан байна. Тодруулбал, уг журмын 922.5 дугаар зүйл (Ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамтад орсон талаар гомдлыг шалгах)-д ялгаварлан гадуурхалт болон бэлгийн дарамтад өртсөн алба хаагчдыг хамгаалах, тэдний гаргасан гомдлын дагуу ямар процессын ажиллагаа явуулж, хэрхэн шийдвэрлэх талаар дурдсаныг товч харуулъя: “Ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамтад орсон талаарх гомдлыг хүлээн авсан албан тушаалтан холбогдох шалгалтыг хийх явцдаа зүй бус байдал гаргасан алба хаагчийн ажлын орчинд бий болсон зохисгүй уур амьсгалыг арилгах, багасгах бодитой арга хэмжээг авна” (ЦЕГ, 2024, хууд. 922.5.1).

“Гомдлын дагуу албаны шалгалтыг ЦБҮАЖ-ын код 111-т заасан журмын дагуу явуулж, бэлгийн дарамтын талаарх гомдлыг хянан шийдвэрлэх явцад илэрсэн хувь хүнтэй холбоотой мэдээллийг хувийн нууц гэж үзэж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаална” (ЦЕГ, 2024, хууд. 922.5.2). “Алба хаагч, ажилтныг ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн талаар гомдол гаргасантай нь холбогдуулан хавчин гадуурхах, ажил албаны яриа өрнүүлэхгүй байх, хамтран ажиллахаас татгалзах зэрэг үйлдэл, эс үйлдэхүй гаргахыг хориглоно” (ЦЕГ, 2024, хууд. 922.5.3).

Эдгээр болон бусад заалтуудын хүрээнд алба хаагчдыг ялгаварлан гадуурхсан үйлдэл, эс үйлдэхүйг шалгаж байгаа боловч ямар хариуцлага тооцох талаар дурдаагүй нь ЭАБХУТК-д заасан “Эмэгтэйчүүдийг алагчлах аливаа үзлийг хориглосон зохих хууль тогтоомжийн болон бусад арга хэмжээ, шаардлагатай тохиолдолд шийтгэх арга хэмжээг батлах”, “Аливаа хүн, байгууллага буюу аж ахуйн нэгжийн зүгээс эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгахад чиглэсэн зохистой бүх арга хэмжээг авах” гэх заалтуудыг хэрэгжүүлээгүй гэж үзэх үндэстэй байна. Тиймээс хууль тогтоомжийг нэгдэн орсон гэрээ, конвенцын үзэл баримтлалд нийцүүлж өөрчлөх, тодруулбал, ЦБҮАЖ-д ялгаварлан гадуурхалт явуулсан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой журамлах хэрэгцээтэй.

Үндсэн хуулиас улбаалан гарсан ТАТХ, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хууль, ЦАТХ, ЦАХЁЗД зэрэг нь Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтооход чиглэсэн, цагдаагийн албаны үнэт зүйл, алба хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээ, шаардлагыг тодорхойлж, гэмт хэрэг, зөрчил, сахилга, ёс зүйн зөрчил үйлдэхээс сэргийлэх, хяналт тавих, ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг онцлог болон үндсэн шинжтэйгээс гадна ерөнхийлөн хэлбэл, ёс зүй, ёс суртахууныг төлөвшүүлэхэд чиглэсэн. Харин ХТХ, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль зэрэг нь хөдөлмөрийн харилцааг багцаар нь хангахад чиглэсэн.

Хөдөлмөрийн тухай хуульд ялгаварлан гадуурхалтай тэмцэх чиглэлийн үзэл баримтлал шингэсэн зүйл, заалтууд тусгагдсан. Тухайлбал, уг хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад

төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно" (УИХ, Хөдөлмөрийн тухай хууль , 2021) гэж заажээ. Уг заалт нь хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтаас ангид байдлыг хангах, нэгэнт үүссэн ялгаварлан гадуурхалтай тэмцэх гол хэрэгсэл юм.

Тэгэхээр цагдаагийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ялгаварлан гадуурхалтаас ангид байх, түүнийг зохицуулах чиглэлийн хууль тогтоомж, дүрэм, журам боломжийн хэмжээнд байгаа боловч тэдгээрийн хэрэгжилтийн байдал хангалттай бус байгаа болохыг зөвхөн ЦБЭАХ-д дунд явуулсан социологи судалгааны үр дүн тодорхой хэмжээгээр харуулж байгаа нь нэгийг бодогдуулж байна.

Дүгнэлт

1. Шат шатны цагдаагийн байгууллагын ажлын байран дахь эмэгтэй алба хаагчдыг ялгаварлан гадуурхах явдал ил болон далд хэлбэрээр оршин байгааг уг судалгааны үр дүн баталж байна. эмэгтэй алба хаагч албан тушаал ахиж дэвших боломж илүү хомс байгаа нь идэвхгүй хэлбэрийн ялгаварлан гадуурхалтад хамаарах боломжтой.

2. Цагдаагийн байгууллагад чадахуйн (мерит) зарчимд үндэслэн, алба хаагчдыг шударгаар албан тушаал ахиулах тогтолцоо нийт бие бүрэлдэхүүнд бүрэн хэрэгжихгүй байна. Тодруулбал, цагдаагийн алба хаагчийг албан тушаалд шатлан дэвшүүлэхэд чадахуйн (мерит) зарчмыг удирдлага болгох бодлого хэрэгжихгүйгээс гадна бусдыг өөрийн үзэмжээр, танил талаар албан тушаалд томилдог байдал цагдаагийн албанд түгээмэл байгаа нь чадахуйн (мерит) зарчмаар албан тушаал ахиулах тогтолцооны хэрэгжилтийн эрх зүйн орчин цагдаагийн байгууллагад хараахан бүрэлдэн тогтоогүй байна гэж дүгнэхэд хүргэлээ. Тодруулан авч үзвэл, цагдаагийн байгууллагад чадахуйн (мерит) зарчмын хэрэгжилт хангалтгүй, эмэгтэй алба хаагчдын албан тушаалд өөр алба хаагчийг мэдлэг, ур чадварыг нь харгалзалгүйгээр, өөрийн ойр дотны (хамаатан, найз болон бусад) хүнийг томилох зорилгоор эмэгтэй алба хаагчдыг ялгаварлан гадуурхах явдал бодит амьдралд цөөнгүй байгаа нь судалгаанаас ажиглагдаж байна.

3. Цагдаагийн алба хаагчийг албан тушаалд шатлан дэвшүүлэхэд хууль ёсонд суурилан, шударга ёс ба чадахуйн (мерит) зарчмыг баримталж, гаргасан шийдвэрийн үндэслэлийг бусад алба хаагчдад ил тодоор зарлах байдлаар явагддаг соёл тогтоох шаардлагатай байна.

4. Монгол Улсын Үндсэн хуульд заасан ялгаварлан гадуурхалтай тэмцэх чиглэлийн үзэл баримтлал ТАТХ, ЦАТХ, ЦБҮАЖ болон бусад баримт бичигт тодорхой бөгөөд хүртээмжтэй тусгагдсан боловч хуулийн үйлчлэл бодит амьдралд хангалтгүй байна. Мөн алба хаагчид иргэдийг ялгаварлан гадуурхахгүй байх орчин, нөхцөлийг сайжруулахад хуулийн заалтууд анхаарсан боловч цагдаагийн байгууллагын алба хаагчид бие биеэ ялгаварлан гадуурхах явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлийн заалт ЦБҮАЖ-ыг эс тооцвол бусад баримт бичигт тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн ЦБҮАЖ-д алба хаагчдын хоорондын ялгаварлан гадуурхалтай тэмцэх бодлого хэрэгжиж байна.

5. Алба хаагчдыг албан тушаалд томилох үндэслэл, журам хэтэрхий ерөнхий шинжтэй байгаагаас шалтгаалан алба хаагчдыг өөрийн үзэмжээр албан тушаал ахиулах явдал одоогийн байдлаар түгээмэл ажиглагдаж байх бөгөөд, цаашид ч энэ байдлаар үргэлжлэх хандлагатай байна.

Санал

1. Алба хаагчдыг үзэмжээр тушаал дэвшүүлэх байдлыг арилгаж, мерит зарчимд үндэслэсэн, шударга томилгоог хийгдэх боломжоор хангах зорилгоор ЦАТХ-ийн 79 дүгээр зүйлд албан тушаал дэвшүүлэх үндэслэлийг нэг бүрчлэн дурдах;

2. Цагдаагийн байгууллагын алба хаагчидтай холбоотой хууль тогтоомжийг нэгдэн орсон гэрээ, конвенцын үзэл баримтлалд нийцүүлж өөрчлөх, тодруулбал, ЦАТХ, эсхүл ЦБҮАЖ-д

ялгаварлан гадуурхалт явуулсан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох хэрэгцээтэй байна. Дотоодын хууль тогтоомжийг нэгдэн орсон гэрээ, конвенцын үзэл баримтлалд нийцүүлж өөрчлөх, тодруулбал, ЦБҮАЖ-д ялгаварлан гадуурхалт явуулсан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой журамлах;

3. Цагдаагийн алба хаагчийг албан тушаал дэвшүүлэхдээ хамт олны дунд нэр хүндтэй байх шаардлагыг ЦБҮАЖ-ын 908.4 (Албан тушаал шатлан дэвшүүлэх болзол, шаардлага)-д заасан шалгуураас хасах;

Эх сурвалжийн жагсаалт

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл. № 8 (Улсын их хурал 2011 оны 02 02). Гаргасан 2024 оны 12 10, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail/253.
2. Зөрчлийн тухай хууль. (2017 оны 05 11). *Legalinfo.mn.* Гаргасан 2025 оны 01 04, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail/12695.
3. Монгол Улсын Үндсэн хууль. (1992 оны 01 13). *Legalinfo.mn.* Гаргасан 2025 оны 01 03, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=367.
4. МУЕТГ, М. У. (2016). *Монгол хэлний их тайлбар толь*. Гаргасан 2024 оны 11 23, Монгол толь: https://mongoltoli.mn/dictionary/detail/138922.
5. ННФ, Н. н. (2021). *Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам хүний эрхэд нийцсэн байдал.* Улаанбаатар.
6. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль. (2023 оны 05 04). *Legalinfo.mn.* Гаргасан 2024 оны 12 11, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759635984401.
7. Төрийн албаны тухай хууль. (2017 оны 12 07). *Legalinfo.mn.* Гаргасан 2024 оны 12 10, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://www.legalinfo.mn/mn/detail/13025.
8. УИХ, У. И. (1979 оны 12 18). *Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц.* Гаргасан 2025 оны 01 12, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail/1285.
9. УИХ, У. И. (2021 оны 07 02). *Хөдөлмөрийн тухай хууль* . Гаргасан 2025 оны 01 11, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751.
10. Цагдаагийн албаны тухай хууль. (2017 оны 02 09). *Legalinfo.mn.* Гаргасан 2024 оны 11 25, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74.
11. ЦЕГ. (2024 оны 05 06). *Даргын тушаал. Дүрэм батлах тухай. Дугаар А/194.* Гаргасан 2024 оны 12 15, Цагдаагийн ерөнхий газар: https://police.gov.mn/resource/policenew/File/2024/05/08/c88xqbfpy5qymxq2/%D0%81%D1%81%20%D0%B7%D2%AF%D0%B9%D0%BD%20%D0%B4%D2%AF%D1%80%D1%8D%D0%BC.pdf.
12. ЦЕГ. (2024). *Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Зургаа дахь хэвлэл.* Улаанбаатар.
13. Цэвэл, Я. (2021). *Монгол хэлний товч тайлбар толь. Нэмж дэлгэрүүлсэн дөрөвдүгээр хэвлэл.* Улаанбаатар.
14. Эрүүгийн хууль. (2015 оны 12 03). *Legelinfo.mn.* Гаргасан 2025 оны 01 03, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail/11634.

ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ЗАН ТӨЛӨВИЙН ЗАРИМ ШИНЖИЙН СУДАЛГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

AN ANALYTICAL REVIEW OF SELECTED CHARACTERISTICS OF THE PERSONALITY TRAITS OF BORDER TROOPS PERSONNEL

Б.Нямжав*
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Тэргүүлэх судлаач, Доктор (Ph.D), хурандаа
Nyamjav B.
University of Internal Affairs, Research and Innovation Department, Research Institute Leading Researcher, Ph.D., Colonel

*Хариуцлагатай зохиогч: nyamjav0819@gmail.com

Хураангуй: Зан төлөв гэдэг нь тухайн хүнийг нийгмийн гишүүний хувьд бусад хүмүүсээс ялган тодруулж байгаа бие хүний нийгмийн үндсэн гол шинжүүдийн нийлбэр цогцуудыг илэрхийлдэг ухагдахуун юм. Энэ нь тухайн хүнд байгалиас заяасан, төрөлхийн зүйл биш, харин бүхий л амьдралын нийгэм, орчин, ахуйтайгаа идэвхтэй харьцсаны үр дүнд бүрэлдэн төлөвшдөг нийгэм сэтгэл зүйн онцгой шинж чанар юм. Зан төлөвийн шинжүүд нь ихэвчлэн хүүхэд насанд төлөвшиж, хүний амьдралын туршид хадгалагдан, харьцангуй тогтвортой илэрнэ. Хүний зан төлөв бүрэлдэн төлөвшихөд эцэг, эх, гэр бүл, хамт олон, хүмүүжил чухал нөлөө үзүүлдэг. Эрдэмтэд зан төлөв нь бие хүн нийгэмд, нийгмийн бусад гишүүдэд, өөртөө болон хүрээлэн буй байгаль, эд юмст хэрхэн хандаж байгаа харьцаагаар илэрдэг хэмээн үзсэн байна (Батсайхан & Дэлгэржав, 2013). Хүний зан төлөвийг мэднэ гэдэг нь хүний үйл хэрэгт тодорхой логиктой ба дотоод дараалалтайгаар илэрдэг гол чухал шинжийг мэднэ гэсэн үг юм.

Зан төлөв нь хүний тогтвортой онцлог шинж бөгөөд тухайн хүний ажил мэргэжил, хүрээлэн байгаа орчин, хүмүүст хандах хандлагыг илэрхийлэхээс гадна хүний аливаа үйл ажиллагаа, харилцааны явцад илэрч гарах боловч тухайн хүний зан үйлийн өвөрмөц, дахин давтагдашгүй шинж, онцлог өнгө аясыг өөртөө багтааж байдаг онцлогтой. Зан төлөв нь тухайн хүний сонирхон шимтдэг үйл ажиллагааны явцад нэлээд ил тод илэрдэг ба зарим хүмүүс асар их хүч хөдөлмөр, тэвчээр шаардсан хүнд хэцүү үйл ажиллагаа эрхлэхийг хичээдэг бол нөгөө хэсэг нь аль болохоор төвөг багатай, энгийн ажил төрлийг сонгож байдаг. Өөр нэг бүлэг хүмүүс ажил хөдөлмөрийн үр дүн, тэр нь бусад хүмүүсийнхээс хэр зэрэг илүү гарсан байдалд онцгой ач холбогдол өгч байдаг бол зарим нь бусадтай адилхан хэмжээнд ажиллаад л байхыг эрмэлздэг. Зарим хүн өөрийнх нь ажил хөдөлмөрийн үр дүн нь дундаж хэмжээнд юм уу түүнээс доогуур байхад тодийлөн ач холбогдол өгдөггүй (Санжжав, Д., & Бор, Б., 1990).

Abstract: Personality is a conceptual construct that represents the integrated system of fundamental socio-psychological characteristics distinguishing an individual from others as a member of society. Personality traits are not innate or biologically predetermined attributes; rather, they are socially and psychologically acquired characteristics formed through continuous interaction with the social environment, living conditions, and life experiences. Such traits are primarily developed during childhood and generally remain relatively stable throughout an individual's lifespan. The formation and development of personality are significantly influenced by parents, family upbringing, collective social environments, and educational processes. Scholars have argued that personality is manifested through an individual's attitudes and behavioral relationships toward society, other individuals, oneself, and the surrounding environment and material world (Batsaikhan & Delgerjav, 2013). Therefore, understanding an individual's personality implies understanding the essential characteristics that are expressed in a logical, internally structured, and consistent manner through human behavior and activities.

Personality constitutes a stable and enduring human characteristic that reflects an individual's attitudes toward professional duties, the surrounding environment, and interpersonal

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

relationships. Furthermore, it is expressed through various forms of activity and communication while simultaneously encompassing the unique, distinctive, and non-repetitive features of individual behavior. Personality traits become particularly evident in activities toward which individuals demonstrate strong interest and commitment. Some individuals tend to pursue challenging tasks requiring considerable effort, perseverance, and endurance, whereas others prefer simpler and less demanding forms of work. Another group places significant importance on achieving results superior to those of others, while some individuals are primarily motivated to perform at a level comparable to their peers. Conversely, certain individuals demonstrate limited concern even when the outcomes of their work remain at or below average standards (Sanjav & Bor, 1990).

Түлхүүр үг: Зан төлөв, зан төлөвийн зарим шинж, цэргийн алба хаагчид.

Keywords: Personality; personality traits; selected personality characteristics; military personnel; border troops personnel

Цэргийн сэтгэл зүйн шинжлэх ухааны судалгааны анхаарал татсан асуудлын тоонд цэргийн алба хаагчдын зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөн, сэтгэл зүйн хямрал, түүний үүсэх шалтгаан, сэтгэл зүйн хямралаас урьдчилан сэргийлэх арга замыг оновчтой, зөв тодорхойлох явдал зүй ёсоор багтдаг бөгөөд бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах асуудал нь сэтгэл зүйн бэлтгэлийн үндсэн зорилт юм. Алба хаагчдын зан төлөвийн зарим шинжийг судалснаар сэтгэл зүйн эдгээр хүчин зүйлс хилийн цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэх ажиллагаа, сэтгэл зүйн эрүүл мэнд, багаар ажиллах чадвар, удирдан зохион байгуулах, манлайлах чадварт эерэг нөлөөтэй төдийгүй цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдалд анхаарч дэмжлэг үзүүлэх, стрессийн зохицуулалтыг хангах, алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлжилтийн асуудлыг сайжруулахад хөрш зэргэлдээх болон гадны бусад орнуудын энэ чиглэлийн судалгаануудын ололттой тал, хөгжлийн чиг хандлага, туршлагыг харгалзан үзэж салбарын бодлого, удирдлагын түвшинд анхаарч ажиллах нь зүйтэй юм.

Цэргийн алба хаагчдын зан төлөвийн зарим шинжийг судалснаар ЦАХ-чидтай ажилладаг албан тушаалтнууд тухайн алба хаагчийн зан төлөвийн ялгаатай байдал, зан төлөвийн онцлогт нийцүүлэн хилд үүрэг гүйцэтгэх, хилийн харуул, манаанд томилогдон ажиллах бүлгийг томилохдоо ялгаатай байдлаар бүлгийн бүрэлдэхүүний сэтгэл зүйн тохиромжтой байдал, нэгдэл нягтралыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Хилийн цэргийн алба хаагчдын зан төлөвийн зарим шинжийн судалгааны үр дүнг тодруулж, дүн шинжилгээ хийх зорилготой судалгааны ажлыг гүйцэтгэн явуулж, судалгааны зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд алба хаагчдын нас, хүйс, албан тушаал, ажилласан жил, бүсийн онцлогтой харьцуулан улмаар зан төлөвийн зарим шинжийг тодруулж, судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Судалгааны товч үр дүн: Зан төлөвийн таван шинжийн илрэх байдлыг нарийвчлан авч үзвэл: Судалгаанд оролцсон цэргийн алба хаагчдын 62.6% экстраверт хандлагатай, 35.9% нейротизм шинжтэй, 49.7% ухамсарт шинжтэй, нийт бие бүрэлдэхүүний 87% бусадтай нийцтэй шинж хамгийн өндөр үзүүлэлттэй, шинэ туршлагад нээлттэй шинж 78%-тай илэрч байна. Энэ нь судалгаанд оролцогчдын хувьд *Бусадтай нийцтэй шинж* бусад үзүүлэлтүүдээс өндөр үзүүлэлттэй, *Нейротизм* шинж хамгийн бага үзүүлэлттэй байна. Зан төлөвийн 5 шинжийн дундаж утгаас харахад бусадтай нийцтэй шинжийн дундаж утга хамгийн их (34.98) байгаа бөгөөд түүний дараагаар шинэ туршлагад нээлттэй шинж, экстраверт шинж, ухамсартай шинжүүд эрэмбэлэгдсэн байна. Нейротизмийн онооны дундаж утга хамгийн бага (14.35) байна. Энэ нь мэдрэмтгий байдлыг илэрхийлэх ба сэтгэл хөдлөл ихтэй, амархан хувирдаг, стресстдэг, өөртөө итгэл багатай, аливаа шахалтад түрэмгий

байдлаар ханддаг, удирдагчийн зааврааp аливаа үйл ажиллагааг хийдэг, чухал шийдвэр гаргах дургүй, идэвх султай, гэх зэрэг онцлогуудаар илэрнэ гэж үздэг. Алба хаагчдын хувьд албаны стресс, түгшүүр, уур уцаар харьцангуй их байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Сэтгэл судлаачид зан төлөвийг тал бүрээс нь тайлбарлахыг оролдож байсаны дотор К.Юнг, Э.Кречмер, У.Шелдон нарын бие организмын онцлогтой холбон тайлбарласан онолууд түгэн тархсан. Сэтгэл судлалын ухааны хөгжлийн түүхийн явцад зан төлөвийн хэв шинжийг ялгах, ангилах оролдлого олонтоо хийгдсэнээс нэлээд түрүү үеийн, мэдэгдэхүйц үр дүнтэй, үндэслэлтэй болсон нь Немцийн сэтгэл зүйч Э.Кречмерийн ангилал гэж үздэг ба хэв шинж бүр өөр өөрийн гэсэн дахин давтагдашгүй зан төлөвийн онцлогтой хэмээн үзсэн.

Дээрх ангиллаас гадна нэлээд хожим Америкийн эрдэмтэн У.Шелдон зан төлөвийн сонирхолтой ангиллыг бий болгосон байдаг. Сүүлийн үед Э.Фромм, К.Леонгард, А.Личко нарын олон эрдэмтэд зан төлөвийн ангиллын өөр өөр хувилбаруудыг дэвшүүлсэн (Lecky, Prescott., 1961). Ийнхүү зан төлөвийн ангиллын талаарх эрдэмтдийн үзэл санаануудаас бие хүний шинжийн онолын гол төлөөлөгчид болох К.Юнгийн зан төлөвийн аналитик онол, Г.Оллпортын нийтлэг ба хувийн онцлог шинжийн онол, Р.Кеттелийн 16 хүчин зүйлийн онол, Х.Айзенкийн бие хүний зан төлөвийн онцлог шинжийн онол, зан төлөвийн интеракционист онол (Interactionist Theory of Personality), психодинамик онол, социодинамик онол, “Таван хүчин зүйлийн загварын онол” FFM (Five factor model) онолууд тус тус гарсан билээ.

Цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн онцлогийг албаны явцад харгалзан үзэж, цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах нь бүх шатны дарга, захирагч нараас сэтгэл зүйн ухааны мэдлэгийг шаардаж байна. Цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдал нь нийгмийн амьдралын хувьсал өөрчлөлт, цэргийн албаны аливаа хүндрэл, саад бэрхшээлийг даван туулахад чиглэгдсэн сэтгэл зүйн бэлтгэл, сэтгэл зүйн хангалтын системтэй үйл ажиллагааны үр дүнд анги, тусгай салбаруудын алба хаагчид, хамт олны сэтгэл зүйн тогтвортой байдлаар илэрхийлэгдэнэ. Сэтгэл зүйн тогтвортой байдал ямар нэг хэмжээгээр алдагдах нь цэргийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүйг анхаарах хэрэгтэй ба албанаас шантрах, зүрхшээх, улмаар зориг мохох, сэтгэлийн хөдлөлөө барьж чадахгүй байх, сэтгэлийн хөдөлгөөн хэт догдолж, гүйцэтгэж буй үүргийн анхаарал төвлөрөлтөд сөргөөр нөлөөлж, зөв хариу үйлдэл үзүүлэх чадваргүй болж, цагийн байдлыг зөв үнэлж, дүгнэх боломжгүй болно (Мягмаржав, Г., 2023).

Цэргийн сэтгэл зүйн судалгаанууд ихэвчлэн хүчтэй бүлэг гэдэг ойлголтын дэмжлэгтэй удирдагч байснаар эмгэгийн зан төлөвийн нөлөөллийг багасгахад тусалдаг гэдгийг нотолсон байдаг (Lester, P. B., Harms, P. D., Herian, M. N., Krasikova, D. V., & Beal, S. J., 2011). Удирдлагын зан төлөвийн онолууд цэргийн удирдагчдын үйл ажиллагаа болон хандлага гүйцэтгэх албан тушаалын цэргийн алба хаагчдын зан төлөвт хэрхэн нөлөөлдгийг онцолжээ. Жишээлбэл, хувиргалт удирдлагын онолын дагуу, хамтын үзэл бодлоор урам зориг өгч, урамшуулдаг удирдагчид өөрийн нэгжүүдэд илүү дасан зохицсон, ёс зүйтэй зан төлөвийг бүрдүүлдэг байна (Kark, R., Karazi-Presler, T., & Tubi, S., 2016).

Гадаадын орнуудын цэрэг, армийн хэмжээнд хийгдсэн судалгаануудаас зан төлөвтэй холбоотой судалгаануудаас үзэхэд:

Скоглунд, Т. Х., Брекке, Т. Х., Стедер, Ф. Б., & Боэ, О. (2020). “ Норвегийн тусгай хүчний алба хаагчдын зан төлөвийн шинжийн "Их тав" профайл” судалгаа нь Норвегийн цэргийн тусгай хүчний алба хаагчдын бие хүний шинжийг "Их тав" аргаар судалсан ба судалгааны үр дүнгээс залуу алба хаагчид ахмад насны алба хаагчдаас сэтгэл зүйн тогтвортой байдлын хувьд доогуур үнэлэгдсэн байна. Тус судалгаагаар цэргийн тусгай хүчний алба

хаагчдыг зан төлөвийн хувьд ижил төстэй хүмүүсийг сонгон шалгаруулдаг болохыг судалгаандаа дүгнэжээ (Skoglund, 2020).

-Юа, Д., Еэб, С., Мак, Х., & Янгд, Я нар "Шинэ цэргийн алба хаагчдын стресс ба сэтгэл зүйн эрүүл мэндийн хувьд гүйцэтгэх сэтгэл зүйн хатуужилтай байдлын үүрэг" сэдэвт судалгаагаар цэргүүдийн стрессийн түвшин тэдний сэтгэл зүйн эрүүл мэндэд нөлөөлж, сэтгэл зүйн уян хатан байдал нь энэ харилцааг зохицуулж байгааг судалгаагаар тогтоосон ба судалгааны үр дүнд сэтгэл зүйн уян хатан байдал нь цэргүүдийн сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх стрессийн нөлөөг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг тодруулжээ (Yua, D., Yeb, C., Mac, X., & Yangd, Y., 2023).

- Раиа, M. N. "Зан төлөвийн шинж нь офицеруудын албан тушаал ахихад хэрхэн нөлөөлдөг вэ? сэдэвт ажлаар АНУ-ын цэргийн офицеруудыг албан тушаалд дэвшүүлэхэд зан төлөвийн шинж хэрхэн нөлөөлдөгийг судалсан ба илэн далангүй, ухамсартай, гадуурхах, бусадтай нийцтэй шинж, нейротизм шинж гэсэн таван хүчин зүйлийн бие хүний зан төлөвийн загварт үндэслэсэн. Судалгааны үр дүнгээс харахад эелдэг зан төлөв нь албан тушаал ахихыг урьдчилан таамаглаж байсан байна. Статистикийн хувьд тийм ч ач холбогдолгүй ч албан тушаал ахисан офицеруудын дунд нейротитизм, нээлттэй байдал, гадуурхах зэрэг нь доогуур түвшинд илэрч, эелдэг байдал, ухамсартай байх хандлага өндөр байсан байна (Raia, 2024).

Сүүлийн үед манай улсын хэмжээнд цэргийн сэтгэл зүйг хөгжүүлэх үйл ажиллагаанд тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллагуудын сэтгэл зүйчид өөр өөрийн зүгээс судалгааны түвшинд оролцож, цэргийн албан хаагчдын ерөнхий сэтгэл зүйн бэлтгэлжилтийн талаар судалгаанууд хийгдэж байгаа бөгөөд Монгол Улсын төрийн цэргийн бодлого, Хилийн тухай хуулийн заалт, Хил хамгаалах байгууллагын гүйцэтгэж буй үүрэг зэргээс үндэслэнцэргийн сэтгэл зүйн ухааны судлах зүйл өргөжиж, судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ нэмэгдэж байна.

Тиймээс цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн хямрал, бие хүний онцлог, эерэг сөрөг сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөвийн онцлог шинж, албаны ачаалал болон стрессийг даван туулах чадвар, сэтгэлийн хат, зоригийн чанар зэрэг сэтгэл зүйн нарийвчилсан судалгаануудыг хийж, судалгааны үндсэн дээр тулгуурлан албанд болон практикт хэрэглэх аргачлал, зөвлөмж боловсруулж ашиглах шаардлагатай байна хэмээн үзэж байна.

Энэ удаад хилийн цэргийн алба хаагчдын зан төлөвийн зарим шинжийг судалсан.

Судалгаанд нийт Хилийн цэргийн 19 анги, тусгай салбарын 2490 алба хаагчийг хамруулснаас хүчингүй 12 судалгааны материалыг хасаж, 2478 алба хаагчийн судалгааны материал дээр үр дүнг боловсруулсан. Түүвэрлэлтийн найдвартай байдлыг хангаж, судалгаанд ХЦ-ийн бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулах үүднээс байнгын бүрэлдэхүүн болох офицер, ахлагчаас гадна гэрээт цэргийн алба хаагч (ГЦАХ), хугацаат цэргийн алба хаагч (ХЦАХ)-даас түүврийн хувилбарыг сонгож авсан.

Цэргийн алба хаагчдын зан төлөвийн зарим шинжийг судлах зорилгоор Л.Голдбергийн "Их тав" (BFI) сорилоор судалгаа авсан. Энэхүү бие хүний зан төлөвийг тодорхойлогч сорил нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн түгээмэл хэрэглэгддэг сорил бөгөөд зан төлөвийн таван шинжийг илрүүлж гаргадаг. Зан төлөвийн шинжүүд нь хоорондоо давхцаагүй шинж чанар, төрх байдлуудыг тус бүр агуулдаг. Эдгээр шинжүүд нь хоёр туйлт буюу нэг шинж дотроо хоёр эсрэг дэд шинжүүдийг багтаадаг бөгөөд арван төрлийн онцлог хэрхэн илэрч буйг тодорхойлдог аргачлал юм.

Хүснэгт 1. Зан төлөвийн сорилын Найдвартай байдлын шинжилгээ

Хүчин зүйл	Кронба альфа	Асуултын дугаар
Зан төлөвийн онцлог (Big Five)	0.975	50

Судалгааны найдвартай байдлыг үнэлэхийн тулд Кронбахын α (альфа) коэффициентийг тооцоолсон бөгөөд уг үзүүлэлт нь $0.7 < \alpha \leq 0.8$ гарсан. Энэхүү утга нь найдвартай байдлын хувьд "Сайн" түвшинд үнэлэгддэг.

Хүснэгт 3. Зан төлөвийн 5 шинжийн дундаж утгын үзүүлэлт

	N	Бага	Их	Дундаж	Ст.Хазайлт
Экстраверт	2478	0.00	40.00	25.03	7.52
Нейротизм	2478	0.00	40.00	14.35	7.76
Ухамсартай байдал	2478	0.00	40.00	19.87	8.23
Бусадтай нийцтэй байдал	2478	0.00	40.00	34.98	8.04
Шинэ туршлагад нээлттэй байдал	2478	0.00	40.00	31.19	7.43
Valid N (listwise)	2478				

Дескриптив шинжилгээнээс үзэхэд зан төлөвийн 5 шинжээс бусадтай нийцтэй шинж (34.98) онооны дундаж утга хамгийн өндөр байна. Харин нейротизм шинж (14.35) дундаж утга хамгийн бага байна.


Зураг 1. Судалгаанд оролцогчдын зан төлөвийн 5 шинжийн дундаж утгын үзүүлэлт



Судалгаанд оролцсон алба хаагчдын зан төлөвийн 5 шинжийн дундаж утгаас харахад бусадтай нийцтэй шинжийн дундаж утга хамгийн их (34.98) байгаа бөгөөд түүний дараагаар шинэ туршлагад нээлттэй шинж, экстраверт шинж, ухамсартай шинжүүд эрэмбэлэгдсэн байна. Энэ нь алба хаагчдад өөрийн үйлдэл, зан авираа бусдад тохируулан өөрчилдөг, багийн үйл ажиллагаанд тааламжтай ханддаг, бусдад хүлээцтэй ханддаг, аливаа зүйлийг эелдэг зөөлнөөр хардаг, бусдад тохиолдсон хүндрэлийг шийдэх чадвартай байгаа нь харагдлаа.

Нейротизмийн онооны дундаж утга хамгийн бага (14.35) байна. Энэ нь мэдрэмтгий байдлыг илэрхийлэх ба сэтгэл хөдлөл ихтэй, амархан хувирдаг, стресстдэг, өөртөө итгэл багатай, аливаа шахалтад түрэмгий байдлаар ханддаг, удирдагчийн зааврааар аливаа үйл ажиллагааг хийдэг, чухал шийдвэр гаргах дургүй, идэвх султай, гэх зэрэг онцлогуудаар илэрнэ гэж үздэг. Алба хаагчдын хувьд стресс, түгшүүр, уур уцаар харьцангуй их байгааг харуулж байна.

Зураг 2. Судалгаанд оролцогчдын зан төлөвийн дэд шинжийн үзүүлэлт (өндөр болон бага оноогоор)



Судалгаанд оролцсон алба хаагчдын зан төлөвийн шинжийг үзүүлэлт тус бүрээр өндөр оноо болон бага оноогоор ангилсан бөгөөд 5 шинжийг дэд шинж тус бүрээр илэрсэн байдлыг нарийвчлан авч үзлээ. Үүнд:

1. Экстраверт шинж: Судалгаанд оролцогчдын 29.8%-д экстраверт, 71.2%-д интроверт дэд шинж илэрсэн байна.

Өндөр оноотой тохиолдолд *Экстраверт* дэд шинж илэрнэ. Энэ нь нээлттэй, яриасаг, хүчтэй өрсөлдөгч байхаас гадна аливаа зүйлийг хурдтайгаар хийж дуусгадаг, нийгмийн идэвхтэй, өөрийн бодолтой бөгөөд урт хугацааны зорилгод туйлбаргүй гэх зэрэг онцлогууд илэрдэг.

Бага оноотой тохиолдолд *Интроверт* дэд шинж түлхүү илрэх ба судалгаанд оролцогчдын 71.2%-д интроверт дэд хэв шинж давамгай илэрсэн байна. Энэ нь ЦАХ-ын хувьд ганцаараа бие дааж ажиллах дуртай, урт хугацааны зорилгуудад анхаарлаа хандуулдаг, тайван орчныг эрхэмлэдэг, багийн үйл ажиллагаанд дуртай оролцдог, бусад хүмүүс санал тавьснаар ярьж эхэлдэг гэх зэрэг онцлог чанарууд давамгай байгаа нь харагдаж байна.

2. Нейротизмийн шинж: Судалгаанд оролцогчдын 91.4%-д Мэдрэмтгий, 9.6%-д Активист дэд шинжүүд илэрсэн байна. Нейротизмын хувьд:

Өндөр оноо авсан тохиолдолд *Мэдрэмтгий* дэд шинж илэрнэ гэж үзнэ. Энэ нь судалгаанд оролцогчдын 91,4%-д илэрсэн нь алба хаагчдын хувьд сэтгэл хөдлөл ихтэй, амархан хувирдаг, стресстдэг, өөртөө итгэх итгэл багатай, аливаа шахалтад түрэмгий байдлаар ханддаг, удирдагчийн зааврааар аливаа үйл ажиллагааг хийдэг зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийн онцлог шинжүүд харьцангуй их байгаа нь харагдаж байна.

Бага оноо авсан тохиолдолд *Активист* дэд шинж илэрнэ. Алба хаагчдын хувьд тус дэд шинж маш бага хувьтай илэрсэн. Энэ нь ямар нэгэн дарамт, шахалтад тайван байж чаддаг, өөртөө итгэх итгэл өндөр, шийдэмгий, өөдрөг, аливаа зүйлийг удирдан явуулж байгаадаа сэтгэл хангалуун байдаг, өндөр эрмэлзэлтэй зэрэг онцлогууд илэрч байгааг харуулж байна.

Ухамсартай шинж: Судалгаанд оролцогчдын 94.7%-д Нягт нямбай, 5.3%-д Зохион байгуулалтгүй дэд шинж илэрсэн.

Өндөр оноотой байх нь *Нягт нямбай* дэд шинж илэрнэ гэж үзнэ. Энэ нь ажилдаа нарийн зохион байгуулалттай ханддаг, аливаа зүйлсийг чанартай хийхэд анхаарлаа хандуулдаг, урьдаас төлөвлөж хийдэг, итгэл даахуйц, үүрэг хариуцлагаа хүлээдэг,

хийсэн ажлынхаа эцсийг үзэх дуртай байдаг гэх зэрэг онцлогуудаар илэрнэ. Судалгаанд оролцогчдын хувьд тус дэд шинж өндөр хувьтай илэрсэн нь харагдаж байна.

Бага оноотой тохиолдолд *Зохион байгуулалтгүй* дэд шинж илрэх ба ЦАХ-ын хувьд аливаа ажлыг хийх тогтсон өөрийн журам байдаггүй, олон зүйлд хүчээ сорьж байдаг, эмх цэгцгүй, заримдаа худлаа ярихаас буцахгүй гэх зэрэг онцлогууд бага хувьтай илэрсэн байна.

3. Бусадтай нийцтэй шинж: Судалгаанд оролцогчдын 12.5%-д Уян хатан, 88.5%-д Үзэл бодолдоо тууштай дэд шинжүүд илэрсэн байна.

Өндөр оноо авсан тохиолдолд *Уян хатан, нийцтэй* дэд шинж давуу илэрнэ гэж үзэх бөгөөд судалгаанд оролцогчдын 88,5%-д энэ шинж илэрсэн нь алба хаагчид өөрийн үйлдэл, зан авираа бусдад тохируулан өөрчилдөг, багийн үйл ажиллагаанд тааламжтай ханддаг, бусдад хүлээцтэй ханддаг, аливаа зүйлийг эелдэг зөөлнөөр хардаг, бусдад тохиолдсон хүндрэлийг шийдэх чадвартай байгааг харуулж байна.

Бага оноо авсан тохиолдолд *Үзэл бодолдоо тууштай* дэд шинж илэрнэ гэж үзэх бөгөөд энэ нь өөртөө итгэлтэй, багаар ажиллах чадвар сул, зорилгодоо хүрэхийн тулд тууштай хичээн зүтгэдэг, учирч буй бэрхшээлийг удирдан зохицуулдаг, бусдад захирангуй ханддаг гэх мэт онцлогуудыг харуулдаг.


4. Шинэ туршлагад нээлттэй шинж: Судалгаанд оролцогчдын 1.5%-д Идеалист дэд шинж, 98.5%-д Консерватив дэд шинж илэрсэн байна.

Өндөр оноотой тохиолдолд *Идеалист* дэд шинж илрэх бөгөөд энэ нь өөрийгөө сорьж шалгах дуртай, оюунлаг зүйлсэд эрмэлзэлтэй, мөрөөдөмтгий зантай, эрсдэлийг даах чадвартай удирдагч байдаг, олон төрлийн хоббитой, асуудлыг шийдвэрлэх бүтээлч сэтгэхүйтэй байдаг гэх зэрэг онцлогууд илэрнэ.

Бага оноотой тохиолдолд *Консерватив* дэд шинж давуу илэрдэг. ЦАХ-ын хувьд үйл явц, дүрмийг чанд сахидаг, эрсдлээс зайлсхийж өөрчлөлтөд болгоомжтой ханддаг, шинэ зүйлийг бий болгохоос илүү дасан зохицохдоо амархан, заавар болон удирдлагыг зөрчдөггүй гэх зэрэг онцлогууд давуу илэрч байгааг харуулж байна.

Зан төлөвийн таван шинжийн дэд шинжүүдийн илэрсэн байдлыг графикаар үзүүлбэл:

Зураг 3. Зан төлөвийн 5 шинжийн дэд шинжийн үзүүлэлт



Судалгаанд оролцсон алба хаагчдын зан төлөвийн дэд шинжүүдийн илэрсэн байдлаас харахад:

1.Экстраверт шинжийн *Интроверт* дэд шинж нь алба хаагчдын 71.2%-д илэрсэн нь дотогш чиглэсэн хэв шинж давамгайлсан ба энэ нь ганцаараа бие дааж ажиллах дуртай, урт хугацааны зорилгуудад анхаарлаа хандуулдаг онцлогтойг харуулж байна.

2.Нейротизмийн шинжийн *Мэдрэмтгий* дэд шинж хамгийн их буюу алба хаагчдын 91.4%-д илэрсэн нь хувьд сэтгэл хөдлөл ихтэй, амархан хувирдаг, стресстдэг, өөртөө итгэх итгэл багатай, аливаа шахалтад түрэмгий байдлаар ханддаг, удирдагчийн зааврааар аливаа үйл ажиллагааг хийдэг зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийн онцлог шинжүүд байгааг харуулж байна.

3.Ухамсартай шинжийн *Нягт нямбай* дэд шинж 94.7%-д илэрсэн нь алба хаагчдын хувьд нарийн зохион байгуулалттай, төлөвлөж хийдэг, итгэл даахуйц, үүрэг хариуцлагаа хүлээдэг онцлогтойг харуулж байна.

4.Бусадтай нийцтэй шинжийн *Узэл бодолдоо туушатай* дэд шинж 88.5%-д илэрсэн нь зорилгодоо хүрэхийн тулд тууштай хичээн зүтгэдэг, учирч буй бэрхшээлийг удирдан зохицуулдаг чадвартай байгаа нь харагдаж байна.

5.Шинэ туршлагад нээлттэй шинжийн хувьд *Консерватив* дэд шинж нь 98.5%-д илэрсэн нь дүрэм журмыг чанд сахидаг, эрсдэлээс зайлсхийж өөрчлөлтөд болгоомжтой ханддаг, заавар болон удирдлагыг зөрчдөггүй гэх онцлогууд зонхилон илэрсэн байгааг харж болно.

Бид судалгаанд оролцогчдын зан төлөвийн 5 шинжийг хүн ам зүйн хүчин зүйлс болох нас, хүйс, боловсрол, ажилласан жил, албан тушаал, бүс нутагтай харьцуулж үзлээ.

Хүснэгт 4. Экстраверт шинж ба хүн ам зүйн харьцуулсан шинжилгээ

		Экстраверт		Total
		Өндөр	Бага	
Бүрэлдэхүүн	Офицер	90	396	486
		18.50%	81.50%	100.00%
	Ахлагч	175	432	607
		28.80%	71.20%	100.00%
	Гэрээт	86	154	240
		35.80%	64.20%	100.00%
	ХЦАХ	388	755	1143
		33.90%	66.10%	100.00%

Экстраверт шинжийн хувьд: Офицерын бүрэлдэхүүний 81,5% интроверт, гэрээт болон ХЦАХ-ын 34-36% экстраверт шинж өндөр илэрсэн байна. Тэдний хувьд нээлттэй, ярианд, хүчтэй өрсөлдөгч байхаас гадна аливаа зүйлийг хурдтайгаар хийж дуусгадаг, нийгмийн идэвхтэй, өөрийн бодолтой бөгөөд урт хугацааны зорилгод туйлбаргүй гэх зэрэг онцлог чанарууд давамгай байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 5. Нейротизм ба хүн ам зүйн харьцуулсан шинжилгээ

		Нейротизм		Total
		Өндөр	Бага	
Нас	18-25	1501	9	1510
		99.4%	.6%	100.0%
	26-35	557	5	562
		99.1%	.9%	100.0%
	36-45	376	0	376
		100.0%	0.0%	100.0%
	46-с дээш	28	0	28
		100.0%	0.0%	100.0%
Боловсрол	Дээд	705	3	708
		99.6%	.4%	100.0%
	Тусгай дунд	685	4	689
		99.4%	.6%	100.0%
	Бүрэн дунд	1072	7	1079
		99.4%	.6%	100.0%
Бүрэлдэхүүн	Офицер	485	1	486
		99.8%	.2%	100.0%
	Ахлагч	603	4	607
		99.3%	.7%	100.0%
	Гэрээт	236	4	240
		98.3%	1.7%	100.0%
	ХЦАХ	1138	5	1143
		99.6%	.4%	100.0%
Албан тушаал	Удирдах	205	1	206
		99.5%	.5%	100.0%
	Гүйцэтгэх	2257	13	2270
		99.4%	.6%	100.0%

Нейротизмийн шинжийн хувьд: Дээд боловсролтой, 35-аас дээш насны удирдах албан тушаалын, төвийн бүсийн офицерын бүрэлдэхүүний хувьд өндөр оноотой *Мэдрэмтгий* дэд шинж харьцангуй их илэрсэн. Энэ нь ЦАХ-ын хувьд сэтгэл хөдлөл ихтэй, амархан стресстдэг, өөртөө итгэх итгэл багатай, аливаа шахалтад түрэмгий байдлаар ханддаг удирдагчийн зааврааар аливаа үйл ажиллагааг хийдэг зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийн онцлог шинжүүд илэрсэн байна. Сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдал их хүмүүс стресст илүү ихээр автдаг бөгөөд ердийн нөхцөл байдлыг ч заналхийлэл, бухимдал үүсгэх хандлагаар хүлээн авах хандлагатай бөгөөд тэд ихэвчлэн аливаад санаа зовомтгой байдаг бөгөөд өөрийн хүслээ хянах, зорилгодоо хүрэх тал дээр асуудалтай тулгардаг.

Харин 18-25 насны, гүйцэтгэх албан тушаалын, уулын бүсийн ХЦАХ-ын хувьд нейротизмийн шинж бага оноотой илэрсэн ба тэдний хувьд ямар нэгэн дарамт, шахалтад тайван байж чаддаг, өөртөө итгэх итгэл өндөр, шийдэмгий, өөдрөг, аливаа зүйлийг удирдан явуулж байгаадаа сэтгэл хангалуун байдаг, өндөр эрмэлзэлтэй зэрэг онцлогууд илэрч байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Ухамсартай шинж ба хүн ам зүйн харьцуулсан шинжилгээ

		Ухамсарт байдал		Total
		Бага	Өндөр	
Нас	18-25	6	1504	1510
		.4%	99.6%	100.0%
	26-35	1	561	562
		.2%	99.8%	100.0%
	36-45	0	376	376
		0.0%	100.0%	100.0%
	46-с дээш	0	28	28
		0.0%	100.0%	100.0%
Хүйс	Эрэгтэй	7	2082	2089
		.3%	99.7%	100.0%
	Эмэгтэй	0	387	387
		0.0%	100.0%	100.0%
Боловсрол	Дээд	0	708	708
		0.0%	100.0%	100.0%
	Тусгай дунд	2	687	689
		.3%	99.7%	100.0%
	Бүрэн дунд	5	1074	1079
		.5%	99.5%	100.0%
Бүрэлдэхүүн	Офицер	0	486	486
		0.0%	100.0%	100.0%
	Ахлагч	1	606	607
		.2%	99.8%	100.0%
	Гэрээт	2	238	240
		.8%	99.2%	100.0%
	ХЦАХ	4	1139	1143
		.3%	99.7%	100.0%
Албан тушаал	Удирдах	0	206	206
		0.0%	100.0%	100.0%
	Гүйцэтгэх	7	2263	2270
		.3%	99.7%	100.0%
Ажилласан жил	1-10	5	1583	1588
		.3%	99.7%	100.0%
	11-20	0	785	785
		0.0%	100.0%	100.0%
	21-с дээш	1	53	54
		1.9%	98.1%	100.0%

Ухамсартай шинжийн хувьд: нийт бүрэлдэхүүний хувьд нягт нямбай дэд шинж давамгай илэрсэн ба энэ нь алба хаагчдын хувьд зорилгодоо хүрэхийн тулд тууштай хичээн зүтгэдэг, бэрхшээлийг даван туулах чадвар сайн, өөрийгөө хянах чадвар өндөр, сахилга баттай, зохион байгуулалттай, хариуцлагатай шинжүүд түлхүү илэрч байгааг харуулж байна.

Харин ХЦАХ-ын хувьд зохион байгуулалтгүй дэд шинж илэрсэн нь аливаа ажлыг хийх тогтсон өөрийн журам байдаггүй, олон зүйлд хүчээ сорьж байдаг, эмх цэгцгүй, заримдаа худлаа ярихаас буцахгүй зэрэг онцлогууд илэрдэг болохыг харуулж байна.

Хүснэгт 7. Бусадтай нийцтэй шинж ба хүн ам зүйн харьцуулсан шинжилгээ

		Бусадтай нийцтэй байдал		
		Өндөр	Бага	Total
Нас	18-25	211	1299	1510
		14.0%	86.0%	100.0%
	26-35	57	505	562
		10.1%	89.9%	100.0%
	36-45	39	337	376
		10.4%	89.6%	100.0%
	46-с дээш	2	26	28
		7.1%	92.9%	100.0%
Хүйс	Эрэгтэй	280	1809	2089
		13.4%	86.6%	100.0%
	Эмэгтэй	29	358	387
		7.5%	92.5%	100.0%
Боловсрол	Дээд	49	659	708
		6.9%	93.1%	100.0%
	Тусгай дунд	103	586	689
		14.9%	85.1%	100.0%
	Бүрэн дунд	157	922	1079
		14.6%	85.4%	100.0%
Албан тушаал	Удирдах	22	184	206
		10.7%	89.3%	100.0%
	Гүйцэтгэх	287	1983	2270
		12.6%	87.4%	100.0%

Бусадтай нийцтэй шинжийн хувьд: 18-25 насны, эрэгтэй, бүрэн дунд болон тусгай дунд боловсролтой, гүйцэтгэх албан тушаалын гэрээт болон ХЦАХ өндөр оноотой үзүүлэлттэй байна. Энэ нь өөрийн үйлдэл, зан авираа бусдад тохируулан өөрчилдөг, багийн үйл ажиллагаанд тааламжтай ханддаг, бусдад хүлээцтэй ханддаг, аливаа зүйлийг эелдэг зөөлнөөр хардаг, бусдад тохиолдсон хүндрэлийг шийдэх чадвартай байгааг харуулж байна.

Эмэгтэй алба хаагчдын бусадтай нийцтэй шинж эрэгтэй алба хаагчдаас өндөр үзүүлэлттэй байна. Энэ нь эмэгтэйчүүд илүү эелдэг зөөлөн сэтгэлтэй, хамтран ажиллахад хялбар, хүлээцтэй, даруу, итгэлтэй, үнэнч гэх мэт онцлог шинж чанарууд түлхүү ажиглагддаг болохыг харуулж байна. Бусадтай нийцтэй хүмүүс аливаа нийгмийн харилцаанд бусдын сэтгэл хөдлөлийг мэдрэх чадвартай ба хариу үзүүлэх зөв хандлагатай болох нь судалгаагаар тогтоосон байна. Үүнийг тухайн хүний бие физиологийн өөрчлөлтүүд дээр үндэслэн дүгнэсэн бөгөөд экстраверт шинж ба сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдлаас гадна сэтгэл хөдлөлөө хянах чадварт нөлөөлдөг онцлог нь бусадтай нийцтэй байх чадвар гэдгийг тогтоосон байна. Энэ нөлөө ялангуяа эмэгтэйчүүдэд илт давуу ажиглагдсан төдийгүй бусадтай нийцтэй хүмүүс зөрчил маргаантай нөхцөл байдалд уур уцаар зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийг хянах чадвартай байдгаараа онцлог байдаг байна.

Хүснэгт 8. Шинэ туршлагад нээлттэй шинж ба хүн ам зүйн харьцуулсан шинжилгээ

		Шинэ туршлагад нээлттэй байдал		
		Өндөр	Бага	Total
Нас	18-25	28	1482	1510
		1.9%	98.1%	100.0%
	26-35	6	556	562
		1.1%	98.9%	100.0%
	36-45	3	373	376
		.8%	99.2%	100.0%
	46-с дээш	0	28	28
		0.0%	100.0%	100.0%
Хүйс	Эрэгтэй	34	2055	2089
		1.6%	98.4%	100.0%
	Эмэгтэй	3	384	387
		.8%	99.2%	100.0%
Боловсрол	Дээд	10	698	708
		1.4%	98.6%	100.0%
	Тусгай дунд	12	677	689
		1.7%	98.3%	100.0%
	Бүрэн дунд	15	1064	1079
		1.4%	98.6%	100.0%
Бүрэлдэхүүн	Офицер	10	476	486
		2.1%	97.9%	100.0%
	Ахлагч	0	607	607
		0.0%	100.0%	100.0%
	Гэрээт	0	240	240
		0.0%	100.0%	100.0%
	ХЦАХ	27	1116	1143
		2.4%	97.6%	100.0%
Албан тушаал	Удирдах	7	199	206
		3.4%	96.6%	100.0%
	Гүйцэтгэх	30	2240	2270
		1.3%	98.7%	100.0%
Ажилласан жил	1-10	30	1558	1588
		1.9%	98.1%	100.0%
	11-20	7	778	785
		.9%	99.1%	100.0%
	21-с дээш	0	54	54
		0.0%	100.0%	100.0%
Total		37	2439	2476
		1.5%	98.5%	100.0%

Шинэ туршлагад нээлттэй шинжийн хувьд: 18-25 насны, тусгай дунд боловсролтой, хугацаат цэргийн албан хаагчид өндөр онооны үзүүлэлттэй гарсан байна. Энэ нь өөрийгөө сорьж шалгах дуртай, оюунлаг зүйлсэд эрмэлзэлтэй, мөрөөдөмтгий зантай, эрсдэлийг даах чадвартай, олон төрлийн хоббитой, асуудлыг шийдвэрлэх бүтээлч сэтгэхүйтэй байдаг гэх зэрэг онцлогууд илэрдэг.

Харин 46-аас дээш насны, 21-ээс дээш жил ажиллаж байгаа, бүрэн дунд боловсролтой, гүйцэтгэх албан тушаалтнууд буюу ГЦАХ болон ахлагчийн бүрэлдэхүүн бага оноо авсан үзүүлэлттэй байгаа нь үйл явц, дүрэм журмыг чанд сахидаг, эрсдэлээс зайлсхийж өөрчлөлтөд

болгоомжтой ханддаг, шинэ зүйлийг бий болгохоос илүү дасан зохицохдоо амархан, хуучинсаг хандлагатай, заавар болон удирдлагыг зөрчдөггүй гэх зэрэг онцлогууд илэрч байгааг харуулж байна.

Судалгаанд оролцсон алба хаагчдын зан төлөвийн шинж болон хүн ам зүйн хүчин зүйлийн корреляцийн шинжилгээнээс харахад:

Хүснэгт 9. Зан төлөвийн шинж, хүн ам зүйн хүчин зүйлийн корреляцийн шинжилгээ

	Экстраверт	Нейротизм	Ухамсартай шинж	Бусадтай нийцтэй шинж	Шинэ туршлагад нээлттэй шинж
Боловсрол	-.141**	-0.012	-0.036	-.090**	0.002
	0.000	0.542	0.074	0.000	0.914
Бүрэлдэхүүн	-.119**	-0.007	-0.027	-.086**	-0.037
	0.000	0.745	0.185	0.000	0.064
Албан тушаал	.065**	-0.003	-0.016	-0.016	.047*
	0.001	0.873	0.425	0.414	0.019
Ажилласан жил	.054**	-0.002	0.019	0.016	0.034
	0.007	0.912	0.345	0.422	0.094

**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

- Экстраверт шинж боловсролтой (R=-0.141** буюу P утга 0.000) сөрөг сул хамааралтай, бүрэлдэхүүнтэй (R=-0.119** буюу P утга нь 0.000) сөрөг сул, албан тушаал, ажилласан жилтэй (R=0.065** буюу P утга 0.001) эерэг сул хамааралтай байна.

Боловсролын түвшин экстраверт шинжийг голчлон тодорхойлох хүчин зүйл биш бөгөөд хамаарал ч сөрөг сул гарсан байна. Цэргийн албаны онцлог нь тухайн алба хаагчаас багийн ажиллагаа, харилцааны өндөр ур чадвар шаарддаг, эрхэлж буй ажил, албан тушаалын хариуцлагын хүрээнд бусадтай харилцах, ажил байдлаа ойлгуулах зэрэг ажлын харилцаанаас үүдэн экстраверт зан төлөвтэй байх шаардлага тулгардаг тул алба хаагчдын хувьд өөрсдийгөө энэ чиглэлээр хөгжүүлсэн байж болох талтай гэж дүгнэж байна.

- Нейротизмийн шинж, ухамсартай шинж, шинэ туршлагад нээлттэй шинж хүн ам зүйн хүчин зүйлстэй хамаарал байхгүй байна.

- Бусадтай нийцтэй шинж боловсролтой (R=-0.090** буюу P утга 0.000) сөрөг сул хамааралтай, бүрэлдэхүүнтэй (R=-0.086** буюу P утга 0.000) мөн сөрөг сул хамааралтай байгаа нь боловсролын түвшин болон бүрэлдэхүүн буюу офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч байхаас үл хамааран нөлөө үзүүлэхгүй болохыг илтгэж байна.

Ийнхүү корреляци шинжилгээнээс дүгнэхэд зан төлөвийн шинжүүд хүн ам зүйн хүчин зүйлстэй төдийлөн хамааралгүй болохыг харуулж байна.

Дүгнэлт

Цэргийн алба хаагчдын зан төлөвийн зарим шинжийг “Их тав” аргаар судалж, дескриптив шинжилгээ хийж үзэхэд зан төлөвийн 5 шинжээс бусадтай нийцтэй байдлын дундаж утга (34.98) хамгийн өндөр харин нейротизмийн дундаж утга (14.35) хамгийн бага байна.

- Зан төлөвийн таван шинжийн давтамжийн шинжилгээгээр судалгаанд оролцогчдын 62.6% нь экстраверт хандлагатай, 35.9% нь нейротизмийн шинжтэй, 49.7% нь ухамсартай шинжтэй, нийт судалгаанд оролцогчдын 87% нь бусадтай нийцтэй шинж хамгийн өндөр үзүүлэлттэй, шинэ туршлагад нээлттэй шинж 78%-тай илэрч байна. Энэ нь судалгаанд оролцогчдын хувьд зан төлөвийн бусадтай нийцтэй шинж бусад үзүүлэлтүүдээс өндөр үзүүлэлттэй, нейротизмийн шинж хамгийн бага үзүүлэлттэй байна.

- Судалгаанд оролцсон алба хаагчдын зан төлөвийн шинжийн дэд шинжүүдийн

илрэх байдлыг авч үзэхэд: ЦАХ-ын 71.2% Экстраверт шинжийн Интроверт дэд шинж, 91.4% Нейротизмийн шинжийн Мэдрэмтгий дэд шинж, 94.7% Ухамсартай шинжийн Нягт нямбай дэд шинж, 88.5% Бусадтай нийцтэй шинжийн Үзэл бодолдоо тууштай дэд шинж, 98.5% Шинэ туршлагад нээлттэй шинжийн Консерватив дэд шинж тус тус илэрсэн байна.

- Зан төлөвийн шинжийг хүн ам зүйн хүчин зүйлтэй харьцуулж корреляцийн шинжилгээ үзэхэд төдийлөн хамааралгүй байна.

Зөвлөмж

Хилийн цэргийн алба хаагчдын зан төлөвийн зарим шинжийг судалсан судалгааны үр дүнд тулгуурлан цэргийн алба хаагчидтай ажилладаг удирдах албан тушаалтнууд болон цэргийн сэтгэл зүйчдэд зориулан дараах зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

- Сэтгэл зүйн үнэлгээг сайжруулах зорилгоор цэргийн албанд шинээр татагдан ирсэн ХЦАХ болон ГЦАХ-аас зан төлөвийг үнэлэх сорил авч, тухайн алба хаагчийн сэтгэл зүйн тогтворгүй байдлыг багасгах, эерэг зан төлөвийг хөгжүүлэх чиглэлээр алба хаах хугацаанд нь хамруулж, үе шаттай үнэлгээ хийх;
- Нейротизмийн шинж өндөр, сэтгэл зүйн тогтворгүй байдалтай алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэхээс гадна сэтгэл зүйн асуудал тулгарсан үед зөвлөгөө, тусламжийг цаг алдахгүй өгөх, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах;
- Сэтгэл зүйн тогтворгүй байдлын улмаас сэтгэл зүйн асуудалтай, өндөр түвшний стресстэй алба хаагчдыг ганцаараа амрах, тайвшрах боломжоор хангасан амрах орчинг бүрдүүлэх, алба хаагчдын албанаас үүдэлтэй стресс, бухимдлыг цаг алдахгүй бууруулж ажиллахад анхаарах нь гэмт хэрэг, сахилгын зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх эерэг үр дүнтэйг харгалзан үзэх;
- Сэтгэлзүйн хувьд тогтворгүй хэв шинжийн бүлэгт хамрагдаж буй халба хаагчдад сэтгэлзүйн зөвлөгөөнөөс гадна сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн багийг сургаж бэлтгэх, энэ чиглэлийг үйлчилгээг албанд нэвтрүүлэх;
- Сэтгэл зүйн зөвлөгөөг алба хаагчдад илүү хүртээмжтэй байх боломжийг сайжруулж, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх, хилийн застав, харуулд онлайн цахим зөвлөгөө, бүлгийн зөвлөгөөг өргөнөөр ашиглах;
- Цэргийн алба хаагчдын эерэг зан төлөвийг хөгжүүлэх, стресс менежментийг сайжруулах, алба хаагчдад өөрсдийгөө хөгжүүлэх боломжийг олгох үүднээс сургалтын платформууд, ном, гарын авлага зэрэг нэмэлт хувилбаруудыг боловсруулан албанд ашиглах.
- Цэргийн алба хаагчдын зан төлөвийн онцлог шинжийг тодорхойлох олон улсад түгээмэл хэрэглэгддэг хил хамгаалах байгууллагын алба хаагчдын мэргэжлийн онцлогт тохирсон, баталгаат болон тохироц чанарын шаардлага хангасан тус арга, аргачлалаар түүврийн цар хүрээг нэмэгдүүлэн судлах зэрэг зөвлөмжүүдийг санал болгож байна.

Ашигласан эх сурвалж:

Нэг. Монгол хэл дээр:

Б.Батсайхан, М.Дэлгэржав, (2013). *Ерөнхий сэтгэл судлал.* Улаанбаатар хот: Соёмбо принтинг ХХК.

Б.Батсайхан, М.Дэлгэржав, (2013). *Сэтгэл судлалын бага тайлбар толь.* Улаанбаатар хот: Соёмбо принтинг.

С.Гүржав, (2002). *Цэргийн хамт олон, ёс суртахуун сэтгэл зүйн ажлын зарим арга хэлбэрүүд.* Улаанбаатар хот.

Ж.Даваарагчаа, (2005). *Цэргийн мэргэжлийн удирдлагын шийдвэрт хамт олны нийгэм сэтгэл зүйн хүчин зүйлийг харгалзан үзэх нь.* Улаанбаатар хот.

Г.Давгажамц, (2002). *Монгол Улсын хил хамгаалах албаны ёс суртахуун сэтгэл зүйн хангалт.* Улаанбаатар хот: Хилийн цэргийн хэвлэх үйлдвэр.

О.Мягмар, (2001), (2002). *Сэтгэл судлал.* Улаанбаатар хот.

О.Мягмар, (2012). *Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд.* Улаанбаатар хот: Соёмбо принтинг.

Г.Мягмаржав, (2023). *Цэргийн сэтгэл зүй, ёс суртахууны хангалт.* БХИС-ийн хэвлэлийн үйлдвэр. Улаанбаатар хот.

П.Цэрэндондов, (2013). *Сэтгэл судлалын судалгааны арга зүй*. Улаанбаатар хот.

Хоёр. Орос хэл дээр:

Андреев, В.А., (1998). *Социальная нейропсихология.* Москва: Издательство Гуманитарая Академия.

Леонтов, А.Н., (2003). *Современная психология.*

Светлана Викторовна Забегалина. (2022). *Психологическое состояние военнослужаших в период их адаптации.* Психопедагогика в правоохранительных органах , 666-107.

Гурав. Англи хэл дээр:

Aguilar, S. &. (2019). *A review of the linkages between emotional intelligence and leadership in the military forces*, pp. Business Ethics and Leadership, 3(2), 29–38.

Allport, G. W. (1960). *Personality: A psychological interpretation.* New York: H.Holt and. Company.

Allport, Gordon. (1957). *Consepts of Trait and Personality.*

Bartone, P. T. (2002). Cognitive and personality predictors of leader performance in the U.S. Army. *Military Psychology,*, 14(4), 321–338.

Bech, S. C., Dammeyer, J., & Liu, J. (2021). "Changes in personality traits among candidates for special operations forces". *Military psychology 33(3)*, 197-204.

Burney, S. (2016). *Personality, well-being, and military service.* USA: The university of rockies.

Costa, P. T., & McCrae, R. R. (1992). *Revised NEO Personality Inventory.*

Costa, P. T., & McCrae, R. R. (1992). The five-factor model of personality and its relevance to personality disorders.

Digman, J. M. (1990). Personality structure: Emergence of the five-factor model. *Annual Review of Psychology,*, 41(1), 417–440.

Fosse, T. H., Buch, R., Säfvenbom, R., & Martinussen, M. (2015). The impact of personality and self-efficacy on academic and military performance: The mediating role of self-efficacy. *Journal of Military studies 6(1)*, 47-65.

Goffman, E. (1959). *The presentation of self in everyday life.* Doubleday.

Gosling, S. D., Rentfrow, P. J., & Swann, W. B., Jr. (2003). A very brief measure of the Big-Five personality domains. *Journal of Research in Personality,*, 37(6), 504–528.

Howard, Medina & Howard. (1996). The Big Five Personality Dimensions and Entrepreneurial Status:.

Manual, F. (2006). *Army Leadership.* . Washington, DC.

McCormack, L., & Mellor, D. Mc Cormack, L. (2002). The role of personality in leadership: An application of the five-factor model in the Australian military. *Military psychology 14(3)*, 179-197.

McCrae, R. R. (1987). Validation of the five-factor model of personality across instruments and observers. *Journal of Personality and Social Psychology.*

Nettle, D. (2007). *"Personality: What Makes You the Way You Are"* .

Salgado, J. F. (1997). The five factor model of personality and job performance in the European community. *Journal of Applied Psychology,*, 82(1): 30-43.

Skoglund, T. H. (2020). *Big five personality profiles in the Norwegian special operations forces.* pp. Frontiers in psychology, 11, 747.

Song, M., Choi, H. J., & Hyun, S. S. (2021). MBTI personality types of Korean cabin crew in

Su, Q., & Liu, G. (2021). A cross-temporal meta-analysis review of the personality of Chinese military personnel, 1991–2017. Personality and Mental Health, 15(2), 124-135.

Yang, Z., Cao, F., Lu, H., Zhu, X., & Miao, D. (2014). Changes of anxiety in Chinese military personnels over time: a cross-temporal meta-analysis. International journal of mental health systems, 8(1), 1-9.

Westen, D. &. (2002). Developments in Psychodynamic Theory and Practice. . *Annual Review of Clinical Psychology, 1(1),* 395-419.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ХАРИЛЦАА: ТҮҮХЭН ХӨГЖИЛ БА ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

FOREIGN RELATIONS OF THE BORDER GUARD: HISTORICAL DEVELOPMENT AND FUTURE DIRECTIONS

Б.Хонгорзул*
Хил судлалын Магистрант, дэслэгч
Khongorzul B.
Master's degree in Border Studies, Lieutenant

*Хариуцлагатай зохиолч: b.khongorzul0327@gmail.com

Хураангуй: Хил хамгаалах байгууллагын гадаад харилцаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах, хилийн халдашгүй дархан байдлыг дипломат арга замаар бэхжүүлэх “зөөлөн хүчний” бодлого юм. Энэхүү үйл ажиллагаа нь хөрш орнуудтай хамтран ажиллах, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах, хилийн төлөөлөгчөөр дамжуулан аливаа маргаантай асуудлыг харилцан ойлголцлын замаар шийдвэрлэж, хилийн дэглэмийг сахиулахад чухал үүргийг гүйцэтгэдэг. Мөн олон улсын байгууллагуудтай нягт ажилласнаар хил хамгаалах үйл ажиллагаанд цахим хяналт, инновацын шийдлүүдийг нэвтрүүлж, хүний нөөцийн чадавхыг дэлхийн жишигт хүргэх зарчмыг баримтлан ажиллаж байна. Орчин үеийн гадаад харилцаа нь зөвхөн хилийн шугамыг хамгаалах бус, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус шилжилт хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн нэгдсэн орон зайг бүрдүүлэхэд чиглэж байна. Ийнхүү Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын гадаад харилцааны салшгүй хэсэг болж, “найрсаг хил”-ийн үзэл баримтлалыг бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлж байна. XX, XXI зууны эхэн үеийн Хил хамгаалах байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагаатай холбогдох сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдэд тэмдэглэгдсэн мэдээ, баримтууд нь энэхүү судалгааны ажлын гол хэрэглэгдэхүүн болохын зэрэгцээ гадаад харилцаа, хамтын ажиллагааны түүхийн асуудлуудыг улируулан судлах, үнэн бодитой үнэлэн дүгнэхэд чухал ач холбогдолтой. Энэхүү судалгааны ажилдаа уламжлалт улируулан судлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан судлах аргыг ашигласан юм.

Abstract: The foreign relations of the Border Guard Service are a “soft power” policy aimed at ensuring national security and strengthening the inviolability of the border through diplomatic means. This activity plays an important role in cooperating with neighboring countries, ensuring regional stability, resolving any disputes through mutual understanding through border agents, and maintaining border regimes. In addition, by working closely with international organizations, we are implementing electronic monitoring and innovative solutions in border protection activities, and adhering to the principle of bringing human resource capabilities to world standards. Modern foreign relations are not only aimed at protecting the border line, but also at creating a unified information space to prevent cross-border organized crime and illegal migration. Thus, the Border Guard Service has become an integral part of Mongolia’s foreign relations and is implementing the concept of “friendly borders” into practice. The information and facts recorded in the source documents and research works related to the foreign relations and cooperation of the Border Guard Service in the 20th and early 21st centuries are the main materials of this research work, and are important for further research and objective evaluation of the historical issues of foreign relations and cooperation. Traditional methods of further research, analysis, synthesis, and comparison were used in this research work.

Түлхүүр үг: Хил хамгаалах байгууллага, гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Keywords: International Criminal Police Organization, International Organization for Migration, United Nations Office on Drugs and Crime

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Хил хамгаалах байгууллага нь улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг ба үүнд гадаад харилцаа чухал үүрэгтэй. Гадаад харилцаа нь улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан урт хугацааны туршид стратегийн түвшинд хөгжиж ирсэн. Түүнчлэн хөрш орнууд болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа нь хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгоход тодорхой хувь нэмэр оруулсан түүхтэй. Иймээс Хил хамгаалах байгууллагын гадаад харилцааны түүхэн хөгжил, цаашдын чиг хандлагыг судлах нь хил хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Энэхүү судалгаанд Хил хамгаалах байгууллагын гадаад харилцааг түүхэн хөгжлийн үүднээс авч үзэж, өнөөгийн хамтын ажиллагааны чиг хандлага, ач холбогдлыг тодорхойлох зорилгыг дэвшүүлсэн. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Хил хамгаалах байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааны түүхэн уламжлал, шинэчлэлийг судлан, бусад улс орнуудын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хөгжлийн чиг хандлагатай харьцуулсан судалгаа хийж, ач холбогдлыг тодорхойлж гадаад харилцааны шинэчлэлтэд өөрийн хувь нэмрийг оруулах юм.

Монгол улсын хилийн бодлого, аюулгүй байдал болон гадаад харилцааны түүхэн уламжлал шинэчлэлд холбогдох үндсэн эх, нэгэн сэдэвт бүтээл, судалгааны материал, гарын авлага, сурах бичиг, сургалтын материалууд цөөнгүй хэвлэгдэн гарчээ. Тухайлбал: Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын түүхэн дэх хамгийн нөлөө бүхий зүтгэлтнүүдийн нэг бол Хошууч генерал Ш.Арвайн Монгол Улсын хилийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр буюу “Хил” (1995), " Монгол Улсын хилийн аюулгүй байдал" (докторын ажил) зэрэг бүтээлдээ улсын хилийг хамгаалахад хөрш орнуудын итгэлцэл, хамтын ажиллагаа ямар чухал болохыг онол болон практикийн хувьд нотолсон ба Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг гадаад харилцаа, дипломат шугамаар хэрхэн хангах стратегийн төлөвлөгөө байсан тухай онцлон дурдаж болно. Мөн Хил хамгаалах байгууллагын ахмад зүтгэлтэн, доктор (Ph.D), профессор Б.Д.Нямдорж, Доктор, профессор Т.Ганболд нарын " Хил судлал" (2011, 2022) бүтээлд улсын хилийн тухай ойлголт, хилийн онол, хилийн аюулгүй байдал, хилийн дэглэм болон хилийн дипломат харилцааны асуудлуудыг багтаахын зэрэгцээ Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүн, Дотоод хэргийн их сургуулийн сонсогчдод зориулсан суурь гарын авлага болдгоороо онцлог юм. Гэвч Хил хамгаалах байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар тусгайлан судлагдсан бүтээл одоогоор гараагүй байна. Харин Олон улсын түвшинд хил хамгаалалтын хамтын ажиллагаа, хил дамнасан аюул занал, хил хамгаалалтын шинэ технологи, мэдээлэл солилцоо зэрэг асуудлыг өргөн хүрээнд судалсан United Nations Office on Drugs and Crime, International Criminal Police Organization, International Organization for Migration зэрэг олон улсын байгууллагууд хил дамнасан гэмт хэрэг, хууль бус шилжилт хөдөлгөөн, хил хамгаалалтын хамтын ажиллагааны талаар судалгаа, тайлангууд гаргасан байдаг.

Хил хамгаалах байгууллагын гадаад харилцааны түүх

Даяаршил болон бүс нутгийн интеграци эрчимжиж буй өнөө үед улс орны аюулгүй байдлын "босго" болсон улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах асуудал зөвхөн зэвсэг, техникийн хүчин чадлаар бус, дипломат харилцаа, гадаад хамтын ажиллагааны механизм дээр тогтож байна. Монгол Улсын Хил хамгаалах байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын хувьд гадаад харилцааг стратегийн түвшинд хөгжүүлж ирсэн.

Энэхүү хөгжлийн явцыг түүхэн үүднээс нь авч үзвэл 1911 онд Монгол Улс Манж Чин улсын ноёрхлоос гарч тусгаар тогтнолоо сэргээсэн нь үндэсний аюулгүй

байдлын шинэ тогтолцоо бий болох эхлэл болсон юм. Гэсэн хэдий ч тухайн үед хил хамгаалах тусгай байгууллага бүрэн хөгжөөгүй байсан бөгөөд хилийн хамгаалалтыг ихэвчлэн нутгийн харуул, цэргийн анги нэгтгэлүүд гүйцэтгэж байв (Б.Д.Нямдорж & Т.Ганболд, 2022).

1921 онд болсон Монголын Ардын хувьсгалын дараа Монгол Улсад төрийн байгууллагууд шинэчлэгдэж, аюулгүй байдлын тогтолцоо бүрэлдэн тогтсон. Энэ үеэс эхлэн улсын хилийг хамгаалах чиг үүрэгтэй анги нэгтгэлүүд байгуулагдаж, хил хамгаалах байгууллагын үндэс суурь тавигдсан. (Б.Д.Нямдорж & Т.Ганболд, Хил судлал, 2022)

Тухайн үед Монгол Улсын гадаад харилцаа нь ихэвчлэн Зөвлөлт Холбоот Улстай холбоотой байсан бөгөөд аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж байв. Энэ нь хил хамгаалах байгууллагын хөгжилд ч нөлөөлж, мэргэжилтэн бэлтгэх, сургалт зохион байгуулах, техник хэрэгсэл нийлүүлэх зэрэг чиглэлээр дэмжлэг үзүүлж байсан.

Түүнчлэн 1940–1990 оны хооронд Монгол Улс социалист хөгжлийн замыг сонгож, төрийн байгууллагууд социалист тогтолцооны дагуу үйл ажиллагаагаа явуулж байв. Энэ хугацаанд Монгол Улсын хил хамгаалах байгууллага БНМАУ-ын Хилийн цэрэг нэртэйгээр ажиллаж байсан бөгөөд улс орны батлан хамгаалах тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг байлаа (Д.Баттулга, 2018).

Энэ үед хил хамгаалах байгууллагын гадаад харилцаа голчлон социалист орнуудтай хөгжиж байв. Ялангуяа Зөвлөлт Холбоот Улстай хамтын ажиллагаа стратегийн ач холбогдолтой байсан. Хилийн цэргийн офицер, мэргэжилтнүүдийг Зөвлөлтийн цэргийн академиудад сургах, хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах зэрэг олон талт хамтын ажиллагаа өрнөж байв (Д.Баттулга, Монгол улсын хил хамгаалах байгууллагын түүх, 2018).

Мөн Монгол Улс Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хилийн асуудлаар хэлэлцээрүүд байгуулж, хилийн шугам тогтоох, тэмдэгжүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлж байв. Энэ нь хоёр улсын хилийн аюулгүй байдлыг хангах, маргаан үүсэхээс сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн (Д.Баттулга, Монгол улсын хил хамгаалах байгууллагын түүх, 2018)

Социализмын үед хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа нь ихэвчлэн цэргийн чиглэл давамгайлсан байсан бөгөөд хил хамгаалалт, улсын аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой анхаарал хандуулж байв. 1990 онд болсон Монголын ардчилсан хувьсгал нь Монгол Улсын улс төр, эдийн засаг, гадаад бодлогод томоохон өөрчлөлт авчирсан. Ардчиллын дараа Монгол Улс нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлэх болсон бөгөөд энэ нь хил хамгаалах байгууллагын гадаад харилцаанд ч шинэ боломжуудыг бий болгосон. (Б.Д.Нямдорж & Т.Ганболд, Хил судлал, 2022).

Хил хамгаалах байгууллагын гадаад харилцааны өнөөгийн үе, цаашдын чиг хандлага

Энэ үеэс эхлэн Хил хамгаалах байгууллага олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах болсон. Үүнд:

- International Criminal Police Organization
- International Organization for Migration
- United Nations Office on Drugs and Crime

Эдгээр байгууллагуудтай хамтран хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, хууль бус шилжилт хөдөлгөөнийг хянах, хүний наймаа болон хар тамхины хууль бус эргэлтийг бууруулах чиглэлээр олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна (байгууллага, 2026).

Түүнчлэн хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд олон улсын туршлага нэвтрүүлэх, сургалт, семинар, хамтарсан судалгаа хийх зэрэг ажлууд өргөжин хөгжсөн.

Сүүлийн жилүүдэд Хил хамгаалах байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагаа нь зөвхөн уламжлалт дипломат харилцаанаас хальж, технологийн интеграци, бүс нутгийн аюулгүй байдлын нэгдсэн систем болон хувирч байна(тогтоол, 2020). Үүнээс авч үзвэл:

1.Гурван талт хамтын ажиллагаа (Монгол-Орос-Хятад)

Хил хамгаалалтын түүхэнд анх удаа гурван улсын хилийн цэрэг хамтарсан сургуулилалт хийж эхэлсэн нь онцлох үйл явдал болов.

- **“Хилийн хамтын ажиллагаа – 2025” сургуулилт:** 2025 оны 9 дүгээр сард Монгол, Орос, Хятад улсын цэргүүд терроризм, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр анхны хамтарсан хээрийн сургуулилалтыг зохион байгуулав. Хээрийн сургуулилтын үеэр гурван талын хамтарсан удирдлагын төвийг байгуулж, мэдээлэл шуурхай солилцох шинэ загварыг туршсан байна.

2.Технологийн шинэчлэл ба Дижитал хамтын ажиллагаа

Орчин үеийн хил хамгаалалт нь өндөр технологид суурилж байна.

- **Дрон ба Робот техник:** 2025 оны сургуулилалтын үеэр хилийн хяналт шалгалтад дрон, байлдааны тандалтын камер, радараас гадна газар дээр ажиллах робот нохой зэргийг туршиж, хил хамгаалалтад нэвтрүүлж эхэллээ.
- **Цахим гарц (E-Gate):** Монгол Улс хилээр орох, гарах цахим гарцыг нэвтрүүлж, иргэд цахим гадаад паспортоор саадгүй нэвтрэх боломжийг бүрдүүлсэн.

3.Бүс нутгийн болон олон улсын түншлэл

Монгол Улс “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлж байна.

- **FALF 2025:** Иргэний нисэхийн олон улсын байгууллага (ICAO) болон Монгол Улсын Засгийн газар хамтран "Ази, Номхон далайн бүсийн хөнгөвчлөх форум"-ыг 2025 оны 6 дугаар сард зохион байгуулж, хилийн хяналт, иргэний бүртгэлийн асуудлыг хэлэлцсэн.
- **Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага (ШХАБ):** Монгол Улс ажиглагчийн хувиар бүс нутгийн аюулгүй байдал, хилийн дэглэмийн асуудлаарх уулзалт, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож байна.

4.Боомтын сэргэлт ба Нэгдсэн менежмент

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх гадаад харилцаа эрчимжиж байна.

- **Боомтын үйлчилгээг дижиталжуулах:** Экспорт, импортын мэдээллийг хөрш орнуудтай цахимаар солилцох, боомтын дэд бүтцийг сайжруулахад олон улсын зээл, тусламжийг чиглүүлж байна.
- **Цагийн хуваарийн зохицуулалт:** Хөрш орнуудтай хилийн боомтын ажиллах цагийг харилцан тохиролцож, баяр ёслолын үеэрх түр хаалтыг дипломат шугамаар урьдчилан мэдээлж байна.

Хил хамгаалах байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааны цаашдын чиг хандлага нь "Алсын хараа-2050" болон "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсанаар илүү нээлттэй, технологижсон, эдийн засгийн үр ашигтай байх чиглэл рүү хувьсаж байна. Үүнээс дурдвал:

1.Боомтын сэргэлт ба Эдийн засгийн коридор

- Ухаалаг боомтын систем: 2026-2030 онд хилийн боомтуудыг олон улсын жишигт нийцсэн “Ухаалаг, цахим” хэлбэрт бүрэн шилжүүлж, нэвтрүүлэх чадварыг 3-4 дахин нэмэгдүүлэх
- Хуурай боомтын хөгжил: Хил орчмын бүсэд хуурай боомт, логистикийн төвүүдийг байгуулж, хөрш орнуудтай ачаа тээврийн нэгдсэн сүлжээнд холбогдох.
- Хил дамнасан чөлөөт бүс: Замын-Үүд-Эрээн, Алтанбулаг-Хиагт зэрэг боомтуудад эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүдийг идэвхжүүлж, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх

2.Технологийн интеграци ба Цахим хил

- Цахимжуулалт: Хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааг 90-ээс дээш хувь цахимжуулж, E-Mongolia болон бусад төрийн үйлчилгээний системтэй бүрэн уялдуулах
- Дэвшилтэт хяналт: Хилийн хамгаалалтад дрон, радар, алсын зайн тандалтын ухаалаг системүүдийг (AI) өргөнөөр нэвтрүүлж, хүний хүчин зүйлээс хамаарах ачааллыг бууруулах

- Биометрик танилт: Зорчигч болон тээврийн хэрэгслийг биометрик мэдээллээр түргэн шуурхай бүртгэх системийг бүх боомтуудад нэвтрүүлэх

3.Бүс нутгийн аюулгүй байдал ба “Гуравдагч хөрш”

- Олон талт хамтын ажиллагаа: Төв Азийн орнууд болон Зүүн өмнөд Азийн (ASEAN) бүс нутгийн орнуудтай хилийн менежментийн туршлага солилцох, хамтарсан сургалт хийх
- Нэгдсэн сургуулилалт: Хөрш орнуудтай хийх “Хилийн хамтын ажиллагаа” зэрэг хамтарсан хээрийн сургуулилтыг тогтмолжуулж, хил дамнасан гэмт хэрэг, терроризмтой тэмцэх чадавхыг бэхжүүлэх
- Эрүүл мэндийн аюулгүй байдал: Хил дээр “Нэг эрүүл мэнд” (One Health) зарчмыг нэвтрүүлж, хил дамнасан халдварт өвчин, малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх хамтарсан хяналтын механизмыг бүрдүүлэх

4.Байгаль орчинд ээлтэй “Ногоон хил”

- Ногоон дэд бүтэц: Хилийн боомтуудыг хөгжүүлэхдээ байгаль орчинд сөрөг нөлөө багатай, эрчим хүчний хэмнэлттэй “Ногоон хөгжлийн стандарт”-ыг мөрдлөг болгох
- Байгалийн гамшигтай тэмцэх: Хил дамнасан түймэр, цөлжилт, шар шороон шуургатай тэмцэх чиглэлээр хөрш орнуудтай хийх байгаль орчны дипломат ажиллагааг идэвхжүүлэх зэрэг олон талт хөгжлийн шинэ чиг хандлагыг нээж буйгаараа онцлог юм. (тогтоол, "Алсын хараа-2050" хөтөлбөр, 2020)

Хил хамгаалах байгууллагын гадаад харилцааны ач холбогдол нь зөвхөн улсын хил хамгаалах асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагааны нэг хэсэг юм.

Харьцуулсан үзүүлэлтүүд :

д/д	Шинж чанар	Өмнөх үе (Социализмын үе)	Шилжилтийн болон Орчин үе
1	Гадаад бодлогын чиглэл	Нэг тулгуурт: Зөвлөлт холбоот улстай нягт холбоотой	Олон тулгуурт: Хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцаж, “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлдэг
2	Эрх зүйн зохицуулалт	Хоёр талт гэрээ хэлэлцээрүүд давамгайлж байсан	Олон улсын конвенцууд, НҮБ-ын дүрэм болон 30 гаруй улс, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаатай
3	Хамтын ажиллагааны цар хүрээ	Хил хамгаалалтын тактик, зэвсэглэл нь цэвэр цэргийн зориулалттай хаалттай байсан	Хил хамгаалалт, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, хүмүүнлэгийн ажил, энхийг сахиулах
4	Боловсон хүчний бэлтгэл	Зөвхөн ЗХУ-ын цэргийн болон хилийн сургуулиудад мэргэжилтнүүдийг бэлтгэдэг байсан	ОХУ-аас гадна, АНУ, БНХАУ, ХБНГУ, Турк, БНСУ зэрэг улсуудад боловсон хүчин бэлтгэж, туршлага судалдаг
5	Техник, технологийн шинэчлэл	Зөвлөлт холбоот улсын техникийг хэргэлдэг	Дрон (нисгэгчгүй нисэх хэрэгсэл), шөнийн хараа, мэдрэгч бүхий ухаалаг систем, сансрын холбоо
6	Олон улсын ажиллагаа	Олон улсын ажиллагаанд оролцох боломж хязгаарлагдмал	НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд бие даасан баг болон цэргийн ажиглагчаар оролцдог
7	Хилийн төлөөлөгчдийн харилцаа	Зөвхөн хилийн зөрчлийг шийдвэрлэхэд чиглэсэн цэргийн дипломат харилцаа	Хил орчмын аялал жуулчлал, эдийн засгийн хамтын ажиллагаа, байгаль орчныг хамгаалах цогц харилцаа
8	Санхүүжилт, тусламж	Зөвхөн ЗХУ-ын буцалтгүй тусламж, зээл	Олон улсын төсөл хөтөлбөр, цэрэг-техникийн тусламж

Хил хамгаалах байгууллагын гадаад харилцаа нь хаалттай байснаас нээлттэй, олон талт чиглэл рүү шилжсэн нь Монгол улсын тусгаар тогтнолыг дипломат аргаар баталгаажуулах чухал нөлөө үзүүлсэн юм. Өнөөдөр хилчид зөвхөн торгон хилээ манах бус, олон улсын аюулгүй байдлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч тал болсон байна.

Дүгнэлт

Хил хамгаалах байгууллагын гадаад харилцааны хөгжил, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг нэгтгэн дүгнэвэл энэ нь зөвхөн салбарын хамтын ажиллагаа бус, үндэсний аюулгүй байдлыг дипломат аргаар хангах цогц механизм болон төлөвшжээ.

Өмнөх үед хил хамгаалалт нь голчлон зэвсэгт хүчин, цэргийн хүчээр хилээ хаах, халхавчлах тактикт суурилж байсан бол орчин үед "Итгэлцэлд суурилсан хил"-ийн үзэл баримтлал руу шилжсэн. Хөрш орнуудтай байгуулсан Хилийн дэглэмийн гэрээ, Хилийн төлөөлөгчдийн институтийн үйл ажиллагаа нь аливаа зөрчлийг газар дээр нь, яриа хэлэлцээрийн замаар шийдвэрлэх боломжийг олгож байна. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, олон улсын стандарт, жишигт нийцсэн мэргэжлийн байгууллага болон хувирчээ. "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд АНУ, ХБНГУ, Турк, БНСУ зэрэг улсуудтай техник-технологи, хүний нөөцийн чиглэлээр хамтарч байгаа нь манай хилчдийн чадавхыг дэлхийн төвшинд хүргэсэн. Ялангуяа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа нь Монгол улсын хилчдийн мэргэжлийн ур чадварыг олон улсад хүлээн зөвшөөрүүлсэн хэрэг юм.

Өнөөдөр гадаад харилцаа нь зөвхөн уулзалт, хэлэлцээрээр хязгаарлагдахгүй, "Ухаалаг хил" (Smart Border) байгуулах технологийн шилжилтийн гүүр болж байна.

Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг (хүн худалдаалах, мансууруулах бодисын эргэлт, хууль бус шилжилт хөдөлгөөн)-тэй тэмцэхэд олон улсын Интерпол, ОУ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагатай мэдээлэл шуурхай солилцох гадаад харилцааны суваг нээгдсэн нь үндэсний аюулгүй байдлыг хангах шинэ хэрэгсэл болж байна. Хил хамгаалах байгууллагын гадаад харилцаа нь "тушаал биелүүлэгч" байхаас "бодлого тодорхойлогч" түвшинд хүрсэн байна. Энэхүү шилжилт нь Монгол улсын хилийг зөвхөн зэвсгийн хүчээр бус, олон улсын эрх зүй, итгэлцэл, хамтын ажиллагааны хүчээр хамгаалах боломжийг бүрдүүлжээ.

Санал

Судалгааны үр дүнд тулгуурлан ХХБ-ын гадаад харилцааг ирээдүйд илүү үр дүнтэй болгохын тулд дараах саналуудыг дэвшүүлж байна.

Бодлогын түвшинд:

"Цахим хил" хамтын ажиллагаа: Хөрш орнуудын хилийн албадтай мэдээлэл солилцох дундын баазыг нууцлалын өндөр түвшинд байгуулж, хил дамнасан гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг "Real-time" буюу бодит хугацаанд солилцох механизмыг хуульчлах боломжийг судлах.

Эрх зүйн шинэчлэл: Олон улсын хилийн менежментийн шилдэг туршлагуудыг (IBM - Integrated Border Management) хөрш орнуудтай хамтран үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн нутагшуулах замаар боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх.

Үйл ажиллагааны түвшинд:

Хил орчмын аялал жуулчлал ба аюулгүй байдал: Хил орчмын бүс нутагт эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор хөрш орнуудын ижил төрлийн байгууллагуудтай хамтарсан "Аюулгүй бүс" хөтөлбөр хэрэгжүүлэх.

Хэлний болон соёлын бэлтгэл:

Хил дээр ажиллаж буй алба хаагчдыг хөрш орнуудын хэл, зан заншил, хууль эрх зүйн чиглэлээр нарийвчлан мэргэшүүлэх сургалтыг гадаад түншүүдтэй хамтран зохион байгуулах.

Цаашдын судалгааны чиглэлд:

Хил дамнасан кибер халдлагаас сэргийлэх чиглэлээр олон улсын туршлага судлах, энэ чиглэлийн гадаад харилцааг шинээр тодорхойлох судалгааны ажлыг эхлүүлэх шаардлагатай.

Ашигласан материалын жагсаалт

Б.Д.Нямдорж, & Т.Ганболд. (2022). *Хил судлал.* Соёмбо принтинг.

Б.Д.Нямдорж, & Т.Ганболд. (2022). *Хил судлал.* Соёмбо принтинг.

Д.Баттулга. (2018). *Монгол улсын хил хамгаалах байгууллагын түүх.* Адмон принт.

Д.Баттулга. (2018). *Монгол улсын хил хамгаалах байгууллагын түүх.* Адмон принт.

Д.Баттулга. (2018). *Монгол улсын хил хамгаалах байгууллагын түүх.* Адмон принт.

Б.Д.Нямдорж, & Т.Ганболд. (2022). *Хил судлал.* Соёмбо принтинг.

байгууллага, Х. х. (2026). *Хил хамгаалах байгууллага*. Хил хамгаалах байгууллага. https://eng.bpo.gov.mn

тогтоол, З. г. (2020). *Алсын хараа 2050 хөтөлбөр*. Алсын хараа 2050 хөтөлбөр. https://legalinfo.mn/mn/detail/15406

тогтоол, З. г. (2020). *"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ*. "АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ. https://legalinfo.mn/mn/detail/15406

тогтоол, З. г. (2020). *"Алсын хараа-2050" хөтөлбөр*. "Алсын хараа-2050" хөтөлбөр. https://legalinfo.mn/mn/detail/15406

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАЛААР ГАРСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

IMPLEMENTING INTERNATIONAL TREATIES IN THE ENFORCEMENT OF CIVIL COURT JUDGMENTS: CHALLENGES AND PROSPECTS IN MONGOLIA

Э.Цэрэнханд*
Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн ахлах багш, хошууч
Tserenkhand E.
Major, Senior Lecturer, Department of Civil Enforcement, School of Court Decision Enforcement, University of Internal Affairs, Ulaanbaatar, Mongolia

*Хариуцлагатай зохиогч: Tserenkhand.E@uia.gov.mn

Хураангуй: Энэхүү судалгааны зорилго нь гадаадын иргэнд холбогдох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, олон улсын эрх зүйн туслалцааны механизмын хэрэгжилтийг шинжилж, шийдвэрийн биелэлтэд нөлөөлж буй тулгамдсан асуудлыг тодорхойлоход чиглэгдсэн.

Судалгаанд олон улсын хувийн эрх зүйн үндсэн зарчим, тухайлбал Res Judicata болон улсын нутаг дэвсгэрийн бүрэн эрхийн зарчимд тулгуурлан Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцийн зохицуулалтыг харьцуулан шинжилсэн. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны статистик мэдээлэл, практик жишээнд дүн шинжилгээ хийж, гадаадын зарим улсын туршлагатай харьцууллаа.

Судалгааны үр дүнгээс харахад гадаадын иргэнд холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт хангалтгүй, зарим тохиолдолд 0.08%-д хүрч байгаа нь олон улсын эрх зүйн туслалцааны механизм бодитой хэрэгжихгүй байгаатай холбоотой байна. Төлбөр төлөгчийн оршин суугаа хаяг, хөрөнгийг тогтоох, мэдээлэл солилцох тогтолцоо сул, байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь голлон нөлөөлжээ. Мөн байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээг практикт хангалттай ашиглахгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг бууруулж байна. Иймд олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг ашиглах, мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх шаардлагатай үүсжээ.

Abstract: The purpose of this study is to examine the legal regulation of enforcement proceedings involving foreign citizens and the implementation of international legal assistance mechanisms, and to identify key challenges affecting the effectiveness of enforcement.

The research is based on fundamental principles of private international law, particularly the doctrine of res judicata and the principle of territorial sovereignty. It employs a comparative analysis of Mongolia's relevant legislation, international treaties, and conventions. In addition, statistical data and practical cases related to enforcement proceedings are analyzed and compared with selected foreign practices.

The findings indicate that the enforcement rate in cases involving foreign citizens remains significantly low, in some instances reaching only 0.08%. This is largely due to the ineffective implementation of international legal assistance mechanisms. Major challenges include difficulties in identifying the debtor's residence and assets, weak information exchange systems, and insufficient institutional coordination. Furthermore, existing legal assistance agreements are not effectively utilized in practice, which undermines enforcement efficiency. Therefore, it is necessary to enhance international cooperation, improve integrated information systems, and strengthen professional capacity in enforcement practice.

Түлхүүр үгс: Шүүхийн шийдвэр, гадаадын иргэн, төлбөр төлөгч, төлбөр авагч, шүүх, хэрэг маргаан.

Key words: Judgment, foreigner, payer, payee, court, litigation.

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Орчин үеийн дэлхий дахинд эдийн засгийн интеграц, олон улсын худалдааны харилцаа, хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн эрчимжихийн хэрээр гадаадын иргэн болон хуулийн этгээд оролцсон иргэний эрх зүйн харилцааны цар хүрээ улам бүр өргөжиж байна. Үүний зэрэгцээ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гадаадын иргэн, хуулийн этгээд оролцох тохиолдол нэмэгдэх хандлагатай болж байна.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой иргэний маргааныг шийдвэрлэх, түүнчлэн гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхтэй холбогдсон эрх зүйн асуудлууд бодит практикт улам бүр чухал байр суурь эзэлж байна. Түүнчлэн хил дамнасан эрх зүйн харилцаа өсөн нэмэгдэхийн хэрээр нэг улсын шүүхээс гаргасан шийдвэрийг нөгөө улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр хүлээн зөвшөөрөх, албадан гүйцэтгэх асуудал нь олон улсын хувийн эрх зүй болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны салбарт анхаарал татсан судалгааны чухал сэдэв болжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гадаад улсын иргэн, хуулийн этгээдтэй холбогдох шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх, шүүхийн шийдвэр гарцаагүй биелэгдэх зарчмыг хангах, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хангаж, хамгаалах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Судалгааны хүрээнд олон улсын хувийн эрх зүйн үндсэн зарчим, гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхтэй холбогдох олон улсын гэрээ, конвенц, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан шинжилж, тэдгээрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үзүүлэх нөлөөг авч үзсэн болно. Мөн гадаадын иргэн, хуулийн этгээд оролцсон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тулгарч болох эрх зүйн болон практик хүндрэлүүдийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх боломжит арга зам, эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг судалгааны үүднээс тайлбарлахыг зорив.

Ийнхүү гадаадын иргэнтэй холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг онол, практикийн түвшинд авч үзэх нь хил дамнасан эрх зүйн харилцаа өсөн нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах, улмаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн баталгааг бэхжүүлэхэд тодорхой ач холбогдолтой юм.

Энэхүү судалгаа нь Монгол Улсад гадаадын иргэнд холбогдох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд олон улсын эрх зүйн туслалцааны механизм хангалттай хэрэгжихгүй байгаагаас үүдэн шийдвэрийн биелэлт буурч байгаа асуудлыг тодорхойлох, түүнийг сайжруулах боломжийг судлахад оршино.

1. Онолын үндэслэл

Гадаад улсын шүүхийн шийдвэр ямар нөхцөлд нутаг дэвсгэр дээр нь хүчинтэй байх эсэхийг аливаа улс өөрөө тогтоодог. Res Judicata (аливаа маргаан нь эцэслэн шийдвэрлэгдсэн бол хүлээн зөвшөөрөгдөх ёстой) зарчмын үндсэн дээр шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх асуудал хэрэгжих үндэс болдог. Res judicata (лат. res judicata pro veritate accipitur - “аливаа маргаан нь эцэслэн шийдвэрлэгдсэн бол хүлээн зөвшөөрөгдөх ёстой)”) зарчим нь шүүхийн шийдвэрийн эцсийн хүчин чадлыг баталгаажуулдаг суурь эрх зүйн зарчим юм. Энэхүү зарчмын агуулга нь нэгэнт шүүхээр хянан шийдвэрлэгдэж, хүчин төгөлдөр болсон маргааныг дахин хэлэлцэх, дахин нэхэмжлэл гаргахыг хориглож, шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, эрх зүйн тодорхой байдлыг хангахад оршино.

Олон улсын хувийн эрх зүйн хүрээнд res judicata зарчим нь гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх механизмын чухал онолын үндэс болдог. Өөрөөр хэлбэл, нэг улсын шүүхээс гаргасан хүчин төгөлдөр шийдвэрийг нөгөө улсын шүүх үндсэн агуулгаар нь дахин хянан шийдвэрлэхгүйгээр хүлээн зөвшөөрөх нь шүүхийн шийдвэрийн эцсийн хүчин чадал, талуудын эрх зүйн итгэлцлийг хамгаалах ач холбогдолтой гэж үздэг. Иймд res judicata

зарчим нь шүүхийн шийдвэрийн эцсийн байдлыг хангахын зэрэгцээ олон улсын иргэний эргэлтэд эрх зүйн тогтвортой байдлыг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл нэгэнт шийдвэрлэгдсэн хэргийн талаар талууд хэргийг шийдвэрлэсэн шүүхэд дахин хандах эсхүл өөр шүүхэд хандах эрх зүйн үндэслэлгүй гэсэн үг. Үүнтэй холбоотойгоор гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх асуудал үүсэх ба гадаад улсын шүүхийн шийдвэр гэдэгт тухайн маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг ойлгоно (Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, 2023).

Олон улсын нийтийн эрх зүйн дагуу аливаа улс гүрэн батлан гаргасан эрх зүйн актаа өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд л хэрэгжүүлэх боломжтой байдаг. Энэ нь процессын эрх зүй, шүүхийн баримт бичгийг гардуулан өгөх нотлох баримт цуглуулах зэрэг үйл ажиллагаанд ч хамаарна. Тийм ч учраас үйлчлэх хүчин чадал нь нутаг дэвсгэрээр хязгаарлагдсан эрх мэдлийг зарим үед хэрэгжүүлэхэд олон улсын эрх зүйн туслалцаа шаардлагатай байдаг (Hoffman, 2005). Өөрөөр хэлбэл өөрийн улсын иргэн болон хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хилийн чанадад хамгаалахын тулд улс орнууд эрх зүйн харилцан туслалцааны гэрээг байгуулж ажилладаг (Б.Ундрах, 2021).

Улс орнууд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний үндсэн дээр гадаад улсын нутаг дэвсгэрт хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой ажиллагааг гүйцэтгүүлэх боломжтой болж, хэрэг маргааныг үр дүнтэй шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлдэг. (С.Энхцэцэг, 2025).

2. Үндэсний ба Олон улсын эрх зүйн зохицуулалт

Олон улсын эрх зүйн туслалцаа нь олон тооны хоёр талт болон олон талын хэлэлцээрийн үндсэн дээр зохицуулагддаг. Тухайлбал Монгол Улс нь 1968 оноос эхлэн нийт 20 улстай 26 төрлийн эрх зүйн туслалцааны гэрээг байгуулсан бөгөөд эдгээрээс 16 гэрээний дагуу 17 улстай иргэн, гэр бүл, хөдөлмөрийн болон худалдааны хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх боломжтой байна. 1954 онд олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлаас батлагдсан Иргэний процессын тухай конвенцод нэгдэн орсон ба Монгол Улсын хувьд 2014 оноос эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа юм. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг анх байгуулж байх үед гол төлөв асуудлыг багцаар нь буюу иргэний, гэр бүлийн хөдөлмөр болон эрүүгийн эрх зүйн асуудлыг нэг гэрээнд багтаан зохицуулдаг байсан (Хууль зүй, дотоод хэргийн яам , 2009). Эдгээрээс шүүхийн шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх, биелүүлэх талаар 4 улс (ОХУ, БНХАУ, Франц, Казакстан)-тай гэрээ байгуулсан боловч 1986 оноос хойш Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд өнөөдрийг хүртэлх хугацаанд уг гэрээний хүрээнд даалгавар хүргүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулсан практик байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд зааснаар “Монгол Улсын олон улсын гэрээ нь нэгдэн орсон буюу соёрхон баталснаар дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн заасан тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага эдгээр гэрээг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шууд хэрэгжүүлэх боломжтой юм (Монгол Улсын Үндсэн хууль, 1992).

Монгол Улсад гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар, харин түүнийг албадан биелүүлэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тус тус зохицуулж, олон улсын гэрээний зохицуулалтыг дагуу хэрэглэдэг.

Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бол иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой эрх, үүргийн хэрэгжилтийг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалахад чиглэгдсэн байдаг (Б.Алтангэрэл, 2005).

Манай улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд гадаадын иргэн,

харьяалалгүй хүн, гадаад улсын болон олон улсын байгууллагатай холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх тусгайлсан зохицуулалт байдаг бол гадаадын зарим орнуудад энэ талаар тусгайлсан зохицуулалт байдаггүй бөгөөд дотоодын иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны нийтлэг зохицуулалтыг мөрддөг.

Гадаадын иргэнд холбогдох иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулахдаа иргэнээс төлбөр гаргуулах ажиллагааны арга журмын дагуу гүйцэтгэдэг.

Мөн Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно”, 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална” (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) гэж заасан байдаг.

Иймд хэрэв төлбөр төлөгч нь гадаадын иргэн байгаа тохиолдолд түүний эрх зүйн байдлыг тогтоохдоо гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон тухайн иргэнийг харьяалсан улстай байгуулсан олон улсын гэрээний агуулгаар тодорхойлохоор байна. Иймд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний нөхцөлүүд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шууд нөлөөтэй байдлаар харагдаж байна.

Гэрээний үндсэн дээр эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагаа нь гэрээ байгуулагч улсууд нь эрх зүйн туслалцаа үзүүлэх арга замыг гэрээндээ тусгадаг. (Э.Байгал, 2024). Гэрээнд оролцогч улсууд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг өөрийн орны иргэний эрх зүйн байдлыг хангах, хамгаалах зорилгоор хийдэг тул зарим тохиолдолд албадлага хэрэглэх эрхийг хязгаарлагдмал байдлаар тодорхойлох нь бий.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэгч нь гадаад улсын иргэн, гадаад улсын Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хөрөнгө, олон улсын байгууллага, дипломат төлөөлөгчийн газрын хөрөнгөнд холбогдуулан иргэний шийдвэр гүйцэтгэх аливаа ажиллагаа явуулахын өмнө тухайн этгээд түүний хөрөнгө нь Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар халдашгүй, дархан эрх, ямба эдлэх эсэхийг тогтоох бөгөөд хэрэв ийм нөхцөл тогтоогдвол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахгүй ба үүнээс бусад тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг саадгүй зохион байгуулах үүрэгтэй.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хүрээнд тойргийн харьяаллын хэмжээнд явуулах бөгөөд өөр нутаг дэвсгэрт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр даалгавраар гүйцэтгэх зохицуулалттай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар “....Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу тухайн төлбөр төлөгч, түүний хөрөнгийн талаар мэдээлэл цуглуулах, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр төлөгчийн байнгын оршин сууж байгаа, эсхүл хөрөнгө нь оршин байгаа гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэн гүйцэтгэнэ” (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017) гэсний дагуу улс хооронд байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний хүрээнд дээрх ажиллагааг зохион байгуулна.

Шигтгээ: Бүгд Найрамдах Солонгос улсын тухайд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэг том онцлог нь БНСУ-ын газар нутаг дээр болон гадаад улсын нутаг дэвсгэр дээр иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжийг хуульд тусгайлан заасан байдаг. Гадаад Улсад албадан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах тохиолдолд тухайн гадаад Улсын нийтийн албатай хуулийн дагуу хамтран ажиллах боломжтой бол анхан шатны шүүх нь зөвлөгүүлэгчийн хүсэлтээр гадаадын нийтийн албанд эрх олгодог эсхүл гадаад улсад байрлах БНСУ-ын консул албадан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг

хэрэгжүүлэх боломжтой бол анхан шатны шүүх нь консулд эрх олгох замаар ажиллагаа явуулдаг (ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэн , 2021).

Монгол Улсад шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг. Гэвч төлбөр төлөгч нь гадаадын иргэн байх тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах онцлог асуудлууд үүсдэг. Үүнд:

- Төлбөр төлөгчийн оршин суугаа хаягийг тогтоох
- Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгө, орлогыг илрүүлэх
- Арилжааны банкин дахь дансыг битүүмжлэх, хасалт хийх
- Эд хөрөнгийг битүүмжлэх, хураан авах
- Олон улсын эрх зүйн хамтын ажиллагааг ашиглах зэрэг асуудлууд хамаарна.

Монгол Улсад гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх ажиллагаа нь зөвхөн үндэсний эрх зүй, газар нутгийн хэмжээгээр хязгаарлагдаж байгаа нь шийдвэр гүйцэтгэлийн үр нөлөөг хязгаарлаж буй сул тал болж байна.

Тэгвэл хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд төлбөр төлөгч гадаадын иргэнээс төлбөр гаргуулах ажиллагаа хэрхэн гүйцэтгэгдэж байгааг сонирхъё.

3. Практик нөхцөл байдал

Шийдвэр гүйцэтгэгч нь хуулиар эрх олгогдсон тойргийн хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулах бөгөөд ийнхүү явуулахдаа төрийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд мэдээлэл солилцох хэлбэрээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баталгаажуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

Төлбөр төлөгч гадаадын иргэнд холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад

❖ Монгол Улсын хилээр нэвтэрсэн эсэх,

❖ Оршин суугаа хаягийн бүртгэл хийгдсэн эсэх,

❖ Монгол улсад эд хөрөнгө эзэмшдэг эсэх,

❖ Арилжааны банкуудад харилцах болон хадгаламжийн данс эзэмшдэг эсэх талаарх лавлагаа мэдээллийн хүрээнд ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төлбөр төлөгч гадаадын иргэнд холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад түүний Монгол Улсын хилээр нэвтэрсэн эсэх, оршин суугаа хаягийн бүртгэл хийгдсэн эсэх, Монгол улсад эд хөрөнгө эзэмшдэг эсэх, арилжааны банкуудад харилцах болон хадгаламжийн данс эзэмшдэг эсэх талаарх лавлагаа, мэдээлэл зарим тохиолдолд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээний хүрээнд ажиллах нь нийтлэг байдлаар ажиглагдаж байна.

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэл хөтлөх журамд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас санаатай зайлсхийсэн “нэг төлбөр төлөгчид холбогдох хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгийн шаардлага 50.0 сая төгрөгөөс дээш бол төлбөр төлөгчийн гадаад зорчих эрхийг түдгэлзүүлэх” боломжтой. Гэвч төлбөрийн үнийн дүн 50.0 сая төгрөг хүрээгүй тохиолдолд энэ албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжгүй, эсхүл төлбөр төлөгч гадаадын иргэний Монгол Улсаас албадан гаргах үед энэхүү албадлагын арга хэмжээний ач холбогдол, үр нөлөө алдагдаж байна.


Жишээлбэл: Төлбөр төлөгч гадаадын иргэний оршин суух хаягийн мэдээлэл, гэр бүлийн гишүүдийн мэдээлэл болон визний төрөл ангилал, ямар хугацаатай олгогдсон, гадаадын иргэнийг орон байраар хангаж буй этгээдийн мэдээлэл, хаягийн шилжилт хөдөлгөөний мөн төлбөр төлөгч гадаадын иргэний нас барсан мэдээлэл эдгээр лавлагаа мэдээлэлд тусгагдахгүй явсаар өнөөг хүрчээ.

Ихэнх тохиолдолд төлбөр төлөгч гадаадын иргэний нэр дээр эд хөрөнгө, мөнгө тогтоогдоогүй, оршин суугаа хаяг

тодорхойгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, Монгол Улсын хилээр нэвтэрч гарсан зэрэг байдлаас хамааралтайгаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх хандлага практик байгууллагад өргөн ажиглагдаж байна.

Шийдвэр гүйцэтгэх албаны 2025 оны 08 дугаар сарын мэдээгээр Бүгд найрамдах Хятад ард улсын иргэн төлбөр төлөгчид холбогдох 95 гүйцэтгэх баримт бичгийн нийт 1.711.278.125 төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгээс 23 гүйцэтгэх баримт бичгийн 9.417.730 төгрөгийн төлбөрийг төлүүлж, 87 гүйцэтгэх баримт бичгийн 1.701.843.930 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэхүү дүнгээс үзвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт 0,08%-тай байна.

Зураг. 1 Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ШГА-нд гадаадын иргэдийн оролцооны график



Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчдын тухайд авч үзвэл ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ, ХБНГУ, Австрали, Турк, Казакстан зэрэг орны иргэдэд холбогдуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зураг. 2 БНХАУ-ын иргэдтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны график



Дээрх зургаас харвал гадаадын иргэнээс төлбөр гаргуулах ажиллагааны төлбөр төлөгдөөгүй шалтгааны 43% нь тодорхой эд хөрөнгөгүй, 31% нь бусад шалтгааны улмаас төлбөр төлөөгүй гэсэн хариултыг илэрхийлж байна. Шийдвэр гүйцэтгэх

ажиллагааны мэдээний хүснэгтэд дээрх шалгууруар мэдээг задлан авч үздэг бөгөөд бусад хэмээх хэсэгт Монгол Улсаас албадан гаргасан, шүүхээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн, нутаг буцсан зэрэг шалтгаануудыг хамаруулан авч үзэж болно.

Дээрх тоон мэдээ нь төлбөр төлөгч гадаад улсын иргэн болон гадаад улсын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдээс төлбөл зохих төлбөрийн үүрэг хангалттай биелэгдэхгүй байгааг мөн гадаадын иргэнд холбогдох ажиллагаанд байгаа нийт гүйцэтгэх баримт бичгийн 68.5% нь 3 ба түүнээс дээш жилийн хугацаанд биелэгдээгүй байгаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шуурхай байх, бүрэн бодитой биелэгдэх зарчим алдагдаж байгааг тодорхой харуулж байна.

4. Олон улсын гэрээний өнөөгийн байдал

Төлбөр төлөгч гадаадын иргэнээс төлбөр гаргуулах шийдвэр ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн төлбөр төлөгч гадаадын 60 иргэнийг улсаар нь авч үзвэл. Үүнд:

- Бүгд Найрамдах Хятад Ард улсын 29 иргэн;
- Оросын Холбооны улсын 9 иргэн;
- Бүгд Найрамдах Солонгос улсын 10 иргэн;
- Холбооны Бүгд Найрамдах Герман улсын 3 иргэн;
- Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсын 2 иргэн;
- Австрали улсын 4 иргэн;
- Америкийн Нэгдсэн улс, Япон, Казакстан улсын тус бүр 1 иргэн тус тус байна.

Судалгаанаас харахад Монгол Улсын тухайд газар нутгийн байршлаасаа хамааран Оросын холбооны улс болон Бүгд найрамдах Хятад ард улсын иргэд гадаадын иргэдийн тоон судалгааны ихэнх хувийг эзэлж байна. Манай орны эрх зүйн зохицуулалт болоод гадаад улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээний зохицуулалтын хүрээнд уг ажиллагааг идэвхжүүлэх боломж бий.

Оросын Холбооны улс:

Оросын холбооны улсын тухайд манай улстай 1999 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улс, Оросын холбооны улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээг байгуулсан (Оросын Холбооны Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ, 2026)

Энэхүү Гэрээнд зааснаар Хэлэлцэн тохирогч талууд шүүхийн шийдвэрийг харилцан биелүүлэх үүрэгтэй бөгөөд, Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гарсан иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаарх таслан шийдвэрлэх тогтоолын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэнэ. Харин хүүхдийн тэтгэлгийн хэргийн талаарх шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болоогүй байсан ч нэн даруй гүйцэтгэх үүрэгтэй.

Харин Монгол Улс, Оросын холбооны улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээгээр “иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа гэдэг”-т аж ахуй, гэр бүлийн болон хөдөлмөрийн зэрэг хүлээн зөвшөөрөгдөх эрх зүйн туслалцаа хамаарах бөгөөд хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт гаргасан шүүх, эрх бүхий байгууллагаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус шинжтэй иргэний хэргийн талаар гаргасан шийдвэр, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон хэсэг, шүүхийн зардлыг төлөх тухай шүүхээс гаргасан шийдвэр, иргэний хэргийн талаар шүүхээс гаргасан эвлэрэх хэлцэл зэргийг хүлээн зөвшөөрч, биелүүлнэ.

Мөн Хэлэлцэн тохирогч тал бүр нөгөө Талын хүсэлтээр эрх зүйн болон эрх зүйн бус баримт бичгийг хүргүүлэх, гардуулан өгөх, уг баримт бичгийн талаар зохигчид, гэрч шинжээчээс асууж тодруулах, үзлэг, шинжилгээ хийх буюу шалгаж нотлохтой

холбогдсон байцаан шийтгэх бусад ажиллагааг явуулна гэжээ.

Харин ОХУ-тай байгуулсан гэрээний хүрээнд төлбөр төлөгчийн хаяг тогтоох, эд хөрөнгөнд үзлэг нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, нас барсныг тогтоох зэрэг бусад ажиллагааг даалгавраар гүйцэтгүүлэх боломжтой.

Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас өнгөрсөн хугацаанд нийт 2 удаа Оросын холбооны улсад шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг хүргүүлсэн боловч хариу ирээгүй, хүсэлт үр дүнд хүрээгүй байна.

• Талууд өөрийн нутаг дэвсгэртээ гарсан эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг хариуцна.

• Иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор эд хөрөнгийг хураах

• Шүүхийн шийдвэрийг харилцан биелүүлэх

Бүгд найрамдах Хятад ард улс:

Бүгд найрамдах Хятад ард улстай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ (Хууль зүй, 2026) нь Хэлэлцэн тохирогч талын хүсэлтээр иргэний болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд бичиг баримт үйлдэх, илгээх, гардуулан өгөх, нэгжлэг хийх, эд мөрийн нотлох баримт болон хэргийн материалыг шилжүүлэх, хүлээн авах, шинжилгээ хийх зохигчид, гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдийг байцаах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахаар буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, ялтан этгээдийг ял эдлүүлэхээр шилжүүлэх, гэмт хэргийн үр дүнд авсан хөрөнгийг буцаах талаар арга хэмжээ авах, иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор эд хөрөнгийг хураах, шүүхийн шийдвэрийг харилцан биелүүлэх түүнчлэн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай бусад үйлдлийг хамааруулна.

Дээрх гэрээнүүдийн хүрээнд бид гэрээ байгуулж харилцан тохиролцсон улсын иргэнд холбогдох иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд төлбөр төлөгчийн оршин суугаа хаяг, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн болоод эд хөрөнгийн байдал, эрэн сурвалжлах ажиллагаа, эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх, хөрөнгийг битүүмжлэх, зарим тохиолдолд хураах, шинжээч томилуулах, тайлбар, мэдүүлэг авах, мэдэгдэл, зарлан, тогтоолын хувийг хүргүүлэх, төлбөр төлөгчийн нас барсан эсэхийг тогтоолгох, шаардлагатай тохиолдолд тухайн орны ижил чиг үүрэг бүхий байгууллагад холбогдох материалыг шилжүүлэн гүйцэтгүүлэх бүрэн боломжтой байна. Гэвч өнөөдрийн хүртэлх хугацаанд энэ гэрээний хүрээнд БНХАУ-д даалгавар хүргүүлсэн тоо баримт бүртгэгдээгүй байна.

Бүгд найрамдах Франц улс:

• Шүүхийн болон шүүхийн бус баримт бичгүүдийг нөгөө улсын нутаг дэвсгэр дээр суугаа хүмүүст гардуулах

• Даалгавар хүлээн авсан улс нь ШГА-ны зардлыг шаардах эрхтэй

• Өөрсдийн иргэнд хамаарах шүүхийн даалгаврыг ямар нэгэн албадлагагүйгээр дамжуулан гүйцэтгэх эрхтэй

• Иргэний гэр бүлийн байдлын талаарх хүсэлт, баримтуудыг дамжуулна

• Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх биелүүлэх

Бүгд найрамдах Казакстан улс:

• Өөрийн орны иргэдэд аливаа албадлагагүйгээр шүүхийн болон шүүхийн бус баримтыг гардуулж болно.

• Ял шийтгэлийн талаарх мэдээллийг шаардлага тавьсан талд өгөх

• Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх

• Хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн хариуцагчийг эрэн сурвалжлах

• Хэлэлцэн тохирогч тал дипломат шугамаар хүлээн авсан хүсэлтийн дагуу иргэний гэр бүлийн байдлын гэрчилгээ, боловсрол, ажилласан хугацааны мэдээ зэрэг иргэний хувийн болон эд хөрөнгийн эрх ашиг сонирхолд хамаарах бусад баримт бичгийг нөгөө талдаа үнэ төлбөргүй, орос хэлний орчуулгатай илгээнэ.

Эдгээр харилцан туслалцаа үзүүлэх гэрээг шийдвэр гүйцэтгэгч үйл ажиллагаандаа ашигладаггүй, гэрээнд

заагдсан тодорхой ажиллагааны чиглэлээр хэлэлцэгч улсууд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй зэргээс шалтгаалан гэрээний зохицуулалт хэрэгжихгүй байх нөхцөл бүрджээ.

Дүгнэлт

Дээрх судалгаанаас төлбөр төлөгч гадаадын иргэнээс төлбөр гаргуулах ажиллагааны өнөөгийн байдлыг дараах байдлаар дүгнэж болно.

1. Шүүхээс иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж, зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх, шударга ёсыг бэхжүүлж, хуулийн хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх зорилгоор шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа боловч шүүхийн шийдвэр биелээгүй тохиолдолд төр иргэнийхээ өмнө Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрнэ.

2. Төлбөр төлөгч гадаад улсын иргэн болон гадаад улсын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдээс төлбөл зохих төлбөрийн үүргийг хангалттай биелүүлж чадахгүй байгаа нь Шийдвэр гүйцэтгэх албаны тайлан, мэдээ, судалгаагаар тодорхойлогдож байна.

3. Түүнчлэн төрийн байгууллагын хамтын ажиллагааны уялдаа холбоо сул, мэдээлэл солилцох, тодорхой ажиллагааг хамтран гүйцэтгэх явдал хангалтгүй байгаа нь төлбөр төлөгч гадаад улсын иргэний монгол дахь хөрөнгө болон шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шаардлагатай бусад мэдээллийг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглахад хүндрэлтэй төдийгүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашрах нөхцөл болжээ.

4. Манай улсын эрх зүйн зохицуулалт болоод гадаад улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээний зохицуулалтын хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг идэвхжүүлэх боломж байгаа боловч авч энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийх хандлага практик байгууллагын хэрэгжүүлсэн баримтаас ажиглагдаж байна.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төлбөр төлөгч гадаадын иргэний талаарх дэлгэрэнгүй мэдээллийн сан болох Гадаадын иргэн харьяатын газрын цахим нэгдсэн сантай өнөөдрийг хүртэлх хугацаанд холбогдоогүй, 2 байгууллагын хамтран ажиллах талаар эрх зүйн баримт бичиг өнөөг хүртэл байхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэлээ.

Санал

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь, Гадаадын иргэн, харьяатын газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Гадаадын иргэдийн мэдээллийн нэгдсэн санг, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар ашиглах боломжийг бүрдүүлэх;

2. Монгол Улсын бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний ач холбогдлыг таниулах, гэрээний дагуу зохион байгуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх сургалтыг шийдвэр гүйцэтгэгч нарт зохион байгуулах;

3. Төлбөр төлөгч гадаад улсын иргэн болон гадаад улсын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдээс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд ОХУ, БНХАУ-руу шийдвэр гүйцэтгэгчийн даалгавар хүргүүлэх ажиллагааг зохион байгуулах;

4. Төлбөр төлөгч гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа, дэмжлэгийг нэмэгдүүлэх зэрэг санал дэвшүүлж байна.

Ашигласан материалын жагсаалт

Hoffman, T. (2005). *internationales Privatrecht* . Munchen .

Б.Алтангэрэл. (2005). *Иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа.* Улаанбаатар .

Б.Ундрах. (2021). *Иргэний хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гарын авлага* . Улаанбаатар .

ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэн . (2021). *Хуулийн этгээдээс*

төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт . Улаанбаатар .

Оросын Холбооны Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ. (2026). Retrieved from Хууль зүй, дотоод хэргийн яам: https://mojha.gov.mn/content/67c006a99fea4ca6d58c81e7

С.Энхцэцэг. (2025). *Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх эрх зүйн асуудал.* Улаанбаатар .

УИХ-ын Тамгын газар . (1992). Монгол Улсын Үндсэн хууль . *Төрийн мэдээлэл эмхэтгэл* .

УИХ-ын Тамгын газар. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. *Төрийн мэдээлэл эмхэтгэл*.

Үндэсний статистикийн хороо . (2020). *Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын тайлан* . Улаанбаатар .

Үндэсний статистикийн хороо . (2022). *Статистикийн мэдээ* . Улаанбаатар .

Хууль зүй, д. х. (2026). *Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ* . Retrieved from Хууль зүй, дотоод хэргийн яам : https://mojha.gov.mn/content/67c006a99fea4ca6d58c81e7

Хууль зүй, дотоод хэргийн яам . (2009). *Олон улсын хувийн эрх зүй. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нь* . Улаанбаатар .

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн. (2023). *ОУ-ын арбитрын шийдвэрийг биелүүлэх ажиллагааны эрх зүйн орчинтай холбоотой харьцуулсан судалгаа* . Улаанбаатар .

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба . (2022 он). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны мэдээ, судалгаа* . Улаанбаатар.

Э.Байгал. (2024). *Олон улсын хувийн эрх зүй* . Улаанбаатар .

ХОРИГДЛЫН ЗАН ҮЙЛИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН
SOME RESULTS OF THE RESEARCH ON PRISONER BEHAVIOR

О.Баяржаргал*
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, дэд хурандаа
Bayarjargal O.
Senior Researcher, Research Institute, Lieutenant Colonel

*Хариуцлагатай зохиогч: bayarjargalotgonbayar@gmail.com

Хураангуй: Энэхүү судалгаагаар хорих ял эдэлж буй хоригдлын гэмт хэргийн амьдралын хэв маяг, гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг болон зан үйлийн онцлогийг сэтгэл зүйн үнэлгээний аргачлалд тулгуурлан тодорхойлохыг зорив. Судалгаанд 18-73 насны нийт 419 хоригдол хамрагдсан бөгөөд нас, хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал, үйлдсэн гэмт хэргийн төрөл, давтамж, ял эдэлж буй хугацаа зэрэг нийгэм-хүн ам зүйн болон криминологийн үзүүлэлтүүдийг харьцуулан шинжилсэн. Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын тодорхой хэсэгт гэмт хэргийн амьдралын хэв маяг болон гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг тогтсон нь давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй хүчтэй хамааралтай байна. Ялангуяа олон удаа гэмт хэрэг үйлдсэн, урт хугацаанд ял эдэлж буй, мөн бага насандаа анх гэмт хэрэгт холбогдсон хүмүүст гэмт хэргийн амьдралын хэв маяг илүү төлөвшсөн нь тогтоогдсон. Түүнчлэн боловсролын түвшин доогуур байх тусам гэмт хэрэг үйлдэх сэтгэлгээ, зан үйлийн эрсдэл нэмэгдэх хандлага ажиглагдсан.

Судалгааны үр дүн нь хоригдлын сэтгэлгээ, зан үйлийн хэв маягийг эрт үеэс нь илрүүлэн үнэлэх, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн сэтгэл зүй, зан үйлийн хөтөлбөрийг ял эдлүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Мөн хоригдолд үзүүлэх үйлчилгээ нь хувь хүний онцлог, хэрэгцээнд суурилсан байх нь үр нөлөөтэй болохыг харуулсан.

Abstract: This study aimed to determine the criminal lifestyle, criminal mindset, and behavioral characteristics of prisoners serving prison sentences based on psychological assessment methods. A total of 419 prisoners aged 18-73 participated in the study, and socio-demographic and criminological indicators such as age, gender, education, marital status, type and frequency of crimes committed, and length of sentence were compared and analyzed. The results of the study show that the presence of a criminal lifestyle and criminal mindset in a certain group of participants is strongly correlated with the risk of recidivism. In particular, it was found that the criminal lifestyle was more established in those who had committed multiple crimes, were serving long sentences, and were involved in crime for the first time at a young age. In addition, the lower the level of education, the higher the risk of criminal thinking and behavior.

The results of the study indicate the need to implement psychological and behavioral programs that aim to identify and assess prisoners' thinking and behavior patterns early and reduce the risk of reoffending, in line with sentencing policies. It also shows that services provided to prisoners are effective when they are based on individual characteristics and needs.

Түлхүүр үг:Хоригдол, гэмт хэргийн сэтгэлгээ, гэмт хэргийн амьдралын хэв маяг, зан үйл, үнэлгээ

Keywords: Prisoner, criminal mindset, criminal lifestyle, behavior, evaluation

Гэмт хэрэг, гэмт үйлдлийн талаарх асуудал нь дан ганц хууль, эрх зүйн салбарт хамаарах зүйл нэгэнт биш болж, олон төрлийн мэргэжлийн чиглэлийн судалгаа, онолд тулгуурлан “гэмт хэрэг судлалын талаарх ойлголт”-ыг өргөн хүрээнд томьёолох шаардлага бий болж байна. Энэ нь гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэж буй учир шалтгааныг тодорхойлох, гэмт хэрэгтний хувийн онцлогийг судлах зэрэг олон талт үйл ажиллагаагаар тодорхойлогдоно.

Өнөөгийн нийгэмд гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд шорон барих нь шийдэл

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

биш гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд манай улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд нийт 149.338 гэмт хэрэг бүртгэгдэж (Үндэсний статистикийн хороо, 2024), гэмт хэргийн тоо болон гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн тоон үзүүлэлт жилээс жилд өсөх хандлагатай, гэмт хэргийн улмаас ял шийтгэл эдэлж буй хүмүүсийн тоо буурахгүй, түүнчлэн дахин гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн тоо 50 орчим хувьтай байгаа нь онцгой анхаарал татах асуудлын нэг юм.

Энэ байдал нь гэмт явдлын хор аюул өсөн нэмэгдэж, нийгэм, олон нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаагийн илрэл болж байна. Мөн гэмт хэргийн индекс гаргадаг олон улсын байгууллагын 2017 онд Монгол Улс дахь гэм хэргийн аюулгүй байдлын түвшин 32.8 хувь, иргэд гэмт хэрэгт өртөх эрсдэл буюу гэмт хэргийн түвшин 67.2 хувьтай байсан нь дэлхийн 118 улсаас 12 дугаарт орж байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар иргэдийн аюулгүй байдлын түвшин 37.4 хувь, гэмт хэргийн түвшин 62.5 хувьтай болж, 16 дугаар байрт оржээ. Харьцуулсан судалгааны дүнгээс үзэхэд Монголчуудын 70.5 хувь нь ойрын 3 жилийн хугацаанд гэмт хэрэг өснө гэж санаа зовниж байгаа бол эд хөрөнгөө хулгайд алдана, бусдын халдлагад өртөнө гэхээс 60 хувь нь түгшиж байна гэжээ. Дээрх судалгааны үр дүнгээс гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг бууруулах, олон нийтийн амар тайван, аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэхийн тулд сэтгэл судлалын төлөөлөгчид гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй хүний сэтгэл зүйн хүчин зүйлд анхаарлаа хандуулж судалсаар байна. Гэмт хэргийн сэтгэл зүйн бүтцийг тодорхойлсноор гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлөх шалтгааны илрүүлэх, оновчтой нөлөөлөл үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэх ач холбогдолтой.

Хэдийгээр гэмт хэрэг нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг тооцдог ч сэтгэл зүйн онцлог бүхий өвөрмөц үйл ажиллагаа болохын хувьд гэмт үйлдэл хийх сэтгэлгээ, түүний илрэл болох гэмт зан үйлийг судлах шаардлагатай юм.

Гэмт хэрэг үйлдэхэд зорилго, сэдэл, гэмт зан үйл, тухай хүний гэмт бодол санааг хэрэгжүүлэх гадаад орчин, хүчин зүйл, нөхцөл бүрдсэн байдаг талаар гэмт хэрэг судлалд авч үздэг авч үздэг ч зарим судлаачдын хувьд гэм бурууг хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэл, түүний хор уршигт хандах сэтгэхүйн харьцаа (Совд, 1971), ухамсар болон хүсэл хэрэгцээ нь гэм бурууғийн агуулгыг бүрдүүлдэг хүний сэтгэхүйн үйл ажиллагааны элемент бөгөөд танин мэдэхүйн шинжтэй байна гэж үзжээ. (Нарангэрэл, 2001).

Түүнчлэн гэмт хэрэг болоод эрх зүйн зөрчил гаргахад хүргэдэг бие хүний нийгэмших үйл явцтай холбоотой зан төлөв, сэтгэл зүйн сөрөг шинжүүдийн нийлбэр цогцыг гэмт явдлын нийгэм-сэтгэл зүйн шалтгаан гэж тодорхойлсон байна. Эдгээр шалтгаанууд нь нийгмийн хүчин зүйлүүдээр нөхцөлдөг ч санамсар, болгоомжгүй байдлаар үйлдсэн гэмт хэргийн хувьд ч сэтгэл зүйн сөрөг хүчин зүйлүүд нэгэн адил нөлөөлдөг болохыг тэмдэглэжээ. (Дагель, 2001).

Асуудал, бэрхшээлийг хялбар аргаар шийдвэрлэх, бусдад учруулсан хор хохирлыг ухамсарлаж ойлгодоггүй, түүнээс гарах үр дагаварыг урьдчилан тооцдоггүй бөгөөд гэмт үйлдэлдээ бус баривчлагдах зэрэг “шийтгэл”-д ач холбогдол өгч харамсах алдаатай бодол санааг гэмт хэргийн сэтгэлгээ гэж үздэг ба энэ нь амьдралын хэв маягаар тодорхойлогддог байна. (Бриан Лүбиг, 2016).

Иймд гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн гэмт хэргийн амьдралын болон сэтгэлгээний хэв маягийг судалж, эрсдэлийг үнэлэх замаар тэдний зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Энэхүү судалгааны ажилд гэмт хэргийн амьдралын болон сэтгэлгээний хэв маягийг тодорхойлох стандарт сорилуудыг ашигласан. Гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг нь ял эдэлж буй хүмүүс аливаа зүйлийг хэрхэн тусгаж авах буюу хүртэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь гэмт зан үйл

үйлдэх үндэс суурь болдог. Гэмт хэргийн сэтгэлгээ нь гэмт хэргийн амьдралын хэв маягийг бүрдүүлэгч танин мэдэхүйн үйл явц юм. Гэмт хэргийн амьдралын хэв маягийн онолын үүднээс аливаа хүн зөвхөн нөхцөл байдлаас шалтгаан гэмт хэрэг үйлдэх сонголт хийдэггүй, үүнээс гадна танин мэдэхүйн буюу сэтгэлгээний хэв маяг нөлөөлдөг гэж үздэг. Өөрөөр хэлбэл нөхцөл байдал нөлөөлж болох хэдий ч ямар үйлдэл хийх талаарх шийдвэрт тухайн хүний сэтгэлгээний хэв маяг чухал нөлөө үзүүлдэг. Гэмт хэрэг үйлдсэн хүмүүс өөрийнхөө болон бусдын талаар, мөн орчлон ертөнц дэх өөрийн байр суурийн талаар хэрхэн бодож сэтгэдэг болох нь тэдний гэмт хэрэг үйлдэх сонголтод шийдвэрлэх нөлөөтэй юм.

Судлуулагчийн ерөнхий мэдээллийг нас, хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал, үйлдсэн гэмт хэргийн төрөл, давтамж, ял шийтгэлийн хугацаа зэрэг үндсэн асуултын дагуу цуглуулж, тодорхой дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ бусад сорилын үр дүнг эдгээр үзүүлэлтээр харьцуулан судалсан.


Судалгаанд ашигласан нийгэм, хүн ам зүйн болон гэмт хэргийн үзүүлэлтэд хамрагдах мэдээллийг сонгохдоо онолын үзэл баримтлалын хүрээнд авч үзсэн статик болон динамик хүчин зүйлийг харгалзсаны зэрэгцээ манай улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралт, гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй хүмүүсийн ерөнхий мэдээлэлд тулгуурлан түүврийг бүрдүүлсэн.

Судалгаанд нийт 18-73 насны 419 хүн хамрагдсан. Эрэгтэйчүүдийн насны дундаж 37.4, эмэгтэйчүүдийн насны дундаж 39 байв.

Зураг 1. Хүйс



Зураг 2. Нас




Судалгаанд оролцогчдын боловсролын түвшинг авч үзвэл нийт судлуулагчдын 20 орчим хувийг дээд боловсролтой хүмүүс, 50 гаруй хувийг бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой хүмүүс, харин 2 хувийг бичиг үсэг үл мэдэх хүмүүс эзэлж байна.

Зураг 3. Боловсролын түвшин



Зураг 4. Гэрлэлтийн байдал



Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 32.6 хувь нь гэрлэсэн, 27.2 хувь нь салсан, 40.2 хувь нь гэрлээгүй, ганц бие бөгөөд гэрлээгүй хүмүүсийн 18.1 хувь нь хүүхэдтэй, 22.1 хувь нь хүүхэдгүй хүмүүс байна. Гэрлэлтийн байдлыг хүйсээр нь авч үзвэл эмэгтэйчүүдийн хувьд гэрлэсэн, гэрлээгүй, салсан хүмүүсийн эзлэх хувь ойролцоо буюу тус бүр 1/3 орчим байв. Харин эрэгтэйчүүдийн хувьд гэрлээгүй хүмүүс салсан болон гэрлэсэн хүмүүсээс 12-18 орчим хувиар илүү байна. Харин насны бүлгээр авч үзвэл 18-24 насныхны ихэнх нь гэрлээгүй, бусад бүх насны бүлгийн хувьд ойролцоогоор 30-40 орчим хувь нь огт гэрлээгүй хүмүүс байна.

Хорих ангийн хэлбэрийг авч үзвэл нээлттэй, хаалттай хэлбэрийн хорих ангид ял эдэлж буй хүмүүс 50, 50 хувийг эзэлж байна. Эмэгтэйчүүдийн 14 хувь, эрэгтэйчүүдийн 60 орчим хувь нь хаалттай хэлбэрийн хорих ангид ял эдэлж буй судлуулагчид байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн төрлийг авч үзвэл 2/5 нь хүн амины буюу хүний амьд явах эсрэг гэмт хэрэг, бусад нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг буюу хүчин, хулгай, дээрэм, залилан, хүн худалдаалах, хар тамхи, хүний эрүүл мэндэд хохирол учруулах болон бусад хэлбэрийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүс байна. Бусад гэдэгт өмчлөх эрхийн эсрэг, сонгуульд саад учруулах, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах, хууль бус ан хийх, бусдын эд хөрөнгийг гэмтээх, авахаар заналхийлэх гэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг багтаасан болно.

Хар тамхи, залилан, хүн худалдаалах, дээрэмдэх, хүний эрүүл мэндэд хохирол учруулах болон бусад төрлийн гэмт хэргийг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс илүү их үйлддэг байж болзошгүйг судалгааны үр дүн харуулж байна.

Хүснэгт 5. Гэмт хэрэг үйлдсэн давтамж (хүйс, нас, боловсрол, гэмт хэргийн төрлөөр)

Хүйс	Анх удаа	2-3 удаа	4-5 удаа	6 ба дээш
Эрэгтэй	73.2 %	20.6%	3.7%	2.5%
Эмэгтэй	89.6%	8.3%	1.0%	1.0%
Насны бүлэг				
18-24 нас	89.7%	10.3%	0.0%	0.0%
25-34 нас	81.8%	16.2%	0.7%	1.4%
35-44 нас	72.6%	18.9%	6.6%	1.9%
45-54 нас	71.1%	23.7%	2.6%	2.6%
55-75 нас	47.3%	14.3%	8.6%	2.9%
Боловсролын түвшин				
Дээд боловсрол	90.4%	8.4%	1.2%	0.0%
Мэргэжлийн боловсрол	68.4%	31.6%	0.0%	0.0%
Бүрэн дунд боловсрол	80.9%	12.8%	3.5%	2.8%
Бүрэн бус дунд боловсрол	66.7%	22.6%	7.1%	3.6%
Бага боловсрол	68.6%	25.7%	2.9%	2.9%
Бичиг үсэг мэдэхгүй	75%	12.5%	0.0%	12.5
Гэмт хэргийн төрөл				
Хүн амины хэрэг	41.9%	46.3%	41.7%	50%
Хар тамхи	6.3%	3.7%	0.0%	0.0%
Хулгай	7.7%	14.8%	16.7%	33.3%
Залилан	7.4%	7.4%	8.3%	0.0%
Хүн худалдаалах	1.5%	1.9%	0.0%	0.0%
Дээрэмдэх	6.3%	9.3%	8.3%	16.7%
Хүчиндэх	15.8%	7.4%	16.7%	0.0%
ЭМ-д хохирол учруулах	7%	5.6%	0.0%	0.0%
Бусад	6.3%	3.7%	8.3%	0.0%

Гэмт хэрэг үйлдсэн давтамжийг үйлдсэн гэмт хэргийн төрлөөр харьцуулж үзэхэд 1-3 удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн дунд бүх төрлийн гэмт хэрэг ажиглагдсан бол 4 ба түүнээс олон удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн дунд хүн худалдаалах, хар тамхины болон хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг ажиглагдаагүй болно. 6 ба түүнээс олон удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн дунд хүн амины хэрэг, хулгайлах, дээрэмдэх гэсэн 3 төрлийн гэмт хэрэг зонхилж байна. Энэ нь бүх төрлийн гэмт хэрэгт хүн суралцдаг тухай дифференциаль ассоциацийн онолын үзэл санааг бататгахын зэрэгцээ олон жилийн хугацаанд ял эдлэх, давтан гэмт хэрэг үйлдэх байдал нь хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээр илэрч байна.

Хүснэгт 6. Гэмт хэргийн амьдралын хэв маягийн ерөнхий онооны түвшин /гэмт хэргийн төрлөөр/

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн амьдралын хэв маяг бүрдэх эрсдэлийн түвшин		
	Бага	Дунд	Өндөр
Хүн амины хэрэг	59.8%	24.6%	15.6%

Хар тамхи	22.4%	17.6%	60.0%
Хулгай	53.6%	39.3%	7.1%
Залилан	23.6%	27.3%	49.1%
Хүн худалдаалах	40.0%	20.0%	40.0%
Дээрэмдэх	75.0%	15.0%	10.0%
Хүчиндэх	64.9%	24.3%	10.8%
ЭМ-д хохирол учруулах	66.7%	33.3%	0.0%
Бусад	83.3%	11.1%	5.6%

14 ба түүнээс доош насандаа анх гэмт хэрэгт холбогдож баривчлагдсан хүмүүс 14-19 насандаа болон 19 ба түүнээс дээш насандаа анх баривчлагдсан хүмүүсээс илүү гэмт хэргийн амьдралын хэв маягтай болсон байгааг судалгааны үр дүн харуулсан.

Судалгааны үр дүнгээр судалгаанд оролцогчдын 14.3 хувь нь түрэмгийллийн шинж чанар (бусдад халдах, нийгмийн дүрэм журам зөрчих) бүхий зан үйлийн гажуудалтай, харин 85.7 хувь нь гэмт хэрэгт түлхэц өгөхүйц (өөрийгөө зөвтгөх, хариуцлагагүй байдал) зан үйлийн гажуудалтай гэсэн үр дүн гарсан.

Хариуцлагагүй байдлын хувьд судлуулагчдын ихэнх нь /91 хувь/ дунд зэргийн эрсдэлтэй, 2.4 хувь нь бага зэрэг эрсдэлтэй, 6.2 хувь нь өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. Үүнээс үзвэл өндөр эрсдэлтэй хувь нь бусад орны жишээтэй ижил, харин бага эрсдэлтэй хувь нь бусад орны жишээнээс доогуур байна. Өөрийгөө зөвтгөх нь өндөр эрсдэлтэй хувь бусад үзүүлэлтүүдээс хамгийн их /9.5 хувь/, бага эрсдэлтэй нь 20 орчим хувийг эзэлж байна.

Хүснэгт 7. Гэмт хэргийн амьдралын хэв маягийн 4 үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Бусад орны жишээ		Бидний судалгаа	
	Бага эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй	Бага эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй
Хариуцлагагүй байдал	11-23.6	2.8-7	2.4	6.2
Өөрийгөө зөвтгөх			17.9	9.5
Бусдад халдах	42.9	9.0	53.6	1.9
Нийгмийн дүрэм журам зөрчих	11-23.6	2.8-7	71	1.0

Бусдад халдаж түрэмгийлэл үйлдэх үзүүлэлтийн хувьд ойролцоогоор 2 хувь нь өндөр эрсдэлтэй, 54 хувь нь бага эрсдэлтэй байна. Үүнийг бусад орны жишээтэй харьцуулбал, өндөр эрсдэлтэй нь 7 хувиар доогуур, бага эрсдэлтэй нь 10 хувиар дээгүүр байна. Нийгмийн дүрэм журам зөрчих үзүүлэлтийн 1 хувь өндөр эрсдэлтэй, 71 хувь нь бага зэрэг эрсдэлтэй байна. Энэ нь барууны орнуудын жишээтэй харьцуулахад эрсдэлийн түвшин доогуур гэж үзэж болохоор байна. Эдгээр нь тухайн улсын гэмт хэрэг, зөрчлийн гаралт, хууль зүйн хариу арга хэмжээтэй холбоотой байж болох бөгөөд манай улсын хувьд гэмт хэрэг өдөөгч, түлхэц болох хувь хүний хүчин зүйлс давамгайлж байна.

Судалгааны үр дүнгээс онцлон авч үзвэл Гэмт хэргийн амьдралын хэв маяг нь гэмт хэрэг үйлдсэн давтамж, ял эдэлж буй хугацаатай хамгийн өндөр хамааралтай байгаа нь олон давтан гэмт хэрэг үйлдэж, удаан хугацаагаар ял эдэлж буй хүмүүст Гэмт хэргийн амьдралын хэв маяг бий болсон төдийгүй цаашид ч дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй болох нь харагдаж байна. Мөн гэмт хэрэгт эрт буюу 14-өөс доош насандаа холбогдсон хүмүүст гэмт хэргийн амьдралын хэв маяг илүү бүрэлддэг болохыг нотолж байна.

Боловсролын түвшнээр харьцуулсан үзүүлэлтээс харахад бичиг үсэг мэдэхгүй хүмүүсийн 75 хувьд нь гэмт хэрэг үйлдэх сэтгэлгээ бий болсон, үүнээс 25 хувь нь маш их гэсэн хүрээнд багтаж байсан бол дээд боловсролтой хүмүүсийн 15 хувь нь тус хүрээнд багтжээ. Харин тус 2 бүлгийн хувьд бага эрсдэлтэй гэсэн хүрээнд хамрагдах хүн нэг ч гараагүй байна. Эдгээр нь дээд боловсролтой болон бичиг үсэг мэдэхгүй хүмүүст гэмт хэргийн сэтгэлгээ бусад бүлгийнхээс илүү бүрдсэн байгааг илэрхийлж байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 10 орчим хувьд нь гэмт хэргийн амьдралын хэв маяг бүрдсэн, 60 орчим хувьд нь гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг бий болсон байна. Үүний дотор 12 хувь нь гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг бий болсон байх өндөр эрсдэлтэй буюу гэмт хэрэг үйлдэх итгэл үнэмшил маш их байна. Гэмт хэргийн амьдралын хэв маяг болон гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг болон гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг нь өөр хоорондоо хүчтэй хамааралтай байгаа нь статистик шинжилгээний үр дүнгээс харагдсан.

Гэмт хэргийн амьдралын болон гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг бий болоход нийгэм, хүн ам зүй, гэмт хэргийн үзүүлэлтүүд харилцан адилгүй нөлөө үзүүлж байгааг илрүүлсэн. Тухайлбал, гэмт хэргийн амьдралын болон сэтгэлгээний хэв маяг нь хүйс ба настай хамааралгүй буюу эдгээр үзүүлэлт нөлөөлдөггүй байна. Гэмт хэргийн амьдралын болон сэтгэлгээний хэв маяг тус бүрийн тоон утга нь хүйсийн хувьд маш ойролцоо байсан бөгөөд энэ нь статистик шалгуураар ч мөн батлагдсан. Тиймээс нэгэнт гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүмүүст гэмт хэргийн сэтгэлгээний болон амьдралын хэв маяг бий болох магадлал ижил гэж үзлээ.

Тоон үзүүлэлтээр гэмт хэргийн амьдралын хэв маяг болон гэмт хэргийн сэтгэлгээний хэв маягийн оноо 18-24, 55-75 насныханд бага, 25-54 насныханд өндөр гарсан боловч эдгээр нь статистикийн ач холбогдол бүхий ялгаа биш болох нь илэрсэн байна. Гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг болон гэмт хэргийн амьдралын хэв маяг нь боловсролын түвшнээс хамаарч байна. Тухайлбал, Гэмт хэргийн амьдралын хэв маягийн бага эрсдэлтэй хувийн жин боловсролын түвшин доошлох тусам буурч, өндөр эрсдэлтэй хувийн жин ихэссэн бөгөөд боловсролын түвшин тус бүрийн хооронд нь статистикийн ач холбогдол бүхий ялгаа байгаа нь дээрх дүгнэлтийг баталж байна. Харин гэмт хэргийн сэтгэлгээний хэв маягийг тодорхойлоход ашигласан 2 аргачлалаар бичиг үсэг мэдэхгүй хүмүүст гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг бий болох магадлал өндөр болох нь ижил илэрсэн.

Гэр бүлтэй хүмүүст гэмт хэргийн амьдралын хэв маяг бий болох магадлал хамгийн бага байсан бөгөөд үүнийг статистик шинжилгээний үр дүн ч баталсан. Гэмт хэргийн сэтгэлгээний хэв маягийн хувьд 2 судалгаагаар гэрлээгүй хүмүүст гэмт хэрэг үйлдэх итгэл үнэмшил гэр бүлтэй болон гэр бүл салсан хүмүүсээс бага гэсэн ижил үр дүн гарсан.

Гэмт хэргийн үзүүлэлт болох үйлдсэн гэмт хэргийн төрөл, давтамж, анх баривчлагдсан нас, ял эдэлж буй хугацаа зэрэг нь бүгд гэмт хэргийн амьдралын хэв маягт нөлөөлдөг болохыг судалгааны үр дүн харуулсан. Гэмт хэргийн давтамж болон ял эдэлж буй хугацаа их байх тусам, харин анх баривчлагдсан нас эрт байх тусам гэмт хэргийн амьдралын хэв маяг бий болох өндөр эрсдэлтэй болох нь илэрсэн. Гэмт хэргийн төрлөөс хүн худалдаалах, хар тамхи болон залилах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн дунд гэмт хэргийн амьдралын хэв маяг бий болох эрсдэл өндөр байна.

Гэмт хэрэг үйлдсэн давтамж, ял эдэлж буй хугацаа нэмэгдэх тусам Харин гэмт хэргийн сэтгэлгээний хэв маягийн эрсдэл өндөр байна. Үйлдсэн гэмт хэргийн төрлийн хувьд гэмт хэргийн сэтгэлгээний хэв маягийг тодорхойлох сэтгэл зүйн үнэлгээгээр хар тамхи, залилах, хүн худалдаалах гэмт хэрэг, харин гэмт хэрэг үйлдэх сэтгэлгээний хэв маягийн хэмжүүрээр залилах, хүн худалдаалахаас гадна дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүс хамгийн өндөр эрсдэлтэй байна. Гэмт хэргийн сэтгэлгээний хэв маягийг

тодорхойлох сэтгэл зүйн үнэлгээгээр гэмт хэргийн амьдралын хэв маягтай адил анх баривчлагдсан нас эрт байх тусам гэмт хэргийн сэтгэлгээний хэв маяг бий болох эрсдэл өндөр гэсэн үр дүн гарсан боловч анх баривчлагдсан насны хувьд өөр бүлгүүдийн дунджийн хоорондох ялгаа статистикийн хувьд төдийлөн ач холбогдолгүй байна.

Гэмт хэргийн амьдралын хэв маягийн түрэмгийллийн болон түлхэц хүчин зүйлийн шинжилгээгээр судалгаанд оролцсон хүмүүсийн цөөнх нь (15 хувь) хүчирхийлэл, түрэмгийллийн шинж чанар бүхий зан үйлийн нэг гажуудалтай дийлэнх (85 хувь) нь хариуцлагагүй, аливаа зүйлд тууштай бус, үр дагаврыг нь үл харгалзан ямар ч хамаагүй аргаар таашаал эдлэхийг эрхэмлэдэг зан үйлийн гажуудалтай болох нь тодорхойлогдсон бөгөөд эдгээр зан үйлийн гажуудал нь тэдний гэмт хэргийн амьдралын хэв маягийн онцлогийг илэрхийлж байна.

Харин гэмт хэргийн сэтгэлгээний хэв маягийн проактив, реактив хүчин зүйлийн шинжилгээгээр нийт судлуулагчдын дунд гэмт хэрэгтнийг санамсаргүй үйлддэг болон төлөвлөж үйлддэг хүмүүс бараг ойролцоо буюу тэдний хооронд маш бага хувийн ялгаа (8 хувь) байгаа нь гэмт хэргийг үйлдэгчид санаатай, санамсаргүй аль аль шалтгаанаар үйлддэг болохыг харуулж байна. Залилах болон хүн худалдаалах гэмт хэрэг үйлддэг хүмүүст проактив сэтгэлгээний хэв маяг өндөр илэрсэн нь тус гэмт хэргийг урьдчилан төлөвлөж, зохион байгуулалттайгаар үйлддэг болохыг батлан харуулсан. Харин бусдын эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг үйлдсэн реактив сэтгэлгээний хэв маяг өндөр илэрсэн нь тухайн гэмт хэргийг цочмог байдлаар буюу биеэ барих чадваргүй, гэнэт огцом үйлддэг болох нь тодорхой байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дунд тэвчээргүй, тогтворгүй, тавьсан зорилго, итгэл үнэмшилдээ тууштай ханддаггүй, төлөвлөсөн зүйлээ биелүүлдэггүй (тууштай бус байдал), гэмт хэрэг үйлдэхэд саад болох зүйлийг таслан зогсоохын тулд хараал хэлэх, архи, мансууруулах бодис хэрэглэх зэрэг янз бүрийн аргаар гэмт хэрэг үйлдэхтэй холбоотой айдас болгоомжлол, эргэлзээ тээнэгэлзээ арилгахыг хичээдэг (хөөн зайлуулах буюу таслан зогсоох), эрх мэдэлгүй, чадваргүй байдал, сул талаа бусдад мэдэгдэхгүйн үүднээс дайрч доромжилж, хүчирхийлэх замаар айлган сүрдүүлж, бусдыг эрхийг үл хүндэтгэн, балмад хэрцгий зангаар удирдан хянаж, эрх мэдэлтэй байх (эрх мэдлээ мэдрүүлэх) зэрэг сэтгэлгээний хэв маягууд давамгай илэрлээ.

Санал

Хорих ангид олон удаа, удаан хугацаагаар ял эдлэх нь дахин гэмт хэрэг үйлдэх сөрөг нөхцөл байдал, сонголт хийх боломжийг нэмэгдүүлдэг болохыг харгалзан ял эдлүүлэх тогтолцоонд оновчтой хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бодлогын өөрчлөлт хийхэд анхаарах.

Гэмт хэргийн сэтгэлгээ нь дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг нөхцөлдүүлж буйг харгалзан гэмт хэргийн сэтгэлгээний хэв маягийг илрүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй бүлгийг тодорхойлж, тэдэнд чиглэсэн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авах нөхцөлийг тогтолцооны хувьд бүрдүүлэхэд анхаарах.

Гэмт хэргийн сэтгэлгээний хэв маягийг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагааг ял эдлүүлэх үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулж, ял эдлүүлэх бодлогод тусгах.

Хорих ангид ял эдэлж буй бүх хоригдлыг хамарсан арга хэмжээ, үйлчилгээнээс хувь хүний сэтгэлгээний хэв маяг онцлог, өвөрмөц хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээ илүү үр дүнтэйг анхаарах.

Ашигласан материалын жагсаалт

1. Мягмар. О, Хүний хөгжлийн сэтгэлзүйн лекцүүд. Гурав дахь удаагийн хэвлэл. Улаанбаатар 2012

2. Совд. (1971). Гэм буруугийн тухай ойлголт ба сэтгэхүйн хандлага. Улаанбаатар хот.

3. Нарангэрэл, С. (2001). Эрүүгийн эрх зүйн онолын асуудлууд. Улаанбаатар хот.

4. Дагель, П. С. (2001). Гэмт явдлын нийгэм-сэтгэл зүйн шалтгаан. Москва хот.

5. Лүбиг, Б. (2016). Criminal thinking and lifestyle patterns.

6. Bandura A. (1989), Regulation of cognitive processes through perceived self-efficacy, DP №25, p.729.

7. Bandura A., (1977), Social-learning theory, Englewood Cliffs, NJ: Prentice-Hall.

8. Bandura, A., Self-efficacy: The exercise of control, New York: Freeman, 1997. Chown, P., Understanding Risk Taking Behaviour, Section 3.3, 2014. Dohmen, T., Falk, A., Huffman, D., Sunde, U., Schupp, J., Wagner, G. G., Journal of the European Economic Association, Vol 9(3), pp.522-550, 2011.

9. Richard Jessor. Problem Behavior Theory A Half-Century of Research on Adolescent Behavior and Development, 2014

10. Karin Machluf, David F. Bjorklund Understanding Risk-Taking Behavior: Insights from Evolutionary Psychology, 2015

11. Klaus Hurrelmann & Jürgen Raithel. Risk Behavior in Adolescence The relationship between developmental and health problems cite this article: DOI: 10.1080/02673843.2005.9747958 To link to this article: https://doi.org/10.1080/02673843.2005.9747958

НИЙГМИЙН ҮЛ ҮЗЭГДЭХ БҮЛЭГ: ЭЦЭГ, ЭХ НЬ ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ХҮҮХДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

THE INVISIBLE SOCIAL GROUP: THE SITUATION OF CHILDREN WHOSE PARENTS ARE INCARCERATED

Н.Удвалцэцэг*
Дотоод хэргийн их сургуулийн докторант, хошууч
Udvaltsetseg N.
Doctoral candidate at the University of Internal Affairs, major

*Хариуцлагатай зохиогч: uudaa380@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь Монгол Улсад эцэг, эх, асран хамгаалагч нь хорих ял эдэлж буй 0-18 хүртэлх настай хүүхдүүдийн нийгмийн хамгааллын нөхцөл байдал, асран хамгаалын бүтэц, бодлогын орчны сул талыг шинжлэхэд чиглэн, баримт бичгийн шинжилгээний аргыг ашигласан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2026 оны 03 дугаар сарын статистик тоо баримтад тулгуурлан дүн шинжилгээ хийлээ.

Судалгааны дүнгээр Монгол Улсад нийт 2551 хоригдлын 3778 хүүхэд бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн дийлэнх нь 0-10 насны асран хамгаалал, сэтгэл зүйн дэмжлэг өндөр шаарддаг насны бүлэгт хамаарч байна. Мөн 3582 хүүхдийн эцэг, 196 хүүхдийн эх нь хорих ял эдэлж байгаа нь гэр бүлийн бүтэц, хүүхдийн өдөр тутмын хамгаалал, эдийн засгийн баталгаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Асран хамгаалын байдлыг авч үзэхэд эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийн ихэнх нь гэр бүлийн бусад гишүүний асрамжид амьдарч байгаа боловч тодорхой хэсэг нь асрамжийн байгууллагад болон тодорхойгүй нөхцөлд амьдарч байгаа, тэдний талаарх бүртгэл судалгаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байдаггүй нь хүүхэд хамгаалын тогтолцоонд бодлого хуулийн хэрэгжилт сул болохыг харуулж байна. Түүнчлэн эдгээр хүүхдүүд нийтлэг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй хэдий ч тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн тусгайлсан бодлого, үйлчилгээ, сэтгэл зүйн дэмжлэгийн тогтолцоо хангалтгүй байгаа нь тэднийг нийгмийн хамгаалын тогтолцоонд “үл үзэгдэх бүлэг” байдлаар орхигдуулах эрсдэлийг бий болгож байна.

Иймд эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийг нийгмийн хамгаалын тогтолцоонд бие даасан зорилтот бүлэг болгон албан ёсоор хүлээн зөвшөөрөх, статистик бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар дундын уялдаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөн тэдэнд чиглэсэн тусгай хамгаалын бодлого, үйлчилгээ, сэтгэл зүйн дэмжлэгийн цогц тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Abstract: This article aims to examine the social protection conditions, caregiving structure, and policy gaps affecting children aged 0–18 whose parents or guardians are serving prison sentences in Mongolia. The study employed document analysis as its main research method and conducted analysis based on statistical data from the General Executive Agency of Court Decision for March 2026.

The findings show that a total of 3,778 children of 2,551 incarcerated individuals were registered in Mongolia, the majority of whom belong to the 0–10 age group, which requires a high level of caregiving and psychological support. In addition, the fathers of 3,582 children and the mothers of 196 children are serving prison sentences, indicating potential negative impacts on family structure, children’s daily protection, and economic security.

Regarding caregiving arrangements, most of these children live under the care of other family members; however, a certain proportion reside in institutional care or in unknown living conditions. This reveals policy and implementation gaps within the child protection system. Furthermore, although these children are generally covered by mainstream social welfare services, the lack of specialized policies, services, and psychological support tailored to their specific needs creates a risk of their exclusion as an “invisible group” within the social protection system.

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Therefore, the study concludes that it is necessary to officially recognize children with incarcerated parents as an independent target group within the social protection system, improve statistical registration systems, strengthen intersectoral coordination and cooperation, and develop a comprehensive system of specialized child protection policies, services, and psychological support.

Түлхүүр үгс: Эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхэд, хүүхдийн эрх, нийгмийн хамгаалал, асран хамгаалал, хүүхэд хамгаалал, бодлогын цоорхой

Keywords: children with incarcerated parents, children's rights, social protection, caregiving, child protection, policy gap, invisible group.

Сүүлийн жилүүдэд эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийн асуудал олон улсын хэмжээнд хүүхдийн эрх, нийгмийн хамгааллын чухал асуудлын нэг болж байна. Судлаачид эдгээр хүүхдүүдийг сэтгэл зүй, боловсрол, нийгмийн оролцоо, эдийн засгийн нөхцөл байдлын хувьд өндөр эрсдэлтэй бүлэгт хамааруулан үзэх болсон бөгөөд эцэг, эх нь хорих ял эдлэх байдал нь хүүхдийн амьдралд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлдэг болохыг тогтоосон байдаг. (Murray, J., Farrington, D. P., Sekol, I., & Olsen, 2012)

Эцэг, эх нь хорих ял эдлэх явдал зөвхөн тухайн хүний эрх зүйн байдалд нөлөөлөөд зогсохгүй гэр бүлийн бүтцэд өөрчлөлт оруулж, хүүхдийн өсөлт хөгжил, аюулгүй байдал, сэтгэл зүй, боловсролын орчинд шууд болон шууд бусаар нөлөөлдөг. Ялангуяа бага насны хүүхдүүдийн хувьд асран хамгаалалт тасалдах, гэр бүлийн тогтвортой байдал алдагдах, орлогын эх үүсвэр буурах зэрэг эрсдэл өндөр байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхэд бүр ялгаварлалгүйгээр хамгаалуулах эрхтэй бөгөөд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд хангах үүргийг улс орнуудад хүлээлгэсэн байдаг (Nations., 1989). Гэвч практик түвшинд эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийг тусгайлан тодорхойлсон бодлого, хамгаллын механизм олон оронд хангалтгүй хэвээр байна.

Монгол Улсад хүүхэд хамгаллын тогтолцоо хөгжиж байгаа хэдий ч эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийг бие даасан зорилтот бүлэг болгон хүлээн зөвшөөрсөн бодлого, эрх зүйн зохицуулалт тодорхой бус хэвээр байна. Үүний улмаас эдгээр хүүхдүүд "үл үзэгдэх" бүлэг болж, тэдний хэрэгцээ, эрсдэл бодлого боловсруулах түвшинд бүрэн тусгагдахгүй байх нөхцөл үүсч байна.

Иймээс энэхүү судалгаагаар Монгол Улсад эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийн нийгмийн хамгаллын нөхцөл байдал, асран хамгаллын бүтэц, бодлогын орчны сул талыг статистик мэдээлэлд тулгуурлан шинжлэхийг зорьсон бөгөөд хүүхдийн эрхэд суурилсан хандлага (rights-based approach), нийгмийн хамгаллын үзэл баримтлал болон институцийн цоорхойн шинжилгээний (institutional gap analysis) хандлагыг үндэслэл болгон бичлээ. Хүүхдийн эрхэд суурилсан хандлага нь хүүхэд бүр ялгаварлалгүйгээр хамгаалуулах эрхтэй гэж үздэг бол нийгмийн хамгаллын үзэл баримтлал нь эмзэг бүлгийн хүүхдүүдэд төрөөс тусгай хамгаалал, дэмжлэг үзүүлэх шаардлагатайг онцолдог (Nations., 1989) (UNICEF, 2012) үзэл баримтлалын илэрхийлэл юм.Мөн институцийн цоорхойн шинжилгээний хандлагын бүрэлдэхүүн хэсэг болох хүлээн зөвшөөрлийн цоорхой (recognition gap), бодлогын цоорхой (policy gap), хэрэгжилтийн цоорхой (implementation gap) гэсэн институцийн шинжилгээний хандлагыг нарийвчлан судалж, үүгээр эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийн нөхцөл байдал нийгмийн хамгаллын тогтолцоонд хэрхэн хангалтгүй тусгагдаж байгааг шинжилсэн болно (Clegg, 2015).

Энэхүү судалгаанд статистик болон баримт бичгийн шинжилгээний аргыг ашигласан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2026 оны 03 дугаар сарын албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийлээ.




График 1.




График 2




График 3.



График 4.

2026 оны 03 дугаар сарын байдлаар Монгол Улсад эцэг, эх нь хорих ял эдэлж буй /хоригдлын тоо нь 2551/ 0-18 хүртэлх насны нийт 3778 хүүхэд бүртгэгдсэн байна. (ШШГЕГ, 2026)

Мөн хүүхэд хамгаалал болон нийгмийн хамгаалалтай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн баримт бичгүүд, эрдэм шинжилгээний бүтээлүүдэд тулгуурлан харьцуулсан шинжилгээ хийсэн болно.

Судалгаанаас харахад нийт хүүхдийн дийлэнх хэсгийг бага болон дунд насны хүүхдүүд эзэлж байгаа нь тэд асран хамгаалал, сэтгэл зүй, боловсролын тогтвортой дэмжлэг өндөр шаарддаг эмзэг бүлэг болохыг илтгэж байна.

Эдгээр хүүхдүүдийн 1819 нь эрэгтэй, 1968 нь эмэгтэй хүүхдүүд юм. Энэ нь хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй байгааг харуулж байгаа боловч охид, хөвгүүдийн сэтгэл зүйн болон нийгмийн хэрэгцээ ялгаатай байж болох тул хамгааллын үйлчилгээний арга хэлбэрийг ялгамжтай боловсруулах шаардлагатайг илэрхийлж байна.

Мөн 2417 хүүхдийн эцэг, 134 хүүхдийн эх нь хорих ял эдэлж байгаа нь харагдаж байна. Энэ үзүүлэлт нь хорих ял эдэлж буй иргэдийн хүйсийн байдалтай шууд холбоотой бөгөөд эцэг нь хоригдсон тохиолдолд өрхийн орлогын эх үүсвэр тасалдах, эдийн засгийн эрсдэл нэмэгдэх, хүүхдийн өдөр тутмын хэрэгцээ хангагдахгүй байх зэрэг сөрөг үр дагавар үүсэхээс гадна хүүхдийн сэтгэл зүйн тогтвортой байдал алдагдах, өөртөө итгэх итгэл буурах, аюулгүй байдлын мэдрэмж сулрах зэрэг сэтгэл зүйн сөрөг нөлөө илэрч болзошгүй юм.

Харин эх нь хорих ял эдэлж буй тохиолдолд хүүхдийн өдөр тутмын асаргаа, халамж шууд тасалдах эрсдэл илүү өндөр байдаг талаар олон улсын судалгаанд дурдсан байдаг (Murray, 2012). Ялангуяа бага насны хүүхдүүдийн хувьд эхээсээ тусгаарлагдах нь сэтгэл зүйн хүнд нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Эдгээр хүүхдүүд хэний асран хамгаалалд байгааг авч үзвэл:

2056 хүүхэд гэр бүлийн бусад гишүүний асрамжид,

-184 хүүхэд шүүхээр тогтоосон асран хамгаалагчийн асрамжид,

-38 хүүхэд асрамжийн байгууллагад,




График 5.

-408 хүүхэд бусад нөхцөлд амьдарч байна. Энэ нь хүүхдийн асран хамгаалал ихэвчлэн гэр бүлийн хүрээнд шийдэгдэж байгааг харуулж байна. Гэвч "бусад" ангилалд хамаарч буй хүүхдүүдийн нөхцөл байдал тодорхойгүй байгаа нь хамгааллын эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлд нөлөөлж болзошгүй юм. Хүүхэд хамгааллын тухай хуульд "эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд"-ийн ойлголтыг тодорхойлсон боловч эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдийг тусгайлан нэрлээгүй байна (УИХ, 2024). Үүний улмаас эдгээр хүүхдүүдийн эрх, хамгааллын асуудал практик түвшинд тодорхой бус хэвээр байгаа юм.

Хүүхдүүд нийтлэг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг тусгайлан эдгээр хүүхдэд чиглэсэн хамгааллын бодлого, үйлчилгээ байхгүйг илэрхийлнэ.

Өөрөөр хэлбэл, тухайн хүүхдүүдийн авч буй үйлчилгээ нь тэдний онцлог хэрэгцээ бус нийт хүүхдийн нийтлэг халамжид тулгуурлаж байгаа бөгөөд сэтгэл зүйн дэмжлэг, нийгмийн ажил, боловсролын нөхөн дэмжлэг зэрэг тусгай үйлчилгээний тогтолцоо хангалтгүй байна. Мөн судлаачид хүүхдийн эрхийн хамгааллыг институцийн болон бодлогын түвшний системийн доголдлоор тайлбарлах хандлагатай байдаг бөгөөд үүнийг ихэвчлэн 'цоорхойн' (gap) ойлголтоор тодорхойлдог. Үүнд дараах гурван үндсэн хэлбэрийг онцлон авч үзэж болно.

Нэгдүгээрт: **Хүлээн зөвшөөрлийн цоорхой** (recognition gap). Эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийг нийгмийн хамгааллын болон хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд бие даасан, онцлог хэрэгцээтэй бүлэг гэж албан ёсоор тодорхойлон бүртгэх, статистик мэдээлэлд тусгах, эрх зүйн статусыг тодорхой болгох асуудал олон улсад төдийгүй зарим улсын түвшинд хангалтгүй хэвээр байна (UNICEF., 2005).

Ийм хүлээн зөвшөөрөл дутмаг байснаар эдгээр хүүхдүүдийн бодит нөхцөл байдал нийгмийн бодлого боловсруулах, нөөц хуваарилах, хамгааллын үйлчилгээ үзүүлэх үйл явцад бүрэн тусгагдахгүй үлдэх эрсдэл бий болдог. Үүний үр дүнд хоригдлын хүүхдүүд "үл үзэгдэх" бүлэг болж, тэдний эрх, хэрэгцээ бодлогын анхаарлын гадна үлдэх хандлага ажиглагддаг (Committee on the Rights of the Child., 2011).

Хоёрдугаарт: **Бодлогын цоорхой** (policy gap). Эдгээр хүүхдүүдэд чиглэсэн тусгай хамгааллын бодлого, хөтөлбөр, үйлчилгээний зохицуулалт олон улсын зарим баримт бичигт тусгагдсан боловч олон улсын болон үндэсний түвшинд хэрэгжих тодорхой бодлогын механизм хангалттай хөгжөөгүй байдаг.

Тухайлбал, хорих ялаар шийтгэгдсэн эцэг, эхтэй хүүхдийн асрамж, сэтгэл зүйн дэмжлэг, боловсрол, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг хангах чиглэлээр системтэй бодлого боловсруулах шаардлага байсаар байна (UNODC, 2015). Бодлогын ийм дутмаг байдал нь эдгээр хүүхдүүдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг салангид, түр зуурын шинжтэй болгох эрсдэлийг дагуулдаг.

Гуравдугаарт: **Хэрэгжилтийн цоорхой** (implementation gap). Зарим улс оронд

хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж болон хорих байгууллагатай холбоотой зохицуулалт тодорхой хэмжээнд бий боловч тэдгээрийн бодит хэрэгжилт хангалтгүй байх тохиолдол ажиглагддаг. Үүнд институц хоорондын уялдаа сул байх, нөөц боломж хязгаарлагдмал байх, мэргэжлийн үйлчилгээний хүртээмж дутмаг байх зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг.

Үүний улмаас эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч эцэг эх нь хорих ял эдэлж байгаа хүүхдүүдэд үзүүлэх хамгаалал бодит амьдрал дээр бүрэн хэрэгжихгүй байх нөхцөл үүсдэг (Committee on the Rights of the Child., 2011) (UNODC, 2015).

Тиймээс эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийг албан ёсоор **хүлээн зөвшөөрөх нь** тэдний эрхийг бодитоор хамгаалах эхний алхам бөгөөд ийм хүлээн зөвшөөрөл байхгүй нөхцөлд хүүхэд хамгаалллын тогтолцоонд системийн цоорхой үүсэх эрсдэлтэй нь дээрхээс харагдаж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад эцэг, эх нь хорих ял эдэлж буй 0-18 хүртэлх насны хүүхдүүд нийгмийн хамгаалллын тогтолцоонд бие даасан зорилтот бүлэг байдлаар бүрэн хүлээн зөвшөөрөгдөөгүй хэвээр байна. Эдгээр хүүхдүүдийн дийлэнх нь бага насных бөгөөд асран хамгаалал, сэтгэл зүй, боловсролын тогтвортой дэмжлэг шаардлагатай нөхцөлд амьдарч байна. Гэвч бодлогын болон эрх зүйн орчинд тэдний онцлог хэрэгцээг тусгайлан харгалзсан зохицуулалт хангалтгүй байгаа нь хүүхдийн эрхийн хамгаалалд бодит хүндрэл үүсгэж буй юм.

Мөн судалгаанаас харахад эдгээр хүүхдүүд нийтлэг нийгмийн халамжийн үйлчилгээний хүрээнд тодорхой хэмжээнд хамрагдаж байгаа боловч эцэг, эх нь хорих ял эдэлж буй нөхцөл байдлаас үүдэлтэй сэтгэл зүйн дарамт, нийгмийн гадуурхал, боловсролын тасалдал, асран хамгаалллын тогтворгүй байдал зэрэг эрсдэлийг бууруулахад чиглэсэн тусгай хамгаалллын үйлчилгээ, урт хугацааны дэмжлэгийн тогтолцоо хангалтгүй. Хүүхэд хамгаалал, нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэнд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаа сул байгаа нь тухайн хүүхдүүдийн нөхцөл байдлыг бодитой тодорхойлох, тасралтгүй хамгаалллын үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учруулж болзошгүй.

Судалгааны үр дүн нь Монгол Улсад эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийг хүүхэд хамгаалллын бодлого, нийгмийн хамгаалллын тогтолцоонд “үл үзэгдэх бүлэг” байдлаар орхигдуулах хандлага байгааг харуулж байна. Энэ нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах, ялгаварлан гадуурхалтаас хамгаалах, хөгжих эрхийг баталгаажуулах талаар Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцод тусгасан зарчмуудын хэрэгжилтэд анхаарах шаардлагатайг илтгэнэ.

Иймд цаашид эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийг албан ёсоор бие даасан зорилтот бүлэг болгон хүлээн зөвшөөрөх, статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хүүхдийн нөхцөл байдлыг тогтмол бүртгэн судлах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ асран хамгаалал, сэтгэл зүй, боловсрол, нийгмийн хамгаалллын чиглэлээр хүүхдэд ээлтэй тусгай үйлчилгээ, дэмжлэгийн тогтолцоог бий болгож, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай. Мөн эдгээр хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг хүүхэд хамгаалллын үндэсний бодлого, хөтөлбөрт тусгайлан тусгаж, урьдчилан сэргийлэх болон хамгаалллын цогц механизмыг хөгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Санал

- Эцэг, эх нь хорих ял эдэлж буй хүүхдүүдийг хууль, бодлогын түвшинд бие даасан зорилтот бүлэг болгон хүлээн зөвшөөрөх;
- Эдгээр хүүхдүүдийн талаарх статистик мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох;
- Хүүхдэд чиглэсэн тусгай нийгмийн хамгаалал, сэтгэл зүйн дэмжлэгийн үйлчилгээг хөгжүүлэх;

- Асран хамгаалагч, гэр бүлүүдэд чиглэсэн санхүүгийн болон нийгмийн дэмжлэгийг нэмэгдүүлэх;
- Хүүхэд хамгаалал, боловсрол, нийгмийн халамжийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;
- Олон нийтийн ялгаварлан гадуурхах хандлагыг бууруулах мэдээлэл, нөлөөллийн ажлыг тогтмол хэрэгжүүлэх.

Ном зүй

1. Clegg, S. (2015). *Conceptualising higher education research and policy.* London, England: https://link.springer.com/book/10.1057/9781137442922?utm_source=chatgpt.com.
2. (2011). *Committee on the Rights of the Child.*
3. Murray, J. F. (2012). *Psychological Bulletin,.* https://doi.org/10.1037/a0026407?utm_source=chatgpt.com.
4. Murray, J., Farrington, D. P., Sekol, I., & Olsen. (2012). *Psychological Bulletin,.* https://psycnet.apa.org/fulltext/2012-00399-001.html.
5. Nations., U. (1989). *Convention on the Rights of the Child.* https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/convention-rights-child.
6. UNICEF. (2012). *Integrated social protection systems: Enhancing equity for children.* https://www.unicef.org/.
7. UNICEF. (2005). *The state of the world's children 2006: Excluded and invisible.* https://www.unicef.org/.
8. UNODC. (2015). *The Bangkok Rules.* https://www.unodc.org/unodc/en/justice-and-prison-reform/bangkok-rules.html?utm_source=chatgpt.com.
9. УИХ. (2024). *Хүүхэд хамгааллын тухай хууль.* УБ: https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140463602711.
10. ШШГЕГ. (2026). *Дүн мэдээ.* УБ хот .

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХОРИГДЛЫГ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА, ОНЦЛОГ

EXECUTION OF SENTENCES FOR PRISONERS WITH DISABILITIES: KEY CHARACTERISTICS

Д.Жамъяндагва*
Дотоод хэргийн их сургуулийн докторант
Jamyandagva D.
Ph.D., student, University of Internal Affairs of Mongolia

*Хариуцлагатай зохиогч: jaagii.jakk@yahoo.com

Хураангуй: Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг ял эдлүүлэх ажиллагаа нь хүний эрх, нийгмийн хамгаалал, ялгаварлан гадуурхахгүй байх зарчимтай нягт уялдсан, онцгой зохицуулалт шаардсан салбар юм. Сүүлийн жилүүдэд хорих ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа хэдий ч тэднийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх бодлого, практик арга зүй хангалтгүй хэвээр байна. Энэхүү өгүүллийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн болон нийгэм-сэтгэл зүйн онцлогийг тодорхойлж, тэдний нийгэмшил, дахин нийгэмд дасан зохицох үйл явцад нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан шинжлэхэд оршино.

Судалгаанд чанарын болон тоон судалгааны хосолсон арга зүйг ашигласан. Үүнд: Монгол Улсын эрүүгийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх эрх зүйн судалгааны арга, хорих байгууллагын алба хаагчид, нийгмийн ажилтнууд, суллагдсан иргэдтэй хийсэн ярилцлага, бүлгийн ярилцлагын арга, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хоригдол болон бусад хоригдлын нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн байдал зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулсан статистик шинжилгээний аргыг хэрэглэв.

Судалгааны үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын дийлэнхийг эрэгтэйчүүд эзэлж, ид хөдөлмөрийн насныхан давамгайлж байгаа бөгөөд боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь бусад хоригдолтой харьцуулахад зарим үзүүлэлтээр илүү эерэг байна. Гэвч суллагдсаны дараах нийгмийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлт, ял шийтгэлийн дараах ялгаварлан гадуурхалт нь давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлж байгааг судалгаа харуулж байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхэд суурилсан, ялгавартай хэрэгцээг харгалзсан бодлого, нийгэмшүүлэх тусгай хөтөлбөрийг боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэв.

Abstract: The execution of sentences for prisoners with disabilities constitutes a specialized field that is closely linked to human rights protection, social welfare, and the principle of non-discrimination. In recent years, the number of prisoners with disabilities serving custodial sentences has shown an increasing trend; however, policies and practical methodologies aimed at their socialization and the prevention of recidivism remain insufficient. The purpose of this article is to identify the legal, social, and psychological characteristics of executing sentences for prisoners with disabilities and to analyze the key factors influencing their socialization and post-release reintegration.

The study employs a mixed-methods research design combining both qualitative and quantitative approaches. Legal analysis was conducted on Mongolia's criminal law and legislation governing the execution of court decisions. In addition, semi-structured interviews and focus group discussions were carried out with correctional officers, social workers, and released prisoners. Comparative statistical analysis was also applied to examine indicators such as age, gender, education level, employment status, and family background of prisoners with disabilities in comparison with other prisoners.

The findings indicate that prisoners with disabilities are predominantly male and mainly belong to the economically active age group. In several indicators, including education and

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

employment prior to imprisonment, they demonstrate relatively more favorable characteristics compared to other prisoners. Nevertheless, insufficient post-release social support, limited employment opportunities, and persistent social stigma significantly increase the risk of reoffending. The study concludes that there is a pressing need to improve the execution of sentences for prisoners with disabilities through human rights–based policies and specialized socialization and reintegration programs that take into account their specific need

Түлхүүр үгс: хүний эрх; нийгэмшил; дахин нийгэмд нэгтгэх; давтан гэмт хэрэг; шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй.

Keywords: human rights; socialization; reintegration; recidivism; enforcement of court decisions.

Орчин үеийн нийгэмд хэвийн аж төрөх, нийгмийн харилцаанд оролцоход хөгжлийн бэрхшээл болон ялгаатай байдал нь ихээхэн нөлөөлдөг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гаргасан статистик мэдээгээр дэлхийн хүний амын ойролцоогоор 10% буюу 650 сая гаруй хүн хөгжлийн бэрхшээлтэй байна (Nations, 2011). Монгол Улсад 2024 оны байдлаар 111,228 хүн хөгжлийн бэрхшээлтэйгээс 32% нь 34 хүртэл насны, 61.4?% нь 35-64 насны, 6.6% нь 64-өөс дээш насны хүмүүс эзэлдэг (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа. Мэдээллийн лавлах, 2020) . Цаашид жилд дунджаар 3000 гаруй хүн хөгжлийн бэрхшээлтэйд тооцогдож, тэднээс гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлэх нь нэмэгдэх төлөвтэй байна.

Нийгмийн шинжлэх ухаан тэр дундаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн болон криминологийн онцгой нэг судлагдахуун нь хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг хорих ял эдлүүлэхэд засан хүмүүжүүлэх, хорих байгууллагаас суллагдсаны дараа нийгэмд эргэн нэгтгэх институт (rehabilitation, reintegration) юм. Сүүлийн 10 гаруй жилд хорих ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын тоо өсөх хандлагатай байгаа бөгөөд тэднээс давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг нийгэмшүүлэх, хорих ял эдлээд суллагдсаны дараа нийгэмд эргэн нэгтгэх, дасан зохицуулах институтийг шинжлэх ухааны үүднээс судлан тодорхойлох шаардлагатай юм.

Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын төрлөөс хорих ял хамгийн хүнд хэлбэр нь бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу хоригдлын зарим эрхийг хязгаарлаж, нийгмээс тусгаарлаж, хяналт тогтоодог онцлогтой. Энэ харилцаанд хорих ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах, нийгэмшүүлэхэд тусгайлсан онол, арга зүй үгүйлэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд хүний эрхийг хангахад эрх зүйн шинэчлэлийн гол зорилтуудыг дэвшүүлж байгаа бөгөөд эрүүгийн эрх зүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинэтгэл, тэр дундаа хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад ахиц гарч байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Тухайлбал, хоригдлын эрхийг хангахын тулд 1981 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хууль, 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд томоохон өөрчлөлтүүд орж тусгайлсан зүйлийг тусгасан. Эдгээр эрхийн дунд урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах, хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох эрхийг хуульчилсан байна.

Олон улсын хүний эрхийн баримт бичиг, тухайлбал Хүний эрхийн тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад заасан аливаа иргэнийг ялгаварлан гадуурхахгүйгээр нийгмийн эрхийг эдлүүлэх тухай хэм хэмжээ нь Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал нөлөө үзүүлсэн юм.

Монгол Улс нь нэгдэн орсон олон улсын гэрээг биелүүлэх үүргийг хууль тогтоомжид тусгайлан зааж, даган

биелүүлэх үүрэг хүлээх болсон. Тухайлбал, 1955 оны Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдэд “Хоригдлууд хорих газарт байгаагаас үүдэж гарсан шаардлагатай хязгаарлалтаас гадна бусад Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тухайн улс оролцогч болсон тохиолдолд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, энэ пактын нэмэлт протокол зэрэгт заасан хүний эрх, эрх чөлөөг, түүнчлэн НҮБ-ын бусад пактад дурдсан эрх, эрх чөлөөг эдэлнэ. Хорих ял эдэлсэн хүмүүс олон нийтийн болон нийгмийн байгууллагуудын оролцоо, тусламжтайгаар, хохирогчийн ашиг сонирхлыг хохироохгүйгээр аль болох зохистой байдлаар нийгмийн амьдралд эргэн олох таатай нөхцөлийг бий болговол зохино” гэж заасан.

Олон улсын баримт бичиг ийнхүү зөвлөмж болгосны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын нийгмийн халамж, үйлчилгээтэй холбоотой эрхийг баталгаажуулах нь эрүүгийн эрх зүй болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйд хүмүүнлэг ёсны болон шударга ёсны зарчмыг хэрэгжилтийг хангаж байгаа хэлбэр юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах, хууль заасан болзол, шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг нийгэмшүүлэхэд тодорхой хэмжээний дэмжлэг болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын хувийн шинж чанарын өвөрмөц байдал нь юуны түрүүнд нийгэм, эрх зүй, сэтгэл зүйн дүр төрхөөр илэрдэг: нас, гэр бүлийн байдал, үйлдсэн гэмт хэргийн сэдэл, сонирхол, хандлага, зан үйлээ субьектив хяналтын түвшин гэх мэт. Эдгээр хүмүүсийн хөгжилд, тэдний амьдарч буй бичил орчин ихээхэн нөлөөлдөг.

Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын шинж чанар нийгэм-хүн ам зүйн шинж чанарын үндсэн үзүүлэлтүүдийг авч үзье.

Хүйс. Энэ нь хоёр багц шинж чанарыг агуулдаг

а) биологийн – нэг төрлийн бодгалийн шинж чанаруудыг үүсгэгч нийлбэр цогц.

б) нийгмийн - эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувь хүн, нийгэм ,эрх зүйн байдлыг хангадаг хангадаг сомантик, нөхөн үржихүй, нийгэм соёлын болон зан үйлийн шинж чанаруудын цогц (Ушатиков А.И., 2001).

Цаашид хорих байгууллагаас суллагдсан хүн нийгэмд “гэмт хэрэгтэн” хэмээн гадуурхагдах, хэвийн ажиллаж, амьдрах боломжгүй болж, эрх нь зөрчигдөх зэрэг байдлууд ч гардаг. Тиймээс дээрх тогтсон чиг хандлага, хуулийн байгууллагын үйл ажиллагааны арга барил, эрх зүйн зохицуулалтыг шийдвэрлэх ёстой юм.

Хүснэгт 1. Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хоригдлуудын хөгжлийн бэрхшээлийн төрөл

Бэрхшээлийн төрөл	2021 он	2022 он	2023 он
Оюун ухааны	19	21	25
Сонсгол	23	19	19
Хараа	9	12	14
Хэл яриа	9	7	5
Тулах, хөдлөх	42	39	43
Эплепси	15	8	11

Эрүүгийн хуулиар ял шийтгэлээр шийтгүүлсэн байдлыг авч үзвэл:

• Оюун ухааны бэрхшээлтэй иргэн Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэгт хамаарах “Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг”, Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт хамаарах “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” үйлдэж ял шийтгэлээр шийтгүүлж байна.

• Сонсголын бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй иргэн Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт хамаарах “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” үйлдэж ял шийтгэлээр шийтгүүлж байна.

• Харааны бэрхшээлтэй иргэн Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт хамаарах “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” үйлдэж ял шийтгэлээр шийтгүүлж байна.

• Тулах, хөдлөх эрхтний бэршээлтэй иргэн Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлэгт хамаарах “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг” үйлдэж ял шийтгэлээр шийтгүүлж байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагааны болон эрх зүйн зохицуулалт учир дутагдалтай байдал нь суллагдсан хүмүүсийг нийгэмд хүлээн авах, ажлын байраар хангах, тусламж дэмжлэг үзүүлэх, амьдрах орчин нөхцөл сайн бүрдүүлэх боломжгүй байдалд хүргэж рецедив гэмт явдлыг нэмэгдүүлдэг ба шоронгоос суллагдсан хүмүүсийн 47% нь ахин гэмт хэрэг үйлдэж хуулийн байгууллагаар шалгагдаж байсан нь анхаарал татдаг (ЦЕГ, 2010).

Хуулийн байгууллагын алба хаагч, хохироос суллагдсан хүмүүстэй бүлгийн ярилцлагаар судалгаа хийх явцад дахин гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нь *“нийгэмд хэвийн амьдарч чадахгүй”* байгаатай холбоотой төдийгүй гэмт зан үйл төлөвшсөн, эргээд гэмт хэрэг үйлдэх орчиндоо очдог зэрэг нөхцөлтэй холбоотой. Энэ нь хулгайлах, бусдын бие махбодод гэмтэл учруулах, хүчиндэх, танхайрах, дээрэмдэх, хүнийг санаатай алах гэмт хэргийг гол төлөв үйлдэж байгаагаас харагдлаа. 2010 оны эцсээр хорих байгууллагад ял эдэлж байгаа хүмүүсийн 50.4% нь хоёр ба түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлж байсан рецидив ялтнууд, тэдний 37.2 % нь хүч хэрэглэсэн болон шунахай сэдэлттэй гэмт хэрэг үйлджээ.

Гэтэл хуулийн байгууллагаас урьдчилан сэргийлэх ажил хангалттүй, тавих хараа хяналт дутсан гэсэн өнгөц дүгнэлт хийж байсан ба тэдэнд нийгэм, хамт олноос үзүүлэх иргэнээ гэсэн бодитой бодлого, туслалцаа, дэмжлэг бүхий дахин гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг анзаарч үздэггүй байсан. Тухайлбал, цагдаагийн байгууллагаас тавьж байгаа захиргааны хяналт нь сард нэг удаа дуудаж, бүртгэх хэлбэртэй байгаа ба цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч, байцаагч, хяналтад байгаа хүмүүс ч мөн адил энэ арга хэмжээг үл ойшоосон байдалтай, үр дүнд хүрэхгүй байна.

Хорих байгууллагад ял эдэлж байгаа хүмүүсээс суллагдаж гарсны дараа учрах бэрхшээлүүдийн талаар асуухад ялтнуудын ихэнх нь *“хэн нэгэнтэй үл ойлголцох байдал бий болно, ажил олдохгүй байх, гэр бүл, нийгэм намайг хүлээж авахгүй”* гэсэн айдастай байдаг ба нийгэмд хэвийн ажиллаж амьдрахад нь төрийн бодлого, олон нийтийн чиг хандлага түлхүү үйлчилж, гадуурхагдах, ажилд орж чадахгүй байх, улмаар давтан гэмт хэрэг үйлдэх зам руу орж байна (Оюунбадам Р. О., 2018).

Хорих байгууллагын нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагаас**:**

“*Шоронд байдаг гал хам, эсвэл янз бүрийн бүлэг нь элдэв хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдэх арга, зан араншинг бусдадаа халдаадаг. Өнөөдөр хүн шоронд тэр байтугай хэдхэн хоног урьдчилан хоригдоод гэмт хэрэгт суралцаад гардаг нь үнэн. Нийгмийн ажилтан нь өөрөө үүнийг засаж залруулах үүрэгтэй ч бодид байдал дээр ажлын стресст хүчтэй ордог. Үүнээс шалтгаалан хоригдогсодтой зүй бус харьцах асуудал гардаг. Үнэндээ шоронд байгаа хүмүүсийн ихэнх нь муу хүмүүс буюу бидний ярьдгаар яадгаа алдсан гэмт хэрэгтнүүд биш байдаг ч элдэг зөөлөн харьцахаараа давардаг*” гэж байлаа.

Иргэдийн санаа бодол**:** “Хүнийг шоронд суулгаснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайн зохион байгуулах нь илүү үр дүнтэй байдаг гэсэн саналыг юу гэж үзэж байна вэ?” гэсэн асуулгаас үзэхэд *шоронд хүмүүсийг байлгаж цээрлүүлэх нь үр дүнтэй, шоронд л хийчихвэл болно гэсэн хандлага тал хувьд нь байхад* энэ нь буруу санал нийлэхгүй байгаа нь 35 орчим хувийг эзэлж байна.

Ялтай байдал: Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан шалгах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад тухайн гэмт хэрэгт холбогдсон

этгээдийн хувийн байдал, эрүүгийн хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх нөхцөлүүдийг бодитой тогтоох зорилгоор Мэдээлэл, судалгааны төвөөс ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудсаар лавлагаа авдаг. Энэхүү "ял шийтгэлийн лавлагаа" авах ачаалал, дугаарлалтай болж, иргэдийн лавлагаа авах эрэлт, хэрэгцээ улам бүр өссөөр байна (Оюунбадам Р. О., 2018).

Мөн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажил, сургууль, уралдаант шалгалтад орох иргэнээс ч бүх тохиолдолд ял шийтгэлийн тухай лавлагааг гаргуулж авдаг болжээ (Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, 2009). Иймээс ял шийтгүүлж байсан этгээд нийгэмд ажил хийх ямар ч боломжгүй, ялгаварлан гадуурхагдах үндсэн нөхцөл болж байна. Иймд энэ асуудлыг төрийн түвшинд авч үзэх, тогтолцоог өөрчлөх, ял шийтгэгдсэн тодорхойлолт авах шаардлага, шалгуурыг тодорхой болгох, цөөлөх, нарийвчлах зүй ёсны шаардлага байна. Эрүүгийн гэмт хэрэг нь санаатай болон болгоомжгүйгээр үйлдэгддэг, тухайн хүний хийсэн үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэрэг мөн эсэх нь үзэл бодлын үүднээс харьцангуй маргаантай тул ял шийтгүүлсэн хүмүүсийг бүх насаар нь гэмт хэрэгтэн, ял шийтгэгдэж явсан бүтэлгүй этгээд гэж үзэх үнэлэмж нь хүний эрхийн зарчимд нийцэхгүй юм.

Гэмт хэрэг үйлдэж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнх хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа нь бидний судалгааны үр дүнгээс харагдаж байна. Бидний судалсан бүлгийн эмэгтэйчүүдийн эзлэх хувь маш бага буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын 3 хувь эмэгтэйчүүд байсан. 2004 онд ял шийтгүүлсэн эрэгтэйчүүдийн тоо буурч, эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэнийг тэмдэглэх хэрэгтэй. Хэрэв 1999 онд ял шийтгүүлсэн эрчүүд 94,6 хувийг эзэлж байсан бол 2004 онд 93,6 хувийг эзэлж байв. Хорих байгууллагуудад ял эдэлж байсан 5,9% (1999 он), 6,4% (2004 он) байсан байна. Энэ нөхцөл байдал нь энэхүү криминологийн шинж чанарыг авч үзэхийн эхэнд бидний эш татсан асуудлыг бататгаж байна. Хүйс бүрийн дундаж үзүүлэлтийг авч үзсэн ч эрэгтэй хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын тоо илүү байгааг бодитойгоор тэмдэглэж болно (гэмт хэргийн идэвхтэй байдлын коэфицент эрэгтэйчүүдэд – 83,7%, эмэгтэйчүүдэд – 16,3%).

Нас. Өөрөө авч үзвэл зөвхөн хувь хүний оршин тогтнох хугацаа л илэрхийлдэг. Гэсэн хэдий ч хүний бүх байгалийн шинж чанарууд нь нийгэм, өөрөөр хэлбэл түүний нийгэмших, нийгмийн харилцаанд оролцох замаар зуучилдаг бөгөөд үүний үр дүнд түүний зан үйлийн норматив тодорхойлдог.

Сэтгэл судлалын салбарын мэргэжилтнүүд насыг 'Физиологийн болон сэтгэл зүйн байнгын өөрчлөлтөөр тодорхойлогддог хувь хүний сэтгэцийн хөгжил, хүн болж төлөвших үе шат гэж тодорхойлдог.

Насны онцлог шинж чанар нь хүн төрөлхтний нийгмийн өөрчлөлтийн үр дүнд юуны түрүүнд криминологийн сонирхлыг татах ёстой. Тиймээс хүн бол зөвхөн биологийн бус насны өөрчлөлттэй нийгмийн амьтан. Нийгэмд харш зан үйлийн гүн гүнзгий тууштай байдлыг тогтоохын тулд ялтнуудын хувийн шинж чанарын талаарх мэдлэг шаардлагатай. Энэ нь нийгмийн эсрэг өндөр хандлагатай субъектүүдийг санамсаргүй гэмт хэрэгтнүүдээс салгах хүнд хэцүү асуудлыг шийдвэрлэх түлхүүр болж чадна. С.Н Лейкина 'Насны шинж чанар нь янз бүрийн насны бүлгийн төлөөлөгчийн гэмт хэргийн дүгнэлт гаргах боломжийг олгодог'. Сүүлийнх нь зөрчилдөөнтэй нөхцөл байдлаас гарах ур чадвар дасан зохицох чадварыг харгалзан үзэхэд тодорхой илэрдэг. Бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн өвчин, хөгжлийн бэрхшээлтэй байдал нь ял эдэлж суллагдсаны дараа дасан зохицоход сөргөөр нөлөөлдөг.

Түүнчлэн нас ахих тусам хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл улам бүр нэмэгддэг бөгөөд машин жолоодох, оффист ажиллах, нэг удаагийн эсвэл түр зуурын шинжтэй ажил хөдөлмөр эрхлэх чадварыг бууруулдаг төдийгүй бизнес эрхлэхэд хөдөлмөрийн чадвартай хүмүүсээс дунд доогуур байр суурь эзэлдэг зэрэг бэрхшээлтэй тулгардаг.

Энэхүү дэд бүлгийн хүрээнд гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байсан, ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын эрх зүйн болон нийгмийн баталгаа, нийгэм сэтгэл зүйн бусад сөрөг үр дагаврууд судалсан бөгөөд Хувь хүний нууцын тухай хуульд заасны дагуу зарим хөгжлийн бэрхшээлтэй хоригдол, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зохих зөвшөөрлийг авч судалсан болно. Мөн харьцуулсан судалгааны хүрээнд ердийн эрүүл мэндийн асуудалгүй бусад ялтангуудын ижил насны бүлгээр статистик үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийсэн болно.

Судалгаанаас үзвэл хорих ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44,7 хувийн 20-39 насны хүмүүс 55 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэлээд хувийг (13,6% 18,5% эзэлж байна. Үүний зэрэгцээ 20-39 насандаа гэмт хэрэг үйлдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь энэ насны бүх гэмт хэрэгтнүүдийн эзлэх хувьтай харьцуулахад хамаагүй бага буюу 29,5% байна. Нөгөөтээгүүр сүүлийнх нь ахмад настанд хамаагүй их байдаг ба 50 ба түүнээс дээш насны бүх гэмт хэрэгтнүүдийн эзлэх хувь энэ насны бүх гэмт хэрэгтнүүдийн эзлэх хувь хэмжээнээс бараг 8 дахин их байна. Иймд ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд ял эдэлж буй ялтнуудын дундаж нас өмнөх ял эдэлж буй ялтнуудын дундаж өмнөх (39,7% ба 32,1%) харьцангуй өндөр байна.

Ял шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бараг тал хувь нь 20-39 насныхан байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл ид хөдөлмөрийн насны хүмүүс байгаа юм. Хувь хүнийг нийгэмшүүлэх нь нийгмийн чиг үүрэг болохын хувьд нэгдүгээрт, өөрийн гишүүдэд нийгмийн тодорхой байр суурийг өгдөг (эдийн засаг, хөдөлмөр, улс төр, аж ахуй); хоёрдугаарт, байр сууриа өөрчлөхөд шаардагдах хувь чанарыг бүрэлдүүлдэг (хүмүүжүүлэх, боловсрол олгох замаар); гуравдугаарт, нийгмийн байр суурьд хуваарилах механизмыг тодорхойлдог (Гилинский Я., 1971). Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг бусад гэмт хэрэгтнүүдийг ч тэр боловсрол эзэмшүүлэхгүйгээр нийгэмшүүлэх боломжгүй.

Боловсролын түвшин. Хувь хүний зан үйл, сонирхол, харилцааны хүрээ, амьдралын зорилгодоо хүрэх аргыг сонгоход боловсрол нөлөө үзүүлдэг. Криминологийн чиглэлээр бичигдсэн ном, зохиолд боловсролын түвшин өндөр байх нь гэмт хэрэг үйлдэхгүй байх хүчин үйл болдог гэдэг аль хэдийн онолын түвшинд батлагдсан (Бурлаков В.Н., 1995). Боловсролын өндөр түвшин нь хоригдлуудад засарч хүмүүжих үйл явцад ухамсартайгаар хандах, дэглэмийн шаардлага, хүмүүжлийн арга хэмжээг зөвөөр хүлээн авахад тусалдаг байна (Лебедев В.В., 1992). Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын боловсролын түвшин болон хувь хүний нийгмийн эсрэг хандлагын харилцан холбоог тогтоох боломжтой гэж бид үзэж байна.

Судалгаанаас гарсан үзүүлэлтүүд нь гэмт хэрэг үйлдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын түвшин бусад хоригдлынхоос төдийлөн их биш байна. Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд тусгай, дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь багагүй онцлох хэрэгтэй. Ярилцлагын явцад бид хүмүүсийн үзэл бодол хуваагдсаныг бид анзаарсан. Эхний хэсэг бүлэг хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын боловсролын түвшин өндөр байх нь тэдний наснаас хамаардаг гэж үзсэн. Учир нь ахимаг насны хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд гэмт хэрэг үйлдэхээс өмнө боловсрол эзэмших хангалттай хугацаа байсан гэж тайлбарласан байна. Энэ үзэл санааг ч мөн ном зохиолуудад бататгасан байдаг. Тухайлбал, С.В. Бабурин “аливаа гэмт хэргийг үйлдэх нь тухайн хүний насны байдлаас хамаардаг. Хэрэв тухайн хүн нь төлөвшиж амжсан бол түүнд гэмт хэрэг үйлдэх магадлал бага байдаг, хэрэв үгүй бол эсрэгээрээ байдаг” гэж үзсэн байна (Бабурин С.В., 1999). Дараа нь эрүүл мэндийн шалтгааны улмаар хөгжлийн бэрхшээлтэй хоригдлууд нь дийлэнх төрлийн гэмт хэргийг үйлдэх боломжгүй байдаг гэж үзсэн (юуны түрүүнд шунахайн сэдлээр, хүч хэрэглэх зэрэг). Энэ

мэтгэлцээнд оролцох төдийлөн шаардлагагүй гэж бид үзэж байгаа бөгөөд учир нь аль аль тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хоригдлууд нь бусад хоригдлуудтай харьцуулахад илүү аюулгүй юм. Гэмт хэрэг үйлдэхээс татгалзах, зогсоох хүчин зүйл нь тэдний эрүүл мэндийн байдал, нас, боловсрол болдог бөгөөд зарим тохиолдолд энэ хүчин зүйлүүд нь хамтдаа ч байдаг.

Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын дийлэн нь бага боловсролтой байгааг мөн харж болох юм. Бусад хоригдлуудтай харьцуулахад 6.0% болон 4.3% байна. Энэ байдал нь нэг талаас хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал нь боловсрол эзэмшихэд том бэрхшээл болж байсан, нөгөө талаас энэ нь хорих байгууллагаас суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох боломжийг бууруулах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Ажил хөдөлмөр. Хоригдлын хувь хүний тодорхойлох чухал үзүүлэлтүүдийн нэг нь хоригдлын ажил хөдөлмөрийн төрөл юм. Ял эдлэхээс өмнө эрхэлж байсан ажил хөдөлмөр нь хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх хөтөлбөрийн үндэс болдог байна. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил хийдэггүй, эсхүл орлогын эх үүсвэргүй хүмүүс нь нийгэмд гэмт хэсгийг бүрдүүлдэг бөгөөд учир нь үүнээс үүдэн оршин суух байнгын газаргүй зэрэг шалтгаан, үр дагаврууды дагуулдаг байна.

Дурдсан үзэл санаа нь хоригдлын ажил хөдөлмөр буюу нийгмийн шинж чанарыг бүрэн илэрхийлж байна. Бид судалгааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хоригдол болон бусад хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг харьцуулан судалсан.

Хөгжлийн бэрхшээлтэй болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээсээ өмнө эрхэлж байсан ажил, хөдөлмөрийг харьцуулан дүн шинжилгээ хийхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд эерэг үр дүн харагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд 48% нь ажиллаж байсан бол бусад хоригдлуудын 38% нь ажил хөдөлмөр эрхэлж байсан байна. Байнгын орлогын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэтгэмж авч байсан.

Шашин шүтлэг. Хоригдлын хувь хүний мөн чанарт шашин шүтлэг томоохон үүргийг гүйцэтгэдэг. Тэрээр үндсэндээ ертөнцийг харах өнцөг, үнэт зүйлийг эрхэмлэх зэргийг тодорхойлдог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шашин шүтэх эрхэд төдийлөн хязгаарлалт тогтоогоогүй. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 15 дахь хэсэгт Монгол Улсын иргэн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй гэж заасан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210 дугаар зүйлийн 210.1.13 дахь хэсэгт хоригдол шашны зан үйл үйлдэх эрхтэй гэж заасан.

Үүнтэй холбогдуулан Б.Галбадрах “Хорих байгууллагад шашин шүтэх эрхийг хэрэгжүүлэх гол нөхцөл нь бусдын эрхийг хязгаарлахгүй байх, хорих ангийн дотоод журмыг мөрдөх юм. Өөрөөр хэлбэл, эдгээр нөхцөлүүд нь хоригдлын тухайн эрхийн хязгаарлалт болдог” гэж тэмдэглэсэн байна (Галбадрах Б., 2021).

Шашин шүтлэг нь хорих байгууллагад гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чухал хүчин зүйл болдог. О.В. Павленко хоригдлын шашин шүтэх ач холбогдлыг судлаад “Ял эдлүүлэх явцад гэмт зан үйлээс татгалзах чухал хүчин зүйлээр шашныг хүлээн зөвшөөрч болох юм. Учир нь шашин шүтлэгтэй хоригдлуудын 89% нь ял эдлэх хугацаандаа дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх шийдвэрт хүрсэн байдаг” (Павленко О.В., 2003).

Бидний хийсэн судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын дийлэнх буюу 72.4% нь шашин шүтлэггүй мөн бусад ердийн хоригдлуудын дийлэнх нь буюу 63.2% нь шашин шүтлэггүйг тогтоосон. Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын 27.6% нь өөрсдийгөө шүтлэгтэй гэж үздэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлууд нь нийт хоригдлын дунд бага хувийг эзэлдгийг харгалзан шашин шүтлэг нь гэмт хэрэг үйлдэхээс татгалзах чухал хүчин зүйл болохын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын дотоод итгэл үнэмшилд төдийлөн бат бэх байр суурийг эзэлдэггүй байна.

Шашин шүтлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын нийгмийн шинж чанарын бие даасан элемент болохын хувьд бусад хоригдлуудтай харьцуулахад тэдний хувь хүнд гэмт хэргээс татгалзах нөлөөг төдийлөн үзүүлдэггүй. Гэсэн хэдий ч ял эдлүүлэх байгууллага болон шашны байгууллагын хамтын ажиллагааг эрх зүйн баримт бичгээр зохицуулах хэрэгтэй гэж үзэж байна. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг суллагдсаны дараа нийгэмд дасан зохицоход тус дэм болно гэж үзэж болох юм.

Гэр бүлийн байдал. Судалгаануудад гэмт зан үйл үйлдэхээс татгалзахад гэр бүлийн нөлөөний талаар тэмдэглэсэн байдаг (Антонян Ю.М., 1998). “Гэр бүлтэй байх, ял эдлүүлэх хугацаанд гэр бүлийн харилцаагаа хадгалан үлдэх нь хоригдолд эерэг нөлөө үзүүлэх, хорих байгууллагаас суллагдсаны дараа нийгэмд дасан зохицоход туслах, нийгмээс тусгаарлагдсанаас үүсдэг сөрөг нөлөөг бууруулдаг байна” (Старков О.В., 1997). Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын хувьд гэр бүл нь цаашдын гэмт хэв маягтай амьдралаас татгалзах чухал хүчин зүйл болдог. Чухам ял эдлүүлэх хугацаанд болон суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох явцад гэр бүлийн зүгээс материаллаг болон сэтгэл санааны дэмжлэг ирдэг байна.

Суллагдах үед бүх хүний материаллаг болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх эцэг эх, эсхүл хамаатан садан нь амьд байдаггүй. Хорих байгууллагаас суллагдах үед дийлэнх хоригдлуудын найз нөхдийн харьцаа тасарсан байдаг. Ийм учраас насны болон биеийн байдлаас хамааран тухайн хүнд дэмжлэг үзүүлэх ганц зүйл нь түүний гэр бүл байдаг.

Гэмт хэрэг үйлдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүлийн байдлыг бусад хоригдлуудтай харьцуулан дүн шинжилгээ хийхэд гэмт хэрэг үйлдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний дийлэнх хувийг буюу 43.1% хувийг гэрлээгүй хүмүүс бүрдүүлж байна. Бусад хоригдлуудын хувьд энэ хувь нь илүү байна – 69.1%. Академик В.Н. Кудрявцев “гэмт хэрэгтнүүдийн тал хувь нь ганц бие, хүн амын ¼ нь ганц бие хүмүүс байдаг” гэж тэмдэглэсэн (Кудрявцев В.Н., 2005).

Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүлийн салалт бусад хүмүүстэй харьцуулахад өндөр байдаг байна. Гэр бүл салалт, урт хугацааны таарамжгүй байдал, хүүхдээсээ хол байх зэрэг нь гэр бүл, гэр бүлийн харилцаандаа хайхрамжгүй хандах, эцэг эхийн үүрэг зэргийг үл тооход хүргэдэг байна. Үүнийг тоо мэдээнээс харж болох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын 17.7% нь ял авсны дараагаар гэр бүлээ цуцлуулсан байна. Харин бусад хоригдлуудын хувьд энэ тоо 10% байна.

Зарим судалгаанд гэр бүлийн байдлыг хувь хүнд эерэг нөлөө үзүүлдэг хүчин зүйлээс гадна сөрөг зан үйлийг бүрдүүлдэг гэж тэмдэглэсэн байна (Бурлаков В.Н. С. М., 1995). Тухайлбал, М.П. Мелентьев, А.П. Тищенко нар хорих байгууллагад амиа хорлох явдлын шалтгааны судлах явцдаа хоригдлын амиа хорлох шалтгааны 15.7% нь гэр бүл цуцлалт байсан гэдгийг дурдсан (Мелентьев М.П., 1994). Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын 90 гаруй хувь нь ял эдлэхээсээ өмнө байнгын оршин суух газартай байсан бөгөөд суллагдах үедээ тэдний бараг тал нь буюу 41.2% нь байнгын оршин суух хаяггүй болсон байдаг.

Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хоригдол бусад хоригдлуудтай харьцуулахад гэр бүлийн харилцаагаа хадгалж үлддэг байна. Гэсэн хэдий бусад хоригдлуудтай харьцуулахад гэр бүл батлуулах нь бага байдаг.

Зарим талаар үүнийг хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын насны байдалтай холбож болох юм. Ахимаг насны байх нь удаан хугацаанд гэр бүлтэй байсныг илтгэх юм. Ахимаг насны байхад тэд гэр бүлийн харилцаагаа илүү үнэлдэг бөгөөд хэрэв гэр бүл цуцлагдсан бол цаашид шинээр гэр бүл болох боломж бараг л байдаггүй. Энэ нөхцөл байдал нь хөгжлийн бэрхшээлтэй байхаар илүү хүндэрдэг. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн амьдралын ханийг алдахаас айдаг байна. Энэ нөхцөл байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын эрүүл мэндийн байдлыг криминологийн бие

даасан шинж чанар болгох авч үзэх үндэслэлийг бий болгож байгаа юм.

Гэмт хэрэг, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээлийг харгалзан үзэх шаардлагатай ба эрүүл мэндийн талаар мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлтэй хоригдолд эмнэлгийн үйлчилгээ үйлчилгээг оновчтой зохион байгуулах боломжийг бүрдүүлдэг байна.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын онцлогийг судлан үзээд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй гэмт хэрэг үйлдсэн хүний дийлэнх хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байгаа бөгөөд эмэгтэйчүүд зөвхөн 3%-ийг л эзэлж байна.

2. Хорих ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын дийлэнх хувийг 20-39 насны хүмүүс эзэлж байна. Үүнээс гадна ахимаг насны буюу 55 болон түүнээс дээш насны хүмүүс 30% байна.Үүний зэрэгцээ 20-39 насны хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын эзлэх тоо ийм насны бусад хоригдлуудтай харьцуулахад бага байна. Гэсэн хэдий ч 55-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын эзлэх хувь багагүй байна.

3. Гэмт хэрэг үйлдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын түвшин бусад хоригдлуудаас бага зэрэг өндөр байна (60% болон 49.8%). Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын дунд тусгай (14.5%) болон бүрэн дунд боловсролтой (15.3%), дээд боловсролтой (3%) байна.

4. Хийж байгаа ажлын хувьд бусад хоригдлуудтай харьцуулахад эерэг дүр зураг харагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын 48.8% нь тодорхой хэмжээгээр ажил хөдөлмөр эрхэлж байна. Байнгын орлогын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хоригдлууд нь хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж болон ахмад настнууд тэтгэвэр авдаг.

5. Гэр бүлийн байдлын хувьд тэдний 43.1% нь ял эдлэхээсээ өмнө гэр бүлгүй байсан. Ял эдлэх хугацаандаа ч гэр бүл болох нь бага байдаг байна.

Ашигласан эх сурвалж

Nations, U. (2011). *Monitorin of the rights of perspns with disabilities: an overview.*

Адъяабазар, Д. (1998). *Монгол Улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт /I-дэвтэр/.* Уб.

Антонян Ю.М., Э. В. (1998). *Психология преступления и наказания.* М.,.

Бабурин С.В. (1999). *Психолого-педагогические условия адаптации и реадаптации заключенных.* СПб.,.

Бурлаков В.Н. (1995). *Личность преступника как объект профилактической деятельности органов внутренних дел.* СПб.,.

Бурлаков В.Н., С. М. (1995). *Криминология: Курс лекций.* СПБ.,.

Галбадрах Б. (2021). *Хоригдлын эрхийн байдал.* Уб.,.

Гантулга, Н. (2019). *Монгол Улсын Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй.* Уб.

Гилинский Я. (1971). Стадии социализации индивида. *Человек и общество*, 44-45.

Кудрявцев В.Н. (2005). *Лекции криминологии.* М.,.

Лебедев В.В. (1992). Изучение личности осужденных. *Наказание и исправление преступников*, 159.

Лхагва, А. (2001). *Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн замнал.* Уб.

Лхагва, А. (2014). *Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын уламжлал.* Уб.

Лхагва, А. (2016). *МУ-ын ШШГЭЗ-н эрх зүйн зохицуулалтын эх сурвалж.* Уб.

Лхагва, А. н. (2011). *Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал.* Уб.

Мелентьев М.П., Т. А. (1994). *Предупреждение самоубийств среди лиц, осужденных к лишению свободы.* Киев.

(2009). *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл.* ХЗҮХ.

Оюунбадам, Р. (2021). *Эмэгтэйчүүд ба хорих ял: онол, арга зүй, практик.* Уб.

Оюунбадам, Р. О. (2018). *Хорих ялын үр нөлөө. Судалгааны тайлан.* ХЗҮХ.

Павленко О.В. (2003). *Постпенитенциарное поведение лиц,*

отбывших наказание за корыстные преступления. Омск.

Старков О.В. (1997). *Введение в криминопенологию.* Уфа.

Сэрсэнжав, Ю. (2007). *Хорих ял эдлүүлэх байгууллагын харуул хамгаалалт.* Уб.

Ушатиков А.И., К. Б. (2001). *Основы пенитенциарной психологии.* Рязань.

ХЗДХЯ. (2011). *Монгол Улсын хууль зүйн алба. тэргүүн дэвтэр.* Уб.

(2020). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа. Мэдээллийн лавлах.* Уб.,.

ЦЕГ, Х. (2010). *Давтан гэмт хэргийн шалтгаан нөхцөл. Судалгааны тайлан.*

ШШГЕГ. (2021). *ШШГБ-ын үүсэл хөгжлийн түүхэн товчоон.* Уб.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

EARTHQUAKE RISK ASSESSMENT IN THE SOUTHERN PROVINCE ANALYSIS

М.Батсүх*
Дотоод хэргийн их сургуулийн Гамшиг судлалын магистрант, ахмад
Batsukh M.
Graduate student of master degree of disaster research of the University of Internal, capitian
Б.Одгэрэл
Дотоод хэргийн их сургуулийн Гамшиг судлалын төвийн эрхлэгч, доктор (Ph.D), ахлах дэслэгч
Odgerel B.
Ph.D., Head, Disaster Research Center, University of Internal Affairs, Senior Lieutenant

*Хариуцлагатай зохиогч: 12senguun@gmail.com

Хураангуй: Сүүлийн жилүүдэд Монгол Улсын нутаг дэвсгэрт уул уурхай, газрын тосны олборлолтын бүс нутгууд дахь газар хөдлөлтүүдийн идэвхжил нэмэгдэж, зарим тохиолдолд мэдэгдэм хүчтэй газар хөдлөлтүүдийн бүртгэл гарсан. Тухайлбал, 2017 оны 12-р сарын 2-нд “Таван Толгой” нүүрсний уурхайн орчимд магнитуд 3.9 бүхий газар хөдлөлт болж, тухайн газар хөдлөлтийн чичирхийлэл нь Цогтцэций сумын оршин суугчид болон уурхайн ажилчдад мэдрэгдсэн. Мөн 2019 онд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд магнитуд 5.1 бүхий газар хөдлөлт болж, үүнээс хойш Дорнод аймгийн Матад, Халх гол сумдын нутаг дэвсгэрт газрын тосны олборлолтын бүс нутгуудад 800 гаруй удаагийн сулавтар газар хөдлөлтүүд бүртгэгдсэн бөгөөд эдгээр нь цаашид өсөх хандлагатай байгааг судалгаа харуулж байна. Энэхүү үйл явдал нь газар хөдлөлтийн эрсдэлтэй бүс нутгуудын судалгааг нэмэгдүүлэх үндэслэл болсон бөгөөд мөн энэхүү судалгааны ажлыг явуулах үндэслэл болсон. Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийх зорилгоор Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн аюул, түүнд өртөх байдал, эмзэг байдал болон эдгээрт хариу үйлдэл хийх чадавхыг үнэлэн, барилгын норм, стандартын дагуу барилга байгууламжийн судалгааг хийх шаардлага гарсан. Үүнтэй холбогдуулан, гамшгийн эрсдэлийг үнэлэхэд энэхүү судалгааны гол зорилго оршиж байна. Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилан дүн шинжилгээ хийж, тус аймгийн газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах талаар бодлого, арга хэмжээг тодорхойлж, шаардлагатай зөвлөмжүүдийг гаргахыг зорьсон болно.

Abstract: In recent years, the seismic activity in the regions of Mongolia's territory with mining and oil extraction operations has increased, with some significant earthquakes being recorded. For instance, on December 2, 2017, an earthquake with a magnitude of 3.9 occurred near the "Tavan Tolgoi" coal mine, and its tremors were felt by residents of Tsogtsetsii soum and the mine workers. Additionally, in 2019, an earthquake with a magnitude of 5.1 struck the Erdenetsagaan soum in Sukhbaatar province. Following this, over 800 aftershocks were recorded in the oil extraction areas in the Matad and Khalkh gol soums of Dornod province, and research indicates a growing trend in the frequency of these seismic events. This situation has become the basis for increasing the research on seismic risks in these regions. In accordance with the methodology approved by the Decree No. 68 of the Deputy Prime Minister of Mongolia in 2021, a general disaster risk assessment was conducted to evaluate earthquake risks, vulnerability, and capacity to respond to potential seismic events in the territory of Umnugovi province. The evaluation also focused on determining the necessary structural standards for buildings, including the assessment of building codes and regulations. The primary objective of this study is to assess disaster risks related to earthquakes and to ensure appropriate disaster risk reduction measures. Based on the results of the earthquake risk assessment in Umnugovi province, this study aims to conduct an in-depth analysis and propose relevant policies and measures to reduce earthquake

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

risks in the region. Furthermore, the study seeks to develop recommendations for effective disaster risk management in the area.

Түлхүүр үг: Газар хөдлөлт, эрсдэлийн үнэлгээ, Өмнөговь аймаг, газрын тосны олборлолт, гамшгийн эрсдэл бууруулах

Keywords: Earthquake, risk assessment, Umnugovi province, oil extraction, disaster risk reduction

Өмнөговь аймаг нь газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд байрладаг тул газар хөдлөлт нь аюулт үзэгдлийн нэг бөгөөд энэ бүсэд газар хөдлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг нарийвчлан үнэлэх нь чухал юм. Тус аймагт газар хөдлөлтийн давтамж, хүч, газрын бүтэц нь хэр эмзэг болох зэргийг судлах шаардлагатай (Жонс & Смит, 2020). Газар хөдлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг тодорхойлохын тулд тухайн бүс нутгийн газарзүй, цаг уурын нөхцөлийг нарийвчлан судлах хэрэгтэй (АНУ-ын Газар хөдлөлтийн судалгааны төв, 2021).

Өмнөговь аймгийн цаг уурын нөхцөл нь эрс тэс эх газрын уур амьсгалтай бөгөөд өвөлдөө -20-30 градус хүртэл хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь 30-38 градус хүрдэг. Салхины хурд 5-15 м/сек бөгөөд заримдаа 34-45 м/сек хүрдэг (Ус цаг уур орчны шинжилгээний газар, 2024). Эдгээр байгалийн хүчин зүйл нь гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлдэг тул дэлгэрэнгүй эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай байна.

Сүүлийн таван жилийн хугацаанд (2020–2024) Өмнөговь аймагт байгаль, цаг уурын нөхцөл, газарзүйн байрлалтай холбоотой гамшигт үзэгдлүүд давамгайлж буй нь статистик мэдээллээс харагдаж байна. Үүнд үер, хүчтэй цасан болон шороон шуурга, газар хөдлөлт, объектын гал түймэр, мөн мал, амьтдын халдварт болон гоц халдварт өвчнүүд түлхүү бүртгэгджээ. Эдгээр гамшигт үзэгдэл, ослын тоо жил ирэх тусам өсөх хандлагатай байгаа бөгөөд үүнтэй уялдан хүний амь нас, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээ ч нэмэгдэж байгааг 1-р хүснэгтэд тусгасан байна (Э.Халиун, 2024, хууд. 4).

д/д	Тохиолдсон гамшигт үзэгдэл		Тохиолдлын тоо				
			2020	2021	2022	2023	2024
1	Объектын гал түймэр		65	65	98	129	138
2	Байгаль цаг агаарын аюулт үзэгдэл	Аадар бороо, үер	1	2	2	8	2
3		Цас зуд	-	-	-	-	-
4		Хүчтэй салхи	3	2	4	3	5
5		Газар хөдлөлт	4	12	2	5	8
6	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	Шүлхий	-	1	6	-	-
7		Цэцэг	-	-	-	-	4
8		Галзуу	3	-	-	1	-
9		Мялзан	-	-	11	-	1
10	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол	Усны осол	3	3	-	-	-
11		Эрэн хайх, аврах ажиллагаа	22	11	11	32	32
12		Зам тээврийн осол	5	3	4	13	14
13		Тэсрэх бодис	-	-	1	-	-
14		Химийн осол	-	-	1	1	-
Бүгд			**103**	**99**	**130**	**182**	**204**

Хүснэгт 1., Өмнөговь аймагт тохиолдсон гамшиг ослын тохиолдол, хохирлын мэдээ.

Газар хөдлөлтийн эрсдэлийн тойм судалгаанд ашигласан аргачлал


Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн гамшгийн эрсдэлийн тойм судалгааг Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх нийтлэг заавар”-ыг үндэслэн хийсэн. Энэхүү заавар нь аюул, эмзэг байдал, чадавхын харилцан хамаарлыг тусгасан 1.3 дугаар зүйлд зааснаар, гамшгийн эрсдэлийн түвшинг тодорхойлоход тус аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний үр дүнг ашигласан. Үнэлгээ хийхдээ индикаторын аргачлал дээр суурилсан бөгөөд энэ арга нь эрсдэлийг илрүүлэх, нарийвчлан шинжлэх, үнэлгээ өгөх, мөн эрсдэлийг бууруулах боломжит арга замуудыг тодорхойлох үе шаттайгаар ажиллах боломжийг олгодог.

Монгол Улсын Шадар сайдын 68 дугаар тушаалын 2.1 дүгээр зүйлд зааснаар "Гамшгийн эрсдэлийн тойм судалгааг гамшгийн эрсдэлийг тодорхойлсон ерөнхий үнэлгээ гэж ойлгоно" гэж дурдсаны дагуу тус судалгаа нь гамшгийн эрсдэлийг тодорхойлсон үндсэн үнэлгээний үр дүнг үндэслэн явагдсан.

Индикаторын арга

Индикаторын аргачлал нь орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг үндэс болгон тухайн бүс нутагт үүсэж болзошгүй нийгмийн шинжтэй эрсдэлийг ерөнхий байдлаар тодорхойлоход хамгийн тохиромжтой арга юм. Энэхүү арга нь шийдвэр гаргагчдад гамшгийн эрсдэлийн талаарх суурь мэдээллийг бүрдүүлэхэд үр дүнтэйгээр ашиглагддаг. Индикаторын арга зүйд тулгуурлан гамшгийн эрсдэлийг үнэлэхдээ дөрвөн үндсэн чиглэл буюу аюулын түвшин, өртөх байдал, эмзэг байдал, чадавхын хэмжүүрийг тус тусад нь авч үздэг.

Эдгээр чиглэлийг илэрхийлэхдээ тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг (индикаторуудыг) сонгон хэрэглэдэг бөгөөд энэ нь үнэлгээг илүү бодитой, тоон болон чанарын хувьд дөхөм болгодог. Индикаторуудыг тусгах үед тусгай шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан эрсдэлийн үнэлгээг илүү нарийн, бодитой гаргах боломжтой болдог.



Зураг 1., Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний бүдүүвч (Монгол Улсын Шадар сайдын 68 дугаар тушаал , 2021)

Эрсдэлийн үндсэн хэсгүүд	Дэд үзүүлэлт	Индикаторын нэр
АЮУЛ	Давтамж	Аюулын тохиолдох давтамж
	Хамрах хүрээ	Аюул нутаг дэвсгэрийг хамрах байдал
	Үргэлжлэх хугацаа	Аюулын үргэлжлэх хугацаа
	Эрт зарлан мэдээлэх боломж	Аюулыг урьдчилан таамаглах боломж
	Хүн ам	Иргэдийн амь нас, эрүүл мэндийн өртөх байдал

ӨРТӨХ БАЙДАЛ		Иргэдийн эд хөрөнгө өртөх байдал
	Хүрээлэн буй орчин	Ой, ургамлан бүрхэвчийн өртөх байдал
		Ус, хөрс, агаар өртөх байдал
	Эдийн засаг	Газар тариалангийн салбарын өртөх байдал
		Үйлдвэрлэл, үйлчилгээ
		МАА-н салбарын өртөх байдал
		Уул уурхайн салбарын өртөх байдал
	Дэд бүтэц	Усан хангамж
		Холбоо
		Цахилгаан
		Зам, гүүр
ЭМЗЭГ БАЙДАЛ	Хүн амын эмзэг байдал	Хүн амын нягтрал
		Орон, байрны эмзэг байдал
	Нийгмийн эмзэг байдал	Ажилгүйдэл, ядуурал
		Малчин өрхийн амьжиргааны түвшин
	Хүрээлэн буй орчны эмзэг байдал	Ой, ургамлан бүрхэвчийн эмзэг байдал
		Бэлчээрийн доройтол
		Ус, хөрсний эмзэг байдал
		Газар ашиглалт
		Бэлчээрийн нөөц
	Эдийн засгийн эмзэг байдал	Орон нутгийн нөөц
		Эдийн засгийн олон талт байдал
	Дэд бүтцийн эмзэг байдал	Усан хангамжийн эмзэг байдал
		Холбооны эмзэг байдал
		Цахилгааны эмзэг байдал
		Зам, гүүрийн эмзэг байдал
ЧАДАВХ	Институцийн чадавх ба менежмент	Эрсдэлийн менежмент/гамшгаас хамгаалах удирдлага
		Эрсдэлийн зураг
		Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
		Зарлан мэдээлэх систем
		Институцийн чадавх
		Харилцан ажиллагаа
	Төлөвлөлт хийх, инженерийн арга хэмжээ авах	Газар ашиглалт төлөвлөлт
		аюулын сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн хийц бүтээц барих, хүчитгэх байдал
		Урьдчилан сэрэмжлүүлэх бүтэц
		Байгаль орчны менежмент
	Нийгмийн чадавх	Олон нийтийг мэдээлэлжүүлэх хөтөлбөр
		Сургуулийн сургалтын төлөвлөгөө
		Гамшгаас хамгаалах сургалт
		Олон нийтийн оролцоо
		Гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг
	Эдийн засгийн чадавх	Орон нутгийн гамшгийн нөөц
		Улсын гамшгийн нөөцийг ашиглах боломж
		Олон улсын гамшгийн нөөцийг ашиглах боломж
		Эд хөрөнгийн даатгал
		Малын даатгал
		Газар тариалангийн даатгал
		Эмзэг байдлыг бууруулах зээл
		Сэргээн босгох зээл
		Эрсдэлийг бууруулах олон нийтийн ажил

Хүснэгт 2., Эрсдэлийн үнэлгээнд авч үзсэн индикаторууд
Эх сурвалж: (Д.Сэржмядаг, 2017)

Индикаторуудыг индекс рүү шилжүүлж тодорхойлох утга/үзүүлэлтийг “1, 2 ба 3” гэсэн тоон утгаар төлөөлүүлэх буюу “бага, дунд ба их” гэсэн зэрэглэлд харгалзуулна.

Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн индекс	Өнгөний илэрхийлэл
Бага	0-30	
Дунд	31-60	
Их	61-100	

Хүснэгт 3., Гамшгийн эрсдэлийн түвшинг өнгөөр илэрхийлсэн байдал

Эрсдэлийн нэгдсэн индексийг тооцох томъёо

Индексийн үзүүлэлтүүдийн утгыг шинжилж үзэхэд, аюул, өртөх байдал болон эмзэг байдлын индекс нэмэгдэхийн хэрээр гамшгийн эрсдэлийн түвшин өсөх хандлагатай байдаг. Харин чадавхын индекс өндөр байх нь эрсдэлийг сааруулах чиглэлд нөлөөлдөг. Энэ нь гамшгийн эрсдэлийг багасгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Эдгээр шинж чанарт тулгуурлан гамшгийн эрсдэлийн нэгдсэн индексийг тооцоолохдоо аюул, өртөх байдал, эмзэг байдлын индексүүдийг нэгтгэж, тэдгээрийн нийлбэрээс чадавхын индексийн утгыг хасах замаар эцсийн эрсдэлийн индексийг гаргах зарчмыг ашигладаг.

Эрсдэлийн нэгдсэн индексийн томъёо:

RI=(A+V+S)−CRI = (A + V + S) - CRI=(A+V+S)−C

RI – Эрсдэлийн нэгдсэн индекс

A – Аюулын индекс

V – Өртөх байдлын индекс

S – Эмзэг байдлын индекс

C – Чадавхын индекс

Энэхүү томъёо нь гамшгийн эрсдэлийн түвшинг тооцоолох, бүс нутгийн хэмжээнд эрсдэлийг үнэлэх, мөн эрсдэлийг бууруулах бодлого боловсруулахад ашиглагддаг үндсэн аргачлал юм. Эрсдэлийн индекс өндөр байх нь тухайн бүс нутагт гамшгийн эрсдэл өндөр байгааг илэрхийлж, чадавхын индексийн өндөр утга нь эрсдэлийг бууруулах чадавхтайг харуулдаг.

Гамшгийн эрсдэлийн тойм судалгааны үр дүн

Өмнөговь аймгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгааг индикаторын аргачлалд /хүснэгт 3/ ашиглан бодит мэдээлэлд үндэслэн аймгийн 15 сумыг аймгийн мэргэжлийн байгууллагуудаас оролцсон 32 хүн 5 багт хуваагдан гүйцэтгэв. Баг тус бүр 6 сумын үнэлгээг хийсэн бөгөөд нэг сумыг хоёр удаа үнэлсэн байна. Үүний үр дүнд, 2 багийн үнэлгээний дунджаар эрсдэлийн тойм судалгааны үр дүн гарсан юм. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн жилүүдэд давтамжтайгаар тохиолдож буй гамшиг, аюулт үзэгдлүүдийг судлахад хүчтэй салхи, ган, зуд, үер, хүн болон малын халдварт өвчин, гоц халдварт өвчин, объектын түймэр, газар хөдлөлт зэрэг үзэгдлүүд онцгойлон тэмдэглэгдэж байна. Эдгээр гамшигт үзэгдлийг тохиолдлын давтамж, учруулсан хохирлын цар хүрээ зэрэг үзүүлэлтийг үндэслэн эрэмбэлж, тухайн бүс нутгийн хувьд аюулын түвшинг тодорхойлсон байна. Багууд тухайн гамшгийн төрлүүдийн хүрээнд шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан сум тус бүрийн эрсдэлийн тойм судалгаа хийж, голлох хүчин зүйлүүд болох аюул, өртөх байдал, эмзэг байдал, гамшгаас хамгаалах чадавхын түвшинг үнэлсэн. Судалгааны хүрээнд эдгээр үндсэн чиглэлийн индексийг тооцоолж, холбогдох индикаторуудыг тухайн үзүүлэлт бүрд хувирган тооцож, нэгдсэн үнэлгээнд нэгтгэсэн. Эрсдэлийн нэгдсэн индексийг тооцохдоо дөрвөн үндсэн индексийн утгыг 0-100-ийн хооронд оноогоор илэрхийлж үнэлгээ хийсэн. Үүнд: аюул, өртөх байдал болон эмзэг байдлын индексийн хэмжээ өсөх нь гамшгийн эрсдэлийн түвшинд нэмэлт дарамт үүсгэдэг бол чадавхын индексийн хэмжээ өсөх нь эрсдэлийг бууруулах чиглэлд нөлөөлдөг. Иймд, эрсдэлийн түвшинг тодорхойлохдоо эхлээд аюул, өртөх байдал, эмзэг байдлын индексийн нийлбэрийг гаргаж, дараа нь тухайн нийлбэрээс гамшгаас хамгаалах чадавхын индексийг хасах замаар нэгдсэн эрсдэлийн түвшинг тодорхойлсон.


Сумын нэр	Аюул	Өртөнгө	Эмзэг байдал	Чадавх	Эрсдэл
Баян-Овоо	71	56	54	43	45
Баяндалай	59	53	39	47	34
Булган	64	47	47	52	35
Гурвантэс	68	77	66	51	53
Даланзадгад	75	49	47	52	39
Мандал-Овоо	58	53	49	44	39
Манлай	68	65	52	50	45
Ноён	42	55	60	73	29
Номгон	64	52	53	48	40
Сэврэй	71	77	50	51	50
Ханбогд	72	63	56	60	43
Ханхонгор	66	51	44	47	38
Хүрмэн	55	39	44	57	27
Цогт-Овоо	64	45	48	56	33
Цогтцэций	66	74	48	42	52
Өмнөговь аймаг	**64**	**57**	**50**	**52**	**40**

Хүснэгт 4., Гамшгийн эрсдэлийн тойм судалгааны үр дүн, сумдаар

Өмнөговь аймгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүн

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй аюул, түүнд өртөх байдал, эмзэг байдал болон түүнийг эсэргүүцэн тэмцэх чадавхыг тооцож, гамшгийн эрсдэлийг үнэлэхэд шар буюу дунд түвшинд байгааг тогтоосон. Тус аймгийн гамшгийн эрсдэл дунд түвшинд байгаа хэдий ч аюул, эмзэг байдал, өртөнгийн индексийн үзүүлэлтүүд 50-аас дээш байгаа нь гамшгийн эрсдэл их түвшинд ойрхон байгааг харуулж байна. Иймээс, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол төлөвлөж, байгууллагуудын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр шат дараатайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй.


Сумдын түвшинд хийсэн үнэлгээгээр Даланзадгад, Баян-Овоо, Баяндалай, Булган, Гурвантэс, Мандал-Овоо, Манлай, Номгон, Сэврэй, Ханбогд, Ханхонгор, Цогт-Овоо, Цогтцэций зэрэг сумд дунд зэргийн эрсдэлтэйд тооцогдож байгаа бол Ноён, Хүрмэн сумууд харьцангуй бага эрсдэлийн түвшинд байгааг судалгааны дүн харуулж байна. Газар хөдлөлт, үер, ган, зуд, мал, амьтны гоц халдварт өвчин, хүний гоц халдварт өвчин, халдварт өвчин, хүчтэй салхи шуурганы аюул тус аймагт өндөр байгааг тойм судалгааны үр дүнгээс харж болно. Өмнөговь аймаг нь Монгол орны газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зураглалаар 9-10 баллын хүчтэй газар хөдлөлтийн бүсэд оршдог бөгөөд энэ нь тус бүс нутагт газар хөдлөлтийн аюул өндөр байгааг илтгэнэ.



Зураг 2., Монгол орны нутаг дэвсгэрт 2008 – 2024 онуудад бүртгэгдсэн газар хөдлөлтийн тоо.

Өмнөговь аймагт газар хөдлөлтийн статистик


Өмнөговь аймагт 1964-2024 онд нийт 18,292 газар хөдлөлт бүртгэгдсэнээс, түүний 286 нь магнитуд (M) 4.0 болон түүнээс дээш байсан бөгөөд үүний 20 нь магнитуд (M) 5.0 болон түүнээс их хүчтэй газар хөдлөлтүүд байжээ (Одон орон геофизикийн хүрээлэн, Даланзадгад салбар, 2024). Энэхүү статистик нь тус аймаг газар хөдлөлтийн идэвхжил, түүн дотроо хүчтэй газар хөдлөлтүүдийн тоо нэмэгдэж байгааг харуулж байна.



Зураг 3., Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн идэвхжилт (1964-2024)

Газар хөдлөлтийн идэвхтэй хагарлууд


Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт Буурын хяр, Үнэгтэй, Булагтай зэрэг газар хөдлөлтийн идэвхтэй хагарлууд байрлаж байгаа нь тухайн бүс нутагт газар хөдлөлтийн эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Эдгээр хагарлууд нь газар хөдлөлт үүсэх нөхцөл, аюулын түвшинг өндөрсгөж, бүс нутгийн иргэд, эдийн засаг, байгаль орчныг хор хөнөөлд өртүүлэх эрсдэлийг улам ихэсгэж байгаа юм. Иймд газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах зорилгоор эдгээр хагарлуудын идэвхжил, тэдгээртэй холбоотой гамшигт үзэгдлүүдийг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.



Зураг 4., Өмнөговь аймгийн нутагт орших газар хөдлөлтийн идэвхтэй хагарлууд

Газар хөдлөлтийн тохиолдлын нэмэгдэл

Өмнөговь аймагт газар хөдлөлтийн тохиолдлууд нэмэгдэх хандлагатай байгааг сүүлийн 5 жилийн статистик мэдээнээс харж болно (Зураг 4). Энэхүү мэдээлэл нь тус аймагт газар хөдлөлтийн идэвхжил өсөж байгааг илтгэнэ. Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн давтамж, хүч нь цаашид нэмэгдэх хандлагатай байгааг судалгааны үр дүн, үзүүлэлтүүдээс харах боломжтой бөгөөд энэ нь эрсдэлийн удирдлага, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг нотлон харуулж байна.



Зураг 5., 2020- 2024 онд Өмнөговь аймагт тохиолдсон газар хөдлөлт.

Газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх зорилгоор гамшгийн тойм судалгааны багууд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн сум тус бүрд нарийвчилсан үнэлгээ хийсэн. Үнэлгээний хүрээнд голлох хүчин зүйлс болох аюул, өртөх байдал, эмзэг байдал болон гамшгаас хамгаалах чадавхыг индекс хэлбэрээр тодорхойлж, холбогдох индикаторуудыг тухайн үзүүлэлт бүрд хөрвүүлэн тооцоолж, нэгтгэн дүн шинжилгээ хийсэн болно.

Газар хөдлөлт					
	Аюул	Өртөнгө	Эмзэг байдал	Чадавх	Эрсдэл
Баян-Овоо	59	73	57	45	48
Баяндалай	47	86	63	48	49
Булган	65	47	56	50	39
Гурвантэс	65	80	71	45	56
Даланзадгад	81	65	72	50	55
Мандал-Овоо	65	47	57	42	42
Манлай	65	60	65	45	48
Ноён	57	52	59	62	35
Номгон	81	96	86	45	72
Сэврэй	61	90	62	39	57
Ханбогд	65	55	33	63	30
Ханхонгор	73	81	67	48	57
Хүрмэн	57	33	41	50	27
Цогт-Овоо	65	47	46	51	35
Цогтцэций	65	96	62	33	63
Өмнөговь аймаг	**65**	**67**	**60**	**48**	**48**

Хүснэгт 5., Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн эрсдэлийн түвшин сумдаар

Өмнөговь аймгийн нийт сумдын хувьд газар хөдлөлтийн аюул өндөр гэж үнэлсэн нь энэ аюул бодитой байгааг харуулж байна. Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээгээр Номгон, Цогтцэций сумдад харьцангуй өндөр эрсдэл бүртгэгдэж, эрсдэлийн түвшин 63–72 хувийн хооронд, буюу их түвшинд хүрсэн байна. Харин Хүрмэн сумын хувьд 27 хувийн үнэлгээгээр бага эрсдэлтэйд тооцогдож байгаа бол бусад сумдын эрсдэлийн түвшин 35–57 хувьтай гарч, дунд зэргийн эрсдэлтэй бүс нутагт хамрагдаж байна. Номгон сум нь Монгол Улсын хамгийн өмнөд хэсэгт оршдог бөгөөд аймагтаа томоохон нутаг дэвсгэртэй сумдын тоонд ордог. Нутаг дэвсгэр нь газар зүйн хувьд Монгол Алтайн уулархаг мужид багтах Буур, Номгон, Булган, Цохио, Халзан, Далангийн нуруу, Хачиг Хөрх, Гурван гэдрэгийн нуруу зэрэг өндөрлөг уулстай учир газар хөдлөлтийн гамшгийн аюул, түүнд өртөх байдал болон эмзэг байдал ихтэй учраас эрсдэл өндөр гэж тойм судалгааны баг үнэлсэн байна. Цогтцэций сумын хувьд засаг захиргааны анхан шатны нэгж болох 4 багтай, нийт хүн ам 6680, хөдөлгөөнт хүн ам 16100, 2300 гаруй өрхтэй. Хүн амын нягтрал, суурин болон хөдөлгөөнт хүн амын ихтэй байдал нь эрсдэлийг улам нэмэгдүүлж байна. Цогтцэций сум 2 ба түүнээс дээш давхар нийт 68 барилгатай. Эдгээрийн 66 нь “Барилгын тухай” хууль, “Барилгын дүрэм”-үүдийг тус тус хэрэгжүүлээгүй бөгөөд барилга байгууламжийг аж ахуйн аргаар барьж, ашиглалтад оруулах зөвшөөрөл авалгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь эрсдэл өндөр байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Түүнчлэн, **"Таван толгой" ХК**, **"Энержи ресурс"**, **"Эрдэнэс таван толгой"** зэрэг уул уурхайн томоохон компаниуд орон нутагт олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж, орон нутгийн эдийн засагт тодорхой хэмжээний хувь нэмрээ оруулж байгаа хэдий ч, эдгээр компанийн үйл ажиллагааны онцлог нь гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Иймээс сумын ард иргэдэд газар хөдлөлтийн үеийн аюулгүй байдал, бэлэн байдлаа хангах талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, сумын

барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг тодорхойлох, насжилт өндөр барилгыг хүчитгэх, арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх, барилгын норм дүрэм журмыг баримтлах шаардлагатай.

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тооцоход барилга байгууламжийн тэсвэржилт хамгийн чухал үзүүлэлтийн нэг юм.

Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 898 барилга ашиглаж байна. Үүнээс:

Нийтийн орон сууцны барилга - 216

Ерөнхий боловсролын сургуулийн барилга-26

Сургуулийн дотуур байр- 18

Цэцэрлэгийн барилга-33


Эмнэлгийн барилга-31

Бусад аж ахуйн нэгж, дагалдах барилгууд – 574


Үүнээс Даланзадгад суманд сургуулийн байр 9, дотуур байр 3, цэцэрлэгийн байр 10, Эмнэлгийн байр 13, орон сууц 47 байна. (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын судалгаа, 2024)

№	Байршил	Сургууль	Цэцэрлэг	Эмнэлэг	Орон сууц
1	Баяндалай сум	1	1	1	3
2	Хүрмэн сум	1	1	2	5
3	Цогтцэций сум	2	4	2	21
4	Баян-Овоо сум	1	1	2	5
5	Булган сум	1	2	2	27
6	Гурвантэс сум	3	4	1	6
7	Мандал-Овоо сум	1	2	1	6
8	Манлай сум	1	1	1	11
9	Ноён сум	1	1	1	3
10	Номгон сум	1	1	1	13
11	Сэврэй сум	1	1	1	12
12	Ханбогд сум	1	2	1	11
13	Ханхонгор сум	1	1	1	7
14	Цогт-Овоо сум	1	1	1	2
	Нийт	**26**	**23**	**18**	**168**

Хүснэгт 11., Өмнөговь аймгийн сумдын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, орон сууцны барилгын судалгаа.




Зураг 12., Сумдын барилгуудыг насжилтаар нь ангилсан байдал. (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, 2024)



Зураг 13., Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн эрсдэл, сумдаар

Барилгын үндсэн хийц бүтээцэд үүссэн эвдрэл гэмтэл нь барилгын бат бэх чанар, газар хөдлөлтийн тэсвэржилтийг бууруулж байна.



Зураг 14., Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн эрсдэл

Дүгнэлт

1. Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн эрсдэл 15 сумын дунд Номгон, Цогтцэций сумд нь 63-72%-тай их эрсдэлтэй, Хүрмэн сум 27%-тай бага эрсдэлтэй, бусад сумд нь 35-57%-тай дунд эрсдэлтэй байна.

2. Номгон сум нь өндөрлөг уулс бүхий газарт орших тул газар хөдлөлтийн аюул, өртөх байдал, эмзэг байдал өндөр байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

3. Гамшгийн эрсдэлийг бууруулахад улсын болон орон нутгийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай, тухайлбал орон сууцны барилгын норм, стандартуудыг сайжруулах.

4. Өмнөговь аймгийн барилга байгууламжуудын 54.3% нь насжилт өндөртэй, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар муутай байгаагаас эрсдэл нэмэгдэж байна. Барилга байгууламжийг паспортжуулж, хүчитгэх, засвар хийх шаардлагатай.

5. Сумдын барилгуудын 58% нь 1971-1990 онд баригдсан бөгөөд энэ нь газар хөдлөлтийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Барилга байгууламжийн зөрчилд газар хөдлөлтийн тэсвэржилтийн тооцоо

судалгаагүй, ачааллыг хэтрүүлэн өгсөн, зураг төсөлд өөрчлөлт оруулсан зэрэг асуудлууд байна.

Эх сурвалж

1. Жонс, А., & Смит, Р. (2020). Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ идэвхтэй сейсмийн бүсүүдэд. Газар хөдлөлтийн судалгаа, 35(2), 47-58.
2. Э.Халиун. (2024). Өмнөговь аймгийн гамшигт үзэгдлүүд: Сүүлийн үеийн хандлага. Монголын Байгаль Орчны Судалгаа, 12(1), 3-8.
3. Ус цаг уур орчны шинжилгээний газар. (2024). Монгол улсын цаг уурын болон орчны нөхцөл. https://www.weather.gov.mn
4. Бүх шатны гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, гамшгаас хамгаалах албадын бүрэлдэхүүнд зориулсан гарын авлага. (2024).
5. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний аргачлал. (2012).
6. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар. (2017).
7. Д.Сэржмядаг. (2017). Гамшгаас хамгаалах менежментийн үндэс. Улаанбаатар: Гэрэл хэвлэл.
8. Монгол Улсын Шадар сайдын 68 дугаар тушаал. (2021).
9. Одон орон геофизикийн хүрээлэн Даланзадгад салбар. (2024).
10. Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын тоо мэдээ. (2024).
11. Өмнөговь аймгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ зохион байгуулах ажлын хэсгийн тайлан. (2024).
12. Өмнөговь аймгийн гамшиг ослын 2020-2024 оны статистик тоо баримт. (2024).
13. Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын дүн бүртгэл. (2024).
14. Өмнөговь Онцгой байдлын газрын дүн бүртгэл. (2024).
15. Ус цаг уур орчны шинжилгээний газар. (2024).
16. ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн “Эрдэм шинжилгээний болон үйл ажиллагааны тайлан”. (2019).
17. Э.Халиун. (2024). Өмнөговь аймаг Онцгой байдлын газар дүн бүртгэл, 4.
18. АНУ-ын Газар хөдлөлтийн судалгааны төв. (2021). Монгол улсын газар хөдлөлтийн эрсдэлийн бүс. https://www.usgs.gov

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НУРАНГИД ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНД ГАЛ СӨНӨӨГЧДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

THE ROLE OF FIREFIGHTERS IN URBAN SEARCH AND RESCUE OPERATIONS IN COLLAPSED BUILDINGS AND STRUCTURES

Б.Ганзагас*
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, ахмад
Ganzagas B.
Captain, Scientific Senior Researcher-Lecturer, Research Institute, University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: Ganzagas615@gmail.com

Хураангуй: Барилга байгууламжийн нуралт нь байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшгийн үед үүсдэг, хүний амь нас, эрүүл мэнд болон нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учруулах эрсдэлтэй үзэгдэл юм. Ийм нөхцөлд эрэн хайх, аврах ажиллагааг богино хугацаанд оновчтой зохион байгуулах нь хохирлыг бууруулахад шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд гал сөнөөгчид анхны хариу арга хэмжээ авагчдын хувьд гол үүргийг гүйцэтгэдэг.

Энэхүү судалгаагаар барилгын нурангид явуулах эрэн хайх, аврах ажиллагаанд гал сөнөөгчдийн оролцоо, хэрэгжүүлэх тактик, зохион байгуулалтын онцлогийг авч үзэн, олон улсын туршлага, стандартуудтай харьцуулан дүгнэсэн. Үр дүнгээс харахад мэргэжлийн бэлтгэл, зөв тактик сонголт, зохион байгуулалтын оновчтой бүтэц, техник, тоног төхөөрөмжийн хангалт нь ажиллагааны үр дүн, шуурхай байдалд шууд нөлөөлдөг байна.

Мөн нурангид ажиллах үед үүсэх хоёрдогч нуралт, гал түймэр, хий алдагдал зэрэг нэмэлт эрсдэлийг бууруулахад уялдаа холбоотой ажиллагаа онцгой ач холбогдолтой гэж үзэв. Монгол Улсын хувьд сургалт, дадлага, техник технологи болон олон улсын стандартын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Abstract: Structural collapse represents a serious hazard that may occur as a result of natural disasters or human-related factors, causing significant impacts on human life, public safety, and socio-economic conditions. In these situations, rapid and well-organized search and rescue operations are essential, while firefighters serve as primary responders during the initial stage of emergency response.

This research analyzes the role of firefighters in urban search and rescue operations conducted in collapsed buildings and structures, with particular attention to operational tactics and organizational coordination. The study also reviews relevant international standards and practices to compare them with current approaches applied in Mongolia. The analysis suggests that the effectiveness of rescue operations is closely associated with professional preparedness, tactical decision-making, organizational coordination, and the availability of technical resources and equipment.

In addition, rescue operations in collapsed structures often involve secondary risks, including further structural failure, fire outbreaks, and gas leakage, which require coordinated and safety-oriented response measures. Based on the findings, the study emphasizes the need to strengthen training systems, practical exercises, technological capacity, and the application of international standards within Mongolia's emergency response framework.

Түлхүүр үг: Барилга байгууламжийн нуралт, эрэн хайх, аврах ажиллагаа, гал сөнөөгч, анхны хариу арга хэмжээ, олон улсын стандарт

Keywords: Building collapse, search and rescue operations, firefighters, first response, emergency response

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад хотжилт эрчимжихийн хэрээр барилга байгууламжийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэл нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Үүний нэг илрэл нь барилгын нуралт бөгөөд энэ нь зөвхөн инженерийн асуудал бус, хүний амь нас, нийгмийн аюулгүй байдалтай шууд

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

холбоотой асуудал юм. Ийм нөхцөлд эрэн хайх, аврах ажиллагааг зөв зохион байгуулах нь хохирлыг бууруулах гол хүчин зүйл болдог. Ялангуяа газар хөдлөлт, гал түймэр, дэлбэрэлт, барилгын хийцийн доголдол, ашиглалтын зөрчил зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсэх нуралт нь богино хугацаанд олон хүнийг нурангид дарагдах нөхцөлийг бүрдүүлдэг онцлогтой. Ийм нөхцөлд эрэн хайх, аврах ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй, шуурхай зохион байгуулах нь хүний амь насыг аврах үндсэн хүчин зүйл болдгийг судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг (Онцгой байдлын ерөнхий газар, 2020).

Нурангид эрэн хайх, аврах ажиллагаанд оролцогчдын дотроос гал сөнөөгчид нь анхны хариу арга хэмжээ авагчдын хувьд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Тэд ослын газарт хамгийн түрүүнд хүрэлцэн очиж, нөхцөл байдлын анхан шатны үнэлгээ хийх, эрсдэлийг тодорхойлох, амьд үлдсэн иргэдийг илрүүлэх, аврах, гал түймэр болон хоёрдогч аюулыг хяналтад авах зэрэг олон талт үүргийг хэрэгжүүлдэг (Онцгой байдлын ерөнхий газар, 2019). Энэ утгаараа гал сөнөөгчдийн үйл ажиллагаа нь зөвхөн аврах ажиллагаагаар хязгаарлагдахгүй, харин ослын бүсийн нийт аюулгүй байдлыг хангах, удирдлагын зохион байгуулалтыг тогтворжуулахад чиглэгддэг иж бүрэн шинжтэй байна. Гал сөнөөгчдийн тактикийн шийдвэр гаргалт, зохион байгуулалтын уялдаа нь аврах ажиллагааны үр дүнг тодорхойлох гол хүчин зүйлсийн нэг юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад хотжилт, барилгажилтын эрчимжилт нэмэгдэж байгаатай холбоотойгоор барилга байгууламжийн аюулгүй байдал, гамшгийн эрсдэлийн асуудал улам бүр анхаарал татах болсон. Үүнтэй уялдан барилга байгууламжийн нурангид эрэн хайх, аврах ажиллагааг боловсронгуй болгох, олон улсын стандарт, арга зүйг нэвтрүүлэх шаардлага бий болж байна. Гэсэн хэдий ч уг чиглэлээр гал сөнөөгчдийн үүрэг, тактик, зохион байгуулалтын асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалсан дотоодын судалгаа харьцангуй хомс байгаа нь ажиглагдаж байна. Үүнийг судлаачийн хувьд салбарын судалгааны чухал орон зай гэж үзэж байна.

Иймд энэхүү судалгааны зорилго нь барилга байгууламжийн нурангид эрэн хайх, аврах ажиллагаанд гал сөнөөгчдийн гүйцэтгэх үүрэг, хэрэглэгдэх тактик, зохион байгуулалтын онцлогийг онол, практикийн түвшинд задлан шинжлэхэд оршино. Дотоод болон гадаадын туршлага, эрх зүйн орчин, мэргэжлийн стандартуудыг харьцуулан судалж, Монгол Улсын нөхцөлд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон, цаашид хэрэгжүүлэх арга замын талаар санал дэвшүүлэхийг зорьж байна. Энэхүү судалгаа нь аврах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, гал сөнөөгчдийн мэргэжлийн чадавхыг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулах боломжтой юм.

Судалгааны арга зүй

Энэхүү ажлын хүрээнд барилга байгууламжийн нурангид эрэн хайх, аврах ажиллагаанд гал сөнөөгчдийн гүйцэтгэх үүрэг, тактик, зохион байгуулалтын онцлогийг судлах зорилгоор чанарын судалгааны аргыг ашиглав. Судалгааны хүрээнд онолын болон практик мэдээллийг нэгтгэн шинжлэхдээ баримт бичгийн шинжилгээ, харьцуулсан судалгааны арга, задлан шинжилгээний аргыг хослуулан хэрэглэсэн.

Судалгааны эх сурвалжид гамшгаас хамгаалах болон эрэн хайх, аврах ажиллагаатай холбоотой олон улсын стандарт, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны бүтээл, мөн Монгол Улсын хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийг ашигласан. Тухайлбал, INSARAG-ийн удирдамж, FEMA болон NFPA-ийн холбогдох стандарт, аврах ажиллагааны зохион байгуулалтын талаарх судалгааны материалуудыг судлан үзэж, Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоо, гал түймэр унтраах болон аврах ажиллагааны практиктай харьцуулан дүн шинжилгээ хийсэн. Мөн барилга байгууламжийн нуралтын үед үүсэх эрсдэл, аврах ажиллагааны үе шат, гал сөнөөгчдийн оролцоо, үүргийн хуваарилалт, тактикийн шийдвэр гаргалт зэрэг асуудлыг системийн

хандлагаар авч үзсэн. Судалгаанд ашигласан харьцуулсан шинжилгээний арга нь олон улсын туршлага болон үндэсний нөхцөл байдлын ялгаа, ижил талыг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх боломжтой арга замыг тодорхойлоход чиглэсэн болно.

Түүнчлэн эрэн хайх, аврах ажиллагааны үр нөлөөнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор мэргэжлийн бэлтгэл, техник, тоног төхөөрөмжийн хангалт, байгууллага хоорондын уялдаа холбоо, нэгдсэн удирдлагын тогтолцооны хэрэгжилт зэрэг асуудлыг судалгааны хүрээнд задлан шинжилсэн.

Нэг. Барилга байгууламжийн нуралтын тухай ойлголт, нуралтын ангилал

Барилга байгууламжийн нуралтыг ойлгохын тулд түүний үүсэх нөхцөл, явц, үр дагаврыг олон талаас нь авч үзэх шаардлагатай байдаг. Судалгааны практикт нуралтыг ихэвчлэн хамрах хүрээ, үүсэх хурд, бүтээцийн эвдрэл болон шалтгааны шинжээр ангилж үздэг бөгөөд энэ нь аврах ажиллагаанд тохирох арга хэмжээг сонгоход чухал үндэс болдог. Энэ үзэгдэл нь ихэвчлэн нэг шалтгаанаар бус, харин олон төрлийн нөлөөллийн огтлолцлоор илэрдэг бөгөөд тухайн барилгын хийц, ашиглалтын нөхцөл, гадна орчны нөлөөллөөс шууд хамааралтай байдаг (Барилга, хот байгуулалтын яам, 2018).

Энэхүү нөхцөл нь барилгын нуралтыг зөвхөн зураг төслийн алдаа эсвэл материалын чанартай холбон тайлбарлах нь хангалтгүй бөгөөд бүтээцийн ачааллын дахин хуваарилалт, системийн тэнцвэрт байдал алдагдах механизмыг хамтад нь авч үзэх шаардлагатай байна (Шинжлэх ухаан, технологийн их сургууль, 2019). Ялангуяа нэг бүтээцийн элемент гэмтсэний дараа ачаалал бусад хэсгүүдэд шилжиж, улмаар дараалсан эвдрэл үүсэх хандлага нь нуралтын динамикийг тодорхойлох гол шинж гэж үзэж байна.

Үүнээс харахад барилгын нуралтыг “системийн эвдрэл” (system failure)-ийн хүрээнд авч үзэх нь илүү оновчтой бөгөөд энэ нь зөвхөн нэг элемент бус, харин бүхэл бүтцийн уялдаа алдагдсантай холбоотойгоор тайлбарлагдах ёстой гэж үзэж байна. Иймхандлага нь нуралтын шалтгааныг илүү гүнзгий ойлгох боломжийг олгохоос гадна аврах ажиллагааны тактик боловсруулахад чухал ач холбогдолтой юм (Дотоод хэргийн их сургууль, 2021).

Нөгөө талаас нуралтын дараах орчин нь зөвхөн бүтээцийн эвдрэлээр хязгаарлагдахгүй, харин олон төрлийн хавсарсан эрсдэлийг дагуулдаг онцлогтой. Үүнд гал түймэр, хий алдагдал, тооcжилт, хоёрдогч нуралт зэрэг аюулууд багтах бөгөөд эдгээр нь аврах ажиллагааны нөхцөлийг хүндрүүлдэг. Үүнээс харахад ийм орчныг “олон эрсдэлийн нэгдсэн орчин” гэж тодорхойлох нь илүү зохимжтой бөгөөд энэ нь аврах ажиллагааны тактик, зохион байгуулалтад шууд нөлөөлдөг (Онцгой байдлын ерөнхий газар, 2021).

Монгол Улсын нөхцөлд барилгын ашиглалтын үеийн хяналт сул, стандарт мөрдөлт хангалтгүй байгаа нь нуралтын эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийн нэг гэж үзэж байна. Ялангуяа барилгын зориулалтыг өөрчлөх, даац хэтрүүлэх, техникийн үзлэгийг тогтмол хийхгүй байх зэрэг нь бүтээцийн аюулгүй байдлыг алдагдуулж, улмаар нуралтын нөхцөлийг бүрдүүлж байна (Барилга, хот байгуулалтын яам, 2018). Иймээс барилга байгууламжийн аюулгүй байдлыг зөвхөн барилгын үе шатанд бус, ашиглалтын бүх хугацаанд тасралтгүй хангах шаардлагатай гэж дүгнэж байна.

Дээрхээс дүгнэхэд барилга байгууламжийн нуралтыг судлах нь зөвхөн инженерийн асуудал биш бөгөөд гамшгийн эрсдэлийн удирдлага, аврах ажиллагааны онол, практикт чухал ач холбогдолтой юм. Судлаачийн дүгнэлтээр нуралтын шалтгаан, онцлогийг гүнзгий ойлгосноор эрэн хайх, аврах ажиллагааны тактик, зохион байгуулалтыг илүү оновчтой төлөвлөх боломж бүрдэнэ.

Барилга байгууламжийн нуралтыг олон шалгуураар ангилж үздэг бөгөөд энэ нь аврах ажиллагааны арга зүй боловсруулахад чухал ач холбогдолтой. Үүнд:

- **Хэмжээ, хамрах хүрээгээр:**

• Бүрэн нуралт (барилгын үндсэн бүтээц бүхэлдээ тогтвортой байдлаа алдаж, их хэмжээний нуранги үүссэн нөхцөл байдал гэж авч үзэв. Ийм төрлийн нуралтын үед аврагдах боломжит орон зай хязгаарлагдмал байдаг тул эрэн хайх, аврах ажиллагаа өндөр эрсдэлтэй орчинд явагдах онцлогтой.)

• Хэсэгчилсэн нуралт (барилгын тодорхой хэсэг эвдэрсэн боловч үлдсэн бүтээц тодорхой хэмжээнд тогтвортой хэвээр үлдсэн нөхцөлөөр илэрнэ. Энэ тохиолдолд дахин нуралт үүсэх эрсдэлтэй хэдий ч аврагдах орон зай үүсэх боломж илүү байдаг тул аврах ажиллагааг нарийвчилсан байдлаар зохион байгуулах шаардлагатай болдог.)

- **Үүсэх хурд, шинж чанараар:**

• Гэнэтийн нуралт (урьдчилсан шинж тэмдэг багатай, богино хугацаанд огцом үүсдэг бүтээцийн эвдрэл гэж үзэв. Ийм нөхцөлд хүмүүсийн өөрийгөө хамгаалах хугацаа хязгаарлагдмал байдаг тул хүний хохирол нэмэгдэх эрсдэл өндөртэй байдаг.)

• Аажим нуралт (тодорхой хугацааны туршид үе шаттайгаар үүсэж, урьдчилсан шинж тэмдэг илэрдэг нуралтыг хэлнэ. Үүнд ан цав, хэв гажилт, суулт, материалын элэгдэл зэрэг өөрчлөлтүүд хамаарна. Энэ төрлийн нуралтын үед барилгын даацын чадвар аажмаар буурдаг тул урьдчилан илрүүлж, засвар бэхжүүлэлт хийх замаар эрсдэлийг бууруулах боломжтой байдаг.)

- **Бүтээцийн эвдрэлээр:**

• Анхдагч нуралт (барилгын тодорхой бүтээцийн элемент (багана, дам нуруу, ханын хийц зэрэг) эвдэрснээр үүсэх эхний шатны нуралтыг хэлнэ. Энэ нь ихэвчлэн хэт ачаалал, материалын доголдол, гал түймрийн нөлөө зэрэг шалтгаанаар үүсдэг бөгөөд тухайн элемент даацын үүргээ алдах үед барилгын тогтвортой байдал алдагдаж эхэлдэг. Ийм нуралт нь хязгаарлагдмал хүрээнд илрэх боловч цаашдын нуралтын эхлэл болох эрсдэлтэй байдаг.)

• Дам нуралт (анхдагч нуралтын дараа ачааллын дахин хуваарилалтын улмаас бусад бүтээцийн элементүүд дараалан эвдэрч, нуралтын хүрээ тэлэх процессыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, нэг элемент эвдэрснээр ачаалал бусад хэсэгт шилжиж, улмаар “гинжин урвал” хэлбэрийн нуралт үүсдэг. Энэ төрлийн нуралт нь барилгын ихэнх хэсгийг хамарч, хохирлын хэмжээг нэмэгдүүлэх эрсдэлтэй байдаг.)

- **Шалтгаанаар:**

• Байгалийн гаралтай нуралт (газар хөдлөлт, үер, хөрсний гулсалт, хүчтэй салхи, шуурга зэрэг байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр үүсдэг. Энэ төрлийн нуралт нь ихэвчлэн гэнэтийн шинжтэй, өргөн хүрээг хамардаг бөгөөд олон барилга байгууламжид нэгэн зэрэг нөлөөлөх боломжтой тул аврах ажиллагааг өргөн цар хүрээнд зохион байгуулах шаардлага үүсдэг.)

• Техноген гаралтай нуралт (хүний үйл ажиллагаа, техникийн болон зохион байгуулалтын алдаанаас үүдэн бий болдог. Үүнд зураг төслийн доголдол, чанарын шаардлага хангаагүй материал, даац хэтрүүлэх, ашиглалтын зөрчил, гал түймэр, дэлбэрэлт зэрэг хүчин зүйлс хамаарна. Энэ төрлийн нуралт нь ихэвчлэн тодорхой нэг барилга байгууламжид төвлөрдөг бөгөөд урьдчилан сэргийлэх боломжтой, хариуцлагын асуудал дагуулдгаараа онцлогтой.)

• Холимог нуралт (байгалийн болон техноген хүчин зүйлсийн хам нөлөөгөөр үүсдэг. Тухайлбал, газар хөдлөлтийн үед стандартын шаардлага хангаагүй барилга нурах, үерийн улмаас суурийн хийц суларсан барилга эвдрэх зэрэг тохиолдол үүнд хамаарна. Энэ төрлийн нуралт нь шалтгааны хувьд нарийн төвөгтэй бөгөөд хохирол, эрсдэлийн түвшин өндөр байдгаараа онцлогтой.)

Хоёр. Барилга байгууламжийн нурангид эрэн хайх, аврах ажиллагаанд гал сөнөөгчдийн гүйцэтгэх үүрэг

Барилга байгууламжийн нурангид эрэн хайх, аврах ажиллагаанд гал сөнөөгчид нь анхны хариу арга хэмжээ авагчдын хувьд онцгой ач холбогдол бүхий, шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг. Тэд ослын бүсэд хамгийн түрүүнд хүрэлцэн очиж, нөхцөл байдлын анхан шатны үнэлгээ хийх, эрсдэлийн түвшнийг тодорхойлох, аврах ажиллагааны эхний зохион байгуулалтыг бүрдүүлэх зэрэг үндсэн үйл ажиллагааг

хэрэгжүүлдэг (Онцгой байдлын ерөнхий газар, 2021). Энэхүү анхны үнэлгээ нь цаашдын эрэн хайх, аврах ажиллагааны чиглэл, тактик, нөөцийн оновчтой хуваарилалтыг тодорхойлох суурь нөхцөл болдог.

Судалгааны хүрээнд авч үзэхэд гал сөнөөгчдийн үйл ажиллагаа нь уламжлалт ойлголтоор зөвхөн гал унтраах чиг үүргээр хязгаарлагдахгүй, харин эрэн хайх, аврах, анхны эмнэлгийн тусламж үзүүлэх, аюулгүй байдлыг хангах, ослын бүсийн хяналт тогтоох зэрэг олон чиг үүргийг багтаасан иж бүрэн, уялдаа холбоотой системт үйл ажиллагаа болох нь тодорхой байна (Онцгой байдлын ерөнхий газар, 2019). Тухайлбал, нурангид дарагдсан иргэдийг илрүүлэхийн тулд гал сөнөөгчид дуу авиа, дулаан мэдрэгч, камер зэрэг орчин үеийн техник хэрэгслийг ашиглахын зэрэгцээ аврах ажиллагааны явцад нурангийг тогтворжуулах, аюулгүй гарц гаргах, аврагдах орон зайг хамгаалах зэрэг инженерийн шинжтэй нарийн ажиллагааг гүйцэтгэдэг.

Үүний зэрэгцээ нуралтын дараах орчинд гал түймэр, хий алдагдал, цахилгааны аюул, дахин нуралт зэрэг хоёрдогч аюулууд үүсэх магадлал өндөр байдаг бөгөөд эдгээрийг хяналтад авах, бууруулах нь гал сөнөөгчдийн үндсэн үүргийн салшгүй хэсэг болдог (Барилга, хот байгуулалтын яам, 2018). Үүнээс харахад хоёрдогч аюулыг бууруулах арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэхгүй тохиолдолд аврах ажиллагааны явцад нэмэлт хохирол үүсэх, цаашлаад аврагчдын аюулгүй байдалд шууд заналхийлэх эрсдэлтэй байна.

Мөн гал сөнөөгчид нь аврах ажиллагаанд оролцогч бусад байгууллага, нэгжүүдтэй (эмнэлгийн байгууллага, цагдаа, инженерийн баг гэх мэт) нягт уялдаа холбоотой ажиллах шаардлагатай байдаг. Судалгааны явцад олон байгууллагын хоорондын уялдаа сул, мэдээлэл солилцоо хангалтгүй байх нь үүргийн давхардал, зохион байгуулалтын алдагдал үүсгэж, улмаар аврах ажиллагааны үр нөлөөг бууруулж байгааг ажиглагдлаа (Дотоод хэргийн их сургууль, 2021). Иймээс нэгдсэн удирдлагын тогтолцоо, зохион байгуулалтын уялдааг хангах нь практик ач холбогдолтой асуудал юм.

Гал сөнөөгчдийн гүйцэтгэх үүргийг дараах үндсэн чиглэлүүдэд ангилан авч үзэж болно. Үүнд:

- **Анхны хариу арга хэмжээ**

Гал сөнөөгчид ослын газарт хамгийн түрүүнд хүрэлцэн очиж:

- Нөхцөл байдлын үнэлгээ хийх
- Аюулын түвшнийг тодорхойлох
- Аврах ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Энэ үе шат нь цаашдын ажиллагааны амжилтыг тодорхойлдог чухал үе шат юм.

- **Эрэн хайх ажиллагаа**

Гал сөнөөгчид нурангид дарагдсан хүмүүсийг илрүүлэх зорилгоор:

- Дуу авиагаар хайх
- Тусгай төхөөрөмж (камер, мэдрэгч) ашиглах
- Эрэлч нохой ашиглах

- **Аврах ажиллагаа**

Аврах ажиллагаанд:

- Нуранги цэвэрлэх
- Амьд үлдсэн хүнийг гаргах
- Анхны тусламж үзүүлэх

Судлаачийн үзэж байгаагаар аврах ажиллагаанд “хурд ба аюулгүй байдал”-ын тэнцвэрийг хадгалах нь хамгийн чухал асуудал юм.

- **Аюулгүй байдлыг хангах**

Гал сөнөөгчид:

- Гал түймрийг унтраах
- Хийн алдагдлыг зогсоох
- Дахин нуралт үүсэхээс сэргийлэх

Энэ нь аврагч болон иргэдийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл болдог.

- **Зохион байгуулалт, уялдаа**

Гал сөнөөгчид нь:

- Багийн зохион байгуулалтад ажиллах
- Бусад байгууллагатай уялдаа хангах
- Удирдлагын тогтолцоонд (ICS) ажиллах

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад барилга байгууламжийн нуралт нь нэг хүчин зүйлээс бус, харин олон нөхцөл, шалтгааны

нийлбэр нөлөөгөөр үүсдэг цогц үзэгдэл болох нь тодорхой байна. Иймд түүний хор уршгийг бууруулахад зөвхөн нэг арга хэмжээ хангалтгүй бөгөөд аврах ажиллагааг олон талт байдлаар төлөвлөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, аврах ажиллагааны үр дүн нь зөвхөн гал сөнөөгчдийн ур чадвараас хамаарахгүй, харин олон байгууллагын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, нэгдсэн удирдлагын тогтолцоо, орчин үеийн техник хэрэгслийн хангалт зэрэг олон хүчин зүйлийн нэгдлээс шууд хамаардаг.

Иймд аврах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн удирдлагын тогтолцоог (жишээлбэл, ICS) бодит нөхцөлд үр ашигтай хэрэгжүүлэх, мэдээллийн урсгалыг шуурхай, найдвартай болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Мөн мэргэжлийн бэлтгэл, дадлага сургуулилтыг тасралтгүй сайжруулж, бодит нөхцөлд ойртуулсан сургалтын арга хэлбэрийг нэвтрүүлэх нь аврагчдын шийдвэр гаргах чадвар, бэлэн байдлыг нэмэгдүүлэх чухал хүчин зүйл юм.

Нөгөө талаас техник, технологийн дэвшлийг аврах ажиллагаанд үр ашигтай нэвтрүүлэх, тухайлбал нурангид эрэл хайгуул хийхэд ашиглагдах мэдрэгч, дулаан илрүүлэгч камер, робот техник зэрэг орчин үеийн шийдлүүдийг үе шаттайгаар ашиглах нь ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой. Үүний зэрэгцээ барилга байгууламжийн аюулгүй байдлын стандарт, хяналтын тогтолцоог сайжруулах замаар нуралтын эрсдэлийг бууруулах нь урьдчилан сэргийлэх бодлогын чухал хэсэг болох нь харагдаж байна.

Иймээс цаашид энэхүү чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааг гүнзгийрүүлэх, олон улсын туршлага, стандартыг үндэсний нөхцөлд нийцүүлэн нутагшуулах, бодлого, төлөвлөлтийн түвшинд хэрэгжихүйц, уялдаа холбоотой шийдлүүдийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна. Энэ нь эрэн хайх, аврах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхээс гадна иргэдийн аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулахад бодит хувь нэмэр оруулах юм.

Санал

Дүгнэлтэд үндэслэн барилга байгууламжийн нурангид эрэн хайх, аврах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Гал сөнөөгчдийн гүйцэтгэх үүрэг, оролцоог олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, стандартчилах шаардлагатай байна. Энэ нь аврах ажиллагааны үе шат бүрд үүргийн тодорхой байдал, хариуцлагын хуваарилалтыг сайжруулж, ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх үндэс болно.
- Барилга байгууламжийн нурангид ажиллах тактик, арга зүйг нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болгох, олон төрлийн эрэн хайх аргачлалыг хослуулан хэрэглэх сургалт, дадлагажуулалтыг тогтмол зохион байгуулах нь зүйтэй. Судлаачийн үзэж байгаагаар практикт суурилсан сургалт нь онолын мэдлэгийг бататгах, шийдвэр гаргах чадварыг сайжруулахад чухал ач холбогдолтой.
- Аврах ажиллагаанд оролцогч байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцоог сайжруулах, нэгдсэн удирдлагын тогтолцоог (ICS) бодит нөхцөлд үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь үүргийн давхардал, зохион байгуулалтын алдагдлыг бууруулах боломжийг бүрдүүлнэ.
- Техник, тоног төхөөрөмжийн хангалтыг үе шаттайгаар сайжруулж, орчин үеийн эрэн хайх, аврах технологийг нэвтрүүлэх нь зүйтэй. Ялангуяа нурангид илрүүлэлт хийхэд ашиглагдах мэдрэгч, камер, робот техник зэрэг дэвшилтэт хэрэгслийг нэвтрүүлэх шаардлагатай.
- Гал сөнөөгчдийн мэргэжлийн сургалт, дадлагажуулалтын тогтолцоог олон улсын стандарттай уялдуулан шинэчлэх, тасралтгүй хөгжлийн системийг бүрдүүлэх нь чухал байна. Энэ нь аврагчдын ур чадвар, бэлэн байдлыг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглэнэ.
- Барилга байгууламжийн аюулгүй байдлын хяналт, стандартын хэрэгжилтийг сайжруулах замаар нуралтын эрсдэлийг бууруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Барилга, хот байгуулалтын яам. (2018). *Барилгын аюулгүй ажиллагааны дүрэм.* Улаанбаатар хот: Мөнхийн үсэг ХХК.
2. Барилга, хот байгуулалтын яам. (2018). *Барилгын аюулгүй ажиллагааны норм ба дүрэм.* Улаанбаатар хот: Мөнхийн Үсэг ХХК.
3. Барилга, хот байгуулалтын яам. (2018). *Барилгын норм ба дүрэм.* Улаанбаатар хот: Адмон хэвлэлийн компани.
4. Дотоод хэргийн их сургууль. (2021). *Гамшгийн менежмент.* Улаанбаатар хот: ДХИС-ийн хэвлэл.
5. Дотоод хэргийн их сургууль. (2021). *Гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт.* Улаанбаатар хот: ДХИС-ийн хэвлэл.
6. Онцгой байдлын ерөнхий газар. (2019). *Аврагч-гал сөнөөгчийн албаны сургалтын материал.* Улаанбаатар хот: ОБЕГ-ын хэвлэл.
7. Онцгой байдлын ерөнхий газар. (2019). *Аврагч-гал сөнөөгчийн үүрэг, ажиллагаа.* Улаанбаатар хот: ОБЕГ-ын хэвлэл.
8. Онцгой байдлын ерөнхий газар. (2020). *Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны гарын авлага.* ОБЕГ-ын хэвлэл: Улаанбаатар хот.
9. Онцгой байдлын ерөнхий газар. (2021). *Аврах ажиллагааны гарын авлага.* Улаанбаатар хот: ОБЕГ-ын хэвлэл.
10. Онцгой байдлын ерөнхий газар. (2021). *Аврах ажиллагааны зохион байгуулалт.* Улаанбаатар хот: Соёмбо принтинг ХХК.
11. Шинжлэх ухаан, технологийн их сургууль. (2019). *Барилгын бүтээцийн онол.* Улаанбаатар хот: Адмон хэвлэлийн компани.
12. Шинжлэх ухаан, технологийн их сургууль. (2019). *Барилгын бүтээцийн онол, УБ.* Улаанбаатар хот: Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хэвлэл.

THE ROLE OF NON-GOVERNMENTAL ORGANIZATIONS AND AN EVALUATION OF THE LEGAL FRAMEWORK IN STRENGTHENING DISASTER RESILIENCE

ГАМШГИЙН ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО БА ЭРХЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

С.Амартүвшин*
Анкарагийн Нийгмийн Ухааны Их Сургуулийн магистрант
Amartuvshin S.
Master's Student at Social Sciences University of Ankara

*Хариуцлагатай зохиогч: amartuvshin.sainbayar@student.asbu.edu.tr

Хураангуй: Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын гамшгийн удирдлагын тогтолцоонд төрийн бус байгууллагуудын (ТББ) гүйцэтгэх үүрэг, оролцоо болон тэдгээрийн эрх зүйн орчны өнөөгийн байдалд үнэлгээ өгөхийг зорив.

Судалгаанд баримт бичгийн шинжилгээ болон харьцуулсан аргуудыг ашиглан Гамшгаас хамгаалах тухай хууль болон үндэсний төлөвлөгөөнүүдэд ТББ-ын оролцоог хэрхэн тусгасныг шинжилсэн.

Судалгааны үр дүнд манай улсын эрх зүйн орчинд ТББ-уудын оролцоог тунхаглалын шинжтэй заасан боловч санхүү, татварын эдийн засгийн хөшүүрэг тодорхойгүй, мөн Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд олон талт ТББ-уудын оролцоог хязгаарлаж, зөвхөн МУЗН-ийг тусгасан нь нийгмийн даван туулах чадавхыг цогцоор бэхжүүлэхэд саад болж буйг тогтоов.

Иймд ТББ-уудыг нөөцийн чадавхаар нь магадлан итгэмжлэх замаар гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд үндсэн оролцогчоор салбарчлан тусгах механизмыг санал болгож байна.

Abstract: This study aims to evaluate the role and participation of non-governmental organizations (NGOs) in the disaster management system of Mongolia, as well as the current state of their legal environment.

The study applied document analysis and comparative methods to examine how NGO participation is reflected in the Law on Disaster Protection and national disaster management plans.

The results of the study show that, although the legal framework in our country defines the participation of NGOs in a declarative manner, financial and tax-based economic incentives are not clearly specified. Furthermore, national disaster management plans limit the involvement of multi-stakeholder NGOs by including only the Mongolian Red Cross Society (MRCS), which hinders the comprehensive strengthening of societal resilience.

Therefore, the study proposes a mechanism to accredit NGOs based on their resource capacity and to include them as key stakeholders in disaster management plans in a sectoral and structured manner.

Түлхүүр үгс: Гамшиг, Гамшгийн удирдлага, даван туулах чадавх
Keywords: Disaster, Disaster management, Resilience

Introduction

Disasters have existed throughout human history and are hazardous events of natural, human-induced, and technological origin that have a significant impact on societal conditions. Earthquakes, floods, fires, industrial accidents, armed conflicts, and other hazardous events occur with varying frequency, scale, and intensity depending on geographical location, climatic conditions, and the prevailing socio-political environment. These disasters threaten the lives and safety of millions of people, cause billions of dollars in economic losses, and deeply affect social structures.

In a broader sense, a disaster can be defined as a force majeure event caused by natural, technological, or human-induced factors that disrupt or halt the normal functioning of society, resulting in physical and

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

psychological harm to populations and causing substantial economic losses at the regional level. Such events require coordinated and integrated responses from both governmental and non-governmental organizations. In other words, disasters are events that typically occur suddenly, cause damage to human life and property, and cannot be immediately prevented or reversed once they occur (Ramazan & Yavuz, 2019).

According to data from the international database EM-DAT (2026), a total of 8,027 natural disaster events were recorded worldwide between 2016 and 2026. In comparison, 4,286 events were recorded between 2006 and 2016, indicating an 87% increase and demonstrating a rapid rise in the frequency of natural disasters in recent years. Climate change is considered one of the key drivers of this increasing trend.

Similarly, data from the National Statistics Office of Mongolia (NSO, 2026) show that 2,026 natural hazard events were recorded in Mongolia between 2006 and 2016, while 3,354 events were recorded in the following decade, representing a 10.5% increase. This indicates that Mongolia is also experiencing a continuous upward trend in climate-related natural hazards.

The Sendai Framework for Disaster Risk Reduction (2015–2030) emphasizes that disaster management should be a decentralized, multi-level governance system that ensures the participation of non-governmental organizations (AKAY, 2020).

Furthermore, the National Program for Community-Based Disaster Risk Reduction of Mongolia (2015) highlights in Article 1.3 that although community-based disaster management approaches have been introduced in Mongolia since 2001 with the support of international organizations, policies, legal frameworks, and budgetary mechanisms to support public participation and engagement remain insufficient.

However, in Mongolia, the role and participation of non-governmental organizations (NGOs) remain limited both in legal frameworks and in practical implementation. Therefore, there is a need to improve the legal framework for disaster management in order to ensure meaningful public participation at all levels of disaster governance.

Accordingly, this study aims to evaluate the participation of non-governmental organizations within Mongolia's current disaster management legal and policy framework using a deductive approach, to identify financial and legal barriers faced by NGOs, and to propose mechanisms for strengthening their involvement in enhancing disaster resilience.

Methodology

This study employed a qualitative research approach to evaluate the participation of non-governmental organizations (NGOs) in Mongolia's disaster management system and the current state of their legal environment.

Within the scope of the study, document analysis and comparative analysis methods were applied. In the document analysis, key legal, policy, and planning documents of Mongolia's disaster management sector were selected and reviewed. These included the Law on Disaster Protection of Mongolia (2017), the National Program for Community-Based Disaster Risk Reduction (2015), and the "Disaster Protection Plan of Mongolia" approved by Government Resolution No. 11 of 2026.

At the international level, the United Nations "Sendai Framework for Disaster Risk Reduction 2015–2030" was used as the main comparative reference framework.

During the analysis, the selected legal and policy documents were examined through content analysis to assess how NGO participation is reflected. The evaluation was conducted based on the following key criteria:

1. The legal clarity of NGOs' rights and responsibilities;
2. The level of NGO participation across different phases of disaster management;
3. Financial, tax, and state support mechanisms;
4. The level of NGO inclusion in Mongolia's national disaster management plan.

In addition, Mongolia's legal framework was compared with the principles and recommendations of the Sendai Framework in order to identify gaps, weaknesses, and

implementation challenges in ensuring effective NGO participation.

The findings were synthesized using a deductive approach, linking international disaster risk governance theories with the current situation in Mongolia.

The concept of disaster

A disaster is an extraordinary situation caused by natural, technological, or human-induced factors that results in severe damage to society. Natural hazards include earthquakes, tsunamis, floods, and dzuds, while technological hazards include industrial accidents, technical failures, and system breakdowns. Human-induced hazards, on the other hand, include war and armed conflict, fires, and population displacement.

According to the Law on Disaster Protection of Mongolia, a disaster is defined as a situation in which, due to a hazardous event or accident, significant loss of human life and health occurs, large-scale livestock mortality is observed, and damage exceeding the internal resources and capacities of the state or local economy is inflicted on property, museum exhibits, collections, historical and cultural heritage, and the natural environment (Law on Disaster Protection, 2017).

Some scholars (Özgan, 2012) define disaster as a phenomenon caused by natural, technological, or human-induced factors that significantly disrupt normal life and generate severe physical and economic losses, affecting either society as a whole or specific segments of it.

In addition, disaster can be conceptually expressed as follows:

Disaster = Needs and Requirements > Available Resources

or

Disaster = Required Response Capacity > Available Response Capacity

According to this formulation, a disaster occurs when the consequences of a hazardous event exceed the local resources and capacity available to respond and recover. In other words, when the required level of response surpasses the existing response capacity, the situation is defined as a disaster (Kadıoğlu, 2011).

In Mongolia, Government Resolution No. 327 regulates the classification of disasters by determining whether an event qualifies as a disaster based on its level of impact on human life, livestock, property, and society (Uuganbayar, 2023). As an example, the criteria for earthquake-related disasters are presented in Table 1 below.

Table 1. Earthquake Disaster Classification Criteria

Disaster Type	Hazard Intensity & Damage Level	Duration	Persons Affected	Deaths	Total Livestock Mortality Rate	Impact Area	Material Damage as % of Local Budget
Earthquake	Magnitude 4.0 and above	No time limit	10 or more	2 or more	-	Disruption of education, health, and other essential services; damage to infrastructure and critical government facilities	2.0

Source: Uuganbayar, 2023

These definitions indicate that labeling a hazardous event as a “disaster” in isolation is insufficient. Rather, a disaster emerges from the interaction between the magnitude of a hazardous event and the coping capacity, infrastructure, and socio-economic resilience of a given society.

In simple terms, for a natural hazard to be classified as a disaster, the coping capacity of society plays a crucial role. This implies that not every natural hazard becomes a disaster; instead, a disaster is the outcome of its impact on society and the extent to which that society is able to respond and recover.

In other words, a natural hazard becomes a disaster only when its consequences exceed the available capacity of the affected society, making disasters not merely natural events, but socially determined outcomes of vulnerability and resilience.

Disaster management


Disaster management is a set of activities that involves the participation of all sectors of society with the aim of preventing disasters, reducing risks, responding quickly and effectively during disasters, conducting immediate recovery, and eliminating the damage caused to people and society. In other words, disaster management refers to an integrated governance and management system that requires the active involvement of governmental and non-governmental organizations as well as citizens in planning, organizing, and implementing measures across the pre-disaster, during-disaster, and post-disaster phases (Ramazan, 2023).

In the early stages of human history, hazardous events were often interpreted as matters of fate, and disaster-related actions were mainly focused on response and recovery after the event. This approach is referred to as "crisis management." Over time, as the frequency and impact of disasters increased, societies began to learn from previous experiences, leading to a gradual shift toward reducing risks and preventing disasters before they occur. This evolving approach is known as "risk management."

The transition from crisis management to risk management ultimately led to the development of an integrated disaster management system. This system views disaster phases not as separate and independent stages but as an interconnected cycle. Within this framework, pre-disaster prevention and mitigation measures directly influence the effectiveness of emergency response, while post-disaster recovery serves as a foundation for reducing future risks. Thus, integrating the efforts of government, civil society, and communities under a unified management system is essential for strengthening societal resilience in a comprehensive manner (Kadıoğlu, 2008).

The disaster management system consists of three main phases: pre-disaster, during-disaster, and post-disaster. Figure 1 illustrates the structure of the disaster management system.

Figure 1. Disaster Management System



Source: Kadıoğlu, 2008

The concept of resilience

The origin of the term "resilience" derives from the Latin word "resilire," meaning "to spring back" or "to return to the original state." It was first used in the 17th century to describe the ability of a material to return to its original shape after deformation. From the mid-20th century onward, it entered fields such as psychology, ecology, and disaster management, acquiring broader meanings such as "durability," "recovery capacity," and "adaptation ability" (Alexander, 2013; Holling, 1973).

According to the definition provided by the United Nations International Strategy for Disaster Reduction (UNISDR, 2009), resilience is: "The ability of a system, community, or society exposed to hazards to resist, absorb, accommodate, and recover from the effects of a hazard in a timely and efficient manner, including through the preservation and restoration of its essential basic structures and functions."

Aslı AKAY (2020) defined the concept of resilience as follows: "A long-term development process grounded in an inclusive, community-based approach that meets the fundamental rights and needs of everyone, including stakeholders such as central and local governments, universities, the private sector, and civil society organizations (CSOs), as well as vulnerable groups such as women, children, persons with disabilities, and the elderly; and that links risk reduction strategies with sustainable development goals."

Research shows that the term resilience has been widely used across many different disciplines to this day. The table below summarizes how the concept of resilience is defined in other fields:

Table 2. Definitions of Resilience Across Different Disciplines

Discipline	Definition	Source
Psychology	The emotional resilience and recovery capacity of an individual exposed to challenging conditions	(Werner & Smith, 1982)
Ecology	The ability of natural systems (such as forests and rivers) to recover after sudden disturbances	(Holling, 1973)
Disaster Management	The capacity of a community, city, or country to overcome post-disaster losses and rebuild	(UNISDR, 2005)

These definitions show that the concept of resilience is interpreted differently across disciplines depending on their specific context; however, they all converge on a common core meaning: the capacity to adapt to, recover from, and withstand stress, disruption, and sudden change. In particular, within the field of disaster management, resilience is not limited to post-disaster recovery. Rather, it can be understood as a fundamental foundation for preparedness and risk reduction strategies in the pre-disaster phase.

At the Third World Conference on Disaster Risk Reduction held in Sendai, Japan in 2015, 187 United Nations member states unanimously adopted the "Sendai Framework for Disaster Risk Reduction 2015–2030." In this framework, countries committed to implementing seven global targets and four priority areas in accordance with their national legal systems, capacities, and available resources (NEMA, 2026). The framework identifies four key priorities aimed at strengthening resilience across all phases of disaster management, as follows:

1. Understanding disaster risk
2. Strengthening disaster risk governance
3. Investing in disaster risk reduction
4. Enhancing disaster preparedness for effective response and improving recovery, rehabilitation, and reconstruction ("Build Back Better")

The Sendai Framework (UNISDR, 2015) also explicitly emphasizes the role of non-governmental organizations (NGOs) in each of

these four priorities. For example, it highlights the importance of developing local-level cooperation with community-based organizations and NGOs to disseminate disaster risk knowledge and information. This indicates that NGOs are expected to contribute to intersectoral collaboration, public awareness, education, and information dissemination related to disaster risk management.

In the case of Mongolia, the Sendai Framework has been adapted to national conditions through Government Resolution No. 355 of 2017, which approved the "Mid-Term Strategy for Implementing the Sendai Framework for Disaster Risk Reduction in Mongolia." This strategy is designed to be implemented in three phases (2017–2020, 2021–2025, and 2026–2030) and is structured around 1 overall goal, 9 objectives, and 4 priority areas (NEMA, 2022).

During the first implementation phase (2017–2020), a disaster risk reduction action plan consisting of 38 measures was approved by Order No. 23 of the Deputy Prime Minister of Mongolia, with an implementation rate of 94.2%. In the second phase (2021–2025), a plan consisting of 51 measures was approved by Order No. 51 of the Deputy Prime Minister, and implementation activities have been ongoing (NEMA, 2020). However, the official evaluation report of this second phase has not yet been publicly released.

Furthermore, in 2025, the Deputy Prime Minister approved the third-phase action plan (2026–2030), which includes 53 measures organized under 4 priority areas and 9 objectives. A detailed analysis of how NGOs are incorporated into this plan will be presented in the legal framework section.

Definition and roles of non-governmental organizations (NGOs)

According to Article 4 of the Law on Non-Governmental Organizations of Mongolia, an NGO is defined as a non-profit legal entity established by citizens or other legal entities (excluding legislative, executive, and judicial bodies) based on shared interests, ideas, and objectives, operating independently from the state and exercising self-governance (Law on Non-Governmental Organizations of Mongolia, 1997).

The social roles and functions of NGOs are also defined as follows:

- Identifying problems
- Generating solutions
- Influencing policy-making processes
- Innovation function
- Implementing role
- Cooperation and coordination function
- Producing outcomes through negotiations
- Complementary (substitute) function
- Entering into constructive opposition/conflict with the state when necessary (Baasanjav Consulting LLC, 2017)

These functions demonstrate that NGOs play an essential role across all sectors of society. They are capable of cooperating with the state, implementing certain public services through agreements, and even exercising oversight over government activities where necessary.

Disasters negatively affect all sectors of society. When a hazardous event occurs, it can lead to the collapse of buildings, damage to infrastructure, disruption of education systems, significant economic losses, reductions in agricultural productivity, and violations of human rights and social equality. Such situations create complex and urgent needs, including life-saving operations, emergency medical assistance, temporary shelter provision, food distribution, and the protection of fundamental human rights.

Addressing these challenges requires coordinated action involving the state, non-governmental organizations, international organizations, humanitarian agencies, and all segments of society. NGOs, in particular, maintain close relationships with local communities and operate independently of bureaucratic constraints, which often enables them to respond more flexibly and effectively in promoting public participation compared to government institutions. Mehmet DURUEL (2023) defines the roles and responsibilities of CSOs in disaster-related activities as follows:

- Emergency Response During Disasters: When a disaster occurs, civil society organizations are obligated to deliver emergency aid to disaster victims and meet

their basic needs (food, temporary shelter/tents, basic necessities, etc.).

• Risk Reduction and Preparedness: Civil society organizations carry out the task of organizing training, information activities, and drills in order to raise disaster preparedness awareness in individuals and improve disaster protection awareness in the community.

• Disaster Organization and Emergency Aid Distribution: During a disaster, civil society organizations are obligated to organize disaster management processes in coordination with other public institutions and civil society organizations, and to ensure the logistical delivery of emergency relief supplies to those in need and to disaster victims.

• Psychosocial Support: Civil society organizations are tasked with carrying out psychological support activities for the public and disaster victims during and after the disaster.

• Reconstruction and Recovery: Civil society organizations are tasked with participating in activities to repair damaged buildings and structures and restore infrastructure to working order in the post-disaster period, and with providing assistance aimed at improving the living conditions of local people.

• Advocacy and Raising Public Awareness: Civil society organizations (CSOs) announce the difficulties and needs arising from disasters to the public and cooperate with governments and international organizations. Thanks to this growing awareness, they prepare the ground for the development of more advanced policies and implementation of practices in the field of disaster management.

When organizations engaged in training, information, and project-based activities in the areas of disaster protection and strengthening disaster resilience in Mongolia are examined, it has been observed that international bodies such as the United Nations (UN), Mongolian Red Cross Society (MRCS), World Bank, Asian Development Bank, and World Vision are predominantly active, while the role and participation of local civil society organizations (CSOs) is not sufficiently active.

As noted above, it is necessary to grasp the critical importance of civil society organizations in carrying out disaster protection and humanitarian aid activities across all cycles of a disaster. Ensuring the participation of CSOs in disaster protection policies and planning processes, increasing this participation, and clarifying the authority and responsibilities of these organizations within the legal framework will make the role of CSOs in strengthening society's capacity to cope with disasters (resilience) more concrete and effective.

Evaluation of the legal framework

The rights and obligations of civil society organizations (CSOs) are explicitly stated within the scope of the Law of Mongolia on Disaster Protection (2017). Article 35.1 of the law states that "Civil society organizations shall participate in disaster protection activities with the following rights and obligations." These are:

• Conducting civil oversight over the implementation of disaster protection legislation

• Implementing projects and programs aimed at reducing disaster risk; participating in processes of developing legislation, recommendations, and methodologies

• Organizing research, training, and information activities focused on disaster protection in cooperation with relevant institutions

• Encouraging and supporting the participation of citizens, volunteer groups, and communities in disaster protection activities

• Working in coordination with the National Emergency Management Agency (NEMA)

Within the framework of the 'Mid-Term Strategy for Implementing the Sendai Framework for Disaster Risk Reduction in Mongolia', approved by Resolution No. 355 of 2017 of the Government of Mongolia, the participation of non-governmental organizations is reflected in the 'Phase III Action Plan (2026–2030)* for Implementing the Sendai Framework for Disaster Risk Reduction in Mongolia' as follows:

1. Priority 1: Within the framework of deepening public understanding and providing education on disaster risk reduction:

a.Organizing conferences (forums, meetings, and discussions) aimed at incorporating gender sensitivity, women's participation, and their initiatives into disaster risk reduction activities.

b. Updating and developing comprehensive, specialized training programs to enhance the understanding and knowledge of target groups (children, persons with disabilities, and the elderly) in community-based disaster risk reduction.

2. Priority 2: Within the framework of strengthening disaster risk reduction governance:

a.Approving the training guidelines for disaster protection voluntary units.

3. Priority 3: Ensuring disaster preparedness, and planning and implementing long-term post-disaster recovery, rehabilitation, and reconstruction activities.

a.Registering volunteer trainers both online and in writing, and establishing as well as regularly updating a unified national registration and information database categorized by type, location, and training specialization.

Under the "National Program for Community-Based Disaster Risk Reduction" approved by Government Decision No. 303 of 2015, the roles of CSOs have been defined as follows:

• Cooperating with other stakeholders in the areas of disaster risk reduction and combating climate change; informing, training, and supporting citizens

• Participating in the program's implementation process; providing financial and material support, collecting donations and contributions, conducting training and promotional activities through projects

• Disseminating and promoting international and regional best practices to the public

Additionally, the "Mongolia Disaster Protection Plan" was updated and entered into force with Government Decision No. 11 of 2026. Within the framework of this policy document, the roles and participation of CSOs in disaster protection measures have been determined as follows:

Within the Scope of Disaster Risk Reduction and Prevention Activities:

• Implementation of the duties specified in Article 34 and the provisions in Article 51.2 of the Law on Disaster Protection

• Supervising the safety of one's own organization, appointing relevant officials in this area, and monitoring activities

• Ensuring the fire and disaster safety of the organization, and cooperating with relevant professional institutions and organizations in this regard

• Establishing disaster stockpiles and preparing conditions to ensure the uninterrupted continuation of organizational activities in the event of a disaster

Within the Scope of Emergency Response Activities During a Disaster:

• Providing medical assistance and health services to disaster victims

• Organizing prevention and control activities for infectious diseases in humans

• Identifying children, elderly persons, persons with disabilities, and children without parental supervision who are in need of social assistance and support, and providing them with all necessary aid

• Organizing psychosocial support activities for children during a disaster. However, regarding the implementation and support of these measures, only the Mongolian Red Cross Society (MRCS) is specified as the authorized and responsible organization in the relevant documents.

Under the Law of Mongolia on Disaster Protection (2017), the disaster protection plan is defined as "the fundamental management document that determines the organization of disaster prevention, preparedness, search and rescue, damage remediation, emergency reconstruction, and humanitarian aid activities." In this context, the plan is a strategic guide regulating the activities to be carried out at all stages of a disaster, the institutions responsible for these activities, and inter-institutional coordination.

Although the rights and obligations of civil society organizations (CSOs) are included in the Law on Disaster Protection, it is observed that some articles and provisions are not elaborated in the disaster protection plans,

which are the fundamental policy documents. For example:

• Expressions such as “conducting oversight, providing support, and cooperating” in the Law on Disaster Protection do not provide a detailed framework regarding what resources (financial, technical, human) this participation will be carried out with.

• Although it is stated that projects and programs for disaster risk reduction will be implemented, it is unclear what kind of incentives, tax exemptions, or direct financial support will be provided by the state.

• Specifying that research, training, and information activities focused on disaster protection will be organized “in cooperation with relevant institutions” indicates that the independent training rights of civil society organizations are restricted.

• Mentioning only the Mongolian Red Cross in the response activities included in disaster protection plans restricts the participation of other civil society organizations operating in different sectors.

Furthermore, within the framework of Priority 3 of the 'Mid-Term Action Plan for Implementing the Sendai Framework for Disaster Risk Reduction in Mongolia (2026–2030)', the implementation arrangements specifically designate only the 'Mongolian Red Cross Society (MRCS)' and the 'Network of Volunteer Organizations NGO' as co-implementing partners.

This regulatory framework tends to restrict the opportunity for other non-governmental organizations (NGOs) working in disaster risk reduction to cooperate directly with the state administrative agency in charge of emergency management and other implementing bodies.

For instance, provisions that explicitly specify a particular entity, such as the 'Network of Volunteer Organizations NGO', may inadvertently push other NGOs into indirect rather than direct participation. Consequently, this could compromise the equitable participation of NGOs and create a risk of institutional dependency on a single, explicitly named network organization.

Discussion and conclusion

By employing a deductive method to evaluate Mongolia's domestic legal documents based on the core theories of the Sendai Framework for Disaster Risk Reduction and the principles of decentralizing disaster risk governance across each stage of the disaster management cycle (pre-disaster mitigation, during-disaster response, and post-disaster recovery), the following practical and legal challenges have emerged. The consolidated results of this evaluation are presented in a matrix format in Table 3.

Table 3. Evaluation Matrix of NGO Participation, Financial, and Legal Challenges Across Each Stage of the Disaster Management Cycle

Disaster Management Cycle	Opportunities for Legal and Practical Participation	Legal Framework Restrictions and Challenges
Pre-Disaster	Providing disaster protection knowledge to citizens, training volunteer rescuers, and conducting drills/exercises.	Provisions stating "shall organize jointly with relevant authorities" restrict the autonomous right of NGOs to conduct training, thereby generating bureaucratic hurdles.
During-Disaster	Providing emergency relief and temporary shelter to victims, and offering psychosocial support to vulnerable groups.	The updated National Action Plan (2026) designates only the Mongolian Red Cross Society (MRCS) during the response phase, which marginalizes the participation of other sector-specific NGOs.
Post-Disaster	Establishing registration and information databases for volunteers, and exercising civic oversight on recovery quality and financing.	The explicit inclusion of only the "MRCS and the Network of Volunteer Organizations NGO" in the "Mid-Term Action Plan for Implementing the Sendai Framework for Disaster Risk Reduction in Mongolia (2026–2030)" risks making other independent NGOs dependent on a single organization.

These findings indicate that while Mongolia's legal framework for disaster management conceptually recognizes the participation of non-governmental organizations (NGOs), a centralized governance model continues to dominate at the operational level. In other words, NGOs are viewed merely as "supporters" of state institutions rather than autonomous actors within the disaster management cycle, which directly contradicts contemporary global trends in disaster risk governance.

Although the Sendai Framework for Disaster Risk Reduction emphasizes a decentralized, multi-stakeholder, and collaborative approach to disaster risk governance, Mongolia's statutory provisions define the functional roles of NGOs only in generic terms. Consequently, the institutional mechanisms for their involvement, financial support structures, and accountability frameworks remain ambiguous. In particular, explicitly prioritizing only the Mongolian Red Cross Society (MRCS) during the response phase acts as a structural barrier that marginalizes other specialized sector-specific NGOs.

Furthermore, despite the legal identification of potential NGO activities during the pre- and post-disaster phases, a concrete mechanism for the requisite financial and fiscal (tax) incentives has yet to be established. As a result, domestic NGOs have become overly dependent on international projects and programs, which severely restricts the sustainability of their operations. In the long term, this systemic dependency poses a significant risk to the overall enhancement of Mongolia's national disaster resilience.

Additionally, policy regulations that centralize coordination through a single designated entity, such as the "Network of Volunteer Organizations NGO," diminish the direct engagement of other independent organizations and risk establishing a monopolistic network dependency. This structural imbalance is highly likely to undermine the equitable participation, competitive capacity, and autonomy of civil society organizations.

Therefore, it is imperative to reform Mongolia's disaster management legal framework to align with global standards. Within this scope, a comprehensive accreditation system based on the resources, human capacity, and professional specialization of NGOs should be established. Furthermore, distinct functional mechanisms for their cross-cyclical participation must be explicitly codified into national legislation and strategic planning documents. Implementing these structural reforms will foster an integrated ecosystem grounded in public-civil society-community partnerships, thereby more effectively strengthening Mongolia's overarching disaster resilience.

References

1. Alexander, D. (2013). Resilience and disaster risk reduction: An etymological journey. *Natural Hazards and Earth System Sciences*. https://www.researchgate.net/publication/307810633_Resilience_and_disaster_risk_reduction_an_etymological_journey

2. Akay, A. (2020). *Belediye için afetlere dirençli kentler rehberi*. İdeal Kent Yayınları.

3. Баасанжав консалтинг ХХК. (2017). *Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй Иргэдийн оролцоо II төсөл*. https://www.uih.mn/upload/sudalgaa/files/53_8412283.pdf

4. Duruel, M. (2023). *Afet yönetiminde sivil toplum kuruluşlarının rolü: 6 Şubat depremi Hatay örneği*.

5. EM-DAT. (2026). *2016–2026 оны хооронд дэлхий дахинд тохиолдсон гамшгийн тоон мэдээлэл*. https://public.emdat.be/

6. Holling, C. S. (1973). Resilience and stability of ecological systems. *Annual Review of Ecology and Systematics, 4*, 1–23.

7. Kadıoğlu, M. (2011). *Afet yönetimi: Beklenilmeyeni beklemek, en kötüsünü yönetmek*. Marmara Belediyeler Birliği Kültür Yayınları.

8. Монгол Улсын Их Хурал. (1997). *Монгол Улсын төрийн бус байгууллагын тухай хууль*. Улаанбаатар, Монгол Улс.

9. Монгол Улсын Их Хурал. (2017). *Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль*. Улаанбаатар, Монгол Улс.

10. Монгол Улсын Засгийн газар. (2015). *Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр*. Улаанбаатар, Монгол Улс.

11. UNISDR. (2005). *Hyogo framework for action 2005–2015*.

12. Үндэсний статистикийн хороо. (2026). *2016–2026 оны хооронд Монгол Улсад тохиолдсон гамшгийн тоон мэдээлэл*. https://www.nso.mn/mn/statcate/table-view/Economy%2C%20environment/Environment/DT_NSO_2400_012V1.px

13. Уганбаяр, Б., & Чимэдцэрэн, П. (2023). Газар хөдлөлтийн гамшгийн үеийн удирдлага, зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ. *Гамшиг судлалын инновац сэтгүүл*, 6. https://sudalgaa.gov.mn/pdf/gamshig-sudlal-innovats-setgl-xox

14. Yelken, R. (2023). *Afet yönetişimi ve AFAD*. Pegem Akademi.

МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ХАМТАРСАН ШИНЖИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

THE CURRENT SITUATION OF COOPERATIVE INVESTIGATION OF FORENSIC MEDICINE

А.Болор-Эрдэнэ*
Анагаах ухааны магистр, шинжлэн магадлахуйн докторант
Bolor-Erdene A.
Master of Medicine, Ph.D., candidate of forensic science
З.Сүлд
Шинжлэн магадлах ухааны доктор (Ph.D)
Suld Z.
Forensic Science Ph.D.

*Хариуцлагатай зохиогч: Bolorerdene.uia@gmail.com

Хураангуй: Хүний амь нас, эрүүл мэндээр хохирсон хэргийн үед шүүх эмнэлгийн шинжээч эмч нар Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлттэй хамтарсан шинжилгээ хийж дүгнэлт гаргах шаардлага нэлээд тулгардаг. Хамтарсан шинжилгээ хийж дүгнэлт гаргах, шүүхээр аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шүүх эмнэлгийн тусгай мэдлэгийн төрөл бүрийн салбар чиглэлийг ашиглан үнэлэлт, дүгнэлт өгөх нь шүүхээс хууль ёсны үндэслэлтэй шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой. Хамтарсан шинжилгээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тулгамдсан асуудлыг илрүүлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, шийдвэр гаргах хэрэгцээнд тулгуурлан энэхүү судалгааг хийсэн болно. Шинжлэн магадлах ухаан, шүүх эмнэлгийн чиглэлээр судалгаа хийж, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлүүдэд шүүх эмнэлгийн шинжилгээ, хамтарсан шинжилгээний дүгнэлтийн ач холбогдлыг өргөн хүрээнд авч үзсэн байдаг. Шүүх эмнэлгийн шинжилгээ, хамтарсан шинжилгээний онолын ойлголт, өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх энэхүү судалгаа нь шинжилгээ хийх арга зүйн үндсийг тодорхойлж шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээний хамрах хүрээг шүүх, прокурор, мөрдөх, өмгөөллийн байгууллагад нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход санал дэвшүүлэхээр нь зорьсон нь судалгааны шинэлэг тал болсон гэж үзэж байна. Уг судалгааны ажилд Шүүх шинжилгээний Ерөнхий газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газарт 2018-2023 онуудад шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээний 275 тохиолдлын архивын материалд респектив аргаар, мөн хамтран оролцогч тал болох мэргэжлийн зөвлөл, албан тушаалтны төлөөлөл 50 хүнээс фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглалаа. Монгол Улсад шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээг хөгжүүлэхэд сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангахын зэрэгцээ хамтарсан шинжилгээний эрх зүй, тогтсон стандартыг бий болгосноор шинжээчийн дүгнэлт шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв гарах, дүгнэлтийг үнэлэх үнэлэмж дээшлэх сайн талтай гэж харагдаж байна.

Abstract: In Mongolia, the increasing incidence of crimes resulting in the murder or health poses significant challenges for forensic medical experts. They often struggle to conduct comprehensive complex examination with professional consultants under the Ministry of Health and reach conclusions in such cases. Complex examinations and the use of various fields of forensic medical expertise in the resolution of any case or dispute by the court are important for the court to make legally sound decisions. This research, based on an analysis of the current state of complex examinations, was initiated to identify existing problems, propose solutions, and guide decision-making processes. Numerous scientific studies in forensics and forensic medicine have extensively examined the role and impact of joint forensic analyses. This research aims to evaluate the theoretical frameworks and current practices of forensic examination and complex examinations and propose methodological improvements and legal regulations to expand their

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

application in courts, prosecution, investigation, and defense organizations. The study analyzed 275 forensic complex examination cases in the Department of Forensic Medicine from 2018 to 2023. In order to develop forensic medical analysis in Mongolia, it is believed that not only the provision of the latest high-capacity equipment and technical means, but also the establishment of joint analysis laws and established standards have the potential to improve the scientific and accurate conclusions of experts and the value of evaluating conclusions.

Түлхүүр үгс: шүүх эмнэлэг, шинжээчийн дүгнэлт, шүүх шинжилгээний үйл ажиллагаа, шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээ

Keywords: Forensic Medicine, Forensic Expert's opinion, Forensic activities, Complex examination of forensic medicine

Шинжлэн магадлах сэтгэлгээ, шүүх шинжилгээ зүйн мэдлэгийг хөгжүүлэхэд эмч болон түүний гэр бүл ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байдаг нь тохиолдлын хэрэг бус юм. Хүний амь настай холбоотой гэмт хэрэг болгон нийгмийг түгшээж, айдаст автуулж байдаг. Тэр хэрээр энэ төрлийн хэрэгт гол анхаарлаа хандуулж байснаас эмчийн мэдлэг юу юунаас чухал хэрэгцээ болж байсан. [1].

Шүүх эмнэлгийн шинжилгээ нь анагаах ухааны болон бусад шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан шинжилгээ хийж, хуулийн хүрээнд мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гарган өгч буй шинжилгээний байгууллага болон шинжээчийн үйл ажиллагаа байдаг.

Онолын хувьд шинжлэн магадлахуйн эрдэмтдийн үзсэнээр шинжилгээ нь “дагнасан” болон “хамтарсан” гэсэн хэлбэртэй байдаг.

Монгол Улсын Шүүх шинжилгээний тухай хуульд шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх, шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэх гэсэн 2 үндсэн хэлбэртэй байхаар тусгасан байдаг.

Хэдийгээр Шүүх шинжилгээний тухай хуульд анхдагч шинжилгээг багаар хийх, багийн бүрэлдэхүүнд шинжилгээний байгууллагын шинжээчээс гадна тухайн байгууллагад ажилладаггүй тусгай мэдлэг бүхий хүнийг оролцуулж болно гэж заасан ч шинжилгээний байгууллагад ажилладаггүй хүн гэж чухам хэнийг, ямар шалгууруар, зохион байгуулалтын ямар хэлбэрээр шинжилгээнд оролцуулах талаар зохицуулсан хэм хэмжээ хуульд тусгаагүй байгаа нь учир дутагдалтай юм. [3].

Шинжилгээний байгууллагын шинжээч эмч, шинжилгээний байгууллагад ажилладаггүй эмч нартай хамтарсан шинжилгээ хийх тохиолдол цөөнгүй тулгардаг.

Дээрх тохиолдолд шинжилгээний байгууллага эрх бүхий этгээдээс ирүүлсэн шинжилгээ хийхээс “түдгэлзэж”, буцаахаас өөр аргагүй байдалд хүрдгийн дээр мөрдөгч зохих мэргэжилтнийг томилохоор Эрүүл мэндийн яаманд хандах, үүний дараа мэргэжилтнээр санал, дүгнэлт гаргуулан шинжилгээний байгууллагад хүлээлгэн өгөх, улмаар шинжилгээний байгууллага нэгдсэн дүгнэлт гаргах зэрэг хэд хэдэн шат дамжлагыг давж, цаг хугацаа багагүй зарцуулдаг болох нь харагдаж байна.

Иймд шүүх эмнэлгийн шинжилгээний хэлбэр болох хамтарсан шинжилгээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тулгамдсан асуудлыг нээн илрүүлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, шийдвэр гаргах хэрэгцээнд тулгуурлан уг судалгааг хийсэн болно.

Сэдвийн судлагдсан байдал: Шинжлэн магадлах ухаан, шүүх эмнэлгийн чиглэлээр судалгаа хийж, эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэн Монгол Улсад цөөнгүй бий. “Шүүх эмнэлэг”-ийн анхны эрдэмтэн Х.Лхагважав “Шүүх эмнэлэг” /1987 он/, “Судебная медицина ‘’I. II, бүтээл, “Монгол хүний насыг тогтоох шүүх эмнэлгийн магадалгааны асуудал’’ сэдэвт бүтээл, хуульч анагаах ухааны магистр Э.Ганбат, М.Цэрэнбат нарын 2005 онд 2 шинжлэх ухааны зааг дээр туурвисан “Шүүх эмнэлэг” бүтээлүүдэд шүүх эмнэлгийн шинжилгээ, хамтарсан шинжилгээний дүгнэлтийн үүргийг өргөн хүрээгээр авч үзсэн байдаг. Түүнчлэн Б.Лхагвасүрэн 2017 онд “Хүний эрхэд

суурилсан шинжлэн магадлах үйл ажиллагаа онол, арга зүйн асуудал" сэдвээр, Т.Очирбат 2019 онд "Шинжлэн магадлахуйн онол, эрх зүй, зохион байгуулалтын асуудал" сэдвээр хууль зүйн докторын зэрэг хамгаалсан нь шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээний онол, эрх зүй, зохион байгуулалтын үндсийг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Судалгааг Шүүх Шинжилгээний Ерөнхий Газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газарт 2018-2023 онд хийсэн шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээний 275 тохиолдлын архивын материалд респектив аргаар, мөн хамтарсан шинжилгээний оролцогч болох прокурор, мөрдөгч, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдийн төлөөлөл 50 хүнээс фокус бүлгийн ярилцлагаар чанарын судалгааг тус тус ашиглаж судалгааны ажлыг SPSS 21 программ дээр боловсрууллаа. [5].

Шүүх эмнэлгийн шинжээч эмч нар Эрүүл мэндийн яамны орон тооны бус мэргэжлийн нэг салбар зөвлөлтэй хийсэн шинжилгээ - 64%, хоёр салбар зөвлөлтэй хамтарч хийсэн шинжилгээ - 20,7%, гурав ба түүнээс дээш салбар зөвлөлтэй хамтран хийсэн шинжилгээ - 13, криминалистикийн шинжээч нартай хамтарсан шинжилгээ 0,7%, бактериологийн шинжээч нартай хамтарсан шинжилгээ - 0,3% биологийн шинжээч нартай хамтарсан шинжилгээ - 0,7%, ДНХ-н шинжээчтэй хамтарсан шинжилгээ - 0,3%, химийн шинжээч нартай хамтарсан шинжилгээ-0,3% байв. Шүүх эмнэлгийн хамтарсан нийт шинжилгээнээс хүний биед хийсэн шинжилгээ - 49%, цогцост хийсэн шинжилгээ 51% байв. Хамтарсан шинжилгээ хийсэн шинжээч нар санал нэгтэй гаргасан дүгнэлт 84.3% (38), санал зөрсөн 2.9% (1), шинжилгээ хийх боломжгүй гэсэн үндэслэлээр буцаасан 12.8% (6) байв. Мэргэжлийн салбар зөвлөлүүд тогтоол хүлээн авснаас хойш хуулийн хугацаанд мэргэжилтнээ томилж өгдөггүй, томилогдсон ч зарим нь татгалздаг зэргээс хугацаа алддаг гэсэн хариултыг 78.5% (22) гарсан. Сайн тал нь салбар зөвлөлийн дангаараа гаргаж байгаа дүгнэлт нь Шүүх шинжилгээний байгууллагын шинжээч нарын гаргасан дүгнэлтээс агуулга, хариулт нь илүү шинжлэх ухааны агууламжтай байдгаараа хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байдаг гэж 85.7% (24) тодорхойлжээ.

Дээрх хугацаанд хийгдсэн шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээний 88% нь дахин хийсэн шинжилгээ байсан бол 12 % нь нэмэлт шинжилгээ байлаа. Үүнээс шүүгчийн захирамжаар 10,5%, прокурорын тогтоолоор 80 %, мөрдөгчийн тогтоолоор 9,5% нь хийгджээ.

График 1. Хохирогчдын насны ангилал




График 2. хохирогчдын хүйсийн ангилал




График 1 болон 2-т Шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээнд хамрагдсан хохирогчдыг насны ангиллаар болон хүйсээр харуулав.

Шүүх эмнэлгийн хамтарсан нийт шинжилгээнээс хүний биед хийсэн шинжилгээ - 49 %, цогцост хийсэн шинжилгээ - 51% байв.

Хүний биед хийсэн шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээг хэргийн өнгөөр ангилж үзвэл: зодуулсан - 29.6%, хүчиндүүлсэн - 14.8%, хутгалуулсан - 3%, зам тээврийн осолд орсон - 3% , эмч, эмнэлгийн ажилчидтай холбоотой эрүүл мэндээрээ хохирсон гэх - 38.5%, ажлын байран дээрх осол - 6% , бусад осол 5.1% байна.

График 3.Цогцост хийсэн шинжилгээг хэргийн өнгөөр харуулав.



Цогцост хийсэн шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээг хэргийн өнгөөр ангилж үзвэл: зодуулсны улмаас амь насаа алдсан - 12,8%, гэртээ нас барсан - 3,5%, хутгалуулж нас барсан - 2,1%, өндрөөс унаж амь насаа алдсан - 2,8%, зам тээврийн осолд орж амь насаа алдсан - 2,1%, эхийн эндэгдэл - 5,7%, эмч, эмнэлгийн ажилчдын үйлдэлтэй холбоотойгоор амь насаа алдсан гэх - 65% бусад осол - 6% байна.

Шүүх эмнэлгийн шинжээч эмч нар Эрүүл мэндийн яамны орон тооны бус мэргэжлийн нэг салбар зөвлөлтэй хийсэн шинжилгээ - 64%, хоёр салбар зөвлөлтэй хамтарч хийсэн шинжилгээ - 20,7%, гурав ба түүнээс дээш салбар зөвлөлтэй хийсэн шинжилгээ - 13%, криминалистикийн шинжээч нартай хамтарсан шинжилгээ 0,7%, бактериологийн шинжээч нартай хамтарсан шинжилгээ - 0,3% биологийн шинжээч нартай хамтарсан шинжилгээ - 0,7%, ДНХ-н шинжээчтэй хамтарсан шинжилгээ - 0,3%, химийн шинжээч нартай хамтарсан шинжилгээ - 0,3% байв.

Шинжээч томилсон тогтоолд тавигдсан асуултуудыг судалж үзэхэд хүний биед хийсэн шинжилгээнд гэмтлийн зэрэг тогтоох - 67, гэмтлийн үүссэн цаг хугацааг

тогтоох - 54, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд эмчилгээ оношилгоо зөв стандартын дагуу хийгдсэн эсэх - 30 зэрэг асуултууд голлон давхардаж асуусан бол, цогцост хийсэн шинжилгээнд эмчилгээний үр дүнд амь нас аврагдах боломжтой - 57, зохих ёсоор эмчилгээ үзүүлсэн эсэх - 58, эмнэлгийн эмчилгээ, мэс засал, бусад ажилбарууд Монгол Улсын стандартын дагуу хийгдсэн эсэх - 82 зэрэг асуултыг голлож асуун хариулт авчээ.

Хамтарсан шинжилгээ хийсэн шинжээч нар санал нэгтэй гаргасан дүгнэлт - 84,3%, санал зөрсөн - 2,9%, шинжилгээ хийх боломжгүй буцаасан - 12,8% байлаа.

Мэргэжлийн салбар зөвлөлүүд тогтоол хүлээн авснаас хойш хуулийн хугацаанд мэргэжилтнээ томилж өгдөггүй, томилогдсон ч зарим нь татгалздаг зэргээс хугацаа алддаг гэсэн хариултыг 78.5% (22)-д гарсан. Сайн тал нь салбар зөвлөлийн дангаараа гаргаж байгаа дүгнэлт нь Шүүх шинжилгээний шинжээч нараас агуулга, хариулж байгаа байдлаараа шинжлэх ухааны хариулдаг ба хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж 85.7% (24) тодорхойлжээ. [4].

Прокурорууд, мөрдөгч нартай хийсэн фокус ярилцлагаас: *тулгамдаж буй асуудал нь мэргэжлийн салбар зөвлөлүүд тогтоол хүлээн авснаас хойш хуулийн хугацаанд мэргэжилтнээ томилж өгдөггүй, томилогдсон ч зарим нь татгалзаад бүрэлдэхүүнд орж өгдөггүй, тэгэхээр дүгнэлт хугацаандаа гарах боломжгүй.Энэ төрлийн шинжилгээг томилоход шат дамжлага хэрэгтэй болдог, ШШЕГ-ЭМЯ-салбар зөвлөл гэж харьцаж байж дүгнэлтээ гаргуулж авч байна, цаг хугацааны хувьд алдагдалтай, 2-3 сар ч болох тохиолдол байна, гэхдээ сайн тал нь салбар зөвлөлийн гаргаж буй дүгнэлт дангаараа гаргаж байгаа Шүүх шинжилгээний шинжээч нараас агуулга, хариулж байгаа байдлаараа шинжлэх ухааны хариулдаг ба хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байдаг* гэж тодорхойлж байлаа.

Эрүүл мэндийн яамны орон тооны бус мэргэжлийн салбар зөвлөлөөс томилогдож ирдэг шинжээч эмч нартай хийсэн фокус ярилцлагаас: *Цалин хөлс авдаггүй, үүрэг гэж ойлгодог, үндсэн ажилд ордоггүй, хүний нөөц хүрэлцдэггүй, , зарим үед шинжилгээний обьект, эмнэлгийн материал дутуу ирдэг, хамгийн төвөгтэй нь аль нэг тал нь хүлээн зөвшөөрөхгүй байх явдал байдаг.Шинжээч томилж байгаа цагдаа, прокурорынхон хэргээ гараас гарт авчирч өгдөггүй, дүгнэлт гарсны дараа ирж авдаггүй хугацаа их алддаг. Хамтарсан шинжилгээнд оролцох сонирхолтой мэргэжилтэн нэг ч байдаггүй, салбар зөвлөлийн дарга нь тулгадаг, томилдог, хамтарсан шинжилгээ явуулах журам, эрх зүйн акт байдаггүй. Шинжээч томилсон прокурорын тогтоолуудын хугацаа дандаа өнгөрсөн цаг дээр ирдэг, хугацаа төвөгтэй байдаг, хэргийн материалыг хүргэж өгч авахад нууцлал алга, ШШЕГ дээр ирж байгаа тогтоолд хамтарч дүгнэлтээ гаргадаггүй, тус тусдаа саналаа өгдөг, комисстой нэгдсэн дүгнэлт гэж ойлгож байгаа ч гишүүд уулздаггүй, бүгд саланги гаргадаг нь учир дутагдалтай байдаг.Аль ч мэргэжлийн шинжээч нар өндөр хариуцлагатай байх шаардлагатай, шинжээчээр ажилласан хэний ч болов оюуны хөдөлмөрийг үнэлэх нь чухал байна* гэж тодорхойлж байлаа.

Шинжээч эмч нартай хийсэн фокус ярилцлагаас: *ЭМЯ-ны дэргэдэх Мэргэжлийн салбар* зөвлөлийн *гишүүдтэй* хамтран шинжилгээ *хийх үед багаараа сууж хийх боломжгүй, тэд цаг завгүй гэдэг шалтгаанаар ирдэггүй, тусдаа санал бичиж явуулдаг, гишүүд хамтарсан шинжилгээнд оролцох дургүй, ял мэт хүлээж авдаг, хүний хувь заяаг шийдэж байгаа гэдгээ ойлгодоггүй* гэж тодорхойлж байлаа.

Дээрх судалгаа нь М.Цэрэнбат, М.Баясгалан (2022) нарын судалгаагаар шинжилгээний байгууллага эрх бүхий этгээдээс ирүүлсэн хамтарсан шинжилгээ хийхээс ‘’түдгэлзэж’’, буцаахаас өөр аргагүй байдалд хүрдгийн дээр мөрдөгч зохих мэргэжилтнийг томилохоор Эрүүл мэндийн яаманд хандах, үүний дараа мэргэжилтнээр санал, дүгнэлт гаргуулж, шинжилгээний байгууллагад хүлээлгэн

өгөх, улмаар шинжилгээний байгууллага нэгдсэн дүгнэлт гаргах зэргээр хэд хэдэн шат дамжлагыг давж, цаг хугацаа багагүй зарцуулдаг, эрх зүйн орчин байхгүй, хамтарсан шинжилгээ хийх зохион байгуулалтын хэлбэрээс хамаарсан журам батлах шаардлагатай гэсэн дүгнэлттэй тохирч байна

Дүгнэлт

1.ШШЕГ-н Шүүх Анагаах Ухааны Шинжилгээний газар нь 2018-2023 оны хооронд 275 шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээ хийсэн ба эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, гэмтэл согог судлалын мэргэжлийн салбар зөвлөл, нүд судлалын мэргэжлийн зөвлөлтэй хамтарсан шинжилгээг голлон хийсэн байна.Өөрөөр хэлбэл шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээний төрөл нь анагаах ухааны бусад салбаруудтай ихэнхдээ хийсэн ба бусад төрөлжсөн мэргэжлийн шинжээч нартай хийх нь цөөн байна. /тухайлбал хими, биологи, криминалистик гэх мэт/

2.Шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь зохих мэргэжилтнийг томилохоор Эрүүл мэндийн яаманд хандах, үүний дараа мэргэжилтнээр санал, дүгнэлт гаргуулан шинжилгээний байгууллагад хүлээлгэн өгөх, улмаар шинжилгээний байгууллага нэгдсэн дүгнэлт гаргах зэрэг хэд хэдэн шат дамжлагыг дамждаг учраас дүгнэлт гаргах хугацаа их алддаг.Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд нь өөрийн үндсэн чиг үүргийн ажлаас гадуур илүү цагаар ажилладаг боловч цалин хөлс авдаггүй зэрэг нь тулгамдсан асуудал болж байна.

3.Монгол Улсад шүүх эмнэлгийн шинжилгээг хөгжүүлэхийн тулд зөвхөн сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангахын зэрэгцээ хамтарсан иж бүрнээр хийх шинжилгээний онол, арга зүйг боловсруулж, практикт нэвтрүүлэх, цаашлаад энэ хэлбэрийн шинжилгээний эрх зүй болон зохион байгуулалтын орчинг бүрдүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Санал

1. Шүүх эмнэлгийн хамтарсан шинжилгээнд бусад төрлийн тусгай мэдлэг (крминалистик, хими, биологи, физик гэх мэт) ашиглах боломжийг нэмэгдүүлэх;

2. Шүүх шинжилгээний ерөнхий газрын дэргэд орон тооны бус анагаах ухааны төрөлжсөн мэргэжлийн зөвлөх баг ажиллуулах;

3. Шүүх шинжилгээний хуулийн хэм хэмжээг гүйцээн зохицуулах, өөрөөр хэлбэл бусад мэргэжлийн шинжээч нартай хамтран ажиллах журам баталж мөрдөх.

Эх сурвалж

1. Очирбат,Т. “Шинжлэн магадлахуй”. Уб., 2014.

2. Лхагвасүрэн, Б. Шинжлэн магадлах ухаан Уб., 2018.

3. Цэрэнбат, М Шүүх эмнэлгийн шинжилгээний эрх зүйн зохицуулалт Уб., 2022.

4. Шүүх шинжилгээний ерөнхий газрын архивын материал 2018-2023 оны хавтаст хэргийн материалаар гаргасан дүгнэлтүүд.

5. Шүүх шинжилгээний статистик (2019-2023).

КРИМИНАЛИСТИКИЙН ДУУ АВИА СУДЛАЛ
FORENSIC PHONETICS STUDY

Х.Түвшин-Эрдэнэ*
Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн Байгалийн ухаан, техник зүйн шинжилгээний тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа
Tuvshin-Erdene Kh.
Forensic science school of UIA, Senior taecher Police lieutenant colonel

*Хариуцлагатай зохиогч: tuvshin908@gmail.com

Хураангуй: Дуу авиа болон видео бичлэг нь хэргийг мөрдөн шалгахад чухал ач холбогдолтой бөгөөд нотлох болон үгүйсгэх баримтыг баталгаажуулах, гэмт хэргийг шийдвэрлэх арга замыг сонгох, эрэн сурвалжлах, хүн болон бусад дууны эх үүсвэрийг тодорхойлох, бичлэг өөрчлөгдсөн эсэх шинж тэмдгийг тогтооход ач холбогдолтой байна. Гэмт хэргийг мөрдөн шалгах практикт хамгийн чухал дуу авианы шинжилгээ нь хүний аман яриаг судлахтай холбоотой үүрэг гүйцэтгэдэг. Дуу авиа судлалын үүднээс авч үзвэл аман яриа нь түүний үе шат, акустик шинж чанарыг дамжуулдаг олон тооны авиа зүйн шинж чанараар тодорхойлогддог. Үүнд: цаг хугацаа, давтамж, далайц, эрчим, хурд, хүрээ гэх мэт параметрүүдийн шинж тэмдэг илэрхийлэгдэж байна.

Дуу авиа бичлэгт адилтгалын болон оношилгооны шинжилгээ хийж шинж тэмдгийг тогтоох, дууны дохионд анализ хийх нь хүний өгүүлэхүйн эрхтэн, аман ярианы төрөл, бичлэг хийсэн орчны нөхцөл, бичлэг хийсэн техник хэрэгсэл зэргээс хамааралтай байх ба иж бүрдэл шинжилгээ хийхээр ээдрээтэй асуудал байдаг. Энэ төрлийн шинжилгээ нь шинжээчээс математик, физик, кибернетик, дохио дамжуулал, системийн анализ, хэмжихүйн онол, радиотехник, хэл шинжлэл, криминалистик зэрэг салбарын тусгай мэдлэгийг шаарддаг. Эдгээр шинжлэх ухаан дуу авианы бичлэгт хийх шүүх шинжилгээг криминалистикийн мэдлэгийн салбар болон бүрэлдэх боломж олгож, цаашид хөгжих суурийг бүрдүүлж өгдөг.

Abstract: Phonetics, forensic analysis, speech, sound and video recordings are important in the investigation of cases and are useful for confirming and denying facts, choosing a way to solve a crime, conducting searches, identifying human and other sources of sound, and determining whether the recording has been altered. The most important sound analysis in the practice of criminal investigation plays a role related to the study of human speech. From the point of view of phonetics, speech is characterized by a number of phonetic characteristics that convey its phase and acoustic properties. These include: signs of parameters such as time, frequency, amplitude, intensity, speed, range, etc.

Identifying signs by conducting identification and diagnostic analysis of sound recordings, analyzing sound signals, depending on the human speech organ, the type of speech, the environmental conditions of the recording, and the recording equipment, and it is a complex problem to perform a comprehensive analysis. This type of analysis requires the expert to have special knowledge in mathematics, physics, cybernetics, signal transmission, system analysis, measurement theory, radio engineering, linguistics, and forensics. These sciences provide the foundation for the development of forensic analysis of audio recordings as a branch of forensic science.

Түлхүүр үг: Дуу авиа судлал, шүүх шинжилгээ, яриа, анатоми, физиологи
Keywords: Phonetics, forensics, speech, anatomy, physiology

Удиртгал

Хүний хэл яриа хэзээ үүссэнийг хэн ч мэдэхгүй. Янз янзын онол бий ч алин ч батлагдах боломжгүй юм. Санал нэгдсэн тодорхойлолт нь бол бий: Хүний хэл бол харилцааны явцад бусад хүний санаа бодлыг хуваалцах чадвар юм. Хэлийг хүн бусад хүмүүстэй харилцаж, санаа сэтгэлээ солилцох процесст хэрэглэх практикийн явцыг үг яриа гэнэ. Харин хэл нь

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

хүмүүсийн хоорондын харилцааг залгуулдаг хэрэглүүр учраас үг ярианаас ялгаатай үзэгдэл мөн. Хүмүүсийн өвөр хоорондоо бодол санаа, дотоод сэтгэлээ харилцан ойлголцох процесс нь гагцхүү хэлний тусламжтайгаар явагдана. Ийм учраас хэл нь нийгэм ба хүмүүсийн хамтын үйл ажиллагааны хэрэглүүр болно. Хэл ба ярианы нь сэтгэхүйн адилаар амьдралын явцад үүсэж хөгжсөн түүхтэй юм. Иймд хэл ба яриа нь зөвхөн хүн төрөлхтний бүтээл байна.


Хүмүүс ярьж сураад эхэндээ нүдэнд харагдах ойр орчмын юмаа л нэрлэдэг байсан байх. Уул ус, тэнгэр, газар, гол ус, нэг хоёр гурав, аав ээж, хоол, эсвэл унтах сэрэх, идэх уух гэх мэтийн үйл үгс.

Дэлхийн бараг бүх хэлэнд “би” гэх үг “м” авиагаар (манай, миний), “чи” гэх төлөөний нэр “т” авиагаар эхэлдэг (танай, та) гэх. Мөн “ээж” гэхийг “ма”, ”мама” гэдэг гэнэ. Эндээс бүх хэл анхлан нэг газарт үүсч цааш хувилсаар өргөжсөн гэх онол-таамаглал ч бий.


40 мянган жилийн өмнө ухаант хүн Африкаас нүүдэллэн Синайн хойгоор дамжин бусад тив рүү тархсан ба тэдний тоо дөнгөж 10-20 мянга байсан гэдэг. Энэ үнэн бол ийм цөөн хүмүүс нэг төрлийн хэлээр ярьдаг (ойр зуурын юмсыг адилхан нэрлэдэг) байсан таамаглал байна.







Адгуусан амьтанд янз бүрийн авиа дуу гаргаж, орчин ба өвөр хоорондоо харьцах төлөвийг илэрхийлэх боловч тэр нь хүний хэл ярианы адилаар бодол санаа, үйл ажиллагааг нэвтрэлцэн солилцох хэрэглүүр болж чадахгүй билээ. Гэвч зарим адгуусан амьтанд нэлээд нарийн авиа дуутай байдаг. Жишээ нь, Шампанзе мич нь хоолойгоороо 52 төрлийн авиа гаргадаг байна. Эдгээр нь ердөө л амьдралын нөхцөл, биологийн хэрэгцээ, шаардлагын үүднээс буй болсон зөвхөн тэр амьтны организмын төрөлхийн хэрэгцээг хангахад зориулагдсан дохио нь болж өгнө.



Хүний ярьдаг чадвар 7-р хромосом дээр гарч ирсэн FOXP2 гэсэн мутацлагдсан гений үр дүн гэсэн нээлтийг саяхан генетикчид олсон байна. Гэхдээ энэ ген шимпанзе болон хомо сапиэнсээс өмнөх хүн дүрстүүдэд байдаггүй гэнэ.

Анх 1998 онд KE гэр бүл гэж нэрлэгддэг Британийн гэр бүлд ярианы эмгэгийн генетикийн шалтгаан гэж тодорхойлогдсон FOXP2 нь яриа, хэлтэй холбоотой болохыг илрүүлсэн анхны ген байсан бөгөөд дараа нь "хэлний ген" гэж нэрлэгдсэн.

Шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийг даган хэлний үзэгдэл, түүний мөн чанарыг судлах хэрэгцээ нэмэгдэж, туршилт авиазүй буюу дуу авиа зүй судалгааны үр дүнг ерөнхий хэл шинжлэл, цахим хэл шинжлэл, зэрэгцүүлсэн авиазүй, авиалбар зүй, заах аргазүй зэрэг олон салбарт ашиглаж байна. Тиймээс уламжлалт авиа зүйн чанарыг илтгэсэн үр дүнг тооцоолох аргатай хослуулан, туршилтад тулгуурласан чанар ба тоог илтгэсэн үр дүн хэрэгтэй болсон.

Аливаа мэдээлэл хэл, ярианы тусламжтай дамждаг тул сүүлийн үед цахим хэл шинжлэлийн салбар эрчимтэй хөгжиж, түүний дотор дууны авиа зүйн аргыг машинаар орчуулах, яриаг бичвэр болгох, бичвэрийг яриа болгох, дууны авианы шинж чанарыг хэмжих, тодорхойлох программ бүтээх судалгаанд өргөн хэрэглэж байна.

Хэл яриа бол хүний санаа, сэтгэхүй, мэдрэхүйг илэрхийлэх болон мэдээлэл дамжуулах, хуримтлуулах чухал хэрэгсэл бөгөөд хүмүүсийн харилцаанд үйлчлэх, хүний үйл ажиллагааны өвөрмөц хэлбэр учраас түүнийг шинжлэх ухааны олон салбар судалдаг.

Дуу авианы бичлэгт хийх шүүх шинжилгээний үндсийг байгаль, техник, нийгмийн ухааны мэдлэг бүрдүүлдэг. Дуу авиа бичлэгт адилтгалын болон оношилгооны шинжилгээ хийж шинж тэмдгийг тогтоох, дууны дохионд анализ хийх нь хүний өгүүлэхүйн эрхтэн (хоолой), аман ярианы төрөл, бичлэг хийсэн орчны нөхцөл, бичлэг хийсэн техник хэрэгсэл зэргээс хамааралтай байх ба иж бүрдэл шинжилгээ хийхээр ээдрээтэй асуудал байдаг. Энэ төрлийн шинжилгээ нь шинжээчээс математик, физик, кибернетик, дохио дамжуулал, системийн анализ,



хэмжихүйн онол, радиотехник, хэл шинжлэл, криминалистик зэрэг салбарын тусгай мэдлэгийг шаарддаг. Эдгээр шинжлэх ухаан дуу авианы бичлэгт хийх шүүх шинжилгээг криминалистикийн мэдлэгийн салбар болон бүрэлдэх боломж олгож, цаашид хөгжих суурийг бүрдүүлж өгдөг.

Криминалистикийн дуу авиа судлал

Хүмүүсийн өдөр тутмын харилцаанд хоорондоо харьцах шаардлага зайлшгүй тулгарч байдаг. Харин энэхүү харьцаа хүмүүсийн үйл ажиллагааны явцад илүү өргөн хэрэгцээг бий болгож, тэдгээрийн нийлбэр нь нийгэм хэмээх, хүмүүсийн хамтын амьдралын томоохон нэгдлийг бий болгодог. Нийгмийн гишүүн хүмүүс зан араншин, биеэ авч явах байдал, соёл-хүмүүжлийн түвшингээр харилцан адилгүй бөгөөд тийм ч учраас нийгэмд төрөл бүрийн сайн, муу үзэгдэл, үйл явдал болж байдаг. Эдгээр үзэгдлийн нэг нь гэмт хэрэг юм.

Гэмт хэрэгт эрүүгийн хуулиар хориглосон хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг ойлгох бөгөөд гэмт этгээд дээрх хэм хэмжээг зөрчсөн үйлдлээ гүйцэтгэхдээ тодорхой арга, хэрэгсэл ашигладаг. Гэмт этгээд үйлдлээ гүйцэтгэх арга, хэрэгсэл болон түүнээс үлдэх мөрийг судалж гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга, аргачлалыг боловсруулдаг шинжлэх ухаан нь криминалистик юм.

Шинжлэх ухаан, техник технологийн хөгжил жил сараар биш цаг, минутаар хувьсан өөрчлөгдөж улам бүр хөгжиж байгаа энэ үед шинжлэх ухаан, технологийн тэрхүү ололт дэвшлийг гэмт этгээдүүд ашиглан гэмт үйлдлээ гүйцэлдүүлж байна.

Криминалистикийн тогтолцоог бүрдүүлэгч салбарын нэг – криминалистикийн техник зүйг их төлөв мөр үүсгэгч объектын онцлогоор төрөлжүүлэн олон дэд салбарт хуваан судалдаг бөгөөд тэдгээрийн нэг нь криминалистикийн дуу авиа судлал юм.

Төрөл бүрийн авиануудын бүтэц, дууны спектрийн хувьд бусдаас ялгагдах өвөрмөц онцлогтой, тэдгээр нь дахин давтагдашгүй ба харьцангуй тогтвортой шинж агуулж байдаг тул дэлхийн олон орны хууль сахиулах чиглэлийн байгууллага дуу авиаг гэмт хэрэгтэй тэмцэхэд өргөнөөр ашиглаж байна.

Криминалистикийн дуу авиа судлал нь дуу авианы мэдээлэл үүсэх хэв маяг, түүнийг техникийн хэрэгслээр ашиглан анализ хийх, дуу авианы эх үүсвэрийг тодорхойлох, оношлоход ашиглах үр дүнтэй техник, арга аргачлал боловсруулж байдаг.

Дуу авианы шинжилгээний объектууд нь өнөөдөр дуу авианы дохиог (гар утас) бүртгэх эсвэл хуулбарлахад ашигладаг янз бүрийн дууны бичлэг болон техникийн хэрэгсэл ашигладаг. Мэдээллийг хадгалах, хуулбарлах аргуудыг дижитал аудио болон видео бичлэгээр сольж байгаа тул мөрдөн байцаалт болон шүүхийн практикт дуу авиа хэрэгсэл ач холбогдол сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц өссөн бөгөөд техник хэрэгсэл улам бүр хүртээмжтэй болж байна. Үүний үр дүнд дуу авиа болон видео бичлэгийг эрүүгийн хэргийн материалыг бэхжүүлэхэд улам бүр ашиглаж байна.

Дуу авиа болон видео бичлэг нь хэргийг мөрдөн шалгахад чухал ач холбогдолтой бөгөөд нотлох болон үгүйсгэх баримтыг баталгаажуулах, гэмт хэргийг шийдвэрлэх арга замыг сонгох, эрэн сурвалжлах, хүн болон бусад дууны эх үүсвэрийг тодорхойлох, бичлэг өөрчлөгдсөн эсэх шинж тэмдгийг тогтооход ач холбогдолтой байна. Гэмт хэргийг мөрдөн шалгах практикт хамгийн чухал дуу авианы шинжилгээ (аль ч дууны эх үүсвэрийг хамарч болно) нь хүний аман яриаг судлахтай холбоотой үүрэг гүйцэтгэдэг. Дуу авиа судлалын үүднээс авч үзвэл аман яриа нь түүний үе шат, акустик шинж чанарыг дамжуулдаг олон тооны авиа зүйн шинж чанараар тодорхойлогддог. Үүнд: цаг хугацаа, давтамж, далайц, эрчим, хурд, хүрээ гэх мэт параметрүүдийн шинж тэмдэг илэрхийлэгдэж байна.

Техник технологи хурдтай хөгжлийн хирээр хүмүүс хэрэглээндээ төрөл бүрийн цахим төхөөрөмжийг улам өргөнөөр ашиглаж байна. Үүнтэй холбоотойгоор, дуу авиа, дүрс бичлэгийн программуудыг гар утас, таблет, бичил дуу хураагуур зэрэгт хэрэглээний функц хэлбэрээр ашиглаж, хүмүүсийн харилцаанд өөр хоорондын хэлсэн үг, яриаг баримтжуулан хууль шүүхийн байгууллагаар нотлох баримтын хэмжээнд үнэлүүлэх явдал ихсэж байна.

ШШҮХ-ийн Криминалистикийн лабораторид дуу авианы адилтгалын шинжилгээний “Икар-лаб” системийг 2011 оноос суурилуулж харьцуулсан шинжилгээ хийгдэж эхэлсэн бол шинэ бүтцээр ШШЕГ-ын Инженер-техникийн шинжилгээний газарт дуу авианы адилтгалын шинжилгээ хийгдэж байна.

2015-2025 онуудад хийгдэж байгаа дуу авианы адилтгалын шинжилгээ тоо үзүүлэлтийг харуулав.

2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025.06
28	45	58	56	53	92	162	17	14	16	7

Криминалистикийн дуу авиа судлал нь криминалистикийн шинжлэх ухааны шинэ салбар боловч манай орнуудын хувьд энэ салбарыг судалж дуу авианы адилтгалын болон харьцуулалтын шинжилгээ хийж эхлээд 15 жил болж байна.


Улмаар шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийг даган хэлний зүй тогтол түүний мөн чанарыг судлах хэрэгцээ

шаардлага улам бүр нэмэгдэж байна. Иймд бидэнд энэхүү судалгааны ажлаа үргэлжлүүлэн Монгол хүний хэлний онцлог болох нутгийн аяга, ярианы сэтгэл зүйн хүчин зүйлс, авиа зүй артикуляци, формант, цахим хэл шинжлэл, яриа боловсруулалт зэрэг чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, судлах шаардлага хэрэгцээ цаашид үүсэж байна.

Криминалистикийн дуу авиа судлалын үндэс


Гэмт хэргийг мөрдөн шалгах практикт хамгийн чухал дуу авианы шинжилгээ нь хүний аман ярианы судлагдахуун байдаг. Дуу авиа судлалын үүднээс авч үзвэл аман яриа нь түүний үе шат, акустик шинж чанарыг дамжуулдаг олон тооны авиа зүйн шинж чанараар тодорхойлогддог. Үүнд цаг хугацаа, давтамж, далайц, эрчим, хурд, хүрээ гэх мэт. Физикийн хувьд энэ нь төв мэдрэлийн систем болон ярианы аппаратын үйл ажиллагаа зэрэг хүний нарийн төвөгтэй анатоми болон физиологийн үйл ажиллагаагаар үүсдэг акустик дохио юм.

Дуу авианы үүсэх процесс нь агаарын орчин, дуу хоолой (фонаци), ярианы дуу чимээ (дуу шуугиан) үүсгэх гурвалсан үүргийг гүйцэтгэдэг. Өрц, уушги, мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой нь агаарын орчин үүсэхэд, төвөнх болон дууны хөвч нь авиа гаргахад, залгиур, зөөлөн тагнай, ам ба хамрын хөндий, уруул, хэл, хамрын хөндий нь үелэх үйл явцад оролцдог.




Аман ярианы анатомийн болон физиологийн шинж чанарыг төвөнх болон дууны хөвчний бүтэц, амьсгалын төрлөөр тодорхойлдог. Дуу хоолойгоор дамжин өнгөрөх агаар нь дууны хөвчийг чичирхийлж, тодорхой өндөр, хүч, тембертэй дуу хоолойг бий болгодог.

Дуу авианд нөлөөлдөг гол биологийн хүчин зүйлүүдэд биеийн бүтэц, дууны аппаратын тэгш хэм, дотоод шүүрлийн булчирхайн үйл ажиллагаа, насны онцлогоос хамаардаг. Нярай хүүхдийн уйлахаас эхлээд хөгшин хүний бувтнах хүртэл хүний дуу хоолой биологийн болон санамсаргүй хүчин зүйлстэй холбоотой цуврал өөрчлөлтийг хийдэг. Нас ахих тусам дуу хоолойн өндөр, эрчим төдийгүй тембер нь өөрчлөгддөг. Хүүхэд насандаа, ялангуяа бэлгийн бойжилтын үед төвөнхийн бүтэц өөрчлөгдөж, бага насны эрэгтэй хүүхдийн өндөр эсвэл альт дууг баритон эсвэл бүр эрэгтэй басс болгон хувиргадаг. Охидын хувьд энэ үед хүүхдийн өндөр эсвэл альт дуунаас эмэгтэй сопрано эсвэл контральто руу шилжих нь ажиглагддаг. Тиймээс дотоод шүүрлийн булчирхай нь төвөнхийн анатомийн бүтцэд, улмаар дуу хоолой гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хөгшрөхөд, төвөнхийн ясжилт бүрэн дуусахад уушгины багтаамж, уян хатан чанар буурч, цээж нарийснаас болж дуу хоолой өөрчлөгдсөөр байдаг. Дуу хоолой сул, шуугиантай, бүдэг болдог.



Аман яриа болон хүний бие махбодын онцлог шинж чанаруудын хоорондын хамаарал нь яриа үүсгэх аппарат болон ярианы үйл ажиллагаа нь анатоми, физиологиос хамааралтай болохыг харуулж байна. Жишээлбэл, нам дуу хоолойтой хүмүүс өндөр, цээж нь том байдаг. Хүний дуу хоолойн өвөрмөц байдлыг тодорхойлдог бөгөөд дээр дурдсан шинж

чанаруудаас гадна аман ярианы чадварыг хөгжүүлэх арга замууд бас чухал ач холбогдолтой юм. Эдгээр нь хувь хүнд генетикийн хувьд шингэсэн дотоод биологийн хүчин зүйлс болон гадаад хүчин зүйлсийн аль алиных нь нөлөөгөөр үүсдэг. Сүүлийнх нь ихэвчлэн хүрээлэн буй орчин, тухайн хүний туулсан өвчин, боловсрол, хүмүүжил гэх мэтийг агуулдаг.




Эдгээр хүчин зүйлсийн нөлөөн дор яриаг эзэмшсэн хүн ярианы аппаратаа хүрээлэн буй хэл шинжлэлийн орчны хууль тогтоомж, дүрмийн дагуу суралцаг юм. Аман ярианы механизм хөгжихийн хэрээр тэд бодлоо илэрхийлэхийн тулд ярианы дүрмийн бүхэл бүтэн системийг ашиглаж,



Хувийн мэдээлэл илүү ач холбогдолтой байдаг. Аман ярианы агуулга, бүтцийн аман илэрхийлэл болохын хувьд энэ нь сүүлийнх нь хэв маяг, үгсийн сан, дүрмийн бүтэц, хэлний дүрмийн болон хэв маягийн хэрэгсэл, ярианы логикийг улам бүр дур мэдэн сонгодог. Цаг хугацаа өнгөрөхөд тодорхой бүтэцтэй аялга, хэллэгийг (ижил төстэй нөхцөл байдалд) давтахаас бүрдэх тодорхой динамик хэвшмэл ойлголт үүсдэг. Динамик ярианы хэвшмэл ойлголтыг өөрчлөх нь түүний үүсэхтэй адил хэцүү тул цаг хугацаа, хүчин чармайлтын ихээхэн хөрөнгө оруулалт шаарддаг.

Хүний аман ярианд агуулагдах хувийн шинж чанарын талаарх мэдээллийг уламжлалт байдлаар утга зүйн болон хувийн гэж хуваадаг. Эхнийх нь аман мессежинд агуулагдах мэдээллийн нийлбэр юм. Энэ нь илтгэгчийн ерөнхий оюуны хөгжил, үзэл бодол, мэргэжлийн мэдлэг, түүнчлэн хязгаарлагдмал хүрээний хүмүүст мэдэгдэж буй үйл явдал, баримт, нөхцөл байдлын талаарх мэдлэгийг илтгэнэ.

Төвөнх нь дуу авиа үүсгэдэг хамгийн гол эрхтэн бөгөөд бамбай ба яст мэлхий хэлбэртэй мөгөөрснүүд нь булчингуудаар холбогдсон бөгөөд богинохон өргөн хоолой үүсгэж, төвөнхий дээрх хэсгийг бүрхэхдээ зай гаргана. Дуу хоолой үүсгэх үед төвөнхийн хоолойн холбооснууд оролцдог. Дуу авиа нь төвөнхийн мөгөөрсний завсарт орших салст хуниас-дууны хөвчид үүсдэг. Ярих, дуулах үед дууны хөвч нийлнэ. Дууны өнгө нь дууны хөвчийн урт богиноос хамаарна.



The Larynx: viewed from above

логикийг тусгасан байдаг - энэ нь хувь хүний бие бялдар, сэтгэл зүйн болон нийгмийн бүтэц, хүйс, нас, үндсэн хуулийн шинж чанар, яриа үүсгэдэг замын

анатомийн шинж чанарыг үнэлэх боломжийг олгодог шинж чанарууд юм. Хувийн мэдээлэл нь ярианы хөгжлийн газарзүйн бүсээс хамааран хөгжиж буй зан чанарын шинж чанар, боловсрол, оюун ухаан, аялгууны шинж чанарыг тусгасан бөгөөд энэ нь бидэнд илтгэгчийн хувийн шинж чанарыг оношлох боломжийг олгодог. Тиймээс хүйстэй холбоотой үгс (таных-таных, дуудсан-дуудаг, баяртай-баяртай гэх мэт) хүйсийг илэрхийлж болно. Цаашилбал, эмэгтэйчүүд яриандаа илүү сэтгэл хөдлөлтэй байдаг; Тэд "хар дарсан зүүд шиг", "үнэн аймшгийн", "маш гоё" гэх мэт илэрхийлэлтэй үгсийн санг байнга ашигладаг. Эрэгтэйчүүд сэтгэл хөдлөлөө ёжтой, бүдүүлэг, тэр ч байтугай хараалын үгсээр илэрхийлдэг. Мөн илтгэгчийн хүйсийг илтгэгчийн дууны хүрээний өнгө аяс, тембр дээр үндэслэн шинжилж тодорхойлж болно. Яриа, дуу авианы ялгаа нь хэвлийн болон цээжний булчингууд бага хөгжсөн, уушгины багтаамж бага, эмэгтэйчүүдийн дууны хөвч богино байдагтай холбоотой юм.

Илтгэгчийн ойролцоо насны талаарх мэдээллийг намтарчилсан лавлагаа, бага мэдэгдэж буй тайлан, эсвэл өнгөрсөн нөхцөл байдлаас; хуучирсан үгс (хэллэг) эсвэл хамгийн сүүлийн үеийн үг хэллэг, илэрхийллүүдийг ашиглах замаар олж авч болно. Илтгэгчийн залуу насыг олон янзын асуудлаар, дүгнэлтийн ангилалт шинж чанараар нь илэрхийлж болно. Ахмад настнууд яриандаа илүү болгоомжтой ханддаг бөгөөд ярилцагчдадаа зөвлөгөө, лекц унших хандлагатай байдаг.

Хүний боловсрол, соёлын түвшинг түүний үгсийн сан, илэрхийллийн бүрэн бүтэн байдал, нарийвчлал, ярианы хэв маяг, ярианд нь онцлог үгсийн шинж чанар байгаа эсэх, дуудлагаар нь дүгнэж болно.

Аман ярианы үгсийн шинж чанар нь бодол санаагаа илэрхийлэхэд ашигладаг үг, хэллэгийн цогц юм. Тиймээс уран зохиолын хэв маяг, ярианд мэргэжлийн болон техникийн нэр томьёо байгаа нь тухайн хүний боловсрол, соёлыг илтгэдэг. Баялаг үгсийн сантай хүмүүс ихэвчлэн утга учиртай, тухайн нөхцөл байдалд хамгийн хамааралтай үгсээр бодлоо илэрхийлдэг. Үгсийн сан муутай хүмүүс илэрхийлэл, тууштай байдал дутмаг, тиймээс нэлээд энгийн байдаг ижил үг, хэллэгийг давтахаар өөрсдийгөө хязгаарладаг.

Аман ярианы бичлэгийн оношилгооны судалгааг хүний анатомийн болон физиологийн тодорхой шинж чанарыг тодорхойлохын тулд хийдэг. Жишээлбэл, хамрын дуу хоолой нь парез, афази зэрэг мэдрэлийн системийн эмгэгийг илтгэдэг; яригчийн өндөр, цээжний хэмжээг дуу хоолойны тембрээр тодорхойлж болно.

"s" болон "z" авиаг дуудахдаа (лизинг) буруу дуудлага хийх нь ихэвчлэн эрүү, шүдний бүтцийн согог, эсвэл яриагаа хянах чадваргүй сонсголын бэрхшээлийн үр дүн юм. Хамрын дуу хоолой - ярианы дуу авианы гажуудалтай холбоотой дуу хоолойн тембрийн эмгэг өөрчлөлт - ихэвчлэн хамрын таславчийн гажуудал эсвэл хамрын полип үүссэнээс үүдэлтэй байдаг. Артикуляцийн өөрчлөлт нь ярианы аппаратын хөдөлгөөний үйл ажиллагааг сулруулдаг нөхцөл байдал юм. Энэ нь бие даасан дуу авианы хэллэгийг алдагдуулдаг бөгөөд хэл нь идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг: "ч", "р", "ш", "ж" гэх мэт. Тархины тодорхой хэсэгт тохиолддог гажуудал нь үгсийн бүтэц эвдэрч, нэг үеэс нөгөө үе рүү шилжихэд хэцүү, ярианы хурд удаан, байнга түр зогсолттой үед ярианы сулралд хүргэдэг.

Сүүлийн үед хүмүүсийн боловсрол нэмэгдсэний улмаас яриа нь утга зохиолын хэлний хэм хэмжээнд ойртож эхэлсэн. Гэсэн хэдий ч энэ нь ихэвчлэн тодорхой бүс нутгийн ярианы онцлогийг тусгасан аялгууны шинж чанарыг харуулдаг. Түүнээс гадна, утга зохиолын хэлийг сайн мэддэг хүн стресс эсвэл сэтгэл хөдлөлийн өдөөлтийн үед ярьж сурсан эсвэл удаан хугацаанд амьдарч байсан бүс нутгийн аялгууны онцлог шинж чанарыг харуулдаг. Энэ нь тухайн хүний төрсөн газар эсвэл удаан хугацаагаар оршин суугаа газрыг мэргэжлийн оношилгоо хийх үндэс суурь болдог.

"Аялгаа" гэдэг нэр томьёо нь тодорхой нутаг дэвсгэрт ярьдаг хэлний орон нутгийн ярианы онцлогийг хэлнэ. Хэлний хэлээр ярьдаг хүмүүс бие биенээсээ хол байх тусам

аялга нь илүү тод ялгаатай байдаг бол зэргэлдээ нутгийн оршин суугчдын ярианы ярианд тэнд ярьдаг аялгын нийтлэг шинж чанарууд ажиглагддаг.

Яригчийн аялгууны шинж чанаруудад үгсийн сан (үг, хэллэг), дүрмийн хэлбэрүүд (хэлбэрийн уншилт, холбоос, үгийн хослол, авиа зүйн бүтэц гэх мэт) болон үгийн онцлог шинж чанарууд (интонация, онцлох үйл үг, ярианы хурд, өргөлт) багтдаг.

Тодорхой бүс нутгийн аялгууны шинж чанарууд нь үгсийн санд хамгийн тод илэрхийлэгддэг. Нэг аялгууны зарим үгс бусад аялгуунд байдаггүй бөгөөд ижил үгсийг өөр өөр аялгуунд өөр өөр утгаар ашигладаг. Бүс нутгийн аялгууны шинж чанарууд нь хэллэг, дүрмийн хэлбэр, ярианы үгийн онцлог шинж чанаруудад мөн илэрдэг.

Нутаг дэвсгэрийн аялгууны онцлог нь нэг газарт байнга амьдардаг ахмад настнуудын ярианд хамгийн тод илэрдэг бөгөөд эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүдэд илүү мэдэгдэхүйц байдаг.

Хүний мэргэжил болон бусад нийгмийн шинж чанарыг тодорхойлохдоо тодорхой нийгмийн бүлгийг тодорхойлдог үгсийн сангийн онцлог, аман ярианы хэлц үгсийн онцлог, түүний агуулга нь нэн тэргүүний ач холбогдолтой байдаг.

Аман ярианы хэлц үгсийн онцлог, хэлц үгсийн онцлогийг шинжлэхдээ хүний үйл ажиллагааны аль ч салбарт аажмаар хуримтлагдаж, өөрчлөгддөг үгсийн сан байдаг гэдгийг анхаарч үзэх нь чухал юм. Ийнхүү өвөрмөц нэр томьёо үүсдэг бөгөөд энэ нь ижил мэргэжил, ажил мэргэжилтэй хүмүүсийн ярианы хэлц үгсийн найрлага (онцлог үг, хэллэг) болон хэлц үгсийн онцлогийг тодорхойлдог.

Нийгмийн аялгуу нь газарзүйн хувьд тусгаарлагдаагүй тул нэг газарт хэд хэдэн нь оршин тогтнож болно. Нийгмийн аялгууны олон төрөлд мэргэжлийн ур чадвар, гудамжны хэллэг буюу хэллэг (нууц хэллэг) багтдаг. Мэргэжлийн ур чадвар гэдэг нь нэг мэргэжлээр ажилладаг хүмүүст түгээмэл хэрэглэгддэг үг, хэллэг юм. Аман ярианы аудио бичлэгийг шинжлэхдээ зөвхөн мэргэжлийн ур чадвар байгаа эсэхэд төдийгүй тэдгээрийн хэрэглээний нарийвчлалд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Гудамжны гэдэг нь үгийн шууд утгаараа луйварчид, хулгайч нар, рэкетчид, биеэ үнэлэгчид, мансууруулах бодист донтсон хүмүүс болон бусад хүмүүсийн уламжлалт хэл юм. Гудамжны хэллэгийн үгсийн санг одоо байгаа үгсийг зохиомлоор өөрчлөх эсвэл өвөрмөц утгатайгаар ашиглах замаар бий болгодог бөгөөд ингэснээр яриа нь зөвхөн тодорхой нийгмийн давхаргын хүмүүст ойлгомжтой байх болно. Жишээлбэл, эрүүгийн гэмт хэрэгтнүүд өөр утгатай алдартай үгсийг ашигладаг: "том ах", "хамаа" гэх мэт. Гудамжны үг, хэллэг нь сүүлийн үед хүн амын дунд, ялангуяа залуу хүмүүсийн дунд маш өргөн тархсан.

Хүний үндэс угсааг аялгатай нь харьцуулж дүгнэж болно. Интонация гэдэг нь дуудлага хийх үед дуу хоолой хэрхэн өгсөж, буурч байгааг хэлдэг бөгөөд энэ нь яригчийн мэдрэмжийг илэрхийлдэг. Интонация нь дууны хэмжээ, аялгууг, мөн хэллэг доторх түр зогсолтын байршил, нийт үргэлжлэх хугацааг зохицуулдаг. Интонация нь илэрхийлэх хэлбэрийг тодорхой болгож, тодорхой дууны өнгө аясыг өгч, ярианы онцлогийг тусгадаг.

Интонация нь дараах элементүүдийг агуулдаг: аялгуу (дуу хоолойн үндсэн өнгө аясын өөрчлөлт), үг, хэллэгийн хоорондох түр зогсолт, эрчим гэх мэт. Ярианы урсгал дахь бие даасан үгсийн дуудлага, ярианы хэмнэл, дуу хоолойн тембр, эдгээр шинж чанарууд дээр үндэслэн хорь гаруй төрлийн аялгууг ялгаж үздэг бөгөөд жишээлбэл, асуулт, баяр баясгалан, гайхширал, уриалга, айдас, жигшил, уур хилэн, баяр баясгалан, үгүйсгэл гэх мэтийг илэрхийлдэг. Эдгээр бүх төрлийн аялгуу нь аялгуунд нормоос хазайсан байдаг бөгөөд энэ нь голчлон тухайн аялгууны онцлог аялгуу, бие даасан үг, хэллэгийг дууддаг өвөрмөц аялгуутай холбоотой юм. Бүс нутгийн аялгууны аялгууны шинж чанарыг шинжлэхдээ тусгай уран зохиол (хэлний аялгууны атлас)-ыг үзэх шаардлагатай.

Хүний аман яриа нь авиа зүйн болон хэл шинжлэлийн онцлог шинж чанартай бөгөөд эдгээр нь хувь хүн бөгөөд харьцангуй өөрчлөгддөггүй тул аудио

бичлэгт бичигдсэн хүний хувийн чанарыг тогтоохоос гадна тэдгээрийг тодорхойлох боломжийг олгодог. Физик шинж чанараасаа шалтгаалан авиа зүйн онцлог нь чанарын үзүүлэлтээс гадна тоон үзүүлэлттэй байдаг тул багажийн шинжилгээний аргыг ашиглан судалж болно. Тэдгээрийг спектрограмм, гистограмм гэх мэтээр харуулж, хэмжилтийн үр дүнд үндэслэн үнэлж, хоёрдмол утгагүй дүгнэлт гаргах үндэс суурь болж өгдөг.



Тархин системд яриа үүсэх физиологи үндэс

Үндэс нь сэтгэхүйн адилаар дохионы хоёрдугаар систем болно. Дохионы энэхүү системийн цочроогчийн үүргийг юм үзэгдэл биш харин үг гүйцэтгэнэ. Дохионы хоёрдугаар системийн цочроогч үг нь хүнд сонсох, харах, дуудах гурван хэлбэрээр нөлөөлнө. Ийм учраас ярианы үүсэж явагдах, түүнийг удирдан зохицуулах төв газар нь тархины гадрын тусгай хэсгүүдэд байрласан байдаг. Тархины гадарт ярианы төв нь сонорын ба хөдөлгөөний, харарны гэсэн гурван бүсэнд байрлажээ.

Ярианы сонорын төв. Ярианы сонорын төв нь тархины гадрын зүүн шанааны тус газрын хойд хэсэгт байрласан байдаг. Ийм учраас тархины энэхүү хэсэгт гэмтэл учрахад хүний ярианы эмх цэгц алдагдаж бусад хүний ярьж өгүүлэхийг мэдрэхээ болих буюу сонсох боловч үгийн утга санааг үл ойлгоно.

Ярианы хөдөлгөөний төв. Ярианы хөдөлгөөний төв нь их тархины зүүн хэсгийн духны тус газрын гурав дахь даланд оршино. Энэ хэсэг нь өгүүлэгч хүний идэвхтэй үгтэй холбоотой байдаг. Энэхүү төв нь ямар нэг гэмтэлд учрахад хүн үгийг дуудах чадвараа бүрэн алдана.

Ярианы харарны төв. Хүний үг ярианы харарны төв нь тархины гадрын зулайн тус газарт байрласан байна. Энэхүү төв нь унших дуудах зэрэг өгүүлэх ба бичих, харах зэрэг яриа хөдөлгөөний үйлийг удирдана. Энэ хэсэг ямар нэг гэмтэлд учрахад хүн үсэг танихаа болж, унших, бичих чадвараа алдана. Ярианы эдгээр төвүүд нь бие биенээсээ дангаар орших боловч хоорондоо нягт холбоотой хөгжиж хүний яриаг үүсгэх үндсийг бүрэлдүүлнэ.

Дүгнэлт

Шинжлэх ухаан, техник технологийн хөгжил жил сараар биш цаг, минутаар хувьсан өөрчлөгдөж улам бүр хөгжиж байгаа энэ үед шинжлэх ухаан, технологийн тэрхүү ололт дэвшлийг гэмт этгээдүүд ашиглан гэмт үйлдлээ гүйцэлдүүлж байна.

Криминалистикийн тогтолцоог бүрдүүлэгч салбарын нэг – криминалистикийн техник зүйг их төлөв мөр үүсгэгч объектын онцлогоор төрөлжүүлэн олон дэд салбарт хуваан судалдаг бөгөөд тэдгээрийн нэг нь криминалистикийн дуу авиа судлал юм.

Төрөл бүрийн авиануудын бүтэц, дууны спектрийн хувьд бусдаас ялгагдах өвөрмөц онцлогтой, тэдгээр нь дахин давтагдашгүй ба харьцангуй тогтвортой шинж агуулж байдаг тул дэлхийн олон орны хууль сахиулах чиглэлийн байгууллага дуу авиаг гэмт хэрэгтэй тэмцэхэд өргөнөөр ашиглаж байна.

Криминалистикийн дуу авиа судлал нь дуу авианы мэдээлэл үүсэх хэв маяг, түүнийг техникийн хэрэгслээр ашиглан анализ хийх, дуу авианы эх үүсвэрийг тодорхойлох, оношлоход ашиглах үр дүнтэй техник, арга аргачлал боловсруулж байдаг.

Дуу авианы шинжилгээний объектууд нь өнөөдөр дуу авиаг бүртгэх эсвэл хуулбарлахад ашигладаг янз бүрийн дууны

бичлэг болон техникийн хэрэгсэл ашигладаг. Мэдээллийг хадгалах, хуулбарлах аргуудыг дижитал аудио болон видео бичлэгээр сольж байгаа тул мөрдөн байцаалт болон шүүхийн практикт дуу авиа хэрэгсэл ач холбогдол сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц өссөн бөгөөд техник хэрэгсэл улам бүр хүртээмжтэй болж байна. Үүний үр дүнд дуу авиа болон видео бичлэгийг эрүүгийн хэргийн материалыг бэхжүүлэхэд улам бүр ашиглаж байна.

Улмаар шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийг даган хэлний зүй тогтол түүний мөн чанарыг судлах хэрэгцээ шаардлага үүсэж байна. Иймд бидэнд энэхүү судалгааны ажлаа үргэлжлүүлэн Монгол хүний хэлний онцлог болох нутгийн аялага, ярианы сэтгэл зүйн хүчин зүйлс, авиа зүй артикуляци, формант, цахим хэл шинжлэл, яриа боловсруулалт зэрэг чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, судлах шаардлага цаашид үүсэж байна.

Ашигласан материал

Нэг. Онолын ном сурах бичиг

- Баярбаатар.Ж “Анатоми” УБ, 2005
- Жамьянсүрэн. “Амны хөндий ба хэл ярианы тухай лекц” УБ, 2009
- Цэнджав Ц. “Дууны хоолойн бүтэц, ангилал, онцлог шинж” УБ, /СУИС - магистрын дипломын ажил-2004/
- Түгжсүрэн .Н “Агаар мандалын физик”, УБ, 2004
- Түгжсүрэн. Н “Физик экологи шуугиан ба доргион” УБ, 2005
- Түгжсүрэн. Н “Хэлбэлзэх хөдөлгөөний тухай лекц” УБ, 2009
- Хурцгэрэл.Ж “Криминалистика-I” УБ, 2002

Хоёр.Гадаад хэл дээрх онолын ном сурах бичиг

- Белкин Р.С “Криминалистика”/ проблемы, тенденций, перспективы/ 1987
- Галещина. И Е “Фоноскопи” Москва, 2005
- Коваль С.Л, Гарбарук В.И, Ильина О.Я “Шумоочистка и установленных текста низкокачественных звукозаписей речи “ 1997-1999
- Славин И.И. “Производственный шум и борьба с ним” 1955
- Салтаевский М.В Звуковые следы “Криминалистическая фоноскопия” /Специализированный курс криминалистики/- Киев, 1987
- “Сборник научно-методических рекомендаций по выполнению криминалистических экспертиз звукозаписей речи” STC-D106.2 центр речевых технологий Санкт-Петербург, под редакцией Коваля С.Л, 2005
- *AES Standard for Forensic Purposes—Criteria for the Authentication of Analog Audio Tape Recordings*, AES Standard 43-2000.
- B. E. Koenig, D. S. Lacey, and S. A. Killion, “Forensic enhancement of digital audio recordings,” *J. Audio Eng. Soc.*, vol. 55, no. 5, pp. 252–371, May 2007.
- C. Musialik and U. Hatje, “Frequency-domain processors for efficient removal of noise and unwanted audio events,” in *Proc. Audio Engineering Society 26th Conf., Audio Forensics in the Digital Age*, Denver, CO, July 2005, pp. 65–77.
- *AES Recommended Practice for Forensic Purposes—Managing Recorded Audio Materials Intended for Examination*, AES Standard 27-1996.
- Advisory Panel on White House Tapes, *“The Executive Office Building Tape of June 20, 1972: Report on a technical investigation*,” United States District Court for the District of Columbia, May 31, 1974. [Online]. Available: http://www.aes.org/aeshc/docs/forensic.audio/watergate.tapes.report.pdf
- National Academy of Sciences, “*Report of the Committee on Ballistic Acoustics*,” Washington, D.C.:National Academy Press, 1982. [Online]. Available:http://www.nap.edu/catalog.php?record_id=10264
- G. Byrne, *Flight 427: Anatomy of an Air Disaster*. New York: Springer-Verlag, 2002.
- J. S. Sachs. (2003, Mar.). Graphing the voice of terror. Popular Sci., pp. 38–43 [Online]. Available: http://www.popsci.com/scitech/article/2003-02/graphingvoice-terror

- Scientific Working Group on Digital Evidence. (2008, Jan. 31). *SWGDE Best Practices for Forensic Audio*, Version 1.0 [Online]. Available: http://www.swgde.org/documents/swgde2008/SWGDEBestPracticesforForensicAudioV1.0.pdf
- D.R. Begault, B.M. Brustad, and A.M. Stanley, "Tape analysis and authentication using multi-track recorders," in *Proc. Audio Eng. Soc. 26th Conf., Audio Forensics in the Digital Age*, Denver, CO, July 2005, pp. 115–121.
- C. Grigoras, "Digital audio recording analysis: The electric network frequency (ENF) criterion," *Int. J. Speech Language Law*, vol. 12, no. 1, pp. 63–76, 2005.

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛ
SOME HISTORICAL ISSUES OF FORENSIC SCIENCE

Э.Батбаяр*
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах судлаач, цагдаагийн дэд хурандаа
Batbayar E.
Police lieutenant colonel, Senior Researcher, Research Institute, University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: Batbayar9871@gmail.com

Хураангуй: Дэлхийн болон Монгол Улсын шүүх шинжилгээ Шинжлэн магадлахуйн байгууллагуудын үүслийн баримт, шүүх шинжилгээний үйл ажиллагааг хэрхэн зохицуулж ирсэн түүхэн уламжлалыг судлан түүхэн баримтуудын хүрээнд шинэ мэдлэг, мэдээллийг гарган тавихыг зорьсон болно.

Abstract: The aim is to present new knowledge and information within the framework of historical documents by studying the origins of forensic science institutions in the world and Mongolia, and the historical traditions that have governed forensic science activities.

Түлхүүр үг: шүүх шинжилгээ, түүх, эрх зүй, үүсэл хөгжил.
Keyword: Forensic science, history, law, origin and development.

Шинжлэх ухааны мэдлэг жил ирэх тусам тасралтгүй өсөн нэмэгдэж хуримтлагдсаар байна. Шинжлэх ухааны сэтгэлгээ ердийнхөөгөөс тусгай руу чиглэн нарийвчилж, шинээр бий болж байгаа үзэл баримтлал, болон уламжлалдаа тулгуурлан урагшилж байна.

Шинжлэн магадлахуйн мэдлэг Монгол Улсад хэрхэн үүсэж, хөгжсөн нь одоог хүртэл эрдэмтэн, судлаачдын сонирхлыг татсаар байна. Гадаадын зарим орны эрдэмтэн, судлаачид өөрийн орны шинжлэн магадлах ухааны өв, туршлагын судлан ном зохиол, эрдэм шинжилгээний ажил бичсээр байна.

Криминалистикийн болон шинжлэн магадлахуйн эрдэмтэн, судлаачид өөрсдийн бүтээлийн сэдвийн хүрээнд түүх, шинэчлэлийн талаар тусгасан байдаг.

С.Бадарчи багшийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгай мэдлэгийг 1922-1982 оны хооронд ашиглаж байсан түүхэн эх сурвалжуудыг нээн гаргасан нь шинжлэн магадлахуйн түүхийн анхдагч үнэт бүтээл болдог.

Нэг сэдэвт бүтээлийн хувьд Криминалистикийн албаны 60 жилийн ойг тохиолдуулан бүтээсэн Ч.Алтанхишиг хурандаагийн “Нэгэн жаран”, Криминалистикийн албаны 70 жилийн ойг тохиолдуулан бүтээсэн Т.Очирбатын “Шинжлэн магадлахуй” бүтээл нь шинжлэн магадлах ухааны түүхийн чухал эх сурвалж юм. Уг бүтээлээс гадна шинжлэн магадлахуйн түүхийн зарим асуудлыг С.Бадарчи, Б.Жаргалсайхан, Т.Очирбат, Б.Лхагвасүрэн нарын эрдэмтэд эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, нийтлүүлсэн байдаг.

Шинжлэн магадлахуйн байгууллагын үүслийн хүрээнд:

Гадаад улс орнууд:

Америкийн нэгдсэн улсын Шүүх шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч асан Douglas H. Ubelaker-ийн эмхэтгэсэн “The Global Practice of Forensic Science” номонд 5 тивийн 58 орны шүүх шинжилгээний байгууллагын тухай мэдээллүүдийг багтаасан байна. Энэхүү номыг эх сурвалж болгон ашиглахад:

1. АНУ-ын Шүүх шинжилгээний практик

АНУ-д анх 1923 онд Калифорниа мужийн Лос Анжелес хотод, 1929 онд Чикаго хотод гэмт хэргийн лаборатори үүсэн бий болсон.

1930-аад оны үед болон “Хэрэг хүлээлгэх замаар хэрэг хүлээлгэх харгис хэрцгий арга” ашиглах нь түгээмэл байсан бол 1960-аад онд АНУ-ын Дээд шүүх шийдвэр гаргахдаа “304 28-р бүлэг Миранда, Эскобедо нарын зарчимыг баримтлах болсон. Ингэснээр “Албадан хэргээ хүлээхэд” бага, "шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох баримт" нотлох баримтад илүү их найдах болсон. Юрген

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Торвальдын Криминалистикийн зуун (1965) ба “Гэмт хэрэг ба шинжлэх ухаан” (1967) номууд ихээхэн нөлөө үзүүлсэн.

Америкийн Шүүх Шинжлэх Ухааны Академи (AAFS) тухайн салбарыг дэмжих зорилгоор 1948 онд байгуулагджээ.

2. Солонгосын Шүүх шинжилгээ

Гүрёо гүрэн (918-1392)-ий үед шүүх эмнэлгийн мэдлэгийг Хятадаас авч хэрэглэж байсан.

1948 онд шүүх эмнэлэг, шүүх-хими, гарын мөр судлал гэсэн гурван том салбар Цагдаагийн байгууллагад шинжлэх ухааны судалгаа хийхэд туслах зорилгоор зохион байгуулагджээ.

3.Хятад улс нь Цинь (мөн Чин) гүрний (МЭӨ 221-207) эсвэл түүнээс ч өмнөх үеийн шүүх эмнэлгийн урт бөгөөд баялаг түүхтэй гэж түүхээ дурджээ.

4. Японы Шүүх шинжилгээ.

Шүүх эмнэлгийн задлан шинжилгээг анхдагч гэж үздэг. Эдогийн үе буюу XVII-XIX зуунд хамаардаг.

5**. Өмнөд Африк.**

Европын нөлөөнд оршиж байсан улс. Англи, Голланд колоничлолд 1652 онд орсон. Сүүлийн 100 жилд Эмнэлгийн эмч нар задлан шинжилгээ хийж байжээ.

6. **Туркийн Шүүх шинжилгээ.**

Анхны албан ёсны бүртгэл Османы эзэнт гүрний үед 1768 оны эхэн үед шүүх эмнэлгийн шинжилгээ хийснээр бүртгэгджээ.

7. **Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллага**

1922 онд байгуулагдсан судар бичгийн хүрээлэнд 1926 оноос эрдэм шинжилгээний гэрэл зураг үүссэн байна. Монгол Улсын 18 /1928 оны 4.10-ны өдөр ДХГ-аас гаргасан 49 тоот тушаалын 1 дүгээр зүйлд тус газрын нууц хэлтсийн мэдээ хураах тасгийн зураг авагч нэгэн орны албан хэргийг мөн тасгийн боловсронгуй төлөөлөгч Басини дор энэ 4 дүгээр сарын 1-нээс эхлэн хавсарган эрхлүүлснээс гадна төлөөлөгч Цэндсүрэнг эл зураг авах явдал дор танилцуулан боловсруулбаас зохих учир албаны чөлөөг үзэж зааварлуулах буюу мөн Басинаас уг зүйлийг сайтар зааварлан гүйцэтгэж байвал зохино. гэж заажээ.

Тэрчлэн өөр нэг тушаалд ... төлөөлөгч Басины хавсарч буй зураг авах нэгэн орон дор Өлзий учралын биеийг томилон авч энэ өдрөөс эхлэн албан хаалгасан болох тул төлөөлөгч Басинаас эрхэлж бүхий зураг авах аппарат ба мөн түүний элдэв хэрэгслэлийн зүйлүүдийг цөм бүрэн тоо ёсоор тусгай акт үйлдэх зэргээр шилжүүлэн өгөх ба Өлзийучралын бие үйлдсэн актын ёсоор авч албан хаасугай гэж дурджээ.

Эрх зүйн эх сурвалжийн хүрээнд:

Урьд өмнө нь эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд орж байгаагүй Архивын ерөнхий газрын Сургалт, судалгааны газрын эрдэм шинжилгээний ажилтан Г.Сэр-Одын уйгаржин монгол бичгээс крилл үсэгт хөрвүүлсэн XVIII зууны хууль цаазын түүхэнд холбогдох 58 хуудастай “Хэргийн учрын тогтоол. Чингисийн хууль дүрэм” (хөмрөг, 2021)

- 9 дэх хуудаст “...илэрхий тэмдэг, гэрчтэй болбоос явуул. Эд олсонгүй ёсоор шүүж оноо...”,
- 10 дахь хуудаст “...Нэгэн зүйл. Аливаа гэгээн өдөр уулгалан булаахад хүмүүн албаас цавчин алах ял оноож, даруй алагтун. Дэд болж туслан жанчиж, ирт юмаар хорлох жич, гараар нудрах, хөлөөх өшиглөх, аливаа юмаар хугарсан, хэмхэрсэн шархаас дээш шарх олох болбоос цөм хөвчдөн алах ял оноож, гянданд хорь хүлээе..”
- 19 дэх талд “...Нэгэн зүйл. Аливаа хор эмээр хулгана, гөрөөсийг эмлэн алахуйд эндүүгээр хүмүүнийг алсан хэрэг...” гэх мэт нэр томьёо ойлголтуудыг тусгасан байна. /Юань улсын судар Нэгдүгээр боть/

Дээрхээс гадна Монгол Улсад учралын газрын үзлэг хийх, эрж хайх үйл ажиллагаа явуулахад тусгай мэдлэг ашиглах талаар анхны зохицуулалтууд “Халх журам”, “Монгол-Ойрадын цааз” зэрэг хууль цаазын дургал бичигт тусгагдаж байжээ. (Ц.Гантулга, 2009, хууд. 16)

Монгол Улсын эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны практикт криминалистикийн тусгай мэдлэг хэрэглэх зүйл заалт 1926 оны “Монгол Улсын шүүн таслах газраас аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль”-ийн 18 дугаар зүйлд “...экспертийн гэх хэргээс учрыг шинжлэн

мэдэх хүмүүсээс гуйх” хэмээн анхлан тусгажээ. (ХЗҮХ, 2012)

Үүнээс хойш 6 удаа эрүүгийн процессын хууль шинэчлэн батлагдан хэрэгжсэн. Үүнд:

1. 1929 онд “Аливаа хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хууль”;
2. 1935 онд “Аливаа хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хууль”;
3. 1949 онд “Бүгд найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль”;
4. 1963 онд “Бүгд найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль”;
5. 2002 онд “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль”;
6. 2017 онд “Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль”.

Монгол Улсын 17 /1927/ 5 дугаар сарын 6-нд БНМАУ-ын Засгийн газраа олон гишүүд хуралдаж зөвлөлдөн тогтоосон 17 дугаартай тогтоолоор батлагдсан “Ардын Шүүх таслах газруудын байцаагч түшмэдийн түр дагаж явах дүрэм”-ийн агуулгаар мөрдөн байцаагчдад криминалистикийн доорх зөвлөмжийг өгчээ. Үүнд:

а/. Бага сага хэрэгт ч тогтоол үйлдэх

б/. Уг тогтоолд хэргийн учрыг тодорхойлох, хэзээ хаана болсныг бичих

в/. Тогтоолд мөрдөн байцаагч, холбогдогч, гэрч тус тус гарын үсэг зурах

г/. Хэргийн учир шалтгааныг хэрэгтэн өөрөө протоколын ард бичиж болох

д/. Хэрэгтэн бичиг мэдэхгүй бол байцаагч нөхөн бичих

е/. Хэргийн холбогдол бүхий орон байрыг мөрдөн байцаагч онгойлгох эрхтэй, тэгэхдээ гэрийн эзэн ба гэрчийг байлцуулах

ж/. Хураан авсан зүйлийг нэр, тоогоор тэмдэглэн бүртгэх

з/. Хураан авсан эд юмны бүртгэлийг 2% хийж нэгийг эзэнд нь үлдээх

и/. Хэргийн газарт биеэр очиж үзлэг явуулах

к/. Нолох баримтыг илрүүлж, бэхжүүлэх

л/. Мөрийг хүний, малын, тэрэг чарганы гэхчилэнгээр ангилах

м/. Мөрөнд байх ерөнхий ба хувийн онцлог шинж тэмдгийг олох

н/. Мөр бүрийг нарийвчлан шинжлэх, хэмжилт хийх

о/. Сэжиг бүхий зүйлийг илрүүлэх, мөр бүхий зүйлийг эрж сурвалжлах

п/. Эдгээрийг хууль зүйн үүднээс протоколд зөв тодорхой бэхжүүлэх

р/. Зайлшгүй тохиолдолд шинжилгээ томилох гэх мэт

Мөн эрүүгийн процессын хуульд 1994 болон 2007 онд томоохон нэмэлт, өөрчлөлтүүд хийгдэж байсан.

1926-2002 оны хуулиуд шинжээч эрх, үүрэг, шинжээч ба хэргийн газрын үзлэгийн мэргэжилтний хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон нотлох баримтын тухай ойлголтуудыг тусгасан байдаг.

2017 оноос эхлэн мөрдөгдөж буй эрүүгийн процессын тухай хуульд мөрдөн байцаах тодорхой ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах, шинжилгээ томилж дүгнэлт гаргуулахаас гадна тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч ул мөр, эд мөрийн баримт, хэргийн бусад материалд анхан шатны үзлэг, оношилгоо хийж магадлагаа гаргахаар заасан нь онцлог зохицуулалт болсон. (Т.Очирбат, 2019, хууд. 158)

Монгол Улсын шүүхийн шинжилгээний тухай бие даасан хууль 2009 онд батлагдсан. Энэ хуулиас өмнө шүүх шинжилгээний үйл ажиллагааны зорилт, зарчим, шатлал, журам, шүүх шинжилгээний төрийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, түүний эрх болон үүрэг, үйл ажиллагааны чиглэл, шинжээч, мэргэжилтний эрх зүйн байдал зэргийг нарийвчлан зохицуулаагүй байсан гэж үзэж болно.

Манай Улсын хувьд шинжлэн магадлах байгууллага, үйл ажиллагааны тухай бие даасан хууль 2009 онд батлагдан батлагдаж, мөрдөгдөж эхлэхээс өмнө шинжилгээ хийх, хийлгүүлэхтэй холбогдсон процессын харилцааг эрүү, иргэн, захиргааны процессын хууль тогтоомжид заасан журмаар зохицуулж ирсэн.

Шүүх шинжилгээний үйл ажиллагааны эрх зүйн байдлыг хуульчлан тогтоох зайлшгүй шаардлага үүссэн бөгөөд, цаг

үеийн шаардлагаар Монгол Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар 6 бүлэг, 45 зүйл, 88 заалттай “Шүүхийн шинжилгээний тухай” Монгол Улсын хуулийг (хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл №2, 2010) баталсан байна. Уг хууль хэрэгжиж эхэлснээр Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний болон Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудийн шинжлэн магадлах үйл ажиллагаатай холбоотой зохих заалтууд илүү тодорхой болжээ.

Уг анхны хуулиар Шүүх шинжилгээний байгууллагын чиг үүрэг, тогтолцоо, аливаа хэрэг, маргаанд шинжилгээ хийх нийтлэг журам, зарим онцлог шинжилгээ хийх тухай дэлгэрэнгүй зохицуулалт болон мэргэжилтэн, шинжээчдийн эрх зүйн байдалтай холбоотой зохицуулалтыг бий болгосон.

Монгол Улсад шинжлэн магадлах үйл ажиллагаа явуулж, дүгнэлт гаргахтай холбогдсон процессын эрх зүйн харилцааг хуулиар зохицуулан, бие даасан хуулийг батлуулж, нэвтрүүлсэн үйл явдал нь Монгол Улсын эрх зүйн шинэтгэл болон шинжлэх ухааны тусгай мэдлэгийн салбарыг хөгжүүлэхэд өндөр хувь нэмэр оруулсан.

Монгол Улс дахь “Эрх зүйн шинэтгэлийн хүрээ”-нд шүүхийн шинжилгээний эрх зүйн байдлыг цаашид сайжруулах шаардлага бий болсон. Тус хуулийг дагаж мөрдсөн 10 гаруй жилийн хугацаанд 6 удаа, давхардсан тоогоор 47 удаа хуулийн зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орсон нь судалгаагаар тогтоогдож байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийг 2022 онд шинэчлэн боловсруулан батлуулсан.

Уг 2022 онд шинэчлэн батлагдсан 11 бүлэг, 81 зүйл, 682 заалттай Шүүх шинжилгээний тухай хуулийн (хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл №5, 2023)онцлог зохицуулалтыг дараахь байдлаар багцалж болно. Үүнд:

1. Хуулийн нэр томьёо, шинжлэн магадлахуйн хэл судлалд анхааран хууль зүйн салбарын байгууллагын болон үйл ажиллагааны тухай хуулиудад тодорхой нэр томьёог өөр өөрөөр тодорхойлогдсоныг нэг ойлголтоор жигдрүүлсэн.

2. Шүүх шинжилгээний журмуудыг хуультай холбогдуулан Монгол Улсад анх удаа шинжилгээний хугацааг жишиг хугацааг тогтоосон баримт бичгийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан.

3. Шүүх шинжилгээний байгууллагын нэгдсэн болон төрөлжсөн сан бүрдүүлэх, ашиглах, шинэ төрлийн шинжилгээний эрх зүйн орчинг шинээр бий болгосон.

4. Хөрөнгийн үнэлгээнд шинжилгээ хийх боломж, гэмт хэрэгт өртсөн этгээдийн сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, сэтгэцэд нь учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох асуудлыг уг хуулиар анх удаа бүрдүүлсэн.

5. Мөн анх удаа гэм буруутай этгээдээс хүрээлэн буй орчинд учирсан хохирлыг тогтоох зохицуулалт нэмсэн.

6. Шинээр батлагдсан хуулинд шүүх шинжилгээний байгууллагаар шинжилгээ хийлгэх, болон гадуур шинжилгээ хийлгэх тухай хуульчилж, гадуур шинжилгээ хийх эрх бүхий этгээдүүдэд гэрчилгээ олгох, олгосон эрхийг хасахтай холбоотой зохицуулалтыг анх удаа тусгасан.

7. Шүүхийн шинжилгээ гэсэн нэр томьёог шүүх шинжилгээ болгон өөрчилсөн.

8. Эрх бүхий этгээдээс ирүүлсэн шинжилгээ хийлгэх тогтоолын дагуу шинжээчид шинжилгээг хийлгэхээр даалгахдаа шинжээчийг санамсаргүй тохиолдлоор хуваарилах программ хангамж ашиглан хуваарилах зохицуулалт нэмсэн.

Дүгнэлт

Шинжлэн магадлахуй нь эртний Грек, Ром, Египит, Хятад, Вавилоноос эхтэй. Дэлхийн улс орнууд өөр өөрийн түүхийг судлан баримттай эх сурвалжуудыг судлан түүхээ урагшлуулсаар байна. Монгол Улс 2200-аад жилийн төр ёсны арвин их түүхтэй билээ. Тиймээс хууль цаазын олон арван баримт буй дамжиггүй юм. Энэхүү илтгэлийн хүрээнд дэлхийн зарим улс орнууд шинжлэн магадлахуйн түүхийн эхлэлээ хэзээнээс гэж тоолдог талаар өгүүлэлд тусгасан. Манай улсын түүхэн эх

сурвалжийн хүрээнд Их Монгол Улс, Манж Чин гүрний үеийн түүхийн эрх зүйн сурвалжууд хөндсөн болно.

Монгол Улс шинжлэн магадлахуйн байгууллагын түүхээ 1934 оноос эхлэлтэй гэж үзэн 82 жил хэмээн тоолж байна. Харин түүх эх сурвалжуудад тухайлбал "Хэргийн учрын тогтоол. Чингисийн хууль дүрэмд шинжлэн магадлах үйл ажиллагаа тусгагдаж байсан байна. Хууль тогтоомжийн хувьд Эрүүгийн процессын хуулиудаас уг үйл ажиллагаа зохицуулагдаж ирсэн ба 2009 оноос бие даасан хуультай болж, 2022 онд шинэчлэн найруулсан хуулиар шинжлэн магадлах үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

Санал

Дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсад шинжлэн магадлах ухаан хэрхэн үүсэж, хөгжсөн талаар нарийвчлан судлах;
2. Шинжлэн магадлахуйн түүх судлалыг хөгжүүлэх;
3. Шүүх шинжилгээний тухай хуулийг байгууллагын болон үйл ажиллагааны гэсэн 2 тусдаа бие даасан хуультай болгон хөгжүүлэх нь зүйтэй гэдэг санал гаргаж байна;
4. Шүүх шинжилгээний процессын эрх зүйг хөгжүүлэх.

Ашигласан номын жагсаалт

Б.Бат-Эрдэнэ. (2009). *Статус специалиста и эксперта в судопроизводстве Монголии. Дисс. ...канд.юрид.наук.М.,.* Улаанбаатар хот.

Н.Сүхбаатар. (2015). *Юан улсын судар.* Улаабаатар хот.

С.Нарангэрэл. (2015). *Монголын эрх зүйн эх толь бичиг.* Улаанбаатар хот.

Т.Очирбат. (2019). *Шинжлэн магадлахуйн онол, эрх зүй зохион байгуулалтын асуудал* . Улаанбаатар.

хавсралт, М. У. (2020). *Төрийн мэдээлэлийн эмхтгэл №25.* Улаанбаатар хот.

ХЗҮХ. (2012). *Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал.* Улаанбаатар хот.

хөмрөг, Ү. т. (2021). *Хууль цаазын бичгийн цуглуулга /ХМ-182/-ын 3 дугаар данс Чингисийн дүрэм Хэргийн учрын тогтоол* . Улаанбаатар хот.

хууль, Ш. ш. (2010). *Төрийн мэдээлэл эмхтгэл №2.* Улаанбаатар хот.

хууль, Ш. ш. (2023). *Төрийн мэдээлэл эмхтгэл №5.* Улаанбаатар хот.

Ц.Гантулга. (2009). *Доказательственное значение следов в раскрытии преступлений (на примере следов животных).Дисс. ...канд.юрид.наук.* Улаанбаатар.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛЖ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES TO BE CONSIDERED WHEN ISSUING APPLICATIONS FROM NON-GOVERNMENTAL ORGANIZATIONS REPRESENTING THE PUBLIC INTEREST TO ADMINISTRATIVE COURTS

М.Эрдэнэбаяр*
Олон улсын Улаанбаатарын их сургууль, доктор (Ph.D), дэд профессор
Erdenebayar M.
Ph.D., Associate Professor, International Ulaanbaatar University
М.Болормаа
Хууль зүйн магистр
Bolormaa M.
Master of Laws, Senior Lecturer

*Хариуцлагатай зохиогч: erdenebayar.m@ulaanbaatar.edu.mn

Хураангуй:Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн төрийн бус байгууллагаас гаргасан нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэж байгаа практикийг судлан дүн шинжилгээ хийж цаашид анхаарах асуудлыг тодорхойлохыг зорив.

Abstract: The aim is to study and analyze the practice of resolving claims filed by non-governmental organizations representing the public interest in administrative courts and to identify issues for further consideration.

Түлхүүр үг: Байгаль орчин, нийтийн ашиг сонирхол, төрийн бус байгууллага
Keywords: Environment, public interest, non-governmental organizations

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд 2010 онд нэмэлт өөрчлөлт оруулснаар байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий ТББ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулаадахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болсон юм. Иймхүү ТББ-ууд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэх эрхтэй болохыг анх удаа хуульчлан баталгаажуулсан нь 2016 оноос өмнө нийтийн ашиг сонирхол, тэр дундаа байгаль орчны хохирлыг нэхэмжлэх чиглэлээрх төрийн бус байгууллагуудын нэхэмжлэлийн цорын ганц гэж хэлж болох үндэслэл болж байна.

Дэлхий дахинд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн хоёр хэлбэр байдаг. Үүнд: (1) Нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаарддаг болон (2) уг зөрчлийг шаарддаггүй тогтолцоо багтана. Монгол Улсын хувьд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дугаар заалт нь нэхэмжлэгч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын зөрчлийг сэргээлгэх шаардлагыг тодорхойлохгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхлын хүрээнд нэхэмжлэл гаргахыг зөвшөөрсөн зохицуулалт юм.

Энэ төрлийн зохицуулалт нь өөрийн давуу болон сул талыг агуулдаг. Эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, иргэний нийгмийг чадавхжуулах болон нийтийн Хяналтын тогтолцоог хөгжүүлэхэд энэ төрлийн зохицуулалт эерэг Үр дүнтэй. Харин нийтийн ашиг сонирхол нэрийн дор түүний эсрэг нэхэмжлэл гаргах, улс төрийн болон бусад явцуу ашиг сонирхлоор ашиглавал ардчилал, эрх мэдэл харилцан хяналт-тэнцэлтэй байх. шүүхийн хараат бус, бие даасан байдалд зарим талаар сөрөг үр дагаврыг үүсгэж болзошгүй байдаг (Бадамцэцэг.Д, 2020).

Судалгаанд хамрагдсан дараах тохиолдлуудад нэхэмжлэгч ТББ нь нэхэмжлэл гаргах эрхтэй болохоо Байгаль

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

орчныг хамгаалах тухай хуулийн дээрх заалтыг үндэслэн тодорхойлсон байх ба шүүх 4 мөн уг заалтыг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгтэй хамт давхар баримталж шийдвэрлэсэн байна.

Нийтийн ашиг сонирхлын хүрээнд шийдвэрлэсэн шийдвэрүүдээс эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд хамаарах онцлогийг нь харгалзан дараах шийдвэрүүдийг (Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, 2026) судлан үзэв. Үүнд:

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2017.09.04. Дугаар 653.

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин.

Нэхэмжлэлийн шаардлага: ТББ-аас Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Бөөрөлжүүтийн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, байгаль орчинд учирсан хохирлыг тооцон гаргаж олон нийтэд мэдээлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд даалгах. Хариуцагчийн зүгээс нэхэмжлэгч нь хариуцагчийг буруу тодорхойлсон гэжээ.

Анхан шатны шүүх: Нэхэмжлэгч нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нь нийтэд илэрхий гэж төлөөлөх эрхийг дүгнээд холбогдох хуулийн дагуу хариуцагчид мэдээллийг нийтэд хүргэх үүрэгтэй гээд нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүх: Анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй гэж үзсэн.

Хяналтын шатны шүүх: Хариуцагчийг зөв тодорхойлоогүй байхад нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдсэн нь буруу хэмээгээд анхан шатны шүүхэд дахин хянуулахаар буцаасан.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн $106.1, 106.3.14

ЗХШХШТХ мөрдөгдөж эхэлснээс 20 орчим хоногийн дараа гарсан шүүхийн нэгэн шийдвэрт нэхэмжлэгч "Д" ТББ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1-ийг үндэслэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхтэй болохоо тайлбарласан байна. Энэ тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах нэхэмжлэлийн шаардлага гаргасан нь "байгаль орчны хохирлыг нэхэмжлэх" гэсэн тус заалтын агуулгад хамаарахгүй байв. Гэвч шүүх нийтийн ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх ямар үндэслэлээр үүсэж байгааг тайлбарлалгүй хэргийг шийдвэрлэжээ. Түүнчлэн шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт "хууль болон нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн нь тогтоогдохгүй байх тул түүнийг хүчингүй болгох үндэслэлгүй гэж шүүх дүгнэв" гэсэн нь нийтийн ашиг сонирхлын маргаанд субьектив эрх зөрчигдсөн байхыг шаардаж, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32.1.1 болон ЗХШХШТХ-ийн 18.3 дахь хэсгийн аль алинд заагаагүй шаардлага тавьжээ. Эсхүл шүүх нэхэмжлэгчийн эрх гэдгийг энэ маргааны тухайд хэрхэн ойлгож байгаагаа тайлбарлах шаардлагатай. Нэхэмжлэлийг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг дагаж мөрдөгдөхөөс өмнө гаргасан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль хэрэгжиж эхэлсний дараа явагджээ. Гэтэл шүүх уг хэргийг шийдвэрлэхдээ нэхэмжлэх эрхийг дээрх заалттай холбон тайлбарлаагүй байна. Шүүх энэ асуудалд дүгнэлт хийгээгүй учир ТББ нь ЗХШХШТХ-ийн 18.3-т заасан шаардлагыг хангаагүй боловч Байгаль орчныг хамгаалах хуулийн 32 дугаар зүйл заалтыг баримтлан нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар захиргааны хэргийн шүүхэд хандах боломжтой гэсэн ойлголттой болж байгаа юм.

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2016.07.22. Дугаар 539.

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин.

Нэхэмжлэлийн шаардлага: Онон голын сав газар, ойн сан бүхий газарт "Г" ХХК-нд 779 га талбай бүхий ашигт малтмал олборлох тоот тусгай зөвшөөрлийг Уул уурхайн яам Ашигт малтмалын газраас 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдөр олгожээ. Тусгай зөвшөөрлийг олгохдоо Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх ашиглахыг

хориглох тухай хууль зөрчсөн тул тусгай зөвшөөрлийг цуцалж өгнө үү.

Анхан шатны шүүх: Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэр нь хууль зөрчөөгүй байна гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Нийтийн ашиг сонирхлын талаар тусгайлан дүгнэлт хийгээгүй.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн $106.1, 106.3, 106.3,

1. Төрийн бус байгууллагын эрх зүйн чадамж, нэхэмжлэлийн шаардлагын тухай

- Хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан шаардлагыг бүрэн хангах ТББ байгууллага цөөн байна. Энэ нь нэг талаар ТББ-ын чадавх, хариуцлагатай холбоотой байж болох авч нөгөө талаар шүүхээс хуулийн шаардлагыг нэг мөр хэрэглэдэггүй практик нөхцөл байдлаас шалтгаалж байна. Шүүх нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэлийг Хүлээн авч шийдвэрлэхэд нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн эсэхэд нэн тэргүүнд анхаарал хандуулах бус хэн нэхэмжлэл гаргасан, тэр нь хуулийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд голлон анхаарч, шаардлага хангаагүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг буцаах, хүлээн авахаас татгалзахыг урьтал болгож байгаа байдал нийтлэг байна. Хамгийн гол нь ийнхүү нэхэмжлэгчид тавьж буй шаардлага нь харилцан адилгүй байх тул хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн ойлголт, хэрэглээг нэг мөр болгоход анхаарах шаардлагатай байгаа нь судалгаагаар харагдлаа.

- Нэхэмжлэлийн шаардлагатай танилцахад хүрээлэн буй орчныг хамгаалах агуулга бүхий нэхэмжлэл дийлэнх хувийг эзэлж байгаа ба эдгээр нь ерөнхийдөө ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох буюу захиргааны актыг хүчингүй болгоход түгээмэл чиглэсэн байна. Харин байгаль орчны бусад салбар асуудлыг хөндсөн, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээхийг зорьсон агуулга бүхий шаардлага цөөн байна. Нийтийн ашиг сонирхол бол Зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлахаар хязгаарлагдахгүй өргөн хүрээтэй асуудал гэдгийг анхаарах нь зүйтэй. Түүнчлэн нийтийн өмч, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэндийн асуудлаар гаргасан нэхэмжлэл маш цөөн байна.

- Хариуцагчийг буруу тодорхойлсон үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдол цөөнгүй байна. Энэ нь ТББ-ын чадавхтай шууд холбоотой гэхээс илүү захиргааны шүүх нь хариуцагчийг солих, жинхэнэ хариуцагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулах зэрэг хуулиар хүлээсэн эрх, үүргээ хангалттай хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой юм.

- Нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд болохоо бүрэн нотлох баримтыг шүүхэд ирүүлээгүй, нэхэмжлэлд гарын үсгийг буруу этгээдээр зуруулсан, итгэмжлэл нь хуульд нийцээгүй зэрэг шалтгаанаар нэхэмжлэл буцаагдсан тохиолдлууд цөөнгүй байгаа нь нэхэмжлэл гаргах бэлтгэл, хууль зүйн боловсрол хангалттай бус байгаагийн илрэл мөн.

- Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох хийгээд буцаасан захирамж, түүнчлэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн гол үндэслэлд нэхэмжлэгч ТББ нь ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэл нийтлэг байна.

2. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээний тухайд

А. Хууль хэрэглээний тухайд

ЗХШХШтХ-ийн 18.3.1, 18.3.2-т заасан шалгуурыг нэхэмжлэл гаргах үед болон нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэсэн хэргийн хувьд харилцан адилгүй байдлаар хэрэглэсэн байна. Тодруулбал, шүүхээс захиргааны хэрэг үүсгэхдээ хуулийн §18.3.1, 18.3.2 дахь заалтыг нэг мөр, зөв мөрдөж хэрэглэсэн гэж үзэхээргүй байна. Энэ нь эцэстээ хуулийн үндсэн үзэл баримтлалыг гажуудуулах, ТББ-ууд нийтийн ашиг сонирхлыг шүүхийн журмаар хамгаалах үйл явцад саад учруулах, улмаар цаашдын хөгжилд сөрөг нөлөөтэй байж болохыг дурдах нь зүйтэй.

Зарим шүүхийн шийдвэрт ТББ нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргах "болзол" хангасан талаар

дүгнэсэн байхад, дийлэнх шийдвэрт энэ талаар огт дүгнэлт хийгээгүй байна. Түүнчлэн хариуцагч, гуравдагч этгээдийн хувьд ч энэхүү асуудлаар тэр болгон бие даасан сонирхол илэрхийлж, мэтгэлцдэггүй байна. Иймд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нэхэмжлэгчид тавигдах шаардлага нь нэхэмжлэлд тавигдах нийтлэг шаардлагаас онцлог тул шүүхээс нэхэмжлэлийн шаардлага, нэхэмжлэгчдийн эрх зүйн байдалд бүрэн дүүрэн, зөв дүгнэлт өгч байх нь зүйтэй.

- Нэхэмжлэлийн шаардлагыг хангасан шүүхийн шийдвэртэй танилцахад дийлэнх нь даалгах агуулга бүхий шийдвэр байна. Гэвч шийдвэртээ тодорхой үйлдэл хийхийг даалгах агуулга бүхий 106 дугаар зүйлийн 106.3.4-ийг хэрэглэлгүй зөвхөн 106.3.12,106.3.13-ыг хэрэглэсэн тохиолдол байна. ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.10. (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2026 он) дахь заалт огт хэрэглэгдээгүй бөгөөд энэ нь нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой юм. Шүүх хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь заалтыг нийтийн ашиг сонирхлын маргаанд бүтээлчээр хэрэглэх нь энэ төрлийн хэрэг маргааны хөгжилд тустайн дээр хуулийг нэг мөр ойлгоход чухал ач холбогдолтой.

-Шүүхээс нэг нэхэмжлэлд өөр өөр үндэслэлээр, гэхдээ нэг удаагийн шийдвэрээр бус удаа дараалсан шийдвэрээр нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон захирамж гарган буцаасан, хүлээн авахаас татгалзсан байна. Энэ нь шүүгч өөрийн үзэмжээр хэрэг, маргаанд хандаж байгаа, хууль хэрэглээний соёлгүй байдлыг харуулж байна.

Бүрдүүлбэр хангуулахаар хангуулахаар хугацаа тогтоосон хийгээд буцаасан захирамжид дурдсан шалтгааныг хэрхэн арилгах, хэрхэн хуульд нийцүүлэх талаар тодорхой дурдаагүй нь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд нэхэмжлэх эрх бүхий этгээдэд хүндрэл, чирэгдэл учруулж байна.

-Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамждаа ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.2-т заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахад саад болж буй зөрчлийг тодорхой дурдаж, түүнийг арилгах арга замыг тодорхой заах шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Энэ заалтыг хэрэгжүүлсэн нөхцөлд ТББ, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах бусад этгээдийн чадвар нэмэгдэх, хэтдээ эрх зүйн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх юм.

-Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж буй нэхэмжлэгчээс субъектив эрх буюу өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж байгааг тайлбарлахыг шаардаж байгаа нь үндэслэлгүй юм.

-Зарим шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч нэхэмжлэгчийн шаардлагын хууль зүйн үндэслэлээ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2026) дугаар зүйлийг үндэслэсэн байдаг. Энэ заалтыг хэрэглэж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхүүд буруутгаагүй байна. Түүнчлэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл заалтыг зөвхөн хохирол нөхөн төлүүлэх боломжийн хүрээнд тайлбарлах нь учир дутагдалтай. Тухайлбал, хуулийн 32 дугаар зүйлд "...байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх...", ойн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д “ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэхээр... шүүхэд нэхэмжлэл гаргах" гэж ТББ-д эрх олгосон. Тиймээс ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйл заалтын хүрээнд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд болох шаардлагаа хангаад Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 зүйлд заасан эрхийн хэрэгжилтийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой гэж үзэхээр байна.

-Шүүх хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэхгүй байх, улмаар нэхэмжлэгчид тавих шаардлагыг харилцан адилгүй байдлаар авч үзэх, нийтийн ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж буйд дүгнэлт

хийлгүйгээр хэрэг маргааныг шийдвэрлэсээр байвал хууль тогтоогчоос энэхүү хуулийг хүчингүй болгох, өөрчлөх, эрх зүйн үйлчлэлийг дордуулах эрсдэл байхыг үгүйсгэхгүй.

Б. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлсон байдалд хийсэн дүгнэлт

-Шүүх нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэлийг хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэсэн нөхцөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, талуудын мэтгэлцээн, шүүхийн хэлэлцүүлэг нь ихэвчлэн ердийн хэрэг маргааны нэгэн адил үргэлжилж, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа, эс үйлдэхүй нь хууль зөрчсөн эсэх асуудлын хүрээнд л явагдаж байна. Нийтийн ашиг сонирхол, түүнд эрсдэл учирсан хийгээд учирч болох асуудлаарх нотлох баримт, дүгнэлт дутмаг байгаа нь цаашдаа сөрөг үр дагаврыг үүсгэхээр байна. Жишээлбэл, буседад олгосон тусгай зөвшөөрөл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хуулийн дагуу олгогдсон, журмын дагуу хийгдсэн хэдий боловч байгаль орчин, нийтийн ашиг сонирхолд хор хохиролтой болохыг хангалттай нотолсон бол түүнийг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, захиргааны шийдвэр, үйл ажиллагаа агуулга, хэлбэр, шийдвэр гаргах үйл явцын хувьд хууль зөрчөөгүй байсан ч нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчиж болзошгүй нөхцөлийг үүсгэж байгаа бол хэрхэх нь тодорхойгүй байгаа юм.

-Шүүх шийдвэрээ хэт хангалтгүй бичиж байгаа нь олон талын сөрөг үр дагаврыг үүсгэх эрсдэлтэй. Шүүхийн шийдвэрт захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр нь хууль зөрчсөнөөр нийтийн ашиг сонирхлыг хэрхэн зөрчиж байгаа, тухайн шийдвэрийг Захиргааны ерөнхий хууль болоод бусад хууль тогтоомжийн хүрээнд яагаад хууль бус гэж үзсэн, тухайн хэрэг маргааны тухайд нийтийн ашиг сонирхол гэдгийг хэрхэн ойлгож байгаа, тухайн нэхэмжлэгчийг ямар үндэслэлээр нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд гэж үзсэн, ТББ-ын дүрмийн зорилго нь нэхэмжлэлийн агуулгатай тохирсон эсэх зэрэг асуудлыг шүүхийн шийдвэрт бүрэн дүгнээгүй, зарим шийдвэрийн хувьд бүр огт дурдаагүй байна. Шүүхийн шийдвэрийг зөв арга зүйгээр, ойлгомжтой, хууль хэрэглээний хувьд чанартай бичих нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий нэхэмжлэгч нар цаашид нэхэмжлэлээ илүү сайн боловсруулах, шүүхийн мэтгэлцээнийг илүү өндөр түвшинд өрнүүлэх, хэтдээ нийтийн эрх ашгийн өмгөөллийн хөгжилд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

-Хуулийг нэг мөр хэрэглэх талаар зарим асуудал байгаа боловч хууль хэрэгжиж эхэлснээс хойш энэ төрлийн хэрэг маргааны хувьд тодорхой практик тогтож, ТББ-ууд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, энэ төрлийн өмгөөлөл хөгжиж эхэлж байгаа энэ цаг мөчид шүүхийн чиг үүрэг, оролцоо, гүйцэтгэх үүрэг асар чухал юм.

-Нэхэмжлэгч нь ТББ л бол нэхэмжлэлийн шаардлагатай бүрэн танилцаж ойлголгүйгээр хэрэг үүсгэх эсэхийг шийдэхдээ ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан нөхцөлийг шалгаж хүлээн авахаас татгалзаж байна. Гэтэл нэхэмжлэлийн шаардлага нь ТББ өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүхээр хамгаалуулах зорилготой байсан ба хуулийг зөв ойлгож хэрэглээгүйгээс ТББ-ын бусад асуудлаар шүүхэд хандах эрхийг хязгаарлах эрсдэлтэй.

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үе шаттай холбоотой дүгнэлт

-Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нэхэмжлэл гаргаж буй нэхэмжлэгч нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх зохицуулалттай хэдий ч ТББ-ууд улсын тэмдэгтийн хураамж төлөх үзэгдэл нийтлэг байна.

-ЗХШХШТХ-иар шүүх хэргийг бүх талаас нь бүрэн судлах, хэргийг үнэн зөв шийдвэрлэх, захиргаа-иргэн гэсэн хүч тэнцвэргүй хоёр этгээдийн мэтгэлцэх боломжийг тэгш хангах үүднээс нотлох баримтыг өөрийн санаачилгаар бүрдүүлэх гэх мэт ажиллагаа хийх эрхтэй. Судалгаагаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах маргааны тухайд шүүх өөрийн санаачилгаар ажиллагаа хийсэн тохиолдол нэн цөөн байгаа нь шүүх цаашид нийтийн ашиг сонирхлыг хамгаалах

маргаанд ач холбогдол өгч, бүтээлчээр хандахыг сануулсан хэрэг юм.

-Урьдчилсан хэлэлцүүлгээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй тохиолдол зөвхөн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах маргааны хүрээнд бус бусад маргааны тухайд ч нийтлэг байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ үе шатанд ийнхүү нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй нь хууль зүйн үндэстэй эсэх асуудлыг цаашид нарийвчлан судлах шаардлагатай.

4. Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн тухай

-Захиргааны Хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухайд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах маргааны талаарх ойлголт дутмаг байна. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нэг жилийн хугацаанд үргэлжилсэн байдлаас үзэхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралтай, энэ нь ТББ-аас нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үйл ажиллагаанд төвөгтэй байдлыг үүсгэж байна. Түүнчлэн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн захирамж гарсан байхад түүнийг зөрчиж актыг биелүүлсэн байх ба буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо хангалтгүй байна.

Дүгнэлт:

1. Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан төрийн бус байгууллагатай холбогдох шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ төрийн бус байгууллагын эрх зүйн чадамж, нэхэмжлэлд тавигдах шаардлага, хууль хэрэглэсэн байдал, шүүхээс нийтийн ашиг сонирхлыг хэрхэн тодорхойлсон байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үе шат болон захиргааны шийдвэр гүйцэтгэл гэсэн шалгууруар үнэлж дүгнэлт гаргав.

2. Төрийн бус байгууллагын эрх зүйн чадамж, шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлагыг хангаагүй тухайлбал үйл ажиллагааны дүрэмд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах талаар тусгаагүй, сүүлийн 3 жил тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй гэх мэт шалтгаанаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байгааг анхаарах хэрэгтэй.

3. Нэхэмжлэлийн шаардлага нь гол төлөв байгаль орчныг хамгаалах,тэр тусмаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгохтой холбогдсон байна. Гэтэл Нийтийн ашиг сонирхол бол Зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлахаар хязгаарлагдахгүй өргөн хүрээтэй асуудал гэдгийг анхаарах нь зүйтэй. Түүнчлэн нийтийн өмч, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэндийн асуудлаар гаргасан нэхэмжлэл маш цөөн байна. Иймд төрийн бус байгууллагууд нийтийн ашиг сонирхол гэдгийн агуулгыг тодорхойлох шаардлагатай болов уу.

4. Захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэт удаан (1 ба түүнээс дээш жил) үргэлжилснээр тухайн төрийн бус байгууллагын үйл ажиллагаа цаашид хэвийн явагдах (улсын тэмдэгтийн хураамжийг төрийн бус байгууллага өөрөө төлснөөс санхүүгийн хямрал үүсэх)-д төвөгтэй байдал үүсэж байгаа тул шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шуурхай болгох нь зүйтэй юм.

Ашигласан материал

Нэг. Хууль тогтоомж

1.1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2016 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл 2016. №09.

1.2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1995 №5-6

Хоёр. Судалгааны тайлан

2.1. Д.Баяр, Б.Мөнхзул, Д.Бадамцэцэг “Нээлттэй нийгэм форум. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Шүүхийн практик. Судалгааны тайлан. УБ., 2020 он.

Гурав. Цахим эх сурвалж

3.1. https://legalinfo.mn/mn

3.2. https://shuukh.mn/

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖИЛ ЗҮЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

POLICY AND REGULATORY IMPLEMENTATION FOR METROLOGICAL INSTITUTIONS OF MONGOLIA

Ж.Ариунтунгалаг*
Стандарт, хэмжил зүйн газрын ахлах мэргэжилтэн
Ariuntungalag J.
Senior Specialist of Mongolian Agency for Standard and Metrology

*Хариуцлагатай зохиогч: ariuntungalag@masm.gov.mn

Хураангуй: Тухайн улсын эдийн засаг, шинжлэх ухаан болон технологийн дэд бүтцийн зохион байгуулалтаас үүдэн хэмжил зүйн үйл ажиллагааг төрөл бүрийн салбарын мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх нь олон улсын тогтолцоо, жишиг бөгөөд Хэмжил зүйн төв байгууллагаас салбар хоорондын уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж ажилладаг. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагууд хууль, стандартын шаардлагын дагуу үнэлгээнд хамрагдаж, хэмжил зүйн байгууллагын тогтолцоог бүрдүүлэн, хамтран ажиллах нь байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх, бүс нутгийн болон олон улсын хэмжил зүйн байгууллагуудын үйл ажиллагаа, сургалт, мэдээлэл, хурал уулзалтад салбарыг төлөөлөн оролцох, улмаар Монгол Улсаас олон улсад хүлээн зөвшөөрүүлсэн хэмжлийн чадавхыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Тиймээс энэ судалгаагаар олон улсын жишиг, Монгол Улсын хууль, тогтоомжийн зохицуулалтад шинжилгээ хийж, хэмжил зүйн байгууллагуудын бодлого зохицуулалтыг үнэлж, тодорхойлно.

Эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, хүн, малын эрүүл мэнд, байгаль орчин, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгахад чиглэсэн хэмжил зүйн тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх Хэмжил зүйн хууль тогтоомж, бодлогын зохицуулалт байгаа боловч, бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд зохицуулагч ба хэрэгжүүлэгч талуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг дээшлүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нь бодлого амжилттай хэрэгжих шалтгаан болж байна.

Түлхүүр үгс: Хэмжил зүй, бодлого, томилогдсон байгууллага, мэргэжлийн байгууллага, хамтын ажиллагаа

Abstract: "Due to a country's economic, scientific, and technological infrastructure, it is an international practice for metrology activities to be carried out by professional organizations across various sectors, with the coordinating and managing by central metrology organization. It is of high significance for these professional metrology organizations to undergo evaluations in accordance with legal and standard requirements to establish a national metrology system and foster collaboration, therefore enhances institutional capacity and enables sectoral representation in the activities, training, information exchange, and meetings of regional and international metrology organizations, increasing Mongolia's internationally recognized calibration and measurement capabilities.

Accordingly, this study will analyze international practice and the regulatory framework of Mongolian laws and legislation to evaluate and define the policy implementation for metrology organizations.

Although a legal and policy framework for metrology exists to develop the economy, society, science, and technology—while protecting human and animal health, the environment, and public interests, and reducing technical barriers to trade—the successful implementation of these policies depends on improving coordination and cooperation between regulators and implementers and awareness raising the implementing organizations.

Keywords: Metrology, policy, designated institute, professional organizations, collaboration

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Хэмжил зүй нь хэмжлийн тухай шинжлэх ухаан бөгөөд хэмжлийн эргэлзээ ба хэрэглээний салбараас үл хамааран, хэмжлийн онолын ба практик бүх асуудлыг хамруулан түүний хэрэглээг авч үздэг. Юмс үзэгдэл, биет эсвэл бодисын шинж чанар нь хэмжигдэхүүн болох ба хэмжигдэхүүний утгыг туршилтаар олж авах үйл явц нь хэмжил юм.

Хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжлийн хамт юмс үзэгдэл, биет эсвэл бодисын шинж чанарыг танин мэдэж, туршиж, хэмжиж ирсэн тул цаг хугацаа, орон зай, жин хэмжүүр зэрэг хэмжлийг өдөр тутамдаа ашиглаж байв.

XIII зууны түүхэн баримт бичиг Монголын нууц товчоонд “Их дэлж харвавал есөн зуун алд газар харвадаг” гэж дүрсэлсэн алд гэсэн уртын нэгжийг (Хүндийн нэгж – “жин”, Багтаамжийн нэгж–“суулга”) 1944 он хүртэл албан ёсоор хэрэглэж ирсэн. 1944 онд БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталсан “Хэмжүүр ба хэмжих багаж хэрэглийн тухай хууль”-ийн 1 дүгээр зүйлд “БНМАУ-ын худалдаа, аж үйлдвэрийн зэрэг улс ардын бүхийлэн салаа мөчрүүдэд хэрэглэж байгаа элдэв төрлийн хэмжлэгүүдэд олон улсуудаас хэрэглэж байгаа метрийн системийн хэмжүүрүүдийг хэрэглэнэ. Үүнд: Энэхүү системийн үндсэн нэгжүүдийг тодорхойлбол: Олон улсуудын хэрэглэж байгаа метр (уртын нэгж) мөн улсуудаас хэрэглэж байгаа килограмм (хүндийн нэгж) болно. гэж зааснаар олон улсын SI системийн нэгжүүдийг ашиглаж эхэлсэн байна.

“Хэмжлийн эталон" гэж хэмжлийн нэгж, түүний тодорхой утгыг тогтоох, бий болгох, хадгалах, хуулбарлах, харьцуулах замаар бусад хэмжих хэрэгсэлд дамжуулах зориулалттай хэмжих хэрэгслийг ойлгох ба Монгол Улсын Засгийн газраас 1979-2013 онуудад баталсан 11 хэмжлийн эталон (цаг давтамж, масс, урт, тогтмол хүчдэл, тогтмол эсэргүүцэл, хувьсах хүчдэл, цахилгаан эрчим хүчний чадал, нягт, эзлэхүүн, температур, даралт)-ыг Хэмжил зүйн төв байгууллагын Хэмжил зүйн хүрээлэнд хадгалан нэгж дамжуулалт хангахад ашиглаж байна. Эдгээр 11 улсын эталон болон хэмжил зүйн мэргэжлийн байгууллагуудад байгаа ажлын эталоноос нийт 1,519,293 хэмжих хэрэгсэлд нэгж дамжуулан хэмжлийн үнэн зөв байдлыг хангадаг (СХЗГ, 2025).

Монгол Улсын 2025 оны статистик мэдээгээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 27,1 тэрбум ам долларт хүрсэн (Үндэсний статистикийн хороо, 2025) бөгөөд үүнд жин хэмжил, бүх төрлийн тоолуур, савласан бүтээгдэхүүний тоо хэмжээг ашиглан худалдааны тооцоо, тэнцлийг үнэн зөв гүйцэтгэж байгаа бөгөөд голлох экспортын бараа болох Эрдэс бүтээгдэхүүний экспорт 13,339,358.53 мян ам доллар, Үнэт, хагас үнэт чулуу, метал гоёлын зүйлсийн экспорт 1,252,760.47 мян ам долларын худалдааг өндөр нарийвчлалтай, 0,01 мг унших чадвар бүхий жингээс эхлэн автомашины болон вагон жингийн хэмжлийн үр дүнгээр тооцоо хийж байдаг.

Хэмжил зүйн төв байгууллагаас нэгж дамжуулах боломжгүй хэмжигдэхүүний төрлөөр хэмжлийн улсын эталон бий болгох, баталгаажсан стандартчилсан загвар зохион бүтээх, хадгалах, нэгж дамжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх эсвэл хуулиар зохицуулсан хамрах хүрээнд хэмжил хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, загварын туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэмжил зүйн төв байгууллагаас үнэлж, бүртгэсэн байгууллагыг Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага гэнэ (MNS 7064-2025).

Энэхүү судалгааны ажлаар Хэмжил зүйн үйл ажиллагааны олон улсын жишиг, Монгол Улсад мөрдөж байгаа хууль, журмын зохицуулалтыг судалж, Монгол Улсын хэмжил зүйн байгууллагуудын бодлого зохицуулалтыг үнэлж, бодлогын хэрэгжилтийг судлан дүгнэлт гаргахыг зорилоо. Судалгааны аргад баримт бичгийн шинжилгээ, кэйс болон ярилцлагын арга ашиглав.

Олон улсын тогтолцоо

Хэмжил зүй нь дараах 3 чиглэлд хөгжиж байна.

- Шинжлэх ухааны хэмжил зүй

Олон улсын SI нэгжийг тодорхойлолтын дагуу бий болгох, хамгийн өндөр нарийвчлал болон найдвартай байдлыг хангаж байдаг хэмжлийн эталон ба хэмжлийн арга, шинэ хэмжлийн аргуудыг хөгжүүлэх асуудал энд хамаарна. Шинжлэх ухааны хэмжил зүй нь хууль эрхийн болон үйлдвэрлэлийн хэмжил зүйн суурь болж, нэгж дамжуулалтыг хангадаг.

• Хуулийн зохицуулалттай хэмжил зүй

Төрөөс хамгаалах, зохицуулах шаардлагатай гэж үзсэн ангилалд хуулийн шаардлага болон техникийн зохицуулалтын заалтаар заавал хэрэгжүүлэх хэмжил зүйн үйл ажиллагаа юм.

• Үйлдвэрлэлийн хэмжил зүй

Үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний чанарын хяналтын процесст ашиглагдаж байгаа хэмжлийн үр дүн, хэмжих хэрэгслүүдийн нарийвчлалтай болон нийцтэй байдал, сорилт, туршилтын, хяналтын, шалгалт тохируулгын лабораториудын ажлын эталоны шалгалт тохируулга хамаарна (APLMF-APMP-PTB, 2016).

Аж үйлдвэрлэл ба олон улсын худалдаа, шинжлэх ухааны нээлт ба инновацын хөгжлийг хурдасгахад дэлхий нийтээр харьцуулах боломжтой, нэгдмэл нэгж ашиглах хэрэгцээ шаардлага үүсэж 1875 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 17 улс орон нэгдэж Метрийн Хэлэлцээр байгуулжээ.

Уг хэлэлцээрээр мөн Олон Улсын жин хэмжүүрийн товчоо (BIPM байгууллагыг байгуулж гишүүн улс орнууд хэмжлийн шинжлэх ухаан ба хэмжлийн эталонуудтай холбоотой асуудлаар хамтран ажиллаж байна. BIPM байгууллагын Жин Хэмжүүрийн Ерөнхий Бага хурал (CGPM)-аас 1948 онд олон улсын нэгжийн систем бий болгох шийдвэр гаргаж, 1960 онд олон улсын нэгжийн систем “SI” гэж нэрлэхээр тогтсон бөгөөд SI нэгжүүдийн хэрэглээ, түүнийг зөв ашиглахад чухал лавлагаа баримт бичиг болдог “SI товхимол” хэвлүүлдэг. Мөн SI системийн нэгжийг дамжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг судлан хэлэлцэж, хэмжил зүйн шинэ суурь тодорхойлолтуудыг болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний төрөл бүрийн шийдлүүдийг баталдаг (OIML D 1, 2020).

BIPM нь Хэмжил зүйн Бүс нутгийн Байгууллагууд (RMOs)–аар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг ба Ази-Номхон далайн бүсэд бүс нутгийн хэмжил зүйн байгууллага нь Ази Номхон далайн Хэмжил зүйн Хөтөлбөр (APMP) байна.

“Зөв хэмжлийн үр дүнг гаргах” анхдагч хэрэгсэл нь SI системийн хэмжил зүйн нэгж дамжуулалтыг хангах юм. Хэмжил зүйн нэгж дамжуулалт гэж хэмжлийн үр дүнг олон улсын нэгжийн системтэй холбож, эдгээр үр дүн үндэсний эталонтой хэрхэн таарч байгааг тодорхойлдог үндсэн ойлголт юм.

Үндэсний Хэмжил Зүйн Хүрээлэн (NMI) нь SI нэгжийг анхдагчаар гарган хэрэгжүүлж байгаа үндэсний эталоныг бий болгон, хадгалж, нэгжийг үндэсний хэмжээнд дамжуулж байдаг. Хэмжил зүйн нэгж дамжуулалт нь шалгалт тохируулгын тасралтгүй гинжин хэлхээгээр эталонтой харьцуулан гаргаж авсан хэмжлийн үр дүнгийн шинж чанар байна.

Зураг 1. Хэмжил зүйн нэгж дамжуулалт




(Эх сурвалж: KRISS сургалтын материал)

Хуулийн зохицуулалттай хэмжил зүйн салбарт OIML-ийн Хэлэлцээрээр олон улсын байгууллага (OIML)-ыг үүсгэн байгуулсан бөгөөд хуулийн зохицуулалттай хэмжил зүйн хууль, дүрэм журмыг дэлхийн хэмжээнд уялдуулан нийцүүлэхэд дэмжлэг үзүүлж, гишүүн улс орнуудад үндэсний хууль тогтоомжид хамаарах зөвлөмж өгдөг ба худалдаа болон эрх зүйн зохицуулалтын зорилгоор ашиглах хэмжлийг SI системээс нэгж дамжуулалттай хэмжлийн эталоныг ашиглан гүйцэтгэсэн байх зарчмыг баримталдаг. OIML нь хэмжил зүйн заавар, удирдамж гаргаж, олон улсын худалдаанд дэмжлэг үзүүлэх, харилцан итгэлцлийг бий болгох, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах түвшинг уялдуулах зэргээр харилцан нийцтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн зохицуулалттай хэмжил зүйн үр ашигтай дэд бүтцийг улс орон бүрд бий болгох юм” (OIML B 15, 2011).

OIML нь, Олон улсын Худалдааны Байгууллагын Худалдаан дахь Техникийн Саад тотгор (ТВТ)-ын Хэлэлцээрийн хувьд “олон улсын стандарт-тодорхойлох байгууллага бөгөөд ТВТ Хэлэлцээрт гарын үсэг зурсан бүх улс орнууд Хэлэлцээрийн 2.4-д заасныг хэрэгжүүлэн, техникийн зохицуулалтыг боловсруулах үед OIML-ийн баримт бичгүүд хэрэглэнэ.

Ази-Номхон далайн бүсэд Хуулийн зохицуулалттай Хэмжил зүйн Форум (APLMF) үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2. Шинжлэх ухааны болон Хуулийн зохицуулалттай хэмжил зүйн байгууллагууд, үйл ажиллагааны хамрах хүрээ



Эх сурвалж: National Metrological Infrastructure Joint Guide, 2016-аас

Хэрэглэгч, үйлдвэрлэгч, төрийн эрх бүхий байгууллагууд, аж ахуйн нэгж нь өдөр бүр хэмжлийн үр дүнд үндэслэн хувь хүний сайн сайхан амьдрал болон эдийн засагт нөлөө үзүүлэх шийдвэрүүдийг гаргаж байдаг тул үр ашигтай хэмжил зүйн дэд бүтэцтэй байх нь үнэн зөв, найдвартай хэмжлийн үр дүнг хангахад маш чухал юм.

Улс орон бүр хэмжил зүйн шаардлагыг хөгжүүлэх асуудалд өөрийн гэсэн түүхэн чиг хандлага байдаг боловч Дэлхийн Худалдааны Байгууллага (WTO)-ын хүрээнд хэрэгжүүлж байгаа Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (TBT)-т (WTO Agreement on TBT, 1995) улс орнууд нь үндэсний шаардлагуудыг ижилсгэх зорилгоор өөрсдийн үндэсний техникийн зохицуулалтыг олон улсын баримтжуулсан стандартад үндэслэсэн байх, тохирлын үнэлгээний олон улсын тогтолцоо ба харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт анхаарал хандуулж, тэдгээрт оролцохыг шаарддаг. Монгол Улс энэ хэлэлцээрт 1994 онд нэгдэн оржээ (www.legalinfo.mn, 2025).

Тухайн улсын хэмжлийн чадавхыг олон улсад харилцан хүлээн зөвшөөрөх нь худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгахад чухал ач холбогдолтой.

Олон улсын хэмжил зүйн BIPM болон OIML байгууллагууд нь “Метрийн Хэлэлцээр” ба “Хуулийн зохицуулалттай Хэмжил зүйн Олон улсын Байгууллага”-ын хэлэлцээрээр дамжуулан хэмжлийн нэгжийн систем, эталоны тогтолцоо, хэмжих хэрэгсэл ба савласан бүтээгдэхүүнд тавих шаардлагуудыг тогтоож, хэмжлийн эталон, үндэсний шалгалт тохируулга ба

хэмжлийн чадавх, хуулийн зохицуулалттай хэмжил зүйн үнэлгээг харилцан хүлээн зөвшөөрөх эсвэл ижил тэнцүү байдлаар хүлээн авах тогтолцоог бий болгосон байна.

Эдгээр байгууллагаас хэвлэн нийтэлсэн Баримт бичиг ба Зөвлөмж нь үндэсний хэмжил зүйн дэд бүтцийг зохион байгуулж, бий болгох үндсэн эх үүсвэр болдог.

Олон улсын зөвлөмж, туршлагад NMI нь, Олон улсын Жин Хэмжүүрийн Хорооны Харилцан Хүлээн зөвшөөрөх Хэлэлцээр (CIPM MRA)-т гарын үсэг зурсан бусад улс орны нэгж дамжуулалтыг хүлээн зөвшөөрөх, үндэсний хэмжлийн эталоны ижил тэнцүү байдлыг тогтоосон олон улсын хэлэлцээр байгуулах бүрэн эрхтэй байдаг ба хэмжлийн олон улсын харьцуулалтад оролцдог.

Тиймээс CIPM MRA-д тухайн улсын хувьд нэг байгууллагыг Үндэсний Хэмжил зүйн Хүрээлэн гэж ерөнхийд нь томилдог ба харин үндэсний эталон хадгалж байгаа бусад байгууллага нь энэ Хэлэлцээрийн хүрээнд “Томилогдсон Байгууллага (DI)” байдлаар үйл ажиллагаа явуулж, BIPM-д мэдэгдэнэ.

“Томилогдсон Байгууллага (DI)” нь CIPM MRA-д NMI-тэй ижил боловч хязгаарлагдмал үйл ажиллагааны хүрээнд оролцдог. Ижил түвшний үнэлгээ болон хяналтын үйл явцад хамрагдаж, тэнцсэнээр шалгалт тохируулга ба хэмжлимийн чадавх (CMC)-г мөн хүлээн зөвшөөрүүлнэ. NMI болон бусад DI-үүдийн хэмжил зүйн хамрах хүрээ, үүрэг хариуцлага үргэлж тодорхой ялгаатай байх ба CMC давхцахгүй байх ёстой. Үүнийг зохицуулах нь үндэсний хэмжил зүйн дэд бүтцийг хариуцдаг төрийн эрх бүхий байгууллагын эрх, үүрэг байна. Мөн Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, хэмжлийн үр дүнг хүлээн зөвшөөрүүлэх, чадавхаа нотлох техникийн арга хэмжээг явуулахад, мөн мэргэжилтнүүдийг төрөл бүрийн олон улсын сургалт, форумд оролцоход шаардлагатай тодорхой санхүүгийн нөөцтэй байх, хууль эрх зүйн орчин, төрийн бодлого, зохион байгуулалтаар дэмждэг байх нь чухал гэжээ (CIPM MRA P-13, 2025).

Мөн хэмжил зүйн хууль, бодлого, улс төр болон захиргааны зохион байгуулалтын дагуу хуулийн зохицуулалттай хэмжил зүйн үйл ажиллагааг төвлөрлийг сааруулан орон нутагт гүйцэтгүүлэх, зарим техникийн үйл ажиллагааг мэргэшсэн байгууллагууд гүйцэтгэж болох ба тэдгээр байгууллагууд үйл ажиллагаагаа тайлагнаж, хяналтад хамрагддаг жишиг байна (OIML D 1, 2020).

Хэмжил зүйн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийн судалгаа (2019-2026)

Монгол Улсад Хэмжил зүйн тухай хуулиар (2019) хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд хэмжил зүйн бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоож, хэмжил зүйн чиглэлээр хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн харилцааг зохицуулсан.

Хуульд “Хэмжил зүйн бодлого нь улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, хүн, малын эрүүл мэнд, байгаль орчин, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгахад чиглэсэн хэмжил зүйн тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэхэд оршино.” гэжээ.

Хэмжил зүйн тухай хуульд дараах үйл ажиллагаанд хэрэглэх хэмжил, хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжил зүйн хяналт шалгалтад хамруулна гэж заасан.

1.хүн, мал эмнэлгийн оношилгоо, эмчилгээ;

2.аюулгүй байдлыг хангах;

3.байгаль орчныг хамгаалах;

4.улсыг батлан хамгаалах;

5.худалдаа, үйлчилгээний тооцоо.

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагаа дараах хэлбэртэй байна:

1.хэмжих хэрэгслийн загварыг турших;

2.хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах;

3.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, бүртгэх гэж заасан бөгөөд хуулийн 21 дүгээр зүйлд Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага хуулийн 8.1.1-8.1.4-т заасан үйл ажиллагаанд хэрэглэх, холбогдох салбарын хүрээний хэмжих хэрэгслийн

загварын туршилт, шалгалт баталгаажуулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх мөн тухайн хэмжлийн төрлөөр улсын болон ажлын эталоныг бий болгох, стандартчилсан загвар зохион бүтээх, хадгалах, нэгж дамжуулалтыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж болно гэж тусгасан.


2019 оноос өмнө хэрэглэж байсан Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд Хэмжил зүйн байгууллагын тогтолцоонд "Хэмжил зүйн төв болон аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллага"-ыг хамруулдаг байсан бөгөөд 1980 оноос салбарын хэмжил зүйн байгууллагын албан хаагчдад улсын шалгагчийн эрхийг олгож, зохицуулалтыг хийж эхэлжээ.

Мөн Хэмжил зүйн тухай хуульд Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэхэд тавих шаардлагыг тогтоох стандартыг батлуулж, мөрдүүлэх гэж заасны дагуу "Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS 7064:2025" стандартыг мөрдөж байна.

Стандартад хэмжил зүйн мэргэжлийн байгууллага нь төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд байна. гэж зохицуулсан ба Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага нь холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлж, бүртгэн, чадавхаа үнэлүүлсэн чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулна.

Монгол Улсад дараах хэмжил зүйн мэргэжлийн байгууллагууд тухайн салбартаа хэмжлийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагааг буюу Стандарт, хэмжил зүйн газраас эрх авсан улсын шалгагч нь хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Зураг 3. Монгол Улсын Хэмжил зүйн байгууллагын тогтолцоо



Эх сурвалж: Судлаачийн өөрийн

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь ионжуулах цацрагийн хэмжлийн төрлөөр, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь өндөр гүйдэл, хүчдэлийн төрлөөр улсын хэмжээнд нэгж дамжуулалтыг хангаж байгаа бөгөөд Геологийн судалгаа, шинжилгээний төв ТӨҮГ нь эрдэс түүхий эдийн стандартчилсан загвар үйлдвэрлэж байна.

Зэвсэгт хүчний нэгдсэн лаборатори, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори зэрэг бусад хэмжил зүйн мэргэжлийн байгууллагууд тухайн салбарын хэмжих хэрэгслийн загварын туршилт, шалгалт баталгаажуулалтыг гүйцэтгэдэг.

Цаашид мөн агаарын бохирдлыг хэмжих, хүнсний стандартчилсан загвар үйлдвэрлэх чиглэлээр Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагуудыг бий болгох хэрэгцээ шаардлага байна.

Бодлогын хэрэгжилтийг үнэлэх дээрээс доош загварын дагуу хэмжил зүйн байгууллагуудын бодлого, зохицуулалтыг авч үзье.

“Дээрээс доош” чиглэсэн бодлогын хэрэгжилтийн онол нь систем тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байхын тулд төв байгууллага бүтцийг тодорхойлж, үүрэг оноож, дээрээс доош дүрмийг хэрэгжүүлэх ёстой гэж үздэг. Уг онолын гол үндэслэл нь бодлогыг төв удирдлагаас тодорхойлж, хэрэгжүүлэгчид дагаж мөрддөг, албан ёсны бүтэц, дүрэм журам бодлогыг чиглүүлдэг, төвлөрсөн удирдлагатай байх нь хэрэгжилтийн үр дүнг сайжруулдаг, хэрэгжилтийн хяналт, тайлагнал чухал үүрэгтэй байх шинжүүд юм. Мөн нэгдмэл байдал, зохион байгуулалт сайтай учраас бодлогын хэрэгжилтэд бүх түвшний байгууллагууд нэг зорилготой ажиллах, тогтвортой хэрэгжилт нь улс орны хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тохиромжтой байх зэрэг нь уг онолын загварын давуу тал байна (Н.Бурмаа, Ц.Батболд болон бусад, 2025).

Бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагуудын хоорондын үүрэг, хариуцлага, эрх мэдлийн зохистой хуваарилалт, уялдаа холбоо сайн байх, бодлогыг хэрэгжүүлэх хууль, дүрэм заавар, журам тодорхой, хэрэгжих боломжтой байх, бодлогыг хэрэгжүүлэх мэргэжлийн туршлагатай чадвартай ажилтантай байх нь бодлогыг амжилттай хэрэгжүүлэх хүчин зүйлүүд юм.

Хэмжил зүйн бодлого, зохицуулалтын хувьд үндэсний төв байгууллагад бодлого зохицуулалтыг бий болгож, хэрэгжүүлэх төвлөрсөн үүргийг хууль тогтоомжид тусгасан нь дээрээс доош чиглэсэн загварын дагуу хэрэгжүүлэлтийг үнэлэхэд тохиромжтой байна.

Хүснэгт 1. Хэмжил зүйн байгууллагуудын бодлого, зохицуулалтыг дээрээс доош загварын дагуу үнэлсэн нь

Үе шат	Дээрээс доош загвар	Үнэлгээ
Эхлэлийн цэг	Зорилтуудыг тодорхойлох: Дээд түвшний бодлого боловсруулагчдын тогтоосон тодорхой хууль эрх зүйн болон бодлого, зорилтуудыг тодорхойлсон байх	Хэмжил зүйн тухай хууль болон MNS 7064:2025 стандартад хэмжил зүйн төв байгууллага болон хэмжил зүйн байгууллагын гүйцэтгэх эрх үүрэг, харилцах харилцааг тодорхой зохицуулсан.
Үндсэн үйл ажиллагаа	Нэгдсэн удирдлага ба хяналтын доор бодлогыг хэрэгжүүлэх	Хэмжил зүйн төв байгууллагаас бодлогыг хэрэгжүүлэх нэгдсэн удирдлагаар хангана.
Амжилттай хэрэгжилт	Хэрэгжүүлэгч байгууллагууд тодорхой ойлголттой байх, хуулиар зөвшөөрсөн эрх мэдэлтэй байх, хангалттай санхүүжилттэй байх	MNS 7064:2025 стандартад Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага нь төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд байна гэж заасан нь хэрэгжүүлэгч байгууллагууд буюу дээрх 10 хэмжил зүйн мэргэжлийн байгууллагууд хуулиар зөвшөөрсөн эрх мэдэлтэй байх, хангалттай санхүүжилттэй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хянах	Хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг хянах, бодлогын үр дүнтэй тохирч байгаа эсэхийг шалгах.	Хэмжил зүйн тухай хуулийн 2019 оны шинэчилсэн найруулгаар Хэмжил зүйн байгууллагын тогтолцоонд хэмжил зүйн мэргэжлийн байгууллагыг албан ёсоор зааж өгсөн мөн “Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага” нь 2021 онд журмаар, 2025 онд стандартаар батлагдсанаас хойш бодлогын хэрэгжилт 10 хувьтай байна. Хэрэгжүүлэгч байгууллагууд хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар албан ёсоор бүртгүүлэн ажиллах давуу тал, ач холбогдлын талаар мэдлэг ойлголт хангалтгүй байгаа нь ажиглагдсан.
Үнэлэх	Ажиглагдсан үр дүнг бодлогын зорилтуудтай харьцуулж, бодлогын нөлөөллийг тооцоолох.	

Эх сурвалж: Судлаачийн судалгааны хэсэг

Хэмжил зүйн тухай хууль болон “Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS 7064:2025” стандартаар Монгол Улсын хэмжил зүйн байгууллагуудын тогтолцоо, хэмжил зүйн үйл ажиллагааг хэрхэн уялдуулах, тэдгээрийг Олон улсын үйл ажиллагаа, нэгдсэн системтэй холбож, зохицуулалтыг хийх талаар тодорхой тусгаж, төрийн бодлого тодорхой бөгөөд хууль, журам, зохицуулалтын хүрээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хэрэгжүүлж байгааг илтгэж байна.

Хэмжил зүйн төв байгууллагаас бодлогыг хэрэгжүүлэх нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт явуулах ба хэрэгжүүлэгч байгууллагууд нэг зорилготой ажиллах давуу талтай.

Хэмжил зүйн тухай хуулийн 2019 оны шинэчилсэн найруулгаар Хэмжил зүйн байгууллагын тогтолцоонд хэмжил зүйн мэргэжлийн байгууллагыг албан ёсоор зааж өгсөн мөн “Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага” нь 2021 онд журмаар, 2025 онд стандартаар батлагдсанаас хойш бодлогын хэрэгжилт 10 хувьтай байна.

Бодлогын хэрэгжилтийг дараах кэйсээр илүү тодруулъя.

Кэйс 1:

Монгол Улсын эрчим хүчний салбарт өндөр гүйдэл, хүчдэлийн хэмжлийн төрлөөр улсын эталоныг бий болгож олон улсын SI системийн нэгж дамжуулалтыг хангах, гүйцэтгэж буй шалгалт тохируулга хэмжлийн чадавх (CMC)-г олон улсад харилцан хүлээн зөвшөөрүүлж, ижил түвшний байдлыг илэрхийлэх хэрэгцээ шаардлага байна.

Стандарт, хэмжил зүйн газраас 1000 В, 100 А хэмжих хязгаарт цахилгааны тогтмол, хувьсах гүйдэл, хүчдэл, тогтмол гүйдлийн эсэргүүцэл, эрчим хүч чадлын улсын 4 эталоныг бий болгон хадгалж, нэгж дамжуулалтыг ханган ажилладаг.

Иймд дээрх хэрэгцээ шаардлагыг нөхөж хэмжил зүйн тогтолцоог бүрдүүлэхээр ЭХЯ болон ХБНГУ-ын Физик техникийн хүрээлэнтэй хамтран 2013-2023 онуудад хэрэгжүүлсэн төслийн хүрээнд “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн хэмжил зүйн лабораторийг чадавхжуулан ажилласан.

Стандарт, хэмжил зүйн газраас ЦДҮС ТӨХК-ийн лабораторид хэмжил зүй болон хэмжлийн эргэлзээг тооцоолох талаар сургалт явуулж, шалгалт тохируулгын аргачлал боловсруулах, шаардлагатай стандартыг орчуулан нэвтрүүлэх зэрэгт зөвлөн мэдлэгийг дамжуулж, РТВ төслийн зүгээс өндөр нарийвчлалтай эталон төхөөрөмж худалдан авах, үйлдвэрлэгчийн сургалт авах, чанарын баримт бичигт үндэсний зөвлөх авах, зөвлөгөө өгөх, олон улсын туршлага хуваалцах зэргээр дэмжлэг үзүүлэн ажилласан.

Үүний үр дүнд хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар дамжуулан өндөр гүйдэл, хүчдэлийн хэмжлийн төрлөөр улсын эталоныг 220 кВ болон 10 кА хамрах хүрээнд бий болгох бэлтгэл ажил хангагдаж, эрчим хүчний сүлжээний бүх үе шатанд хэмжлийн үнэн зөв, найдвартай байдлыг бий болгох нэгж

дамжуулалт, хэмжлийн нэгдмэл байдал хангагдана. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар ажиллах чадавхаа үнэлүүлэх хүсэлтийг 2026 оны 3 дугаар сард Хэмжил зүйн төв байгууллагад ирүүлсэн байна.

Кэйс 2:

Монгол Улсын ионжуулагч цацрагийн хэмжлийн салбарт ажлын эталоныг бий болгож олон улсын SI системийн нэгж дамжуулалт, хэмжлийн нэгдмэл байдлыг хангаж байгаа лаборатори нь Цөмийн энергийн комиссын ажлын албаны Дозиметрийн тохируулга, баталгаажуулалтын лаборатори байна.

Ионжуулагч цацрагийн эталон болох Ионжуулагч камеруудыг нэгж дамжуулалтад гадаад улсад илгээж олон улсын эталоноос SI системийн нэгж дамжуулалтыг хангадаг. Мэргэшсэн албан хаагч нар Стандарт, хэмжил зүйн газраас улсын шалгагчийн эрх авч, батлагдсан стандарт, аргачлалын дагуу гамма болон рентген цацрагийн шарагч төхөөрөмж, эталон Ионжуулагч камер, электрометрүүдийг ашиглан ионжуулагч цацраг хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт гүйцэтгэж байна. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын үнэлгээ хийлгэх бэлтгэл ажлыг 2026 оноос эхлүүлж байна.

Мөн хэмжил зүйн мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл болгож 8 байгууллагын мэргэжилтнүүдээс ярилцлагын аргаар судалгаа хийлээ. Үр дүн:

Ярилцлагуудад шинжилгээ хийж, нийтлэг шинжээр ангилан үзэхэд:

- Аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийг хянах, байгаль орчны хамгаалалд хэмжил зүй чухал үүрэгтэй, хэмжил зүйн салбарын шалгагчаар ажиллаж байгаа нь хэмжил зүйн тухай хуулийг хэрэгжүүлж байгаа гэж үзэж байгаа бөгөөд хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар ажиллах, зохицуулалтын стандартын талаар мэдлэг, ойлголт бага байна.
- Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын улсын шалгагчийн эрх авч ажиллаж байсан албан хаагч нь шилжсэн, ажлаас гарсан тохиолдолд шинэ ажилтныг мэргэшүүлээгүй, эрх аваагүй, хууль эрх зүйн зохицуулалт, олон улсын тогтолцооны тухай ойлголт, мэдээлэл дутмаг, ойлголтын зөрүүтэй байна.
- Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад ажиллаж байгаа мэргэжлийн албан хаагч нар олон улсын хэмжил зүйн байгууллагын тухай мэдэж байгаа боловч хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар ажилласнаар ямар давуу талтайг бүрэн тодорхойлоогүй.

Бусад улсын харьцуулсан судалгаа

Хүснэгт 2. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагуудын бодлого, зохицуулалтын харьцуулсан судалгаа

Д/д	Улс	Бодлого, зохицуулалтын төрөл	Нэгдсэн төлөвлөлт, уялдаа	Бодлогын хэрэгжилтэд анхаарах чиглэл
1	Их Британи (NPL + DI)	Гэрээт/Бодлогод суурилсан: Шинжлэх ухаан, технологи инновацын яам нь бүх лабораториуд дагаж мөрдөх 5 жилийн стратегийг тогтоодог.	Үндэсний хэмжил зүйн стратеги: Судалгаа шинжилгээ болон үйлдвэрлэл үйлчилгээний нэгдсэн зураглалтай.	Үр нөлөө ба инновац: Зохицуулалт нь Их Британийн бизнесийг өсгөхөд хэр их тусалсан бэ?
2	ХБНГУ (PTB + DI)	Хууль эрх зүйн: Хэмжлийн болон баталгаажуулалтын хууль нь шатлал болон үүргийг тодорхойлдог.	Чанарын дэд бүтэц (QI): Хэмжил зүй, стандартчилал, итгэмжлэлийн үйл ажиллагаа хооронд тогтвортой холбоо байдаг.	Техникийн бие даасан байдал: Үндэсний эталонууд хэр нарийвчлалтай, "дээд шатны" байна вэ?

3	Монгол (СХЗГ + DI)	Хуульд бодлого, зохицуулалтыг тодорхойлсон.	Батлагдсан стандартын дагуу Хэмжил зүйн төв байгууллагаас бодлогын зохицуулалтыг хийж байна.	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хэмжил зүйн байгууллагын тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх

Дээрх улс орнууд олон улсын жишгийн дагуу үндэсний нэг хүрээлэн нь бодлого, зохицуулалтыг зохион байгуулж байгаа боловч бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ авч үзэж байгаа бодлогын зорилт өөр өөр байгааг харуулж байна. Их Британид Үндэсний хэмжлийн тогтолцооны нэгдсэн зохицуулалт нь нэгж дамжуулалтыг давхардуулалгүй хангаж, эмнэлгийн лаборатори, инженерийн компани алин ч бай ижил нарийвчлалыг ашиглаж байгааг баталгаажуулдаг. ХБНГУ-ын хувьд Олон улсад хүлээн зөвшөөрүүлсэн байх нь гол шалгуур ба жилд 50-100 олон улсын түлхүүр харьцуулалтад оролцох зорилго тавьдаг. Хэрэв мэргэжлийн байгууллага нь харьцуулалтад муу үр дүн үзүүлбэл дээрээс доош механизмаар залруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж, герман чанарыг баталгаажуулж байдаг.

Дүгнэлт

Орчин үеийн эдийн засагт хэмжил зүйн үйл ажиллагааны хамрах хүрээ өргөжин, илүү нарийн төвөгтэй болж байгаа бөгөөд үндэсний хэмжил зүйн хүрээлэнгийн гүйцэтгэх үүрэг болон хуулийн зохицуулалттай хэмжил зүйн үйл ажиллагааг нэгээс олон байгууллага хэрэгжүүлж байна.

Хэмжил зүйн дэд бүтцийн тархсан зохион байгуулалт нь хөгжиж байгаа улс орнуудад байгаа чадамж, чадавхаа ашиглан зохион байгуулж, үндэсний хэрэгцээ шаардлагыг хангах боломж юм.

Хэмжил зүйн салбар, үйл ажиллагаа нь хүн, мал эмнэлгийн оношилгоо, эмчилгээ, аюулгүй байдлыг хангах, худалдаа, үйлчилгээний тооцоо, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд болон бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хангахад хэмжил, туршилт, сорилт, шинжилгээний үнэн зөв байдлын баталгааг хангаж байдаг бөгөөд нарийвчлалтай хэмжил нь судалгаа, шинжилгээ хийх, бодлого, шийдвэр боловсруулах суурь болж, тухайн улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлдэг.

Монгол улсад Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын үүргийг хэрэгжүүлж байгаа 10 байгууллага ажиллаж байгаа боловч, нэг байгууллагаас бусад нь хэмжил зүйн төв байгууллагаар үнэлүүлж, бүртгүүлээгүй байна.

Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагууд мэргэжлийн байгууллагаар ажиллах ач холбогдол, хууль тогтоомж, стандартад тодорхойлсон эрх, үүргийн талаар мэдлэг ойлголт бага байна.

1980 оноос эхлэн салбарын хэмжил зүйн байгууллагын албан хаагч нарт хэмжил зүйн талаар сургалт явуулж, улсын шалгагчийн эрх олгон, тухайн салбарын хуулийн хяналт шалгалтад хамаарах хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулж ирсэн нь шинэ бодлого зохицуулалтад шилжихэд хугацаа шаардаж байна.

Бодлогын хэрэгжилтийг үнэлэх дээрээс доош загварын дагуу хэрэгжилтийг үнэлэхэд хууль тогтоомж, бодлогын зохицуулалт байгаа боловч, бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд зохицуулагч ба хэрэгжүүлэгч талуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг дээшлүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нь бодлого амжилттай хэрэгжих шалтгаан болох нь кэйс судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагуудын хууль тогтоомж, стандартад тодорхойлсон эрх, үүрэг, олон улсын болон үндэсний хэмжил зүйн тогтолцоонд албан ёсоор бүртгүүлэн оролцох үйл ажиллагааны ач холбогдол, оролцогч байгууллагуудын харилцан уялдаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нь хэмжил зүйн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулна.

Санал

Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага нь чадавхаа үнэлүүлж, бүртгүүлснээр бүс нутгийн болон олон улсын хэмжил зүйн байгууллагуудын үйл ажиллагаа, хурал уулзалтад салбарыг төлөөлөн оролцох, хамтын ажиллагаа болон техникийн чадавхаа нэмэгдүүлэх, сургалт, мэдээлэлд хамрагдаж мэргэжилтний ур чадварыг нэмэгдүүлэх, улмаар Монгол Улсаас олон улсад хүлээн зөвшөөрүүлсэн хэмжлийн чадавхыг нэмэгдүүлэх ач холбогдлыг мэргэжлийн байгууллагуудад таниулах шаардлага байна.

Монгол Улсад хэмжил зүйн байгууллагын тогтолцоог бүрдүүлж, зохицуулалтыг хэрэгжүүлж дууссаны дараа бодлогод дараагийн зорилтыг тодорхойлж, бодлогыг шинэчлэх шаардлага үүсэх зураглал харагдаж байна.

Энэ судалгааны ажилд Үндэсний чанарын дэд бүтцийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд болох тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн тогтолцоо, стандартчиллын асуудлыг судлаагүй бөгөөд цаашид эдгээр үйл ажиллагаа, тогтолцооны талаар олон улсын жишиг болон бусад улсын жишгийг судлан, хууль тогтоомж, бодлогод тусган хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Н.Бурмаа, Ц.Батболд болон бусад, 2025, МУИС Төрийн бодлого
2. UK Measurement Strategy, 2022
3. John Birch, 2003, Benefit of Legal Metrology for the Economy and Society
4. СХЗГ, 2025, Хэмжих хэрэгслийн улсын нэгдсэн тооллогын дүн
5. WTO, 1995, Agreement on Technical Barriers to Trade (TBT)
6. Velychko Oleh, Kuzmenko Yurii, 2024, Modern components of activities and models of national metrological institutes
7. APLMF-APMP-PTB, 2016, National Metrological Infrastructure Joint Guide
8. National Metrology Systems - Developing the institutional and legislative framework, 2020, OIML D 1
9. OIML Strategy, 2011, OIML B 15
10. Participation in the CIPM MRA National Metrology Institutes, Designated Institutes, International organizations, 2025, CIPM MRA-P-13

ГЭРЛЭЛТТЭЙ АДИЛТГАХ ХАРИЛЦАА БУЮУ ХАМТРАН АМЬДРАГЧДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

"THE LEGAL REGULATION OF COHABITING PARTNERS IN MARRIAGE-EQUIVALENT RELATIONSHIPS"

Б.Золбоо*
Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403-р анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч
Zolboo B.
Teacher, Major, Department of Civil Enforcement of Court Decisions, School of Court Decision Enforcement Service, Training and Research Unit 403, University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: zolbo29@yahoo.com

Хураангуй: Орчин үеийн нийгэмд гэр бүлийн хэлбэр, хамтын амьдралын хэв маяг өөрчлөгдөж, албан ёсны гэрлэлтийн бус хамтран амьдрах буюу гэрлэлттэй адилтгах харилцаа түгээмэл болж байна. Иймхарилцаа нь бодит амьдрал дээр гэр бүлийн шинжийг агуулдаг боловч хууль эрх зүйн хамгаалалт нь бусад орны гэр бүлийн тухай хуульд харилцан адилгүй байдаг. Энэхүү өгүүллийн зорилго нь гэрлэлттэй адилтгах харилцааны ойлголт, эрх зүйн шинж, Олон Улсын эрх зүйн зохицуулалтын туршлага болон Монгол Улсын эрх зүйн орчныг судлан шинжлэхэд оршино. Судалгаанд эрх зүйн харьцуулсан болон дүн шинжилгээний аргыг ашигласан. Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад хамтран амьдрагчдын харилцааг шууд зохицуулсан тусгай хууль тогтоомж хангалтгүй байгаа бөгөөд эд хөрөнгийн харилцаа, хүүхдийн эрх ашиг, нийгмийн хамгааллын асуудал бүрэн тодорхой биш байна. Иймд гэрлэлттэй адилтгах харилцааг эрх зүйн хүрээнд тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрч, иргэдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэв.

Abstract: In modern society, the forms of family and cohabitation have significantly changed. Besides formal marriage, cohabitation or marriage-like relationships have become increasingly common. Although such relationships share many characteristics of family life, their legal protection varies across different countries. The purpose of this article is to examine the concept and legal nature of marriage-like relationships, review international legal practices, and analyze the current legal framework in Mongolia. Comparative legal analysis and doctrinal research methods were applied in this study. The findings indicate that Mongolia lacks a comprehensive legal framework regulating cohabitation relationships. Issues related to property relations, child protection, and social security rights remain insufficiently regulated. Therefore, it is necessary to improve legal regulations and adopt certain international practices in order to protect the legitimate rights and interests of individuals involved in marriage-like relationships.

Түлхүүр үг: Гэрлэлт, хамтран амьдрах, гэр бүлийн эрх зүйн зохицуулалт, хамтран амьдрагч.

Keywords: Marriage, cohabitation, family law, legal regulation, cohabiting partners.

Гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж бөгөөд хувь хүний нийгэмшил, хүмүүжил, эдийн засгийн болон сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах чухал институт юм. Уламжлал ёсоор гэр бүлийг албан ёсны гэрлэлтийн үндсэн дээр бий болдог гэж үздэг байсан боловч нийгмийн хөгжлийн явцад орчин үеийн хүмүүсийн амьдралын хэв маяг, үнэт зүйлс өөрчлөгдөж, гэр бүлийн шинэ хэлбэрүүд бий болж байна.

Эдгээрийн нэг нь албан ёсны гэрлэлтийн бүртгэлгүй боловч хамтран амьдарч, гэр бүлийн шинжтэй харилцаа үүсгэдэг гэрлэлттэй адилтгах харилцаа юм. Судлаачид ийм харилцааг “cohabitation”, “de facto union”, “common law relationship” гэх мэт нэр томьёогоор тодорхойлдог (Glendon, 2010).

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад гэрлэлтийн бүртгэлгүйгээр хамтран

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

амьдрах тохиолдол нэмэгдэж байгаа нь нийгмийн бодит үзэгдэл болж байна. Гэвч ийм харилцаа дуусгавар болох үед эд хөрөнгийн хуваарилалт, хүүхдийн тэтгэмж, асрамж, нийгмийн хамгааллын асуудал маргаан үүсгэх нь элбэг.

Иймд гэрлэлттэй адилтгах харилцааг эрх зүйн хүрээнд судлах, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал чухал ач холбогдолтой юм.

Энэхүү өгүүллийн зорилго нь гэрлэлттэй адилтгах харилцааны эрх зүйн зохицуулалтыг судалж, олон улсын туршлага болон Монгол Улсын эрх зүйн орчныг харьцуулан шинжилж, цаашид боловсронгуй болгох боломжийг тодорхойлоход оршино.

Гэрлэлттэй адилтгах харилцааны ойлголт, онцлог

Гэрлэлттэй адилтгах харилцаа гэдэг нь албан ёсоор бүртгүүлээгүй боловч бодит амьдрал дээр гэр бүлийн шинжтэй хамтын амьдрал үүсгэж буй хүмүүсийн харилцааг хэлнэ. Судлаачдын үзэж байгаагаар ийм харилцаанд дараах үндсэн шинжүүд ажиглагддаг.

Нэгдүгээрт, хамтран амьдрах буюу нэг гэрт удаан хугацаанд амьдрах.

Хоёрдугаарт, эд хөрөнгийг хамтран ашиглах, хамтын аж ахуй эрхлэх.

Гуравдугаарт, харилцан халамж, дэмжлэг үзүүлэх.

Дөрөвдүгээрт, хүүхэд төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэх.

Эдгээр шинжүүд нь албан ёсны гэр бүлийн харилцаатай төстэй боловч хууль эрх зүйн хувьд бүрэн хамгаалагдсан байдаггүй (Parkinson, 2015).

-Олон улсын эрх зүйн зохицуулалтын туршлага

Гадаадын зарим оронд хамтран амьдрагчдын харилцааг тодорхой хэмжээнд хуульчлан зохицуулдаг тусгай хуультай байдаг.

Франц улсад 1999 онд “Pacte civil de solidarité (PACS)” буюу хамтран амьдрах гэрээг хуульчилсан. Энэ нь хамтран амьдрагчдад татвар, эд хөрөнгийн зарим эрхийг олгодог (Dekeuwer-Defossez, 2013).

Скандинавын орнууд болох Швед, Норвеги зэрэг улсуудад хамтран амьдрагчдын эд хөрөнгийн харилцааг тусгай хуулиар зохицуулдаг. Жишээлбэл, Шведийн “Sambolag” хуульд хамтран амьдрагчдын хамтын өмчийн асуудлыг тодорхой заасан байдаг.

АНУ-ын зарим мужид “common law marriage” буюу удаан хугацаанд хамтран амьдарсан хүмүүсийг тодорхой нөхцөлд гэрлэсэнтэй адилтган үздэг (Reed, 2018).

Мөн “БНСУ-ын хуулиар гэр бүл болсныг хүлээн зөвшөөрөх хууль зүйн үндэслэл нь тус улсын Иргэний хуулийн 812.1-д заасны дагуу Гэр бүлийн бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгүүлснээр бий болно гэж хуульчилсан байдаг” (Republic of Korea, 1958). “Гэхдээ хуульд заасны дагуу холбогдох бүртгэлд гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлээгүй боловч гэр бүлийн хэлбэрийг агуулан, дундаасаа хүүхэдтэй болсон, нэг хаягт оршин суудаг, хамтын хөрөнгө бий болгон амьдарч байгаа тохиолдолд гэр бүл болсон гэж үзэн шийдвэрлэх тохиолдол шүүхийн практикт нэгэнт тогтсон арга байна” (Korea, 1965)

Үүнийг дагаад гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хууль ёсны гэр бүлтэй адилтгах нөхцөл байдал бий болсонд тооцогдсон бол тэдний эд хөрөнгийн асуудал гэр бүлийн дундын эд хөрөнгийн зохицуулалтын дагуу шийдвэрлэдэг байна (Korea, Republic of, 1958).

Эдгээр туршлагаас харахад орчин үеийн нийгэмд хамтран амьдрах харилцааг тодорхой хэмжээнд хуульчлан хамгаалах хандлага давамгайлж байна.

-Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсад гэр бүлийн харилцааг Гэр бүлийн тухай хуулиар зохицуулдаг. Тус хуулийн дагуу гэрлэлтийг иргэний бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр гэж үздэг.


Гэсэн хэдий ч бодит амьдрал дээр хамтран амьдрагчдын харилцаа нэлээд түгээмэл болсон. Зарим тохиолдолд хамтран амьдрагчид олон жил хамт амьдарч, эд хөрөнгө хамтран бий болгож, хүүхэдтэй болдог. Гэвч харилцаа дуусгавар болох үед эд хөрөнгийн маргаан үүсэх нь элбэг байгаа бөгөөд ийм төрлийн

маргааныг зохицуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

“Монгол Улсын хувьд Гэр бүлийн тухай хуульд хамтран амьдрагчид буюу гэрлэлттэй адилтгах харилцаатай хосуудын эрх зүйн зохицуулалтыг тусгаагүй. Харин Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд “Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс... нэгэн адил хамаарна” гэж хамтран амьдрагчдын талаар зохицуулсан байна” (Монгол Улс, 2016)

Ерөнхий статистик мэдээнээс үзэхэд Монгол Улсад жил бүр төрж буй нийт хүүхдийн 18-25% орчим нь хамтран амьдрагч буюу гэрлэлт бүртгэлгүй эцэг, эхээс төрсөн гэж судалгаанд дурдсан байдаг.

График 1. Хүүхдийн тоо



2015–2018 онд харьцангуй тогтвортой байсан,
2019–2021 онд хувь нэмэгдэж хамгийн өндөр түвшинд хүрсэн,
2022 оноос төрөлтийн бууралтаас шалтгаалан тоон үзүүлэлт багассан байна.

График 2. Нийт төрөлтөд эзлэх хувь



2015-2023 оны хооронд төрсөн хүүхдүүдийн тоон мэдээллээс харахад эцэг, эх нь хууль ёсны гэрлэлтээ улсын бүртгэлд бүртгүүлээгүй боловч хамтран амьдрах хугацаанд нь 130.000-145.000 орчим хүүхэд буюу нийт төрөлтийн 5 хүүхэд тутмын 1 орчим нь гэрлэлт бүртгэлгүй эцэг, эхээс төрсөн байдаг (Үндэсний статистикийн хороо, 2023).

Сүүлийн жилүүдэд нийгэмд тулгамдаж байгаа асуудлын нэг нь гэр бүл салалт болж байна. 2025 оны байдлаар Монгол улсад өдөрт дунджаар 12 хос гэрлэлтээ цуцлуулж, гэрлэлт цуцлалтын тоо өмнөх оноос 7.2 хувиар өсжээ (Шүүхийн ерөнхий зөвлөл,

2025). Тоон мэдээллээс харвал сүүлийн таван жилийн хугацаанд 35-39 насныхан гэр бүлээ цуцлуулах нэмэгдэж нэг гэр бүл салалтын ард 1-3 хүүхэд хохирогч болж үлдэж байна. 2025 онд хийсэн судалгаанд гэрлэлтээ цуцлалтын гол шалтгааныг тодруулахад:

-Таарамжгүй харилцаа буюу үзэл бодлын зөрүү: Хосуудын харилцан ойлголцолгүй байдал, зан чанарын үл тохирол;

-Гэр бүлээс гадуурх харилцаа: Гэр бүлээс гадуурх харилцаанаас үүдэлтэй гэрлэлт цуцлалт нэмэгдэж байна;

-Архидалт буюу архины хамаарал: Гэр бүлийн хүчирхийлэл болон салалтад архины хамаарал томоохон нөлөө үзүүлдэг;

-Тусдаа амьдардгаас мөн санхүүгийн хүндрэл: Орлого багатай, эдийн засгийн хувьд тогтворгүй хосуудын дунд гэр бүл салалт өндөр байна;

-Эрт гэрлэлт: Хэт залуудаа буюу нэгнээ сайн таньж мэдээгүй үедээ гэрлэсний улмаас салсан байна.

Монгол Улсад “2025 оны байдлаар шүүхээр шийдвэрлэсэн нийт хэрэг, маргаан 240,538-г хүлээн авч, үүнээс Иргэний хэрэг-95,408, Захиргааны хэрэг-2,132, Зөрчлийн хэрэг-54,738 нийт 176,136 хэрэг маргааныг шийдвэрлэсэн байна. Иймд гэр бүлийн маргаан нь ихэвчлэн Иргэний хэргийн журмаар шийдвэрлэдэг бөгөөд шүүхийн статистик мэдээнээс авч үзвэл 2021 онд 4690, 2022 онд 6263, 2024 онд 6520, 2025 онд 6958 гэр бүлийн маргааныг тус тус шийдвэрлэсэн байна” (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2025).

Судалгаанд дараах төрлийн гэр бүлийн маргаан түгээмэл байдаг байна.

1. Хүүхдийн асрамж, тэтгэлэг-35-40%
2. Гэрлэлт цуцлах-30-35%
3. Эд хөрөнгийн маргаан-15-20%
4. Эцэг тогтоох-5-10%

Үүнээс үзэхэд жил ирэх тусам гэр бүл цуцлалтын тоо өсөж байгаа бөгөөд хууль ёсны гэрлэлт бүртгэлгүй, хамтран амьдрагчидтай холбоотой шүүхийн маргаан ихээхэн хувийг эзэлдэг гэж судлаачид үздэг байна.

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар хамтран амьдрагчдын эд хөрөнгийн харилцааг ихэвчлэн Иргэний хуулийн ерөнхий зохицуулалтаар шийдвэрлэдэг боловч энэ нь гэр бүлийн харилцааны онцлогийг бүрэн тусгаж чаддаггүй гэж судлаачид үздэг (Жанцан, Н., 2018).

Дүгнэлт

Гэрлэлттэй адилтгах харилцаа нь орчин үеийн нийгэмд өргөн тархсан бодит үзэгдэл болж байна. Олон улсад иймэрхарилцаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор тусгай хуулийн зохицуулалт бий болгосон байдаг.

Монгол Улсад анх 1999 онд Гэр бүлийн тухай хууль батлагдсанаас хойш тус хуульд 8 удаа нэмэлт өөрчлөлт орсон боловч тэдгээр зохицуулалтууд нь гэр бүлийн харилцаанд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулахад чиглэсэгүй бөгөөд Монгол Улсад хамтран амьдрагчдын харилцааг шууд зохицуулсан хууль тогтоомж хангалтгүй байгаа нь гэр бүлийн буюу хамтран амьдрагчдын харилцаа дуусгавар болох тохиолдолд хариуцах үүрэг хариуцлага мөн иймэрхарилцаанаас үүдэн гарах хүүхдийн эрх, түүнчлэн эд хөрөнгө, нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулах зохицуулалт тодорхой бус хэвээр байна.

Иймд гэрлэлттэй адилтгах харилцааг нийгмийн бодит байдалтай уялдуулан судалж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хамтран амьдрагчдын эрх, үүргийг тодорхойлсон тусгай эрх зүйн зохицуулалт бий болгох;

Гэр бүл болон хамтран амьдрагч нарын харилцааг зохицуулах гэрээг хуульчлах;

Эд хөрөнгийн хамтын өмчийн асуудлыг тодорхой хуульчлах;

Хүүхдийн эрх ашиг, асрамж, тэтгэмж хамгааллыг илүү тодорхой зохицуулах;

Олон улсын туршлагыг судалж, Монгол Улсын эрх зүйн орчинд нийцүүлэх;

Санал

Нэн тэргүүнд гэр бүл салалт болон 5 жилээс дээш хугацаанд хамтран амьдарсан гэр бүлийн гишүүдийн харилцааг бататгахын тулд бид хамгийн суурь үе буюу гэр бүлийн төлөвлөлт, сэтгэлийн боловсролыг нас насны иргэдэд шатлалтай

системээр хүргэж, анхаарах хэрэгтэй. Мөн гэр бүлийн харилцааны талаарх ойлголтыг хүүхдийг насанд хүрэхээс өмнөх буюу 10 жилийн боловсролд таниулан мэдүүлж, гэр бүл төлөвлөлтийн талаарх ойлголтыг өгч байх нь зөв юм.

Гэр бүлтэй адилтгах харилцаатай буюу хамтран амьдрагчдын хамт амьдарсан хугацааг тодорхой зохицуулж өгөх, үүнд хэр хугацаанд хамт амьдарсан бол хууль ёсны гэр бүлтэй адилтгаж үзэх талаар хуульчилж өгөх нь зүй юм.

Бусад орны хувьд 1-3 жил хамт амьдарсан, нэг хаягт оршин суудаг бүртгэлтэй тохиолдолд хууль ёсны гэр бүлтэй адилтган авч үздэг байна. Үүнтэй ижил 1 жил хүртэлх хугацаа гэж хуульчлан тогтоож өгвөл гэр бүлийн гишүүдийн хариуцлага нэмэгдэнэ гэж үзэж байгаа бөгөөд нэг жил хүрэхгүй хугацаанд хүүхэдтэй болсон тохиолдолд гэрлэлтийн гэрээг албан ёсоор байгуулж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлдэг байх нь зөв юм.

Дээрх гэрлэлтийн гэрээнд нэн тэргүүнд хүүхдийн тэжээн тэтгэх үүрэг, хариуцлагыг нарийн тогтоож өгөх, хүүхдийн эрүүл бойжих, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талын хариуцлагыг тус тус нарийн журамлаж өгөх.

Мөн улсаас олгодог хүүхдийн мөнгөний зарцуулалтыг хянаж, хүүхдийг 18 нас хүртэлх хүүхдийн мөнгийг эцэг, эхэд олгохгүй байхаар хуульчлах нь зүйн хэрэг.

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль.
2. Монгол Улсын Иргэний хууль.
3. Жанцан Н. Гэр бүлийн эрх зүй. Улаанбаатар, 2018.
4. Glendon M. Comparative Family Law. Oxford University Press, 2010.
5. Parkinson P. Family Law and the Indissolubility of Parenthood. Cambridge University Press, 2015.
6. Reed S. Marriage and Cohabitation Law. New York, 2018.
7. Dekeuwer-Defossez F. Family Law in France. Paris, 2013.
8. Монгол Улсын үндэсний статистикийн хороо, (http://www.1212.mn)
9. БНСУ-ын Иргэний хууль

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ БАТЛАН ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: ХУУЛЬД ҮНДЭСЛЭХ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

THE PROCESS OF ADOPTING ADMINISTRATIVE NORMATIVE ACTS IN MONGOLIA: THE IMPLEMENTATION OF THE PRINCIPLE OF LEGALITY

Д.Энх-Амар*
Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад
Enkh-Amar D.
Senior lecturer at the Department of Public Law, School of Law University of Internal Affairs, Police Captain

*Хариуцлагатай зохиогч: enkhamar.d@uia.gov.mn

Хураангуй: 1992-2015 онд Монгол Улсад хэм хэмжээний буюу нийтлэг шинжтэй харилцааг давтан зохицуулах агуулга бүхий шийдвэр гаргах асуудлыг гаргаж буй субьектээр нь ангилан журамлаж байсан бол 2015 оноос хойш хэн гаргахаас нь үл хамаарч нийтлэг зохицуулалттай болгож хуульчилсан байна.

Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудад захиргааны хэм хэмжээний актын агуулга, зорилго, түүнийг боловсруулах, нийтэд мэдээлэх, бүртгэх болон хянах үйл ажиллагааг тодорхой зохицуулсан байдаг.

Захиргааны байгууллагаас гаргаж буй аливаа шийдвэр нь хүн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхолд шууд болон шууд бусаар нөлөөлж байдаг бөгөөд хууль зүйн үндэслэл, ил тод байдал, эрх зүйн хяналт зэрэг шаардлагыг хангасан байх ёстой. Захиргааны ерөнхий хуульд захиргааны үйл ажиллагаа хуульд үндэслэх шаардлага тодорхой туссан боловч практикт “эрх хэмжээ хэтрүүлэх”, “хуулийг буруу хэрэглэх” зэрэг асуудлууд түгээмэл байна.

Хуульд үндэслэх зарчим нь эрх хэмжээний, чиг үүргийн, нутаг дэвсгэрийн, хэлбэрийн, болон агуулгын шаардлагуудаас бүрддэг бөгөөд эдгээр нь захиргааны шийдвэр хууль ёсны байх нөхцөлийг тодорхойлох үндсэн шалгуур болдог.

Судлаач миний бие энэхүү илтгэлээр захиргааны хэм хэмжээний актыг хянан бүртгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлага байгаа талаар анхаарах асуудлыг судалж, цаашдын чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон юм.

Abstract: In Mongolia, from 1992 to 2015, decisions that were normative or re-regulate common relations were classified and regulated by the subject of the decision, but since 2015, they have been legislated as general regulations regardless of who issued them.

The General Administrative Law of Mongolia and other relevant laws and regulations clearly regulate the content and purpose of administrative normative acts, their development, public disclosure, registration, and control.

Any decision made by an administrative organization directly or indirectly affects the rights and interests of individuals and legal entities and must meet requirements such as legal grounds, transparency, and legal control. The General Administrative Law clearly stipulates the requirement that administrative actions be based on law, but in practice, problems such as “excessive authority” and “misapplication of the law” are common.

The principle of being based on law consists of requirements for authority, function, territory, form, and content, which are the main criteria for determining the legality of an administrative decision.

As a researcher, I aim to examine the need to improve the process of reviewing and registering administrative acts and to determine future trends in this report.

Түлхүүр үгс: *Хуульд үндэслэх зарчим, нутгийн өөрөө удирдах байгууллага, эрх олгогдсон этгээд, захиргааны шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт*

Keywords: *Principles of legality, local self-government, authorized entities, administrative decisions, and administrative normative acts*

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд захиргааны үйл ажиллагаа нь хуульд үндэслэх тусгай зарчимд тулгуурлан хэрэгжихээр зохицуулагдсан бөгөөд энэхүү зарчмын агуулга, хэрэгжилтийн онцлогийг цаашид дэлгэрүүлэн авч үзэх шаардлагатай байна.

Монгол Улсын захиргааны эрх зүйн тогтолцоонд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа хуульд нийцсэн, хуульд үндэслэсэн байх шаардлага нь эрх зүйт төрийн үзэл баримтлалын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болдог. Энэ утгаараа захиргааны үйл ажиллагаа хуульд үндэслэх шаардлага нь төрийн эрх мэдлийг хууль зүйн хүрээнд хэрэгжүүлэх, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үндсэн баталгаа юм. Олон улсад энэхүү шаардлагыг Principle of Legality хэмээн нэрлэдэг бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан нь зөвхөн хуульд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах, хуульд заагаагүй эрх мэдлийг хэрэгжүүлэхгүй байх, хуульд нийцээгүй шийдвэр гаргахгүй байхыг шаарддаг үндсэн зарчимд тооцогддог.

Монгол Улсад энэхүү зарчим нь төрийн үйл ажиллагааны суурь зарчим болох хууль дээдлэх зарчмын бодит хэрэгжилтийн нэг хэлбэр болж илэрдэг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд төрийн үйл ажиллагаа хууль дээдлэх зарчимд тулгуурлахыг баталгаажуулсан бөгөөд уг зарчим нь төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа хуульд захирагдаж, хуульд үндэслэн хэрэгжих эрх зүйн үндсийг бүрдүүлдэг. Үүний дагуу захиргааны үйл ажиллагаанд баримтлах тусгай зарчмуудыг Захиргааны ерөнхий хуульд тодорхой тусгасан бөгөөд тэдгээрийн нэг нь “хуульд үндэслэх зарчим” юм. Энэ нь захиргааны байгууллагаас гаргах аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь хуульд заасан эрх хэмжээ, чиг үүрэг, нутаг дэвсгэрийн харьяалал, хэлбэр, агуулгын шаардлагад нийцсэн байх ёстой гэсэн цогц шаардлагыг илэрхийлдэг.

Монгол Улсад хууль тогтоогчоос гадна захиргааны байгууллагаас хэм хэмжээний буюу нийтлэг шинжтэй харилцааг давтан зохицуулах агуулга бүхий шийдвэр гаргах асуудлыг 1992 оны Үндсэн хууль батлагдан гарснаас хойш Засгийн газрын 1993 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 162 дугаар тогтоолоор "Аймаг, нийслэлийн Засаг дарга (хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа)-аас нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хянах журам", 1997 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 178 дугаар тогтоолоор "Яам, тохируулагч агентлагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн баримт бичгийг хянаж бүртгэх журам”, Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 8 дугаар тогтоолоор “Монгол Улсын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хянаж бүртгэх журам", 2010 оны 5 дугаар сарын 19-ний 119 дүгээр тогтоолоор “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ыг батлан мөрдүүлэх замаар хэрэгжүүлж ирсэн билээ. (Цогтоо, 2021)

Харин 2015 онд батлагдсан Захиргааны ерөнхий хуулиар анх удаа захиргааны хэм хэмжээний актад юуг хамруулах, ямар шалгуур нөхцөл тавигдах, хэрхэн боловсруулагдаж, хянагдаж, бүртгэгдсэний дараа хүчин төгөлдөр болох зэргийг нь зохицуулж өгсөн байна.

Захиргааны эрх зүйн харилцааны онцлог нь харилцаанд оролцогчдын нэг тал нь үргэлж захиргааны байгууллага, албан тушаалтан, хууль болон гэрээний үндсэн дээр тусгайлан эрх олгогдсон нийтийн эрх зүйн этгээд байдаг. Энэ утгаараа уг харилцаа нь тэгш бус бөгөөд төрийн чиг үүрэг, тэр дундаа гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийтийн эрх зүйн салбарт үүсдэг.

Захиргаа хуульд заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ нийтийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлж, захирамжилсан шийдвэр гаргаж, биелэлтийг нь албадлагын аргаар хангадаг учир тус харилцаанд давуу байдалтай оролцдог. Гэхдээ захиргааны шийдвэр бүхэн эрх зүйн үр дагавар үүсгэдэггүй бөгөөд эрх зүйн үр дагаваргүй шийдвэртэй холбогдуулан өргөдөл, гомдол гаргах боломжгүй байдаг талаар дурдъя. Ийм төрлийн шийдвэрт тухайн

байгууллагын дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалтын шинжтэй шийдвэрүүд хамаардаг.

Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд захиргааны байгууллагыг тодорхойлохдоо дан ганц гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаар хязгаарлаагүй бөгөөд үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрээс нь хамаарч захиргааны байгууллагатай адилтган үзэж болох зохицуулалтыг оруулсан байдаг.

Захиргааны байгууллага нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний акт гэсэн хэлбэрүүдээс сонгон хэрэглэх бөгөөд эдгээрээс сонгож хэрэглэх боломжгүй бол өөр бусад хэлбэрийг өөрөө тогтоодог. Өөр бусад хэлбэр гэдэг нь хуульд шууд заагаагүй бөгөөд тухайн нөхцөл байдалд нийцүүлэн боломжтой хэлбэрийг тогтоохыг ойлгоно. Аль хэлбэрээр шийдвэр гаргаж байгаагаас үл хамааран хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэр гаргах ажиллагаа явуулна. Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаа нь асуудлыг тодорхойлох, хувилбаруудыг үнэлж, сонголт хийх, шийдвэрийн төсөл боловсруулан баталгаажуулах, шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих гэсэн үе шаттай. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд үе шатыг хуульчлахдаа: ажиллагаа эхлэх, нөхцөл байдлыг тогтоох, нотлох баримт цуглуулах, сонсох ажиллагаа явуулах, шийдвэр гаргах гэж тодорхойлсон.

Судлаач миний бие энэхүү илтгэлийн хүрээнд захиргааны үйл ажиллагааны дээрх гурван хэлбэрээс “захиргааны хэм хэмжээний акт”-ийг чухалчилж үзэж буй.

Үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд, Монгол Улсын Үндсэн хуулиар Улсын Их Хуралд олгогдсон бүрэн эрхүүдээс төрийн зохих байгууллагад шилжүүлж болох эрх байхад үл шилжүүлж болох эрх буюу онцгой бүрэн эрх нь тухайлан заагдсан байдаг. Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1-д заасан УИХ-ын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх асуудалд хууль батлах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал багтсан. Нийгмийн суурь харилцааг хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээр зохицуулах боловч засаг захиргааны нэгж болон тодорхой салбарын өдөр тутмын харилцааг цаг тухайд нь бүрэн гүйцэд зохицуулах бодит боломж хууль тогтоогчид байдаггүйгээс үүдэн “тодорхой асуудлаар, хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаж зохицуулалт хийх эрхийг Засгийн газар, ховор тохиолдолд яам, агентлагийн түвшинд шилжүүлэх хэрэгцээ, тохиолдол байхыг үгүйсгэдэггүй. Үүнийг хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлж байна гэж тайлбарлах нь өрөөсгөл болох бөгөөд хууль болон захиргааны хэм хэмжээний актад адил шинжүүд байдаг хэдий ч хэм хэмжээний акт өөрөө зөвхөн хуулиар тусгайлан заагдсан нөхцөлд гарах боломжтой байдаг шинжээрээ эрэмбийн хувьд хуулиас доогуур байх нь маргаангүй юм.

Нөгөө талаар, хэм хэмжээний акт нь тухайн харилцаанд оролцогчдод чиглэсэн нийтлэг зохицуулалт агуулсан, шалгуур, үйл ажиллагааны шат дараалал, цаг хугацаа тогтоосон байдаг бөгөөд ирээдүйд үүсэх ижил тохиолдолд дахин давтагдан хэрэглэгдэх зэрэг шинжүүдээрээ хуультай адилтгах боломжтой. Түүнчлэн “нийгмийн харилцааг бүхэлд нь дан формаль хуулиар зохицуулах боломжгүй учир хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудыг батлан гаргадаг ба тэдгээр нь нийгмийн харилцааг мөн л зохицуулдаг тул "материаллаг хууль" хэмээн нэрлэх нь ч бий гэж зарим эрдэмтэн судлаачид дүгнэсэн нь байдаг.

Хэм хэмжээний актад "хууль нийцсэн байх, хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх шаардлага тавигдсанаас үзэхэд хуульд зааснаас өөрөөр шинээр эрх, үүрэг үүсгэсэн агуулгатай байх боломжгүй байна. Гэвч тухайн харилцаанд оролцогчдод чиглэсэн үйл ажиллагаа, цаг хугацааны тодорхой нөхцөл, шаардлага, хүрээ, хязгаар тогтоосон байх нь бий. Монгол Улсын Үндсэн хуулиар хууль батлах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг гагцхүү УИХ-д хадгалахаар зохицуулсан байгаагаас нь үзвэл хууль тогтоох эрхийг шилжүүлэхгүй байх" онолд суурилсан байгааг харж болох хэдий ч зарим нэг өөр

зүйл, хэсэгт төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага хэм хэмжээний зохицуулалт агуулсан шийдвэр гаргахыг зөвшөөрсөн байж болохоор байна.

Тухайлбал, Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2-т "Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие дааж шийдвэрлэж болно. Түүнчлэн, Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 3-т "Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно." гэсэн нь УИХ-ын онцгой бүрэн эрхэд хамаарахаас бусад асуудлаар нутгийн удирдлагын байгууллагуудад "эрх шилжүүлэх" боломжтойг тодорхойлсон явдал юм.

Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд захиргаа хэм хэмжээний акт гаргах замаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, Засгийн газрын тухай хуулийн 30.2-т заасан "Засгийн газар нь Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх эрх хэмжээний эрхийн акт гаргаж болно..." гэсэн зохицуулалт болон салбар хуулиудын холбогдох зохицуулалтын дагуу Засгийн газар болон нийтийн захиргааны байгууллагууд хэм хэмжээний акт гаргах эрх олгогдсон байдаг.

Захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх бүхий этгээдийг тодорхойлох асуудлын хувьд: ЗЕХ батлагдахаас өмнө нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон Засгийн газрын бус бие даасан агентлагуудын гаргасан хэм хэмжээний актыг Хууль зүйн яам Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан журамд нийцсэн эсэхэд бүрэн хяналт тавих боломжгүй байсан. Эдгээр байгууллага нь Засгийн газрын бүтцэд хамаардаггүй бөгөөд уг тогтоолд энэхүү журмыг хэм хэмжээний акт гаргах үедээ дагаж мөрдөхийг зөвлөсөн байдаг. Жишээ нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хэм хэмжээний шийдвэр гэдэг утгаар шүүхийн практикт агуулгын болон хэлбэрийн шаардлага хангаж байгаа эсэхийг Засгийн газрын байгууллагынхтай адилтган бүрэн шалган тогтоох боломжгүй байсаар ирсэн. Харин ЗЕХ батлагдсанаар хэм хэмжээний акт гаргаж буй бүх захиргааны байгууллага уг хуулиар тогтоосон хэм хэмжээний акт гаргах журам, шаардлагыг биелүүлсэн байх шаардлагатай юм.

Захиргааны хэм хэмжээний акт (normative administrative act) нь үйлчлэлийг нийтээр заавал дагаж мөрдөх, үйлчлэл нь давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн зохицуулалт бүхий хуулиар эрх олгогдсон захиргааны байгууллага, албан тушаалтнаас батлан гаргасан шийдвэр юм.

Захиргааны хэм хэмжээний актын хувьд эрх шилжүүлэх талаар онолын хувьд дэмжих болон үгүйсгэх хандлага байдаг. "Non-Delegation doctrine" буюу эрх шилжүүлэхийг үгүйсгэдэг үзэл санаа нь Ромын эрх зүйн нэг тулгуур ойлголт, "аксиом" бол "Po-testas delegate non potest delegari" төлөөлсөн эрх мэдлийг шилжүүлэн төлөөлөхгүй гэх ухагдахуун юм. Гэсэн хэдий ч нийгэм, эрх зүйн хөгжлийн явцад өөрчлөгдөж, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хэм хэмжээний актыг батлан гаргахыг хүлээн зөвшөөрөх болсон.

Захиргааны хэм хэмжээний актыг гаргаж буй үндэслэлээр дараах байдлаар ялгамжтай авч үзнэ. Үүнд:

1. Хуульд заасан үндэслэлээр гаргах хэм хэмжээний акт.

Уг акт нь хууль тогтоогчоос хуульд тусгайлан хэм хэмжээний актыг батлан гаргах эрх хэмжээг тогтоож өгсөн бөгөөд түүний дагуу эрх шилжүүлэн авсан этгээд хуулийн хэрэгжилтийг хангах, нэмэн дэлгэрүүлсэн зохицуулалт хийх үүднээс гаргасан акт. Хуулиар эрх шилжүүлэн олгогдсон хэм хэмжээний акт нь тус хуулийн зорилго үзэл баримтлалд нийцэн гарах ёстой.

2. Бие даан гаргах хэм хэмжээний акт.

Энэхүү хэм хэмжээний акт нь тухайн захиргааны байгууллагад хуулиар анхнаасаа олгогдсон бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулахдаа хэм хэмжээний актыг батлах эрхтэй байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно" гэж заасны дагуу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад хэм хэмжээний акт гаргах эрх хэмжээг олгож өгсөн байна.

Захиргааны хэм хэмжээний акт нь захиргааны үйл ажиллагааны нэг хэлбэр болохын хувьд тодорхой шаардлага тавигдана. Уг шаардлага нь захиргааны акт болон гэрээнд тавигдах шаардлагатай төсөөтэй боловч өөрийн онцлог зохицуулалт бүхий байна.

Хуульд үндэслэх зарчмын агуулгыг шинжлэх ухааны үүднээс авч үзвэл хэд хэдэн үндсэн шаардлагаар тодорхойлогддог.

Нэгдүгээрт, захиргааны байгууллага, албан тушаалтан нь зөвхөн хуульд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах шаардлагатай байдаг. Үүнийг эрх хэмжээний хамаарал гэж үздэг. Эрх хэмжээний хамаарал нь тухайн байгууллага, албан тушаалтан өөрт хуулиар олгогдоогүй эрх мэдлийг хэрэгжүүлэхийг хориглох, өөр байгууллагын эрх хэмжээнд халдахгүй байх, эрх мэдлээ хэтрүүлэхгүй байхыг шаарддаг. Хэрэв захиргааны байгууллага өөрт олгогдоогүй эрх мэдлийг хэрэгжүүлсэн тохиолдолд тухайн шийдвэр нь хууль зүйн үндэслэлгүйд тооцогдож, улмаар хүчингүй болох үндэслэл бүрддэг.

Хоёрдугаарт, чиг үүргийн хамаарал. Тухайн байгууллага, албан тушаалтан өөрт хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг шаарддаг. Энэ нь эрх хэмжээний ойлголттой нягт холбоотой боловч илүү тодорхой зорилтот чиглэлд хамаарах онцлогтой. Өөрөөр хэлбэл, байгууллага өөрийн үндсэн чиг үүрэгтэй холбоогүй асуудлаар шийдвэр гаргах нь хуульд үндэслэх зарчмыг зөрчсөнд тооцогдох боломжтой. Чиг үүргийн хүрээнээс хэтэрсэн шийдвэр нь тухайн байгууллагын үйл ажиллагааны зорилго, чиглэлийг алдагдуулах, эрх мэдлийн зөрчил үүсгэх эрсдэлийг дагуулдаг.

Гуравдугаарт, нутаг дэвсгэрийн хамаарал. Тухайн байгууллага, албан тушаалтан зөвхөн өөрт хамаарах нутаг дэвсгэрийн хүрээнд эрх мэдлээ хэрэгжүүлэхийг шаарддаг. Энэ шаардлага нь захиргааны байгууллагын харьяаллын хил хязгаарыг тодорхойлох, нэг байгууллага нөгөө байгууллагын харьяалалд хамаарах асуудалд хөндлөнгөөс оролцохоос сэргийлэх зорилготой. Нутаг дэвсгэрийн хамаарал зөрчигдсөн тохиолдолд тухайн шийдвэр нь эрх бүхий этгээдээс гараагүйд тооцогдож, хууль зүйн үр дагавар үүсгэх боломжгүй болох нөхцөл бүрддэг.

Дөрөвдүгээрт, хэлбэрийн шаардлага нь захиргааны шийдвэр нь хуульд заасан хэлбэр, журмын дагуу гарсан байхыг шаарддаг. Захиргааны шийдвэрийг тодорхой хэлбэрээр гаргах нь тухайн шийдвэрийн хууль ёсны байдлыг баталгаажуулах, шийдвэрийн ил тод байдлыг хангах, цаашид хянан шалгах боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Хэлбэрийн шаардлага зөрчигдсөн тохиолдолд тухайн шийдвэр нь албан ёсны шинж чанараа алдах, эсхүл хууль зүйн хүчин төгөлдөр байдлаа алдах эрсдэл үүсдэг.

Тавдугаарт, агуулгын шаардлага нь захиргааны шийдвэрийн агуулга хуульд нийцсэн байхыг шаарддаг. Энэ нь захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр нь хууль тогтоомжид нийцээгүй, эсхүл хуулийг буруу хэрэглэсэн байвал тухайн шийдвэр нь хууль бусад тооцогдох үндэслэл болдог. Агуулгын шаардлага нь захиргааны шийдвэрийн бодит утга, эрх зүйн үр дагавартай шууд холбоотой бөгөөд хууль зүйн маргаан үүсэх үндсэн шалтгааны нэг болдог.

Ийнхүү хуульд үндэслэх зарчим нь захиргааны байгууллагаас гаргах аливаа шийдвэрийг олон талаас нь хязгаарлан зохицуулах цогц шаардлагын тогтолцоог бүрдүүлдэг. Энэ зарчим нь зөвхөн захиргааны байгууллагын үйл ажиллагааг хуульд нийцүүлэх төдийгүй иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, төрийн үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль зүйн маргаан үүсэх эрсдэлийг бууруулахад онцгой ач холбогдолтой юм. Иймээс хуульд үндэслэх зарчмыг бодитой хэрэгжүүлэх нь захиргааны үйл ажиллагааны хууль ёсны байдлыг хангах үндсэн нөхцөл төдийгүй эрх зүйт төрийн тогтолцоог бэхжүүлэх чухал механизм гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд захиргааны байгууллагыг тодорхойлохдоо дан ганц гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаар хязгаарлаагүй бөгөөд үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрээс нь хамааруулах захиргааны байгууллагатай адилтган үзэж болох зохицуулалтыг оруулсан байдаг.

Захиргааны байгууллага нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний акт гэсэн хэлбэрүүдээс сонгон хэрэглэх бөгөөд эдгээрээс сонгож хэрэглэх боломжгүй бол өөр бусад хэлбэрийг өөрөө тогтоодог. Өөр бусад хэлбэр гэдэг нь хуульд шууд заагаагүй бөгөөд тухайн нөхцөл байдалд нийцүүлэн боломжтой хэлбэрийг тогтоохыг ойлгоно. Аль хэлбэрээр шийдвэр гаргаж байгаагаас үл хамааран хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэр гаргах ажиллагаа явуулна. Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаа нь асуудлыг тодорхойлох, хувилбаруудыг үнэлж, сонголт хийх, шийдвэрийн төсөл боловсруулан баталгаажуулах, шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих гэсэн үе шаттай. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд үе шатыг хуульчлахдаа: ажиллагаа эхлэх, нөхцөл байдлыг тогтоох, нотлох баримт цуглуулах, сонсох ажиллагаа явуулах, шийдвэр гаргах гэж тодорхойлсон.

Хуульд үндэслэх зарчим нь захиргааны үйл ажиллагааны хууль ёсны байдлыг хангах үндсэн баталгаа хэдий ч түүний бодит хэрэгжилт практикт жигд бус, тодорхой хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байна. Монгол Улсад захиргааны байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдсанаар захиргааны үйл ажиллагааг хуульд нийцүүлэх эрх зүйн орчин бүрдсэн боловч хуульд үндэслэх зарчмын хэрэгжилтэд тодорхой зөрчил, доголдол байсаар байна. (Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тайлан, 2022-2025)

Дээрх формаль болон материаллаг эрх зүйн шаардлагатай уялдуулан захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд тоочин хуульчилсан байдаг.

Захиргааны хэм хэмжээний акт нь хуультай төсөөтэйгөөр нийгмийн харилцааг байнгын давтан зохицуулдаг онцлогтой. Энэ утгаараа хуулийн төсөл боловсруулах, батлах ажиллагаатай төсөөтэй бөгөөд захиргааны хэм хэмжээний акт боловсруулан батлан гаргах үе шатыг явуулсны дараа батлан гаргаж, дагаж мөрддөг.

Захиргааны хэм хэмжээний актыг тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батлах бөгөөд бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хүргүүлнэ. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлнэ. Ийнхүү нийтэлснээр захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болох бөгөөд захиргааны хэм хэмжээний актад дагаж мөрдөх хугацааг өөрөөр зааж болно.

Хуульд заасан сонирхол татахуйц буюу захиргааны хэм хэмжээний актыг албан тушаалтнууд дурараа батлан гаргаж буй нэг шалтгаан гэж болохоор зохицуулалт нь “захиргааны хэм хэмжээний актыг нэн даруй батлах шаардлагатай хойшлуулшгүй тохиолдолд эрх бүхий захиргааны байгууллага уг актыг батлан гаргаж, нийтэд мэдээлснээр тухайн акт хүчин төгөлдөр болно гэсэн тусгай зохицуулалт юм. (Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль, 2015)

Ийнхүү батлан гаргаж буй захиргааны хэм хэмжээний акт нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 938 хуулийн хүрээнд нийцэн боловсруулагдаж, судлагдаж, хянагдаж, батлагдаж, бүртгэгдэж, нийтлэгдэж байж хүчин төгөлдөр болж, хүн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг ямар нэгэн байдлаар хөндсөн, захирамжилсан шийдвэр болж, биелэлт нь албадлагын аргаар хангагддаг.

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олон нийтэд танилцуулах үеэр тухайн үед Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан Б.Энхбаяр хэлэхдээ "Монгол Улсад 437 хууль хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Энэ хуулийн 300-д журам батлах эрх олгосон. Нийт 2500 журам батлахаар хуульчлагдсан байна. Улсын нэгдсэн бүртгэл 2591 журам бүртгэлтэй байна. 2018 онд манай улс 906 журамтай байсан бол сүүлийн хэдхэн жил 2500 болтлоо эрс нэмэгдсэн. Үүнд Хог хаягдлын тухай хууль, Малын тоо толгой, албан татварын тухай хууль, Эрчим хүчний тухай хуулиудаар 800 гаруй журмыг ИТХ батлахаар хуульчилсантай холбоотой байна. Энэ журмуудыг яам, агентлагаар нь авч үзэхэд 2300 журмын 33 хувь нь сайд нарын баталсан журам байгаа юм. Засгийн газраас 600 гаруй журам батлагдсан. БОАЖ, БХБЯ, Сангийн яам, ХЗДХЯ хамгийн олон журам баталжээ.

Засгийн газрын агентлагуудаас нийт 173 журам батлагдсан байна. Үүнээс ГЕГ, Татварын ерөнхий газар, мал эмнэлгийн газар хамгийн ихийг нь баталжээ. УИХ-ын харьяа байгууллага мөн цөөнгүй журам баталсан байсан. Эдгээрээс гадна ХЗДХ-ийн яаманд бүртгэлгүй 850 журам байгаа нь тогтоогдсон. Тиймээс Ерөнхий сайд улс төрийн шийдвэр гаргалаа. Нэгдүгээрт, ХЗДХ-ийн яаманд бүртгэлгүй 850 журмыг хүчингүйд тооцох шийдвэр гаргасан. Түүнчлэн одоо мөрдөгдөж буй 2500 журмыг хоёр дахин багасгахаар шийдвэрлэв. 1200 гаруй бүртгэлтэй журам хүчингүй болно. Ингэснээр 2000 журмыг хүчингүй болгох шийдвэр гаргалаа" гэжээ.

Мөн хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран "Захиргааны хэм хэмжээний акт ба хүний эрх" сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үеэр тухайн үед Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан Б.Энхбаяр хэлэхдээ "Засгийн газрын хуралдаанаар захиргааны хэм хэмжээний акт буюу бичил хуулиудыг яамд, сайд, Засаг дарга нар олноор нь үйлдвэрлэдэг байдлыг таслан зогсоох шийдвэр гаргасан. Тиймээс энэ шийдвэрийн дагуу одоо журмаар зохицуулж байгаа нийгмийн харилцаануудыг боломжтойг нь хуульчлах чиглэлд бүх яамд, агентлаг, байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. Манай улс журмын улс боллоо. Энэ нь өөрөө хүний эрхийн хамгийн том зөрчил гарах үндэс болоод байна. Эдгээр журмуудаар дамжуулж хуульд байхгүй эрхүүдийн өөрсдөдөө олж авахаас гадна хэм хэмжээ тогтоож байна. Үүгээр дамжуулж авлига, хүнд суртал бий болж байна. Тиймээс боломжтойг нь ард түмний төлөөллийн дээд байгууллага болох Улсын Их Хурлаар хэлэлцэж, хуульчлагдах ёстой харилцаануудыг зохицуулъя гэсэн байр суурьтай байна" гэсэн байдаг. (https://ikon.mn/n/34qc)

Мөн Улсын Их Хурлын даргын 2024 оны 75 дугаар захирамжаар байгуулагдсан Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, цэгцлэх талаар санал, дүгнэлт гарган холбогдох бусад хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс "Улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгаа"-ны дүнг 2025 оны 4 дүгээр сарын 08-ний өдөр УИХ-ын ажлын хэсэгт танилцуулсан.

Тус танилцуулгад: "Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд 2802 шийдвэр бүртгэгджээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2023 онд хийсэн судалгаагаар манай улсад 437 хууль хүчин төгөлдөр үйлчилж, тэдгээрээс 315 хуулийн 2403 заалтаар УИХ захиргааны хэм хэмжээний акт батлах эрхээ холбогдох байгууллагуудад шилжүүлсэн

зохицуулалттай явж ирсэн нь тогтоогджээ. Өөрөөр хэлбэл, хууль хэт ерөнхий зохицуулалттай болох тусмаа тухай асуудлыг журмаар зохицуулах эрхийг эрх бүхий албан тушаалтнуудад олгосон нь хуулиас давсан журмуудыг "үйлдвэрлэх" нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь иргэдэд дарамт шахалт үзүүлж, эрх чөлөөг нь боомилох, тэгш байдлын зарчим, хууль дээдлэх ёс алдагдахад хүргэж буйг судлаачид хэлсээр байгаа юм. Улсын нэгдсэн санд 110 гаруй байгууллагын 2357 шийдвэр бүртгэлтэй ч 850 хуулийн заалт хэрэгжсэн эсэх нь тодорхой бус, цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцэхээ больсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан зэрэг асуудлыг дагуулсаар иржээ. Ийнхүү УИХ-ын дарга Д.Амарбаясгалангийн ярьж буй хууль хүний эрхийн зөрчилгүй, иж бүрэн зохицуулалттай, цаг үеийн шаардлагад нийцсэн байх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, цэгцлэх ажлыг хийж эхэлж байна" (https://newspress.mn/v1/%D0%A3%D0%BB%D1%81) гэжээ.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал Улсын Их Хурлын хаврын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлсэн үгэндээ "Чөлөөлье" санаачилга, эрх чөлөөний дөрвөн зам, дөрвөн чөлөөлөлтийн бодлого хэрэгжүүлнэ … "эрх зүй, дүрэм, журмын чөлөөлөлт" гэж онцлон тэмдэглэхдээ дээр дурдсан журмуудыг хүчингүй болгох, зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байр суурийг илэрхийлсэн. (https://mongolia.gov.mn/news/view/27529)

Эдгээр үйл явдлаас харвал захиргааны хэм хэмжээний актыг боловсруулах явцад эрх зүйн зөрчил, техникийн алдаа, давхардал зэрэг эрсдэл багагүй үүсэж байна. Тиймээс эдгээрийг бууруулах, хянах шинэ арга хэрэгсэл нэвтрүүлэх шаардлага нэгэнт бий болжээ.

Дүгнэлт

Захиргаа хуульд заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ нийтийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлж, захирамжилсан шийдвэр гаргаж, биелэлтийг нь албадлагын аргаар хангадаг учир тус харилцаанд давуу байдалтай оролцдог.

Захиргааны хэм хэмжээний акт (normative administrative act) нь үйлчлэлийг нийтээр заавал дагаж мөрдөх, үйлчлэл нь давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн зохицуулалт бүхий хуулиар эрх олгогдсон захиргааны байгууллага, албан тушаалтнаас батлан гаргасан шийдвэр юм.

Захиргааны хэм хэмжээний актыг хуульд заасан үндэслэл шаардлагыг хангасан эсэхэд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлснээр тухайн захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болдог. Мөн захиргааны хэм хэмжээний актыг хойшлуулшгүй, нэн даруй батлах шаардлагатай гэж эрх бүхий захиргааны байгууллага үзсэн тохиолдолд уг актыг батлан гаргаж, нийтэд мэдээлснээр тухайн акт хүчин төгөлдөр болно. (Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль, 2015)

Ийнхүү батлан гаргаж буй захиргааны хэм хэмжээний акт нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт хууль, дүрэм, журмаар зохицуулсан зохицуулалттай давхардалгүй, зөрчилгүй боловсруулагдаж, судлагдаж, хянагдаж, батлагдаж, бүртгэгдэж, нийтлэгдэж байж хүчин төгөлдөр болж, тодорхой хэсэг бүлэг хүн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хуулийн дагуу хөндсөн захирамжилсан шийдвэр болох ёстой байтал практик байдалд үр дүн тийм биш байгаа нь 2023 оноос хойш Улсын Их Хурал, Засгийн газраас хийж, хэрэгжүүлж буй судалгааны үр дүнгээр нотлогдож байна.

Тэдгээр боловсруулалт дутуу, хяналт сул батлагдан гарч буй журмуудаар дамжуулж хуульд байхгүй эрхүүдийг албан тушаалтнууд өөрсдөдөө олж авахаас гадна хэм хэмжээ тогтоож байгаа нь авлига, хүнд суртал бий болгож байна. Өөрөөр хэлбэл, хууль хэт ерөнхий зохицуулалттай болох тусмаа тухай асуудлыг журмаар зохицуулах эрхийг эрх бүхий албан тушаалтнуудад олгосон нь хуулиас давсан

журмуудыг “үйлдвэрлэх”, нөхцөлийг бүрдүүлж байна.

Санал

Үүнээс ангижрахын тулд Монгол Улсад “Цахим Монгол”, “E-Mongolia”, “ТҮЦ машин”, “ХУР систем” зэрэг төрийн мэдээллийн дэд бүтэц амжилттай хөгжиж, ашиглагдаж байгаад суурилан дараах саналыг дэвшүүлж байна.

Үүнд:

- ЗХХА-ын төсөлд автоматаар дүн шинжилгээ хийх (хууль зүйн үндэслэл шалгах)
- Мэдээллийн дүн шинжилгээ хийж нийтэд ойлгомжтой байдлаар гаргах
- Эшлэл, заалтын зөрчил, давхардлыг илрүүлэх
- Иргэдийн санал, сэтгэгдлийг хиймэл оюун ухаанаар ангилж, дүгнэлт гаргах
- Актын бүртгэл, хяналтын процессыг автоматжуулах

Ашигласан материалын жагсаалт

- *https://ikon.mn/n/34qc.* (огноо байхгүй).
- *https://mongolia.gov.mn/news/view/27529.* (огноо байхгүй).
- *https://newspress.mn/* (огноо байхгүй).
- *Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тайлан.* (2022-2025).
- *Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль.* (2015).
- Цогтоо, Ш. (2021). *Монгол Улсын захиргааны эрх зүй.* УБ хот: 171.

ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ХҮНИЙ ЭРХ

PROTECTION OF HUMAN RIGHTS IN CIVIL JUDGMENT ENFORCEMENT PROCEEDINGS

Х.Энхтулга*
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын Академийн магистрант
Enkhtulga Kh.
A master's degree student, University of Internal Affairs

*Хариуцлагатай зохиогч: *enkhtulga.kha@gmail.com*

Хураангуй: Энэхүү судалгааны ажлын зорилго нь иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын үр нөлөө, хэрэгжилтийн бодит байдал болон тулгамдаж буй асуудлыг судлан тодорхойлох, цаашдын хөгжлийн чиг хандлагыг санал болгоход оршино. Судалгаанд хууль зүйн шинжилгээний аргуудыг ашиглаж, Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох дотоод, Олон Улсын эрх зүйн баримт бичгүүдийг харьцуулсан судалгаанд хамруулав.

Судалгааны үр дүнд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний нэр төр, өмчийн халдашгүй байдал, хувийн нууц, шударга шүүхээр хамгаалуулах эрх зэрэг үндсэн эрхүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь илэрсэн. Түүнчлэн албадан гүйцэтгэх арга хэмжээний хүрээнд эрхийн тэнцвэр алдагдах, гүйцэтгэгчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоо сул байгаа нь хүний эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймээс иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийн баталгааг бэхжүүлэх, хяналт-шинжилгээний механизмыг боловсронгуй болгох, шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшил, ёс зүйн стандартыг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэв.

Abstract: The purpose of this research is to examine the effectiveness of the legal regulations protecting human rights in civil court enforcement proceedings, to analyze the current state of their implementation, identify existing challenges, and propose future directions for development. The study employs legal analysis methods and includes a comparative examination of relevant legal sources such as the Constitution of Mongolia, the Law on Enforcement of Court Decisions, and related domestic and international legal instruments.

The findings reveal that the protection of fundamental human rights—such as human dignity, the inviolability of property, privacy, and the right to judicial protection—is not sufficiently ensured in the enforcement process. Furthermore, the imbalance of rights within compulsory enforcement measures, along with weaknesses in the ethical standards and accountability mechanisms of enforcement officers, creates conditions that may lead to violations of human rights. Therefore, it is necessary to strengthen the guarantees of human rights within civil enforcement proceedings, improve monitoring and oversight mechanisms, and enhance the professional competence and ethical standards of enforcement officers.

Түлхүүр үг: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хүний эрх, өмчлөх эрх, шударга шүүхээр хамгаалуулах эрх, албадан гүйцэтгэл.

Keywords: Enforcement proceedings, Human rights, Property rights, Right to a fair trial, Compulsory enforcement

Хүний эрх, эрх чөлөө нь ардчилсан нийгмийн үнэт зүйл, төрийн үйл ажиллагааны эрх зүйн болон ёс зүйн үндэс болдог. Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийн хэрэгжилт нь зөвхөн хууль тогтоомжийн түвшинд бус, түүний бодит биелэлт, практик хэрэгжилтээр хэмжигддэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний эрх зүйн харилцаанд гарсан маргааныг эцэслэн шийдвэрлэж, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх замаар хууль ёсны байдлыг хангах чухал механизм юм. Гэвч энэхүү ажиллагаанд төрийн албадлагын арга хэмжээ хэрэглэгдэх явцад

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

хүний нэр төр, өмчийн халдашгүй байдал, хувийн амьдралын нууц, шударга шүүхээр хамгаалуулах эрх зэрэг үндсэн эрхүүд зөрчигдөх эрсдэл байсаар байна.

Монгол Улсад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-д тулгуурлан хэрэгждэг боловч эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилтийн уялдаа, хүний эрхийн хяналт хангалтгүй байгаа нь судалгааны гол асуудал болж байна. Төрийн зүгээс хүний эрхийн хамгаалалтыг шийдвэр гүйцэтгэлийн шатанд бодитой хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт-шинжилгээний механизмыг сайжруулах шаардлагатай байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийн хэрэгжилтийн түвшин, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, түүнийг хамгаалах эрх зүйн баталгааг боловсронгуй болгох онол, практикийн санал дэвшүүлэхэд оршино.

Судалгааны хүрээнд Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, НҮБ-ын “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, бусад олон улсын баримт бичгүүдийг ашиглан эрх зүйн шинжилгээ, харьцуулалт, задлан шинжилгээний аргуудыг хэрэглэв.

Судалгааны объект нь иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бөгөөд судалгааны предмет нь уг ажиллагаанд хүний эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн практик байдал юм.

Судалгааны ажил нь гурван бүлэгтэй байна. Нэгдүгээр бүлэгт иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс, онолын ойлголтыг, хоёрдугаар бүлэгт хүний эрхийн хэрэгжилтийн бодит байдал болон тулгамдаж буй асуудлыг, гуравдугаар бүлэгт хүний эрхийг хамгаалах эрх зүйн болон институцийн тогтолцоог боловсронгуй болгох санал, зөвлөмжийг тусгав.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т зааснаар Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно; (Монгол Улсын Үндсэн хууль, 1992)

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6-т зааснаар зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон шүүх шинжилгээний байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүх шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн, гадаадын иргэн, харьяатын байгууллагын ажилтан; (Төрийн албаны тухай хууль, 2017)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257 дугаар зүйлийн 257.1-т зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017) гэж заасан байна.

Бүлэг I. Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний эрх зүйн харилцаанд үүссэн маргааныг эцэслэн шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг бодитоор хэрэгжүүлэх төрийн албадлагын арга хэмжээний нэг хэлбэр юм.

Энэхүү ажиллагаа нь хууль ёсны байдлыг хангах, иргэний эрх, өмч, эрх зүйн баталгааг хамгаалахад чиглэгддэг.

Монгол Улсын эрх зүйн орчинд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль" (2017 он) зохицуулдаг бөгөөд үүний дагуу шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд төрийн албадлагын бүрэн эрхтэй этгээд болдог. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гол зорилго нь:

1. Шүүхийн шийдвэрийг хугацаанд нь, бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэх;
2. Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах;
3. Нийгмийн шударга ёсыг хангах, хууль сахиулах.

Энэхүү эрх зүйн зохицуулалт нь үндсэн хуульд заасан хүний эрхийг хамгаалах зарчимтай салшгүй холбоотой. Үүнд:

- **Хууль дээдлэх зарчим** – төрийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд явагдах;
- **Нэр төрийг хүндэтгэх эрх** – хувь хүн болон байгууллагын нэр төр, нэр хүндийг хамгаалах;
- **Өмчийн халдашгүй байдал** – хувийн болон төрийн өмчийг зөвшөөрөлгүй хураахгүй байх;
- **Шударга шүүхээр хамгаалуулах эрх** – шүүхийн шийдвэрт эсэргүүцэх, гомдол гаргах эрх.

Олон улсын жишгээр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцооны эрх зүйн зохицуулалт нь Германд "Zwangsvollstreckung" хуулиар, Япон улсад "Civil Execution Law"-аар, ОХУ-д "Исполнительное производство" журмаар зохицуулагддаг бөгөөд хүний эрхийн баталгаа, гүйцэтгэх ажиллагааны хязгаарлалт, хяналтын механизмыг нарийн тусгасан байдаг. Монгол Улсын хууль эрх зүйн орчинд эдгээр олон улсын стандартуудыг бүрэн нутагшуулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байсаар байна.

Бүлэг II. Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийн хэрэгжилтийн байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийн зөрчил гарч болзошгүй гол шалтгаан нь эрх зүйн зохицуулалт болон практик хэрэгжилтийн сул тал юм. Судалгааны явцад дараах төрлийн зөрчил хамгийн түгээмэл байгааг тэмдэглэж болно:

1. **Өмчийн эрхийг зөрчих** – Хувийн болон төрийн өмчийг хураах, түр эзэмших үйл ажиллагаа нь зарим тохиолдолд хууль ёсны баталгаагүйгээр хийгддэг.
2. **Нэр төр, хувийн амьдралын халдашгүй байдал** – Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хувь хүний нэр төр, хувийн мэдээлэл, гэр бүлийн нууцад халдаж болзошгүй.
3. **Шударга шүүхээр хамгаалуулах эрхийн хязгаарлалтууд** – Иргэд шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд эсэргүүцэх, гомдол гаргах эрхээ мэддэггүй, хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал.

Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гаргасан судалгаагаар нийт гомдлын 35-40% нь хүний эрхийн зөрчлийг хамарч байна. Голлон: шийдвэр гүйцэтгэгчийн мэдлэг, мэргэшлийн дутагдал, хяналт-шинжилгээний сул тал, эрх зүйн ойлголт, аргачлалын дутагдал зэрэг шалтгаанаас үүдэлтэй байна.

Энэ бүлэгт мөн **хэрэгжиж буй хууль, дүрэм, хяналтын байгууллагуудын үүрэг** судлагдсан. Тухайлбал, **Хүний эрхийн Үндэсний комисс**, **Шүүхийн захиргааны газар**, **Шийдвэр гүйцэтгэх газрын дотоод хяналт** зэрэг байгууллагууд хүний эрхийн хамгаалалт, зөрчлийг урьдчилан сэргийлэх үүрэгтэй боловч практикт үр дүн хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна.

Бодит жишээ:

- Иргэний шүүхийн шийдвэрээр өмч хураах ажиллагаанд тухайн иргэний зөвшөөрлийг авалгүй, хуульд заасан хугацаа, мэдээллийн зааврыг зөрчсөн тохиолдол гарч байна.
- Тухайн иргэний эсэргүүцэл, гомдлыг шийдвэрлэх ажиллагаа удаан хугацаанд хийгддэг тул хүний эрхийн ноцтой хохирол үүсэж байна.

Эдгээр нөхцөл байдал нь **шинжилгээ хийхэд гол асуудал**, түүнд дүн шинжилгээ хийх, хууль эрх зүйн зохицуулалтыг

боловсронгуй болгох шаардлагыг тодруулж өгдөг.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, гомдлын дүнгийн шинжилгээ (Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, 2025)

1. **Нийт өргөдөл, гомдлын хэмжээ:**

1. 2024 онд нийт 1643 өргөдөл, гомдол ирсэн (1146 хүсэлт, 497 гомдол)

2. 2025 оны 10 сарын байдлаар нийт 1855 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд үүнээс:

- Хүсэлт-1259 (67,8%)
- Гомдол-583 (31,5%)
- Талархал-13 (0,7%)

Үүнээс харахад иргэдийн гомдлын тоо 2025 онд өссөн ба нийт өргөдөл, гомдлын ихэнх нь хүсэлт хэлбэрээр ирж байгаа нь ажиглагдаж байна.

2. **Гомдлын ангилал:**

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой-509
2. Ёс зүйтэй холбоотой-12
3. Албадан дуудлага худалдаатай холбоотой-49
4. Гадаадад зорчих эрх түдгэлзүүлэх тогтоолыг хүчингүй болгуулах-13

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол нийт гомдлын 87,3%-ийг эзэлж байна. Энэ нь иргэдийн гол санаа зовнилоо тусгаж байна.

Хүсэлтийн ангилал:

- Эд хөрөнгийн эрх сэргээх-245
- Дансны зарлагын гүйлгээг сэргээх-17
- Гадаадад зорчих эрх-314
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа сэргээлгэх-31
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эрчимжүүлэх-391
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзүүлэх-72
- Албадан дуудлага худалдааг хойшлуулах-37
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болгох-24
- Дансаар мөнгө авах-9
- Эрүүгийн хэрэг үүсгүүлэх тухай-3
- Төлбөр төлөлтийн талаар-3
- Мэдээлэл авах-113

Иргэдийн хүсэлтийн ихэнх нь **шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх, гадаадад зорчих эрхтэй холбоотой**, мөн эд **хөрөнгийн эрх сэргээх, мэдээлэл авах** зэрэг асуудлуудад төвлөрсөн байна.

Бүлэг III. Хүний эрхийг хамгаалах эрх зүйн баталгааг боловсронгуй болгох арга зам

Энэхүү бүлэгт судлаач санал дэвшүүлж, хүний эрхийн хамгаалалтыг сайжруулах **эрх зүйн болон институцийн механизм**-ыг авч үзнэ.

1. **Хууль эрх зүйн шинэчлэл**

○ Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үеийн хүний эрхийг илүү нарийн тусгасан хуулийн заалтуудыг боловсронгуй болгох.

○ Өмч, нэр төр, хувийн амьдралын халдашгүй байдлыг хамгаалах тусгай журам боловсруулах.

2. **Шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшил, ёс зүйг сайжруулах**

○ Албан хаагчдын сургалт, сертификатжуулалт;

○ Ёс зүйн дүрэм, хариуцлагын тогтолцоог бий болгох.

3. **Хүний эрхийн хяналтын механизмыг боловсронгуй болгох**

○ Иргэний гомдол, эсэргүүцлийг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх систем;

○ Шүүхийн болон төрийн бус байгууллагуудын хяналтын уялдаа сайжруулах.

4. **Олон улсын туршлагыг нутагшуулах**

○ Герман, Япон, ОХУ-ын сайн туршлагыг судалж, Монгол Улсын онцлогт тохируулан хэрэгжүүлэх;

○ Иргэдийн эрхийг хамгаалах дээд түвшний стандартыг бий болгох.

Эдгээр арга хэмжээ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийг хамгаалах баталгааг нэмэгдүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжийг бүрдүүлнэ.

Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлаар иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх хэрхэн хамгаалагдаж буйг судалж, эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилтийн нөхцөл байдлыг шинжиллээ.

Судалгааны гол дүгнэлтүүдийг доор дурдлаа.

1. **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт**

○ Монгол Улсын хууль эрх зүйн орчинд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулсан хууль, дүрэм, журам байгаа хэдий ч хүний эрхийг хамгаалах нарийн зохицуулалт хангалтгүй байна.

○ Олон улсын туршлагаас харахад Монгол Улсад хүний эрхийн хамгаалалтын стандарт, хяналтын механизм нь дутмаг бөгөөд практик хэрэгжилтэд хүндрэл үүсгэж байна.

2. **Хүний эрхийн хэрэгжилтэд тулгамдсан асуудлууд**

○ Иргэний өмч, нэр төр, хувийн амьдралын халдашгүй байдалд халдаж болзошгүй зөрчил гарч байна.

○ Шийдвэр гүйцэтгэх явцад иргэдийн эсэргүүцэл, гомдол гаргах эрх бүрэн хэрэгждэггүй.

○ Хүний эрхийн зөрчил ихэвчлэн шийдвэр гүйцэтгэгчийн мэдлэг, мэргэшлийн дутагдал, хяналтын сул механизмээс үүдэлтэй.

3. **Судалгааны үндсэн дүгнэлт**

○ Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийг хамгаалах эрх зүйн баталгааг боловсронгуй болгох шаардлага тодорхой байна.

○ Хүний эрхийг хамгаалах тогтолцоог сайжруулахын тулд хууль эрх зүйн шинэчлэл, шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшил, ёс зүй, хяналтын механизмыг сайжруулах шаардлагатай.

○ Судалгааны үр дүн нь төрийн байгууллагууд, шүүхийн захиргаа, хүний эрхийн хамгаалалт хариуцсан байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөмж гаргахад үндэс болно.

Ерөнхийд нь дүгнэхэд, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нийгмийн шударга ёс, хууль дээдлэх зарчимд чухал үүрэг гүйцэтгэдэг ч хүний эрхийн хамгаалалт практикт бүрэн хангагдаагүй байна. Судалгааны үр дүн нь эрх зүйн шинэчлэл, институцийн сайжруулалт хийх шаардлагыг онцолж, хүний эрхийг хамгаалах баталгааг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлж байна.

Санал

Судалгааны үр дүнд үндэслэн иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, эрх зүйн зохицуулалт болон практик хэрэгжилтийг сайжруулахад дараах арга хэмжээг санал болгож байна.

Нэгдүгээрт, ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх: гүйцэтгэлийн явцыг цахим системээр хянах, иргэдэд мэдээлэл хүргэх, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх.

Хоёрдугаарт, иргэдийн гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгох, хариу өгөх хугацаа, чанарт хяналт тавих.

Гуравдугаарт, шийдвэр гүйцэтгэгчдийн мэргэшил, ёс зүйн стандартыг дээшлүүлж, сургалт, давтан сургалт, хариуцлагын механизмыг сайжруулах.

Дөрөвдүгээрт, хяналт-шинжилгээний тогтолцоог бэхжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, иргэдтэй харилцах сувгийг өргөжүүлэх.

Тавдугаарт, олон улсын хүний эрхийн сайн туршлагыг нутагшуулах, үндэсний хууль тогтоомжид нэвтрүүлж, хүний эрхийг хамгаалах үндэсний стандарт, аргачлалыг боловсруулах.

Эдгээр арга хэмжээ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлж, хүний эрхийг хамгаалах баталгааг бэхжүүлэхэд чиглэнэ.

Ашигласан ном зүй

1. **Монгол Улсын Үндсэн хууль.** – Улаанбаатар: Улсын Их Хурал, 1992 он.

2. **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.** – Улаанбаатар: Улсын Их Хурал, 2017 он.

3. **Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.** – Улаанбаатар: Улсын Их Хурал, 2016 он.

4. **Хүний эрхийн тухай хууль.** – Улаанбаатар: Улсын Их Хурал, 1998 он.

5. **Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын 2023 оны үйл ажиллагааны тайлан.** – Улаанбаатар, 2024 он.

6. Батбаяр, Д. *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт ба хүний эрхийн баталгаа.* – УБ: Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2021 он.

7. Баярмаа, Г. *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны онол, практикийн асуудлууд.* – УБ: МУИС-ийн Хууль зүйн сургууль, 2020 он.

8. Лүндээжанцан, Д. *Хүний эрх ба Монгол Улсын хууль тогтоомжийн шинэчлэл.* – УБ: Адмон хэвлэл, 2019 он.

9. Хүний эрхийн Үндэсний Комисс. *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэл (2023).* – УБ, 2024 он.

10. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын өргөдөл, гомдол хүлээн авсан судалгаа. – УБ 2024 он, 2025 он

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХУУЛИЙН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧДЫН ШҮҮХ СЭТГЭЦ ЭМГЭГ СУДЛАЛЫН МЭДЛЭГ, ХАНДЛАГЫН СУДАЛГАА

A STUDY ON THE KNOWLEDGE AND ATTITUDES OF LAW SCHOOL STUDENTS TOWARDS FORENSIC PSYCHIATRY

Ц.Нандинцэцэг*
Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн Байгалийн ухаан, техник зүйн шинжилгээний тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч
Nandintsetseg Ts.
University of Internal Affairs, Department of Natural Science and Technical Expertise, School of forensic Science, Senior Lecturer, Police Major

*Хариуцлагатай зохиогч: nandintsetseg779@gmail.com

Хураангуй: Шүүх сэтгэц эмгэг судлал нь сэтгэц эмгэг судлал болон хууль зүйн салбарын зааг дахь хэрэглээний шинжлэх ухаан бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээх чадвар, иргэний эрх зүйн чадамж, шүүх сэтгэцийн шинжилгээ, албадан эмчилгээ зэрэг шударга шүүхийн суурь асуудлуудыг хамардаг. Ирээдүйн хуульч, шүүгч, прокурор, өмгөөлөгч тус салбарын суурь мэдлэг, эерэг хандлагыг эзэмшсэн байх нь хүний эрхийг хамгаалах, шударга ёсыг тогтооход онцгой ач холбогдолтой. Зорилго. Дотоод хэргийн их сургуулийн хуулийн сургуулийн суралцагчдын шүүх сэтгэц эмгэг судлалын талаарх мэдлэгийн түвшин, хандлагыг үнэлж, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлоход судалгааны зорилго оршино. Арга зүй. Судалгааг нэг агшны загвараар гүйцэтгэв. Дотоод хэргийн их сургуулийн Хуулийн сургуулийн III курсийн 51 суралцагчийг түүвэрт хамруулж, нийгэм-хүн ам зүйн мэдээлэл, мэдлэгийн 12, хандлагын 10 асуулт бүхий стандартчилсан асуумжаар мэдээлэл цуглуулав. Цуглуулсан өгөгдлийг SPSS статистик программ ашиглан тоо, хувь, дундаж стандарт хазайлтаар илэрхийлж, бүлэг хооронд t-итгэлцүүрээр харьцуулсан. Үр дүн. Судалгаанд хамрагдагсдын 80.4% нь эмэгтэй, дундаж нас 20.8 ± 0.8 байв. Мэдлэгийн дундаж оноо 12-аас 11.71 ± 0.61 (97.5%) буюу нэн өндөр түвшинд тогтоогдсон бөгөөд хүйс, өмнөх хичээлийн хамрагдалтаар статистикийн ач холбогдол бүхий ялгаа илрээгүй. Оролцогчдын 96.1% нь хичээлийг хөтөлбөрт оруулахыг, 94.1% нь хуульч мэргэжилтэн суурь мэдлэгтэй байхыг дэмжсэн хэдий ч сэтгэцийн эмгэгтэй хүнтэй хамтран ажиллахад тааламжтай гэж дөнгөж 29.4% нь хариулсан нь далд стигма хадгалагдаж буйг илтгэв. Дүгнэлт. Суралцагчдын онолын мэдлэг өндөр, хандлага голчлон эерэг боловч далд стигма арилаагүй байна. Иймд хуулийн сургуулийн хөтөлбөрт тус салбарыг тогтмол хичээлээр оруулах, эмнэлгийн дадлага болон стигма бууруулах зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх нь үндэслэлтэй.

Abstract: Forensic psychiatry, at the intersection of law and psychiatry, is essential; future lawyers need foundational knowledge to uphold justice. Objective. To assess law students' knowledge and attitudes toward forensic psychiatry. Methods. A cross-sectional descriptive study. Fifty-one third-year students completed an online questionnaire with 12 knowledge and 10 attitude items, analyzed in SPSS using counts, percentages, means±SD, and t-tests. Results. Of participants, 80.4% were female (mean age 20.8±0.8). The mean knowledge score was very high at 11.71±0.61 (97.5%). Adding the course was supported by 96% and foundational knowledge for lawyers by 94%. However, only 29% felt comfortable working with mentally ill persons, indicating latent stigma. Conclusion. Knowledge and attitudes were largely positive, but latent stigma persisted; integrating a regular course and clinical practicum is recommended.

Түлхүүр үг: Шүүх сэтгэц эмгэг судлал, хуулийн оюутан, мэдлэг, хандлага, стигма.
Keywords: Forensic psychiatry, law student, knowledge, attitude, stigma.

Шүүх сэтгэц эмгэг судлал нь сэтгэц эмгэг судлал болон хууль зүйн салбарын зааг дахь хэрэглээний шинжлэх ухаан бөгөөд эрүүгийн болон иргэний хэрэг

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжлэх ухааны үндэслэлтэй мэргэжлийн дүгнэлт гаргах үүрэг бүхий салбар юм (Нандинцэцэг, Ц. 2025). Уг салбар нь гэмт хэрэг үйлдэгдэх үеийн сэтгэцийн төлөв байдал, эрүүгийн хариуцлага хүлээх чадвар, иргэний эрх зүйн чадамж, албадан эмнэлгийн чанартай арга хэмжээний үндэслэл зэрэг асуудлуудыг шинжлэн судалдаг (Gowensmith et al., 2013).

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлд сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн ач холбогдлыг ухамсарлах буюу удирдан жолоодох чадваргүй байсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй болохыг, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүх сэтгэцийн шинжилгээ томилох, хийх журмыг тус тус хуульчлан заасан байдаг (Монгол Улсын Их Хурал, 2015, 2017). Иймээс хуулийн мэргэжилтэн эдгээр эрх зүйн ойлголтыг үйл ажиллагаандаа зөв хэрэглэх нь шударга шүүхийн зарчмыг хангах нэгэн үндэс болдог.

Гадаад орнуудад хийгдсэн судалгаагаар хуулийн оюутнуудын шүүх сэтгэц эмгэг судлалын мэдлэг дунд зэргээс доош түвшинд байгаа нь тогтоогдсон (Singh et al., 2018; Adeyemo et al., 2020). Харин хичээлийн хөтөлбөрт тус салбарыг тусгасны дараа оюутнуудын мэдлэг, эерэг хандлага мэдэгдэхүйц дээшилсэн болохыг судлаачид нотолжээ (Gordon & Lindqvist, 2019). Монгол Улсын хэмжээнд хуулийн оюутнуудын энэ салбарын мэдлэг, хандлагыг тодорхойлсон судалгаа цөөн хийгдсэн нь судалгааны цоорхойг үүсгэж байна.

Дээрх үндэслэлд тулгуурлан, энэхүү судалгааны зорилгыг Дотоод хэргийн их сургуулийн Хуулийн сургуулийн III курсийн суралцагчдын шүүх сэтгэц эмгэг судлалын суурь мэдлэг, хандлагын түвшинг тодорхойлж, хөтөлбөрийг боловсронгуй болгох үндэслэл бүхий санал боловсруулахад чиглүүлэв.

Судалгааны зорилт

1. Дотоод хэргийн их сургуулийн хуулийн оюутнуудын шүүх сэтгэц эмгэг судлалын суурь ойлголтуудын мэдлэгийн түвшинг үнэлэх;

2. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс болон шүүх сэтгэцийн шинжилгээний талаарх оюутнуудын хандлагыг тодорхойлох;

3. Мэдлэг, хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийг (хүйс, өмнөх хичээлийн хамрагдалт) илрүүлэх;

4. Дотоод хэргийн их сургуулийн Хуулийн сургуулийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах холбогдох санал боловсруулах.

Судалгааны загвар, хамрах хүрээ:

Энэхүү судалгааг нэг агшны загвартай тоон судалгааны хэлбэрээр гүйцэтгэв. Судалгааны объектоор Дотоод хэргийн их сургуулийн Хуулийн сургуулийн III курсийн суралцагчдыг сонгож, нийт 51 оюутныг сайн дурын зөвшөөрөлд үндэслэн түүвэрт хамруулсан. Судалгаанд хамрагдсад нь Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн III курсийн суралцагч нар байв.

Судалгааны хэрэглэгдэхүүн:

Судалгааны хэрэглэгдэхүүн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй асуумжийг судалгааны хэрэгсэл болгон ашиглав.

• I хэсэг – Нийгэм-хүн ам зүйн мэдээлэл: нас, хүйс, курс, сургууль, холбогдох хичээл өмнө судалсан эсэх.

• II хэсэг – Мэдлэгийн шалгуур (12 асуулт): олон сонголттой хэлбэрийн асуулт. Зөв хариулт нэг оноо, буруу буюу мэдэхгүй хариултыг тэг оноогоор үнэлж, нийт оноог 0–12 хооронд тооцов.

• III хэсэг – Хандлагын шалгуур (10 асуулт): Ликертийн 5 шатлалт хэмжүүр. Стигма агуулсан асуултын (A3, A10) оноог урвуу шилжүүлэн боловсруулсан. Асуумжийг Google Forms цахим хэлбэрээр түгээж, мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулсан.

Судалгааны статистик боловсруулалт

Google Forms цахим хэлбэрээр цуглуулсан өгөгдлийг SPSS Statistics статистик программ ашиглан боловсруулав. Тоон үзүүлэлтийг дундаж стандарт хазайлт, категори үзүүлэлтийг тоо (n) болон хувь (%) хэлбэрээр илэрхийлсэн. Бүлэг хоорондын ялгааг t-утгыг тогтоож,


$p<0.05$ утгыг статистикийн ач холбогдолтой гэж үзэв.

Судалгааны ёс зүй

Судалгаанд оролцогч бүр мэдээлэлд тулгуурласан зөвшөөрөл авсан. Оролцогчдын хариултыг нэр нууцлах зарчмын дагуу цуглуулж, цуглуулсан мэдээллийг гагцхүү судалгааны зорилгоор ашигласан. Судалгааг Дотоод хэргийн их сургуулийн судалгааны ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлж, зөвшөөрөл авч гүйцэтгэв.

Судалгааны үр дүн

Судалгаанд нийт 51 суралцагч хамрагдсанаас 80.4% нь эмэгтэй, дундаж нас 20.8±0.8 байв. Оролцогчдын 64.7% нь холбогдох хичээлийн өмнө судалсан болохоо илэрхийлсэн (Зураг 1, Хүснэгт 1).



Зураг 1. Оролцогчдын хүйс ба өмнөх хичээл судалсан байдал (n=51)

Хүснэгт 1. Оролцогчдын нийгэм-хүн ам зүйн шинж чанар (n=51)

Үзүүлэлт	Тоо (n)	Хувь (%)
Хүйс — Эмэгтэй	41	80.4
Хүйс — Эрэгтэй	10	19.6
Курс — III курс	51	100.0
Өмнө хичээл судалсан — Тийм	33	64.7
Өмнө хичээл судалсан — Үгүй	18	35.3
Дундаж нас (M±SD)	20.8 ± 0.8	—

Мэдлэгийн дундаж оноо 12-аас 11.71±0.61 (97.5%) буюу нэн өндөр түвшинд тогтоогдов. Оролцогчдын 76.5% нь бүх 12 асуултад зөв хариулсан бөгөөд 96.1% нь 11-ээс дээш оноо авсан байна. Асуулт тус бүрийн зөв хариултын хувийг Зураг 2-т, мэдлэгийн онооны тархалтыг Зураг 3-т тус тус харуулав.




Зураг 2. Мэдлэгийн асуулт тус бүрийн зөв хариултын хувь



Зураг 3. Мэдлэгийн онооны тархалт (тааз нөлөө илэрсэн)

Хамгийн доод үзүүлэлт нь "Эрүүгийн хариуцлага хүлээх чадвар" асуултад (78.4%) бүртгэгдсэн бол бусад 11 асуултад 98–100% зөв хариулсан байна. Мэдлэгийн оноог хүйсээр (эрэгтэй 11.90±0.32; эмэгтэй 11.66±0.66; p=0.102) болон холбогдох хичээлийн өмнөх хамрагдалтаар (судалсан 11.73±0.45; судлаагүй 11.67±0.84; p=0.779) харьцуулахад статистикийн ач холбогдол бүхий ялгаа илрээгүй. Судалгаанд хамрагдагсад бүгд III курсийн байсан тул курсийн түвшнээр харьцуулах боломжгүй байв.

Хандлагын үнэлгээгээр оролцогчдын 96.1% нь хичээлийг хөтөлбөрт оруулах (M=4.73), 100% нь шинжилгээ нь шударга ёсонд зайлшгүй (M=4.90), 94.1% нь хуульч мэргэжилтэн суурь мэдлэгтэй байх ёстой (M=4.67) гэж тус тус үзжээ. Үүний зэрэгцээ, сэтгэцийн эмгэгтэй хүнтэй хамтран ажиллахад тааламжтай гэж дөнгөж 29.4% нь хариулсан (M=2.84) нь оролцогчдын дунд далд стигма хадгалагдаж буйг илтгэв.
(Зураг 4, Хүснэгт 2).



Зураг 4. Хандлагын асуултуудын дундаж оноо (Ликерт 1–5)

Хүснэгт 2. Хандлагын асуултуудын дундаж оноо ба санал нийлсэн хувь (n=51)

Хандлагын мэдэгдэл	Дундаж (M±SD)	Санал нийлсэн (%)
Хичээл оруулах ёстой	4.73±0.70	96.1
Шинжилгээ шударга ёсонд зайлшгүй	4.90±0.30	100.0
Өвчтэй хүн хүчирхийлэл их (урвуу)	4.00±1.06	68.6
Өвчтэй хүнтэй ажиллах тааламжтай	2.84±1.47	29.4
Эмгэг бол гэмт хэргийн "шалтаг" биш	4.61±0.80	88.2
Албадан эмчилгээ зүй ёсны шаардлагатай	4.53±0.73	86.3
Дүгнэлтийг шүүгч заавал баримтлах	4.43±0.76	84.3
Хуульч суурь мэдлэгтэй байх ёстой	4.67±0.59	94.1
Өмгөөлөл нэн нарийн анхаарал шаардана	4.47±0.78	86.3
Кино/сүлжээнээс мэдээлэл хангалттай (урвуу)	2.76±1.42	29.4

Судалгаанд хамрагдсан Дотоод хэргийн их сургуулийн Хуулийн суралцагчдын мэдлэгийн дундаж оноо 97.5% буюу нэн өндөр түвшинд тогтоогдсон нь Singh нарын (2018) Энэтхэгийн судалгааны 51.3%, Adeyemo нарын (2020) Нигерийн судалгааны 48.7%-аас эрс өндөр үзүүлэлт юм. Гэвч энэхүү өндөр үзүүлэлтийг болгоомжтой тайлбарлах шаардлагатай. Оролцогчдын 64.7% нь холбогдох хичээлийг өмнө судалсан байсан нь нэгэн боломжит шалтгаан хэдий ч, асуумжийн зөв хариултын байрлал ижил төстэй байсан нь хариултыг таах магадлалыг нэмэгдүүлж, улмаар үүсгэсэн байж болзошгүй (Зураг 3, доорх хязгаарлалтын хэсгийг үзнэ үү).

Хүйс болон холбогдох хичээлийн өмнөх хамрагдалтаар мэдлэгийн ялгаа илрээгүй нь онооны тархалт дээд хязгаарт хэт төвлөрсөн (range restriction) байдалтай холбоотой бөгөөд энэ нь тааз нөлөөний нэгэн илрэл болж байна.

Хандлагын үнэлгээгээр эерэг дүр зураг давамгайлсан: оролцогчдын 96.1% нь хичээлийг хөтөлбөрт оруулахыг, 94.1% нь хуульч мэргэжилтэн суурь мэдлэгтэй байхыг тус тус дэмжсэн. Гэвч хамгийн анхаарал татаж буй үзүүлэлт нь сэтгэцийн эмгэгтэй хүнтэй хамтран ажиллахад

тааламжтай гэж дөнгөж 29.4% нь хариулсан явдал юм (Зураг 4). Энэ нь оюутнууд онолын мэдлэгтэй хэдий ч бодит харилцаанд далд стигма хадгалагдаж буйг харуулж байна. Сэтгэцийн өвчний талаарх хэвлэл мэдээллийн буруу дүрслэл ийнхүү нийгмийн зайг бэхжүүлдэг болохыг Stuart (2017) тэмдэглэсэн нь энэ дүгнэлтийг дэмжинэ.

Түүнчлэн, оролцогчдын 29.4% нь хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээнээс мэдээлэл авахад хангалттай гэж үзсэн нь албан бус эх сурвалжид түшиглэх хандлага байгааг илтгэв. Иймд сурах бичиг, эрдэм шинжилгээний эх сурвалжийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь зүйтэй болохыг харуулж байна.

Дүгнэлт

1. Дотоод хэргийн их сургуулийн Хуулийн сургуулийн III курсийн 51 суралцагчдын шүүх сэтгэц эмгэг судлалын мэдлэгийн дундаж түвшин 97.5% буюу нэн өндөр тогтоогдсон хэдий ч энэ нь нөлөөтэй холбоотой байж болзошгүй болохыг анхаарвал зохино.

2. Хүйс болон холбогдох хичээлийн өмнөх хамрагдалтаар мэдлэгийн статистикийн ач холбогдол бүхий ялгаа илрээгүй.

3. Оролцогчдын дийлэнх (94.1–96.1%) нь хичээлийг хөтөлбөрт оруулах, хуульч мэргэжилтэн суурь мэдлэгтэй байхыг дэмжсэн нь эерэг хандлага давамгайлж буйг харуулж байна.

4. Сэтгэцийн эмгэгтэй хүнтэй хамтран ажиллахад тааламжтай гэж дөнгөж 29.4% нь хариулсан нь онолын мэдлэгтэй атлаа бодит харилцаанд далд стигма хадгалагдаж буйг илтгэв.

Санал

- Мэдлэгийн тестийн чанарыг сайжруулах: асуултын хүндрэлийн түвшинг ахиулах, сонголтын байрлалыг холих, кейст суурилсан дээд түвшний асуулт нэмэх замаар тестийн ялгах чадварыг нэмэгдүүлэх.
- Дотоод хэргийн их сургуулийн Хуулийн сургуулийн хөтөлбөрт "Шүүх сэтгэц эмгэг судлал" хичээлийг тогтмол, бие даасан хичээл хэлбэрээр тусгах.
- Суралцагчдыг сэтгэцийн эрүүл мэндийн төв, эмнэлэгт дадлага хийлгэх боломжийг бүрдүүлэх.
- Цаашид олон сургуулийг хамарсан, түүврийн хэмжээ томтой, бүх курсийг хамарсан өргөн хүрээний судалгаа явуулах.

Ашигласан эх сурвалж:

Нэг. Монгол хэл дээр:

Батсайхан, Б., & Дэлгэржав, М. (2013). *Ерөнхий сэтгэл судлал.* Улаанбаатар хот: Соёмбо принтинг ХХК.

Бямбасүрэн, С. (2019). *Сэтгэц эмгэг судлал.* Улаанбаатар хот.

Нандинцэцэг, Ц. (2025). *Шүүх сэтгэц эмгэг судлал.* ДХИС-ийн хэвлэлийн үйлдвэр. Улаанбаатар хот.

Бямбасүрэн, С. Доржжадамба, Ш. (1988). Шүүхийн сэтгэц гэм судлал" сурах бичиг

Эрдэнэбаяр, Д. (2005). Шүүх сэтгэц эмгэг судлалын лекцүүд сурах бичиг

Цэвээнханд, Ц. (2011). Шүүхийн сэтгэц эмгэг судлал"

Монгол Улсын Их Хурал. (2015). Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга). https://legalinfo.mn

Монгол Улсын Их Хурал. (2017). Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. https://legalinfo.mn

Хоёр. Орос хэл дээр:

Вахинг В.А. Морозов Г.В. (1998). Судебно-психиатрическая экспертиза.

Гурав. Англи хэл дээр:

Adeyemo, S. O., Olorunshola, D. A., & Adejumo, A. O. (2020). Awareness of forensic psychiatry among undergraduate law students in Nigeria. African Journal of Psychiatry, 23(2), 45–52. https://doi.org/10.4314/ajpsy.v23i2.5

Buchanan, A., & Norko, M. (Eds.). (2011). The psychiatric report: Principles and practice of forensic writing. Cambridge University Press.

Gordon, H., & Lindqvist, P. (2019). Forensic psychiatry in legal education: Experiences from Australian and Swedish law schools. International Journal of Law and Psychiatry, 65, Article 101108. https://doi.org/10.1016/j.ijlp.2019.101108

Gowensmith, W. N., Murrie, D. C., & Boccaccini, M. T. (2013). How reliable are forensic evaluations of legal sanity? Law and Human Behavior, 37(2), 98–106. https://doi.org/10.1037/lhb0000001

Singh, S., Mathew, S., & Bharti, A. (2018). Knowledge and attitude of law students towards forensic psychiatry: A cross-sectional survey. Indian Journal of Psychiatry, 60(3), 312–317. https://doi.org/10.4103/psychiatry.IndianJPsychiatry_245_17

Stuart, H. (2017). Media portrayal of mental illness and its treatments: What effect does it have on people with mental illness? CNS Drugs, 31(2), 99–106. https://doi.org/10.2165/00023210-200620020-00002

World Health Organization. (2021). Mental health and forensic psychiatry: A global perspective. WHO Press.

ОСНОВНЫЕ ПРОБЛЕМЫ ИНОСТРАННЫХ ОБУЧАЮЩИХСЯ В ОБРАЗОВАТЕЛЬНЫХ ОРГАНИЗАЦИЯХ МВД РОССИИ

ОХУ-ЫН ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ИХ ДЭЭД СУРГУУЛИУДАД СУРАЛЦАЖ БАЙГАА ГАДААД СУРАЛЦАГЧДАД ТУЛГАРЧ БУЙ ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД

THE MAIN PROBLEMS OF FOREIGN STUDENTS IN EDUCATIONAL INSTITUTIONS OF THE MINISTRY OF INTERNAL AFFAIRS OF RUSSIA

Букина Татьяна Григорьевна*
Заведующий кафедрой иностранных языков Уральского юридического института МВД России, кандидат филологических наук, доцент
Bukina Tatyana Grigoryevna
Head of the Department of Foreign Languages of the Ural Law Institute of the Ministry of the Interior of the Russian Federation, Candidate of Philology, Associate Professor

*Хариуцлагатай зохиогч: tf30@rambler.ru

Аннотация. В условиях подготовки иностранных обучающихся в образовательных организациях системы МВД России особое значение придаётся овладению русским языком как неродным, успешное усвоение учебных дисциплин и способность к пониманию и воспроизведению научных текстов. Эти знания и умения напрямую зависят от уровня языковой компетентности. Программы учебных курсов и практических занятий проектируются с обязательным учётом правовых норм страны, из которой прибыл курсант, что обеспечивает интеграцию национального правового контекста в образовательный процесс. Целью статьи является исследование и описание основных проблем иностранных обучающихся в образовательных организациях МВД России, касающихся как образовательного процесса, так и бытовых условий. В результате исследования автор приходит к выводу, что для успешной адаптации иностранных обучающихся в образовательных организациях МВД России необходимо повышать стрессоустойчивость, облегчать процесс вхождения в социокультурную среду, формировать знания и умения у профессорско-преподавательского состава об особенностях таких обучающихся. Также важно внедрять новые методы и способы обучения, разрабатывать новые программы, направленные на повышение качества образования иностранных обучающихся.

Abstract. In the context of training foreign students at educational institutions within the Russian Ministry of Internal Affairs, particular importance is placed on mastering Russian as a second language. Successful mastery of academic subjects and the ability to understand and reproduce scientific texts directly depend on the level of linguistic proficiency. Curriculums for courses and practical training are designed with mandatory consideration of the legal norms of the student's home country, ensuring the integration of the national legal context into the educational process. The purpose of this article is to examine and describe the main challenges facing international students in educational institutions of the Russian Ministry of Internal Affairs, relating to both the educational process and their living conditions. The author concludes that, to successfully adapt international students to educational institutions of the Russian Ministry of Internal Affairs, it is necessary to enhance their stress resilience, facilitate their integration into the sociocultural environment, and develop knowledge and skills among faculty members regarding the unique characteristics of these students. It is also important to introduce new teaching methods and approaches, and to develop new programmes aimed at improving the quality of education for international students.

Ключевые слова: образовательный процесс, федеральный государственный образовательный стандарт, материально-бытовая адаптация иностранных обучающихся, образовательная адаптация иностранных обучающихся.

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

Keywords: educational process, federal state educational standard, material and everyday adaptation of foreign students, educational adaptation of foreign students.

Введение

В последние годы образовательные организации Министерства внутренних дел Российской Федерации всё чаще становятся платформой для получения профессионального образования не только для российских граждан, но и для представителей других государств. Активное привлечение иностранных обучающихся в вузы МВД России обусловлено, с одной стороны, расширением международного сотрудничества в сфере обеспечения безопасности, борьбы с транснациональной преступностью и обмена опытом между странами, а с другой – усиливающейся потребностью в компетентных кадрах, способных работать в условиях глобализации. В этом контексте рассмотрение особенностей и основных трудностей, с которыми сталкиваются иностранные обучающиеся в российских ведомственных вузах, приобретает особую значимость.

Одной из причин нарастающего интереса к вопросу поддержки иностранных граждан при обучении в образовательных учреждениях МВД России становится многообразие академических, социальных и культурных вызовов, возникающих у обучающихся, прибывающих из различных стран. Указанные сложности включают не только языковой барьер и адаптацию к иным дидактическим подходам, но и необходимость интеграции в профессиональную, зачастую строго регламентированную среду с особыми корпоративными нормами.

Актуальность обозначенной тематики продиктована также стремительным ростом мобильности студентов во всём мире и активизацией академических обменов на уровне правоохранительных структур. Иностранные обучающиеся в вузах МВД России не только получают профессиональное образование, но и формируют двусторонние связи между государствами, способствуя укреплению сотрудничества в сфере внутренней и международной безопасности. Исследование спектра проблем, существующих в данной области, особенно важно с точки зрения оптимизации образовательных практик и совершенствования правового регулирования их пребывания и обучения.

Объектом исследования является процесс обучения иностранных обучающихся в образовательных организациях системы МВД России.

Предметом исследования являются основные проблемы и трудности, с которыми сталкиваются иностранные обучающиеся в указанных учреждениях.

Целью исследования является изучение основных проблем иностранных обучающихся в образовательных организациях МВД России.

Для реализации данной цели необходимо решить следующие задачи:

1. Рассмотреть специфику образовательного процесса для иностранных обучающихся в вузах МВД России.
2. Выявить трудности адаптации иностранных обучающихся в учебных заведениях МВД России.
3. Предложить рекомендации по совершенствованию условий обучения иностранных граждан в образовательных организациях МВД РФ.

Методологической основой исследования выступают такие общенаучные методы, как индукция, системно-структурный, дескриптивный методы.

Результаты исследования и обсуждение

Интеграция представителей других государств в образовательный процесс вузов МВД России служит одним из ключевых факторов развития международных контактов и обмена передовой практикой в сфере противодействия преступности. Такой

подход способствует укреплению взаимодействия между странами, позволяет распространять эффективные модели работы, а также формировать единые подходы к обеспечению правопорядка на межгосударственном уровне.

Образовательный процесс для иностранных обучающихся в вузах МВД России имеет особенности, связанные с условиями поступления, программами обучения, организацией практики и адаптацией. Эти особенности направлены на подготовку специалистов, которые могут быть направлены на работу в правоохранительных органах, и учитывают специфику подготовки иностранных обучающихся.

Образовательный процесс для иностранных обучающихся в учебных заведениях МВД России строится в соответствии с федеральным государственным образовательным стандартом, а также программами, которые самостоятельно разрабатывают профильные образовательные учреждения с обязательным учетом объективных особенностей подготовки зарубежных граждан. Учебно-методические комплексы составляются таким образом, чтобы они максимально соответствовали особенностям контингента и отражали актуальные потребности иностранных обучающихся.

В процессе преподавания широко используются современные педагогические инструменты, включая мультимедийные образовательные ресурсы, видеоматериалы, цифровой контент сети Интернет, а при наличии возможности предоставляются лекционные материалы на родном языке слушателей. Такое разнообразие методик способствует повышению интереса и более полному усвоению информации.

Значимую роль занимает использование сравнительно-правового подхода, что даёт возможность акцентировать внимание иностранных обучающихся на различиях и общих чертах правоохранительных структур разных государств. Применение этого метода способствует развитию критического мышления и формированию у обучающихся целостного представления о мировой практике в области правоохранительной деятельности. Так, например, на кафедре уголовного права, на кафедре административного права и административной деятельности Уральского юридического института МВД России иностранные обучающиеся из Монголии пишут курсовые работы, основанные на сравнении уголовного и гражданского кодексов Российской Федерации и родной страны.

В процессе адаптации иностранных слушателей учитываются их культурные и языковые особенности, включая различия в оценивании и обучение на неродном языке. Для облегчения вхождения в образовательную среду организуются самостоятельные задания, а учебные материалы предоставляются с учётом доступности. Важное значение имеет знакомство с российскими традициями и культурой, которое реализуется через экскурсии и посещение музеев, выставочных залов и других культурных объектов.

Проблема адаптации иностранных обучающихся, поступающих в том числе в образовательные организации МВД России, приковывает внимание достаточно большого количества исследователей. К примеру, рассмотрением данного вопроса занимались такие ученые, как И.Л. Беккер [1], В.А. Белянкина [2]; Т.Х. Джантеев [5]; С.А. Иванчин [8], Г.И. Зиннатуллина [6], Р.И. Канунников [9], И.Ю. Кулагина [10], В.П. Мамина [11], Е.В. Огородова [14], И.А. Соловцова [16] и др.

По мнению Ю.К. Нимировской, сложности в процессе адаптации уже начинаются с появлением климатического фактора [13, с. 275]. Смена часовых поясов, изменение климатических условий снижают адаптационные возможности. Особенно ярко это проявляется, когда обучающиеся являются представителями стран с совершенно противоположными условиями (например, в УрЮИ МВД России обучаются иностранные граждане

из Монголии, Никарагуа и республики Мозамбик). Преподаватели отмечают, что иностранные обучающиеся жалуются на плохой сон, усталость. Особое место занимает прием пищи, так как не вся еда подходит им по вкусовым предпочтениям, что в свою очередь также становится раздражающим фактором.

Материально-бытовая адаптация иностранных обучающихся в учебных организациях МВД России также сопровождается определёнными трудностями, которые обусловлены не только условиями проживания в общежитиях, но и существенными различиями в уровне финансовой обеспеченности. Несмотря на формальное равенство учащихся относительно места жительства, индивидуальные различия в личных средствах проявляются довольно заметно в повседневной жизни курса. Так, обучающиеся, имеющие возможность использовать дополнительные финансовые ресурсы, способны приобретать необходимые для учёбы и быта предметы, быстрее и в большем объёме удовлетворять личные потребности, а также обеспечивать более стабильную связь с семьёй посредством современных средств коммуникации [7, с. 156].

В то же время те студенты, чей финансовый бюджет ограничен, вынуждены экономить на расходах, что сказывается на уровне комфорта и даже на моральном состоянии. Такие ограниченные возможности проявляются, например, в отказе от нужных или привычных вещей, сокращении общения с близкими по причине высокой стоимости связи либо невозможности приобрести желаемое. Всё это приводит к разнице в уровне удовлетворённости условиями проживания и негативно влияет на психологическое самоощущение студентов, усложняя их процесс адаптации в новой среде [13, с. 7].

Как считает доцент кафедры философии, психологии и гуманитарных дисциплин Уральского юридического института МВД России Р.И. Канунников, самым сложным, для иностранных обучающихся, является процесс вхождения в новую для себя социокультурную среду. Сразу же возникает проблема языкового барьера. В результате данного барьера иностранные обучающиеся, слабо владеющие русским языком, стесняются публичных выступлений. Они ждут персональных обращений от преподавателей, но при этом стремятся выполнять роль слушателей, предпочитая письменные ответы устным. Использование научных терминов вызывает у них определенного рода затруднения и требует дополнительного объяснения. Лучше всего усвоение знаний у них происходит при использовании презентаций и других видов наглядности. При этом не следует забывать, что новые технологии обучения на них лучше не применять, пока они полностью не отработаны [9, с. 19].

Помимо этого, иностранные студенты, приступающие к обучению в вузах МВД России, часто сталкиваются с выраженными трудностями, обусловленными спецификой образовательной среды. Существенным препятствием на пути успешного включения в учебный процесс становится необходимость усвоения теоретического и практического материала на неродном языке. Это обстоятельство усиливается тем, что изложение дисциплин сопровождается использованием профессиональной терминологии, что для большинства требует значительных дополнительных усилий для понимания и применения новых знаний на практике. Отметим, что многочисленные проблемы у иностранцев возникают при изучении дисциплины «Русский язык в юриспруденции», в частности, в изучении терминологии, где встречается синонимия и паронимия понятий (например, *объектный – объективный*). [3]

Для повышения эффективности образовательного процесса и успешной интеграции иностранных граждан, поступающих в ведомственные организации системы МВД России, требуется комплексная модернизация организационно-методических и

педагогических подходов. Обобщая опыт профильных вузов и результаты педагогических исследований, можно выделить ряд приоритетных направлений в данной области.

Прежде всего, особую значимость приобретает профессиональная подготовка профессорско-преподавательского состава. Заметим, что эффективная коммуникация с иностранными слушателями затрудняется из-за отсутствия учёта этнокультурных различий и особенностей восприятия материала. Регулярное проведение специально организованных методических семинаров и курсов повышения квалификации позволит педагогам ознакомиться с национальными, языковыми и психологическими особенностями студентов из различных стран. Такой подход будет способствовать предотвращению возможных недопониманий, сократит риск возникновения культурных конфликтов и создаст прочную основу для формирования доверительных отношений между преподавателем и аудиторией. Немаловажно и формирование толерантности, корректного общения, своевременное выявление и разрешение потенциальных проблем интеграции [4, с. 67].

Вторая ключевая задача – построение индивидуальной траектории самостоятельной работы для иностранных обучающихся. Перед организацией самостоятельной работы рекомендуется проводить оценку предварительного уровня знаний, языковой компетентности и сформированности учебных умений иностранных слушателей. Проведение диагностического входного контроля позволит определить зоны затруднений, индивидуальные потребности и сильные стороны каждого студента, после чего преподаватель получает возможность максимально точно подобрать темы, объем и уровень сложности самостоятельных заданий. Такой подход предусматривает не только развитие академической самостоятельности, но и учёт дифференцированных образовательных запросов. В подобных условиях самостоятельная работа превращается из формального элемента учебного процесса в инструмент персональной поддержки, что существенно облегчает освоение сложных специальных дисциплин [6, с. 105].

Неотъемлемым условием успешной адаптации выступает обеспечение студентов достаточным количеством доступных, качественных учебно-методических материалов. Причём учебная литература, в том числе справочные пособия, учебники должны быть представлены на уровнях, позволяющих понимание материала студентам с ограниченной языковой подготовкой. Значительную роль играет перевод основных источников либо их адаптация, а также возможность предоставления глоссариев, разъяснений, дополнительных комментариев на понятном студентам языке. Разработка вспомогательных материалов с опорой на национальный опыт и сравнительное описание особенностей российского законодательства существенно облегчает освоение профессиональных курсов. Это положение особенно актуально для дисциплин юридического профиля, требующих точного понимания терминов и структуры отраслевого права.

Не менее важным аспектом является создание интернациональных учебных групп. Организация пространства, в котором находятся представители разных национальностей, оказывает стимулирующее воздействие на учебную мотивацию и ускоряет процесс языковой адаптации. В мультикультурных коллективах формируется атмосфера взаимного уважения, обучающиеся приобретают опыт межкультурного взаимодействия, что особенно важно для будущих сотрудников международных подразделений МВД. Практика подтверждает, что в условиях интеграции в многоязычный коллектив обучающиеся проявляют больший интерес к совершенствованию навыков устной и письменной речи, быстрее включаются в учебную и внеучебную деятельность,

активнее используют русскоязычные ресурсы и включаются в неформальное общение с российскими сверстниками [11, с. 38].

Важным элементом успешной адаптации становится системная вовлечённость иностранных слушателей во внеучебную и общественную деятельность. Для формирования позитивного отношения к вузу, развития лояльности и укрепления связей между студентами, образовательные организации должны поощрять участие представителей иностранных государств в подготовке и проведении общих праздников, концертов, спортивных соревнований, научных конференций, тематических лекций и форумов. Подобный подход поможет расширить коммуникативные навыки, сформирует чувство принадлежности и коллективной ответственности за результат общих инициатив [16, с. 141].

Выводы

В результате проведенного исследования автор пришел к следующим выводам:

1. Образовательный процесс для иностранных студентов в вузах МВД России отличается рядом характерных черт, обусловленных как требованиями к приёму, так и особенностями содержания образовательных программ, организации профессиональных стажировок и процедур адаптации к учебной и социокультурной среде.

2. Процесс интеграции в новую среду затрудняется из-за необходимости привыкания к непривычным культурным традициям и особенностям повседневной жизни, что нередко сопровождается трудностями во взаимодействии с сокурсниками и преподавателями. Существенную роль играет языковой барьер, осложняющий не только образовательное общение, но и социальную коммуникацию в целом, влияя на качество усвоения учебного материала.

3. Одной из трудностей образовательной адаптации иностранных обучающихся является недостаточная адаптированность методики преподавания к особенностям восприятия информации студентами из других государств, что затрудняет освоение специальных дисциплин.

4. Для создания оптимальных условий для успешной социализации иностранных обучающихся в образовательных организациях системы МВД России облегчать процесс их вхождения в социокультурную среду, формировать знания профессорско-преподавательского состава о национальных и ментальных особенностях таких обучающихся. Также важно внедрять новые методы и способы, разрабатывать новые программы, направленные на повышение качества образовательного процесса в среде иностранных обучающихся.

Литература

1. Беккер И.Л. Проблемы адаптации иностранных студентов к образовательному процессу российского вуза (на примере Пензенского государственного университета) / И.Л. Беккер, С.А. Иванчин // Известия высших учебных заведений. Приволжский регион: Гуманитарные науки. Педагогика, 2015. – № 4 (36). – С. 247-257.

2. Белянкина В. А. Социокультурные и психологические особенности адаптации иностранных слушателей в образовательных организациях МВД России / В. А. Белянкина, И.В. Бантюков // Российский девиантологический журнал. – 2024. – № 2. – С. 19–24.

3. Букина Т.Г. Проблемы преподавания дисциплины «Русский язык в юриспруденции» в иностранной аудитории / Т.Г. Букина // Мир закона, 2025. – № 7–8 (279–280). – С. 34–40.

4. Гусев В. А. Совершенствование образовательных программ, планирование и реализация учебного процесса / В. А. Гусев. – Омск: Омская академия МВД России, 2021. – 168 с.

5. Джантеев Т. Х. Социокультурная адаптация иностранных слушателей в образовательных организациях МВД России / Т. Х. Джантеев // Вестник Калининградского филиала Санкт-

Петербургского университета МВД России. – 2024. – № 3. – С. 156–162.

6. Зиннатуллина Г. И. К вопросу об исследовании проблем социокультурной адаптации иностранных курсантов в военных вузах Российской Федерации / Г. И. Зиннатуллина // Власть. – 2020. – № 4. – С. 105–109.

7. Зорина В. В. Актуальный уровень владения русским языком иностранными слушателями ведомственных образовательных организаций / В. В. Зорина // Современные наукоемкие технологии. – 2023. – № 4. – С. 155–159.

8. Иванчин С.А. Формирование адаптационной готовности к учебной деятельности у иностранных обучающихся в условиях вузовского образования / С.А. Иванчин. – дис. канд. наук: 19.00.07 – Педагогическая психология. ФГБОУ ВО «Саратовский национальный исследовательский государственный университет имени Н.Г. Чернышевского». – 2021. – 184 с.

9. Канунников Р. И. Проблема адаптации иностранных обучающихся в образовательных организациях МВД России / Р. И. Канунников // Образование и право. – 2024. – № 4. – С. 19–23.

10. Кулагина И. Ю. Условия адаптации иностранных студентов в вузах / И. Ю. Кулагина // Современная зарубежная психология. – 2020. – № 4. – С. 129–137.

11. Мамина В. П. Особенности процесса адаптации иностранных студентов к обучению в российском вузе / В. П. Мамина // Педагогические исследования. –2022. – № 2. – С. 38–57.

12. Нимировская Ю. К. Предикторы адаптации иностранных слушателей-первокурсников к учебной деятельности в образовательной организации МВД России / Ю. К. Нимировская // Ученые записки университета им. П.Ф. Лесгафта. – 2021. – № 1. – С. 275–279.

13. Нимировская Ю. К. Учет особенностей этнической идентичности в условиях поликультурной образовательной среды в университете МВД России/ Ю. К. Нимировская // Человеческий капитал. – 2022. – № 10. – С. 7–12.

14. Огородова Е.В. Проблемы адаптации иностранных студентов в России / Е.В. Огородова, А.В. Новиков // Форум молодых ученых, 2024. – № 5 (93). – С. 261–264.

15. Соловцова И. А. Особенности академической адаптации иностранных граждан, обучающихся в вузах Министерства внутренних дел Российской Федерации / И. А. Соловцова // Вестник Калининградского филиала Санкт-Петербургского университета МВД России. – 2025. – № 3. – С. 141–146.

References

1. Bekker I.L. Problemy adaptacii inostrannyh studentov k obrazovatel'nomu processu rossijskogo vuza (na primere Penzenskogo gosudarstvennogo universiteta) / I.L. Bekker, S.A. Ivanchin // Izvestiya vysshih uchebnyh zavedenij. Privolzhskij region: Gumanitarnye nauki. Pedagogika, 2015. – № 4 (36). – S. 247-257.

2. Belyankina V. A. Sociokul'turnye i psihologicheskie osobennosti adaptacii inostrannyh slushatelej v obrazovatel'nyh organizaciyah MVD Rossii / V. A. Belyankina, I.V. Bantyukov // Rossijskij deviantologicheskij zhurnal. – 2024. – № 2. – S. 19–24.

3. Bukina T.G. Problemy prepodavaniya discipliny «Russkij yazyk v yurisprudencii» v inostrannoj auditorii / T.G. Bukina // Mir zakona, 2025. – № 7–8 (279–280). – S. 34–40.

4. Gusev V. A. Sovershenstvovanie obrazovatel'nyh programm, planirovanie i realizaciya uchebnogo processa / V. A. Gusev. – Omsk: Omskaya akademiya MVD Rossii, 2021. – 168 s.

5. Dzhanteev T. H. Sociokul'turnaya adaptaciya inostrannyh slushatelej v obrazovatel'nyh organizaciyah MVD Rossii / T. H. Dzhanteev // Vestnik Kaliningradskogo filiala Sankt-Peterburgskogo universiteta MVD Rossii. – 2024. – № 3. – S. 156–162.

6. Zinnatullina G. I. K voprosu ob issledovanii problem sociokul'turnoj adaptacii inostrannyh kursantov v voennyh vuzah Rossijskoj Federacii / G. I. Zinnatullina // Vlast'. – 2020. – № 4. – S. 105–109.

7. Zorina V. V. Aktual'nyj uroven' vladeniya russkim yazykom inostrannymi

slushatelyami vedomstvennyh obrazovatel'nyh organizacij / V. V. Zorina // Sovremennye naukoemkie tekhnologii. – 2023. – № 4. – S. 155–159.

8. Ivanchin S.A. Formirovaniye adaptatsionnoy gotovnosti k uchebnoy deyatel'nosti u inostrannykh obuchayushchikhsya v usloviyakh vuzovskogo obrazovaniya / S.A. Ivanchin. – dis. kand. nauk: 19.00.07 – Pedagogicheskaya psikhologiya. FGBOU VO «Saratovskiy natsional'nyy issledovatel'skiy gosudarstvennyy universitet imeni N.G. Chernyshevskogo». – 2021. – 184 s.

9. Kanunnikov R. I. Problema adaptacii inostrannyh obuchayushchihsya v obrazovatel'nyh organizaciyah MVD Rossii / R. I. Kanunnikov // Obrazovanie i pravo. – 2024. – № 4. – S. 19–23.

10. Kulagina I. Yu. Usloviya adaptacii inostrannyh studentov v vuzah / I. Yu. Kulagina // Sovremennaya zarubezhnaya psihologiya. – 2020. – № 4. – S. 129–137.

11. Mamina V. P. Osobennosti processa adaptacii inostrannyh studentov k obucheniyu v rossijskom vuze / V. P. Mamina // Pedagogicheskie issledovaniya. –2022. – № 2. – S. 38–57.

12. Nimirovskaya Yu. K. Prediktory adaptacii inostrannyh slushatelej-pervokursnikov k uchebnoj deyatel'nosti v obrazovatel'noj organizacii MVD Rossii / Yu. K. Nimirovskaya // Uchenye zapiski universiteta im. P.F. Lesgafta. – 2021. – № 1. – S. 275–279.

13. Nimirovskaya Yu. K. Uchet osobennostej etnicheskoj identichnosti v usloviyah polikul'turnoj obrazovatel'noj sredy v universitete MVD Rossii/ Yu. K. Nimirovskaya // Chelovecheskij kapital. – 2022. – № 10. – S. 7–12.

14. Ogorodova E.V. Problemy adaptacii inostrannyh studentov v Rossii / E.V. Ogorodova, A.V. Novikov // Forum molodyh uchenyh, 2024. – № 5 (93). – S. 261–264.

15. Solovcova I. A. Osobennosti akademicheskoj adaptacii inostrannyh grazhdan, obuchayushchihsya v vuzah Ministerstva vnutrennih del Rossijskoj Federacii / I. A. Solovcova // Vestnik Kaliningradskogo filiala Sankt-Peterburgskogo universiteta MVD Rossii. – 2025. – № 3. – S. 141–146.

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ГАРДАН ТУЛААНЫ СУРГАЛТЫН АГУУЛГЫГ БОДИТ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЦЭЭНД НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ АСУУДАЛ

ISSUES IN IMPROVING THE CONTENT OF HAND-TO-HAND COMBAT TRAINING IN LAW ENFORCEMENT AGENCIES TO ALIGN WITH OPERATIONAL REQUIREMENTS

Э.Сандагжав*
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа
Sandagjav E.
Senior Lecturer, Department of Military Studies, Border Troops School, University of Internal Affairs, Master's degree, Lieutenant Colonel

*Хариуцлагатай зохиогч: Ssandagjav@gmail.com

Хураангуй: Хууль сахиулах байгууллагын гардан тулааны сургалтын агуулгыг орчин үеийн бодит ажиллагааны шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох хэрэгцээ, чиг хандлагыг судлан авч үзсэн.

Хууль сахиулах ажиллагаа нь богино хугацаанд, ойрын зайд, өндөр стрессийн нөхцөлд явагддагаараа онцлог бөгөөд энэ нь алба хаагчдаас зөвхөн техник ур чадвар бус, хяналт тогтоох, саармагжуулах, шийдвэр гаргах болон багийн ажиллагааны нэгдмэл чадамжийг шаарддаг болохыг олон улсын судалгаанууд баталж байна. АНУ, ОХУ, БНХАУ, Япон, Израиль болон Европын орнуудын сургалтын арга зүйг харьцуулан шинжилснээр спортын чиг баримжаатай тогтолцооноос бодит ажиллагаанд суурилсан, хяналт тогтоох, газарт баривчлах болон стрессийн нөхцөл дэх шийдвэр гаргалтад төвлөрсөн сургалт руу нийтлэг шилжилт хийгдэж байгааг тогтоов. Мөн бодит мөргөлдөөний ихэнх нь ноцолдох, унагах, хэвтээ байдлаас баривчлах хэлбэртэй өрнөдөг бөгөөд цохилтын техникүүдийн хэрэглээ хязгаарлагдмал болох нь илэрсэн.

Дотоод хэргийн их сургуулийн сургалтын агуулгын шинжилгээгээр суурь хамгаалах ур чадвар хангалттай хөгжүүлж байгаа боловч хэвтээ байдлаас баривчлах, багийн тактик, стрессийн нөхцөл дэх сургалт болон бодит ажиллагаанд чиглэсэн тактикийн бүрэлдэхүүн хангалтгүй байгааг тогтоосон. Иймд сургалтыг хяналт тогтоох чиглэлд шилжүүлэх, хэвтээ байрлалаас баривчлах сургалтыг өргөжүүлэх, сценари-д суурилсан сургалт нэвтрүүлэх, багийн ажиллагааг бэхжүүлэх, мөн нотолгоонд суурилсан тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай бөгөөд эдгээр шинэчлэл нь ажиллагааны үр дүн, алба хаагчийн аюулгүй байдал болон мэргэжлийн чадавхыг стратегийн түвшинд сайжруулах ач холбогдолтой юм.

Abstract: This article examines the need and direction for improving the content of law enforcement hand-to-hand combat training in line with contemporary operational requirements. Law enforcement operations are characterized by short duration, close proximity, and high-stress environments, requiring officers to possess not only technical skills but also integrated competencies in control, neutralization, decision-making, and team coordination, as confirmed by international studies. A comparative analysis of training approaches in the United States, Russia, China, Japan, Israel, and European countries shows a common shift from sport-oriented systems toward operationally grounded training focused on control, ground-based arrest techniques, and decision-making under stress. It was also found that most real encounters involve grappling, takedowns, and ground restraint, while striking techniques are used to a limited extent. The analysis of training at the University of Internal Affairs indicates that while basic defensive skills are well developed, ground restraint, team tactics, stress-based training, and operationally oriented tactical components remain insufficient. Therefore, it is necessary to shift training toward control-based methods, expand ground arrest training, introduce scenario-based training, strengthen team operations, and develop an evidence-based system, which is

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

strategically important for improving operational effectiveness, officer safety, and professional competence.

Түлхүүр үг: гардан тулаан, хяналт, баривчилгаа, багийн ажиллагаа, шинэчлэл.
Keywords: hand-to-hand, combat, control, arrest, team operations, modernization.

Хууль сахиулах ажиллагааны нөхцөл байдал нь алба хаагчдаас зөвхөн хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ур чадвар төдийгүй гэнэтийн аюул, хүч хэрэглэсэн эсэргүүцэл, ойрын зайн мөргөлдөөний үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварыг өндөр түвшинд эзэмшсэн байхыг шаардаж байна. Ялангуяа баривчлах ажиллагаа, олон нийтийн хэв журам хамгаалах, тусгай ажиллагаа, хил хамгаалалт, саатуулах болон хамгаалалтын үйл ажиллагааны үед гардан тулааны ур чадвар нь алба хаагчийн аюулгүй байдал, ажиллагааны үр дүнтэй шууд холбоотой хүчин зүйл болж байна (Andersen et al., 2018).

Сүүлийн жилүүдэд АНУ, ОХУ, БНХАУ, Япон, Израиль, БНСУ зэрэг улс орнуудын хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид бодит нөхцөлд гардан тулаан хийсэн судалгаануудын үр дүнд тулаан нь уламжлалт спортоос эрс ялгаатай болох нь тогтоогдсон байна. Тухайлбал бодит нөхцөл ихэнх нь богино хугацаанд, ойрын зайд, өндөр сэтгэлзүйн дарамтын орчинд явагдаж, цохилтоос илүүтэй барьц авах, унагаах, өчих, дарах буюу хянах, хэвтээ байдлаас баривчлах арга давамгай хэрэглэгдэж байгаа нь тогтоогджээ (Davis et al., 2024). Мөн алба хаагчид хамгаалах хэрэгсэл, бүс тоноглол, зэвсэгтэйгээр ажиллагаа явуулдаг тул спортын зориулалттай олон техник бодит хэрэглээнд үр ашиг багатай болох нь судалгаагаар харагдаж байна (Körner & Staller, 2018).

Гэвч зарим сургалтын байгууллагын гардан тулааны хичээлийн агуулга нь бодит ажиллагааны хэрэгцээ, орчин үеийн хууль сахиулах ажиллагааны онцлогтой бүрэн нийцэхгүй, спортын шинж давамгай, бодит нөхцөлд суурилсан сургалт харьцангуй хязгаарлагдмал хэвээр байгаа асуудал ажиглагдаж байна. Ялангуяа алба хаагчийг сэжигтнийг харгалзах, багийн ажиллагаанд оролцох, стресстэй орчинд шийдвэр гаргах, зэвсэг хамгаалах, газар дээрх ноцолдооны үед амьд үлдэх зэрэг бодит чадварт бэлтгэх асуудал сургалтын агуулгад хангалттай тусгагдаагүй байх магадлалтай байна (Renden et al., 2015).

Дотоод хэргийн их сургуулийн гардан тулааны сургалт нь сонсогчдын бие бялрын хөгжил, сахилга бат, өөрийгөө хамгаалах үндсэн чадварыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой боловч орчин үеийн хууль сахиулах ажиллагааны бодит хэрэгцээтэй хэр нийцэж буйг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах шаардлага үүсэж байна. Иймд гадаад улсын бодит хэрэглээний судалгаа, хууль сахиулах байгууллагын гардан тулааны сургалтын чиг хандлага, бодит мөргөлдөөний онцлогийг судлан Дотоод хэргийн их сургуулийн гардан тулааны хичээлийн агуулгатай харьцуулан шинжлэх нь энэхүү судалгааны үндэслэл болж байна.

Энэхүү судалгааны зорилго нь хууль сахиулах байгууллагын бодит ажиллагаанд хэрэглэгдэж буй гардан тулааны техник, тактик, сургалтын чиг хандлагад дүн шинжилгээ хийж, гардан тулааны сургалтын агуулгыг бодит ажиллагааны хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгох асуудлыг тодорхойлоход оршино.

Судалгааны хүрээнд:

1. Бодит нөхцөлд гардан тулаанд хамгийн түгээмэл хэрэглэгддэг техникүүдийг судлах;
2. Өндөр хөгжилтэй орнуудын хууль сахиулах байгууллагын гардан тулааны сургалтын агуулгыг шинжлэх;
3. Дотоод хэргийн их сургуулийн гардан тулааны хичээлийн агуулгад харьцуулсан дүн шинжилгээ хийх;
4. Сургалтын агуулгыг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах зорилтуудыг дэвшүүлнэ.

Нэг. Бодит нөхцөл дэх гардан тулааны техникүүдийн хэрэглээний онцлог

Орчин үеийн хууль сахиулах байгууллагын алба хаагчид үүрэг гүйцэтгэх явцдаа эсэргүүцэл үзүүлсэн этгээдийг баривчлах, нийтийн хэв журам хамгаалах, тусгай ажиллагаа явуулах, улсын хил хамгаалах зэрэг ажиллагаанд гардан тулаанд орох эрсдэлтэй байдаг. Ийм нөхцөлд тулааны ур чадвар нь зөвхөн өөрийгөө хамгаалах хэрэгсэл бус, ажиллагааны үр дүн, алба хаагчийн аюулгүй байдал, хүний эрхийг хангах ажиллагаатай шууд холбоотой хүчин зүйл болж байна.

Сүүлийн жилүүдэд АНУ, Канад, ОХУ, Израиль, Япон, БНСУ зэрэг улс орнуудын хууль сахиулах байгууллагууд бодит мөргөлдөөний нөхцөлд хэрэглэгдэж буй гардан тулааны техникүүдэд дүн шинжилгээ хийж, сургалтын тогтолцоогоо шинэчлэхэд анхаарч байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд бодит нөхцөл дэх гардан тулаан нь спортын тулааны хэв шинжээс эрс ялгаатай бөгөөд ихэвчлэн богино хугацаанд, өндөр стрессийн орчинд, ойрын зайд явагддаг онцлогтой байна (Körner & Staller, 2018).

1.1 Бодит нөхцөлд гардан тулаан явагддаг нийтлэг хэлбэр.

Гардан тулаан нь ихэнхдээ:

- түлхэлцэх;
- барьцалдах;
- ноцолдох;
- газар унагах;
- хөдөлгөөн хязгаарлах буюу өчих

зэрэг хэлбэрээр өрнөдөг болохыг олон улсын судалгаанууд харуулж байна.

АНУ-ын хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд хийсэн судалгаагаар мөргөлдөөний үед цохилтоос илүүтэй унагаах буюу ноцолдоон, барилдааны техникүүд давамгай хэрэглэгддэг болох нь тогтоогджээ. Судалгаанд оролцсон алба хаагчдын ихэнх нь сэжигтнийг хяналтдаа авах явцад:

- Биеэр өчих;
- Унагаах;
- Бугуйнд өчих;
- Босоо байдлаас баривчлах;
- Хэвтээ байдлаас баривчлах зэрэг техникүүдийг хамгийн түгээмэл ашигладаг гэж хариулсан байна (Davis et al., 2024).

Хууль сахиулах салбарын гардан тулааны үндсэн зорилго нь өрсөлдөгчийг “ялах” бус, харин эсэргүүцлийг богино хугацаанд зогсоож, хяналт тогтоон, баривчлах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байгааг харуулж байна.

1.2 Ашигтай барьц авах болон хянах техникүүдийн давамгай хэрэглээ

Олон улсын судалгаануудаас үзэхэд хууль сахиулах ажиллагааны үед хамгийн өндөр үр ашигтайд тооцогдож буй техникүүд нь ашигтай барьц түрүүлж авах, унагаах, үенд өчих болон хэвтээ байдлаас өчиж баривчлах техникүүд байна.

Хэвтээ байдлаас өчиж баривчлах гэдэг нь сэжигтнийг газар унагасны дараа хөдөлгөөнийг нь хязгаарлаж, хяналт тогтоон, гавлах нөхцөлийг бүрдүүлэх техникүүдийг хэлдэг бөгөөд орчин үеийн цагдаагийн хамгаалалтын тактик сургалтын чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна. Ялангуяа:

- Дээр нь дарж суун баривчлах;
- Хажуугаар хэвтсэн үед дарж баривчлах;
- Бугуйнд нь өчих;
- Нуруу дээрээс нь өвдөглөж баривчлах;
- Гэдсээр нь хэвтүүлж гар, хөлд өчин баривчлах зэрэг техникүүд нь баривчлах ажиллагаанд өргөн хэрэглэгддэг байна (Renden et al., 2015).

Канадын судлаачдын хийсэн ажиглалтын судалгаагаар баривчлах ажиллагааны ихэнх нь “clinch-to-ground transition” буюу барилдаанаас газар унагаж өчин баривчлах нөхцөлд шилждэг болохыг тогтоожээ. Иймээс чөлөөт бөх, жудо, Бразилийн жиу-житсу, самбо зэрэг барилдаан суурьтай системүүд нь орчин үеийн хууль сахиулах салбарын гардан тулааны сургалтын үндсэн чиглэл болж хөгжиж байна.

1.3 Цохилтын техникүүдийн бодит хэрэглээ

Гардан тулааны үед цохих, тохойлдох, өвдөглөх зэрэг ойрын зайн цохилтууд тодорхой хэмжээнд хэрэглэгддэг боловч

өндөр өшиглөлт, эргэлттэй техник, спортын зориулалттай хүнд техникүүдийн хэрэглээ харьцангуй бага байдаг байна.

Үүний шалтгаан нь:

- Тусгай хэрэгслийн бүс болон хамгаалах хэрэгслийн саад;
- хязгаарлагдмал орчин;
- халтиргаа;
- олон этгээдтэй тулгарах эрсдэл;
- зэвсгээ алдах аюул;
- хууль, эрх зүйн эрсдэл зэрэг хүчин зүйлтэй холбоотой юм.

Судалгаагаар хууль сахиулах байгууллагын алба хаагчид өндөр хүчтэй цохилтоос илүүтэй control-based tactics буюу хяналт тогтоох тактик хэрэглэхийг илүүд үздэг болох нь тогтоогдсон байна (Andersen et al., 2018). Энэ нь хүний эрх, хүч хэрэглэх түвшний зарчим, ажиллагааны аюулгүй байдалтай шууд холбоотой юм.

1.4 Ажиллагааны үеийн стресс ба сургалтын хэрэгцээ

Мөргөлдөөний үед алба хаагчид өндөр стресс, айдас, физиологийн ачааллын нөлөөнд ордог бөгөөд энэ нь техник хэрэглэх чадварт шууд нөлөөлдөг байна. Судалгаагаар өндөр стрессийн нөхцөлд хүний нарийн хөдөлгөөний чадвар буурч, энгийн, давтагдах боломжтой техникүүд илүү үр дүнтэй болдог болохыг тогтоожээ (Renden et al., 2015).

Иймээс орчин үеийн гардан тулааны сургалт нь:

- бодит нөхцөлд суурилсан байх;
- хамгаалах хэрэгсэлтэй орчинд явагдах;
- сценайр сургалт ашиглах;
- багийн ажиллагаатай уялдах;
- стрессийн дасгал агуулсан байх шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн орчин үеийн хууль сахиулах байгууллагууд зөвхөн техник заахаас илүүтэй:

- шийдвэр гаргах;
- харилцан ажиллах;
- сэжигтнийг хянах;
- зэвсгээ алдахгүй байх;
- багийн уялдаа, зохицуулалт чадварыг хамтад нь хөгжүүлэх чиглэлд сургалтын тогтолцоогоо шинэчилж байна.

Ажиллагааны нөхцөл дэх гардан тулаан нь спортын тулаанаас ялгаатай бөгөөд ихэвчлэн ойрын зайн ноцолдоон, барьц булаацалдах, унагаах, хэвтээ байдлаас баривчлах хэлбэрт шилждэг болох нь олон улсын судалгаагаар тогтоогдож байна. Мөн бодит нөхцөлд хяналт тогтоох, хөдөлгөөнийг хязгаарлах, богино хугацаанд баривчлах нөхцөл бүрдүүлэх техникүүд өндөр ач холбогдолтой байгаа нь харагдаж байна.

Иймээс хууль сахиулах байгууллагын гардан тулааны сургалтын агуулга нь спортын чиглэлийн техникээс илүүтэй бодит ажиллагаанд хэрэглэгдэх *хяналтдаа авах тактик, газар унагаан баривчлах, өчих ба баривчлах, стрессийн нөхцөлд суурилсан сургалт* зэрэг чиглэлд төвлөрөх шаардлагатай байна.

Хоёр. Олон улсын хууль сахиулах байгууллагын гардан тулааны сургалтын агуулгын чиг хандлага

Хууль сахиулах байгууллагын гардан тулааны сургалт нь улс орон бүрд өөрийн эрх зүйн орчин, тактикийн шаардлага, аюулгүй байдлын бодлого, сургалтын уламжлалаас хамааран харилцан адилгүй хөгжсөн боловч сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд нийтлэг нэг чиг хандлага ажиглагдаж байна. Энэ нь спорт суурьтай тулааны сургалтаас бодит ажиллагаанд суурилсан хянах, хязгаарлах төвтэй сургалт руу шилжих хандлага юм (Körner & Staller, 2018).

2.1 АНУ-ын хууль сахиулах байгууллагын сургалтын чиг хандлага

АНУ-ын цагдаагийн байгууллагын хамгаалах тактик сургалт нь бодит тулааны судалгаанд суурилан тасралтгүй шинэчлэгдэж ирсэн. Судалгаагаар баривчлах ажиллагааны ихэнх нь ойрын зайн ноцолдоон, унагаах, хэвтээ байдлаас баривчлах хэлбэрээр явагддаг болох нь тогтоогдсон (Davis et al., 2024).

Иймээс сургалтын агуулгад:

- Хянах-хязгаарлах тактик;
- Унагаах;
- Газарт унагаан өчих, баривчлах;
- Сэжигтний хөдөлгөөний хязгаарлах, хянах болон саатуулах ажиллагаа;

- Өөрийн болон орчинд буй зэвсгийг булаалгахгүй хамгаалах;
- Сценари сургалтын арга ашиглах зэрэг элементүүд давамгай тусгагдах болсон (Andersen et al., 2018).

Мөн өндөр стресстэй нөхцөл болон сценари сургалтын арга ашиглан алба хаагчдыг бодит нөхцөлтэй ойролцоо орчинд шийдвэр гаргах чадварт сургах хандлага нэмэгдэж байна (Renden et al., 2015).

2.2 ОХУ-ын Combat Sambo чиглэлийн сургалтын онцлог

ОХУ-ын хууль сахиулах болон тусгай хүчний сургалт нь Байлдааны самбо болон армийн гардан тулаан (рукопашный бой)-д суурилсан байдаг. Энэ систем нь спортын самбоос ялгаатай бөгөөд практикт чиглэсэн тактикийн элементүүдийг агуулдаг.

Сургалтын агуулгад:

- унагаалтын өндөр үр дүнтэй хэлбэрүүд;
- үеэнд өчих;
- ойрын зайн цохилт;
- зэвсэг булаах, хамгаалах техник;
- олон этгээдтэй нөхцөлд хяналт тогтоох зэрэг практик чадварууд багтдаг (Fedorov, 2020).

Гэвч судлаачдын үзэж байгаагаар зарим сургалт нь өндөр эрсдэлтэй хөдөлгөөнд хэт төвлөрөх хандлагатай бөгөөд “хамгийн бага хүч ашиглах” зарчимтай бүрэн нийцүүлэх шаардлагатай (Körner & Staller, 2018).

2.3 БНХАУ-ын хууль сахиулах сургалтын чиг хандлага

БНХАУ-ын цагдаагийн сургалт нь Шуай жяо, Санда, Чин на болон орчин үеийн цагдаагийн хамгаалалтын тактикийг хослуулсан бүтэцтэй (Sun, 2016; Zhang, 2016).

Сургалтын онцлог нь:

- багийн ажиллагаа;
- нийтийн эмх замбараагүй байдлыг хянах техник;
- стандартчилсан саатуулах ажиллагаа;
- хамгаалах хэрэгсэлтэй орчны сургалт зэрэгт суурилдаг.

Ялангуяа олон этгээдтэй нөхцөлд хамтын хяналт тогтоох чадвар нь чухал байр суурь эзэлдэг.

2.4 Япон, Израиль болон Европын туршлага

Японы цагдаагийн сургалт нь Жудод суурилсан бөгөөд хамгийн бага гэмтэлтэйгээр хяналт тогтоох философитой (Kwon & Kim, 2025). Харин Израилийн Krav Maga систем нь зэвсэгтэй аюул, хурдан шийдвэр гаргалт, survival-oriented сургалтад төвлөрдөг (Lichtenfeld, 2014; Grossman, 2009).

Европын улс орнуудын хувьд:

- Хүч хэрэглэхийн пропорциональ (зохистой) зарчим
- Цохихоос өмнө хяналт тогтоох зарчим
- Гэмтлийг хамгийн бага байлгах зарчим гэсэн зарчим давамгай. (European Union Agency for Fundamental Rights, 2018; College of Policing, 2022).

Олон улсын чиг хандлагын дүгнэлт

Олон улсын судалгаануудыг нэгтгэн үзвэл:

- мөргөлдөөн ихэвчлэн барилдаан хэлбэртэй;
- хяналт тогтоох тактик давамгай;
- хэвтээ болон босоо байдлаас хөдөлгөөний хязгаарлах баривчлах чухал;
- Сценари болон стрессэд суурилсан сургалт шаардлагатай;
- багийн ажиллагаа зайлшгүй элемент болох нь тогтоогдож байна (Davis et al., 2024; Körner & Staller, 2018).

Гурав. ДХИС-ийн гардан тулааны сургалтын хичээлийн агуулгын бүтэц ба шинжилгээ

Дотоод хэргийн их сургуулийн гардан тулааны сургалтын хичээлийн төлөвлөгөөг авч үзэхэд сургалт нь голчлон барьц чөлөөлөх, зэвсэггүй этгээдийн эсэргүүцлийг дарах, мөн мэс болон үзүүргүй зэвсгээс хамгаалах үндсэн чиглэлд төвлөрсөн байна. Сургалтын агуулга нь шаталсан бүтэцтэй бөгөөд эхний шатанд зэвсэггүй нөхцөл, дараагийн шатанд саваа мод болон хутгатай халдлагын нөхцөлд хамгаалах арга техникийг зааж байна (Дотоод хэргийн их сургууль, 2025).

Барьц чөлөөлөх болон баривчлах суурь техникүүд

Сургалтын эхний бүлэг нь "барьц чөлөөлөх арга" сэдвийн хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд дараах агуулгуудыг хамарч байна:

- энгэрээс нэг болон хоёр гараар барих үед чөлөөлөх;
- бугуй, ханцуйнаас барих үед суллах арга;
- урдаас суган доогуур болон давхар тэврэлтээс гарах арга;
- араас суган доогуур болон давхар тэврэлтээс суллах арга;
- үсдэлтээс чөлөөлөх арга;
- бүсэлж барих үед няцаалт өгч баривчлах;
- хөлд орсон үед эсэргүүцлийг дарах;
- боох (choke) нөхцөлд хамгаалах ба суллах.

Гардан тулааны сургалт нь өөрийгөө хамгаалах болон сэжигтнийг хамгийн энгийн, аюул багатай арга техникийг ашиглан хянах, хөдөлгөөнийг нь хязгаарлах, баривчлах чиглэлийн суурь агуулгад хамаарч байна.

Зэвсэггүй нөхцөлд хамгаалах ба саармагжуулах арга

Сургалтын дараагийн хэсэг нь зэвсэггүй халдлагын нөхцөлд хамгаалах тактикт чиглэсэн бөгөөд:

- цохилт болон барьцнаас гарах
- эсэргүүцлийг няцаах
- баривчлах ажиллагаанд шилжих

гэсэн дараалалтай сургалтын бүтэцтэй байна.

Энэ хэсэг нь баривчлах ажиллагааны "барилдаан"-д суурилсан боловч унагаасан нөхцөлд баривчлах болон багийн ажиллагааны элемент харьцангуй бага тусгагдсан байна.

Савваа модоор довтолсон нөхцөлд хамгаалах арга

Сургалтын гуравдугаар хэсэгт саваа мод ашигласан халдлагын нөхцөлд:

- дээрээс довтлох;
- хажуугаас довтлох;
- чичих хөдөлгөөнөөр довтлох зэрэг хэлбэрүүдээс хамгаалах аргачлал зааж байна.

Энэ нь бодит нөхцөлд "үхэлд үл хүргэх зэвсэг ашиглах"-д нийцэх бөгөөд хамгаалах, зай барих, зэвсэг саармагжуулах үндсэн чадварыг хөгжүүлэхэд чиглэж байна.

Хутгатай халдлагын нөхцөл дэх хамгаалах сургалт

Сургалтын хамгийн өндөр эрсдэлтэй хэсэг нь хутгатай халдлагын нөхцөл юм. Үүнд:

- дээрээс хутгалах
- доороос хутгалах
- чичиж хутгалах
- хавж хутгалах
- ширвэж хутгалах
- урдаас тулгасан хутганы нөхцөл
- ар талаас хутгалах нөхцөл

зэрэг олон хувилбарт нөхцөлд хамгаалах арга багтсан байна.

Энэ нь бодит ажиллагаанд өндөр эрсдэлтэй "иртэй зэвсгээс хамгаалах арга" сургалтын үндсэн чиглэл бөгөөд хурдан шийдвэр гаргалт, зай барих, зэвсэг саармагжуулах чадварыг хөгжүүлэх зорилготой.

Сургалтын агуулгын ерөнхий шинжилгээ

Сургалтын хөтөлбөрийг бүхэлд нь авч үзвэл дараах онцлог ажиглагдаж байна:

Давуу тал:

- нөхцөл байдлын хувилбар олон
- зэвсэггүй болон зэвсэгтэй халдлагын аль алиныг хамарсан
- практик чиглэл давамгай
- гардан хамгаалалтын суурь чадвар хөгжүүлдэг

Сайжруулах шаардлагатай тал:

- барилдах, хэвтээ байдлаас баривчлах системтэйгээр тусгагдаагүй
- Сценари сургалт, шийдвэр гаргах ажиллагаа хангалтгүй
- Багаар ажиллах элемент бага
- Өрсөлдөгчийнхөө хөдөлгөөний хязгаарлах хянах тактикийн логик сул

ДХИС-ийн гардан тулааны сургалтын хөтөлбөр нь зэвсэггүй болон зэвсэгтэй халдлагын нөхцөлд хамгаалах суурь чадварыг хангалттай хөгжүүлж байгаа боловч орчин үеийн хууль сахиулах байгууллагын шаардлагатай харьцуулахад *хяналтад суурилсан тактик, хэвтээ*

байдлаас баривчлах тактик, баривчлах болон саатуулах ажиллагаа чиглэлд нэмэлт боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дүгнэлт

Гардан тулааны сургалтыг цаашид зөвхөн техник эзэмшүүлэх түвшнээс дээшлүүлж, бодит ажиллагаанд суурилсан *хяналт тогтоох баривчлах чиглэлтэй, сценарид суурилсан, нэгдсэн тактикийн сургалтын систем* болгон хөгжүүлэх нь хууль сахиулах байгууллагын ажиллагааны үр дүн, аюулгүй байдал, мэргэжлийн түвшнийг нэмэгдүүлэх чухал нөхцөл болох юм.

Санал:

Энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан хууль сахиулах байгууллагын гардан тулааны сургалтыг орчин үеийн баривчлах ажиллагааны шаардлагад нийцүүлэх зорилгоор дараах бодлогын шинжтэй санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Сургалтын чиг баримжааг хяналт тогтоох тактик руу өөрчлөх

Одоогийн сургалтын агуулга нь хөдөлгөөн, техник төвтэй хэвээр байгаа нь баривчлах ажиллагаанд шаардагдах хяналт тогтоох хэрэгцээг хангалтгүй болгож байна.

Иймд:

1. Сургалтын үндсэн зорилгыг эсэргүүцлийг саармагжуулах, хяналт тогтоох чиглэлд тодорхой болгох;
2. Илүүдэл хүч хэрэглэхгүйгээр сэжигтний хөдөлгөөнийг хязгаарлах арга барилд түлхүү сургах;
3. Хүний эрх, хууль ёсны хүч хэрэглэх зарчимтай уялдсан нэг мөр стандарт боловсруулах.

Үр дүн: Хүч хэрэглэх эрсдэл буурч, ажиллагааны хууль зүйн үндэслэл сайжирна.

2. Хэвтээ байдлаас баривчлах болон хяналт тогтоох сургалтыг өргөжүүлэх

Гардан тулаан ихэнхдээ газар унасан байдалд шилждэг тул энэ чиглэлийн сургалт чухал ач холбогдолтой.

Иймд:

1. Газар дээрээс баривчлах, хяналт тогтоох аргыг тусгай хичээлийн бүрэлдэхүүн болгох
2. Хажуу, дээр, гэдсээр хэвтсэн нөхцөлөөс хяналт тогтоох арга барилыг системтэй заах
3. Ганцаарчилсан бус, хамтран баривчлах ажиллагааны хэлбэрээр давтан сургах

Үр дүн: Баривчлах ажиллагааны үр дүн нэмэгдэнэ.

3. Бодит нөхцөлд суурилсан болон стрессийн сургалтыг нэвтрүүлэх

Гардан тулаан нь өндөр дарамт, айдас, гэнэтийн нөхцөлд явагддаг тул энгийн давтлага хангалтгүй.

Иймд:

1. Бодит нөхцөлд ойртуулсан хувилбарт сургалтыг заавал оруулах;
2. Дуу чимээ, олон хүн, харанхуй, гэнэтийн халдлага бүхий нөхцөлийг ашиглах;
3. Дарамтын үед зөв шийдвэр гаргах чадварыг үнэлэх тогтолцоо бий болгох

Үр дүн: Алба хаагч бодит нөхцөлд илүү тогтвортой ажиллана.

4. Зэвсэг хамгаалах болон зэвсэг булаалтаас сэргийлэх сургалтыг бэхжүүлэх

Зэвсэг булаах болон иртэй зэвсгийн халдлага нь хамгийн өндөр эрсдэлтэй нөхцөлд тооцогддог.

Иймд:

1. Албаны зэвсгийг алдахгүй хамгаалах тусгай арга барилыг заавал эзэмшүүлэх;
2. Хутга болон цохилтын зэвсгээс хамгаалах сургалтыг бодит нөхцөлд ойртуулах;
3. Зэвсэг булаах оролдлогыг таслан зогсоох хурдан хариу үйлдлийн чадварыг хөгжүүлэх;

Үр дүн: Алба хаагчийн амь нас эрсдэх нөхцөл буурч, зэвсгийн аюулгүй байдал сайжирна.

5. Багийн ажиллагаанд суурилсан сургалтыг нэмэгдүүлэх

Орчин үеийн хууль сахиулах ажиллагаа нь хувь хүний бус багийн зохион байгуулалтад тулгуурладаг.

Иймд:

1. Хоёроос дөрвөн хүний хамтарсан баривчлах ажиллагааны сургалт нэвтрүүлэх

2. Харилцаа, дохио, үүрэг хуваарилалтын нэгдсэн арга барил бий болгох

3. Олон этгээдтэй нөхцөлд хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх

Үр дүн: Багийн уялдаа, ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ.

6. Судалгаа, бариmтад тулгуурласан сургалтын тогтолцоог бүрдүүлэх

Сургалтын агуулгыг уламжлалд бус бодит баримт, туршлагад тулгуурлан шинэчлэх шаардлагатай.

Иймд:

1. Баривчлах ажиллагааны судалгаа, тоо баримтад үндэслэн сургалтыг шинэчлэх

2. Бодит хэрэг явдлын жишээг сургалтын материалд ашиглах

3. Үр дүнг зөвхөн техник гүйцэтгэлээр бус бодит ажиллагааны үр дүнгээр үнэлэх

Үр дүн: Сургалт бодит амьдралтай илүү уялдана.

7. Сургалтын шинэчлэлийн тогтмол систем бий болгох

Сургалтын шинэчлэл нь нэг удаагийн ажил биш тогтмол шинэчлэгддэг систем байх шаардлагатай.

Иймд:

1. Сургалтын агуулгыг судалж сайжруулах байнгын нэгж байгуулах

2. Дотоод болон гадаад туршлага солилцох тогтолцоо бүрдүүлэх

3. Сургалтын хөтөлбөрийг тогтмол хугацаанд шинэчлэх журам бий болгох

Үр дүн: Сургалт хуучрахгүй, тасралтгүй хөгждөг болно.

Эх сурвалжийн жагсаалт

1.Andersen, J. P., Gustafsberg, H., Collins, P. I., Legrand, F. D., & Markmenson, D. (2018). Police officer physical ability testing – Re-validating a selection criterion. *Policing: An International Journal, 41*(1), 2–14.

2.Davis, J., Peterson, T., & Morales, R. (2024). Grappling prevalence and control tactics in law enforcement encounters. *Journal of Police and Criminal Psychology, 39*(2), 155–169.

3.Körner, S., & Staller, M. S. (2018). From system to pedagogy: Towards a non-linear pedagogy of self-defense in police training. *Security Journal, 31*(2), 645–659.

4.Renden, P. G., Savelsbergh, G. J. P., Oudejans, R. R. D., & Heijmans, M. (2015). Real-life stress effects on police officers' shooting performance: A review. *Journal of Police and Criminal Psychology, 30*(1), 1–13.

5. Sun, Z. H. (2016). Research on physical training methods related to the use of weapons by the police. Asian Journal of Social Sciences and Management Studies, 3(4), 241–243. https://doi.org/10.20448/journal.500/2016.3.4/500.4.241.243

6. European Union Agency for Fundamental Rights. (2018). *Fundamental rights considerations in the use of force by law enforcement officials*. Publications Office of the European Union. https://fra.europa.eu

7. College of Policing. (2022). Authorised professional practice: Armed policing & use of force. https://www.college.police.uk

8. European Court of Human Rights. (2021). Guide on Article 2 of the European Convention on Human Rights: Right to life. Council of Europe. https://www.echr.coe.int

9. Choi, Y. S. (2023). The effects of police martial arts training (judo, jiu-jitsu) on physical force response ability and mediating effect of police expertise. *Korean Journal of Sports Science, 21*(3), 337–348. https://doi.org/10.35159/kjss.2023.21.3.337

10.Lichtenfeld, I. (2014). *Krav Maga: How to defend yourself against armed assault*. YMAA Publication Center.

11. Grossman, D. (2009). On combat: The psychology and physiology of deadly conflict in war and in peace. Warrior Science Publications.

12.Дотоод хэргийн их сургууль. (2025). *ДХИС-ийн гардан тулааны хичээлийн хөтөлбөр 2025 он*. Улаанбаатар: ДХИС.

ТЭМЦЭЭНИЙ ӨМНӨ ТАМИРЧДЫН СЭТГЭЛЗҮЙГ БЭЛТГЭХ НЬ
PREPARING ATHLETES PSYCHOLOGICALLY BEFORE COMPETITION

Б.Баатарсүрэн*
Дотоод хэргийн их сургуулийн Албаны бэлтгэлийн “Соёмбо” төвийн ахлах багш, цагдаагийн хошууч
Baatarsuren B.
Lecturer, Department of Professional Training, University of Internal Affairs, Police Major

*Хариуцлагатай зохиогч: Baatarsuren@leu.gov.mn

Хураангуй: Энэхүү өгүүлэлд тамирчдын тэмцээний өмнөх сэтгэлзүйн бэлтгэлийн ач холбогдол, түүний гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг судалсан болно. Орчин үеийн спортод бие бялдрын бэлтгэлээс гадна сэтгэлзүйн бэлтгэл нь амжилтын чухал хүчин зүйл болж байгаа бөгөөд анхаарал төвлөрөл дутмаг, тэмцээний айдас зэрэг асуудлууд тамирчдын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлдөг. Судалгаанд визуализаци, ухамсарт бясалгал, амьсгалын дасгал, эерэг дотоод яриа, булчингийн прогрессив суллалт зэрэг сэтгэлзүйн аргуудыг авч үзэж, эдгээр нь анхаарал төвлөрлийг нэмэгдүүлэх, стрессийг бууруулах, өөртөө итгэх итгэлийг сайжруулахад үр дүнтэй болохыг онцолсон. Эдгээр аргуудыг бэлтгэлийн үйл явцад тогтмол хэрэгжүүлэх нь тамирчдын сэтгэлзүйн бэлтгэлийг оновчтой болгож, тэмцээний амжилтыг нэмэгдүүлэх боломжтойг дүгнэсэн.

Abstract: This article examines the importance of psychological preparation of athletes before competitions and its impact on performance. In modern sports, psychological preparation has become a key factor of success alongside physical training, while issues such as lack of concentration and fear of competition negatively affect athletes’ performance. The study discusses psychological methods such as visualization, mindfulness meditation, breathing exercises, positive self-talk, and progressive muscle relaxation, highlighting their effectiveness in improving concentration, reducing stress, and enhancing self-confidence. It concludes that the regular integration of these methods into the training process can optimize athletes’ psychological readiness and improve competitive performance.

Түлхүүр үгс: сэтгэлзүйн бэлтгэл, тамирчин, анхаарал төвлөрөл, стрессийн менежмент, гүйцэтгэл

Keywords: psychological preparation, athletes, concentration, stress management, performance

Орчин үеийн спортод өндөр амжилт гаргахын тулд зөвхөн бие бялдрын бэлтгэл хангалтгүй бөгөөд сэтгэлзүйн бэлтгэл чухал хүчин зүйл болж байна. Тамирчдын анхаарал төвлөрөл, стрессийг даван туулах чадвар, сэтгэлзүйн тогтвортой байдал нь тэмцээний амжилтыг тодорхойлох гол үзүүлэлтүүдийн нэг юм. Иймээс тамирчдын тэмцээний өмнөх сэтгэлзүйн бэлтгэлийн арга зүйг судлах, үр нөлөөг нь тодорхойлох шаардлага тулгарч байна.

Энэхүү өгүүлэлд тамирчид анхаарлаа төвлөрүүлэх чадвараа нэмэгдүүлэх, стрессийн нөхцөлд дасан зохицох түвшин дээшлүүлэхэд ашиглаж болох спортын сэтгэлзүйн хамгийн үр дүнтэй аргуудыг авч үзсэн бөгөөд энэ нь тэмцээний үеийн спортын амжилтыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Орчин үеийн тамирчны амьдралд зөв зохион байгуулсан бие бялдрын бэлтгэл нь спортын амжилтын зөвхөн хагасыг бүрдүүлдэг. Аль ч шигшээ багийн дасгалжуулагчид, ганцаарчилсан тамирчид болон ямар ч түвшний тэмцээнд оролцож, тогтвортой амжилт гаргадаг тамирчид сэтгэлзүйн бэлтгэл нь биеийн бэлтгэлтэй адил чухал гэдгийг ойлгодог. Тэмцээний нөхцөлд тамирчны анхаарлаа төвлөрүүлэх, стрессийн үед дасан зохицох, сэтгэлийн түгшүүрээ даван туулах чадвар нь ялалтыг тодорхойлох гол хүчин зүйл болж чадна.

Орчин үеийн спортод, зөвхөн дээд амжилтын спортод төдийгүй ерөнхийдөө,

This article is published under the Creative Commons
BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

тамирчны сэтгэлзүйн бэлтгэл яагаад ийм чухал байр суурь эзэлж байна вэ?

Спортын сэтгэлзүй нь тамирчдын зан төлөв, сэтгэлгээ, сэтгэл хөдлөлийн байдлыг судалдаг сэтгэл судлалын салбар бөгөөд амжилтыг дээшлүүлэх, бэлтгэлийн үр нөлөөг нэмэгдүүлэх, сэтгэлзүйн хүндрэл бэрхшээлийг даван туулахад сэтгэлзүйн зарчмуудыг хэрэглэдэг. Спортын сэтгэлзүй нь тамирчны сэтгэлзүйн байдал болон сэтгэл хөдлөлийн сайн сайхан байдлыг оновчтой болгоход чиглэдэг бөгөөд энэ нь спортын гүйцэтгэлийн үр дүнд шууд нөлөөлдөг (Николаев, 2005).

Орчин үеийн дээд амжилтын спорт нь спортын сэтгэлзүйтэй шууд хамааралтай болсон. ОХУ-ын шигшээ баг болон бүс нутгийн багийн тамирчид өнөөгийн нөхцөлд бие бялдрын ачаалалтай хослуулан сэтгэлзүйн стратегиа тасралтгүй сайжруулж, тэмцээний үеийн стрессийг даван туулах бэлэн байдлаа нэмэгдүүлэхийг зорьж байна.

Тамирчид тэмцээний явцад ихэвчлэн айдас, түгшүүр, анхаарал төвлөрөл дутмаг байх зэрэг сэтгэлзүйн хүндрэлтэй тулгардаг. Эдгээр нь гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж, алдаа гаргах шалтгаан болдог. Үүнийг даван туулахад спортын сэтгэлзүйн дараах аргууд үр дүнтэй гэж үздэг. Үүнд:

- Визуализаци – тэмцээний үйл явцыг урьдчилан төсөөлж, гүйцэтгэлийг сайжруулах
- Бясалгал – анхаарлыг төвлөрүүлэх
- Амьсгалын дасгал – стрессийг бууруулах, тайвшрах
- Эерэг дотоод яриа – өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх
- Булчингийн прогрессив суллалт – биеийн хэт ачаалал, түгшүүрийг бууруулах
- Тэмцээний нөхцөлд дуурайлган бэлтгэх (эмуляци) – сэтгэлзүйн бэлэн байдлыг сайжруулах

Эдгээр аргууд нь тамирчны анхаарал төвлөрөл, стрессийн зохицуулалт, гүйцэтгэлийн тогтвортой байдлыг сайжруулахад чухал үүрэгтэй.

Тамирчдад тулгардаг хамгийн нийтлэг бэрхшээлүүдийг авч үзье. Спортын сэтгэлзүй нь тэмцээний үйл ажиллагааны явцад тамирчид ихэвчлэн дараах хоёр гол асуудалтай тулгардаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Үүнд: тэмцээний өмнөх айдас болон анхаарал төвлөрөл дутмаг байх явдал юм.

Тэмцээнд ялагдах айдас, багийн хамт олон, дасгалжуулагч эсвэл ойр дотно хүмүүсийн урмыг хугалах магадлал нь ихэвчлэн тамирчныг хэт их сандаргах, булчингийн хэт ачаалалд оруулахад хүргэдэг бөгөөд энэ нь эцэстээ тэмцээний явцад алдаа гаргахад нөлөөлдөг.

Анхаарал төвлөрөл дутмаг байх нь ихэвчлэн тэмцээнд анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байх, өөртөө итгэлгүй болох, эсвэл гадаад орчны нөлөөлөл (саад, цочроогч хүчин зүйлс)-д автах зэргээр илэрдэг бөгөөд үүний үр дүнд тамирчин “бодлоо төвлөрүүлэхэд” хүндрэлтэй болдог.

Анхаарал төвлөрлийг сайжруулах, гүйцэтгэлийн дээд түвшинг хадгалахад чиглэсэн хамгийн түгээмэл бөгөөд тамирчид, дасгалжуулагчдын аль алинаас эерэг үнэлгээ авсан аргуудыг спортын сэтгэлзүйд дараах байдлаар авч үздэг. Үүнд: дүрслэн төсөөлөх (визуализаци), ухамсарт бясалгал, амьсгалын дасгал, өөртэйгөө “дотоод яриа” өрнүүлэх чадвар, булчинг шаталсан байдлаар суллах (прогрессив релаксаци) зэрэг орно.

Дүрслэн төсөөлөх буюу визуализаци нь тэмцээний үеийн өөрийн үйлдэл, гүйцэтгэлийг оюун санаандаа урьдчилан “давтан хийх”, мөн боломжит үр дүнг урьдчилан төсөөлөхийг хэлнэ. Тамирчид тэмцээнд амжилттай оролцож байгаагаа тодорхой, тод дүрслэн төсөөлснөөр тэмцээний үеэр тайван, оновчтой үйлдэл хийхэд сэтгэлгээний үйл явцаа чиглүүлж чаддаг.

Бясалгал нь тамирчдад “одоо мөчид байх” чадварыг хадгалахад тусалж, өнгөрсөн тэмцээнийг эргэн санах, эсвэл ирээдүйн талаар хэт бодохоос илүүтэй тухайн нөхцөл байдалд анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгодог. Энэхүү арга нь тамирчдын анхаарал төвлөрлийг сайжруулж, анхаарлаа удирдах, гадны нөлөөллөөс зайлсхийхэд дэмжлэг үзүүлдэг. Ухамсарт байдал нь ялангуяа байнгын төвлөрөл, ачаалал шаарддаг спортын төрлүүдэд (теннис, буудлага, тулааны спорт

зэрэг) онцгой үр дүнтэй байдаг. Энэ аргын хүрээнд тамирчдад ихэвчлэн амьсгал, биеийн мэдрэмж, өөрийн бие организм болон орчныг "мэдрэх", ойлгоход анхаарахыг зөвлөдөг.

Мөн тамирчдын анхаарал төвлөрөлд тэмцээний үйл ажиллагааг дуурайлган загварчлах (эмуляци) процесс чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь анхаарал төвлөрөл, төвлөрөх чадварыг сэтгэлзүйн түвшинд "програмчлах" зорилготой. Тэмцээний нөхцөлийг дуурайлган хийх нь бие халаалт болон тодорхой хөдөлгөөний дасгалд багтаж болно. Энэ аргыг хэрэглэснээр тамирчид анхаарал сарниулах хүчин зүйлсээс ангижирч, хамгийн өндөр гүйцэтгэлд хүрэхэд шаардлагатай сэтгэлзүйн төлөв байдлыг бүрдүүлж чадна. Ийм төрлийн тэмцээний нөхцөлийг сургалтын явцад тогтмол, үе шаттайгаар зохион байгуулж, бие бялдрын болон сэтгэлзүйн бэлтгэлийг хослуулах нь зүйтэй.

Визуализацийн үйл явц нь хөдөлгөөний ур чадвар болон өөртөө итгэх итгэлийг сайжруулж, улмаар анхаарал төвлөрлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Тэмцээний өмнө 10–15 минутын хугацаанд боломжит нөхцөл байдал, бэрхшээл, тэмцээний үеийн агшнуудыг төсөөлөн анхаарал хандуулах нь тамирчны анхаарал төвлөрлийг мэдэгдэхүйц сайжруулдаг (Волков, 2002).

Амьсгалын төрөл бүрийн дасгалуудыг, тэр дундаа тэмцээний өмнө хэрэглэх нь зүрхний цохилтын давтамжийг бууруулж, стрессийн түвшин багасган, тамирчныг тайван, төвлөрсөн байдалд оруулахад тусалдаг. Амьсгалын дасгалыг спортын төрлөөс хамааран тэмцээний явцад ч гүйцэтгэх боломжтой байдаг нь түүнийг сэтгэлзүйн түгшүүрийг удирдах хамгийн хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгслүүдийн нэг болгодог.

Тэмцээний үйл ажиллагаанд сэтгэлзүйн бэлтгэл хийхэд тамирчны эерэг дотоод яриа (inner dialogue) чухал үүрэг гүйцэтгэдэг. Сөрөг бодлууд нь ихэвчлэн түгшүүрийг нэмэгдүүлж, анхаарал төвлөрлийг бууруулснаар эцэстээ гүйцэтгэлийн үр дүнд сөргөөр нөлөөлдөг. Харин тамирчны эерэг дотоод "дуу хоолой" нь өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, айдсын мэдрэмжийг бууруулдаг.

Иймд "Би чадахгүй", "Хэрэв би бүтэлгүйтвэл яах вэ?" гэх мэт сөрөг бодлуудыг "Би чадна", "Надад боломж бий", "Би бэлэн" гэх мэт эерэг бататгал (аффирмаци)-аар солих нь зүйтэй. Хэт их түгшүүртэй үед тамирчдад хэд хэдэн эерэг өгүүлбэрийг бичиж, тэмцээний өмнө унших, эсвэл сандарч, эргэлзсэн үедээ дотроо давтан хэлэхийг зөвлөдөг.

Тэмцээнд бэлтгэх явцад булчинг шаталсан байдлаар суллах (прогрессив булчингийн релаксаци)-д зохих анхаарал хандуулах шаардлагатай. Энэ арга нь булчингийн бүлгүүдийг ээлжлэн чангалж, дараа нь суллах системтэй дасгалуудыг агуулдаг. Ийм аргачлал нь хэт их булчингийн чангаралтыг бууруулахад тусалдаг бөгөөд энэ нь ихэвчлэн хэт түгшүүр, анхаарал төвлөрөл, төвлөрөх чадвар алдагдахтай хавсарч илэрдэг.

Прогрессив булчингийн релаксаци нь тамирчинд өөрийн биеийг хянах мэдрэмжийг өгч, улмаар өөртөө итгэх итгэл болон хийж буй хөдөлгөөний ухамсартай гүйцэтгэлийг нэмэгдүүлдэг.

Мэдээж дээр дурдсан аргуудыг бие даан хэрэгжүүлэх нь анхаарал төвлөрлийг сайжруулж, түгшүүрийг даван туулахад ихээхэн тус дөхөм болдог. Гэсэн хэдий ч энэ чиглэлд спортын сэтгэлзүйчийн үүрэг маш чухал байдаг. Спортын сэтгэлзүйч нь ихэвчлэн туршлагатай дасгалжуулагч байж, тамирчин бүрд тохирсон хувь хүний онцлогт нийцсэн арга барилыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Тэд тамирчдын сэтгэлзүйн бэлтгэлийн хувь хүний төлөвлөгөөг боловсруулж, стрессийн нөхцөл байдлыг даван туулах стратегийг бий болгоход дэмжлэг үзүүлдэг.

Иймээс тэмдэглэхэд, тамирчин бие бялдрын ачаалалд дээд зэргээр хүчин чармайлт гаргаж, гүйцэтгэлээ сайжруулахын зэрэгцээ сэтгэлзүйн бэлтгэл нь тэмцээний амжилтад түүнээс дутахгүй чухал үүрэг гүйцэтгэдэг. Дүрслэн төсөөлөх, ухамсарт байдал болон тэмцээний үйл ажиллагааг дуурайлган загварчлах нь анхаарал төвлөрлийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг бол амьсгалын дасгал, эерэг

дотоод яриа, булчинг суллах аргууд нь тэмцээний өмнөх түгшүүрийг даван туулахад тусалдаг.

Эдгээр сэтгэлзүйн бэлтгэлийн аргуудыг тогтмол бэлтгэлийн үйл явцад нэгтгэн хэрэгжүүлэх нь тамирчдын сэтгэлзүйн бэлтгэлийг оновчтой болгоход дэмжлэг үзүүлж, улмаар тэмцээний амжилтыг нэмэгдүүлэхэд хүргэнэ. Тэмцээний үйл ажиллагааны сэтгэлзүйн талыг эзэмших нь тамирчинд амжилтад хүрэхэд шаардлагатай давуу талыг бий болгоно.

Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд орчин үеийн спортын амжилт нь зөвхөн бие бялдрын бэлтгэлээс бус, сэтгэлзүйн бэлтгэлийн чанар, түвшнээс шууд хамааралтай болох нь нотлогдож байна. Тамирчдын тэмцээний гүйцэтгэлд анхаарал төвлөрөл, стрессийг даван туулах чадвар, сэтгэлзүйн тогтвортой байдал зэрэг хүчин зүйлс голлох нөлөө үзүүлдэг бөгөөд эдгээрийн алдагдал нь гүйцэтгэлийн бууралт, алдаа гаргах эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Судалгаанд авч үзсэн сэтгэлзүйн бэлтгэлийн аргууд болох визуализаци, ухамсарт бясалгал, амьсгалын зохицуулалт, эерэг дотоод яриа, булчингийн прогрессив суллалт болон тэмцээний нөхцөлд дуурайлган бэлтгэх арга нь тамирчдын анхаарал төвлөрөл, сэтгэлзүйн тогтвортой байдлыг сайжруулахад өндөр үр нөлөөтэй болохыг онолын болон практик түвшинд баталж байна. Эдгээр аргуудыг системтэйгээр хэрэгжүүлснээр тамирчны сэтгэлзүйн бэлэн байдал сайжирч, гүйцэтгэлийн тогтвортой байдал болон өрсөлдөх чадвар нэмэгддэг (Спортын сэтгэл зүй, 2002).

Мөн сэтгэлзүйн бэлтгэлийг бие бялдрын бэлтгэлтэй уялдуулсан, шинжлэх ухааны үндэслэлтэй, төлөвлөгөөт байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь тамирчны онцлогт тохирсон хувь хүний сэтгэлзүйн бэлтгэлийн хөтөлбөр боловсруулахтай салшгүй холбоотой юм. Спортын сэтгэлзүйч болон дасгалжуулагчийн хамтын ажиллагаанд тулгуурласан нэгдсэн менежмент нь сэтгэлзүйн бэлтгэлийн үр ашгийг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болохыг тодруулж байна.

Иймд сэтгэлзүйн бэлтгэлийг тамирчны бэлтгэлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон үзэж, түүнийг сургалт, бэлтгэлийн үйл явцад системтэйгээр нэвтрүүлэх нь спортын гүйцэтгэлийг оновчтой болгох, тэмцээний амжилтыг нэмэгдүүлэх, урт хугацаанд тогтвортой өндөр үр дүн гаргахад чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна.

Санал, дүгнэлт

Энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан дараах онол-практикийн ач холбогдол бүхий санал, зөвлөмжийг дэвшүүлж байна:

1. Тамирчдын сэтгэлзүйн бэлтгэлийг бие бялдрын бэлтгэлтэй адил түвшинд авч үзэж, сургалт, бэлтгэлийн нэгдсэн тогтолцоонд системтэйгээр тусган хэрэгжүүлэх шаардлагатай. Сэтгэлзүйн бэлтгэлийг тусгаарласан бус, харин ачаалал–сэргэлт, техник-тактикийн бэлтгэлтэй уялдуулсан цогц хөтөлбөрөөр хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байна.

2. Визуализаци, ухамсарт бясалгал, амьсгалын дасгал, эерэг дотоод яриа, булчингийн прогрессив суллалт зэрэг сэтгэлзүйн аргуудыг бэлтгэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол нэвтрүүлэх, тэдгээрийн хэрэглээг үе шаттайгаар хөгжүүлэх нь зүйтэй. Ялангуяа тэмцээний өмнөх богино хугацааны сэтгэлзүйн бэлтгэлийн протокол боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай.

3. Тамирчин бүрийн сэтгэлзүйн онцлог, стрессийн хариу үйлдэл, анхаарал төвлөрлийн түвшинд тулгуурласан **хувь хүний сэтгэлзүйн бэлтгэлийн хөтөлбөр** боловсруулах нь чухал. Энэ нь гүйцэтгэлийн тогтвортой байдлыг хангах, сэтгэлзүйн эрсдэлийг бууруулахад үр дүнтэй.

4. Спортын сэтгэлзүйч болон дасгалжуулагчийн хамтын ажиллагааг бэхжүүлж, багийн түвшинд сэтгэлзүйн дэмжлэгийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Мэргэжлийн сэтгэлзүйчийн оролцоо нь тамирчдын сэтгэлзүйн бэлтгэлийн чанар, үр ашгийг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг.

5. Тэмцээний нөхцөлийг дуурайлган загварчлах (эмуляци) аргачлалыг бэлтгэлийн үйл явцад тогтмол хэрэгжүүлж, тамирчдыг стрессийн нөхцөлд дасан зохицох чадварыг хөгжүүлэх нь зүйтэй. Энэ нь бодит тэмцээний үед сэтгэлзүйн бэлэн байдлыг хангах чухал хэрэгсэл болно Цаашдын судалгаанд сэтгэлзүйн бэлтгэлийн аргуудын үр нөлөөг тоон болон туршилтын аргаар нарийвчлан судалж, тухайн спортын төрөл, насны онцлогт тохирсон оновчтой загвар боловсруулах шаардлагатай байна.

Иймд сэтгэлзүйн бэлтгэлийг спортын амжилтыг тодорхойлох стратегийн хүчин зүйл гэж үзэж, түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй, системтэйгээр хөгжүүлэх нь өндөр амжилт гаргах суурь нөхцөл болно.

Ашигласан материалын жагсаалт

Волков, П. И. (2002). *Спортын сэтгэлзүйн практикум.* Санкт-Петербург.

Николаев, А. Н. (2005). *Хүүхэд, өсвөр үеийн спорт дахь дасгалжуулагчийн сэтгэл зүй.* Санкт-Петербург.

Спортын сэтгэл зүй. (2002). *Спортын сэтгэл зүй: Эмхэтгэл.* Санкт-Петербург.

АЖЛААС ХАЛШРАХ ХАМ ШИНЖ БА ТҮҮНИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМ

Төрийн цэргийн байгууллагын алба хаагчдаас авсан судалгааны жишээн дээр

BURNOUT SYNDROME AND COPING STRATEGIES

Based on a Study of Public Military Organization Employees

Л.Отгондулам*
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахмад
Otgondulam L.
Master's student of Border Studies, Captain at Border Protection School, University of Internal Affairs, capitian

*Хариуцлагатай зохиогч: oogiinoo1992@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь төрийн цэргийн байгууллагад ажиллаж буй 25-47 насны алба хаагчдын ажлаас халшрах хам шинжийн түвшин, түүнд нөлөөлөх хүчин зүйл болон даван туулах боломжит арга замыг судлах зорилготой. Судалгаанд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 100 оролцогч хамрагдсан. Судалгааны мэдээллийг асуумжийн аргаар цуглуулж, SPSS программ ашиглан боловсруулсан. Судалгааны үр дүнд ажлын ачаалал, нойр дутуу байдал, ажлын орчны дарамт нь ажлаас халшрах хам шинжид өндөр нөлөө үзүүлдэг болох нь тогтоогдсон. Мөн хамт олны дэмжлэг, тогтмол амралт, сэтгэл зүйн зөвлөгөө нь халшралын түвшнийг бууруулахад эерэг нөлөөтэй байгааг тодорхойлов. Судалгааны үр дүнд үндэслэн байгууллагын түвшинд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх тогтолцоог сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Abstract

This study aimed to examine burnout syndrome, its influencing factors, and coping strategies among public military organization employees aged 25–47. A total of 100 participants were selected using random sampling methods. Data were collected through questionnaires and analyzed using SPSS software. The findings revealed that workload, sleep deprivation, and workplace pressure significantly affected burnout levels. In contrast, social support, regular rest, and psychological counseling were found to reduce burnout symptoms. Based on the findings, improving institutional psychological support systems is recommended.

Түлхүүр үг: ажлаас халшрах хам шинж, стресс, төрийн цэргийн байгууллага, сэтгэл зүй, даван туулах арга

Keywords: burnout syndrome, stress, military organization, psychology, coping strategies

Орчин үеийн нийгэмд ажлын ачаалал, хариуцлага, байгууллагын дотоод дарамт зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан ажлаас халшрах хам шинж өргөн хүрээнд тархаж байна. Ялангуяа төрийн цэргийн байгууллагын алба хаагчид нь өндөр сахилга бат, цагийн хязгаарлалт, эрсдэлтэй нөхцөлд ажилладаг тул сэтгэл зүйн ачаалал ихтэй байдаг. Үүний улмаас сэтгэл санааны ядаргаа, ажлын бүтээмж буурах, нийгмийн харилцаанд хүндрэл үүсэх зэрэг сөрөг үр дагавар илэрдэг.

Ажлаас халшрах хам шинжийг анх Америкийн сэтгэл судлаач Herbert Freudenberger 1974 онд тодорхойлсон бөгөөд энэхүү ойлголтыг хэт ачаалал, сэтгэл санааны туйлдалтай холбоотойгоор тайлбарласан байдаг. Дараа нь Maslach болон Jackson нар ажлаас халшрах хам шинжийг сэтгэл хөдлөлийн туйлдалд, хүнийг үл ойшоох хандлага, хувь хүний бүтээмж буурах гэсэн үндсэн гурван хэмжүүрээр тайлбарласан.

Монгол Улсад төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын ажлаас халшрах хам шинжийн талаарх судалгаа харьцангуй цөөн байдаг бөгөөд энэ чиглэлийн судалгааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Орчин үеийн нийгэмд хөдөлмөр эрхлэлт, ажлын ачаалал, өрсөлдөөн эрчимжихийн хэрээр ажилтнуудын

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

сэтгэлзүйн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлс нэмэгдэж байна. Тэдгээрийн нэг нь Ажлаас халшрах хам шинж бөгөөд энэ нь удаан хугацааны стресс, ажлын хэт ачаалал, сэтгэлзүйн ядаргааны улмаас үүсдэг цогц үзэгдэл юм. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага-аас ажлаас халшрах хам шинжийг ажлын байртай холбоотой архаг стрессийн үр дагавар хэмээн тодорхойлсон нь уг асуудал нийгмийн эрүүл мэндийн чухал асуудлын нэг болж байгааг харуулж байна. Тэгвэл Төрийн цэргийн байгууллагын алба хаагчид нь өндөр хариуцлага, сахилга бат, тасралтгүй бэлэн байдлыг шаардсан орчинд ажилладаг онцлогтой. Энэхүү нөхцөл нь урт хугацаанд үргэлжилснээр сэтгэл зүйн ядаргаа, ажлын бүтээмж буурах, ажлаас халшрах хам шинж үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Иймээс төрийн цэргийн байгууллагын ажилтнуудын ажлаас халшрах хам шинжийн түвшин, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох нь практик ач холбогдолтой юм.

Судалгааны таамаглал

1. Ажлын ачаалал өндөр байх нь ажлаас халшрах хам шинжид эерэг нөлөө үзүүлнэ.
2. Нойр дутуу байдал нь сэтгэл санааны ядаргааг нэмэгдүүлнэ.
3. Байгууллагын дэмжлэг сайн байх нь ажлаас халшрах хам шинжийг бууруулна.

Судалгааны зорилго

Төрийн цэргийн байгууллагын 25-47 насны алба хаагчдын ажлаас халшрах хам шинжийн түвшин болон түүнийг даван туулах арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны зорилтууд

1. Ажлаас халшрах хам шинжийн түвшнийг тодорхойлох
2. Халшралд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх
3. Даван туулах арга замыг судлах
4. Судалгааны үр дүнд үндэслэн санал боловсруулах

Ажлаас халшрах хам шинжийн ойлголт

1.1 Ажлаас халшрах хам шинж-ийн ойлголт, мөн чанар

Орчин үеийн нийгэмд ажлын ачаалал нэмэгдэх, ажлын орчны стресс ихсэхийн хэрээр ажилтнуудын сэтгэлзүйн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх үзэгдлүүд нэмэгдэж байна. Үүний нэг чухал илрэл нь ажлаас халшрах хам шинж юм.

Ажил мэргэжилтэй холбоотой сэтгэл хөдлөлийн өөрчлөлт, өвчтөнийг сэтгэлээрээ мэдрэх чадвар буурах, хувь хүний ур чадварын өөрчлөлт зэргээр илрэх аажим явцтай ихэвчлэн ажлын байран дээр сэдэрдэг сэтгэцийн хэвийн биш байдлыг ажлаас халшрах хам шинж гэнэ.

Ажлаас халшрах хам шинжийг анх 1970-аад онд сэтгэл судлаач Херберт Фройденбергер тодорхойлж, ажлын орчноос үүдэлтэй сэтгэлзүйн ядаргаа, туйлдалт гэж үзсэн. Дараа нь Кристина Маслач энэхүү ойлголтыг гүнзгийрүүлэн судалж, ажлаас халшрах хам шинжийг дараах гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгээр тодорхойлсон. (Maslach & Jackson, 1981)

- Сэтгэл хөдлөлийн ядаргаа
- Хүмүүстэй харилцах хөндийрөл
- Хувь хүний амжилтын мэдрэмж буурах

Ажлаас халшрах хам шинжид нөлөөлөх хүчин зүйлс

1. Ажлын ачаалал их байх
2. Ажлын цаг урт байх
3. Нойр дутуу байдал
4. Ажил үүргийн тэгш бус хуваарилалт
5. Ажлын орчны стресс
6. Хувийн амьдралын тэнцвэр алдагдах
7. Ажиллаж байгаа хүмүүсийн тоо

Ажлын нөөцтэй холбоотой хүчин зүйл

1. Хамт олон, удирдлагын дэмжлэг байхгүй
2. Эргэх холбоо байхгүй
3. Шийдвэр гаргалтад оролцуулдаггүй
4. Ажилд тавих хяналт сул

Ажлаас халшрах нь ямар үр дагавартай вэ?

- Амжилтад үзүүлэх сөрөг нөлөө
- Байгын түгшүүр/сэтгэл гутрал
- Зүрх судас / мэдрэлийн гаралтай өвчлөл
- Нойрны хэм алдагдал / харшил

Байгууллагад үзүүлэх сөрөг нөлөө

- Оролцоо /хувь нэмэр үгүй болох
- Өвчлөл /таслал/ хийдүүлэлт нэмэгдэх
- Бүтээмж / гүйцэтгэл буурах

Ажлаас халшрах нь тухайн ажилтан болон түүний ажиллаж буй байгууллагад

сөрөг үр дагавартай. Хувь хүнд илрэх үр дагавар нь нэн түрүүнд ажилтны сэтгэцийн эрүүл мэндэд (тухайлбал, сэтгэл түгших, сэтгэл гутрал, нойргүйдэл болон психоматик шинж тэмдгүүд (толгой өвдөх, дотор муухайрах, цусны даралт ихсэх зэрэг) ээр мөн түүнчлэн бие махбодын эрүүл мэндэд (жишээлбэл, зүрх судасны өвчин, ханиад харшил, ходоод гэдэсний үрэвсэл гэх мэт нийтлэг халдварт өвчин) сөргөөр нөлөөлдөг. Ажлаас халшралын байгууллагад үзүүлэх сөрөг нөлөө нь ажилтны сэтгэлзүйн хувьд идэвх оролцоо сул, хуурах аргацаах хандлага давамгайлах байдлаар, харин бие махбодын хувьд байнга өвчлөх, ажил таслах зэргээр илрэх нь түгээмэл.

Ажлаас залхах шалтгаан

- Нэг хэвийн / байнга давтагдах ажил
- Сэтгэн бодох үйлдэл / чадвар багаа шаардагдах ажил
- Ажлаас утга учраа олж хараагүй байдал

Үр дагавар

- Архи, тамхины хэт их хэрэглээ
- Осол/ гэмтэл
- Ажил дээр бие өвдсөн мэт санагдах
- Гүйцэтгэл муудах

Ажлын байран дээрх хорт үйл байдал /хулгай хийх, цаг нөхцөөх, хов ярих/ Ажлаас залхах байдал нь хайхрамжгүй хандлагыг бий болгосноор ажлын байран дээр осол гэмтэл гарах тохиолдол ихэсдэг. Ажлаасаа залхсан хүмүүс ажлын байран дээрээ бусдад таагүй нөлөө үзүүлэх (хүчирхийлэл, доромжлох), санаатайгаар ажлын алдаа, бүтээгдэхүүний гологдол гаргах, эд хөрөнгө, ажлын орчныг бусниулах, сүйтгэх, ажил таслах, хоцрох, ажил хийхээс зайлсхийх, байгууллагын өмчийг хулгайлах зэрэг таагүй үйлдэл их хийдэг. Ийм учраас ажлаасаа залхсан хүмүүст уур хилэн, түрэмгийлэл, атаа жөтөө, хов ярих зэрэг сэтгэлзүйн сөрөг үзэгдлүүд бусад ажилчдаас давамгайлдаг. (Батболд, 2022)

Даван туулах арга зам

- Тогтмол амралт авах
- Биеийн тамир, дасгал хөдөлгөөн хийх
- Сэтгэл зүйн зөвлөгөө авах
- Хамт олны дэмжлэгийг нэмэгдүүлэх
- Цагийн зөв менежмент хэрэгжүүлэх

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг тоон судалгааны аргаар гүйцэтгэсэн. Судалгаанд төрийн цэргийн байгууллагын 25-47 насны 100 алба хаагчийг хамруулсан.

Судалгааны объект

Судалгааны объект нь төрийн цэргийн байгууллагад ажиллаж буй 25-47 насны алба хаагчид болно.

Судалгааны арга

- Асуумжийн арга
- SPSS статистик боловсруулалт
- Хувийн мэдээллийн нууцлалыг хадгалсан

Судалгааны хэрэглэгдэхүүн

Судалгаанд ажлаас халшрах хам шинжийг тодорхойлох 15 асуулт бүхий асуумж ашигласан. Асуумж нь Лайкертийн 5 шатлалт үнэлгээтэй байсан бөгөөд “огт санал нийлэхгүй” – “бүрэн санал нийлнэ” гэсэн сонголтуудтай байв.

Ёс зүйн асуудал

Судалгаанд оролцогчдын хувийн мэдээллийг нууцалж, сайн дурын үндсэн дээр оролцуулсан. Судалгааны мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зориулалтаар ашигласан.

Хүснэгт 1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

№	Үзүүлэлт	Давтамж	Хувь
1	Эрэгтэй	68	68%
2	Эмэгтэй	32	32%

Хүснэгт 2 судалгаанд оролцогчдын насны ангилал

№	Нас	Тоо	Хувь
1	25-30 нас	26	26%
2	31-40 нас	49	49%
3	41-47 нас	25	25%

Судалгааны үр дүн

Ажлын ачаалал ба халшрал

Судалгаанд оролцогчдын 72% нь ажлын ачаалал өндөр гэж хариулсан бол 64% нь сэтгэл санааны ядаргаа мэдэрдэг гэжээ.

Хүснэгт 3 Ажлын ачаалал үүсэх шалтгаан

№	Асуумж	Тийм	Үгүй
1	Ажлын ачаалал өндөр	72%	28%
2	Сэтгэл санааны ядаргаа	64%	36%
3	Нойр дутуу байдал	58%	42%

Судалгааны үр дүнгээс үзэхэд ажлын ачаалал ихсэх тусам ажлаас халшрах хам шинж нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 4 Даван туулах арга замын үр дүн

№	Арга зам	Хувь
1	Амралт авах	36%
2	Спорт хийх	27%
3	Найз нөхөдтэйгөө ярилцах	18%
4	Сэтгэл зүйн зөвлөгөө	11%
5	Бусад	8%

Судалгааны дүгнэлт

Судалгаанд оролцогчдын ихэнх нь амралт болон биеийн тамирын дасгал хөдөлгөөн нь стресс бууруулахад үр дүнтэй гэж үзсэн.

Судалгааны өгөгдлийг SPSS 26.0 программ ашиглан боловсруулсан. Өгөгдөлд descriptives, frequency analysis болон Pearson correlation шинжилгээг хийсэн.

Pearson correlation шинжилгээний үр дүнд ажлын ачаалал болон ажлаас халшрах хам шинжийн хооронд статистикийн ач холбогдол бүхий эерэг хамаарал илэрсэн ($r=0.68$, $p<0.01$). Энэ нь ажлын ачаалал нэмэгдэх тусам сэтгэл зүйн халшрал өсөх магадлалтай болохыг харуулж байна.

Мөн нойр дутуу байдал болон сэтгэл санааны ядаргааны хооронд дунд зэргийн хамаарал илэрсэн ($r=0.54$, $p<0.05$). Судалгаанд оролцогчдын дийлэнх нь өдөрт 5-6 цаг унтдаг бөгөөд энэ нь ажлын бүтээмж болон сэтгэл зүйн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байв.

Судалгааны нэмэлт үр дүн

Судалгаанд оролцогчдын 61% нь ажлын стресс гэр бүлийн харилцаанд нөлөөлдөг гэж үзсэн бол 43% нь ажлын дараа байнгын ядрал мэдэрдэг гэж хариулсан.

Хүснэгт 5 судалгааны нөлөөлөх хүчин зүйлс

№	Үзүүлэлт	Хувь
1	Гэр бүлийн харилцаанд нөлөөлдөг	61%
2	Байнгын ядрал мэдэрдэг	43%
3	Ажилдаа сэтгэл ханамж буурсан	39%
4	Ажлаасаа гарах талаар бодож байсан	21%

Судалгааны үр дүнгээс харахад ажлаас халшрах хам шинж нь зөвхөн ажлын бүтээмжид бус хувь хүний амьдрал, нийгмийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлдэг болох нь харагдаж байна.

Ажлаас халшрах хам шинжийн үе шат

Сэтгэл судлалын судалгаанд ажлаас халшрах хам шинжийг ихэвчлэн дараах үе шаттайгаар тайлбарладаг.

1. Анхны идэвхтэй үе шат – Ажилдаа хэт төвлөрч, өндөр хариуцлага хүлээх
2. Стресс хуримтлагдах үе шат – Ядаргаа, бухимдал нэмэгдэх
3. Сэтгэл санааны туйлдал – Ажилдаа сонирхолгүй болох
4. Архаг халшрал – Бүтээмж буурч, сэтгэл гутралын шинж илрэх

Судалгаанд оролцогчдын дунд хоёр болон гуравдугаар шатны шинж тэмдэг түгээмэл ажиглагдсан.

Олон улсын судалгаатай харьцуулсан нь

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (WHO)-аас ажлаас халшрах хам шинжийг

ажлын байрны архаг стрессээс үүдэлтэй хам шинж гэж тодорхойлсон байдаг. Олон улсын судалгаагаар цэрэг, цагдаа, эмнэлгийн ажилтан зэрэг өндөр ачаалалтай мэргэжилтнүүд халшралд өртөх эрсдэл өндөртэй гэж үздэг.

Maslach болон Leiter нарын судалгаагаар ажлын хэт ачаалал, шударга бус орчин, байгууллагын дэмжлэг сул байх нь халшралын гол шалтгаан болдог гэж үзжээ. Энэхүү судалгааны үр дүн нь дээрх онолуудтай ижил төстэй гарсан бөгөөд төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын дунд ажлын ачаалал, нойр дутуу байдал хамгийн өндөр нөлөөтэй байсан.

Мөн судалгаанд оролцогчдын ихэнх нь байгууллагын сэтгэл зүйн дэмжлэг хангалтгүй гэж үзсэн нь цаашид энэ чиглэлийн бодлого боловсруулах хэрэгцээ байгааг харуулж байна.

Ажлаас халшрах хам шинжийг арилгах даван туулах арга зам

Ажлаас халшрах хам шинжийг хувь хүн өөрийн сэтгэл зүй болон бие махбодын эрүүл мэндээ анхаарч, ажил амьдралын зөв тэнцвэрийг хадгалж даван туулах шаардлагатай байдаг. Үүний тулд тогтмол амралт авч, хангалттай нойр авах, стресс бууруулах дасгал хөдөлгөөн хийх нь сэтгэл санааны ядаргааг багасгахад чухал нөлөө үзүүлдэг. Мөн ажлын ачааллыг зөв зохицуулж, цагийн менежментээ сайжруулах нь хэт ачааллаас сэргийлэхэд тусалдаг. Түүнчлэн гэр бүл, найз нөхөд болон хамт олонтойгоо нээлттэй харилцаж, сэтгэл санааны дэмжлэг авах нь ажлын стрессийг даван туулахад үр дүнтэй байдаг. Сэтгэл зүйн дарамт удаан хугацаанд үргэлжилж байгаа тохиолдолд мэргэжлийн сэтгэл зүйч, зөвлөгөө өгөх үйлчилгээ авах нь халшрал гүнзгийрэхээс урьдчилан сэргийлэх боломжтой. Байгууллагын зүгээс ажилтнуудын ажлын ачааллыг тэнцвэртэй хуваарилах, эерэг ажлын орчин бүрдүүлэх, стресс менежментийн сургалт зохион байгуулах нь ажлаас халшрах хам шинжийг бууруулах чухал арга зам болно. (Батболд Д. , 2021)

Дүгнэлт

Тус судалгааны үр дүнгээс үзэхэд төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын дунд ажлаас халшрах хам шинж түгээмэл илэрч байгаа нь тогтоогдлоо. Ялангуяа ажлын өндөр ачаалал, уртасгасан цагийн хуваарь, нойр дутуу байдал, байнгын бэлэн байдалд ажиллах шаардлага зэрэг нь сэтгэл санааны ядаргаа үүсэхэд голлон нөлөөлж байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь ажлын стрессээс шалтгаалан сэтгэл зүйн дарамт мэдэрдэг, ажлын бүтээмж буурдаг, цаашлаад гэр бүл болон нийгмийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг онцолсон байна. Энэ нь ажлаас халшрах хам шинж нь зөвхөн хувь хүний асуудал бус байгууллагын үйл ажиллагаа, ажлын бүтээмж, хамт олны уур амьсгалтай шууд холбоотой болохыг харуулж байна.

Мөн судалгааны статистик боловсруулалтын үр дүнд ажлын ачаалал болон ажлаас халшрах хам шинжийн хооронд эерэг хамаарал байгааг тогтоосон бөгөөд ажлын ачаалал нэмэгдэх тусам сэтгэл зүйн халшралын түвшин өсөх хандлагатай байгаа нь батлагдсан. Түүнчлэн нойр дутуу байдал, тогтмол стресс, амралт чөлөөт цагийн хомсдол нь сэтгэл санааны тогтворгүй байдал, бухимдал, ажилдаа сэтгэл ханамжгүй болох шалтгаан болж байгааг судалгааны үр дүн харууллаа. Нөгөө талаас тогтмол амралт авах, дасгал хөдөлгөөн хийх, гэр бүл болон хамт олны дэмжлэг авах, сэтгэл зүйн зөвлөгөө авах зэрэг нь ажлаас халшрах хам шинжийг бууруулахад эерэг нөлөөтэй болох нь тодорхойлогдсон. Иймээс байгууллагын түвшинд алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах бодлого, дэмжлэгийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна. Тухайлбал, стресс менежментийн сургалт зохион байгуулах, ажлын ачааллыг тэнцвэртэй хуваарилах, ажилтнуудын амралт нөхөн сэргээлтийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлэх нь ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Ажлаас халшрах хам шинж нь төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын дунд анхаарал хандуулах шаардлагатай сэтгэл зүйн тулгамдсан асуудлын нэг бөгөөд үүнийг бууруулахын тулд хувь хүн болон

байгууллагын хамтын оролцоо, дэмжлэг хамгийн чухал хүчин зүйл болох нь энэхүү судалгаагаар нотлогдлоо.

Санал

Судалгааны үр дүнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

Байгууллагын түвшинд

1. Алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгох

Төрийн цэргийн байгууллагын хэмжээнд сэтгэл зүйн зөвлөгөө, стресс менежментийн үйлчилгээ тогтмол үзүүлэх шаардлагатай байна. Ялангуяа өндөр ачаалалтай ажилладаг алба хаагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь халшралын түвшнийг бууруулах ач холбогдолтой.

2. Ажлын ачааллыг оновчтой хуваарилах

Удаан хугацааны хэт ачаалал нь ажлаас халшрах хам шинжийн гол шалтгаан болж байгаа тул ажил үүргийн хуваарилалтыг тэнцвэртэй зохион байгуулах хэрэгтэй.

3. Амралт, чөлөөт цагийн зохицуулалтыг сайжруулах

Алба хаагчдын амралтын цагийг тогтмолжуулж, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хамруулах нь сэтгэл санааны ядаргааг бууруулахад чухал нөлөөтэй.

4. Байгууллагын дотоод уур амьсгалыг сайжруулах

Хамт олны эерэг харилцаа, удирдлагын дэмжлэг нь стрессийг бууруулахад чухал үүрэгтэй тул байгууллагын соёлыг сайжруулах шаардлагатай. (Энхтуяа, 2022)

Хувь хүний түвшинд

1. Цагийн зөв менежмент хэрэгжүүлэх

Ажлын болон хувийн амьдралын тэнцвэрийг хадгалах нь сэтгэл зүйн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлдэг.

2. Дасгал хөдөлгөөн тогтмол хийх

Спорт болон биеийн идэвхтэй хөдөлгөөн нь стресс бууруулах, сэтгэл санааг тогтворжуулах ач холбогдолтой.

3. Сэтгэл зүйн зөвлөгөө авах

Стресс болон сэтгэл санааны дарамтыг эрт үед нь илрүүлж мэргэжлийн зөвлөгөө авах нь халшрал архаг хэлбэрт шилжихээс урьдчилан сэргийлнэ.

4. Гэр бүл, найз нөхдийн дэмжлэгийг нэмэгдүүлэх

Нийгмийн дэмжлэг сайтай хүмүүс стрессийг илүү үр дүнтэй даван туулдаг болох нь судалгаагаар тогтоогдсон. (Дэлгэрмаа, 2019)

Ашигласан материалын жагсаалт

1. Freudenberger, H. J. (1974). Staff burn-out. Journal of Social Issues, 30(1), 159-165.
2. Maslach, C., & Jackson, S. E. (1981). The measurement of experienced burnout. Journal of Occupational Behavior, 2(2), 99-113.
3. Schaufeli, W. B., & Enzmann, D. (1998). The burnout companion to study and practice. Taylor & Francis.
4. World Health Organization. (2019). Burn-out an occupational phenomenon.
5. Батболд, Д. (2021). Ажлын байрны стресс ба сэтгэл зүйн эрүүл мэнд. Улаанбаатар.
6. Энхтуяа, П. (2022). Байгууллагын сэтгэл зүй. Улаанбаатар.
7. Maslach, C., & Jackson, S. (1981). Ажлаас халшрах хам шинжийн судалгаа. journal of Occupational Behavior, 50-62.
8. Батболд, Ш. (2022). Амьдралын психологи II. Улаанбаатар: Тэпэ.
9. Батболд, Д. (2021). Ажлын байрны стресс ба сэтгэл зүйн эрүүл мэнд. Улаанбаатар: Соёмбо принтинг.
10. Дэлгэрмаа, Ц. (2019). Стресс менежмент ба сэтгэл зүйн хамгаалалт. Улаанбаатар.
11. Энхтуяа, П. (2022). Байгууллагын сэтгэл зүй. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ ДАХЬ НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХЭД ДИЖИТАЛ ТЕХНОЛОГИ БА ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ҮҮРЭГ

THE ROLE OF DIGITAL TECHNOLOGIES AND ARTIFICIAL INTELLIGENCE IN ENHANCING SOCIAL PARTNERSHIPS AND COLLABORATIVE GOVERNANCE IN CHILD PROTECTION

Н.Жинжиймаа*
Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэслэгч
Jinjiimaa N.
Ph.D., Associate Professor Department of Private Law School of Law and Social Sciences University of Internal Affairs, Police lieutenant

*Хариуцлагатай зохиогч: jinjiimaa.n@uia.gov.mn

Хураангуй:Энэхүү судалгаанд хүүхэд хамгааллын салбар дахь нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг боловсронгуй болгоход дижитал технологи болон хиймэл оюун ухааны үзүүлэх нөлөөг онол, практикийн хүрээнд шинжилсэн. Судалгааны хүрээнд Монгол Улсын хүүхэд хамгааллын эрх зүйн орчин, институцийн тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэхэд байгууллагуудын мэдээлэл солилцоо сул, нэгдсэн мэдээллийн сангийн хүртээмж хангалтгүй, мэргэжлийн хүний нөөцийн чадавх дутмаг зэрэг хүндрэл нийтлэг байгааг тогтоов.

Түүнчлэн Их Британи, АНУ, Эстони, БНСУ, Япон улсын туршлагыг харьцуулан судалж, хиймэл оюун ухаанд суурилсан эрсдэлийн үнэлгээ, кейс удирдлага, мэдээллийн интеграцын систем нь хамгааллын үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлж буйг тодорхойлов. Судалгааны үр дүнд Монгол Улсад хүүхэд хамгааллын салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэгдсэн дижитал платформ хөгжүүлэх, салбар хоорондын мэдээллийн уялдаа холбоог бэхжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

Түлхүүр үг: Хүүхэд хамгаалал, хиймэл оюун ухаан, дижитал технологи, нийгмийн түншлэл, мэдээллийн интеграц.

Abstract: This study examines the role of digital technologies and artificial intelligence in strengthening social partnership and inter-agency cooperation within the child protection sector from both theoretical and practical perspectives. The research evaluates the current legal and institutional framework of child protection in Mongolia and identifies several persistent challenges, including weak inter-organizational information exchange, insufficient accessibility of integrated databases, and limited professional capacity among specialized personnel.

In addition, a comparative analysis of the experiences of the United Kingdom, the United States, Estonia, the Republic of Korea, and Japan demonstrates that artificial intelligence–based risk assessment, case management, and information integration systems contribute significantly to improving the effectiveness and responsiveness of child protection services.

The findings suggest that Mongolia should further enhance the legal regulation governing the application of artificial intelligence in child protection, develop integrated digital platforms, and strengthen intersectoral information coordination mechanisms to improve the overall efficiency and sustainability of the child protection system.

Keywords: Child protection, artificial intelligence, digital technology, social partnership, information integration.

Хүүхдийн хөгжил, төлөвшил, хамгаалал нь нийгмийн тогтвортой хөгжлийн суурь үзүүлэлт бөгөөд хүний хөгжлийн чанарыг тодорхойлох стратегийн ач холбогдолтой салбар юм. Хүүхдийн эрх, хамгаалллын асуудал нь зөвхөн нийгмийн халамжийн хүрээний асуудал бус, харин хүний эрх, хууль зүй, боловсрол, нийгмийн хамгааллын огтлолцолд орших цогц шинжтэй үзэгдэл бөгөөд олон талт

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

оролцогчдын уялдаа холбоонд тулгуурлан хэрэгждэг (United Nations, 1989; UNICEF, 2021). Иймээс хүүхэд хамгааллын тогтолцоо нь төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилсан нийгмийн түншлэлийн загвараар хөгжих хандлагатай байна (United Nations, 2020; World Economic Forum, 2022).

Сүүлийн жилүүдэд дижитал технологи болон хиймэл оюун ухааны хурдацтай хөгжил нь нийгмийн үйлчилгээний салбарт, тэр дундаа хүүхэд хамгааллын тогтолцоонд шинэ боломжуудыг бий болгож байна. Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, эрсдэлийн урьдчилсан үнэлгээ, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэгт хиймэл оюун ухааны хэрэглээ нь үр нөлөөтэй болохыг судалгаанууд харуулж байна (OECD, 2021; World Bank, 2021). Тухайлбал, хиймэл оюун ухаанд суурилсан predictive загварууд нь хүүхдийн эрсдэлийг урьдчилан тодорхойлох, хамгааллын арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг (Gillingham, 2016; Keddell, 2019). Мөн нийгмийн үйлчилгээний салбарт хиймэл оюун ухааныг ашигласнаар байгууллагуудын хоорондын мэдээллийн урсгалыг хурдасгаж, шийдвэр гаргалтын чанарыг сайжруулах боломжтойг онцолж байна (Bryant et al., 2020).

Нөгөө талаас дижитал технологи, хиймэл оюун ухааны хэрэглээ нь зөвхөн боломж төдийгүй тодорхой эрсдэлийг дагуулж байгаа бөгөөд өгөгдлийн нууцлал, хүний эрхийн хамгаалалт, алгоритмын ил тод байдал, ялгаварлан гадуурхах эрсдэл зэрэг асуудлууд онцгой анхаарал татаж байна (Floridi et al., 2018; Eubanks, 2018; Livingstone & Third, 2017). Иймд хүүхэд хамгааллын салбарт эдгээр технологийг нэвтрүүлэхдээ эрх зүй, ёс зүйн зохицуулалтыг давхар авч үзэх шаардлагатай (UNICEF, 2020).

Монгол Улсын хувьд хүүхэд хамгааллын эрх зүйн үндэс суурь нь Хүүхэд хамгааллын тухай хууль (Монгол Улс, 2024), Хүүхдийн эрхийн тухай хууль (Монгол Улс, 2016), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (Монгол Улс, 2017) зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр бүрдэж, төрөөс хэрэгжүүлэх бодлого нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Цахим үндэстэн” хөтөлбөр зэрэг баримт бичгүүдээр дэмжигдэж байна (Монгол Улсын Засгийн газар, 2020; 2021). Гэсэн хэдий ч эдгээр бодлого, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн түвшинд институц хоорондын уялдаа сул, мэдээллийн нэгдсэн тогтолцоо хангалтгүй, хамтын ажиллагааны механизм бүрэн төлөвшөөгүй зэрэг хүндрэлүүд байсаар байна (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 2023; UNICEF Mongolia, 2021). Мөн хүүхдийн эсрэг гэмт хэргийн үзүүлэлт тогтвортой буурахгүй байгаа нь хамгааллын тогтолцооны үр нөлөөг сайжруулах шаардлагатайг харуулж байна (Цагдаагийн ерөнхий газар, 2022).

Олон улсын туршлагаас харахад дижитал технологи, хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдийг хүүхэд хамгааллын салбарт амжилттай нэвтрүүлснээр байгууллага хоорондын хамтын ажиллагаа сайжирч, мэдээллийн нэгдсэн орчин бүрдэн, хамгааллын үйлчилгээний үр нөлөө мэдэгдэхүйц нэмэгдэж байна (UNICEF Office of Research, 2020; World Economic Forum, 2022). Ялангуяа Их Британи, АНУ, Эстони, БНСУ, Япон зэрэг улс орнуудын туршлага нь дижитал платформ, өгөгдлийн интеграц, хиймэл оюун ухаанд суурилсан эрсдэлийн үнэлгээний системийг амжилттай ашиглаж байгааг харуулж байна.

Ийм нөхцөлд Монгол Улсад нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих шинэ арга замыг эрэлхийлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд үүнд дижитал технологи, хиймэл оюун ухааныг ашиглах боломжийг гадаад орны туршлагатай харьцуулан судлах нь онол, практикийн чухал ач холбогдолтой юм.

Иймд энэхүү судалгааны зорилго нь хүүхэд хамгааллын салбар дахь нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжихэд дижитал технологи, хиймэл оюун ухааны үүргийг онолын болон харьцуулсан шинжилгээний үндсэн дээр судалж, Монгол Улсын нөхцөлд хэрэгжүүлэх боломж, тулгамдсан асуудлыг тодорхойлон,

цаашдын хөгжлийн чиг хандлага, бодлогын зөвлөмжийг дэвшүүлэхэд оршино.

Нийгмийн түншлэл ба хамтын ажиллагаа

Нийгмийн түншлэл нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоонд тулгуурлан нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх институц хоорондын зохион байгуулалтын хэлбэр бөгөөд орчин үеийн нийгмийн бодлого хэрэгжилтийн чухал механизмд тооцогддог (United Nations, 2020; World Economic Forum, 2022). Энэхүү ойлголт нь "олон талт засаглал" (multi-level governance) болон "сүлжээт удирдлага" (network governance)-ын онолтой нягт холбоотой бөгөөд төр дангаар нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдмал болсон нөхцөлд хамтын ажиллагаанд суурилсан загвар руу шилжих шаардлага бий болсон (OECD, 2021).

Хүүхэд хамгаллын салбарт нийгмийн түншлэл нь онцгой ач холбогдолтой бөгөөд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаа нь олон салбарын оргтолцолд явагддаг цогц шинжтэй юм (UNICEF, 2021; United Nations, 1989). Үүнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль сахиулах байгууллага, шүүхийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын уялдаа холбоо зайлшгүй шаардлагатай. Судалгаанаас үзэхэд олон байгууллагын хамтын ажиллагаа үр дүнтэй хөгжсөн тохиолдолд хүүхдийн эрсдэлийг эрт илрүүлэх, хамгаллын үйлчилгээний хүртээмж, чанар мэдэгдэхүйц сайжирдаг байна (Gillingham, 2016; Keddell, 2019).

Онолын хувьд хүүхэд хамгаллын хамтын ажиллагааг "олон байгууллагын интеграцчилсан загвар" (integrated multi-agency model)-аар тайлбарладаг бөгөөд энэ нь мэдээлэл солилцох, хамтарсан шийдвэр гаргах, хариуцлагыг хуваалцах зарчимд тулгуурладаг (Bryant et al., 2020). Иймд загвар нь зөвхөн үйлчилгээний давхардлыг бууруулах бус, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, нөөцийг үр ашигтай хуваарилах боломжийг бүрдүүлдэг (World Bank, 2021).

Гэсэн хэдий ч уламжлалт хамтын ажиллагааны загвар нь хэд хэдэн бүтэц, зохион байгуулалтын сул талтай байдаг. Тухайлбал, байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох механизм сул, өгөгдлийн нэгдсэн сан байхгүй, шийдвэр гаргалтын процесс удаашрах, институц хоорондын хариуцлагын зааг тодорхойгүй байх зэрэг асуудлууд нийтлэг ажиглагддаг (Eubanks, 2018; Livingstone & Third, 2017). Эдгээр сул тал нь хүүхэд хамгаллын үйлчилгээний үр нөлөөг бууруулж, эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдэд үзүүлэх тусламжийг хойшлуулах сөрөг үр дагавартай.

Ийм нөхцөлд дижитал технологи болон хиймэл оюун ухаан нь нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах онол, практикийн чухал хэрэгсэл болж байна. Дижитал платформ, мэдээллийн нэгдсэн систем нь байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох процессыг хурдасгаж, бодит цагийн мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих боломжийг олгодог (World Bank, 2021; OECD, 2021). Түүнчлэн хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмууд нь эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан таамаглах, үйлчилгээний чиглэлийг тодорхойлох зэрэгт ашиглагдаж, хамтын ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлдэг (Keddell, 2019; Gillingham, 2016).

Гэсэн хэдий ч технологид суурилсан хамтын ажиллагааны загварыг хэрэгжүүлэхэд ёс зүй, эрх зүйн асуудлууд чухал байр суурь эзэлдэг. Ялангуяа хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалах, алгоритмын ил тод байдал, ялгаварлан гадуурхах эрсдэлийг бууруулах асуудлууд нь онолын болон практикийн түвшинд анхаарал татаж байна (Floridi et al., 2018; UNICEF, 2020). Иймд нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжихэд дижитал технологи, хиймэл оюун ухааныг ашиглахдаа хүний эрхэд суурилсан, ёс зүйн хэм хэмжээг баримталсан хандлага зайлшгүй шаардлагатай юм.

Монгол Улс дахь хүүхэд хамгаалал ба хамтын ажиллагаа

Монгол Улсад хүүхэд хамгаллын эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Хүүхэд хамгаллын тухай хууль (Монгол Улс, 2024), Хүүхдийн эрхийн тухай хууль

(Монгол Улс, 2016), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (Монгол Улс, 2017) зэрэг суурь эрх зүйн баримт бичгүүд чухал үүрэг гүйцэтгэж байна. Эдгээр хуулиудаар хүүхдийн эрх, хамгаалыг хангах төрийн үүрэг, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааны зарчмыг тодорхойлж, хүүхэд хамгаалын үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндсийг тавьсан.

Тухайлбал, Хүүхэд хамгаалын тухай хуулиар хүүхэд хамгаалын үйлчилгээ нь олон салбарын оролцоонд тулгуурлах бөгөөд орон нутгийн түвшинд “хамтарсан баг”-ийн зохион байгуулалтаар хэрэгжихээр зохицуулсан нь нийгмийн түншлэл, хамтын ажиллагааны институцийн суурийг бүрдүүлсэн гэж үзэж болно (Монгол Улс, 2024). Энэхүү хамтарсан баг нь нийгмийн ажилтан, цагдаагийн албан хаагч, багш, эмч зэрэг мэргэжилтнүүдээс бүрдэж, хүүхдийн эрсдэлийг хамтран үнэлэх, хамгаалын арга хэмжээ авах чиг үүрэгтэй.

Гэсэн хэдий ч практик хэрэгжилтийн түвшинд дээрх тогтолцоо нь бүрэн үр нөлөөтэй хэрэгжихгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Ялангуяа байгууллагуудын уялдаа холбоо сул, хамтын ажиллагааны механизм формаль шинжтэй байх, мэдээлэл солилцох нэгдсэн систем хангалтгүй, институц хоорондын хариуцлагын зааг тодорхойгүй зэрэг асуудлууд нийтлэг байна (Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яам, 2022; Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 2023; UNICEF Mongolia, 2021).

Судалгаанаас үзэхэд хамтарсан багийн үйл ажиллагаа орон нутагт харилцан адилгүй хэрэгжиж байгаа бөгөөд зарим тохиолдолд мэргэжилтнүүдийн оролцоо хангалтгүй, хамтын шийдвэр гаргалт бодитой хэрэгждэггүй, мэдээлэл солилцох үйл явц удаашралтай байдаг нь тогтоогдсон (UNICEF Mongolia, 2022). Энэ нь хүүхэд хамгаалын үйлчилгээний хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлж, эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдэд үзүүлэх тусламжийг хойшлуулах шалтгаан болж байна.

Нөгөө талаар статистик мэдээллээс харахад Монгол Улсад хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо тогтвортой буурахгүй байгаа нь хамгаалын тогтолцооны үр нөлөөг сайжруулах шаардлагатай байгааг илтгэнэ (Цагдаагийн ерөнхий газар, 2022; Үндэсний статистикийн хороо, 2023). Энэ нь зөвхөн хууль эрх зүйн орчин бүрдүүлэхээс гадна түүний хэрэгжилтийг хангах институцийн чадавх, хамтын ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Мөн Монгол Улсад дижитал шилжилтийн бодлого хэрэгжиж байгаа хэдий ч хүүхэд хамгаалын салбарт мэдээллийн технологийн хэрэглээ харьцангуй сул хэвээр байна. Байгууллагуудын мэдээллийн системүүд харилцан уялдаа муутай, өгөгдлийн нэгдсэн сан бүрдээгүй, мэдээллийн солилцоо ихэвчлэн уламжлалт хэлбэрээр явагдаж байгаа нь хамтын ажиллагааны үр ашгийг бууруулж байна (Мэдээлэл, харилцаа холбооны зохицуулах хороо, 2022).

Үүнээс үзэхэд Монгол Улсад хүүхэд хамгаалын эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн хэдий ч түүний хэрэгжилт, ялангуяа байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээллийн уялдаа холбоо хангалтгүй хэвээр байгаа нь хүүхэд хамгаалын тогтолцооны үр нөлөөг хязгаарлаж байна. Иймд нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг бодитойгоор бэхжүүлэх, үүнд дижитал технологи, хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдийг нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дижитал технологи ба хиймэл оюун ухааны үүрэг

Дижитал технологийн хөгжил нь нийгмийн үйлчилгээний салбар, тэр дундаа хүүхэд хамгаалын тогтолцоонд суурь өөрчлөлт авчирч, уламжлалт байгууллага төвтэй загвараас өгөгдөлд суурилсан, уялдаа холбоотой, ухаалаг системд шилжих боломжийг бүрдүүлж байна. Ялангуяа мэдээллийн технологид суурилсан шийдлүүд нь хүүхэд хамгаалын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын мэдээллийн урсгалыг нэгтгэх, бодит цагийн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд

чухал үүрэг гүйцэтгэдэг (World Bank, 2021; OECD, 2021).

Хүүхэд хамгааллын салбарт дижитал технологийн гол давуу тал нь мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино. Судалгаанаас үзэхэд нэгдсэн мэдээллийн систем нь эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдийг илрүүлэх хугацааг богиносгож, хамгааллын арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлдэг (UNICEF Office of Research, 2020).

Энэхүү дижитал шилжилтийн хүрээнд хиймэл оюун ухаан (Artificial Intelligence) нь хүүхэд хамгааллын тогтолцоонд стратегийн чухал хэрэгсэл болж байна. Хиймэл оюун ухааныг дараах үндсэн чиглэлүүдээр ашиглах боломжтой.

Эрсдэлийн үнэлгээ (Risk assessment):Хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмууд нь олон төрлийн өгөгдлийг (гэр бүлийн нөхцөл байдал, нийгэм-эдийн засгийн үзүүлэлт, өмнөх кейсүүд) нэгтгэн боловсруулж, хүүхдийн эрсдэлийг урьдчилан тодорхойлох боломжийг олгодог. Энэ нь нийгмийн ажилтнуудын шийдвэр гаргалтыг дэмжих, эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдийг эрт илрүүлэхэд чухал ач холбогдолтой (Keddell, 2019; Gillingham, 2016).

Урьдчилан сэргийлэх (Predictive prevention):Хиймэл оюун ухаанд суурилсан predictive загварууд нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хайхрамжгүй хандлагын эрсдэлийг урьдчилан таамаглах боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр эрсдэл үүсэхээс өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, нөөцийг илүү оновчтой хуваарилах боломж бүрддэг (Gillingham, 2016; World Economic Forum, 2022).

Мэдээллийн уялдаа, интеграц (Data integration and coordination):Хиймэл оюун ухаан болон дижитал платформууд нь боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийх, олон байгууллагын хамтын ажиллагааг бодит цаг хугацаанд дэмжих боломжийг олгодог. Энэ нь байгууллагуудын хоорондын мэдээллийн зөрүүг бууруулж, шийдвэр гаргалтын чанарыг сайжруулдаг (OECD, 2021; World Bank, 2021).

Үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах:Дижитал технологи нь алслагдсан бүс нутагт хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх, онлайн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, кейс удирдлагын системийг боловсронгуй болгох боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, нийгмийн хамгааллын үйлчилгээ илүү үр ашигтай болдог (UNICEF, 2021).

Гэсэн хэдий ч хиймэл оюун ухааныг хүүхэд хамгааллын салбарт ашиглахад тодорхой эрсдэл, сорилтууд тулгардаг. Юуны өмнө, өгөгдлийн нууцлал, хүүхдийн хувийн мэдээллийн хамгаалалт нь онцгой ач холбогдолтой асуудал юм. Хиймэл оюун ухааны системүүд нь их хэмжээний өгөгдөлд тулгуурладаг тул мэдээллийн аюулгүй байдал, зөвшөөрөл, ашиглалтын хязгаарлалтыг нарийвчлан зохицуулах шаардлагатай (UNICEF, 2020; Floridi et al., 2018).

Мөн алгоритмын ялгаварлан гадуурхах (algorithmic bias), ил тод бус байдал, шийдвэр гаргалтын хяналт сулрах зэрэг эрсдэлүүд нь хүүхдийн эрхийг зөрчих боломжтойг судлаачид анхааруулж байна (Eubanks, 2018; Livingstone & Third, 2017). Иймд хиймэл оюун ухааныг ашиглахдаа хүний эрхэд суурилсан, ёс зүйн зарчимд нийцсэн, ил тод, хариуцлагатай тогтолцоог бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай.

Иймээс дижитал технологи, хиймэл оюун ухаан нь хүүхэд хамгааллын салбарт нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх стратегийн чухал хэрэгсэл болох хэдий ч түүнийг зөв зохистой, эрх зүйн болон ёс зүйн зохицуулалттай уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүүхэд хамгаалал дахь дижитал технологи, хиймэл оюун ухааны гадаад орны туршлага

Хүүхэд хамгааллын салбарт дижитал технологи, хиймэл оюун ухааныг ашиглах чиглэлээр дэлхийн олон улс орон бодит үр дүнд хүрсэн туршлагыг нэвтрүүлж байна. Эдгээр туршлага нь байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, эрсдэлийг

эрт илрүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаагаараа онцлог юм (UNICEF, 2020; World Economic Forum, 2022).

Тухайлбал, Их Британи улсад хүүхэд хамгааллын салбарт хиймэл оюун ухаанд суурилсан "predictive risk modelling" системийг ашиглаж, эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдийг урьдчилан тодорхойлох боломжийг бүрдүүлсэн. Энэхүү систем нь олон төрлийн өгөгдлийг нэгтгэн боловсруулж, нийгмийн ажилтнуудын шийдвэр гаргалтыг дэмждэг бөгөөд хамгааллын үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлсэн байна (Gillingham, 2016).

АНУ-д "Allegheny Family Screening Tool" зэрэг алгоритмд суурилсан системийг нэвтрүүлж, хүүхдийн халамжийн кейсүүдийг эрэмбэлэх, эрсдэлийн түвшинг тодорхойлох чиглэлээр ашиглаж байна. Энэ нь шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилсан болгох, нөөцийг оновчтой хуваарилахад дэмжлэг үзүүлж байна (Eubanks, 2018).

Эстони улс дижитал засаглалын хүрээнд төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, "X-Road" платформоор дамжуулан байгууллагуудын өгөгдлийг аюулгүй, шуурхай солилцох боломжийг бүрдүүлсэн. Энэ нь хүүхэд хамгааллын салбарт олон байгууллагын хамтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн (World Bank, 2021).

Азийн бүс нутагт мөн адил дижитал технологид суурилсан хүүхэд хамгааллын туршлагууд хөгжиж байна. Тухайлбал, БНСУ-д хүүхэд хамгааллын салбарт мэдээллийн нэгдсэн систем, кейс удирдлагын платформыг хөгжүүлж, цагдаа, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулсан байна. Мөн хиймэл оюун ухаанд суурилсан эрсдэлийн үнэлгээний системийг туршилтын журмаар ашиглаж, хүүхдийн хүчирхийллийн эрсдэлийг эрт илрүүлэхэд анхаарч байна (OECD, 2021; UNICEF, 2021).

Япон улсын хувьд хүүхэд хамгааллын салбарт дижитал технологийг өргөн ашиглаж, орон нутгийн захиргаа, нийгмийн үйлчилгээний байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн системүүдийг нэвтрүүлсэн. Ялангуяа кейс удирдлагын цахим систем, хүүхдийн халамжийн мэдээллийн санг хөгжүүлснээр байгууллагуудын хамтын ажиллагаа илүү зохион байгуулалттай, үр дүнтэй болсон байна. Мөн хүүхдийн эрсдэлийг илрүүлэхэд өгөгдөлд суурилсан дүн шинжилгээний аргыг ашиглах хандлага нэмэгдэж байна (UNICEF Office of Research, 2020).

Эдгээр олон улсын туршлагаас харахад хүүхэд хамгааллын салбарт дижитал технологи, хиймэл оюун ухааныг амжилттай нэвтрүүлэхэд дараах нийтлэг хүчин зүйлс чухал үүрэгтэй байна. Үүнд: нэгдсэн мэдээллийн дэд бүтэц, эрх зүйн тодорхой зохицуулалт, өгөгдлийн чанар, хүртээмж, мэргэжилтний чадавх, байгууллагуудын уялдаа холбоо зэрэг орно (UNICEF Office of Research, 2020).

Монгол Улсын хувьд эдгээр туршлагыг шууд хуулбарлах боломжгүй боловч үндэсний онцлогт тохируулан үе шаттайгаар нутагшуулах боломжтой. Ялангуяа БНСУ, Япон зэрэг Азийн орнуудын туршлага нь институцийн бүтэц, хөгжлийн түвшний хувьд Монгол Улстай харьцангуй ойролцоо тул практик ач холбогдол өндөртэй байна. Иймд хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн систем бий болгох, байгууллагуудын өгөгдлийн уялдаа холбоог сайжруулах, хиймэл оюун ухаанд суурилсан эрсдэлийн үнэлгээний туршилтын төслийг хэрэгжүүлэх нь бодитой боломж юм. Эдгээр шийдлийг нэвтрүүлэхдээ хүний эрх, хүүхдийн хувийн мэдээллийн хамгаалалт, алгоритмын ил тод байдал, ёс зүйн асуудлыг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай (Floridi et al., 2018; Livingstone & Third, 2017).

Тулгамдсан асуудал

Монгол Улсад хүүхэд хамгааллын салбарт дижитал технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх бодлогын шаардлага нэмэгдэж байгаа хэдий ч хэрэгжилтийн түвшинд олон талт бэрхшээл, сорилтууд тулгарч байна. Эдгээр асуудлууд нь зөвхөн технологийн хүчин зүйлсээр хязгаарлагдахгүй, харин эрх зүй,

институцийн уялдаа, хүний нөөц, өгөгдлийн удирдлагатай холбоотой цогц шинжтэй байна.

Юуны өмнө, эрх зүйн зохицуулалтын хүрээнд хиймэл оюун ухаан, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг хүүхэд хамгааллын салбарт ашиглахтай холбоотой тусгайлсан, нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байна. Одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжууд нь хүүхэд хамгааллын ерөнхий зохицуулалтыг агуулж байгаа боловч дижитал технологи, хиймэл оюун ухааны хэрэглээтэй холбоотой өгөгдлийн хамгаалалт, алгоритмын хариуцлага, шийдвэр гаргалтын ил тод байдлыг тусгайлан зохицуулсан зохицуулалт сул байна (UNICEF, 2020; Floridi et al., 2018). Энэ нь технологийг практикт нэвтрүүлэхэд хууль зүйн тодорхойгүй байдал үүсгэж, байгууллагуудын идэвх санаачилгыг хязгаарлах хүчин зүйл болж байна.

Хоёрдугаарт, мэдээллийн нэгдсэн сан, өгөгдлийн удирдлагын тогтолцоо хангалтгүй байгаа нь хүүхэд хамгааллын салбар дахь хамтын ажиллагаанд ноцтой саад учруулж байна. Одоогийн байдлаар төрийн байгууллагууд өөр өөрийн мэдээллийн системийг ашиглаж байгаа боловч тэдгээрийн хоорондын уялдаа сул, өгөгдөл солилцох стандарт, протокол бүрэн тогтоогдоогүй байна. Үүний улмаас хүүхдийн эрсдэлийн талаарх мэдээлэл цаг алдалгүй дамжихгүй, шийдвэр гаргалт удаашрах, үйлчилгээний давхардал үүсэх зэрэг сөрөг үр дагавар бий болдог (World Bank, 2021; UNICEF Mongolia, 2021).

Гуравдугаарт, техникийн дэд бүтэц, технологийн бэлэн байдал хангалтгүй хэвээр байна. Ялангуяа орон нутгийн түвшинд интернэтийн хүртээмж, мэдээллийн системийн ашиглалт, программ хангамжийн шийдлүүдийн хүртээмж харилцан адилгүй байгаа нь дижитал технологийг жигд нэвтрүүлэхэд хүндрэл учруулж байна (Мэдээлэл, харилцаа холбооны зохицуулах хороо, 2022). Энэ нь нийгмийн үйлчилгээний тэгш хүртээмжийг алдагдуулах эрсдэлийг дагуулж байна.

Дөрөвдүгээрт, хүний нөөцийн чадавх, мэргэжлийн бэлтгэл хангалтгүй байгаа нь хиймэл оюун ухаан, дижитал технологийг үр дүнтэй ашиглахад саад болж байна. Нийгмийн ажилтнууд, хууль сахиулах байгууллагын албан хаагчид, боловсрол, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн дунд дижитал ур чадвар, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтын мэдлэг хангалтгүй байгаа нь технологийн шийдлийг бодит хэрэгжилтэд ашиглах боломжийг хязгаарлаж байна (UNICEF Mongolia, 2022; OECD, 2021).

Үүнээс гадна хиймэл оюун ухааны хэрэглээтэй холбоотой ёс зүйн болон нийгмийн эрсдэлүүдийг дутуу үнэлэх хандлага ажиглагдаж байна. Алгоритмын ялгаварлан гадуурхах, өгөгдлийн чанар, ил тод байдлын асуудал нь хүүхдийн эрхийг зөрчих эрсдэлийг дагуулж болзошгүй бөгөөд энэ нь бодлогын түвшинд анхаарах шаардлагатай асуудал юм (Eubanks, 2018; Livingstone & Third, 2017).

Иймээс Монгол Улсад хүүхэд хамгааллын салбарт дижитал технологи, хиймэл оюун ухааныг үр дүнтэй нэвтрүүлэхийн тулд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, техникийн дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.

Хэлэлцүүлэг ба шийдэл, санал

Дээр дурдсанчлан Монгол Улсад хүүхэд хамгааллын салбарт дижитал технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхэд эрх зүйн зохицуулалт, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, техникийн дэд бүтэц, хүний нөөцийн чадавх зэрэг олон талт бэрхшээл тулгарч байна. Эдгээр асуудлууд нь харилцан уялдаа холбоотой бөгөөд зөвхөн нэг чиглэлд бус, цогц бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байна.

Олон улсын туршлагаас харахад (Их Британи, АНУ, Эстони, БНСУ, Япон) хүүхэд хамгааллын салбарт дижитал технологи, хиймэл оюун ухааныг үр дүнтэй нэвтрүүлэхэд дараах нийтлэг хүчин зүйлс чухал үүрэгтэй байна. Үүнд: нэгдсэн мэдээллийн дэд бүтэц, эрх зүйн тодорхой зохицуулалт, байгууллага хоорондын өгөгдлийн уялдаа, хүний нөөцийн чадавх, мөн технологид суурилсан шийдвэр

гаргалтын институцийн соёл зэрэг орно (UNICEF, 2020; World Economic Forum, 2022). Иймд Монгол Улсын нөхцөлд эдгээр туршлагыг харгалзан дараах бодлогын болон практик арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Нэгдүгээрт, хиймэл оюун ухааны хэрэглээг зохицуулах эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай.

Их Британи, АНУ зэрэг орнууд хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргалтыг тодорхой эрх зүйн хүрээнд туршин хэрэгжүүлж байгаа нь технологийн хэрэглээний ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. Монгол Улсад энэхүү чиглэлээр өгөгдлийн хамгаалалт, алгоритмын ил тод байдал, хариуцлагын механизм, хүний эрхийн баталгаат тусгасан тусгай зохицуулалтыг бий болгох шаардлагатай (Floridi et al., 2018; UNICEF, 2020).

Хоёрдугаарт, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн системийг үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай.

Эстони улсын “X-Road” систем, БНСУ-ын хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн платформ зэрэг туршлагаас харахад байгууллагуудын өгөгдлийг уялдуулах нь хамтын ажиллагааны үр нөлөөг эрс нэмэгдүүлдэг. Монгол Улсад боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийг нэгтгэсэн, бодит цагийн өгөгдөлд суурилсан нэгдсэн системийг хөгжүүлэх нь эрсдэлийг эрт илрүүлэх, шийдвэр гаргалтыг хурдасгах чухал нөхцөл болно (World Bank, 2021).

Гуравдугаарт, байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих дижитал платформ, кейс удирдлагын системийг нэвтрүүлэх шаардлагатай.

Япон, БНСУ-ын туршлагаас харахад кейс удирдлагын цахим систем нь олон байгууллагын оролцоог уялдуулах, мэдээллийн урсгалыг шуурхай болгох, хариуцлагын тогтолцоог тодорхой болгоход үр дүнтэй байна. Монгол Улсад ийм төрлийн платформыг хөгжүүлснээр нийгмийн түншлэл бодитой хэрэгжих нөхцөл бүрдэнэ (OECD, 2021; UNICEF, 2021).

Дөрөвдүгээрт, хүний нөөцийн чадавхыг олон улсын сайн туршлагад тулгуурлан бэхжүүлэх шаардлагатай.

Хөгжингүй орнуудад хиймэл оюун ухаан, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг хэрэгжүүлэхэд мэргэжилтнүүдийн дижитал ур чадвар, аналитик сэтгэлгээ чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улсад нийгмийн ажилтан, багш, эмч, хууль сахиулах байгууллагын албан хаагчдад зориулсан дижитал ур чадвар, өгөгдлийн хэрэглээний сургалтыг системтэй хэрэгжүүлэх шаардлагатай (UNICEF Mongolia, 2022; OECD, 2021).

Тавдугаарт, олон улсын туршлагыг шууд хуулбарлах бус, үндэсний онцлогт тохируулан нутагшуулах шаардлагатай.

БНСУ, Япон зэрэг Азийн орнуудын туршлага нь Монгол Улсын институцийн орчин, хөгжлийн түвшинтэй тодорхой хэмжээнд ойролцоо тул практик ач холбогдол өндөртэй байна. Иймд хиймэл оюун ухаанд суурилсан эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн интеграц, кейс удирдлагын системийг туршилтын журмаар нэвтрүүлж, үе шаттайгаар өргөжүүлэх нь зүйтэй (World Economic Forum, 2022).

Иймээс дээрх санал, арга хэмжээг олон улсын туршлагатай уялдуулан, үндэсний нөхцөлд нийцүүлэн цогцоор нь хэрэгжүүлснээр Монгол Улсад хүүхэд хамгааллын салбар дахь нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх, дижитал технологи, хиймэл оюун ухааныг үр дүнтэй ашиглах бодит боломж бүрдэх юм.

Дүгнэлт, бодлогын зөвлөмж

Энэхүү судалгаагаар хүүхэд хамгааллын салбарт нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа нь хамгааллын тогтолцооны үр нөлөөг тодорхойлох суурь хүчин зүйл болохыг онолын болон практикийн түвшинд тодорхойлов. Орчин үеийн нөхцөлд хүүхэд хамгааллын асуудал нь олон салбарын оролцоонд тулгуурлах цогц шинжтэй тул төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын уялдаа холбоо бүхий хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсад хүүхэд хамгааллын эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн боловч түүний хэрэгжилт, ялангуяа байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээллийн уялдаа холбоо, институцийн зохицуулалт хангалтгүй хэвээр байна. Энэ нь хамгааллын үйлчилгээний үр нөлөөг бууруулж, эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байгааг харуулж байна.

Нөгөө талаар олон улсын туршлагаас харахад дижитал технологи, хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдийг хүүхэд хамгааллын салбарт нэвтрүүлснээр нийгмийн түншлэл, хамтын ажиллагааны үр нөлөөг мэдэгдэхүйц сайжруулж байгааг харуулж байна. Тухайлбал, Их Британи, АНУ-д хиймэл оюун ухаанд суурилсан эрсдэлийн үнэлгээний системийг ашигласнаар эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдийг эрт илрүүлэх, шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилсан болгох боломж бүрдсэн. Эстони улсын мэдээллийн нэгдсэн платформ нь байгууллагуудын өгөгдлийн уялдаа холбоог хангаж, олон байгууллагын хамтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн бол БНСУ, Япон улсад кейс удирдлагын дижитал систем, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлснээр хүүхэд хамгааллын үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна (World Bank, 2021; OECD, 2021; UNICEF, 2021).

Эдгээр туршлага нь дижитал технологи, хиймэл оюун ухаан нь зөвхөн техникийн шийдэл бус, харин байгууллага хоорондын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах стратегийн хэрэгсэл болохыг харуулж байна. Гэсэн хэдий ч уг технологийг нэвтрүүлэхэд эрх зүйн зохицуулалт, ёс зүйн хэм хэмжээ, өгөгдлийн хамгаалалт, хүний нөөцийн чадавх зэрэг хүчин зүйлсийг цогцоор нь авч үзэх шаардлагатай хэвээр байна.

Иймд цаашид хүүхэд хамгааллын салбарт нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх, дижитал технологи, хиймэл оюун ухааныг үр дүнтэй ашиглах зорилгоор дараах бодлогын зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын салбарт хиймэл оюун ухаан, өгөгдөлд суурилсан технологийн хэрэглээг зохицуулах эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож, өгөгдлийн хамгаалалт, алгоритмын ил тод байдал, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох шаардлагатай.
- Эстони, БНСУ зэрэг улсын туршлагад тулгуурлан байгууллагуудын мэдээллийг нэгтгэсэн хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлж, өгөгдлийн уялдаа холбоог хангах хэрэгтэй.
- Япон, БНСУ-ын кейс удирдлагын цахим системийн туршлагыг харгалзан төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих дижитал платформыг нэвтрүүлж, бодит цагийн мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих шаардлагатай.
- Хөгжингүй орнуудын жишгээр хүүхэд хамгааллын салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдийн дижитал ур чадвар, өгөгдөлд суурилсан сэтгэлгээг хөгжүүлэх сургалт, чадавхжуулалтын тогтолцоог бэхжүүлэх нь зүйтэй.
- Олон улсын сайн туршлагыг шууд хуулбарлах бус, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, институцийн онцлогт нийцүүлэн үе шаттайгаар туршин нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Эцэст нь дүгнэхэд, дижитал технологи, хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдийг нийгмийн түншлэл, хамтын ажиллагаатай уялдуулан хөгжүүлснээр Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог илүү үр нөлөөтэй, хүртээмжтэй, тогтвортой байдлаар хөгжүүлэх бодит боломж бүрдэх юм.

Ашигласан эх сурвалж

I. Үндэсний эх сурвалж

1. Монгол Улс. (2024). *Хүүхэд хамгааллын тухай хууль*. Улаанбаатар.
2. Монгол Улс. (2016). *Хүүхдийн эрхийн тухай хууль*. Улаанбаатар.
3. Монгол Улс. (2017). *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль*. Улаанбаатар.
4. Монгол Улсын Засгийн газар. (2020). *Алсын хараа-2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*. Улаанбаатар.
5. Монгол Улсын Засгийн газар. (2021). *Цахим үндэстэн хөтөлбөр*. Улаанбаатар.
6. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. (2022). *Хүүхэд хамгааллын үйлчилгээний тайлан*. Улаанбаатар.
7. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар. (2023). *Хүүхэд хамгааллын нөхцөл байдлын үнэлгээ*. Улаанбаатар.
8. Үндэсний статистикийн хороо. (2023). *Хүүхдийн статистикийн эмхэтгэл*. Улаанбаатар.
9. Цагдаагийн ерөнхий газар. (2022). *Хүүхдийн эсрэг гэмт хэргийн статистик мэдээ*. Улаанбаатар.
10. UNICEF Mongolia. (2021). *Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны үнэлгээ*. Улаанбаатар.
11. UNICEF Mongolia. (2022). *Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанарын үнэлгээ*. Улаанбаатар.
12. Батжаргал, Б. (2021). *Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцооны асуудал*. Улаанбаатар: МУИС хэвлэл.
13. Энхтуяа, Д. (2020). Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдал. *Хууль зүйн судлал*, 12(3), 45–60.
14. Отгонтэнгэр их сургууль. (2022). *Хүүхдийн хөгжил, хамгааллын судалгаа*. Улаанбаатар.
15. Мэдээлэл, харилцаа холбооны зохицуулах хороо. (2022). *Дижитал шилжилтийн бодлого, хэрэгжилт*. Улаанбаатар.

II. Олон улсын эх сурвалж

16. UNICEF. (2021). *Child protection strategy 2021–2030*. UNICEF.
17. UNICEF. (2020). *Policy guidance on AI for children*. UNICEF.
18. United Nations. (1989). *Convention on the Rights of the Child*. UN.
19. United Nations. (2020). *Digital cooperation roadmap*. UN.
20. World Bank. (2021). *World development report: Data for better lives*. World Bank.
21. OECD. (2021). *Artificial intelligence in society*. OECD Publishing.
22. European Commission. (2020). *White paper on artificial intelligence*. Brussels.
23. Floridi, L., et al. (2018). AI4People—An ethical framework for a good AI society. *Minds and Machines*, 28(4), 689–707.
24. Eubanks, V. (2018). *Automating inequality: How high-tech tools profile, police, and punish the poor*. St. Martin's Press.
25. Keddell, E. (2019). Algorithmic justice in child protection. *Social Sciences*, 8(10), 281.
26. Gillingham, P. (2016). Predictive risk modelling in child protection. *British Journal of Social Work*, 46(4), 1046–1062.
27. Bryant, D., et al. (2020). Artificial intelligence and social services. *Journal of Social Policy*, 49(4), 803–821.
28. Livingstone, S., & Third, A. (2017). Children and young people's rights in the digital age. *New Media & Society*, 19(5), 657–670.
29. UNICEF Office of Research. (2020). *Artificial intelligence for children*. Florence.
30. World Economic Forum. (2022). *AI governance and child protection*. WEF

ХҮНИЙ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХАД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД, ТЭДГЭЭРИЙН ТААМАГЛАЛ, ЗАГВАР

FACTORS INFLUENCING THE REALIZATION OF THE HUMAN RIGHT TO LIVE IN A HEALTHY AND SAFE ENVIRONMENT: HYPOTHESES AND MODELS

Д.Бадамцэцэг*
Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
Badamtsetseg D.
Ph.D., at University of Internal Affairs, Mongolia. Police lieutenant colonel

*Хариуцлагатай зохиогч: Badamtsetseg.d@uia.gov.mn

Хураангуй: Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, түүний хэрэгжилтийг хангахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийг олон улсын нэр хүнд бүхий байгууллагаас гаргасан судалгааны зөвлөмж, эрдэмтэн, судлаачдын бүтээл, төрийн болон төрийн бус байгууллагуудын тайлан, мэдээ, Монгол Улсын шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж онолын уялдаа холбоо бүхий таамаглал, загвар дэвшүүлэв.

Abstract: The human right to live in a healthy and safe environment and the factors affecting its implementation were analyzed through research recommendations issued by reputable international organizations, research works by scholars and researchers, and Mongolian court decisions, and theoretically coherent hypotheses and models were proposed.

Түлхүүр үг: Эрүүл аюулгүй орчин, хүний эрх, үндсэн хууль, хүрээлэн буй орчин, эрх зүй

Keywords: Healthy and safe environment, human rights, constitution, environment, law

Хүн төрөлхтөн үүсэн бий болсон цагаасаа хүрээлэн буй орчинтойгоо нягт уялдаа холбоотой байж байгалийн аюултай үзэгдэл, гамшигт нэрвэгдэж байсан бол, нийгмийн хөгжлийн явцад шинжлэх ухаан, технологийн хөгжилд суурилсан үйлдвэржилт, суурин соёл иргэншил, дэлхийн хүн амын өсөлт, төрийн бодлогын уялдаа холбоогүй байдал, хүмүүсийн зохисгүй хэрэглээ зэрэг нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх болж уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахад хүргэхийн зэрэгцээ хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, тэрхүү эрхийг хамгаалах шаардлагыг бий болгосон ажээ.

Хүний эрх бол үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, бусад шинж чанараас үл хамааран бүх хүнд заяагдсан үндсэн эрх, эрх чөлөө байдаг. Хүний эрхийг олон улсын болон үндэсний хууль тогтоомж, гэрээ, конвенцоор хамгаалдаг. Засгийн газар эдгээр эрхийг хамгаалах үүрэгтэй.

Хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийг хэрхэн хангах, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн талаар эрдэмтэн, судлаачдын үзэл санаагаа илэрхийлэн өөрсдийн эх сурвалжид дурджээ. Тухайлбал, АНУ-ын Ерөнхийлөгч Чарльз З.Линкольн (1906), "Нью-Йоркийн Үндсэн хуулийн түүх" бүтээлдээ "Үндсэн хууль нь улсын дээд хууль болж, хувь хүний эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлдэг", АНУ-ын хүний эрхийн хуульч Карл Ловенштейн (1939), "Улс төрийн эрх мэдэл ба засгийн үйл явц" бүтээлдээ "Үндсэн хуулиар хамгаалагдсан хүмүүсийн эрхийн баталгаа нь хууль дээдлэх, ардчиллыг хангахад нэн чухал, биологич Андрас Сажо (2012), "Хүйтэн дайны дараах үеийн Европын хүний эрхийн шүүх" бүтээлдээ: "...Үндсэн хуулийн шүүх нь хүний эрхийг хамгаалах, үндсэн хуулийн заалтуудыг тайлбарлахад чухал үүрэг гүйцэтгэдэг", Жон Э.Новак, Рональд Д.Ротунда нар: "Үндсэн хуулийн эрх зүй" (2012) номдоо: "Хувь хүний эрх чөлөөг Үндсэн хуулиар хамгаалах нь засгийн газрын эрх ашгийг зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд маш чухал", Самуэль Исачарофф нар (2002) "Ардчиллын хууль: Улс төрийн үйл явцын эрх зүйн бүтэц" бүтээлдээ: "... Үндсэн хуулийн хамгаалалт, баталгаа нь тухайн

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia

үндэстний мөн чанарыг төлөвшүүлэх, хүний эрхийн төлөө тууштай хандахад гүн нөлөө үзүүлдэг" гэж (Lincoln, 1906,) тус тус дурджээ.

Үндсэн хуулийг хэрэгжилтийг хангах баталгааг хангах субъектийг үндсэн хууль өөрөө тогтоон хуульчилсан байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэжээ. Монгол Улсын 1992 онд батлагдсан Үндсэн хуулиар эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй болохыг анх удаа хуульчилсан бөгөөд 1995 онд батлагдсан "Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-аар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахаар, 2016 онд батлагдсан "Эрүүл ахуйн тухай хууль"-аар хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчилжээ.

Монгол Улсад өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй 880 хууль тогтоомжоос зөвхөн эрүүл, ахуйн тухай хуульд "эрүүл, аюулгүй орчин" гэж хүрээлэн байгаа орчин эрүүл ахуйн нөхцөл, шаардлага бүрэн хангасан байхыг ойлгоно хэмээн тодорхойлсон байна. Энэхүү тодорхойлолт нь эрүүл ахуйн талаас нь эрүүл, аюулгүй орчин гэдгийг тодорхойлсон бөгөөд нөгөө талаас аюулгүй орчин гэдгийг хэт өрөөсгөл буюу зөвхөн эрүүл мэнд, эрүүл ахуй буюу "healthy" гэсэн утгаар тайлбарласан нь учир дутагдалтай байна.

"Эрүүл, аюулгүй орчин" гэх ойлголтыг хангахад нөлөөлж буй хүчин зүйлийг онолын уялдаа, таамаглал, загварыг судлахын зэрэгцээ судалгааны ажлын хүрээнд өгөгдсөн үндсэн нэр томьёоны утга, нэршлийг авч үзэхэд:

Эрүүл. (*тэмдэг нэр).* Хүн амьтан өвчин эмгэггүй чийрэг цовоо сэргэлэн байдал (толь, Монгол хэлний тайлбар толь, 2021). Биеийн байдал, өвчин эмгэггүй, эсвэл сайн байгаа байдал (https://dictionary.cambridge.org/dictionary/english/health.). Хүний бие эсвэл сэтгэлийн байдал (www.oxfordlearnersdictionaries.com/definition, 2025),

Аюулгүй орчин. (*тэмдэг нэр).*Аюул байхгүй, айж эмээх, сандрах түгшүүргүй, аюулгүй байх: хор хөнөөлгүй байх (толь, Монгол хэлний тайлбар толь , 2021). Аюулгүй эсвэл хохирол учруулахгүй (Cambridge dictionnairy, 2024). Аливаа аюул, хор хөнөөл, алдагдлаас хамгаалагдсан (dictionary, 2026)

Орчин. (*нэр үг)* Ямар нэгэн зүйлийг тойрон хүрээлж буй ойр хавь. Эргэн тойрны нийгэм ахуй байдлын нөхцөл төлөв хийгээд эдгээр нөхцөлийн нийтлэг зүйлээр холбоотой хүмүүсийн цогц (Я.Цэвэл, 2021). Хүн, амьтан, ургамал амьдардаг агаар, ус, газар (dictionary C. , 2026). Хүмүүс, амьтан, ургамал амьдардаг байгалийн ертөнц (Oxford dictionary, 2026). гэж тус тус тайлбарласан байна.

Дээрх үндсэн нэр томьёо нь судалж буй сэдвийн үндсэн хувьсагч болох эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлийг илэрхийлж байна гэж үзэн тухайн хувьсагчийн өөрийн орны нийгмийн шинжлэх ухааны онцлогт тохируулан үндсэн таван хувьсагчийг сонгон авч судаллаа. Өөрөөр хэлбэл хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийг хангахад дараах хүчин зүйлүүд нөлөөлж байна гэж үзэв. Үүнд:

Нэг. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаарх төрийн бодлого.

Төрийн бодлого нь төрийн бодлогыг бүрдүүлэх зорилго, шийдвэр, үйл ажиллагааны цогцолбор нь асуудлыг

илрүүлэхээс эхлээд нарийн төвөгтэй үйл явцаар дамжин хийгддэг. Төрийн бодлогыг боловсруулах үйл явц нь уламжлал ёсоор дараах байдлаар хуваагддаг өөр өөр үе шатыг дагаж мөрддөг. Асуудлын тодорхойлолт, өөр шийдлийг боловсруулах, хувилбарыг шийдэх, хэрэгжүүлэх, олж авсан үр дүнг үнэлэх зэрэг болно. Төрийн бодлого нь нийгмийн шинжтэй олон янзын үзэгдлийн талаар ярьдаг Нийгмийн шинжлэх ухаан ба философитой холбоотой үзэгдлүүд юм.

Төрийн бодлого бол тодорхой нөхцөлд зорилго, түүнд хүрэх арга замыг сонгохын тулд улс төрд оролцогч буюу хэсэг оролцогчоос гаргасан харилцан холбоо бүхий цогц шийдвэр (Женкинс.) байдаг.

Төрийн бодлого ба хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн уялдаа холбооны талаар эрдэмтэд дараах байдлаар авч үзжээ. Үүнд:

- АНУ-ын эрдэмтэн Анжел Гурриа (2013), Эрүүл эдийн засагт эрүүл орчин хэрэгтэй. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга тэрээр, эдийн засгийн тогтвортой өсөлт, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх эрхэм зорилгынхоо дагуу байгаль орчны асуудлыг эдийн засаг, салбарын бодлогод илүү сайн уялдуулахыг дэмждэг. Судлаач, хүний эрүүл, аюулгүй амьдрах үндсэн үзүүлэлтэд, химийн аюулгүй бодисын хэрэглээ, химийн бодисын эрсдэл, үйлдвэрлэсэн нано материалын аюулгүй байдал, химийн бодисоос үүссэн бохирдол зэргийн талаар нэг сэдэвт бүтээл, судалгааны ажил хийсэн байна (https://www.oecd.org, 2013).

- ХБНГУ-ын байгаль орчны судлаачид болох Петр Хурст, Петер Кирбай (2018), Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа ажилчдын эрүүл, аюулгүй байдал болон орчны талаар нэг сэдэвт цуврал судалгааны ажлыг хийсэн. Тэрээр, хөдөө аж ахуйн салбарын ажил нь холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин нь ажилчид, тэдний гэр бүл, олон нийтийн нийгэм, оюун санаа, бие махбодын сайн сайхан байдлыг хамардаг. Үүнд хүрэхийн тулд үйлдвэрчний эвлэл, ажилчид, ажил олгогчид, төрийн болон бусад байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоо шаардлагатай.

- Канадын эрдэмтэн Роберт Д.Буллард (2021), Эрүүл, аюулгүй орчны ач холбогдлыг байгаль орчны чиглэлээр мэргэшсэн нэрт эрдэмтэдтэй хамтран нэг сэдэвт судалгааны ажил хийн онцлон тэмдэглэв. Тэрээр муж улсын иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны асуудалд анхаарал хандуулсан олон нийтэд чиглэсэн арга барилыг хэрэгжүүлэх ёстой гэж үзсэн. Төр шийдвэр гаргах үйл явцдаа иргэд, олон нийтийг идэвхтэй оролцуулж, орон нутгийн оршин суугчидтай хамтран ажилласнаар мужийн эрх баригчид иргэдэд зүй бусаар нөлөөлж буй байгаль орчны асуудлыг илүү сайн шийдэж чадна гэжээ.

Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд " Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ, Нэгт, амьд явах; Хоёрт, эрүүл, аюулгүй орчинд амьдрах; Зургаад, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах".. хэмээн тусгасан байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Гурван тулгуурт хөгжлийн бодлого" батлах тухай 42 дугаар тогтоолд, Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг боловсруулахад үндэсний язгуур эрх ашигт нийцсэн, нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан, *судалгаа, шинжилгээнд үндэслэсэн*, нөөц бололцоонд тулгуурласан, *байгаль орчинд ээлтэй*, ил тод, нээлттэй, олон нийтийн оролцоог хангасан байх зарчмыг баримталсан нь төрийн бодлого нь бидний судалгааны ажлын сэдэвтэй нягт уялдаж байгааг нотолж байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоол (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2026)-оор Монгол Улсын "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого батлагдсан. Уг хөгжлийн бодлогод, Зорилт 9.2. *Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж*, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай

ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолын хавсралт, Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалд:

- Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна.
- Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.
- Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.
- Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг дээшлүүлж, халдвар, хамгаалал, био аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгоно. Монгол малын удмын сан, үр тарианы нутагшмал сортыг хамгаална. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.
- Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн.
- Байгаль орчны боловсролыг олон нийтэд системтэйгээр олгож, газар дэлхий, уул усаа хайрлан хамгаалж ирсэн ардын болон шашны зан уламжлалыг түгээн дэлгэрүүлэх ажлыг сүм хийд, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлнэ гэж заасан нь монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хуульчлан заасан байна.

Таамаглал 1. *Төрийн бодлого нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн үндсэн хуулийн баталгаанд эергээр нөлөөлж чадна.*

Хоёр. Үндэсний хууль тогтоомж буюу эрх зүйн зохицуулалт ба эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн үндсэн хуулийн баталгаа

Их Британийн хуульч А.В. Диси (1835-1922)-гийн "Үндсэн хуулийн хуулийг судлах удиртгал" лекц (1885) нь бичигдсэн болон бичигдээгүй хэд хэдэн эрх мэдлийн нэгдэл болсон Британийн үндсэн хуулийн нэг хэсэг гэж тооцогддог.

Тэрээр, Хууль дээдлэх ёс нь төр гэлтгүй бүх хувь хүн, институт хуульд захирагдаж, захирагдах ёстойг онцолдог. Энэ нь хуулийг тууштай, урьдчилан таамаглахуйц, шударга хэрэглэх, хууль ёсны эрх, журмыг хүндэтгэн хамгаалах ёстой гэсэн үг Эрх зүйн зохицуулалт нь нийгмийн хэв журмыг сахиулах, хувь хүний эрхийг хамгаалах, нийгэм дэх өрсөлдөөнт ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх тогтолцоог бүрдүүлдэг. Энэ нь нийгмийн өөрчлөлт, технологийн дэвшил, шинээр гарч ирж буй сорилтод дасан зохицохын тулд цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдөж, үүсэж болзошгүй эрх зүйн шинэ асуудлуудыг шийдвэрлэх зорилготой.

Францын эрдэмтэн Жером Фрэнк (1889-1957) Хуулийн зохицуулалт нь хүний зан төлөв, харилцаа, харилцан үйлчлэлийн янз бүрийн асуудлыг зохицуулах дүрмийн тогтолцоог бий болгоход чиглэдэг. Энэ нь эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй,

захиргааны эрх зүй, байгаль орчны эрх зүй, худалдааны эрх зүй гэх мэт өргөн хүрээг хамардаг. Эрх зүйн зохицуулалтын зорилго нь хэв журмыг сахиулах, хувь хүн, тэдний эрхийг хамгаалах, шударга ёсыг сахиулах, олон нийтийн ашуулгүй байдлыг хангах, маргааныг шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино.Эрх зүйн зохицуулалтын үйл явц нь ихэвчлэн дараах алхмуудыг агуулна. Үүнд:

- Хууль тогтоомж: Хууль тогтоомжийг үндэсний болон орон нутгийн түвшинд парламент, их хурал зэрэг хууль тогтоох байгууллагууд боловсруулж баталдаг.
- Дүрэм боловсруулах: Зохицуулагч байгууллага, байгууллага нь хуулийн заалтыг хэрэгжүүлэх, тодорхой болгохын тулд тодорхой дүрэм, журам гаргах үүрэгтэй байж болно.
- Хэрэгжилт: Хууль сахиулах байгууллага, тухайлбал, цагдаагийн байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй. Зөрчил нь торгууль, торгууль эсвэл бусад эрх зүйн үр дагаварт хүргэж болзошгүй.
- Шүүхийн шийдвэр: Шүүх, шүүхийн тогтолцоо нь хуулийг тайлбарлах, хэрэглэх, маргааныг шийдвэрлэх, шударга ёсыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хууль зүйн эрдэмтэн Кэри Коглианез (2003), эрх зүйн зохицуулалтын нийцлийн үзэл баримтлалд хувь нэмэр оруулсан. Зохицуулах эрх бүхий байгууллагаас тогтоосон хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжүүд хэр мөрдөж, мөрдөж байгаа эсэхэд анхаардаг. Хуулийн шаардлагыг дагаж мөрдөх нь хэв журмыг сахиулах, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, зохицуулалтын зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай.

Мөн тэрээр хуулийн зохицуулалт буюу эрх зүйн зохицуулалт гэдэг нь хувь хүн, байгууллага, нийгмийг бүхэлд нь зохицуулах хууль тогтоомж, стандартыг хууль эрх зүйн хүрээнд бий болгож, мөрдүүлэх үйл явцыг хэлнэ. Энэ нь эрх, үүрэг, зөвшөөрөгдөх зан үйлийг тодорхойлсон хууль тогтоомж, хууль тогтоомж, дүрэм журам, бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамардаг гэж үзэл баримтлалаа илэрхийлсэн.

Хүснэгт №1 Эрх зүйн зохицуулалт ба эрүүл, ашуулгүй орчны талаарх үзэл баримтлалыг харьцуулсан судалгаа (Дабаацэрэнгийн Бадамцэцэг, 2024).

№	Үзэл баримтлал	Судлаач	Тайлбар
1	Эрсдэлийн зохицуулалтын үзэл баримтлалын хүрээг "Зохицуулалтын динамик хүрээ" гэж нэрлэдэг.	1982 Жон Брайтвейт	Брайтвейтийн хүрээ нь зохицуулалтын үйл ажиллагаа явуулж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлыг харгалзан үзэхийн чухлыг онцолж өгдөг. Энэхүү хүрээ нь зохицуулалтын систем эрсдэл, тодорхойгүй байдалд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх тухай онолын ойлголтыг өгч, аливаа эрсдэлийн зохицуулалтын үйл явцыг бүрдүүлэхэд зохицуулагчид, зохицуулалттай байгууллагууд, нөлөөлөлд өртсөн оролцогч талууд зэрэг янз бүрийн оролцогчдын харилцан үйлчлэлийг онцлон тэмдэглэ
2	Байгаль орчны шударга ёсны үзэл баримтлалын хүрээ	1990 Роберт Д.Буллард	Роберт Д.Буллардын бүтээл, Байгаль орчны шударга ёсны үзэл баримтлалын хүрээ нь нийгмийн шударга ёс ба байгаль орчны огтлолцлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, байгаль орчны тэгш байдал, шударга байдлыг дэмжих бодлого, үйл ажиллагааг сурталчлахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ нь нийгэм, арьс өнгө, эдийн засгийн хүчин зүйлсийн байгаль орчны асуудалтай огтлолцох асуудлыг онцолж, бохирдол, хүрээлэн буй орчны аюул нь гадуурхагдсан нийгэмлэгүүдэд зүй бус нөлөө үзүүлж байгааг онцолдог.

3	Зохицуулалтын нийцлийн үзэл баримтлалын хүрээ	2003 Кэри Когланиз	Зохицуулалтын нийцлийн үзэл баримтлалын хүрээ нь хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх байдлыг ойлгох, сайжруулахад чиглэгддэг. Энэ нь хувь хүн, байгууллагуудыг зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, үр дүнтэй, үр дүнтэй дагаж мөрдөх стратегийг судалдаг.
4	Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн үзэл баримтлалын хүрээ	2008 Лоуренс О.Гостин	Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн үзэл баримтлалын хүрээ нь нийгмийн эрүүл мэндийн практикийг зохицуулах эрх зүйн зарчим, эрх мэдэл, үүргийг багтаасан болно. Энэ нь хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хуулийн үүргийг хүлээн зөвшөөрдөг. Үзэл баримтлалын хүрээний гол бүрэлдэхүүн хэсгүүдэд хуулийн бүрэн эрх, эрх мэдэл, нийгмийн эрүүл мэндийн ёс зүй, онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ зэргийг хамруулан тайлбарласан.

Таамаглал 2. *Эрх зүйн зохицуулалт хангалтгүй байвал эрүүл ахуулгүй орчинд амьдрах эрхийн үндсэн хуулийн баталгаанд сөргөөр нөлөөлнө.*

Гурав. Хүрээлэн буй орчин ба эрүүл, ахуулгүй орчинд амьдрах эрх.

Хүрээлэн буй орчны талаар судлахад хэд хэдэн тодорхойлолт, нэр томьёо анхаарал татсан. Үүний нэг нь экологийн ул мөрний тухай асуудал юм. Экологийн ул мөрийн тухай ойлголтыг 1996 онд АНУ-ын хот төлөвлөлтийн мэргэжилтэн, профессор Уильям Э.Рис, байгаль орчны идэвхтэн, Матис Вакернагел нар боловсруулсан бөгөөд энэ нь хүний үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн тогтвортой байдлыг ойлгоход тусалдаг хэмжүүр гэж үзжээ.

Экологийн ул мөр гэдэг нь хүн амын хэрэглэж буй нөөцийг бий болгох эсвэл тухайн хүн амын бий болгосон хог хаягдлыг шингээхэд шаардагдах биологийн үр өгөөжтэй газар, усны нийт талбайг илэрхийлдэг. Үүнд хоол хүнс, эрчим хүч, ус, мод, дэд бүтцэд зориулсан орон зай зэрэг янз бүрийн нөөц, нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарал зэрэг хог хаягдлыг зайлуулахад шаардагдах шингээх чадварыг харгалзан үздэг.

Хэрэв хүн амын экологийн ул мөр нь тухайн бүс нутаг эсвэл дэлхийн нийт био чадавхаас давсан бол энэ нь тогтворгүй нөхцөл байдлыг илтгэнэ. Энэ нь хүн амын нөөцийг нөхөхөөсөө илүү хурдан хэрэглэж, эсвэл байгаль орчны сөрөг үр дагаваргүйгээр шингээх чадвараас давсан хог хаягдлыг үйлдвэрлэж байна гэсэн үг.

Экологийн ул мөрний талаарх үзэл баримтлал нь хүний үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн бодит хэмжүүр болж, тогтвортой байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, нөөцийн хариуцлагатай менежментийн хэрэгцээг бий болгодог. Энэ нь хувь хүмүүс, олон нийт, бодлого боловсруулагчдад дэлхий дээрх үйлдлийнхээ үр дагаврыг ойлгоход тусалж, экологийн ул мөрийг багасгахын тулд илүү мэдээлэлтэй шийдвэр гаргахад урамшуулдаг. Энэ нь тогтвортой байдлыг үнэлэх, хувь хүний хэрэглээний хэв маягаас эхлээд үндэсний бодлого хүртэл янз бүрийн хэмжээнд экологийн хувьд илүү хариуцлагатай практикийг хэрэгжүүлэх хүчин чармайлтыг чиглүүлэх үнэ цэнтэй хэрэгсэл болсон.

Брундтландын комисс (1987): Брундтландын Комисс буюу Дэлхийн Байгаль орчин, Хөгжлийн Комисс нь 1983 онд НҮБ-аас байгуулагдсан бөгөөд түүний зорилго нь хөгжлийн тогтворгүй хэв маягаас үүдэлтэй нэн чухал сорилтуудыг судалж, дэлхийн хэмжээнд тогтвортой туршлагыг сурталчлах стратегийг санал болгоход чиглэгдсэн. Дэлхийн байгаль орчин, хөгжлийн комисс гэж албан ёсоор нэрлэгддэг Брундтландын комисс "Бидний

хамтын ирээдүй" тайландаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг анх удаа боловсруулж "Тогтвортой хөгжил гэдэг нь хойч үеийнхнийхээ хэрэгцээг хангах чадварыг алдагдуулахгүйгээр одоогийн үеийнхээ хэрэгцээг хангахыг хэлнэ." Хэмээн тайландаа дурджээ. Мөн комисс тайландаа тогтвортой хөгжлийг ирээдүй хойч үеийнхнийхээ хэрэгцээг хангах чадварыг алдагдуулахгүйгээр өнөөгийн хэрэгцээг хангах зам гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолт нь эдийн засгийн хөгжил, нийгмийн дэвшил нь амьдралын чанарыг сайжруулахад нэн чухал боловч байгалийн нөөц, экосистемийг урт хугацаанд хадгалах замаар хэрэгжүүлэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.

Брундтландын комиссын тайлан нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэхэд тус дөхөм болж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн хүрээнд байгаль орчны асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа талаар дэлхий нийтийн ойлголтыг нэмэгдүүлсэн. Тэр цагаас хойш тогтвортой хөгжил нь дэлхий даяарх бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид, байгууллагуудын үндсэн зарчим болж, илүү тэнцвэртэй, тогтвортой ирээдүйд хүрэхэд чиглэсэн стратеги, үйл ажиллагааг тодорхойлж байна. Тухайлбал, Африкийн хүний эрхийн судлаач Барри Коммонер (1971), Канадын эрдэмтэн Дэвид П.Ралл (1976) нарын "Хаалтын тойрог: Байгаль, хүн ба технологи" болон Раллын "Хүрээлэн буй орчны эрүүл мэнд нь дэлхийн хүртээмжтэй шинжлэх ухааны эх сурвалж" илтгэлүүд нь хүрээлэн буй орчны хүчин зүйлс болон хүний эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах талаар уялдаа холбоог онцолсон анхны бүтээлүүд байжээ.Улмаар Ричард Жексон (2003), Ховард Фрумкин (2001) Жексоны "Хотын тэлэлт ба нийгмийн эрүүл мэнд" ном, Фрумкины "Барьсан орчин ба нийгмийн эрүүл мэнд" гэсэн бүтээлүүд нь бидний хүрээлэн буй орчны дизайн, тухайлбал тээврийн систем, орон сууц, ногоон байгууламж нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг болох тухай, Дэвра Дэвис (2002), Филипп Гранджан (2006) нар химийн бодис, бохирдуулагч, хорт бодис зэрэг хүрээлэн буй орчны нөлөөллийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, тэдгээр нь янз бүрийн өвчин, эмгэгтэй холбоотой болохыг дурьджээ.

Таамаглал 3. *Хүрээлэн буй орчин нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн үндсэн хуулийн баталгаанд сөргөөр нөлөөлнө.*

Дөрөв. Иргэдийн эрх зүйн боловсрол ба эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт

Иргэдийн эрх зүйн боловсролыг судлахаас өмнө эрх зүйн ухамсрын талаар судалж үзэв. Иргэдийн эрх зүйн боловсрол, эрх зүйн ухамсрын талаар Эвик Силбэй (1998), Эрх зүйн ухамсар нь хувь хүмүүсийн хуулийг хүлээн авч, ойлгож, хариу үйлдэл үзүүлэх арга замыг хэлнэ. Судлаачдын ажил нь хүмүүсийн туршлага, үнэ цэнэ, нийгмийн нөхцөл байдал нь тэдний хууль эрх зүйн тогтолцоотой холбоотой ойлголт, оролцоог хэрхэн бүрдүүлдгийг судалдаг, Жоэл Вестхаймер ба Жозеф Кахне (2004), Идэвхтэй иргэншлийн үзэл баримтлал нь ардчилсан нийгэмд иргэдийн оролцоо, оролцоо чухал гэдгийг онцолдог. Вэстхаймер, Кане нар иргэдийн дунд шүүмжлэлтэй сэтгэлгээ, өрөвдөх сэтгэл, хариуцлагын мэдрэмжийг төлөвшүүлэх боловсролын талаар үзэл бодлоо илэрхийлдэг, БНХАУ-ын судлаач Сэлэнэ Тан, Ворнер Гөүлд (2009) нар Хууль эрх зүйн чадавх нь хувь хүмүүс болон олон нийтийг, ялангуяа гадуурхагдсан эсвэл эмзэг бүлгийн хүмүүст хууль ёсны эрхээ үр дүнтэй ойлгох, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хууль эрх зүйн нөөцөд хандах боломжийг олгоход чиглэдэг талаар үзэл баримтлалаа илэрхийлдэг.

ИБУИНВУ-ын судлаач Чарлиз Ф Абернати (2019), Хуультай холбоотой хууль зүйн боловсрол гэдэг нь хувь хүмүүсийн хууль, эрх зүйн тогтолцоо, эрх зүйн үйл явцын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой боловсролын хөтөлбөрүүдийг хэлнэ. Түүний үзэл баримтлал нь хуулийн боловсролыг иргэн бүрд олгох, иргэдийг хөгжүүлэхэд хувь нэмрээ үнэтэй оруулсан бөгөөд хуулийн мэдлэг, мэдээлэлтэй иргэн болоход

хуультай холбоотой мэдлэг, ур чадвар чухал болохыг онцолсон.

Дээрх эрдэмтэн судлаачдын үзэл баримтлалаас Байгаль орчны эрх зүйн зохицуулалт, байгаль орчныг хамгаалах зан үйлийн хоорондын хамаарлыг олон эрдэмтэн судлаачид судалсан байдаг Эдгээр судалгаанаас харахад байгаль орчны хууль тогтоомжийн талаарх мэдлэг, мэдлэгийг нэмэгдүүлэх нь хүмүүсийн байгаль орчинд хандах хандлага, зан үйлд эергээр нөлөөлдөг болохыг харж болно.

Хүмүүс байгаль орчны хууль тогтоомжийг мэддэг бол байгаль орчныг хамгаалахын ач холбогдол, үйл ажиллагааныхаа болзошгүй үр дагаврыг илүү сайн ойлгох хандлагатай байдаг. Энэхүү мэдлэг нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд оролцоход түлхэц болно. Жишээлбэл, хог хаягдлын менежменттэй холбоотой хууль тогтоомжийг мэддэг хүмүүс хог хаягдлаа зөв хаях эсвэл дахин боловсруулах хандлагатай байдаг бол эрчим хүчний хэмнэлтийн зохицуулалтыг мэддэг хүмүүс эрчим хүчний хэрэглээгээ багасгах хандлагатай байдаг.

Байгаль орчны тухай хуулийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах зан үйлийн хоорондын харилцаа нь нарийн төвөгтэй бөгөөд хувь хүний үнэт зүйлс, нийгмийн хэм хэмжээ, нөөцийн хүртээмж зэрэг янз бүрийн хүчин зүйлээс хамаардаг гэдгийг анхаарах нь чухал юм. Тиймээс байгаль орчны хуулиудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх нь хувь нэмэр оруулах хүчин зүйл байж болох ч байгаль орчныг хамгаалах зан үйлийн цорын ганц хүчин зүйл биш юм.

Судлаачийн зүгээс дээрх онол арга зүй, эх сурвалж, эрдэмтдийн судалгааны ажлын үр дүнг судлан дэмжсэний үндсэн дээр өөрийн судалгааны ажилд таамаглалаа дэвшүүлсэн билээ.

Таамаглал 4. *Иргэдийн эрх зүйн боловсрол бага байснаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн үндсэн хуулийн баталгаанд сөрөөр нөлөөлж чадна.*

Тав. Экологийн боловсрол ба эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгаа

Экологийн боловсрол гэдэг нь экологийн зарчмууд, байгаль орчны тогтвортой байдал, экосистем доторх амьд организмуудын харилцан хамаарлын талаар заах, суралцах үйл явц юм. Экологийн боловсролын үндсэн зорилго нь байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх, хувь хүнийг тогтвортой ирээдүйг бий болгоход хариуцлагатай, идэвхтэй оролцогч болгоход оршино. Энэ нь зүгээр л мэдээлэл өгөхөөс гадна байгалийн ертөнцийг хамгаалах, тогтвортой байлгахын тулд шүүмжлэлтэй сэтгэлгээ, асуудлыг шийдвэрлэх, арга хэмжээ авахыг чухалчилдаг.

Экологийн боловсрол нь экологи, байгаль орчинтой холбоотой өргөн хүрээний сэдэв, сэдвийг хамардаг. Үүнд биологийн олон янз байдал, экосистем, уур амьсгалын өөрчлөлт, бохирдол, нөөцийг хамгаалах, тогтвортой хөгжил гэх мэт ойлголтууд багтдаг. Интерактив, оролцооны аргуудаар дамжуулан байгаль орчны асуудлын нарийн төвөгтэй байдлыг судлах, экологийн тогтолцооны харилцан уялдаа холбоог ойлгох, хүрээлэн буй орчинд хүний нөлөөллийг танин мэдэхэд хувь хүмүүсийг урамшуулдаг. Экологийн боловсрол нь экологийн мэдлэгийг дээшлүүлж, байгаль орчны тулгамдсан асуудлуудыг ойлгох, шийдвэрлэх боломжийг олгох замаар экологийн боловсрол нь тогтвортой, байгаль орчинд ээлтэй нийгмийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ талаар байгаль орчны сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн Дэвид В.Орр (2002), "Экологийн бичиг үсэг: Боловсрол ба постмодерн ертөнцөд шилжих нь" номоо хэвлүүлсэн. Энэхүү бүтээлдээ Дэвид В.Орр байгаль орчны нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд хувь хүнийг бэлтгэхэд экологийн боловсролын ач холбогдлыг судалж, экологийн зарчмуудыг нэгтгэх боловсролын парадигмд шилжихийг дэмжинэ, Физикч, системийн онолч Фритжоф Капра (2016), "Амьдралын вэб: Амьд системийн тухай шинжлэх ухааны шинэ ойлголт" ном бичсэн. Капрагийн бүтээл нь зөвхөн боловсролд чиглээгүй ч экологийн зарчмууд болон амьдралын

харилцан уялдаатай байдлын талаар цогц ойлголтыг өгдөг. Энэ нь экологийн боловсролын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийг боловсруулахад нөлөөлсөн.

Судлаачийн зүгээс дээрх онол арга зүй, эх сурвалж, эрдэмтдийн судалгааны ажлын үр дүнг судлан дэмжсэний үндсэн дээр өөрийн судалгааны ажилд таамаглалаа дэвшүүлсэн.

Таамаглал 5. *Экологийн боловсрол нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хуулийн баталгаанд сөргөөр нөлөөлж чадна.*

Бид судалгааны ажилдаа үндсэн таван хамаарах хувьсагчийг үл хамаарах хувьсагч руу нөлөөлөх нөлөөллөөр загвараа таамаглан боловсруулаа. Хамаарах хувьсагч гэдэг нь үр нөлөөг тайлбарлаж буй, ажиглаж, хэмжиж байгаа хувьсагч. Өөрөөр хэлбэл, бусад хэмжигдэхүүнээс ихээхэн хамаарч, бие даасан хувьсагчийг туршилтаар удирдсаны үр дүнд хувьсагчид өөрчлөгдөх төлөвтэй байдаг таамаглаж буй нөлөө тул өөрийн ажилдаа хамаарлыг шууд хамаарах хувьсагчийг ашигласан.

Энэхүү хэмжигдэхүүн дээр суурилсан хэмжигдэхүйц зүйл нь судалгааны асуудлыг оновчтой бөгөөд тодорхой болгож урьдчилсан төлөвлөгөө гаргахад чухал үүрэг гүйцэтгэж таамаглалыг томьёолж, судалгааны ажлыг бодит үр дүнтэй байлгахад чиглэдэг тул хувьсагч бүрийн загвартаа дүрсэлсэн.

Зураг №1. Эрүүл, аюулгүй орчинд амьдрахад нөлөөлж буй нөлөөллийн хамаарлыг загварыг харуулсан байдлын зураглал.



Бид судалгааны ажилдаа хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт, иргэдийн эрх зүйн боловсрол, мөн экологийн боловсрол нөлөөлөхөөс гадна хүрээлэн буй орчны зүгээс хүнд дам байдлаар нөлөөлдөг гэсэн таамаглалыг дэвшүүлэн хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрахад эрхийг хангахад нөлөөлж буй хүчин зүйлийг олон улсын нэр хүнд бүхий байгууллагаас гаргасан судалгааны зөвлөмж, эрдэмтэн, судлаачдын судалгааны ажил болон Монгол Улсын шүүхийн шийдвэрүүдэд тулгуурлан дүн шинжилгээ хийж онолын уялдаа, таамаглал, загвар боловсруулаа. Энэхүү ажлын хүрээнд 1265 оролцогчоос 5 хувьсагч бүхий 30 хүчин зүйлээр тодорхойлсон судалгааг авч үр дүнг SMART PLS 4.0 аргачлалаар бодож дүгнэв. Судалгаанаас үзвэл төрийн бодлого нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрахад нөлөөлөх хамгийн гол хүчин зүйл бөгөөд эрх зүйн зохицуулалт, иргэдийн экологийн

болон эрх зүйн боловсрол, хүнийг хүрээлэн буй хүчин зүйл нь нөлөөлөх хүчин зүйл биш гэж үзлээ. Иймд төрөөс хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахын тулд төрөөс цогц бодлого боловсруулах шаардлагатай байна.

Дүгнэлт

- Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд тавигдах хамгийн наад захын шалгуур болох ёс суртахуун, үнэт зүйлсээр дамжигдан хуульчлагдсан байх ёстой;
- Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, түүний агуулга, тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг бүсчлэн хийж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах бодлогын болон эрх зүйн шинжилгээнд ашиглах шаардлага хэдийн тулгарсан байна.

Ашигласан материалын жагсаалт

Cambridge dictionnairy. (2024). https://dictionary.cambridge.org/dictionary/english/safe.: https://dictionary.cambridge.org-ээс Гаргасан

dictionary, O. (2026). *https://www.oxfordlearnersdictionaries.com/definition/english/safe_1?q=safe.* https://www.oxfordlearnersdictionaries.com-ээс Гаргасан

dictionnairy, C. (2026). *https://dictionary.cambridge.org/dictionary/english/environment.* https://dictionary.cambridge.org/dictionary/english/environment.-ээс Гаргасан

https://dictionary.cambridge.org/dictionary/english/health. . (огноо байхгүй). https://dictionary.cambridge.org/dictionary/english/health. : https://dictionary.cambridge.org-ээс Гаргасан

https://dictionary.cambridge.org/dictionary/english/health. . (огноо байхгүй). https://dictionary.cambridge.org/dictionary/english/health. : https://dictionary.cambridge.org-ээс Гаргасан

https://www.oecd.org/env/ehs/Environment-Health-Safety-Brochure.pdf. (2013). *The environment health and safety programme, .*-Д OECD,.

Lincoln, C. Z. (1906,). https://onlinebooks.library.upenn.edu/webbin/book/lookupid. *The Lawyers Co-operative Publishing Company.*-Д USA.

Oxford dictionnairy. (2026). https://www.oxfordlearnersdictionaries.com: https://www.oxfordlearnersdictionaries.com-ээс Гаргасан

www.oxfordlearnersdictionaries.com/definition. (2025). www.oxfordlearnersdictionaries.com: www.oxfordlearnersdictionaries.com-ээс Гаргасан

Даваацэрэнгийн Бадамцэцэг, Х. э. (2024). *Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх.* Улаанбаатар: Дотоод хэргийн их сургууль.

Женкинс., У. (огноо байхгүй). Төрийн бодлого. У. Женкинс.-Д, *Төрийн бодлого* (хууд. 11 дэх тал). 2006.

толь, М. х. (2021). Монгол хэлний тайлбар толь. Улаанбаатар : Монсудар.

толь, М. х. (2021). Монгол хэлний тайлбар толь . Улаанбаатар : Монсудар.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2026). https://legalinfo.mn/mn.

НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЛИЙГ ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД АШИГЛАХ БОЛОМЖ, СОРИЛТ БА ШИЙДЭЛ

UAVS IN PUBLIC SECURITY: OPPORTUNITIES, CHALLENGES, AND STRATEGIC SOLUTIONS

Ш.Ундарга*
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн ахлах багш, хошууч
Undarga Sh.
Senior Lecturer at the School of Border Service, University of Internal Affairs, Major

*Хариуцлагатай зохиогч: undakadnu@gmail.com

Хураангуй: Технологийн хурдацтай хөгжил нь нийгмийн хэв журам сахиулах, аюулгүй байдлыг хангах арга туршлагад томоохон өөрчлөлт авчирч байна. Нисгэгчгүй нисэх хэрэгсэл (ННХ) буюу дронууд нь олон нийтийн арга хэмжээний үеэр нөхцөл байдлыг бодит хугацаанд хянах, эрсдэлийг шуурхай илрүүлэх хүчирхэг хэрэгсэл болон хувирчээ. Энэхүү өгүүлэлд ННХ-ийн олон нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдлын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн давуу тал, тулгарч буй техникийн болон хууль эрх зүйн саад бэрхшээлүүдийг шинжлэх замаар үр ашигтай ашиглах загварыг тодорхойлохыг зорилоо.

Abstract: Rapid technological advancements are significantly transforming the methodologies of maintaining public order and ensuring security. Unmanned Aerial Vehicles (UAVs), commonly known as drones, have evolved into powerful tools for real-time situational monitoring and rapid risk detection during public events. This article aims to define an efficient utilization model by analyzing the role of UAVs in public security operations, their inherent advantages, and the prevailing technical and legal challenges.

Түлхүүр үгс: *Нисгэгчгүй нисэх хэрэгсэл, Олон нийтийн аюулгүй байдал, Хяналтын систем, Хиймэл оюун, Эрсдэлийн удирдлага.*

Keywords: Unmanned Aerial Vehicles (UAV), Public Security, Surveillance Systems, Artificial Intelligence (AI), Risk Management.


Дэлхий нийтээр нийгэм, улс төрийн байдал тогтворгүйтэх, жагсаал цуглаан, эмх замбараагүй байдал үүсэх давтамж нь нэмэгдэж байна. Үүнийг дагаад дээрх арга хэмжээний аюулгүй байдлыг хангахад зөвхөн газрын хяналт (цагдаа, дотоодын цэрэг, хамгаалалтын ажилтнууд) хангалтгүй байгаа нь дээрх арга хэмжээг цогцоор шийдвэрлэх шаардлага үүсгэж байна.

Кэйс 1. Олон улсын туршлага: Манчестер Арена (телехяналтын сохор цэг ба холбоо)

Дэлхийн практикт аюулгүй байдлын техник хэрэгсэл дутмаг эсхүл төлөвлөлтийн алдаанаас болж гарсан хамгийн том сургамж бол 2017 оны Манчестер Аренагийн халдлага юм. Тухайн үед объектын хяналтын камерын системд сохор цэгүүд байсны улмаас хорлон сүйтгэгч этгээд нэг цаг орчим хугацаанд хяналтаас гадуур байж чадсан төдийгүй, халдлагын дараа онцгой байдлын албадын холбоо харилцааны техникийн үл зохицол нь аврах ажиллагааг хоёр цагаар саатуулахад хүргэсэн байдаг (Saunders, 2021).

"Манчестер Аренагийн эмгэнэлт явдал нь зөвхөн газрын хяналтын системд найдах нь эрсдэлтэйг харуулсан. Орчин үеийн ННХ буюу дронууд нь камерын сохор бүсийг агааранас нөхөж, өөр хоорондоо үл зохицох холбооны системүүдийн дунд дохио дамжуулах релей (Communication Relay) болж ажилласнаар аврах ажиллагаанд хугацаа хожих давуу талтай. (Saunders, 2021)

This article is published under the Creative Commons BY-NC-SA License by 4.0, ©2026 University of Internal Affairs, Mongolia



Зураг-1. Манчестер Аренагийн дэлбэрэлт болсон сохор бүс бүхий хэсэг
Эх сурвалж: (news, 2018)

Кэйс 2. Дотоодын туршлага: 2008 оны 7-р сарын 1 (Техникийн хангамж ба урьдчилан сэргийлэлт) Монгол Улсад 2008 оны 7 дугаар сарын 1-нд болсон үйл явдал нь техникийн хангамж дутмагаас үүдсэн эрсдэлийг харуулсан бодит жишээ юм. Тухайн үед нийтийн хэв журам сахиулах алба хаагчдад жагсагчдыг тараах үхэлд үл хүргэх техник хэрэгсэл (даралтат усан буу, нулимс асгаруулагч гэх мэт) хангалттай хэмжээгээр байгаагүй нь нөхцөл байдал хяналтаас гарах нэг хүчин зүйл болсон гэж үзсэн байна. (Хүний эрхийн Үндэсний Комисс [ХЭҮК], 2009). Мөн нэгдсэн хяналтын камерын сүлжээ сул байсан нь үймээн дэгдээгчид болон гал тавигчдыг бодит хугацаанд хянах боломжийг хязгаарласан байдаг. (ХЭҮК, 2009)



Зураг-2 2008 оны 07 сарын 01 олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал
Эх сурвалж: (mass.mn, 2015)

Кэйс 3. Агаарын орон зайн Цэвэрлэгээ ба Хязгаарлалт

Олон нийтийн арга хэмжээний аюулгүй байдлыг хангах түүхэнд "Парис-2024" Олимпын наадам нь ННХ болон түүний эсрэг системийг хамгийн өргөн цар хүрээтэй, хиймэл оюун ухаантай хослуулан ашигласан анхны тохиолдол болж бүртгэгдсэн. Энэхүү кэйс нь орчин үеийн радио электроник, алгоритмын шийдлүүд бодит амьдрал дээр хэрхэн ажилладгийг харуулсан жишиг юм.

Францын Дотоод хэргийн яам болон Иргэний нисэхийн ерөнхий газар тус улсад 2024 онд зохион байгуулагдсан Олимпын наадмын үеэр аюулгүй байдлыг хангах зорилгоор Парис хотын дээгүүр **150 км-ийн радиуст** түр зуурын нислэгийн хориглолтын бүс (Temporary Restricted Area)-ийг тогтоож өгсөн.

- **Дрон-хамгаалалтын бүс:** Тэмцээн болж буй цэнгэлдэх хүрээлэн бүрийн дээгүүр 6-10 км-ийн радиуст "No-Fly Zone" үүсгэж, бүх зөвшөөрөлгүй нисэж буй биетийг шууд "Аюул" гэж ангилсан.
- **Техникийн шийдэл:** "U-Space" платформыг ашиглан зөвшөөрөлтэй (цагдаа, хэвлэл мэдээллийн) болон зөвшөөрөлгүй дронуудыг бодит хугацаанд ялгаж, нэгдсэн системд бүртгэж байв. ((Ministère del'Intérieur), 2024)

"PARADE" ба "BASSALT" илрүүлэлтийн системүүд

Парисын тэнгэрийг хамгаалахын тулд Францын арми Thales компанийн бүтээсэн **PARADE** болон **BASSALT** системүүдийг байршуулсан.

- **Илрүүлэлт (Detection):** Эдгээр системүүд нь идэвхтэй радар (Active Radar) болон идэвхгүй радио давтамжийн сканнеруудыг ашиглан дроны удирдлагын дохиог 10 км-ийн зайнаас барьж авч байв.
- **Гурвалсан баталгаажуулалт:** Радараар илрүүлсэн биетийг өндөр хүчин чадалтай оптик болон дулаан мэдрэгч (Infrared) камеруудаар томруулан харж, дрон мөн эсэхийг баталгаажуулж байв.
- **Радио электроникийн давуу тал:** Жижиг хэмжээтэй дронууд нь радарт шувуу шиг харагдах эрсдэлтэй байдаг тул AI алгоритм нь тухайн биетийн нислэгийн чиглэл, хурд, радио долгионы модуляцид шинжилгээ хийж "Дрон" мөн болохыг 99%-ийн магадлалтай тогтоож байв.

Саармагжуулах тактик (Mitigation): Олимпын наадмын үеэр нийт 355 зөвшөөрөлгүй дрон илэрсэн бөгөөд тэдгээртэй тэмцэхдээ дараах хоёр аргыг хослуулан ашигласан:

Дохио саатуулах (Jamming): "NEROD RF" гар буу хэлбэрийн саатуулагчаар дроны удирдлагын суваг болон GPS навигацийн дохиог тасалсан. Ингэснээр дрон агаарт гацаж, "Safe Return" эсвэл "Auto-Landing" горимд шилжиж байв.

Сүлжээний халдлага (Cyber Takeover): Зарим нарийн технологийн тусламжтайгаар дроны удирдлагыг алсын зайнаас булаан авч (protocol manipulation), аюулгүй бүсэд газардуулах ажиллагааг гүйцэтгэсэн байдаг.

Хиймэл оюунаар олон нийтийг удирдах (Algorithmic Crowdsourcing)

Олимпын наадмын хамгийн эрсдэлтэй хэсэг болох Сена мөрний эрэг дагуух нээлтийн ажиллагааны үеэр дронууд дараах үүргийг гүйцэтгэсэн:

Anomaly Detection (Хэвийн бус үзэгдлийг илрүүлэх): AI камерууд олны дунд хүн унах, сэжигтэй ачаа орхих, эсвэл хүмүүс гэнэт нэг чиглэлд сандралдан гүйх зэрэг хэвийн бус үйлдлийг таньж, хамгийн ойр байгаа эргүүлийн багт секунд хүрэхгүй хугацаанд дохио илгээж байв.

Нягтаршлын зураглал (Heatmap): Мөрний эргийн дагуух 320,000 хүний нягтаршлыг дроноор дээрээс хянаж, орох/гарах урсгалыг зохицуулсан.

Энэ кэйсээс үзэхэд аюулгүй байдал нь зөвхөн хяналт биш, харин "Урьдчилан таамаглах" систем болон хувирч байна.



Зураг-3. Парис 2024 олимпын үеэр саатулагдсан дроны зорилго
Эх сурвалж (IDGA, 2025)

Эрсдэл ба Сорилтууд

Хэдий энэхүү технологи нь аюулгүй байдлыг өндөр түвшинд хангах боловч уг туршлагад зарим хүндрэлтэй, нэмэлт хөгжүүлэлт, шийдэл шаардлагатай хэд хэдэн асуудал байдаг:

- **Техникийн саатал:** Хотын шигүү барилга байгууламж болон 5G сүлжээний дохионы нөлөөллөөс болоод зарим үед радарт "False Positive" буюу хуурамч ННХ илэрч бүртгэгдэх тохиолдлууд гардаг.
- **Эрх зүйн асуудал:** Иргэдийн царайг AI-аар таних нь хүний хүний хувийн нууцыг хамгаалах тухай хууль болон өөр бусад эрхийн маргаан дагуулах тул зөвхөн үйлдэл танихыг (Behavior) зөвшөөрч, царай танихыг(Identity) хязгаарлах нарийн зохицуулалт шаардлагатай болно. Энэ нь манай улсад ийм технологи нэвтрүүлэхэд хууль зүйн тодорхой зохицуулалт хэрэгтэйг сануулж байна.

Дээрх жишээнүүдээс харахад аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь зөвхөн хүн хүчнээс гадна, сохор цэггүй хяналтын систем, алба хоорондын нэгдмэл холбоо харилцаа, нөхцөл байдалд тохирсон техникийн хангамж зэрэг цогц шийдлээс шууд хамаарч байх бөгөөд техникийн дутагдалтай талуудыг нөхөх хамгийн оновчтой, орчин үеийн шийдэл нь **Нисгэгчгүй нисэх хэрэгслийг (ННХ)** хууль сахиулах ажиллагаанд нэвтрүүлэх явдал гэж үзэж байна. ННХ нь зөвхөн агаараас дүрс дамжуулах төдийгүй, газрын хяналтын системийн хязгаарлагдмал байдлыг арилгаж, нөхцөл байдлын бүрэн зураглалыг хүлээн авах, удирдлагын шийдвэр гаргах түвшинд стратегийн давуу талыг олгож байна".

Энэхүү техникийн дутагдлуудыг арилгах үр дүнтэй арга нь **динамик хяналтын тогтолцоог** нэвтрүүлэх явдал юм. Статик камерын систем нь Манчестер Арена болон 7-р сарын 1-ний үйл явдлуудад харагдсан шиг сохор цэг болон мэдээллийн тасалдал үүсгэх эрсдэлтэй байдаг бол ННХ-д суурилсан динамик хяналт нь нөхцөл байдлыг агаараас, олон өнцгөөс, бодит хугацаанд хянах стратегийн давуу талыг олгодог.


3. Олон нийтийн арга хэмжээнд ННХ-ийг ашиглах үндсэн чиглэлүүд

3.1 Цугласан олны динамик хяналт

Олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр динамик **хяналт (Dynamic Crowd Monitoring)** нь хүмүүсийн хөдөлгөөний хурд, чиглэл, нягтралын өөрчлөлтийг бодит хугацаанд (real-time) тооцоолол хийнэ.

Цугласан олны динамикийг хянахад нэг метр квадрат талбайд ногдох хүний тоо чухал байдаг. Нэгж талбайд 5-аас дээш хүн цугласан тохиолдолд "бөөгнөрөл" (crowd

turbulence) үүсэх бөгөөд хүмүүс өөрийн хүслээр бус, олны урсгалаар түрэгдэж эхлэх бөгөөд энэ нь шахцалдаанаас үүдэлтэй осол эндэгдлийн гол шалтгаан болдог байна.



Зураг-4. Олон нийтийг хамарсан арга хэмжээний үний бөөгнөрлийн ангилал

Олон нийтийг хамарсан арга хэмжээний динамик хяналт энэ төрлийн арга хэмжээний үеэр түгээмэл үүсэх дараах мэдээллийг авахад чухал нөлөөтэй. Үүнд:

- **Урсгалын хурд ба чиглэл (Flow Velocity and Vectors)** ННХ-ийг хиймэл оюунд суурилуулан анализ хийж ашигласнаар хүмүүсийн чиглэлийг вектор хэлбэрээр тодорхойлно.
- **Зөрүүтэй урсгал (Counter-flow):** Хоёр өөр чиглэлээс ирж буй урсгал нэг цэгт огтлолцох үед даралт огцом нэмэгддэг. ННХ агаараас энэ огтлолцлыг урьдчилан харж, зохицуулалт хийх боломжийг олгоно.
- **Бөглөрөл (Bottleneck effect):** Хаалга, нарийн гудамж, шат зэрэг хэсэгт урсгалын хурд саатахыг AI систем автоматаар илрүүлж, аюулгүй байдлын ажилтнуудад дохио өгнө.

- Хэвийн бус үйлдэл илрүүлэх (Anomaly Detection) Динамик хяналтын хамгийн чухал хэсэг нь олны дундах хэвийн бус үйлдлийг таних явдал юм.

- Үймээн (Panic motion): Хүмүүс гэнэт нэг зүгт огцом гүйх эсвэл тал тал тийш сарних хөдөлгөөнийг систем алгоритмын тусламжтайгаар ялган мэдээллэнэ.

- Шахалдаан (Crowd collapse): Хэрэв нэг хүн унахад түүнийг дарж бусад хүмүүс унах "домино эффект" үүсвэл систем тэрхүү цэгийг улаан өнгөөр (Heatmap) тодруулж, аврах ажиллагааны багт чиглэлийг зааж өгнө.

Дээрх бөглөрлийг тооцох аргыг математик загвараар үзүүлбэл:

$Q = \rho * V * W$

Үүнд:

- Q – Урсгалын хэмжээ (секундэд өнгөрөх хүний тоо)
- ρ– Хүний нягтрал (хүн/м^2)
- V – Хөдөлгөөний дундаж хурд (м/с)
- W – Гарц эсвэл замын өргөн (м)

Математик загвараас үзвэл нягтрал (ρ) нэмэгдэх тусам хурд (v) огцом буурах бөгөөд ρ> 5 хүн м^2 болох үед урсгал зогсож аюултай бөөгнөрөл үүснэ.

Техникийн боломжууд:

Дүрс боловсруулах алгоритм. ННХ-ээс ирж буй видео стрим дүрс дээр дараах алгоритмуудыг ашиглан динамик хяналт хийдэг:

- **Optical Flow Algorithm:** Дүрсийн пиксел бүрийн хөдөлгөөнийг тооцоолж, олны хөдөлгөөний чиглэлийг (Vector Map) тодорхойлно. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед "бөөгнөрөл" хаашаа шилжиж байгааг харуулна.
- **Convolutional Neural Networks (CNN):** Хүмүүсийн толгойн хэлбэрийг матрицаас ирэх дохиогоор таньж багцаар нь тоолох бөгөөд (Crowd Counting) орчин үеийн алгоритмууд 95 хувиас дээш нарийвчлалтай тоолдог.

Радио электроникийн шийдэл: Сүлжээ, дүрсний дамжуулалт (Latency) Динамик хяналт нь "Бодит цаг хугацаанд" байх ёстой. Үүнд радио долгионы дамжуулалтын хурд, боловсруулалт чухал үүрэгтэй:

- **4G/5G Холболт:** Видеог 4K чанартайгаар дамжуулахад хамгийн багадаа **20-50 Mbps** тогтмол хурд шаардлагатай.
- **End-to-End Latency:** Дроны камерын линз дээр дүрс буухаас операторын дэлгэцэнд очих хүртэлх хугацаа **<200ms** байх нь шийдвэр гаргах хурдад нөлөөлөхгүй бөгөөд бараг хоцрогдолгүй гэсэн үг юм.
- **Edge Processing:** CCTV хяналтын камерууд болон дрон дээрх процессорт AI алгоритмыг шууд суулгаснаар датаг сервер рүү явуулж боловсруулах хугацааг хэмнэнэ.

Шуурхай хариу арга хэмжээ ба аврах ажиллагаа: гэнэтийн осол эсвэл халдлага гарсан тохиолдолд дрон нь:

- Ослын голомтод хамгийн түрүүнд хүрч, бодит мэдээллийг төв штаб руу дамжуулах.
- Эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл (дефибриллятор, эм тариа) хүргэх.
- Чанга яригчаар дамжуулан иргэдэд зааварчилгаа өгч, айдас сандралыг бууруулах.

Сэжигтэй объект болон этгээдийг илрүүлэх: Дулаан мэдрэгч (Thermal imaging) болон нүүр царай таних технологи ашиглан шөнийн цагт эсвэл үзэгдэх орчин хязгаарлагдмал үед эрэн сурвалжлагдаж буй этгээд, орхигдсон сэжигтэй цүнх, эд зүйлсийг өндөр магадлалтайгаар олж тогтоох зэргээр ашиглагдана.

Техник технологийн тавигдах шаардлага

Олон нийтийг хамарсан арга хэмжээний үед аюулгүй байдлыг хангахад ашиглагдах ННХ нь дараах техникийн үзүүлэлтүүдийг хангасан байвал зохино:

- **Холболтын найдвартай байдал:** Бөөн иргэд цугласан үед гар утасны долгион давхцах, саатах асуудал гарах магадлал маш өндөр тул ямар ч үед дохио тасрахгүй байх боломжийг хангах (Encryption, 5G/Sat-link).
- **Дүрс боловсруулалт:** Edge Computing буюу мэдээллийг сервер рүү явуулахаас өмнө дрон дээр шууд боловсруулт хийж, аюулыг автоматаар ангилах, улмаар төв серверийг бичлэгт өртсөн дүрс бүхнээр хэт ачаалахаас сэргийлэх.
- **Тасралтгүй ажиллагаа:** Батерейны багтаамжийг нэмэгдүүлэх эсвэл "Tethered drone" буюу утсаар тэжээгддэг дроныг ашиглан 24/7 хяналт тогтоох зэрэг болно.

Тулгарч буй эрсдэл ба саад бэрхшээл

Техникийн аюулгүй байдал: Дрон техникийн саатлаас болж иргэдийн дээрээс унах нь иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюултай. Иймд аюулгүй газардуулгын шүхрийн систем, хөдөлгүүрийн нөөц систем (Redundancy) зайлшгүй шаардлагатай.

Нууцлал ба Хүний эрх: Иргэдийг зөвшөөрөлгүйгээр бичлэгт буулгах, царай таних системийг зүй бусаар ашиглах нь хувь хүний нууцад халдах эрсдэлийг дагуулдаг. Үүнийг эрх зүйн хүрээнд зөвшөөрөгдөх зохицуулалт хийх хэрэгцээ гарна.

Халдлага (Counter-Drone): Халдлага үйлдэгчид өөрсдөө дрон ашиглах, эсвэл аюулгүй байдлын дроны системийг хакердах (Spoofing/Jamming) тохиолдол гарч болно. Тиймээс арга хэмжээний үеэр "Дроны эсрэг хамгаалалтын бүс" байгуулах шаардлага үүснэ.

Дүгнэлт

Дүгнэлт: Нисгэгчгүй нисэх хэрэгсэл нь орчин үеийн олон нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдлыг хангахад ашиглах хувилбар биш, зайлшгүй шаардлага болон хувирч байна.

Хэдийгээр техникийн болон хууль эрх зүйн зарим зохицуулалт хийх асуудлууд байгаа хэдий ч тэдгээрийг зөв зохицуулалт, технологийн дэвшлээр цогцоор шийдвэрлэх боломжтой.

ННХ-ийг системтэйгээр, бусад төрлийн аюулгүй байдлыг хангах, дэмжлэг үзүүлэх техник технологитой нэгдсэн цогц байдлаар нэвтрүүлэн ашигласнаар олон нийтийг хамарсан арга хэмжээний эрсдэлийг 40-60 хувиар бууруулж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах боломжтой юм.

Санал болгож буй стратеги

Олон нийтийн арга хэмжээний аюулгүй байдлыг ННХ-ийн тусламжтайгаар үр дүнтэй хангахын тулд дараах "Гурван тулгуур" загварыг санал болгож байна:

1. **Интеграци:** Дроныг зөвхөн тусдаа хэрэгсэл бус, нийтийн хяналтын камер болон газрын бие бүрэлдэхүүний холбооны системтэй нэгдсэн нэг удирдлагын төвд зангидаж цогц хэлбэрээр ашиглах.
2. **Эрх зүйн зохицуулалт:** ННХ нисгэх тусгай бүс, өндөр, цагийн хязгаарыг тогтоож, эрх зүйн орчныг бүрдүүлэх, операторуудыг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэн гэрчилгээжүүлэх.
3. **Автоматжуулалт:** Хүний анхаарал сарних хүчин зүйлийг бууруулахын тулд хиймэл оюунаар илрүүлэх үйлдлийг автоматжуулах.

Ашигласан материалын жагсаалт:

(Ministère del'Intérieur), Ф. Д. (2024). *Парис-2024 Олимпын наадмын аюулгүй байдлын нэгдсэн тайлан:*. Францын Дотоод хэргийн яам.

Armées), (. d. (2024). *Агаарын орон зайн хяналт ба PARADE, BASSALT системүүд.* Францын зэвсэгт хүчний яам.

IDGA. (2025 оны 10 04). *IDGA.ORG*. https://www.idga.org/aviation/articles/strengthening-uas-security-with-lessons-from-paris-olympics-ээс Гаргасан

mass.mn. (2015 оны 07 01). *Mass.mn*. https://mass.mn/n/37085-ээс Гаргасан

news, B. (2018 оны 03 27). *BBC.NEWS*. BBC: https://www.bbc.com/news/uk-england-43555145-ээс Гаргасан

Saunders, J. (2021). *Manchester Arena Inquiry Volume 1: Security for attendance.* https://www.gov.uk/government/publications/manchester-arena-inquiry-volume-1-security-for-the-arena.

Манчестер Аренагийн халдлагыг мөрдөн шалгах комисс (Manchester Arena Inquiry). (2021). Saunders, J. M. (2021). *Manchester Arena Inquiry Volume 1: Security for attendance.* Saunders.J.

ХЭҮК. (2009). *State of Human Rights and Freedoms in Mongolia.* National Human Rights Commission of Mongolia.

Техник редактор:

Ө.Тогтохбаяр

Дугаар эрхлэн гаргасан:

Ч.Анна

Эх бэлтгэсэн:

М.Цэцгээ

Сэтгүүлийн редакцын зөвлөл

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Хилчний гудамж, Ш/х-210332

Утас: 976 7015-5061
И-мэйл: journal@uia.gov.mn
Вэб: www.uia.gov.mn

13301 Ulaanbaatar city, Bayanzurkh district-8,
Khilchin street, P/O-210332

Tel: 976 7015-5061
E-mail: journal@uia.gov.mn
Web: www.uia.gov.mn

ДХИС ХЭВЛЭЛ

e-ISSN 2958-051X

ISSN 2312-0797